

324
6-34

**УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН
АКАДЕМИ**

ДАШДОРЖИЙН БАЯРХҮҮ

**ДЭЛХИЙН БОДЛОГО БА
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА
(90-ЭЭД ОНЫ ҮНДСЭН ХАНДЛАГА)**

**УЛААНБААТАР ХОТ
1995 ОН**

POLITICAL EDUCATION
ACADEMY

Dashdorj BAYARKHUUU

**GLOBAL POLITICS AND
INTERNATIONAL RELATIONS:
KEY TRENDS OF THE 1990'S**

ULAANBAATAR
1995

УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН АКАДЕМИ

Д.БАЯРХҮҮ

ДЭЛХИЙН БОДЛОГО БА
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

(90-ЭЭД ОНЫ ҮНДСЭН ХАНДЛАГА)

Нэг дүгээр хэвлэл

Улаанбаатар хот
1995 он

POLITICAL EDUCATION
ACADEMY

Dashdorj BAYARKHUU

**GLOBAL POLITICS AND
INTERNATIONAL RELATIONS:
KEY TRENDS OF THE 1990'S**

ULAANBAATAR
1995

*Бидний хайрт эцэг Монголын
баримтат киноны нэрт зүтгэлтэн
Балбарын Дашдорж агсны
дурсгалд энэ бүтээлээ зориулав.*

Зохиогч

ЗОХИОГЧИЙН ӨМНӨХ ҮЙ

1994 онд Улс төрийн бэлгэсрөлын Академиас эрхтэй миний хамт номын хэвлэж гаргасныг Та бүхэн мэдэх билээ "Олон улсын харилцааны төлөө түүхэнд" гэсэн сэдвээр бичсэн уул номд олон улсын харилцааны төлөө түүхийг тоймлон бичихийг оролдсон. Тэгэхдээ түүхийн сурталчилгааны толбыг ил болгох замаар урьд бидэнд буруугаар төсөөлж цогц зарим асуудлыг хөндөө гэж зорьсон юм. Орхигдсон олон асуудлыг бид Тэдгээрийн зарим нь судгэрч алга болсон, зарим нь түүхийн хамт гэрээ судлагдахаа хүлээж байна. Тиймийг нь бид эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж хамтын чармайлгаар судлах ёстой. Тийм уурааа гэрээ хөндсөн сэдвээрээ хэнтэй ч хамтран ажиллахад бэлэн байна. Ялангуяа энэ асуудлаар олон жил сонирхож ажилласан эрдэмтэд судлаачид, дипломатуудын санал зөвлөлтөөг дуртайяа хүлээн авна.

Миний түрүүчийн номын агуулгын хамрах хүрээ 1990 он хүртэл дууссан байгаа. Тодорхой хэлбэл "Хүйтэн дайны" төгсгөл буюу Хартигаар дуусгасан. Түүнээс хойш өнөөг хүртэл олон улсын харилцааны ямар замаар урвчилж ирэв гэдгийг энэ номдоо багтаахыг хичээсэн. Тэгэхдээ би энэ номдоо түүхийн ном гэж үзэхгүй. 90-ээд онд олон улсын харилцаа ямар шинэ асуудалтай тулгарав, ямар шийдэл, үйл ажиллагаа, түүний ерөнхий хандлага чиглэл хаашаа байна вэ гэдгийг асуудал асуудлаар нь төрөлжүүлэн бичихийг оролдов. Тэгээд ч түүх болж амжаагүй байгаа асуудлыг үүнээс өөрөөр бичих аргагүй.

Энд бичигдсэн үйл явдлын хэлхээс баримтуудыг дотор нь оруулсан хэсэг 9 бүлэгт хуваан ангилж задлан шинжлэхийг хичээсэн. Анхаарах ёстой өөр нэг асуудал бол зохиогч миний дүгнэлт Та бүхнийхээс өөр байж магадгүй. Би олон улсын харилцааны түүх судлалын болсоч шинэ сэргэг асуудал хөндөж дүгнэхдээ хэзэйд ч хэтрүүлсэн дутуудуулсан байж болно. Ерөөсөө маргаантай байгаа олон асуудал бид Улс бүр, тус тусдаа өөр өөрийнхөөрөө дүгнэж байгаа асуудал зөндөө бий. Олон улсын харилцаанд урьдчилан харж чадахааргүй олон асуудал тулгарч байна. Тэр бүхэнд хэн ч хариулж чадахгүй буюу удаан бодож ултай дүгнэх шаардлага бишгүй тохиолдож байна. Би "Хүйтэн дайны" төгсгөл олон улсын харилцааны шинэ үеийг эхлүүлээ гэдэгтэй өөрийн нийлдэг болсоч тэр шинэ үе нь олон улсын харилцааны шинэ хямрал авчрав уу гэсэн бодолтой байдаг. Түүнийгээ ч энэ номдоо нэлээд хичээсэн. Ямар ч атугай түгшүүртэй байдлын гол юмт, дайны шинэ үеийн улам наашилж, Монголын хилд ойрхон ирэв уу гэсэн сэжиг, шүүмэл дэвшүүлж байгаа. Бидэнд сургамж болж магад гэсэн утгаар энэ зарим асуудлыг хэт нуршсан байх бий. Энэ номын бараг гуравны нэгийг "Уулгаар" Улсуудын Хамтын нөхөрлөлийн (ТУХН) хямрал бэрхшээлийн агуулгын зориулсандаа хүлцэл өчье. Ерөөсөө 90-ээд онд дэлхий дахинд агуу хямрал энд илүү их төвлөрч байна. ТУХН цаашид яах вэ? гэдгээр олон улсын харилцаа, түүний чиг хандлага багагүй тодорхойлогдож байгаа юу. Ялангуяа дэлхийн хэмжээний томхон асуудлууд, Глобал Ариун Төгсөө ертөнцийн цаашидын харилцааг ТУХН-ийн төлөвшил төлөрөгчийг мэдэхээр байна. Тэгээд ч бид хөрш зэргэлдээ том эрдэмтдийг хийж байна.

үйл явдлыг сайтар мэдэж, гярхай ажиглаж, дүгнэлт хийж бэлтгэсэн. Энэ бол улс төр судлаач, олон улсын харилцааны мэргэжилтэн судлаач хэн бүхэнд хамаарах асуудал гэж би хэлэх гээд байна.

Бид өнөөдөр анхаарлаасаа бараг гаргачихаад байсан Дорнод Европ дахь хуучин холбоотнуудынхаа талаар нэг тусгай буюу үгэл оруулав. Коммунизмыг нийгмийн байгууллын хувьд нураахад Дорнод болон Төв Европ дахь орнууд их үүрэг гүйцэтгэсэн. Бидэнд нийгмийн олон асуудал бий. Шийдэх арга зам нь ч адил төстэй байж магадгүй. Энэ утгаар би хуучин анд нөхдөө эргэж "санагалзсан" юм. Эдгээр орчлон гарсан өөрчлөлт ба Оросын 1993 оны сонгуулийн дүнг дагалдан Европын улс төрийн тогтолцоо өөрчлөгдөж байна. Түүнийг тусгахыг хичээсэн. Баг ТУХН ба Дорнод Европ руу чиглэсэн АНУ, Өрнөд Европын бодлогыг энд орхигдуулах ёсгүй.

МУУИС-ийн ОУХДС ба Нидерландын олон улсын харилцааны "Кленгендаль" институтын хооронд тогтоосон хамтын ажиллагааны дагуу тэнд дипломын дамжаа хийснээ ном бичихдээ ашиглахыг хичээсэн. Тэндхийн сургалт болон олон улсын харилцааг дүгнэх нь биднийхээс ялгаатай. Түүнээс хуулбарласан явдал бий. Түүнээ нуух хэрэг алга. Гэхдээ бүхэлд нь хуулбарласан гэж ойлгож болохгүй.

Би ардчилал, гадаад бодлого хоёрыг салшгүй цогц байдлаар авч үздэг. Ардчиллын ачаар бид өдий зэрэгтэй яваа гэж боддог. Энэ утгаар би бичсэн номоороо ардчиллыг сурталчилж, номлож байна гэж ойлголог. Худал бичлээ, дэгсдүүлээ хэмээн зарим асуудал дээр үндэсгүй хардаж сэрдэх хүн гарч магад. Тийм хүн бол ардчиллын талаар дулимаг ойлголттойгоо харуулж байна гэж би үзнэ. Би энэ номд оруулсан баримтаа хөдлөшгүй гэж хамгаалахгүй ч ор үндэсгүй зүйл гэж үзэхгүй. Түүхэн үнэнийг яг байгаагаар нь, үнэнээр нь бичих ёстой. Харин тэгж чадсан эсэхийг уншигч Та бүхэн л шүүн тунгаана. Номын талаар шүүмж хэлж санал зөвлөлгөө өгсөн хүнд талархахаас өөр яахав.

Энэхүү номыг улс төр, олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцааны салбарт суралцаж буй оюутан, магистрант, аспирантуудад зориулсан болно.

Миний хоёр номыг эрхлэн хэвлүүлсэн Улс төрийн боловсролын Академи, ХБНГУ-ын Конрад Аденауэрын санд гүн талархал илэрхийлье. Номын агуулгыг хянан тохинуулах хэвлэн нийтлэхэд сэтгэл харамгүй тусалдаг Б.Дэлгэрмаа, мөн редакцийн ажилтан Т.Сарантуяа, П.Отгонжаргал нарт талархаж явдгаа тэмдэглэе.

ДАШДОРЖИЙН БАЛНХУУ

ОРШИЛ

Та бүхэнд толилуулж байгаа энэ шинэ номын оршил хэсэгт олон улсын харилцааны түүхийн асуудлаас хөндөх нь зүйтэй болов уу. Миний 1994 онд хэвлүүлсэн "Олон улсын харилцаа XX зуунд" номыг олж үзээгүй хүнд энэ нь нэг ёсны дэвсгэр болох байх. Тэр номыг уншсан нэгэнд нь түүхийн зурвасхан аялал болно биз ээ.

(Хүн төрөлхтөний орчин үеийн шинэхэн түүх өнгөрсөн зууны 70-аад онд "Европын эриний" төгсгөлөөр эхэлсэн гэж ихэнх түүхчид үзэж байна. Дэлхийн геополитикт гарсан өөрчлөлтүүд, эдийн засгийн хувьд хөгжингүй гүрнүүд капитализмын шинэ үе шатанд (империализм) шилжсэн явдал европын уламжлалт колонийн гүрнүүдийг дэлхийн тавцнаас аажмаар шахаж эхэлсэн юм. Бас тэр үед дэлхийг хуваах үйл явц шувтарч, их гүрнүүдийн нөлөөнд ороогүй бүс нутаг, улс үндэстэн дэлхийд үлдээгүй. Гэвч ингэж дэлхийг хуваасан нь их гүрэн бүрийн ашиг сонирхолд тэнцүү үйлчлээгүй. Үүний уршиг дагавар дэлхийн нэгдүгээр дайнаар илэрчээ.)

Энэ дайн дэлхийд шинэ дэг журам тогтоох болзлыг ялагч гүрнүүдээс ялагдсан этгээдэд тулгасны хувьд олон улсын харилцааны цоо шинэ системийг үүсгэсэн юм. Энэ систем дэлхий дахины аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг бүхий олон улсын засгийн газар хоорондын анхны байгууллага - Үндэстнүүдийн холбоо (*League of Nation*), түүний үйл ажиллагаагаар хэрэгжиж эхэлсэн. Бас социализм капитализмын хоорондын сөргөлдөөн, дэлхийд шинэ дэг журам тогтоох альтернатив хоёр загварын хоорондын (Вильсон-Ленин) өрсөлдөөн дэлхийн нэгдүгээр дайны үлдээсэн нэг түүхэн үзэгдэл байлаа. Хүн төрөлхтөн тэр үед энэ хоёр загварын эхнийхээр буюу Вудро Вильсоныхоор явсан юм. Тэр нь либерал интернационализм гэсэн гол зарчим дээр тулгуурласан олон улсын харилцааны систем байв. Гэтэл В.И.Ленин үүнийг сэргүүлж пролетарийн социалист интернационализмын зарчмаа дэвшүүлэв. Энэ хоёр зарчим (загвар) нийгмийн байгууллыг зохион байгуулах хоёр өөр аргыг үнэт зүйлээ болгов. Тэр нь ардчилал ба түүний эсрэг ардчилсан төвлөн удирдах ёс, зах зээлийн эдийн засаг ба түүний эсрэг социалист захиран тушаах эдийн засаг гэсэн хэсгүүдэд суурилна. Гэвч энэ хоёр загвар 20, 30-аад онд тэгтлээ ширүүн өрсөлдөөгүй. Учир нь Вильсоны загвар Үндэстнүүдийн холбооны үйл ажиллагаанд бүрэн илрэлээ олж чадаагүй учраас дэлхийд түүнийг хэрэгжүүлж чадаагүй. Лениний загвар Зөвлөлтийн өөрийн нь хил хязгаараас хальж гараагүй.

Энэ бол олон улсын харилцааны хоёр туйлт систем үүсэхийн өмнөх завсрын үе байлаа. Энэ завсрын зурвас үе дэлхийн хоёр дайны хооронд хэрэгжин алдаад өнгөрсөн юм. Түүнд 20, 30-аад

онд дэлхий дахинд үүсч газар авсан фашизм, нацизм, шовинизм гол садаа болсон. Дэлхийн нэгдүгээр дайнаас хойш голтсон олон улсын харилцааны шинэ системд сэтгэл дундуур үлдсэн буюу тэр дайнаар их гүрний статусаа алдсан хэдхэн улсад хамрагдах асуудлын тухай ярьж байна. Нэгэнт олон улсын харилцааны системд өөрийн загвараа тогтоож хүчрээгүй учраас ЗСБНХУ хүчний харьцааны огцом хувиралт. Үндэстнүүдийн холбооны дампуурал дээр тоглохоос өөр арга байсангүй. Өөрөөр хэлбэл өрнөдийн ардчилал, либерал интернационализмын эсрэг чиглэсэн хонзоглогч нацист суртал хийгээд коммунист большевик үзэл суртлынхаа ижилсэх талыг ойртуулахыг зорьсон. Энэ зорилгодоо ч хүрсэн. Энэ нь Зөвлөлтийн хувьд алдаа онооны аль алиныг авчирсан. Үүний хор уршиг 1939 оны есдүгээр сард хурцаар илэрчээ. 1939-1945 болж өнгөрсөн онд дэлхийн хоёрдугаар дайн олон улсын харилцааны хямралын дээд цэг байсан юм. Дайнд ялагчийн үзэмжээр олон улсын харилцааны дайны дараахи шинэ системийг тогтоов. Тэр системийг 1945 оны хоёрдугаар сард Ялтад 3 гүрний удирдагч үндэслэв. Түүнийг товчхоноор *"Олон улсын харилцааны Ялтын систем"* нийтэд ойлгогдож хэвшсэнээр *"Олон улсын харилцааны хоёр туйлт систем"* гэж нэрийддэг бөлгөө.

Нийгмийн хөгжлийн коммунист загварыг өрнөдийнхөн хүлээн зөвшөөрч, хариуд нь ЗСБНХУ тэргүүтэй социалист лагерь өрнөдийн капитализм оршин байх ёстойг зөвшөөрлөө. Ийнхүү зөвшөөрөхдөө ЗСБНХУ, АНУ хоёр нөлөөний хүрээгээ эв зүйгээр хувааж, түүнийгээ олон улсын хууль зүйн үүднээс баталгаажуулсан юм. Үүний тод жишээ нь Европ болсон билээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараа хүн төрөлхтөний шинэ эрин үе эхлэв. Өрнө-дорно, социализм-капитализмын хооронд улс төр, эдийн засаг, цэргийн салбарт урьд өмнө үзэгдээгүй томхон сөргөлдөөн эхэлснээр шинэ эрин үе гэж үздэг юм. Энэхүү сөргөлдөөн олон улсын харилцаа, дэлхийн бодлогыг хэт үзэл сурталчилж, анги намын байр сууринаас дэлхий дахины бүхий л юмс үзэгдлийг үнэлэн цэгнэж, зэвсэглэл ба үзэл суртлын тэмцэлд дэлхийн үндэсний баялгийн ихэнх хэсгийг зарцуулахад хүргэсэн юм. Энэ эринийг товчхондоо *"Хүйтэн дайн"* гэж нэрлэдэг. *"Хүйтэн дайныг"* олон улсын харилцааны хоёр туйлт систем нөхцөлдүүлсэн учраас энэ систем үүргээ өндөрлөсөн цагт л уг дайн мөн төгсгөл болох тавилантай байлаа. Олон улсын харилцааны хоёр туйл болсон ЗХУ, АНУ хоёр нэгэнт нөлөөний хүрээ ба ашиг сонирхлоо харилцан зөвшөөрсөн учраас энэ давуу талаа алдчихгүйн тулд энх тайвныг тогтоон барьж байх ёстой. Олон улсын харилцааг тодорхойлох *хоёр туйлт бүтцийг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн, нөгөө талаас гурав дахь туйл гарч ирэх магадлал байхгүй нөхцөлд урт удаан хугацаанд энх тайвныг тогтоон барих хэрэгсэл нь цэргийн тэнцвэртэй байдал ба цөмийн зэвсэглэл болсон юм. Гэвч ийм тулгууртай энх тайван эмзэг, зөрчилтэй байсан нь мэдээж. ЗХУ,*

АНУ тэргүүтэй хоёрын системийг ашиг сонирхлын хослол Европт тогтворч байснаас үүдэн Европ тив "Хүйтэн дайны" гол талбар болжээ. Хоёр тал ашиг сонирхлоо хангахын тулд зэвслийн бодлого шууштав. Тэр нь Варшавын гэрээний байгууллага, Умард атлантын гэрээний байгууллагын үйл ажиллагаагаар илрэв. Тийм учраас энэ хоёр зэвслийн гишүүн 23 улсад дэлхийн цэргийн нийт зардлын 80 хувь, зэвсгийн экспортын 93 хувь, цэргийн албан хаагчийн 40 хувь, НҮБ, АНУ хоёрт дэлхийд хуримтлуулсан цөмийн зэвсгийн 98 хувь (нийт 55 мянган нэгж) ногдож байв.

"Хүйтэн дайн" дэлхий дахинд хагас зуун жил ноёрхсоноороо энэ зууны түүхийн талыг эзэлсэн юм. Бие биеэ дайсагнасан, ба бие биеэ харилцан хүлээн зөвшөөрсөн хоёр туйлт ертөнцийн бүтэц мөргөндөө харилцан холбоо хамааралтай, хоёр өмнөө үзэгдлийг нэгшуулав. Энэ нь: 1. Түгшүүртэй байдал; 2. Намжмал байдал. "Хүйтэн дайны" түүхийн зурвас үед намжмал байдал олон улсын крилицааг хэсэгхэн зуур ч болов тодорхойлсон учраас "Хүйтэн дайныг" дотор нь нэгдүгээр, хоёрдугаар гэж ангилах явдал бий. Францедийн зарим судлаачид 30 жилийн "Хүйтэн дайн" гэж эхний үнийг 1945-1975 оноор авсан байдаг. Энэ 30 жилийг дотор нь бас Гурав ангилдаг. Үүнд:

1. 1945-1953 оныг "Трумэн-Сталины эрин" буюу хоёр туйлт ертөнц төлөвших үе гэж үзжээ. Энэ хэдэн жилд олон улсын крилицаанд анхаарал татсан гол үйл явдал бол:

- "Хүйтэн дайны" төмөр хөшиг Европт татсан;
- Европыг сэргээн босгох Маршаллын төлөвлөгөө;
- Дайны дараахи олон улсын эдийн засгийн институтын төлөвшилт;
- НҮБ үйл ажиллагаагаа эхэлсэн;
- Өрнөд Европын хамтын батлан хамгаалах систем байгуулсан;
- Германы хоёр улсын үүсэл;
- Хятадад коммунист хувьсгал ялж, Азид социализмын лагерь бэхжсэн;
- Энэтхэг, Индонез, Бирм тусгаар тогтнолоо тунхагласнаар "Гурав дахь ертөнцийн" бүтэц үүссэн;
- Солонгосын дайн. Энэ дайн хоёр системийн анхны халз тулалдааны талбар болсон;
- Атом -цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх эхлэл;
- Социалист лагерь дахь анхны ноцтой зөрчил (Югославыг ганцаардуулах бодлого, 1948 оны Чехословакийн коммунист эргэлт) байв.

2. 1953 онд, ЗХУ, АНУ-ын удирдлага солигдож, улс төрийн шинэ элит засгийн эрх авснаар цоо шинэ бодлого явуулсан юм. 1953-1962 оныг хамрах энэ зурвас үед Европ тив урьдын адил хоёр туйл, хоёр системийн сөрөг төвлөрөл болж байлаа. Европ үйлчлэлжлэн зэвсэглэж, бүгд л зэвсэгт хүчнээ бэхжүүлэв. АНУ-д олон

жил завсарласны эцэст Бүгд найрамдах нам засгийн эрх авсан нь дэлхий дахинд анхаарал татахуйц үйл явдал болов. ЗХУ-д Сталин нас нөхчиж, Хрущев-Маленьков-Булганин нарын хамтын шинэ удирдлага бий болсноор олон арван жил царцаж хөшсөн Зөвлөлтийн тоталитари дэглэмийг зөөлрүүлэх эхлэл тавигдав. 1956 онд хуралдсан ЗХУКН-ын XX их хурал нэг хүнийг тахин шүтэхийн хор хөнөөлийг уудлан илчилснээрээ энэ зууны түүхэнд ул мөрөө үлдээсэн юм. ЗХУ дотооддоо ийнхүү түүхэн томхон эргэлт хийсэн боловч гадаад бодлогодоо тоталитаризмаас татгалзсангүй. Тэр ондоо Унгарт интервенц үйлдэж, Польшийн дотсод хэрэгт байнга оролцож, 1955 онд Варшавын гэрээний байгууллага байгуулж, БНАГУ-ыг өрнөдийн эсрэг цэнэглэн түлхсээр байлаа.

50-иад онд олон улсын харилцаанд гарсан шинэхэн үзэгдэл бол хоёр туйлт ертөнцийн бүтцийг эвдэх анхны оролдлого байв. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үндэс, зарчмыг БНХАУ, Энэтхэг, Индонез, Бирм зэрэг Азийн томхон орнууд тавьсан нь үүнийг илтгэв. Улмаар БНХАУ социалист лагерийн хүрээнд онцгой өвөрмөц зам сонгон авч, ЗХУ-тай сэргэлдэх, байр суурь булаацалдах замд орсон юм. Үүгээр Хятадын коммунизм хөгжлийнхөө шинэ шат руу шилжжээ. БНХАУ олон улсын харилцаанд гурав дахь туйл болох магадлалтайгаар харуулав.

Социализмын тэр хүнд талар талард, цогоо талаас ЗХУ-ын цэрэг стратегийн хүч түүнд өөрийн хэрээр дэлхийн бодлогод тус орны эзлэх байр суурь бэхжээнийг дагалдан бүс нутгийн сэргэлдөөн мөргөлдөөн энэ үеэс эхээ авав. Өрнө-дорнын хоорондын "Хүйтэн дайн" Европоос хальж Газар дундын тэнгис, Ойрхи Дорнод, Энэтхэгийн далай хүртэл хүрээгээ тэлэв. Хамтын батлан хамгаалах систем - НАТО-г дагалдан түүний жишээгээр иймэрхүү чиглэлийн олон бүтэц бий болов. Зүүн өмнөд Азийн гэрээний байгууллага - SEATO, Төвийн гэрээний байгууллага - CENTO, Гурван талын аюулгүй байдлын гэрээ - ANZUS энэ үеэр үүслээ. Арабын ертөнц олон улсын харилцааны нэг зангилаа болов. Араб - Израилийн мөргөлдөөний сунжирсан түүх эхлээд удаагүй байсан үе. 1956 оны Суэцийн хямрал энэ мөргөлдөөнийг шийдвэрлэх боломжгүйг нотлов. Пан - арабизмын үзэл баримтлал, лалын шашны мухар сүсгийн нөлөө, социалист орнуудаас Ойрхи Дорнодын талаар баримталсан бодлого тийм боломжийг үгүйсгэж байв.

Энэ зурвас үеийн төгсгөлд дэлхий дахиныг цочроосон хоёр том үйл явдал болжээ. Хрущевын гадаад бодлогын хийтэй сул тал эдгээрийг нөхцөлдүүлсэн юм. Германы хоёр улс ба хоёр Берлиний талаар түүний явуулсан гэжүүд мугуйд байр суурь Сталины Баруун Берлинг өлсгөлөнгөөр буулгаж авах гэсэн бодлогоос нэг их ялгарахгүй байв. 1948, 1949 онд Баруун Берлин хотыг 462 хоног бүслэн хааж Берлиний эхний хямралыг дэгдээсэн бол 1958-1959

онд дахин хямрал өдөөв. Хрущев Баруун Берлиний суллагч болсон хэлбэртэй түрнүүдээс тулган шаардаж түүнийг босгож дэлхий дахиндаа улмаар энэ жижиг газрыг ХБНГУ, Өрнөд Германиас бүрмөсөн таслан тусгаарлах гэж байгаагаа илэрхийлсээр байв. Ийм нөхцөлд АНУ ХБНГУ-ыг стратегийн талаар дэмжиж, НАТО-г бэхжүүлэхэд арга буюу хүрч байлаа. НАТО-гийн гишүүн Европын зарим орноос Америкийн дунд тусгалтай пуужин байрлуулах асуудал яригдаж 1959 оны эхний хагас жил дэлхийн шинэ дайны ирмэг дээр ирсэн мэт байлаа. Гэвч эрүүл ухаан ялан дийлж, ЗХУ, АНУ хоёр хэлэлцээний ширээнд суусан юм. 1959 оны зун хоёр улсын засгийн газрууд Хрущев, Эйзенхауэр нар харилцан айлчилна гэдгийг зарлалаа. 1959 оны есдүгээр сард Хрущев АНУ-д айлчилснаар яриа хэлцээ дээд хэмжээнд эхэлжээ. Энэ бол ЗСБНХУ-ын түүхэнд, цаашлаад ерөөсөө Оросын түүхэнд анх удаа дээд хэмжээний удирдагч АНУ-д очсон нь тэр байлаа. Гэвч олон улсын харилцаанд дахь энэ хэсэгхэн бүлээрэлтийг Хрущев өөрөө баллав. Парист дээд хэмжээний уулзалтыг орхин одоож, АНУ-ын ерөнхийлөгчийн хариу айлчлалыг цуцлуулж, Африк дахь Конгийн дотоодын хэрэг явдлыг олон улсын маргаан болгож, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганыг үл тоомсорлосон алдаанууд гаргажээ. 1961 оны зун Берлин хямралынхаа дээд цэгт тулж очив. Баруун Берлинг суллаж өгөхийг шаардсан тулгалт нь мухардмагц энэ хотыг тойруулан хэрэм босгож дэлхийгээс бүрмөсөн таслан тусгаарлахаар шийдлээ. Берлиний хоёр хэсгийг заагласан шугам дээр зөвлөлт-америкийн танкууд хэд хоногийн турш байлдааны бэлэн байдалд бие биеэ ойлгон зогсчээ.

Берлиний хана босгосны дараа "Хүйтэн дайн" улам хурц, үедээ орлоо. Зөвлөлт-Америкийн хооронд ямар нэг тохиролцоонд хүрэх магадлал улам хумигдав. Хрущев АНУ-ын Ардчилсан намын шинэ засаг захиргаатай эвлэрэх бодолгүйгээ харуулав. Үүнийг Карибын хямрал дэлхий дахинд нотолж өглөө. Энэ бол Хрущевын гадаад бодлогын хоёр дахь том алдаа мөн. 1962 онд дэлхий нийтээрээ Карибын сав газар, арлын жижиг Куба орноос хараагаа салгасангүй. Тийм учраас 1953-1962 оныг бүхэлд нь сөргөлдөөний үе гэж үеэж ёстой. Карибын хямрал нь пуужинт - цөмийн зэвсгийн эринд дэлхийн шинэ дайн дэгдээх шахсан ноцтой хямрал байсан юм.

1962-1975 он бол олон улсын харилцаанд намжмал байдал, олон туйлт системийн эхлэл үе гэж тооцогддог. Зөвлөлт, Америк гэсэн хоёр туйлтай бүтэц задрах эхлэлээ тавьсныг энд хэлж байна. Олон туйлт дэлхий үүсэх эхлэлийг Франц тавьжээ. Тус орон Шарль де Голлийн засаглалын үед олон улсын харилцаанд мэдэгдэм үүрэг гүйцэтгэжээ. Дайнаас хойшхи Европын улс төрийн уур амьсгалыг зориглон эвдсэн хүний нэг бол де Голль билээ. Түүний орнодийн системийн дотор ч, дорнотой харилцах талаар ч шинэ алхам хийв. Намжмал байдал буюу *Detente* гэдгийг Голланд

үндэслэсэн гэж үздэг. Зөвлөлт - Америкийн харилцаа зогсонги байдалд орсон тэр үед Франц түрүүлж ЗХУ-тай харилцаагаа сайжруулсан юм. Вьетнамын дайн, Зөвлөлт - Хятадын харилцааны хямрал, Индонезийн хувьсгалын мөхөл, дээр нь Зөвлөлтийн шинэ удирдагч Л.И.Брежнев гадаад бодлогын чиг баримжаагаа дөнгөж гаргаж эхэлж байсан зэргээс тус орон дэлхийн бодлогод хөшүүн оролцож байв. 1968 онд Чехословакт Варшавын гэрээний орнууд цэрэглэн халдсанаар олон улсын харилцаа шинэ хямралдаа оров. ЗХУ-тай илт сөргөлдөх замаар олон улсын тавцанд биеэ даасан БНХАУ 70-аад он гараад олон улсын харилцааны гурав дахь туйл болохыг илт оролдож, түүндээ ч зарим талаар хүрчээ. БНХАУ НҮБ-д хууль ёсны суудлаа эзэлж, Япон болон Өрнөд Европын орнуудаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж, улмаар АНУ-тай харилцаагаа хэвийн болгох замд оров.

Де Голлийн бодлогыг залгаад ХБНГУ-ын шинэ удирдагч В.Брандт олон улсын харилцаанд "Остполитик" гэгчийг хэрэгжүүллээ. Өрнөдөөс дорно руу явуулах шинэ бодлогын нэг хэлбэр нь энэ байв. Хрущевын үед хямарч, царцсан Германы асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх эхлэлийг Брандт тавилаа. Брандт Өрнө-Дорнын хооронд нэг ёсны гүүр болсон бодлого хэрэгжүүлсэн юм. АНУ-ын ерөнхийлөгч Р.Никсон Зөвлөлт, Хятадтай харилцаагаа нэгэн зэрэг сайжруулах бодлого явуулж, 1972 онд Хятад, Зөвлөлтөд айлчлав. Бас Вьетнамын дайныг зогсоож, Энэтхэг-хятадын хойгийн хямралыг зохицуулахад бэлэн байгаагаа ажил хэрэг дээр нотлон харуулав. Түүхэнд анх удаа стратегийн довтолгооны зэвсэглэл хорогдуулах, пуужингийн довтолгооноос хамгаалах системийг хязгаарлах хэлэлцээр байгуулав.

Европт гарсан нааштай эхлэлүүд, Зөвлөлт - Америкийн харилцааны сайжрил нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны асуудлаар нийт Европын бага хурал зарлан хийлгэхийг зүй ёсоор шаардсан юм. Хоёр жилийн хугацаанд хэлэлцсэний эцэст түүний гол баримт бичиг бэлэн болжээ. 1975 оны зун Хельсинк хотноо Европын 33 улс, АНУ, Канадын дээд хэмжээний удирдагчид цугларч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны асуудлаархи нийт Европын бага хурлын төгсгөлийн баримт бичигт гарын үсэг зуржээ.

1975 онд ийнхүү олон улсын харилцааны нэг үе шувтарч, дараагийн үе эхэлж байна. Энэ үе 1990 он хүртэл үргэлжилсэн юм. Товчхондоо намжмал байдлаас намжмал байдалд шилжсэн үе гэж нэрлэж болох юм. Тэгэхдээ 1975-1985 оныг тусад нь авч үзэх ёстой. Энэ бол 1975 оны нааштай эхлэлийг эргэж бүснүүлсэн, өрнө-дорнын зөрчил дахин хурцадсан, түгшүүртэй байдал сөргөлдөөний үе байсан юм. Социализмын ертөнц хүрээгээ тэлэхийн хамт шинэ хямрал бэрхшээл дагуулж байв. АНУ Энэтхэг-хятадын хойгоос гарсан боловч энэ бүс нутаг дахин хямралын голомт болов. Африк, Ойрхи Дорнодод мөргөлдөөний ноцтой голомтууд

дундгай Европийг нэгдсэн хувьсгал ялснаар Дундад Дорнод дахь өрсөлдөөний өмнө суурь улам сулрав. Энэ нь эндхийн бүс нутагт ЗХУ-ын төлөөлөгчид ижилдэх боломжийг бүрдүүлжээ. 1979 оны сүүлчээр Афганистанд цэрэглэн халдсанаар олон улсын харилцааны хамралтаар цэргийн тулгалаа Дэлхийн хэмжээнд сэргэлдөөн газар авч, Европын түүнд тусгалтай пуужингийн хөлөлдөө мухардах. ЗХУ-ын төлөөлөгчид дотоод хэрэгт оролцсон зэргээс үүдэн 1975 оны Женевынгийн төгсгөлийн баримт бичгийн хэрэгжилт нэгдөй өргөжүүлжээ тулгарах. 1975 онд 30 жилийн "Хүйтэн дайн" дууларсан бол мөн энэ онд шинэ "Хүйтэн дайн" эхэлсэн юм. Энэ нь 1980, 1991 он хүрч байж төгсгөл болсон билээ.

1985 он дэлхийн болон олон улсын харилцааны түүхэнд нэгдэлтөгдөх он болно. ЗСБНХУ-д *перестройка* эхэллээ. Энэ бол түүхийн үеийн нийгмийн захиалгаар хийхээс өөр аргагүй байсан зүйлээр үзэгдэл юм. Олон улсын харилцаа чинээндээ тулгал жургалсан. Зөвлөлт-Америкийн хооронд цөмийн болон дунд түлгэлтэй зөвсөглөлийн салбарт хөлөлдөн тохирох бүх боломжийг төлөлдүүлсэн. ЗХУ бүс нутгийн мөргөлдөөнд татагдан орж, гарах аргагүй мухардсан, эдгээрээс үүдэн тус орны дотоод бэрхшээл журимтлагдан, шийдэх ёстой өдий төдий асуудал онолын талаар ч, практикийн талаар ч шийдлээ хүлээж байсан нөхцөлд *перестройка* гэгчийг гарцаагүй хийх ёстой байлаа. Тэгэхдээ энэ зорилгодоо амжилт замаар биш, ухаарч байж хүрэх нь төдөрхөй болсон юм. Энэ нь санаачилга авах гэж яарч адгах биш, үзэл суртлаар бөмбөгдөх, коммунист романтик зорилгоо бусдад тулгах биш, гол нь дэлхийд журнаалиас татгалзах, үрэлгэн өдийн засгийн системээс ухрах, өөр системийн өрсөлдөөнд ялагдал хүлээснээ зоригтой хүлээн зөндөөрөх замаар нэр хүндээ бэхжүүлж, дараа нь санаачилга авахын төлөө ажиллана гэсэн үг. Зогсонги байдалд орсон захиран тулаах өдийн засгийн механизм, сталинч маягийн нэг намын дарангуйлал, ардчилал хүний өрхийн эсрэг бүх үйл ажиллагаагаа илгэн засварлана гэсэн үг. *Гласность* ба *перестройка* нь энэ бүхнийг уудлан илчилж, үнэн мөнийг гаргаж тавьсан юм. Тэртээ тэртгүй ЗХУ-д нийгмийн тэсрэлт гарахын өмнөх нөхцөл байдал бүрдээд байсан учраас *перестройка*г хэн ч хориглож хүчрээгүй. Дорнод Европын орнууд ч энэ үйл явдлын гадна идэвхгүй ажиглагч байхыг хүсээгүй. Түүхийн хар цагааныг ялгаж салгах явцад 1956 онд Унгарын, 1968 оны Чехословакийн хэрэг явдлын үнэн мөн илгэн гарлаа. Польшийн дотоод хэрэгт хөндлөнгөөс балмадаар оролцож хүний өрх, ардчиллыг хөсөрдүүлж байсныг зогсоов. Ийм нөхцөлд тэдгээр оронд Москвагаас тулгаж тогтоосон тоталитаризм өршин байх боломжос улам алдав. Ил тод нөхцөлд нэг намын дарангуйллын алдаа завхрал ил болов. Нам, ард түмний хооронд зохиомлоор тогтоосон холбоо суларч, зааг нь ихсэв. ЭЗХТЗ болон Варшавын гэрээ олон улсын шинэ нөхцөлд үүрэг гүйцэтгэх

боломжоо улам бүр алдсаар байлаа. Олон улсын харилцааны хоёр туйлын нэг нь дэлхийн бодлогоос аажмаар холдох нь тодорхой болсоор байв. "Хүйтэн дайн", түүний тогтоон барих хэрэгсэл НАТО, Варшавын гэрээний үүрэг тэгтлээ чухал биш боллоо. 1989 он ардчиллын салхийг дэлхий дахинд хагаллаа. "Хүйтэн дайны" гол фронт болсон БНАГУ-д коммунист тоталитари дэглэмийг уншгав. Дорнод Европын бүх оронд ардчилал яллаа. 1990 онд Монгол Улс Азиас анх түрүүн энэ жагсаалтад нэмэгдэв. Коммунизм дэлхийн систем болохын хувьд сүйрэх нь бүрнээ тодорхой боллоо. Ерөөсөө ЗХУ тэргүүтэй дэлхийн социалист систем цөм нь болж байсан учраас дээрхи хэдэн орон хаашаа эргэнэв дэлхийн коммунизм мөн тийшээ эргэх нь мэдээж. Дорнод Европ, Монголыг хамарсан нийгмийн тайван хувьсгалаар сталинизм хүн төрөлхтөний түүхээс бараг арчигдан арилав.

1990 оны дунд үе гэхэд дэлхий дахины дүр зураг эрс өөр болсон юм. 40 жил бие биеэ сөрөн зогссон цэрэг-улс төрийн хоёр эвсэл ВГБ, НАТО, "Хүйтэн дайны" төмөр хөшгөөр хиймлээр зааглагдсан нийгэм-улс төрийн хоёр систем цаашид тэр утгаараа оршин байх нь үндэсгүй болжээ. Дорнод Европ дахь сталинч дэглэмүүд дараа дараалан унаж, тэндээс Зөвлөлтийн цэргийг гаргамагц Европыг түгшүүлж байсан айдас түгшүүр аяндаа алга болов. "Хүйтэн дайн" дэгдсэн шалтгаан ийнхүү замхрав. Дорнод Европ дахь социализмын цайз бэхлэлт-БНАГУ татан буугдаж, ХБНГУ-ын бүрэлдэхүүнд орсноор "Хүйтэн дайны" сүүлчийн хуудсыг эргүүлээ.

Дэлхий дахинд социализмын үл гүйцэлдэх романтик сургааль балмад хэв загвараа тулган хүлээлгэх гээд сүйрсний түүхэн сургамж бол 1989-1990 оны тэдгээр хэрэг явдал билээ. Ялангуяа Европт коммунист соёл иргэншил өндийхгүй болтлоо цохилт амслаа. Ийнхүү дэлхийн социализмд гарсан хувиралт өөрчлөлттэй холбогдон дэлхийд хагас зууны турш ноёлсон "Хүйтэн дайн" төгсгөл болж, бие биеэ сөрсөн хоёр туйлт ертөнцийн бүтэц задрав. Олон улсын харилцааны системийг шинээр томъёолох асуудал шилжилтийн зурвас үедээ орлоо. Хоёр туйлт систем задарсан учраас үлдэх нэг туйл АНУ дангаараа олон улсын харилцааг тодорхойлох, эвсэл олон туйлт систем төлөвшүүлэх хоёрын нэгийг дэлхий дахин сонгох ёстой.

Хүн төрөлхтөн ийнхүү түүхийнхээ нэг үеийг өнгөрүүлж, шинэ эрин үед шилжсэн учраас 1990 оны арваннэгдүгээр сарын 19-21-нд Парис хотноо түүнийг олон улсын хууль зүйн хувьд хуульчилж өгсөн юм. Европын 32, АНУ, Канадын удирдагчид Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлаараа Парисын Харти баталж, түүндээ цаашдын харилцааныхаа үндсийг тодорхойлсон билээ.

Энэ бүхнийг би түрүүчийн номдоо түүхчлэн бичсэн болно. Одоо толилуулж буй номд "Хүйтэн дайнаас" хойшхи дэлхийн

бодлогын үндсэн хандлага болон олон улсын харилцааны шинэ системийн төлөвшилтийг гаргахыг оролдов. Ингэхдээ 3 үндсэн хэсэгт хувааж авч үзлээ. Нэгдүгээр хэсэг бүхэлдээ посткоммунист ертөнцөд зориулагдав. "Пост" гэсэн нь социализм коммунизм улиран одсоны дараа гэсэн утгыг илэрхийлнэ. Социалист байсан, одоо социалист хэвээр байгаа орнууд дахь нийгэм-улс төрийн үйл шил, өөрчлөлтийг энд тоймлон өгүүлсний сацуу дэлхийн коммунист ажилчны хөдөлгөөн төгсгөл болсон түүхийг эндээс сонирхож болно. Номын хоёрдугаар хэсэг дэлхийн эдийн засгийн асуудалд зориулагдсан. Хөгжингүй орнуудын гадаад дотоод бодлого, олон улсын санхүү-эдийн засгийн зарим институтын үйл ажиллагаа энд нэлээд зай эзлэх байх. Европын холбоо, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын талаар аль болох хэрэгтэй гэж үзсэн мэдээллээ та бүхэн эндээс авч болно. Бас хөгжиж буй орнууд дэлхийн эдийн засаг дэлхийн бодлогод ямар байр эзэлж ирсэн ба одоо эзэлж буй талаар энэ хэсгийн дараагийн бүлэгт түүхчлэн өгүүлэв. Номын гуравдугаар хэсэг олон улсын харилцааны зарим тулгамдсан асуудалд зориулагдсан. Жишээ нь тэр бүр хөндөгдөж байгаагүй сэдэв болох - Хүний эрхийн асуудлыг олон улсын харилцаатай холбон авч үзлээ. Залгаад олон улсын харилцааны шинэ нөхцөлд НҮБ хэрхэн дасч дадаж, шинэчлэгдэж байгаа үйл явц, энхийг сахиулах үйл ажиллагааны тухай эндээс уншиж болно. Төгсгөлд нь бүс нутгийн хямрал голомтуудыг зохицуулж ирсэн үүх түүхээс авч үзэв.

Би түрүүчийн номдоо улс орныхоо гадаад бодлогыг бага тусгасан буюу орхигдуулсан гэсэн зэмлэл хүртсэндээ хүлцэл өчихийн хамт энэ номдоо аль болох оруулахыг хичээснээ хэлэх байна. Гэхдээ холбогдох юм, холбогдохгүй юм гэж бий. Холбогдох талыг хөндөн бичихийн сацуу бас зарим нэг санал дүгнэлт оруулсан байгаа. Тэгэхдээ өөрийн бодлыг бусдад тулгахыг зориогүй. Монгол бол дэлхий ертөнцийн нэг хэсэг. Дэлхий дахинд өрнөж буй үйл явц, тэдгээрийн хандлага Монголд шууд болон шууд бусаар нөлөөлнө гэдэг утгаар хандсан болно.

★

★

★

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

ПОСТКОММУНИЗМ БА ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

1

ЗСБНХУ-ЫН ЗАДРАЛ БА ТУСГААР
УЛСУУДЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛ

2

ТУСГААР УЛСУУДЫН ХАМТЫН
НӨХӨРЛӨЛ БА ОЛОН УЛСЫН ШИНЭ
ХАРИЛЦАА

3

ПОСТКОММУНИЗМ БА ИХ ШИЛЖИЛТ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗСБНХУ-ЫН ЗАДРАЛ БА ТУСГААР УЛСУУДЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛ

НЭГ. ЗСБНХУ: НЭГДМЭЛ УЛСЫН ШИНЭ ЗАГВАРЫН ЭРЭЛД (1991 он)

1991 оны зун гэхэд ЗХУ-д нийгэм-улс төрийн эгзэгтэй гэмээр нөхцөл бүрдээд байсныг эргэж саная Улс төрийн хувьд М.С.Горбачев тэргүүтэй төвийг сахигчид хэдэн талаасаа элдэв дайралттай тулгарав. Орон нутагт зааглан салах явц идэвхжиж, хэрэг дээрээ нэгдмэл цул ЗСБНХУ задран салсан мэт байлаа. Либералууд нийгмийг эрс өөрчлөхийн төлөө байхад, Холбоот Орос Улсын Коммунист намыг тойрсон хуучинсаг хүчин баруун талаас нь довтолж эхлэв. Нэгдмэл ЗХУКН хууль зүйн хувьд оршин байсан ч түүний бүх эрх Оросын коммунистууд руу шилжив. Энэ бол зүйрлүүлж хэлбэл 1917 оны Октябрийн эргэлтийн өмнөх нөхцөл байдал эргэж амилаа юу гэлтэй байв.

Өөрчлөн байгуулалт бэрхшээлтэй тулгарах тусам коммунист хуучинсаг хүчин эгнээгээ бэхжүүлж, 1985 оноос хойш алдсан эрх мэдлээ эргүүлж авахаар оролдов. Үүний тод жишээ нь 1991 оны эхээр хийсэн удирдлага дахь учир битүүлэг халаа сэлгээ боллоо. Өөрчлөн байгуулалтыг Горбачевтой хамт эхлүүлсэн Н.Рыжков, А.Яковлев, В.Бакатин, Э.Шевардназе нар улс төрөөс холдож, тэдний халааг ирээдүйн ГКЧП-истууд болох В.Крючков, В.Павлов, Б.Пуго, Г.Янаев нар авлаа. Шевардназе огцрохынхоо өмнө төрийн эргэлт хийхээр зэхэж байгааг анхааруулсан нь ноцтой юм. Үүнээс Горбачев санаа авсангүй. Ельцин ч 1991 он ардчиллыг аврах уу, алдах уу гэдгийг сорьсон шийдвэрлэх жил болно гэж анхааруулж байжээ. Удирдлагад шинээр дэвшигчдийн улс төрийн нүүр царай ч энэ анхааруулгыг нотолсон мэт байлаа. Тэд засгийн эрхэнд бэхжмэгц эхний алхамаа цусан мөр татуулж гаргасан юм. Литва, Латвийн энгийн тайван жагсаалыг буудах тушаалыг Крючков, Пуго нар өглөө. Зөвхөн нэг шөнийн дотор 15 хүн алагдлаа. Зөвлөлтийн цэрэг Вильнюст зоргоороо авирлав. Литвад үйлдсэн энэ харгислал Зөвлөлтийн нийгэм дэх зааглан салах явцыг бүр ч ил болгож өгөв. Ардчиллыг талархагч, өөрчлөн байгуулалтад сэтгэлээ өгсөн бүх хүчин шинэ удирдлагаас зааглан саллаа. Аядуу центрист Горбачев эвлэрүүлэх талаар бүтэлгүй оролдлого хийж, даж ч хүчирсэнгүй. Зөвлөлт орны задрал Балти хавийн улсуудад өрнөсөн тусгаар голтлолын хөдөлгөөнөөс үүдэн улам эрчээ авав. Муж орон нутаг, автономит (өөртөө засах) улсууд төвдөө итгэл алдарч, нүүрлэж байгаа төрийн эргэлтийн аюулыг улам ч мэдрэх шиг болов.

Ийм нөхцөлд Горбачев маневрлах, буулт хийх, ятгах зэргээр нөхцөл байдалтай зохицож, эх орныхоо мөхлийг аль болохоор хойшлуулсаар байв. Үүний эхнийх нь 1991 оны гуравдугаар сард явуулсан бүх нийтийн санал асуулга боллоо. Дорнод болон Тэн Европт социализм сүйрч, энэ сүйрэл ЗХУ-ыг тойрч гарахгүй гэдэг ойлгомжтой болсон яг тэр үед уг арга хэмжээг зохион байгуулжээ. Ялгаатай нь гэвэл Зөвлөлтийн нийгмийн байгууллын сүйрэл нөхөж баршгүй том хохирол дагалдуулж мөдөхийг Горбачев урьдчилан харсан юм. Тэр нь 1922 оноос хойш оршин тогтносон нэгдмэл, холбооны, олон үндэстний эх оронд нь нөмөрсөн задарч салж бутрах аюул байлаа. Энэ аюулыг гэнэтхөж үүднээс тэрхүү санал асуулгыг явуулжээ. Түүнд оролцогчдын 70 хувь нь улс орноо бүрэн бүтнээр нь байлгах санал өгсөн боловч үр дүн нь хожим нотлогдоогүй. Учир нь Горбачевын санал хуралтад Зөвлөлтийн 15 бүгд найрамдах улсаас 9 нь оролцож, тусгаар тогтнолоо зарласан Армен, Эстон, Гүрж, Латви, Литва, Молдби түүнийг тойрч гарчээ. Энэ утгаараа энэ арга хэмжээ хагас дутуу, эсрэгээр шинжтэй болсон юм. Нөгөө талаас, санал асуулга явуулсан зарим бүгд найрамдах улс түүний хуудсанд өөрсдийн яшиг сонирхлоо тусгасан асуулт нэмж, түүний үр дүн бүрэн бүтэнхтэй, дөрчилтэй болгожээ. Горбачевын хувьд дээр дурдсан 70 хувь гэдгийг гол бодлоод санал асуулга амжилттай болжээ гэж дүгнэсэн нь түүний ноцтой алдаа байв.

Ингээд санал асуулга явуулсан 9 улсын удирдагчидтай зөвшилцөх асуудалд шилжин оров. Ингэхэд юу зөвшилцөх хэрэг вэ? Нэгдмэл ЗСБНХУ-ыг бүрэн бүтэн авч үлдэх Холбооны шинэ гэрээ, өөрөөр хэлбэл 1922 оны Холбооны гэрээг орлох шинэ гэрээний тухай ярьж буй хэрэг. Энэ асуудлыг тойрч удтал маргажээ. Учир нь тэр үед шинэ гэрээ яг тийм байх болно гэж хариулж чадах хүн нэг ч байгаагүй хэрэг. Холбоог шинэчлэн байгуулах үзэл баримтлалаас эхлээд холбооны албан ёсны нэр, төвийн талаар хаана хаанаа ултай бодох ёстой. Үнэндээ "Зөвлөлт Социалист" гэдэг нэр утгаа алдаж, хүн ардын санаанд тэр бүр нийцэхээ больсон үе байлаа. Ер нь ч 1922 онд шууд "Социалист" гэж тодотгож өгсөн нь дэндүү эртэдсэн зүйл байсан байж болох талтай. Үүнийг ч олон хүн шүүмжлэн ярьж, ЗХУКН олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрөөд байсан 1991 онд "Социалист" гэдэг үг бүр ч утгаа алдлаа гэж үзэж байв. Холбооны парламент (тэр үеийн ЗСБНХУ-ын Ардын депутатуудын их хурал ба түүнээс сонгогдсон Дээд Зөвлөл), нийгмийн бүтцийн бусад давхарга, орон нутгийн хууль тогтоох байгууллагад өрнөсөн маргаан мэтгэлцээн дээр шинэ Холбооны нэрийн талаар 3 санал давамгайлж байв. Тэр нь Бүрэн эрхт социалист улсуудын холбоо, Бүрэн эрхт Зөвлөлт Бүгд Найрамдах Улсуудын Холбоо (үүнийг СССР гэж товчилж бас болно) Евро-Азийн Бүгд Найрамдах Улсуудын Холбоо гэж нэрлэе гэсэн санал байв. Ер нь л урьдын СССР гэсэн товчилсон нэрийг нэг

их эвдэхгүйгээр дотор нь үг солих маягаар өөрчлөхийг хүсэн шаардсан захидал хүсэлт Москва руу хөвөрч байв. Ингэхэд шинэ Холбоогоо "Холбоо" гэх үү, "Конфедерац" гэх үү гэдэг дээр ч зэгсэн маргав. Шинэ Холбооны төв ямар эрх эдлэх, тэр нь урьдын Москва шиг бүх юмны төвлөрөл зангилгаа байх асуудал ч мэтгэлцээний нэг гол сэдэв байлаа. Ер нь энэ бүхнийг шийдчихэд тун амаргүй, учир нь тус орны түүхэнд бүү хэл, бусад улсын түүхэнд ийм шинэ Холбоо байгуулж (нэгээс нь нөгөөг төрүүлэх) байсан туршлага үгүй юм. Горбачевын өөрийн нь үзсэнээр, тэрхүү шинэ Холбоо нь нэгдсэн аж ахуйтай, харин Москвагаас бие даасан эрх мэдэлтэй бүгд найрамдах улсууд байхад орших аж.

Хожим нь шинэ Холбоо байгуулагдахын өмнө хуучнаа задалж, шинийг бий болгоогүй олон удирдагч тэр үед бүгд л "Холбооны төлөө!" гэгцгээж байсан нь анхаарал татдаг юм. Энэ нь, заль мэх байв уу, эсвэл тэдний чин хүсэл үү, эсвэл хожмын нэг явдлаас (1991 оны наймдугаар сарын хэрэг явдал) үүдэж үзэл бодлоо өөрчлөхөд хүрсэн аргагүй учир шалтгаан уу гэдгийг түүх шүүг. Энд би урьдчилан олон юм бичихгүй.

Холбооны шинэ гэрээг 5-6 бүгд найрамдах улс зөвшөөрөх л юм бол даруй батлах хэрэгтэй, бусад нь аажимдаа нэгдэх биз гэж тэр үеийн ЗХУ-ын удирдлага үзэж байсныг бодвол, ер нь алгуурлахыг мөхөхийн шинж гэж болгоомжилж байсных. Ийнхүү удтал зөвлөж, зөвшилцсөний эцэст Холбооны Гэрээний төсөл дээр нэгдсэн тохиролцоонд хүрчээ. Үүнийг товчлон "9+1" гэж нэрлэдэг. Гэрээнд гарын үсэг зурах өдрийг 1991 оны наймдугаар сарын 20-оор тогтож, 21-нд Холбооны Зөвлөлийн хурал хийхээр төвлөв. Ингэж тохиролцоход хуучинсаг эрх баригчид саад хийх гэж элдвээр оролдсон боловч Горбачевын зоригийг мохоогоогүй юм. Ийнхүү 1922 онд бий болсон ЗХУ-ын Төрийн бүтцийн хуучирсан хэсгийг халж, Холбооны улсын шинэ бүтэц бий болгох Гэрээ цаасан дээр бэлэн болжээ.

Гэвч ингэж бэлтгэсний цаана зарим ноцтой асуудал шийдэгдэлгүй үлдсэн юм. Тухайлбал, гэрээ батлагдсаны дараа бусад нь аажимдаа нэгдэх үү, үгүй юү гэдэг асуудлыг тун түүхий бодож тооцоолсон байв. Холбооны гэрээнд нэгдэхээс татгалзсан 6 бүгд найрамдах улсын төлөөлөгчид долдугаар сард Тбилист уулзаад, хойшид НҮБ болон олон улсын бусад байгууллагад ЗХУ-аар эрх ашгаа төлөөлүүлэхгүй байх хүсэлт тавьсныг энд харгалзан үзсэнгүй. ЗСБНХУ-ын хуучин бүтэц түүний гишүүдийн харилцаанд нэгэнт нааштай үүрэг гүйцэтгэж чадахгүй болсны нотолгоо энэ юм. Салан тусгаарласан эдгээр 6 бүгд найрамдах улс Холбооны гэрээний гадуур олон улсын идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь илэрхий болжээ. Тэд Югославаас салж гарсан улсуудыг хүлээн зөвшөөрч эхлэв. ЗХУ-ын бүрэлдэхүүнээс гарах асуудлаар есдүгээр сард Арменд санал хураалт явуулахаар тогтов. Нөгөө талаас, дэлхийн хамтын нийгэмлэг ЗХУ-ыг дампуурсан гэж үзэхийн нанги

байсан бөгөөд үүнийг тэр зун Лондонд болсон "7-гийн бүлгийн" уулзалт нотолж өгөв. Энэ уулзалтад анх удаа Зөвлөлтийн удирдагчийг урьсан бөгөөд энэ утгаараа "7+1" гэж томъёолсон нэр үүсчээ. Гэвч 100 хувь итгэл төрүүлэхээр юм гарсангүй. "Их /" тус оронд дэмжлэг үзүүлэх тухай 6 зүйлт тохиролцоо батлахдаг. ЗХУ-ын дотоодын байдалд сэтгэл түгшиж байгаагаа нуугаагүй. Тэгээд ч АНУ ЗХУ-д олгож буй 15 сая долларынхаа тэн хагасыг 13-и хавийн улсуудад хуваарилах, өөрөөр хэлбэл, тэднийг хөл дээрээ босч ирэхэд нь тусална гэж шийдвэрлэжээ. Гэрээ байгуулахнаас наана Зөвлөлт орны улс төрийн амьдралд өөр олон өөрчлөлт гарсны нэг нь Оросын нутагт бүх албан газар намын байгууллагагүй болох тухай "Ельциний" зарлиг байв. Үүнд хуучинсаг гэжүүд коммунистууд бүхнээс цочирдлоо. Яг ийм эгзэгтэй үед хэрэг явдал гэнэт бишэдлээ. Гэрээ боловсруулахад саад хийж хүчрээгүй хуучинсаг, хонзогногч хэсэг түүнд гарын үсэг зурахаас өмнө шууд тасалдуулахаар хөдөлжээ. Тэд Гэрээг тасалдуулах төдий бус зөвсгийн хүчээр Зөвлөлт гүрний мөхлийг аварна гэж тооцоолжээ.

1991 оны наймдугаар сарын 19-ний өглөө дэлхий даяараа айдас төрүүлэм мэдээ. Москвагаас хүлээн авлаа. Ерөнхийлөгч Горбачев ажил хийх чадваргүй болтлоо өвчилж, дэд ерөнхийлөгч Янаев тэргүүтэй Онц байдлын Улсын хороо (ГКЧП) төрийн эрхийг авсан тухай зарлажээ. Уг хороо ЗСБНХУ-ын 1977 оны Үндсэн хууль хүчин төгөлдөр байгааг нотолж, түүний дагуу амжиллаж байсан эрх барих бүтцүүдийг сэргээж, хэд хэдэн нутагт 6 саргаар онц байдал зарлан нийслэлд цэрэг оруулж, цэрэг хүчний бүх үйл ажиллагаа, жагсаал цуглааныг хориглож, хэвлэл мэдээлэлд хатуу хяналт тогтоожээ. Ийнхүү Зөвлөлт нийгмийг хамараан ардчилал, шинэчлэл санаандгүй аюултай тулгарлаа. Ингэнэ гэж хэн ч санаагүйгээр үл барам Зөвлөлтөд ч, хилийн чанадад ч үүнд бэлэн нэг ч хүн байсангүй.

Хууль бусаар төрийн эрх булаан авахаар хөдөлсөн хуйвалдагчидтай нийгэм дэх тун өчүүхэн хэсэг эвлэрэв. Олон арван жил захиран тушаах системийн нөхөөсийн үүрэг гүйцэтгэж ирсэн ҮЭ, комсомол, ахмад дайчдын байгууллага гэх мэт ганц хоёр олон нийтийн байгууллага хуйвалдагчдын талд орж, Холбооны гэрээ бэлэн болсон үеэс хэл нь татчихсан коммунистууд сая нэг амьсгалахтайгаа болжээ. Эднээс өөр ГКЧП-г дэмжсэн хүн хаа ч байсангүй.

Холбооны гэрээ байгуулна гэсэн 9 улс бүгд шууд буюу дам байдлаар хуйвалдааныг эсэргүүцэв. Жишээ нь Б.Ельцин тэргүүтэй Холбоот Орос Улс түүнийг Үндсэн хуулийн эсрэг харгис төрийн эргэлт гэж дүгнээд, ГКЧП-г хууль бус гэж зарлав. Эгдүүцэн дүргүйцсэн москвичууд Цагаан ордныг бүчин авч, хаалт бэхлэлт босгож, болзошгүй халдлагад бэлтгэж эхлэв. Цэргийн ангиуд, тэр ч бүү хэл БХЯ-ны удирдлага бат цул нэгдэлтэй байж чадсангүй.

Оросын дараа орох томхон улсууд-Украин, Белорусс, Казахстан онц байдал тогтоох шаардлагагүйг мэдэгдээд тайван байхыг ард түмэндээ уриалав. Балти хавийн улсууд, Гүрж мэтэд нь ГКЧП-гийн үйл ажиллагааг бүр ч жигшин зэвүүцэж угтжээ. Хуйвалдагчид аргагүй ганцаардаж эхэллээ. Наймдугаар сарын 21-нд Оросын Дээд Зөвлөлийн онц чуулган чуулж, Горбачевыг чөлөөлөх, хуйвалдагчдыг баривчлах шийд гаргав. Ийнхүү үймээн дарагдаж, толгойлогчид нь шүүхэд шилжжээ. Тэгэхдээ энэ бүхнийг ЗСБНХУ-ын хуулийн дагуу бус, ЗСБНХОУ-ын хуулийн дагуу шийдсэн нь хожим хууль бус гэж эргэж бухагдах нэг нохцол болсон байж магадгүй.

Нөгөө талаас, наймдугаар сарын хэрэг явдал дэлхий дахины харилцаанд хүчтэй нөлөө үзүүлжээ. Зөвлөлтөд өрнөж байсан үйл явц хэр нөлөөтэй, ямар их ач холбогдолтой байсны шалгуур болж өглөө. АНУ тэргүүтэй Өрнөдийн бүх орон, олон улсын хамтын нийгэмлэг, ер нь ардчилсан гэгдэх бүх ертөнц хуйвалдагчдыг эрс буруушаалаа. АНУ холбоотнуудтайгаа зөвлөл-дөхөөр Брюссель рүү Төрийн нарийн бичгийн даргаа илгээв. "7-гийн бүлгийн" уулзалтаар амласан нөгөө тусламж зээлийн асуу-дал ч буруугаар эргэлээ. Тухайлбал, Европын хамтын нийгэмлэг тусламжаар олгохоор зэхэж байсан 400 сая эки, зээлээр олгох 500 сая эки, Их Британиас Зөвлөлтийн реформд дэмжлэг болгохоор төсөвлөсөн 50 сая фунтээ зогсоохоор шийджээ. Энэ үймээний өмнөхөн АНУ-ын ерөнхийлөгчийн ЗХУ-д хийсэн айлчлал, тэр үеэр гарсан гарын үсэг зурсан Стратегийн довтолгооны зөвсэглэлийг хорогдуулах, хязгаарлах тухай Зөвлөлт, Америкийн шинэ гэрээ, бусад гэрээ хэлэлцээрийн хувь заяа эргэлзээтэй болж ирэв. Дэлхий даяар хуйвалдагчдыг буруу-шаасан мэдэгдэл, уриа цууриатав. Хэрэв хуйвалдаан үр дүнд хүрсэн бол олон улсын харилцаа дахин хямарч, "Хүйтэн дайн" дахин сэргэх байсанд эргэлзэх зүйл алга. Учир нь хуйвалдагчид Хельсинкийн баримт бичиг, Парисын хартиг шууд хөсөрдүүлэх замд орсон юм. Тэд "эх орон" гэдгээр гул барин "Хүйтэн дайнд" ялагдсанаа нөхөж авна гэж тооцоолжээ. Ийнхүү Өрнө-Дорнын бүх яриа хэлцээ, "Хүйтэн дайныг" эцэслүүлэхэд нөлөөлсөн хамтын ажиллагааны бүх үйл явц, зөвсэглэл, бүс нутгийн мөргөлдөөн, хүний эрх, эдийн засаг-худалдаа зэрэг олон улсын харилцааны хамгийн өргөн салбарууд хумигдах аюултай нүүрлэсэн юм. Хэрэв тэгсэн бол ямар уршигт хүрэх байсныг төсөөлж болно. Зөвлөлтийн бүгд найрамдах улсуудын зөрчил, тэмцэл олон улсын харилцааны ноцтой асуудал болж даамжрах бийлаа. ГКЧП-гийн тушаалаар Балти хавийн улсуудад шууд халдан гүрэмгийлэхээр зэхэж байсныг энд жишээлж болно. Хуйвалдагчид зөвсгийн хүчээр нэгдмэл ЗСБНХУ-ыг "социалист" чигээр нь авч үлдэхийг зорьсон нь тухайн цаг үетэй огт авцалдахгүй байсанд хэргийн учир оршино. Харамсалтай нь цаг үе тэднийхээр болохгүй

гэдгийг ойлгохыг хүсээгүй, үүний уршгаар ч Москвад хүний цус урссан.

Наймдугаар сарын хуйвалдааныг Ельцин ааглан дарсныг дэлхий дахинаараа баярлан хүлээн авсан. Үүнээс үүдэн түүний нэр хүнд эрс дээшилж, Зөвлөлтөд Горбачёвтой өрсөлдөх цорын ганц хүн болж тодорсон билээ. Энэ үйл явдал Зөвлөлт дахь улс төрийн өрнөл хөгжлийг улам хурдасгаж, хүчний харьцааг шинээр төлөвшүүлсэн юм. ЗХУ задран салахыг урьдчилан сэргийлэх ёстой коммунистууд төрийн эргэлтийг санаачилснаараа өөрийгөө мөхөлд хүргэв. Горбачёвын сэтгэлийг сүүлийн жилүүдэд зовоож байсан Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаал ч нэг гийш шийдэгдэв. Ер нь намын Ерөнхий нарийн бичгийн даргын тушаал нийгэмд илүүц зүйл болж хувирсныг Горбачёв нам тарахаас өмнө өөрөө хүлээн зөвшөөрөв. Горбачёвыг дагалдан Казахстаны ерөнхийлөгч Н.Назарбаев ЗХУКН дахь бүх сонгуульд албан тушаалаасаа татгалзав. Улс орны удирдлагад либералууд бэхжиж, коммунистууд мөрөөрөө тонилж, Горбачёв өөрөө либерал-социалист, социал-демократ байр суурь дээр баттай гарч ирлээ. Төрийн эргэлт хийх гэсэнд эгдүүцсэн бүгд найрамдах улсууд түүгээр далимдуулан Холбооны гэрээнээс татгалзлаа. Горбачёвын үүрэг бэлгэ тэмдгийн шинжтэй болж, эрх мэдэл нь Ельцинд аажмаар шилжиж эхлэв. ЗСБНХУ-ын оршин байх эсэх нь цаг хугацааны асуудал болов.

ЗСБНХУ-ын сүүлчийн өдрүүд

1991 оны есөөс арванхоёрдугаар сар бол тус орны түүхийн сүүлчийн зурвас үе билээ. Энэ үе бол анхлан ЗСБНХУ-ыг 1922 онд байгуулсан орнууд - Орос, Украин, Белорусын нэг ёсны хуйвалдааны үе гэж дүгнэсэн ч болно. Горбачёвыг дагалдан Холбооны гэрээ байгуулахыг ам мэдэн дэмжиж байсан эдгээр орон наймдугаар сарын үйл явдлын дараа Горбачёвын хударгаар хуйвалдах замд орсон нь нууц биш. Ямар ч эрх мэдэлгүй болсон Горбачёв, тарж бутарсан Зөвлөлт төр, нэрийн төдий үлдсэн Зөвлөлт засгийн газар (Ерөнхий сайдгүй, улс ардын аж ахуйг шуурхай удирдах хороо, Бүгд найрамдах улс хоорондын эдийн засгийн хороо гэсэн нэртэй) энэ хуйвалдааныг зогсооход хүчин мөхөсдөж байлаа. Слав туургатан энэ гурвын удирдагчид бүх үйл ажилагаагаа аж ахуйн хэлэлцээр байгуулах, Холбооны ирээдүйн тухай ярилцах гэх мэтээр халхавчилж, хэрэг дээрээ нэгдсэн ЗСБНХУ-ыг задлах нууц хэлэлцээнд шилжээд байв. Тэгээд ч наймдугаар сарын хэрэг явдлын дараа Горбачёв тэргүүтэй Төрийн Зөвлөл Балти хавийн 3 улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн тогтоол баталснаараа бусад бүгд найрамдах улсуудын бие даахыг нэг ёсондоо дэмжсэн юм.

Энд ганцхан нэгдмэл холбооны улс задрах тухай асуудал л тавигдаж байсан гэж ойлговол өрөөсгөл зүйл болно. Энэ задралын

цаана Зөвлөлт нийгэм дэх реформ-шинэчлэлийн төгсгөл, коммунист үзэл суртлын бий болгосон тоталитари системийг татан буулгах асуудал босч иржээ. Үүнийг хэн нэгэн ухаантан босгож ирээгүй, нийгмийн хөгжлийн жам хуулиараа гаргаж тавьжээ. Энэ бүхнийг дээр доргүй ойлгож хүлээн зөвшөөрч байлаа. ЗХУ цус урсгалгүй, эсэргүүцэлгүй татан буугдсаны гол шалтгаан үүнд оршино.

Тэгээд ч 1991 оны энэ үед ЗСБНХУ оршин байх нийгэм-улс төр, эдийн засгийн бүх нөөцөө шавхаад байлаа. Ельциний тодорхойлсноор, "Наймдугаар сараас хойш ЗСБНХУ-ын задрах явц сүүлчийн шатандаа орж, амь нь тэмцэж эхэлсэн юм." Бүгд найрамдах улсууд өөрсдийн байдлыг бага ч гэсэн хөнгөвчлөхийн тулд өөрийгөө дангаар аврах, өөрийн хүчээр эрх ашгаа хамгаалах арга хэмжээ авч эхэлжээ. Энэ нь дэлхий дахинд геополитикийн тэнцвэрийг алдагдуулах, хуучин холбооны дотоодод мөргөлдөөн шатлан өргөжүүлэх аюул учруулж байлаа. Нөгөө талаас, ардчилал, шинэчлэлийн үрээр орон нутгууд бие дааж, нэгдсэн төвийн гар харахгүй, заавар зөвлөлгөөг авахгүй оршин тогтнож чадахаар болжээ. Төм жижиг, их багагүй бүх субъект ерөнхийлөгчийн засаглалд шилжиж, бүгд найрамдах улс, автономит бүгд найрамдах улсын хоорондын зааг ялгаа арилжээ. Тэр ч бүү хэл урьд хожид субъект байгаагүй нутаг хүртэл бие даасан улс болох хандлага гарав. Энэ бүхэн зүй ёсны үзэгдэл байлаа. Учир нь эднийг холбон барьж байсан нэгдсэн коммунист намын сүлжээ, захиран-тушаах бүтэц үгүй болсон юм. Харин энэ бүхэн нааштай эхлэл гэхээсээ, уршиг дагавартай аюул болж даамжирсан юм.

Жишээ нь, Оросын холбоонд багтаж, олон жил чив чимээгүй явж ирсэн Умард Кавказын ард түмнүүд хөдөлгөөнд орсон. Наймдугаар сарын үймээн дарагдсаныг далимдуулан Чечень - Ингушт Коммунистуудыг засгийн эрхнээс хүчээр зайлуулж, парламентыг тараан, оронд нь генерал Ж.Дудаев тэргүүтэй үндсэрхэг хүчин засгийн эрх авчээ. Энэ бол санамсаргүй хэрэг биш байлаа. Тэдний ингэж ажиллахад ГКЧП-гийн бүтэлгүйтэл шалтаг болсон юм. Нагорно-Карабахын эргэн тойрны байдал ч ноцтой хурцдав. Угаасаа коммунист үзэл суртал, коммунист нэгдсэн удирдлага үүнийг тогтоон барьж чадаагүй. Одоо бол бүр ч өнгөрсөн хэрэг. Энэ аюул Орос, Кавказ хавь, Крым, Молдовыг илүү заналхийлж, нэгдсэн ЗХУ байх эсэх нь хоёрдугаар зэрэгт тавигдаж, дотроо хэрхэн бүрэн бүтэн үлдэх вэ? гэдэг асуудал цэвшигдэн гарав. Нэгдсэн коммунист тоталитар тогтолцоо нүрахын хэрээр улсууд нэр хаяг, туг сүлд, төрийн дүүллээ өөрчилж, ихэнх нь Үндсэн хуулиа шинэчлэв.

Үүний сацуу зах зээлийн жам хуулиар төвлөрсөн төлөвлөгөөг хилсэн нь ЗХУ-ыг эдийн засгийн хувьд тогтоон барьж байсан орныг мултлав. Зөвхөн төвлөрсөн, захиран тушаах эдийн засагт

зохицон ажиллаж ирсэн тов засгийн газрын үүрэг ондөрлөж, нэгдсэн улсаас үлдсэн аж ахуйн жаал зугаа юмыг хуваах, хуваарилах төдий үүрэгтэй үлджээ. Засгийн газрын бүтцэд ч ихээхэн өөрчлөлт хийхээс аргагүй болов. Хуучин дэглэмийн муу муухайг илчлэх үүднээс аюулаас хамгаалах байгууллагыг өөрчилж, БХЯ-ныг эрх мэдэл, генералитетыг эвдэв. Үүний тод жишээ нь Зөвлөлийн зөвсэгт хүчнийг бүгд найрамдах улсуудын будлианд оролцуулахгүй байх тухай шийдвэр байв. Мөн Горбачев Балтийн 3 улс дахь Зөвлөлтийн арми, дотоодын цэргийн албан хаагчдыг халах зарлиг гаргажээ.

Нэгдсэн улсын гадаад бодлого хаашаа эргэсэн нь ч тодорхойгүй боллоо. Олон улсын гэрээгээр авсан үүргээ биелүүлнэ гэх төдий мэдэгдлээр гадаад бодлогын мухардлыг аргацааж байв. Наймдугаар сарын хуйвалцааны үед унасан гадаад байр суурь, нэр хүндээ өөд татахад хамаг хүчээ хаяв. Энэ үүднээс хаа сайгүй буулт хийж, Өрнөдийн түншүүддээ тал алдахгүйг хичээж байлаа. Үүний сацуу хуучин социалист гэгдэж байсан холбоотнуудтайгаа хамтран шийдэх өдий төдий асуудал хуримтлагджээ. Бие дааж буй өөрийн бүгд найрамдах улсуудтай харилцах гэгч Зөвлөлтийн гадаад бодлогод урьд хожид байгаагүй шинэ чиглэл гарч ирэв. Үүний цаана хэд хэдэн улсыг түгшээх болсон бүс нутгийн мөргөлдөөний шинэ голомтууд, шашин-үндэстний мөргөлдөөн, цөмийн зөвсгийн асуудал сүүмэлзэж байжээ. Энэ бүхнийг шийдье гэхнээ ЗСБНХУ д хүч мөхөсдөж, дотооддоо дэмжлэг илт үгүйлэгдэж байлаа. Нөхцөл байдал ийм ээдрээтэй байсан ч Горбачев нэгдсэн холбооныхоо төлөө итгэлээ гээсэнгүй. Үүнийг аравдугаар сард Алма-Ата хотод гарын үсэг зурсан эдийн засгийн гэрээ харуулав. Энэ бол олон ерөнхийлөгч, олон засаг нэгдмэл нэг улсын дотор бий болсон үеийн анхны баримт бичиг юм. Гэхдээ нэгдмэл улсад жинтэй байр эзэлдэг Украин энэ уулзалтад гэдгэр зангаар ханджээ. Украингүйгээр эдийн засгийн хамтын ажиллагаа байх нөхцөлгүйг тэр үед хэн ч төсөөлөөгүй бололтой. Украины ерөнхийлөгч П.Кравчук ЗХУ-ыг тарааж бутаргахаар шулуудсан мэт (хэрэг дээрээ ЗХУ-ыг задлахын төлөө байв) бүхнийг үгүйсгэн эсэргүүцэх болжээ. Арванхоёрдугаар сар дөнгөж гармагц Украин даяар санал хурааж, хүн амын 90 хувийн дэмжлэгтэйгээр тусгаар тогтнолоо тунхаглажээ. Маргааш нь Орос түүнийг нь хүлээн зөвшөөрөв. Тэднийг Казахстан дэмжлээ.

Энэ бүхэнтэй давхцан Зөвлөлт нийгэмд улс төрийн хагарал цаашаа шатлан өргөжсөн юм. Үйл явдал төсөөлөх аргагүй огцом, гэнэт, цаг хугацааны багахан зайд явагдаж байснаас нийгмийн ихэнх хэсэг алмайрч хоцров. Улс төрийн удирдлагыг авчих улс төрийн дорвитой хүч байхгүйгээс ЗХУКН-ын буурин дээр олон нам хөдөлгөөн гарч ирэв. Энэ бүхэн Горбачев тэргүүтэй либералуудад багагүй садаа учруулав. Хуучинсаг үзэлтнүүд (коммунистууд) наймдугаар сарын хэрэг явдлаар нэр нүүрээ барсан тул цаашид

дампуурах замдаа оров. Хуйвалдаан баларснаар олон коммунист үхлийн шарх олов. ЗХУКН-ын мөнгө-санхүүгийн будлиантай холбогдуулан намын хэд хэдэн хариуцлагатан амиа хорлож, намын архивыг ил болгосноор коммунистуудын паян дэлхий дахинд дэлгэгдлээ. Ингээд тарж бутарсан ЗХУКН-ын суурин дээр зүүний чиглэлтэй гэсэн бүх нам, хөдөлгөөнийг нэгтгэх оролдлого хийж эхэлжээ. Тэд Зөвлөлт гүрэн задарснаас үүссэн нийгмийн хямрал, үнэ чөлөөлснөөс бий болсон эдийн засгийн бүтэлгүйтэл (жишээ нь үнэ чөлөөлөх эхний алхмаар хүн амын хэрэглээ 3 дахин унасан) зэргийг дөрөөлөн өшөө хонзон авах замд оров. Тэдний цаад зорилго нь нэгдмэл социалист гүрнээ сэргээх замаар хямралыг тогтоож, эмх журам тогтоох явдал байв. Улс төрийн либерал, коммунист эдгээр хүчнээс гадна гурав дахь хүч болж, үндэсний -эх оронч, үндсэрхэг нам хөдөлгөөн гарч иржээ. Эд гудамжны популист лоозонгоор халхавчлан нийгмийн сэтгэл зүйг эзэмдэх хортой явууллага хийх болсон нь зохих үр дүнд хүрсэн юм. Энэ тухай Оросын либерал-ардчилсан намын жишээн дээр хожим тодорхой өгүүлнэ. Ийнхүү аль ч талаас нь аваад үзсэн нэгдмэл ЗСБНХУ-ын задрал гарцаагүй болсон байв.

ЗСБНХУ-ын "хойдохыг уншив"

Зөвлөлт оронд бүрэлдсэн ийм эгзэгтэй, зүй ёсны мөчид "Славяны гурвалсан морьтон" (Слав туургатан 3 улсын удирдагч) ЗСБНХУ-ыг булшилсан тамга дарж, лацдахаар нэг дор цугларчээ. Тэр бол 1991 оны арванхоёрдугаар сарын 8-ны түүхэн тэр өдөр билээ. Ельцин, Кравчук, Шушкевич нар Минск-Брестэд цугларч бие даасан улсуудын хамтын нөхөрлөл байгуулснаар шинэ нөхцөлд хамтдаа аж төрж болох цорын ганц боломжийг томъёолжээ. Горбачевын төсөөллөөр Холбооны шинэ гэрээ ЗСБНХУ-ын Үндсэн хуулийг орлох ёстой бол тэр гурвынхаар төсөл нь түүхий, зөрчилтэй гэж үзсэн тэр шинэ гэрээг нь энэ томъёолол гэрээ болж орлох ёстой гэнэ. Ингээд 3 удирдагч "ЗСБНХУ олон улсын хуулийн субъектийн хувьд ч, геополитикийн хувьд ч оршин байх үндэсгүй" болсныг зарлаад, 1922 оны Холбооны гэрээний хүчинтэй байх хугацаа төгсгөл болсныг мэдэгджээ. Оронд нь Бие даасан улсуудын хамтын нөхөрлөл (хожим нь бид ТУХН гэх болсон -Зох) гэгч олон улсын шинэ маягийн нэгдмэл холбоо байгуулна гэдгээ илэрхийлжээ.

Ингээд практик алхам руу шууд шилжив. Энэ 3 бүгд найрамдах улсын парламент Минскийн хэлэлцээрийг зэрэг шахуу баталлаа. Оросын ихэнх нам, улс төрийн хөдөлгөөн хэлэлцээрийг дэмжив. Харин Зөвлөлтийн нийт хүн ам, төв удирдлага, цаашлаад дэлхий нийт цочирдон гайхжээ. Хамгийн түрүүн Горбачев үгээ хэллээ. Тэгээд ч ерөнхийлөгчийн хувьд бүхнээс түрүүн дугарах ёстой. Тэрээр энэ шинэ хэлэлцээрт эдийн засгийн нэгдмэл орон зай бий болгох, санхүү-банкны болон валютын нэгдсэн систем

байгуулах зэрэг нааштай хандлагууд байгааг хүлээн зөвшөөрөөд уг баримт бичиг Зөвлөлтийн ард түмнүүдийн болон дэлхийн хамтын нийгэмлэгийн эрх ашгийг гүнээ хөндөж байна гэж тэмдэглэжээ. Цааш нь Хэлэлцээрт ЗСБНХУ-ыг оршин тогтнохоо больсон гэж шууд зарласныг буруушаагаад, Бүгд найрамдах улс бүр холбооноос гарах эрхтэй боловч олон үндэстний хувь заяаг гуравхан улсын удирдагч шийдэж чадахгүй, энэ асуудлыг бүгдийн оролцоотойгоор, тэдгээрийн ард түмний хүсэл зорилтыг харгалзан шийдвэрлэх ёстой гэж хэлэв. Гол нь энэ баримт бичгээ бүгд найрамдах улсуудын хүн ам, парламентаар хэлэлцүүлэлгүй гэнэт гаргасанд Горбачев эгдүүцжээ. Энэ эгдүүцэл ч хууль зүйн үндэстэй юм. Ер нь аливаа Үндсэн хууль, түүнийг орлох баримт бичгийг бүх ард түмнээр хэлэлцүүлж, дараа нь парламентад хэлэлцсэний эцэст хүчинтэй гэж зарлах ёстой, нөгөө талаас ЗХУ-ын оронд бий болох шинэ холбооны гэрээний төслийг яг хэлэлцэж байх үед ийнхүү гэнэтийн алхам хийснийг бодолцвол Ельцин, Кравчук, Шушкевич нарын ажиллагааг хуйвалдаан, хууль бус гэж үзэх үндэстэй. Хожим нь тал талаасаа боорлуулж, гал мөс хэрэглэх дээрээ тулж байсан нь үүнээс үүдэлтэй гэж ойлгох хэрэгтэй. Бас нэг анхаарах зүйл бий. Хэдийгээр хүч нь суларсан ч ЗСБНХУ гэж нэг төр улс байсан, түүний Ардын депутатуудын их хурал бүрэн эрхийнхээ хугацааг дуустал ажиллах ёстой, их хурлаас сонгогдсон Дээд Зөвлөл энэ бүхний гадна байсанд хэргийн учир оршино. Дээд Зөвлөлийг Их хурал гарах ёстой улс орны оршин тогтнохоо болихыг их хурлын эцсийн шийтгэл гаргаж байж шийднэ. Гэтэл энэ бүхнийг Орос, Украин, Белорус, гурван орнож хийх нь зүйд хэр нийцэх вэ? Ингээд Минскийн гэхирэнцрөөг эсэргүүцсэн ардын депутатууд ээлжит их хурал зарлан хийлгэхээр Москва даяар бөөн шуугиан дэгдээв. Энэ бүхнийг дагалдан юу ч дэгдэж мэдэхээр нөхцөл бүрджээ. Хэрэв Горбачев Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувиар онц эрхээ эдэлсэн бол болох л байсан. Гэвч Горбачевын хүлээцтэй, нөхцөл байдалтай ухаалгаар эвлэрдэг чанар ингүүлээгүй юм.

Минскийн үйл явдлын дараа дэлхий дахин бүр алмайрч хоцров. Ердөө саяхан ГКЧП гэгчийн хор хөнөөлийг дарж, түүний ул мөрийг бүрэн баллаагүй байтал дахиад өөр нэг үзэгдэл гарч ирлээ. Ялангуяа, Өрнөдийн томхон гүрнүүд хэнтэй харилцахаа мэдэхгүй самгардав. Хамгийн түрүүн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга нөхцөл байдлыг тодруулах, тодорхой төсөөлөл авахаар Москвад яаравчлан ирэв. Орос болон шинээр тусгаар тогтносон томхон улсууд, Нэгдсэн зэвсэгт хүчний командлагч нартай бүгдтэй нь уулзахыг тэр хүсчээ. Энэ нь ч аргагүй юм. Учир нь 4 улсын нутагт буй стратегийн цөмийн зэвсэг, Зөвлөлтийн том арми АНУ-ын сэтгэлийг бүхнээс илүү түгшээж байсан хэрэг. АНУ-аас гадна Их Британи, Францын удирдагчид ч шугам шугамаараа Горбачевтой холбоо барьж, учрыг тодруулжээ. Хөрш

Хятадад гаднаа ажрахгүй царайлж байсан ч ЗХУ-ын задрал ихэд бадмагдуулав. Тэд "бидэнд хүртээлгүй, энэ бол Зөвлөлтийн дотоод хэрэг, дотоод хэрэгт нь бид оролцохгүй" гэгцээсэн ч хилийн район, ялангуяа Дундад Азийн шинээр тусгаар тогтнож буй улсуудтай залгаа олон үндэстний Шинжаан-Уйгурын өөртөө засах орноо ихэд анхаарав. Энэ мэт ер нь Зөвлөлтийн задралыг урьдчилан харж, түүнд бэлтгэлтэй байсан орон нэг ч байгаагүй юм. Олон улсын байгууллага ч энэ талаар бэлтгэлтэй байгаагүй нь мэдээж. Ийм нөхцөлд Ельцин бусдаасаа өрсөж тэр үеийг хүртэл ЗХУ-ынх байсан гадаад дахь ЭСЯ, консулын газрууд, худалдааны төлөөлөгчийн газрын бүх өмчийг Оросын өмч гэж зарлажээ. Бусад нь ч үүнийг эсэргүүцсэнгүй. Ельцин уриалга гаргаж олон улсын зарим байгууллагад илгээсний дотор Оросыг НАТО-д элсүүлэх хүсэлт бүхий санал Брюссельд очсон юм. Энэ мэт Орос дангаараа ЗХУ-ыг залгамжлан олон улсын тавцанд гарч ирэх гэж шууд оролджээ.

Ингэхэд Слав туургатан 3 улсын алхамыг бусад нь хэрхэн хүлээж авсан бэ? Шинэ нөхөрлөл маань зөвхөн тэр гурваас бус, ЗХУ-ыг хамтран бүрдүүлж байсан бусад бүх улсаас шалтгаалах ёстой. Энэ асуудлыг 1991-оны арванхоёрдугаар сарын 21-нд Казахстаны нийслэлд шийдвэрлэжээ. ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан 11 бүрэн эрхт улсын тэргүүн нар. ЗХУ-ын БХЯ-ны сүүлчийн сайд Е. Шапошниковын хамт «Минскийн хэлэлцээрийн хавсралт протокол», «Алма-Атын Тунхаглал», «Зөвсөгт хүчний түр командлагчийн тухай зөвлөлтөөний протокол», «Хамтын нөхөрлөлийн зохицуулах байгууллагуудын тухай хэлэлцээр», НҮБ-ийн дүрмийн дагуу хуучин ЗСБНХУ-ын эрх, үүргийг өвлөх эрхийн тухай шийдвэр, Цөмийн зөвсгийн талаархи хамтарсан арга хэмжээний тухай хэлэлцээрт гарын үсэг зурав. Энэ асуудалд оролцохгүй гэдгээ Балтийн 3 улс, Гүрж бүр анхнаасаа мэдэгдэж байснаараа түүний гадна үлджээ. Тэгээд ч Гүржид энэ гэрээнд нэгдэх манатай юм болж, ерөнхийлөгч Гамсахурдиагийн эсрэг зөвсөгт тэмцэл өрнөөд байлаа.

ТУХН байгуулах явц шулуун дардан замаар яваагүйг дээр тэмдэглэсэн. Дахин үүнийг цухас дурдъя. Энэ үед Оросын доторхи автономит эрхтэй Чечень - Ингушийн Бүгд Найрамдах Улс хоёр салж, Чечень тусгаар тогтнолоо зарлаж, салан тусгаарлах замд хэлбэрэлтгүй оржээ. Гүрж өөрөө 3 хуваагдах (Гүрж, Өмнөд Осет, «Абхаз») аюултай нүүрлэж байв. Армен, Азербайжан хоёр ТУХН-ийн гишүүд болсон боловч газар нутаг, шашин-үндэстний мөргөлдөөнөө зохицуулах талаар алхам ч ахиагүй байсан үе. Молдовад мөн ийм явдал лавширч байлаа. Учир нь боломжтой цаг ирвэл Оросын эсрэг лалынхан бус харин цэвэр румын цусны гэгдэх молдовчууд, ЗХУ-д хүчээр нэгтгэгдэн орсондоо гутаж явдаг Балтийн 3 улс босох биз гэсэн эртний таамаглал нотлогдох мэт болжээ. Тэгээд ч хуучин Молдовын ерөнхий сайд өөрөө биечлэн

Молдовыг Румынд нэгтгэх хорооны дарга болж, түүнийг нь таашаагаагүй орос, украинчууд Днестр мөрний зүүн эрэг дээр тусгаар улсаа зарлаж, зэвсэгт мөргөлдөөн дэгдээсэн юм. Молдов дахь Зөвлөлтийн 14-р армийн статусын асуудал ч хурд байв. Мөн Гагаузын туркууд Молдоваас сална гэж зарлажээ. Украин-Крымын харилцаа, Хар тэнгисийн флотын асуудлаар хожим нь Орос-Украины хооронд дэгдсэн маргаан гээд олон асуудал энэ үед буглаад байсан юм. Тийм учраас ТУХН байгуулагдсан цагаасаа элдэв бэрхшээл дагуулж үүсчээ.

/Алма-Атад цугларсан ерөнхийлөгчид ЗСБНХУ-ын ерөнхийлөгчийн хувь заяаг хамтад нь шийджээ. Ойрын үед огцроно гэсэн Горбачевын аман мэдэгдэлд үндэслэн ингэж шийдэхдээ, түүний хойшдын асуудал, эд материалын болон хангамжид хамаатай асуудлыг хөнджээ. Тэр үед бүгд л Горбачевыг хүндэтгэн үздэгээ илэрхийлж, түүний асуудлыг соёлтой шийдэхээ амлацгааж байв. Гэвч маргааш нь шахуу Ельцин хөвлөлд ярилцлага өгөхдөө, Горбачевын үйл ажиллагаанд ТУХН-ын анхны гэмээр дүгнэлт хийсэн юм. Ельцин Горбачевын үйл ажиллагааг хоёр үе шаттай дүгнэсэн байна. Эхний үе нь өөрчлөн байгуулалтын эхэн буюу 1985-1986 он, түүнийг их үнэлдэгээ. Оросын ерөнхийлөгч тэмдэглээд, дотооддоо болон гадаадад ардчиллын төлөө их зүйл хийсэн гэж үзжээ. Ельцинийхээр 1987 оноос Горбачев багагүй алдаа гаргасан аж. Цаг алдаж, эдийн засгийн шинэчлэлийг эхлүүлээгүй, хагас дутуу арга хэмжээ авч байлаа гээд, Горбачевыг огцорсны дараа анхаарал халамж тавих ажлыг Орос өөртөө хүлээнэ гэж Ельцин амлажээ. Ийнхүү ЗСБНХУ-ын анхны бөгөөд сүүлчийн ерөнхийлөгч Горбачев албан тушаалгүй болж, огцров. Энэ бол ЗСБНХУ-ын төр, засгийн бүх бүтцийг татан буулгаж, үүргийг нь Оросын удирдлагад шилжүүлсэн 1991 оны арванхоёрдугаар сарын 25 юм. Энэ өдрөөр ЗСБНХУ-ын түүх төгсгөл боллоо. Ийнхүү гуравхан хүний хуйвалдаанаар олон үндэстний энэ том гүрэн эцэс болжээ.

Эдгээр 3 улс ийнхүү бүхнийг яаравчилж санаачилснаараа нүүрлэж байсан олон аюулыг гэтэлгэж чадсан байж болох юм. Хэрэв ЗСБНХУ-ын аяндаа сүйрэхийг идэвхгүй хүлээж суусан бол бүгд найрамдах улсуудын дотоодын хурцадмал байдал цаашид даамжирч, урьдчилан хэлэхэд хэцүү олон асуудалтай тулгарч болох байсан. Орон нутгийн ба жижиг үндэстний салан тусгаарлах явц өргөжиж байсныг бодолцвол тийм асуудал тохиолдохгүй гэх баталгаа алга байв. Жишээ нь, ЗСБНХУ-ын цорын ганц хууль ёсны залгамжлагч гэж өөрийгөө үзсэн Оросын Холбооны Улс гэхэд л орон нутгуудтайгаа харилцах шинэ маягийн харилцааны шинэ загвар бий болгох ёстой. Үүнээс гадна ТУХН дэх хүчтэй өрсөлдөгчидтэйгээ харилцах, нэг төв, нэг хүний хяналтаас 4 тийшээ салсан цөмийн зэвсгийн хяналтыг цэгцлэх, Өрнөдийн туншуудийн өмнө хүлээх хариуцлага, үүрэг амлалт гээд олон

асуудал эзэнгүй хоцрох байв. Энэ бүхнийг хийж гүйцэтгэх талаар Оросын талд алдаж оносон зүйл их бий. Энэ тухай хожим өгүүлье.

Дүгнэлт

Зөвлөлтийн олон үндэстний ард түмнүүдийн бие даасан байдлын төлөө, бүгд найрамдах улсуудын бүрэн эрхт байдлын төлөө, үүний сацуу холбооны улс, түүний бүрэн бүтэн байдлын төлөө Зөвлөлтийн удирдлага, хүн амын ихэнх нь (70 хувь) зогсолтгүй тэмцэж ирсэн баримт байсаар атал нагаад ийнхүү амархан нурж унаваа? Энэ асуултад бүх юм өөрөөр эргэсэн, үйл нвдлын өрнөлт хөгжилт өөр замаар орсон гэдэг дүгнэлт хиймээр байна. Зохиогч би ч биш, Горбачев өөрөө тэр үед ингэж дүгнэсэн билээ. Хуйвалдсан, цөөхөн хэдэн хүний хүрээнд нууцалж байгаад гэнэт тулгаж тавьсан, ард түмний санал бодлыг сонсоогүй гэсэн үндэслэлтэй би санал нэг байна. Харин нагаад бүх юм өөрөөр эргэв гэдэгт чадах чинээгээрээ хариулъя.

(1) Өөрчлөн байгуулалтын урт зам туулж, маш их эсэргүүцэлтэй тулгарч байж сая нэг өндөрлөлт гарсан яг тэр үедээ Горбачев төсөөлшгүй базаахгүй асуудалтай тулгарчээ. Тэр нь хүлээн авсан эх орон нь байлаа. Дэлхийд хамгийн том газар нутагтай, нефть, шатдаг хий, байгалийн бусад баялгаар гайхуулдаг, шинжлэх ухаан-техник, оюуны болон соёлын потенциалгаар хэний ч дор орохгүй, тэр ч бүү хэл олон салбарт хошуучилж яваа оронд яахаараа ард түмэн нь бусдаас хавьгүй доогуур амьдарч, улам хоцрох болов. Үүний шалтгаан тодорхой бөгөөд Зөвлөлт нийгэм 70 гаруй жил захиран тушаах-хүнд суртлын бахинд хавчигдан баригдсаны үр дүн энэ юм.

(2) Дэлхий дахиныг төмөр хөшгөөр хуваасан "Хүйтэн дайн" Зөвлөлтийн ард түмнийг зэвсэглэлээр хөөцөлдөх хүнд дарамтыг үүрэхээс өөр аргагүй байдалд оруулсан байв. Үүнийг засч залруулахын тулд Горбачев ихээхэн эсэргүүцлийг давж, нийгмийн бүхэл давхаргын (генералитет, цэрэг аж үйлдвэрийн хамслынхан) эрх ашгийг хохироохоос өөр арга байсангүй.

(3) Ерөөсөө Орос орны (хожим ЗСБНХУ-д) түүхэнд заримдаг шинэчлэл хийх гэсэн цөөнгүй оролдлого гарч байсан ч дараа дараалан бүтэлгүйтэж байсан уламжлал бий. Горбачевын хувь тавилан XIX зууны их шинэчлэгч хоёрдугаар Александр хаан, егэнэ алдаж юу ч үгүй хоцорсон Н.Хрущев нартай зүйрлүүлж болохоор юм. Александр хаан Орост хамжлагт ёсыг халсан түүхэн хүн боловч хожим нь амиа хорлуулсан. Хрущев хажуудаа хэн байгааг мэдсээр байж хэт зориглоод өөрийнхөө эсрэг хуйвалдааныг төрүүлдсэн. Энэ утгаар Орост "гай барцадгүй шинэчлэгч байхгүй, хойшдоо төрөхгүй" гэж Горбачев өөрөө дүгнэснийг иш татъя.

(4) Асар их хүч чармайлт, сэтгэлийн тэнхээ, оюуны зориг шаардаж байж хийсэн өөрчлөн байгуулалт нь ЗХУКН, Зөвлөлт төрийн хуучин бүтэц, захиргааны аппарат, үзэл суртлын догм,

тэгшитгэх тэжээлгэх сэтгэлгээ зэрэг соёлт нийгэмд байж таарахгүй, үеэ өнгөрөөсөн хүчин зүйлстэй тулгарч, замдаа саарч зөрчилд орж байлаа. *Оросын болон бусад хоцрогдсон ард түмний улс төрийн соёл доогуур, хүлээцгүй байдал, хулчгар зан ч үүнд дарамт болсон нь эргэлзээгүй. Тийм учраас өөрчлөн байгуулалт өөрөө их цаг алджээ.

5. Эцэст нь наймдугаар сарын тавьтаргүй хэрэг явдал хямралыг дээд цэгт нь тулгажээ. Төр улсын хуучин тогтолцоог халж амжаагүй, шинийг яг зөвөөр төлөвшүүлж эхэлж байтал энэ үймээн дэгдэж, төр улс нэгдсэн холбооны мөхлийг бүр ч хурдасгасан юм. Ингээд Зөвлөлт орон хэтийн төлөвөө алджээ.

Юу хожив? гэдгийн тухайд энд бас хэлэхгүй өнгөрч болохгүй. 1985 онд эхэлсэн ардчилсан шинэчлэл түүхэн үүднээс үнэн зөв үйлс байсныг эхлэн тэмдэглэх ёстой. Яагаад гэвэл:

- Зөвлөлт нийгэм, түүнийг дийлэн нийт социалист систем жинхэнэ эрх чөлөөгөө олж авлаа. Улс төр, оюун санааны тухайд үүнийг бүр ч онцлон тэмдэглэх ёстой. Энэ бол жинхэнэ утгаараа байлдан ололт байлаа.

- Улс орон, нийгмийг анх эрт элбэг дэлбэг, баян цатгалан, цэцэглэн хөгжсөн орон болгох боломжийг олон жил хумиж базсан тоталитари - ганцаар эзлэх тогтолцоог дэлхийн хэмжээнд нураалаа.

Дэлхийн ардмийн замд цомронг (үсрэлт ч гэж болно) хийлээ. Чөлөөт сонгууль, эхнэргийн эрх чөлөө, шүтэн бишрэх үнэмшилтэй байх, засгийн эрх барилцах, олон намын тогтолцоо бодитой тогтлоо. Энд хүний эрхийг эрхэм дээд зарчим гэж хүлээн зөвшөөрсөн нь тэргүүн зэргийн ач холбогдолтой.

- Олон арван жил захиран тушаах - төвлөрөлийн зарчимд тулгуурласан бүлэг орны эдийн засаг зах зээл рүү хандлаа. Энэ утгаараа хүн төрөлхтний нийтлэг жам хууль руу орлоо гэсэн үг.

- "Хүйтэн дайныг" төгсгөл болгож, улс орнуудыг ухаан жолоогүй цэрэгжүүлж, зэвсэглэж байсныг зогсоолоо. Дэлхийн дайн гарах аюулыг зайлуулж чадлаа. Цөмийн зэвсэгт найдвартай хяналт тавих зам нээгдлээ.

- Зөвлөлт болон түүний жишээг дагасан социалист орнууд дэлхий ертөнцөд нээлттэй болж, итгэлцэлийг бэхжүүлж, соёл иргэншлийг хамтдаа авч явах хариуцлагаа зөв хуваалаа.

Энэ бүхнийг базан дүгнэвэл, Горбачевын эхлүүлсэн үйлс ялалт, ялагдлыг нэгэн зэрэг авчирсан юм. Гэхдээ ялалт нь давамгайлах биз ээ. Гагцхүү Горбачевын үйлсийг туйлд нь хүргэж чадаагүй ТУХН-ийн шинэ удирдагчид, тэдний ил далд дайснууд ялагдлыг адилхан хуваалцах учиртай. Энэ зэмлэлийг дараагийн дэд бүлэгт өгүүлэх түүхэн үйл явдлууд нотолж өгнө.

ХОЁР. ЗСБНХУ-ЫГ АВРАХ ЭРЭЛ МУХАРДСАНЫ ДАРАА ЗАМЫН БЭЛЧИРТ (1991-1992 ОН)

Нэгдсэн холбоот улсынхаа халааг авсан ТУХН-ийн гишүүд ямар буурин дээр үлдэв. 1992 гарах босгон дээр ОХУ-ын ерөнхийлөгч ард түмэндээ хандаж шинэ жилийн мөндчилгээ дэвшүүлэхдээ, ЗСБНХУ-ын төгсгөл болсон шалтгаан, түүний дараах Оросын байдлыг тайлбарласан юм. Тэрээр Холбооны шинэ гэрээнд гарын үсэг зурах бодит боломж байсныг хүлээн зөвшөөрөөд, түүнийг нь наймдугаар сарын үймээн баллаж хаясныг дурджээ. ЗСБНХУ тэтгэн буугдсанаар Орос орон ялагдаагүй, харин коммунист үзэл суртал ялагдаж, улс түмэнд тулган хүлээлгэсэн нийгмийн туршилт сүйрчээ. Түүний хэлснээр, Орос орон 1917 онд булаагдсан баялгаа эргүүлэн авчээ. Гэхдээ хүлээн авч буй тэр өв нь үнэхээр сэтгэл гонсоймоор байв. "Манай газар нутгийг дайсан эзэгнэж байсан мэт санагдах юм" гэж Ельцин зүйрлүүлээд, 70 тэрбум долларын өр ЗСБНХУ-аас өвлөн авснаа (1994 онд 120 тэрбум болж өссөн) жишээ болгожээ. Гэхдээ бусад орноос хариуд нь 60 тэрбум долларын авлага авна, ерөөсөө одооноос эхлэн Орос нь бусад оронд туслахыг зогсооно гэж мэдэгдэв.

Ельциний энэ мэдэгдэл санамсаргүй зүйлсээс урган гараагүй. Үнэхээр ЗСБНХУ-ын үлдээсэн бэрхшээлтэй, будлиантай асуудал мөдхөн илэрч, Алма-Атад хэлэлцэн тохирсноо дор дороо шүүмжилж эхлэв. ТУХН байгуулах хэлэлцээр түүнд оролцогчдын үндэсний эрх ашигтай зөрчилдөв. Асуудал шийдэхээр ТУХН-ын төр, засгийн тэргүүн нар шинэ оны босгон дээр Минскт цуглажээ. Тэд хамтын нөхөрлөлийн улс төр, эдийн засаг, цэрэг, шинжлэх ухаан-техникийн харилцааны өргөн хүрээтэй асуудал хэлэлцэв. Төгсгөлд нь 15 баримт бичиг, тухайлбал, стратегийн зөвсөг, зөвсөгт хүчин, хилийн цэрэг, тээвэр, тариф, гадаадаас авсан зээлийг хуваарилах тухай баримт бичигт гарын үсэг зуржээ. Эдгээрээс зөвсөгт хүчний тухай асуудал хамгийн түвэгтэй нь байлаа. Цөмийн зөвсгийг нэгдсэн командлалын мэдэлд үлдээж, ердийн зөвсөгт хүчнийг улс бүр өөрийнхөө хуулиар шийдвэрлэх эрхтэй болжээ. 1994 он гэхэд Украин, Белорусс хоёр нутагтаа буй цөмийн зөвсгийг Орос, АНУ-ын тусалцаатайгаар устгана гэж тогтжээ. Харин Казахстаны талаар годорхой юм зарласангүй.

Уулзалт дээр шийдэх аргагүй асуудал бас гарч ирэв. Тухайлбал, ТУХН-ийн дүрэм батлах талаар юу ч хийсэнгүй, дүрэмгүй болохоор энэ шинэ нөхөрлөлийг холбоо гэх үү, хамтын нийгэмлэг гэх үү, олон улсын хуулийн субъект мөн үү? гэхчлэн олон асуудалд хариу өгсөнгүй. Бас эдийн засагтай холбоотой барим асуудал үлдэв. Тухайлбал, рублийн нэгдмэл бүсийг өөрчлүүцэхгүй гэсэн атлаа хожим нь бүгд түүнийг няцаасан. Хэрэв ТУХН-ийн гишүүн орнууд Оросоос цаасан мөнгө авахгүй бол

рублейн бүс нь хоосон зүйл болж мэднэ гэж сануулж байсан нь хэдхэн хоногийн дараа батлагдсан юм. Учир нь Украин рублийг эсэргүүцэхгүй гэсэн атлаа купон гэгч тасалбар нэвтрүүлэв. Энэ мэт санал зөрөх явдал бишгүй гарч байсан боловч харилцан буулт хийх замаар асуудлыг хурцатгаагүй. Ер нь ТУХН-д байнгын ажиллагаатай нэг байгууллага үгүйлэгдэж байгаа нь илт харагджээ. Ингээд улс бүрийн ГИЯ-ны сайд нар тэр үүргийг гүйцэтгэж байхаар тогтов.

Минскийнгуулзалт явагдаж байх үед дэлхий дахины анхаарал Оросын өмнөд шинэ хөрш Гүрж дээр төвлөрөөд байлаа. Гүрж хэдийгээр ТУХН-д ороогүй ч, аль ч утгаараа энэ шинэ нөхөрлөлийн гадна байх үндэсгүй юм. Тус орон хэдэн сар сөргөлдөж бужигнасны эцэст ширүүн байлдаж, хууль ёсоор сонгогдсон өөрөнхийлөгчөө түлхэн унагажээ. Цэргийн зөвлөл засгийн эрхийг авав. Гүржийн түлхэгдэн унасан удирдагч Абхазын улс байгуулж, байр сууриа бэхжүүлэхээр Сухумид иржээ. Ийнхүү Гүрж бүслэлтийн бае хагаралын байдалд орлоо. Тэндээс бие биеэ үгүйсгэсэн зөрчилтэй мэдээ ирсээр

Залгаад Крымын хойг, Хар тэнгисийн флотын статусын асуудал Орос-Украины маргааны сэдэв боллоо. Крымыг Украины бүрэлдэхүүнд байх өөртөө засах улс гэж зарлав. Украинд 11 сая орос хүн оршин суудгийг бодсон ч энэ маргаан үр дүн авчрахгүй нь мэдээж. Гэвч Кравчукийн гэдгэр зан Ельциний омогтой тулгарчээ. Кравчук Хар тэнгисийн флотыг Украины тус сүлдэнд тангараг өргөхийг шаардсанаас энэ маргаан үүдэв. Ер нь Ельцин мэтийн удирдагчид илүү эрх эдлэх гэвэл Украин Минскийн тохиролцоог хянан үзнэ гэх янзтай мэдэгдэл хийжээ. Бас Украин купон гаргаснаараа Оросын рублийг зах зээлээсээ шахаж, үнэ чөлөөлснөөс үүдсэн Оросын эдийн засгийн хямрал дээр давхар нэрмэв. Үнэ чөлөөлсөн тэр мөчөөсөө эхлэн Орос нь Дэлхийн банк, Олон улсын валютын санд эзсэхээр бэлтгэж эхэлжээ. Үнэ чөлөөлсөн явдал Оросын засгийн газар, парламентын хооронд учир битүүлэг далд тэмцэл эхлүүлэх нэг нөхцөл болжээ. Үнийн өсөлт, амьдралын өртөг ихэссэнийг далимдуулан хонзоглогч хүчин толгойгоо өндийлгөж эхлэв.

Оросын эдийн засгийн хямралаас үүдэн Татарстан, Башкор-тостан зэрэг бие даасан улсууд төвөөс зайлсхийх гэж оролдсон юм. Урал, Сибирь, Алс Дорнодыг Оросоос салгаж Умард Азийн нэгдсэн улс байгуулах санал ч хаа нэгтэйгээс цухалзжээ. Гэтэл Гүржийн бүрэлдэхүүнд байсан өөртөө засах муж - Өмнөд Осет бүгд найрамдах улс болж салан, Оросын нөмөрт орохоор тэндхийн хүн амийн ихэнх нь санал өгчээ. Энэ мэт Орос нэг талаасаа алших, нөгөө талаас нөхөж олох асуудалтай тулгарлаа. Оросын удирдагчид улс орныхоо жинхэнэ эзэд болсны дараа орон нутгаар анжж, үхчиндээ салан тусгаарлах явдлыг намжаахаар оролджээ. Түхийлбэл, парламентын даргын Якутад ирэхэд олон

жил ам нь үдээстэй байсан энэ ард түмэн бие даасан улс болж салах, байгалийн баялгаа өөрсдөө мэдэж зарах тухай шаардаж байсан нь үүний нэг жишээ.

Хэдэн талаасаа мухардаж гацсан Гүржийн шинэ удирдлага улс орноо авч явах боломж тэнхэл илт дутаж байв. Тэд Оростой даруй ойртохыг зорьж, хуучин тус улсын удирдагч байгаад хожим нь Зөвлөлт гүрний ГЯЯ-ыг толгойлсон Шевардназед итгэл хүлээлгэх болжээ. Гэвч энэ орны зардал гарцаагүй болж, ирээдүйд олон асуудалтай тулгарах нь тодорхой болсон байв. Ер нь ЗСБНХУ задарсны дараа самуун дэгдэх аюул хэвээр үлдсэнийг Шевардназе өөрөө тэр үед анхааруулж байсан нь хожим олон үйл явдлаар нотлогдсон билээ.

ТУХН улс хоорондын асуудлыг шийдэх чадвар дутсан нь ийнхүү анхнаасаа харагдаж эхлэв. Ер нь хямрал бэрхшээлийг ерөнхийлөгч нар хичнээн ч уулзаад шийдэж чадахгүй болов. Жишээ нь Кавказын хоёр улсын хооронд Нагорно-Карабахаас үүдэж бүр ЗСБНХУ-ын үед дэгдсэн бүс нутгийн мөргөлдөөн хоёр ерөнхийлөгчийг Алма-Ата, Минскт уулзуулаад шийдэгдсэнгүй. Ингээд зуучлах асуудлыг Азербайжаны ерөнхийлөгчийн хүсэлтээр Иранд тавьжээ. Нөгөө талаар ТУХН-д талцах явдал илэрлээ. Орос-Украины өрсөлдөөн дээр энэ нь илт боллоо. Лалын шашинт улсууд ч энэ хоёрыг дагалдан санал зөрөв. Тэгээд ТУХН-д итгэл алдарсан уу, эсвэл өөр зорилго агуулсан уу, шашин нэгт хөршүүд рүүгээ хандав. Энэ нь бүс нутгийн (Дундад Азийн, Дундад Дорнодын гэх мэт) шинжтэй олон улсын хамтын ажиллагааны (эдийн засгийн 3 байгууллага) хэлбэртэй мэт байсан ч цаанаа Иран, Турк мэт байр сууриа баттай олсон улсыг өөртөө татаж, дэмжлэгийг нь хүлээх санаархлын илрэл гэхээс өөрөөр үзэх аргагүй. 1992 оны хоёрдугаар сард Тегеранд Иран, Турк, Азербайжан, Туркменистан, Пакистан, Узбекистан, Кыргызстан, Тажикистаны дээд хэмжээний төлөөлөгчид оролцсон эдийн засгийн зөвлөлгөөн болсон нь үүний нэг баримт. Боломж гарвал Умард Кавказын лалын шашинтай жижиг улсууд ч энд хамрагдахаас буцахгүй байсан болов уу. Ялангуяа энд Чеченийг жишээлмээр байна. Ингушээс салмагцаа Оросын бүрэлдэхүүнээс гарч тусгаар тогтносноо зарласан Ж.Дудаев тэргүүтэй эрх баригчид бие даасан байдлынхаа төлөө хэнтэй ч эвсэхэд бэлэн байлаа. Гүржийн түлхэгдсэн ерөнхийлөгч Гамсахурдиа Грозныйд ирж, тэдний хооронд өвөрмөц холбоо тогтоосон нь үүнийг бэлхнээ гэрчилнэ. Үүнээс гадна хямралтай байгаа бүс нутагт орон нутгийн хуулийн дагуу Зөвлөлтийн армийн зэвсэг техникийг хуваарилан авч, үндэсний армиудаа байгуулсан нь мөргөлдөөнийг цаашид шатлан өргөжүүлэхэд түлхэц үзүүлжээ. Үүнийг Армен-Азербайжаны дайны явц харуулав. Азербайжаны нутаг дахь Карабахын үндэстний олонхи-армянчууд, Карабахын армийн удирдагчид өөрсдөө Бакугийн засаглалын эсрэг байснаас энэ дайн улам зууралдсан, хонзогносон шинжтэй болжээ. Үүнийг

Карабахын Дээд Зөвлөлийн дарга А.Мкртчяныг хорлосон явдал харуулав.

Зөвлөлтийн армийн зэвсэг техник үрэн таран болох бодит аюултай тулгараад ирмэгц ТУХН-ийн гишүүд хатуу тогтоосон татвараар батлан хамгаалах нэгдсэн төсөв бүрдүүлэх үүрэг хүлээцгээжээ. Гэвч үүнийг Украин гүрүүлж эсэргүүцэв. Нутаг нутагтаа байгаа зэвсэгт хүчний мөрдлөг тус тусдаа даах сэнэл Киевээс тавьжээ. Шилжилтийн энэ эргэлтэй үед ерөнхий цэргийн нэгдсэн хүч байгуулах тухай хэлэлцээрт Армен, Белорусс, Казахстан, Кыргыз, Орос, Туркменистан, Тажикистан, Узбекистан гарын үсэг зуржээ.

Ерөөсөө Зөвлөлтийн армийн хуучин араг яс задарч, тарамдсан учраас Орос армия хамгийн сүүлд эмхлэн байгуулна гэдгээ зарлав. Балти хэвийн улсуудад байрласан цэрэг хамгийн хүнд байдалд байлаа. Учир нь тэдгээр орон хойшид Оросын цэргийн хоол хүнс, гэрэл цахилгааныг даахгүй гэдгээ мэдэгдсэн учраас олон мянган цэрэг, офицер, тэдний гэр бүл, цаашлаад өдий төдий зэвсэг техник, байр сууц хөсөр хаягджээ. Эдгээр бэрхшээлийг үндэслэн Оросын армийг 1 сая 125 мянган хүнтэй мэргэжлийн зэвсэгт хүчин болгон бараг хоёр дахин цөөрүүлж байгуулах төсөл боловсруулжээ. Нөгөө талаар Оросын дотоод байдал эвгүй тийшээ эргэсэн тул ерөнхийлөгч Ельцин ерөнхий сайд, БХН-ны сайдыг өөртөө хавсаргав.

Энэ хугацаанд ТУХН-ын гишүүн орнуудын гадаад дахь байр суурь нэлээд бэхжив 1992 оны гуравдугаар сар гэхэд ЗСБНХУ-аас салсан ТУХН-ийн бүх улс НҮБ-д хууль ёсныхоо суудлыг эзлэв. Украинаас эхлэн бүгд л Европын олон улсын институт руу (жишээ нь НАТО) хандаж эхлэв. Орос, Украин болон Дорнод Европын бусад орны хүсэлтийг харгалзан НАТО-гийн удирдлага тусгай бодлого боловсруулахад хүрлээ. Учир нь урьдын өрсөлдөгч байсан, шилжилтийн үед яваа эдгээр орны өмнө НАТО-г нээхгүй байхаар хатуу шийдсэн юм. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын байгууллагын гишүүн байсан ЗСБНХУ-ын залгамжлагчид бүгд түүнд хамаарах ёстой гэдэг утгаараа Европын 31, АНУ, Канад дээр ТУХН-ийн бүх гишүүд нэгдэж эхлэв. Тэгээд ч ТУХН дэх хямрал бага хурлын гадна үлдэх учиргүй.

ТУХН-ийн гишүүдийн өөр хоорондын цэргийн асуудал будлиантай байснаас 1992 оны гуравдугаар сард Киевт болсон сар тутмын дээд хэмжээний уулзалтаар голчлон аюулгүй байдлын асуудал хэлэлцэв. Тухайлбал, Хамтын нөхөрлөлийн батлан хамгаалах асуудал эрхэлсэн дээд байгууллагуудын бүрэн эрхийн тухай хэлэлцээр, ерөнхий командлалын тухай шийдвэр, нэгдсэн зэвсэгт хүчний үйл ажиллагааны хууль эрхийн үндсийн тухай хэлэлцээр, ийм зэвсэгт хүчин эмхлэн байгуулах зарчмын тухай хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Улс төрийн асуудалд ч цэргийн холбогдолтой асуудал зонхилсон байна. Жишээ нь, улсуудын

харилцаанд хүч хэрэглэхгүй байх, хүч хэрэглэхээр сүрдүүлэхгүй байх тухай конвенц; ТУХН-д энх тайвныг дэмжин сахиулах асуудал эрхэлсэн цэргийн ажиглагчдын корпус, хамтарсан хүчин байгуулах тухай хэлэлцээрийг энд дурдаж болно. Мөн Нагорно-Карабах, Молдовын доторхи Днестр мөрний хавийн улс төрийн асуудлыг сэтгэл түгшин хэлэлцэв. Учир нь тэнд онц байдал тогтоогоод байсан юм. Үүнээс үзэхэд ТУХН өөр хоорондынхоо харилцаанд энх тайвныг сахиулах хүч хэрэглэх болтлоо хурцдаа юу гэлтэй. Энэ бол ноцтой байдлын илрэл.

Яг энэ үетэй давхцан Татарстанд бүх нийтийн санал хураалт явуулж Оросын бүрэлдэхүүнд байх уу, үгүй юу гэдгийг сорьсон айхтар асуудал гаргаж иржээ. Өрх тусгаарлаад хэдхэн сар болж байсан Орост энэ нь том цохилт өглөө. Татарстаны жишээгээр замнах олон улс, бүс нутгийг тогтоон барих гүлхүүр нь ОХУ-ын Холбооны гэрээ байгуулах явдал гэж—Москвад үзэж байлаа. Буриад, Тува, Халимаг, Якут зэрэг олон жил таг чиг байсан алслагдсан нутаг нэр усаа солих, ерөнхийлөгчийн засаглал тогтоох зэргээр дор дорoo хөдөлж эхлэв. Энэ бүхнийг харгалзан ОХУ-ын Холбооны гэрээнд гарын үсэг зурахыг яаравчлав. Гэрээг бүтэн жил хагас боловсруулж 1992 оны дөрөвдүгээр сар гэхэд бэлэн болгожээ. Ингээд ОХУ-ын бүрэлдэхүүнд ордог бүгд найрамдах улс, хязгаар, өөртөө засах тойрог, мужуудын байгууллага, засаг захиргааны байгууллагын эрх мэдлийг зааглан тогтоосон энэхүү шинэ гэрээнд 18 бүгд найрамдах улс гарын үсэг зурж, Татарстан, Чечень хоёр татгалзав. Татарстан Оростой тусад нь гэрээ байгуулах бодолтой байв. Ингэж байж нэг юм Орос орны хагаралыг тогтоох шиг болов.

Гэтэл ТУХН-ийн орнуудын анхаарал Тажикистан руу хүйлраад явчлаа. Юу болов гэтэл засгийн эрхийг буруу шийдсэнээс (1991 оны намар засгийн эрхийн төлөө бужигнах үед коммунистууд ялж, Брежневийн гвардын ахмад зүтгэлтэн Р.Набиевыг ерөнхийлөгч болгосон байлаа -Зох) засгийн эрх баригчид ба сөрөг хүчний хооронд том хагарал гарчээ. Жагсаал цуглаан, өлсгөлөн, суулт эх захаа алдаж, олон сараар сунжрах төлөвийг олжээ. Энэ бүхний уршиг хожим гарсан билээ. Онц байдал тогтоосон Молдов ч анхаарлын гадна үлдсэнгүй. Орос, Украин, Молдов, Румыны ГЯА-ны сайд нар Кишиневт цугларч, Днестрийн мөргөлдөөнийг хэлэлцэв. Анхандаа олигтой шийдвэр гаргаж чадсангүй, гэвч хэдэн өдөр уйгагүй хэлэлцээний эцэст гал зогсоох болжээ. Харин энэ нь удаан үргэлжилсэнгүй. Тавдугаар сар гэхэд Оросын 14-р арми оролцсон томхон мөргөлдөөн болж даамжирлаа.

Тавдугаар сар гараад Тажикистаны байдал ноцтой хурцдав. Босогчид (сөрөг хүчнийхэн) ерөнхийлөгчийн ордон, телевизийн төвийг дайран эзэлж, зэвсэгт мөргөлдөөн дэгдээжээ. Тавдугаар сарын 7-нд Бүгд Найрамдах Крым Улс тусгаар тогтнолдоо тунхаглав. Үүнийг Оросын зарим хүчин далдуур дэмжиж, Украины

парламентаар Крымын шинэ статусыг хүлээн зөвшөөрүүлэхээр оролдов. Крымын тусгаар тогтнолыг тунхагласан нь Украины нутаг дэвсгэрт халдсан хэрэг гэж Украины тал үзээд, үүнийг Үндсэн хуульд харш гэж зарлажээ. Эндээс Крымын эмгэнэлт жүжиг эхэллээ. Крымын тусгаар тогтнолыг Оросын улс төрийн удирдагчид янз янзаар хүлээн авав. Жишээ нь, Оросын Дээд Зөвлөлийн дарга Р.Хасбулатов үүнийг хууль бус гэж нэрлээд, Оросоос Украинд газар нутгийн асуудал тавихгүй, Крым бол Украины хууль ёсны нэг хэсэг мөн гэж мэдэгджээ. Крымын дараа Хар тэнгисийн флотын асуудал Орос, Украин, Гүржийн маргааны сэдэв болж дахин даам-жирлаа. Украин (Үүнээс гадна Белорусс, Казахстан) тактикийн цөмийн зэвсэгээ Орост тушаасан боловч флот, түүний зэвсэглэлийг хөндөхгүй байхыг оролдов. Гэтэл Гүрж 320 км эргээр Хар тэнгистэй хаяа нийлдэг, бас анх Зөвлөлтийн флотыг босгоход үндэсний орлогоосоо өгсөн гэдгээр зохих хувь хүртэхийг хүсчээ. Ингэж асуудалд хандвал Гүржийн Абхаз ч Хар тэнгисийн эрэгт оршдог, бас флоттой байх ёстой л гэх байх. Ингээд энэ маргаантай асуудлаар Крымд бага хурал хийх дээрээ тулжээ.

Тавдугаар сарын хорьдоор Азербайжанд болсон сонгуулиар ялалт байгуулсан Ардын фронт, түүний тэргүүн, хожмын ерөнхийлөгч А.Эльчибэй гэгч түрүүчийн ерөнхийлөгч А.Муталибовын гарын үсэг зурсан ТУХН-ийн хэлэлцээрийг хүчингүй гэж үзэн, тус улс энэ нөхөрлөлөөс гарах тухай зарласан нь, бүхнийг цонхосон хэрэг боллоо. Тус орны парламент ч уг хэлэлцээрийг батлаагүй байсан нь ингэж мэдэгдэх шалтаг болжээ. ТУХН-гишүүн орнууд жинхэнэ бие даасан шинжтэй биш учраас ерөөсөө энэхүү хамтын нөхөрлөлийг хүлээн зөвшөөрөхгүй гэж Эльчибэй хэлжээ. Ийнхүү тус орон ТУХН-ийн бүрэлдэхүүнээс, хэрэг дээрээ хяналтаас гарвал Карабахын дайныг зохицуулах асуудал хүндэрч мэдэх аюултай. Карабахаас гадна Армен, Ираны дунд хавчуулагдсан Нахичеваны өөртөө засах улс гэж орон нутгийн нэг нэгж бий.

Гүржийн байдал ч сэтгэл түгшмээр боллоо. Гүржээс салж Оросын ивээлд орох гэсэн Өмнөд Осет зэвсэгт мөргөлдөөний талбар болов. Оросын бүрэлдэхүүнд байдаг Умард Осеттэй нэгдэх гэсэн өмнөдийнхний оролдлого ингэж байлдах шалтгаан болжээ. Ялангуяа зургадугаар сард Цхинвали хот хавьд Гүржийн арми болон салан тусгаарлагчдын хооронд ширүүн байлдаан болжээ. Гүржийн Төрийн зөвлөлийн дарга Э.Шевардназе энэ хэрэгт Орос буруутай гэж үзэв. Тэгээд ч хэлэлцээний ширээнд ширээнд Гүрж, Орос хоёр суужээ. Дагомыст Ельцин, Шевардназе нар гал зогсоох хэлэлцээр байгууллаа. Түүний дагуу байлдаж буй газар энх тайвныг сахиулах Орос, Гүрж, Осетийн нэгдсэн хүчийг оруулах, байлдаанд нэрвэгдсэн газрыг сэргээн босгохоор тогтжээ. Ийнхүү ТУХН-ийн дотордод энх тайвныг сахиулах ажиллагаа эхэллээ. Дараахан нь Ташкентэд болсон ТУХН-ийн гишүүн орнуудын БХЯ-ны сайд нарын уулзалтаар нөхөрлөл дэх халуун цэгүүдийн байдлыг

• шалтгаал, тэнд энх тайван тогтоохын тулд цэргийн ажиллагааныг
• хэрэг биелүүлж илгээхээр тогтов. Хэдэн сарын турш цус урсгалтай
Молдави энд хамгийн түрүүн оржээ. Осетийн байдал намжиж
байтал Гүржид нөгөө талаас нь бэрхшээл гарч ирлээ. Дөлдугаар
дэвсгэлийн хорьдоор Сухумид Абхазын Дээд Зөвлөл чуулж, Гүржийн
хуулийг хүчингүй болгож, Абхазыг бүрэн эрхт улс гэж
• заруулав. 1925 оны Үндсэн хуулиа сэргээжээ. Үүнийг Гүрж хүчингүй
• хийж үзвэл, өөр арга хэмжээ сэджээ. Ийнхүү олон талаасаа ацан
• авчирч орсон Гүрж Оросын талын хүчтэй шахалт, хөндлөнгийн
• оролдлоотой тулгарч мэдэхээр боллоо. Энэ бүхнийг олон улсын
• байр сууриа бэхжүүлж, дэлхий хамтын нийгэмлэгтэй харилцан
• ажиллаж байж л шийдэх ёстой. Ингээд наймдугаар сар гараад
• ажилла сэргээсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар Гүржийг
• НҮБ-д элсүүлжээ. Наймдугаар сарын хорьдоор Гүржийн цэрэг
• Абхазад орж хяналтаа тогтоожээ. Бүтэн гурван жил ужигран
• хямралын эцэст Гүрж-Абхазын томхон дайн эхлэх бүх нөхцөл
• бүрилээ. Бөдүгээр сард Гүрж, Тажикистанд байдал чинээндээ
• гүншлэн хурцаджээ. Мөргөлдөөнд тэндхийн Оросын цэргийг татан
• оруулахыг ч хэдэнтээ оролдов. Тажикистанд сөрөг хүчнээс төрийн
• эрхлэлт хийх гэсэн оролдлого гарсныг дарж авлаа. Гэвч
• франкийлогчөө олцуулж байж үүнийг хийжээ.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын
• дүгнэлтээр Карабахын асуудлыг зохицуулах олон улсын бага хурал
• хийхээр 11 орон санаачилжээ. Их гүрний хувьд Орос, АНУ, Франц,
• Германи нь түүний санаачилгыг авчээ. Карабахт гал зогсоох
• асуудлыг Австри, Их Британи, Унгар, Канад, Нидерланд, Польш,
• Швейцарийн цэргийн мэргэжилтнүүд хэлэлцэж байв. Энэ бол
• Кавказ дахь дайн ямар шатанд хүрсэн, түүнд дэлхий дахин хэр их
• өртөг түгших болсны хөдлөшгүй нотолгоо болов. ТУХН болон
• хуучин Югославын нутагт болж буй дайн хяналтаас гарч, түүнийг
• НҮБ зогсоож хүчрэхгүйн улмаас Европын зөвсөлт хүчин байгуулж
• хямралыг хүчээр дарж авах саналыг Франц тавьжээ. Ялангуяа,
• Сариево хавьд НҮБ-ын олон цэргийн албан хаагч алагдах буюу
• баригданд орсон байв. Ийм аюул ТУХН-ийн хямралтай нутагт
• гарахгүй гэх баталгаа байхгүй. Учир нь 1991-1992 онд хуучин ЗХУ-
• д 10 орчим томхон зөвсөлт мөргөлдөөн гарч, 70 орчим удаа зөвсөлт
• заригдах дээрээ тулсан маргаан дэгджээ. Эдгээрээс Кавказын ар
• (умард) өвөрт болж буй мөргөлдөөн, Тажикистан хамгийн ноцтой
• нь бишлээ. Оросын бүрэлдэхүүнд байдаг Ингуш (Чечениас салсан),
• Умар Осет хоёрыг хамарсан эмх замбараагүй байдал үндэстэн
• хоорондын мөргөлдөөн, хүчирхийлэл хэрээс хэтэрсэн тул Оросын
• ерөнхий дэглэгийн зарлигаар тэнд онц байдал тогтоожээ.
• Тажикистан дотоодын байдал даамжирсаар хөрш Афганистантай
• хүчлэгдлээ. Засгийн эрх авч чадаагүй сөрөг хүчнийхэн бөөнөөрөн
• үйлдвэрлэж, тэнд зөвсөглөн эргэж дайрах бэлтгэл хийжээ. Энэ
• байдал ил өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Засгийн эрхийн

асуудлыг хүн амын бүх дэвхэргэ, шашин шүтлэг үндэстний зан заншилыг харгалзалгүй Зөвлөлтгийн үеийн аргаар шийдсэний хор уршиг ийнхүү гарчээ.

ТУХН-д үүссэн маргаан, бүс нутгийн чанартай мөргөлдөөнийг (1992 оны байдлаар) доорхи хэд хэдэн ангиллаар авч үзэхэд болохоор байна. Үүнд:

- Түүхэн маргаантай нутаг дэвсгэрээс үүдсэн мөргөлдөөн Үүний тодорхой жишээ нь Нагорно-Карабах;
- Үндэстний олонхи болон үндэстний цөөнхийн хооронд дэгдсэн мөргөлдөөн. Үүнд Молдов дахь орос, украин цөөнхийн асуудал, Балтийн улсууд дахь оросуудын хавчигдмал байдлыг жишээлж болно;
- Нутаг дэвсгэр хил хязгаарыг хүчээр өөрчилснөөс үүдсэн мөргөлдөөн, Крымын хойг, Нагорно-Карабах, Гүрж бүгд л энд орох болов уу;
- Ард түмнүүдэд өөрийн гэсэн төр улс байхгүй буюу байсан нь ор нэр төдий явж ирснээс үүдсэн мөргөлдөөн, энд хамгийн түрүүн Чеченийг нэрлэж болох байх, цаашлаад Умард Кавказаар нутагладаг үндэстнүүдийг оруулж болох юм;
- Үндэстэн ястаныг уугуул нутгаас нь хүчээр хөөн зайлуулсан буюу газар нутгийг нь ийш тийш нь хамаагүй хэсэглэн хувааж, тарааснаас үүдсэн мөргөлдөөн. Энэ балмад хэргийн хамгийн том жишээ бол 1944 онд Сталины явуулсан нүүлгэн шилжүүлэх бодлого. Энд ганцхан Крымын татарууд, месхетийн туркууд өртсөн биш, Дундад Ази, Сибирьт хүчээр цөлөгдсөн бүх үндэстэн ястан орно.
- Эцэст нь омог аймаг-нутаг усны нутгархах явдлаас үүдсэн мөргөлдөөн. Энд Тажикистан хамгийн том жишээ. Ийм мөргөлдөөнийг шашны асуудал бас дагалддаг.

Ингэж ангилах нь бодит байдалд хэр нийцэхийг уншигчид тунгаах биз ээ. Зохиогчийн хувьд энэ бүхнээ нөгөө талаас нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэсэн боловч хянаж зохицуулж болох, хяналтаас бүрэн гарсан, хүч хэрэглээгүй хий мэтгэлцсэн гэсэн өөр нэгэн хэлбэрээр ангилж болох мэт санагддаг.

Ажиглагдсан бас нэг зүйл бол 1992 он гэхэд ТУХН-ийн гишүүд, ялангуяа, хүч дутмаг, мөргөлдөөнд олонтаа нэрвэгдсэн улсууд дотоод гадаадаас элдэв холбоотон хамсаатан хайх бөлеон явдал юм. Талцах, лалынхан хөрш орнууд руугаа хандах болсон жишээг дээр дурдсан. Балтийн Эстон, Латви хоёр Скандинавын орнууд руу, Литва, Белорүсс Польш руу, Молдов Сумын руу, Украин Унгар, Польш, Чех, Словак, Румын руу, Азербайжан Иран руу, Дундад Азийнхан Турк, Хятад, лалын ертөнц рүү идэвхтэй

дипломат бодлого явуулах болсныг үүнтэй холбож төгөж бодсон. Хэрэв ингэж холбоотны харилцаа тогтоож чадвал Орос нь өрнө дорноос газар зүйн хувьд тусгаарлагдаж, тэдний хооронд хамтран нүс ("зөөлөвч") үүсч болох юм. ТУХН нь гишүүддээ аюулгүй байдлын ямар ч баталгаа болохгүй юм шиг дүр зураг өгч өгч харагдана.

Энэ мэт бүс нутгийн асуудал, гишүүн орнуудын аюулгүй байдал, түүнийг зохицуулах цэрэг-стратегийн асуудлаас үүдэн ТУХН дэх хамгийн том хоёр гишүүн-Орос, Украины хооронд учир битүүлэг зөрчил үүссэн нь 1992 онд тодорхой болсон юм. Энэ зөрчил хоёр улсын хоорондын харилцаанаас хальж бусад гишүүддээ нөлөөлөх хэмжээнд очсон нь бүр ч хамгийн аюултай байлаа. Тухайлбал, ТУХН-ийн аюулгүй байдлын нэгдмэл орон зайн нөлөө гэсэн хэсэг улс (Азербайжан, Молдов, Узбекистан, Туркменистан) Украиныг дэмжиж, хоёр талын үндсэн дээр цэрэг-стратегийн харилцаагаа тодорхойлох бодолтой нь Оросыг дагажээ. Оросын цэргийн оролцоотойгоор асуудлаа шийдүүлэх хүсэлтэй, эсвэл нутагт нь Оросын цэрэг-стратегийн нөлөө хэт их Армен, Казахстан, Кыргызстан, Тажикистан энэ бүлэгт оров. Харин Белорусс аль алианаас нь түдгэлзэж, үүгээрээ Оросын найдварыг үхүүлжээ. Ельцин, Кравчук нарын маргаанаас үүдэн Оросын тал Москва-Минск-Алма-атын эвсэлэрхүү юм бий болгох замаар Украины гэдгэр занг дарж авах гэсэн нь ийнхүү замхрав бололтой. Үүний сацуу Узбекистан гуйван дайвж аль алинд нь тал алдахгүйг хичээж баахан цаг үрсэн юм. Ингэж талцсаны дараа өөрийг нь дэмжээгүй орны эсрэг эдийн засгийн хориг тавих оролдлого гарсныг энд бас хэлэх ёстой. Энэ бол ТУХН-ийг хямруулах бас нэг шалтгаан. Жишээ нь цэрэг-стратегийн асуудлаар Оросыг дагаагүйд хилэн нь бадарч, тэвчээр барагдсан Орос нефть шатахуунаа дэлхийн зах зээлийн үнээр худалдахаар шийдсэн юм. Үүнийг эдийн засгийн дарамт үзүүлэх оролдлого гэхээс өөрөөр юу гэх билээ.

ГУРАВ. ОРОС: УЛС ТӨРИЙН ХЯМРАЛЫН ЗАМД (1991-1994 ОН)

КБНХУ-ын задрал Орост юу авчрав? Өөр хоорондоо ижил төсгүй үндэстэн ястныг нэгтгэсэн нэгэн том бүтэц үлджээ. Үүний цаану нүүрлэж буй нэгэн том аюулын тухай түрүүчийн бүлэгт зах зухааг мн. дурдсан. Энд бичигдээгүй орхигдсон буюу олон улсад харилцаанд хамааруулж бичих өөр нэг ноцтой сэдэв байгаа. Тэр бол дээрхи гарчигтай холбогдоно. Учир нь Орос орны дотоодын үн: төрийн амьдрал сүүлийн хэдэн жил дэлхий нийтийн анхдартлын төвд байж ирсэн, Өрнө-Дорно, Орос-АНУ-ын харилцаа

зээл тусламж, Оросын шинэчлэл реформыг дэмжих явдал үүнтэй салшгүй холбоотой, бас ТУХН-ийн байгалийн, стратегийн түүхий эдийн нөөцийн (нефтийн 90 хувь, байгалийн хийн 80 хувь, эрчим хүчний нөөцийн 65 хувь, цэвэр алтны ордны 60 хувь) ихэнхийг хянадаг гэдэг утгаар энэ асуудлыг тойрч гарамгүй байна. Би хувьдаа энэ асуудал олон улсын шинэхэн харилцаанд томхон байр эзлэх байх гэж боддог. Тэгээд ч 1991 оны найм- дугаар сарын тэр хэрэг явдлын үеийн Оросын улс төрийн уур амьсгал түүнээс хойшхи хоёр жилд санаанд багтамгүй хувьсан өөрчлөгдөж, дүгнэж цэгнэхэд амаргүй нөхцөл байдал удаа дараа бий болгож байсан. Үүнд олон улсын харилцаа судлаачид, улс төрчид тэр бүр бэлэн байгаагүй. Тэр хэрээр нэлээд балмагдаж, сандарч байсан үе ч бий. Тэгэхээр энэ тухай зөв ч, буруу ч өөрийн төсөөллөө баримтад тулгуурлаж энд бичлээ.

Улс төрийн сэргэлдөөний түүх

ЗХУ-ын задралын өмнөх Орос орон нэгдмэл, удирдлага нь бат цул нэгдэлтэй байгаа мэт сэтгэгдэл 1991 онд хүн болгонд төрсөн. 1990 онд Ельцинг Оросын парламентын даргаар сонгож байхад, Орост хэн хамгийн их эрх мэдэлтэй байсан бэ? гэдгээс эхэлбэ. Мэдээж хэрэг Ельцин. Гэтэл түүнтэй хожим сэргэлдэх замд орсон улс тэр үед хаа байв. Тэднийг олон нийт таньж мэдэхгүй байхад Оросын Дээд Зөвлөлийн дарга Ельцин тийм нэгэн танихгүй хүн Хасбулатовыг баруун гараа болгосон юм. Дараа нь 1991 оны хавар Ельцин ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхдөө А.Руцкойг дэд ерөнхийлөгчөөрөө дэргэдээ авсан. Энэ хоёр хоёул Ельциний хүчинд улс төрийн тавцанд гарч ирсэн, Ельцин байгаагүй бол түүхэнд Хасбулатов ч, Руцкой ч төрөх байсныг хэн ч мэдэхгүй. 1991 оны наймдугаар сарын тэр өдрүүдэд энэ гурав Цагаан ордныг хамгаалж, хамтран тэмцсэн. Тэр ч бүү хэл Руцкой Цагаан ордны хамгаалалтыг сайн зохион байгуулсан учраас генерал цол шагнуулсан. Эргэлт хийх оролдлого нурсны дараа Цагаан ордонд Ельциний халааг Хасбулатов авч, Ельцин ерөнхийлөгчийн хувиар Кремль рүү нүүж, эндээс эхлэн тэдний улс төрийн зам салжээ.

ЗХУКН-ыг тараасны дараа шинээр үүссэн зүүний чиглэлтэй намуудын нэг бол Руцкойн удирдсан "Чөлөөт Орос" хэмээх Ардын нам билээ. Уг нь ЗХУКН дахь нэг жигүүрийг салгаж удирдахыг оролдож байсан үе Руцкойд бий л дээ. Гэвч тэгж амжилгүй намаа тараалгачихсан. Түүнийг шинэ нам Ельцинг хэлбэрэлтгүй дэмжиж байсан бөгөөд ЗХУН-ыг тараахын төлөө Украин, Белоруссын удирдагчидтай хуйвалдаж байхад нь 100 хувь санал нэг байв.

Гэтэл эв нэгдэлтэй байсан 3 удирдагчийг. Егор Гайдар гэгч гарч ирээд гэнэт "дайсагнуулж" орхижээ. Ельцин 1991 оны арав-дугаар сард радикал эдийн засагч Гайдарыг засгийн газрын бүрэлдэхүүнд оруулж, эдийн-засгийн реформ хийх онц эрх олгосноор энэ дайсагналцал эхэлжээ. Орост ихэнх үнийг чөлөөлж

хоцорсон төлөвлөгөөг халах явдал эхэллээ. Хасбулатов эдийн засгийн эрс шинэчлэлийг эсэргүүцэхийн хамт улс төрийн хүчирхэг машин бий болгохыг зорьжээ. Руцкой бас түүнээс хоцорсонгүй, өөрийн үүрэгт хамаарахгүй олон асуудалд хутгалдан орсон юм. ИХУ гарсны дараа энэ хандлага бүр ч илэрхий болжээ. Реформыг шалтгаан бий болсон бүх бэрхшээл зөвлөн ерөнхийлөгч ба түүний өргүүлсэн засгийн газар руу дайрах аятайхан шалтаг болж өглөө. Ийнхэд Ельцинг зайлуулах асуудлыг сэджээ. 1992 оны дөрөвдүгээр сард Хасбулатовын удирддаг Ардын депутатуудын их хурал (Зөвлөлтийн үеийн) ерөнхийлөгчийн эсрэг байр сууринд баттай шилжлээ. Хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын зөрчил ийнхүү ажлжээ. Их хурал ерөнхийлөгчийн хууль гаргах эрхийг хасах, Гайдарыг огцруулахыг оролдоод бүтсэнгүй, харин Ельцинг бүр ч зоримог алхам руу түлхэж, хоёр сарын дараа Гайдарыг ерөнхийлөгчид үүрэг гүйцэтгэгчээр томилов. Гайдарын засгийн газар реформын зорилгоосоо ухрахгүй байлаа. Гэвч засгийн газраа дэмжих талаар Ардын депутатуудын их хурал, Дээд Зөвлөл юу ч хийгээгүйгээр үл барам ерөнхийлөгчийг халах мугуйд байр сууринаасаа салахгүй зүтгэж байв. Эдэнтэй Руцкой бодон үйлсэрхэг, хуучинсаг, коммунист бүх хүчин эвсэж эхэлжээ.

Тэмцлийн үргэл нь 1992 оны арванхоёрдугаар сар боллоо. Их хурал Ельцинд шахалт үзүүлж чаджээ. Гайдарыг огцруулж, оронд нь Зөвлөлтийн үеийн аж үйлдвэрийн удирдагчийн сонгодог дүр В.И. Курномырдинийг томилов. Гэвч тэр ерөнхийлөгчид үнэнчээ нотлов. Харин Ельцин их хурал дээр давилуун зоримог байдлаасаа ухарч, буулт хийхэд хүрчээ. Энэ өдрийг хүртэл Орост ерөнхийлөгч үү, эсвэл парламент уу? гэсэн бичигдээгүй тэмцэл өрнөж байсан бөгөөд алийг нь вэ гэдгээр бүх нийтийн санал хурдалт явуулахаар тогтжээ. Уг нь бүх ард түмний сонгуулиар сонгогдсоны хувьд Ельцинг Хасбулатов мэдэж огцруулах аргагүй. Үүнийг дахин шалгая гэсэн бололтой.

1993 он гараад Ельциний байр суурь алхам алхамаар суларсаар байлаа. Ельциний санал болгосон бүх нийтийн санал хурдалтыг гуравдугаар сард Их хурал үл тоомсорлож, эрх мэдэл хувиарлах тухай тохиролцооноосоо ухрав. Энэ өдөр олон хүн Ельцинг огцрох нуу гэж бодсон нь талаар болж, хэд хоногийн дараа ерөнхийлөгч өөртөө онц эрх олгожээ. Ийнхүү Ельцин тулгаж өдийг санал хураалт явуулах боллоо. Түүнийг дэмжих дэмжихгүй тийлэр засгийн газар хоёр хуваагдаж, Руцкой ерөнхийлөгчийн эсрэг эргэснээ нотлон харуулав. Ельцин түүнийг огцрохыг шаардлаа. Мөн сарын сүүлээр байдал чинээндээ туллаа. Санал хурдалт явуулах саналаасаа ерөнхийлөгч түдгэлзэж, арваннэгдүгээр сард парламент, ерөнхийлөгчийн сонгууль хийх талаар Хасбулатовтой тохирохыг уриалав. Их хурал түүнийг няцааж, Ельцинг огцруулах асуудлаар бүх нийтийн санал хураахаар тогтоо. Ийнхэд эцсийн үгийг ард түмэн сарын дараа хэлэх болжээ. Тэн

Ельциний хувь заяа төдийгүй Орос дахь реформын бодлого, шинэ Үндсэн хууль батлах эсэхийг нэгэн зэрэг шийднэ.

1993 оны дөрөвдүгээр сарын 25 Бүх нийтийн санал хураалтаар Ельцин ба түүний талынхан ялсан нь маргаангүй боллоо. Шинэ Үндсэн хууль батлах, парламентын шинэ сонгууль явуулах зам нээгдлээ. Оросын хүн амын ихэнх нь реформыг дэмжжээ. Гэтэл зөрүүд гөжүүд Руцкой, Хасбулатов нар санал хураалтын дүнг хүлээн зөвшөөрсөнгүй. Ельцин нэгэнт олонхийн дэмжлэг авсан тул Шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулахыг даалгаж, Үндсэн хуулийн ассамблей сарын дотор түүнийг нь бэлэн болгожээ. Тэр зундаа Оросын улс төрийн тэмцэл түр намжив. Гэтэл намар нь дээд цэгтээ тулж, бүх зүйлийг нэг тийш болгож өглөө. Есдүгээр сард Ельцин Руцкойг, Дээд Зөвлөл Ельцинг огцруулсан шийдвэр гаргажээ. Ельциний дэмжлэг хүлээсэн Гайдар дахин засгийн газрын бүрэлдэхүүнд оров. Орост парламентын шинэ сонгууль явуулахыг Дээд Зөвлөл зөвшөөрвөл Ельцин ерөнхийлөгчийн сонгуулийг хугацаанаас нь өмнө хийх санал дэвшүүлтэл цаадуул нь эрс эсэргүүцжээ. Аргаа барсан ерөнхийлөгч есдүгээр сарын 21-нд Ардын депутатуудын их хурлыг тарааж, шинэ сонгууль арванхоёрдугаар сард хийнэ гэдгээ зарлалаа.

Тараах шийдвэрт эгдүүцсэн Дээд Зөвлөлийн депутатууд Руцкой, Хасбулатов нарын удирдлага дор зэвсэгт үймээн дэгдээх замд оржээ. Үймээний хоёр 7 хоногийн үед Руцкой өөрийгөө ерөнхийлөгч гэж өргөмжилжээ. Аравдугаар сарын эхний хэд хоног 1991 оны тэр өдрүүдийнхээс илүү огцом, хүч үзсэн байдалтай өнгөрөв. Оросын арми хүч хэрэглэн Цагаан ордныг буулгаж авлаа. Үймээний толгойлогчид баривчлагджээ.

Ийнхүү нэг талаас Ельцин тэргүүтэй ардчилсан шинэчлэгчид, нөгөө талаас түүний орлогч асан Руцкой, Хасбулатов нарын толгойлсон хуучныг баримтлагч парламентын хоорондын тэмцэл зэр зэвсгийн хүчээр төгсгөл болжээ. Ельцин нэг дайснаасаа салж авлаа. Одоо түүний улс төрийн байр суурийг арванхоёрдугаар сарын сонгууль бэхжүүлэх л үлджээ.

Оросын сонгуулийн дүн бүх нийтийг түгшүүлэв

Яагаад ийм гарчиг сонгосноо дор бичих зүйлээрээ нотолно. Ардын депутатуудын үймээнийг дарж авсны дараа Ельциний нөгөө жигүүрээс түүний нууц дайснууд ил гарч ирлээ. Тэд бол 1991, 1993 оны үймээний гадна үлдэж хоцорсон хэт үндсэрхэг, коммунист хонзогногч, хүнд сурталтан гэх мэт сөрөг хүчний төлөөлөгчид юм. Ерөөсөө Орост ерөнхийлөгчийг баттай дэмжих либерал, реформист хүчнүүдийг улс төрийн намд нэгтгэж чадахгүй байснаас сонгуулийн дүн буруугаар эргэх нөхцөл бүрджээ. Энэ нь сонгуульд ялагдал хүлээлгээд зогсохгүй реформыг боогдуулж, сөрөг хувьсгалд бэлтгэж мэдэх аюултай. Ельцин ба түүний

таланхан хүчний харьцааг буруу тооцсон, хэт яарсан талч бий. Үг нь сайтар бэлтгэх ёстой. Шинэ Үндсэн хуулийн төслийг сонгогчид тэмцэжээ. Ельцинд их итгэл хүлээлгэсэн. Гэтэл реформын талчид хүчүүд сонгуулийн өмнө нягтрах ёстой атлаа 3 хэсэгт хуваагдаж, тус тусдаа мандаттайгаар сонгуульд өрсөлдсөн нь эрх зөвчлөлдөө ялах нөхцөл бүрдүүлсэн. Ингээд хүчний харьцаа 2:1 буюу хуучныг баримтлагч, үндсэрхэг хүчнийхэн давуутай байдалд бүрджээ.

Гол нь сонгуулийг ийм дүнтэй дуусна гэдгийг Орост ч, талчид дахинд ч олон хүн төсөөлөөгүй байснаас нэг хэсэгтээ цочирдон гайхацгаав. Гэвч энэ гайхширлыг зөөлрүүлэх өөр нэг юм байсан нь Оросын шинэ Үндсэн хуулийг сайшаасан явдал байв. Энэ утгаараа Үндсэн хууль үйлчилж, реформ хөтөлбөргүй хуульчлагдаж, ерөнхийлөгчийн байр суурь бэхжих учиртай. Реформын явцад гардаг зүй ёсны алдаа гажуудалд сэтгэл дундуур бичиг сонгогчдын санаа бодлыг үндсэрхэг үзэлтнүүд ашиг заншаан болгосонд нийтээрээ гонсгор байсан юм. Сонгуулийн дүн хийгээд Оросын парламентын доод танхим - Улсын Думд бүрхэлдсэн хүчний харьцаанд Оросыг дэмжигч өрнөдийн гүрнүүд төдийгүй ТУХН дэх түншүүд, Балти хавийн улсууд, хөршүүд нь сэтгэл дундуур байлаа. Ялангуяа Думд олон суудал авсан Оросын Либерал-ардчилсан Нам (ОЛАН) түүний дарга В.Жириновскийн өмнө төрх айдас төрүүлсэн юм. Тэрээр их Оросын эзэнт гүрнийг хуучин ЗСБНХУ-ын хилийн хүрээнд сэргээн босгохыг удаа дараа үриалан дуудсан хариуцлагагүй мэдэгдэл хийдгээрээ алдаршсан хүн. Түүний хараал зүхлийг сонсоогүй Оросын хөрш орон гэж бийхгүй. Тэгээд ч Жириновскийн ялалт дэлхий дахинд нэгийг бодогдуулсан юм. Энэ тухай хожим өгүүлнэ.

Улсын Дум 1991, 1993 оны үймээн дэгдээгчдийг цагаатган суллах шийдвэр гаргасанд бүр ч их гайхан эгдүүцсэн билээ. Энэ бол Ельцин болон түүний талынханд хүчтэй цохилт болжээ. Оросын реформ ямар замаар явах нь тус орны улс төрийн нөхцөл байдлаас шууд хамаарна. Реформын улс төрийн таатай дэвсгэр нь ардчилал байх ёстой. Гэтэл ардчиллыг нухчин дарах гэж хууль зөрчсөн этгээдүүд ялтны ширээнээс мултарчээ. Ерөнхийлөгч Думын энэ шийдвэрийг цуцлуулах гэж үр дүнгүй оролдоод мухардав.

Дүгнэлт

Дээр Оросын улс төрийн дотоод тэмцлийг хоёр үе шаттай авч үзжээ. Эхнийнх нь 1991 оны хавраас 1993 оны хаврыг хамарч байна. Энэ үед эсрэгцэн зааглах явц нууц явж ирсэн. Дараагийнх нь 1993 оны хавраас 1993 оны намрыг хамрах бөгөөд энэ үед засгийн эрхийн төлөө хууль тогтооох, гүйцэтгэх хоёр засаглал чинээндээ түлгэл зөрчилдсөн үе. Түүнийг зэвсгийн хүчээр шийдвэрлэжээ. Энэ бол үйл явдлын ноён оргил нь юм уу гэмээр. Үүний дараа Орост

улс төрийн өрнөлт хөгжилтийн шинэ үе эхэлсэн нь 1993 оны шинэ сонгууль. Сонгуулиар яаж ч тогтворгүй эргэж мэдэх тун амаргүй нөхцөл бүрдээд байна. Яагаад ийм олон үе дамжиж, даамжрав?

1. Орос ийм хямрал гарцаагүй байсанд эргэлзэх зүйл алга. Яагаад гэвэл энэ хямрал бол ЗХУ-ын үлдээсэн зүй ёсны өвийн хурц хэлбэр нь. Оросын ард түмэн ихээхэн бэрхшээл туулж, маш их цаг алдаж хохирч байж реформын үр дүнг үзэх ёстой. Тийм учраас тэр үр дүнд хүрэхийн наана хямралтай бишгүй тохиолдоно.
2. Хямарч итгэлээ гэсэн сонгогчид хэнд ч итгэхээ больдог нь зүйн хэрэг. Тийм учраас тэдний бухимдал гомдол дээр ОЛАН мэтийн үндсэрхэг хүчин дөрөөлөн сонгуульд ялсан байна.
3. Реформын төлөө тууштай тэмцэгч ардчилсан хүчнүүдийн эв нэгдэл шилжилтийн ийм эгзэгтэй үед бүхнээс чухал гэдгийн нотолгоо Орос болж өглөө. Эд хичнээн эв нэгдэлтэй, нэгдмэл бат цул байхын хэрээр ард түмэн төдий чинээ тогтвортой, завсрын популист хүчнүүд сул байх болно.
4. Сонгуулийн үр дүнд бий болсон ээдрээтэй үед ерөнхийлөгч ба гүйцэтгэх засаглалын байр суурь шийдвэрлэх үүрэгтэй. Черномырдин тэргүүтэй реформист засгийн газрын үйл ажиллагаанд шинээр гарч ирсэн үндсэрхэг үзэлтнүүдийг оролцуулахгүй байгаа нь зөв зүйтэй бөгөөд ерөнхийлөгчийн засаглалын хүчтэйг энэ нь бас харуулж байна. Энэ бол Оросын улс төрийн хүчнүүдийн хооронд баланс барих нэг баталгаа.
5. ЗХУ задарч, төвлөрсөн социалист тогтолцоо нурахын хэрээр их гүрнээ эмхлэн байгуулах эрмэлзэлтэй үндсэрхэг, хуучинсаг хонзогногч, сталинч хүчнүүд нэгдэн нягтарч, тэдний хооронд зааг ялгаа арилж, нэг хөрсөн дээр бөөгнөрдөгийн тодорхой жишээ Орос харагдлаа. Энэ нь цаанаа тэдний оршин байх агаар нэгэн буйн нотолгоо бөгөөд ардчилсан хэмжүүрээр тэднийг "фашист" гэж тодорхойлж байсныг эргэн санахад илүүдэхгүй.

Эдгээрээс гадны Оросын шинэ гадаад орчны талаар дүгнэлтийн чанартай хэдэн зүйл хэлье. Энэ бол цаашдаа байдлыг дүгнэж цэгнэхэд хэрэг болж магадгүй.

Бид нэгдмэл *ЗСБНХУ тарсны дараах эхний хоёр жилд ТУХН-д өрнөсөн нөхцөл байдлыг* Оросоор гол болгон авч үзлээ. Учир нь Орос нь ЗХУ-ын үлдээсэн ачааны ихэнхийг үүрсний хувьд, цаашлаад ЗХУ-ыг шууд залгамжлагч болсны хувьд анхаарлын төвд байх ёстой. Нөгөө талаас дэлхий дахин Оросыг ажиглаж, энэ их гүрний цаашдын төлөв байдал бусаддаа хэрхэн нөлөөлөхийг төсөөлөх гэж оролдсон юм. Энэ утгаар бол миний цаашид бичих асуудал ч Орос төвлөрөх болно.

Бүлгийн энэ хоёр хэсэгт бичсэн баримт, үйл явдлын хэлхээсийг гадаад талаас нь хэрхэн дүгнэх вэ?

- 1 Цараг стратеги, олон улсын байр суурь эдийн засгийн нөхцөний хувьд Орос орон аугаа их гүрэн байхаа больжээ. Түүнд урьдын ЗСБНХУ-ын дайтай цараа илт дутжээ. Газар нутгаараа XVIII зууны үетэй, хүн амын нь тоо XX зууны эхэл үеийн байдалд дөхөж очив. Гэсэн ч газар нутгаараа дэлхийд тэргүүлсэн хэвээр, харин хүн амаараа зургадугаар байрт (Жинтад, Энэтхэг, Индонез, АНУ, Бразилийн дараа) орж байна. Эдийн засгийн хүч чадлыг нь тоон үзүүлэлтээр Германтай дохуулж болох боловч АНУ, Японоос бараадахгүй хэл хөгжрчээ.
- 2 Олон улсын харилцаанд эзлэх байр суурийн хувьд зонхилсоор байгаа нь хүчирхэг их гүрэндээ бус, харин тус оронд болж буй нөхцөл олон улсын амьдралд шууд нөлөөлж байгаатай, цаашлаад ийм эгзэгтэй, тогтворгүй оронд цөмийн өдий төдий эмсэг байгаатай холбоотой.
- 3 IXV задарснаар Орос Европтой шууд хиллэхээ больж, харин Украин, Белорусс хоёр Европтой шууд харилцах боломжтой болжээ. Ингээд Орос орон улам хойд зүг Евразийн булан руу шахагдсан байдалтай байна. Бас үүнтэй зэрэгцээд Орост тасархай нутаг дэвсгэр бий болов. Тэр нь Белорусс, Литвагаар тусгаарлагдсан Калининград муж. Тэр бол Оросын Европ руу харах "донх".
- 4 Оросын хилийн хамгаалалтын зурвас байхгүй болж, харин оронд нь хилийн дагуу халуун цэгүүд бүрджээ. Тэнд болж буй үндэстэн ястан, шашин омгийн мөргөлдөөн задгайрч, Оросын хил даван орж ирлээ. Үүнийг дагалдан аюулгүй байдал, орос үндэстний цөөнх, дүрвэгсэдийн асуудал гарч ирлээ.
- 5 Эдгээр бэрхшээлүүдийг дан ганд хэлэлцээний аргаар бус, хүч хэрэглэх, зарим үед их оросын үндсэрхэг үзлийг дэвэргэх замаар шийдэхээс өөр аргагүй.
- 6 Орос "Хүйтэн дайнд" ялагдсанаараа гадаад дахь дарамтаараа салж авлаа. Олон орныг дайсны жагсаалтаас хасч, зөвсөглөлөөр хөөцөлдөж байсан ачааллаа хөнгөвчлөв. Одоо өргөдийн орнуудтай дайтах аюул алга.
- 7 Геополитикийн шинэ нөхцөл байдал, тухайлбал, урьд нь нэг их анхаардаггүй байсан далайн гарц нь Оросыг Ази, Европыг холбох гүүр болгож байна. Энэ нь европын шинжээ алдахгүй байх нэг боломж. Тэгээд ч газар нутгийн дөрөвний нэг, хүн амын 70 хувь нь Европын хэсэгтээ байгаа. Ийм учраас Орос нь Япон, АНУ, Умард Европын орнуудтай ухаалгаар харилцах ёстой.

Эдгээрт нь нэг үгээр дүгнэж хэлбэл, ЗХУ-ын задрал Орост ашиг, хөжирлийн аль алиныг авчирчээ. Ашиг нь ЗХУ-ын буурай хөгжилтэй хэргүүдийг салснаараа нүсэр хүнд ачаагаа хөнгөвчлөв. Хуучин жинхэнэ эдийн засаг, санхүүгийн ихэнх нөөцийг өөртөө үлдээж, бие мацварлаг мэргэжилтнүүдтэй үлдлээ. Хөжирөл нь эргэн тойрог

халуун цэгүүд бий болж, тийшээ үлдсэн хүч, анхаарлаа тараах бэрхшээлтэй тулгарав. Ерөөсөө нэг аюулыг зайлуулж, нөгөө нэг аюулыг өөртөө хураажээ.

ДӨРӨВ. ТУСГААР УЛСУУДЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛ ДЭХ ЗӨРЧИЛ БЭРХШЭЭЛ

ТУХН-ийн эхний жилийн гараа ямар байсан, ямар бэрхшээл зовлон дагалдаж, түүнийг шийдэх талаар юу хийсэн тухай дээр өгүүлсэн. Тэнд би 1992 оны гол гол үйл явдлыг баримтаар жагсаан тоочсон. Энд ТУХН дэх зөрчил, түүний учир шалтгааныг тайлбарлахыг хичээнэ. ЗСБНХУ-ын задрал түүний халааг авсан ТУХН-д тааж хэлэхэд хэцүү олон асуудал тулгасан билээ. Шинээр үүссэн тусгаар улсууд өөр хоорондоо л биш бол холбоотон гэх юм үгүй болсон байв. Хил хязгаарын өөрчлөлтүүд, геополитикийн ч шинэ нөхцөл байдлыг бий болгов. Тус тусдаа өрх тусгаарласан улсууд, ялангуяа ЗСБНХУ-ын гол араг ясыг бүрдүүлж байсан том улсууд практик эрх ашгаа хамгаалахын тулд ТУХН байгуулагдсаны бараг маргаашаас нөлөөний хүрээний төлөө тэмцэлд орсон. Гэтэл эдний нөгөө талд *урьд хожид хэзээ ч тусгаар улс байж үзээгүй улс үндэстнүүд* шийдэхэд бэрх олон асуудалтай тулгарсан юм. Угаасаа ЗХУ-ын үед шийдэж чадаагүй олий төдий асуудал байсан, түүн дээр шинэ асуудал нэмэгдсэн. Ерөөсөө ТУХН-ийн гишүүд Балтийн 3 улс шиг тусгаар тогтноход яг бэлэн байгаагүй. *Тусгаар тогтнож аваад дараа нь ямар зовлонтой учрахыг урьдчилан харж чадаагүй.* Энэ бол хамгийн ноцтой хүчин зүйл юм. Үүнийг доорхи баримтууд нотолно. ТУХН-ийн хоёр том гүрний харилцаанаас эхлэн ярья.

Орос-Украин: түншлэл үү? сэргөлдөөн үү?

Орос-Украины харилцаанд мэнгэ болж үлдсэн 3 гол асуудлыг энд авч үзнэ. Энэ бол

- 1) Хар тэнгисийн флотыг хэсэглэн хуваах буюу эзэмших асуудал;
- 2) Крымын хойгийг тойрсон маргаан;
- 3) Стратегийн довтолгооны зэвсэглэл, түүнийг устгах асуудал билээ.

Энэ 3 үндсэн асуудлыг тойрч ТУХН-ийн хоёр том гүрэн дөрөв дэх жилдээ маргаж байна. Гэвч бодит үр дүн алга. Ялангуяа эхний хоёр асуудал дээр. Гурав дахь асуудал бол энэ хоёр улсаас гадна АНУ-аас ихээхэн шалтгаалах бөгөөд ганц Украин ч биш, бас Белорусс, Казахстан хоёр мөн энд нэгдэх учиртайг бодолцон жич өгүүлье.

Эдгээрээс гадна энэ хоёр улс Хар тэнгисийн эдийн засгийн хамтын ажиллагаа, Молдов дахь мөргөлдөөн, өөр хоорондын

эдийн засгийн харилцаа, ТУХН-д энх тайвныг сахиулах ажиглалтын нэг мэг олон асуудалд хамтран оролцож байгаа.

Хар тэнгисийн флотыг тойрч бүтэн 4 жил үр дүнгүй маргалдсан үүнийг М.С.Горбачев азарган тахианы зодоонтой зүйрлэснийг эцэс дүрднэ. Азарган тахианы зодоонд хэн ч дийлдэггүй шиг Хар тэнгисийн флотыг эзэмших эрхийг булаацалдаад хэн нь ч дийлдэггүй өнөө хүрчээ. Энэ флотын үндсэн зэвсэглэл болох 380 бийндааны хөлөг онгоц, бүх офицер, цэргүүдийн хувь заяа, тэдний ажил гэр, цэргийн хотхон, зогсоол гээд бүгд л энд хамрагдах асуудал. Эхлээд Ельцин, Кравчук хоёр дор дороо зарлиг гаргаж флотыг тус тусын өмч гэж үзсэн. Гэтэл хэн хэндээ буулт хийхгүй байснаас нэг хэсэг булаацалдаж, хатуу үгээр бие биеэ харилцан бумбөгдөв. Энэ нь аажимдаа үндсэрхэг чанартай гомдол болж нэвчирсэн. Флотын талаархи үр дүнгүй маргаан Крымын хойгийн асуудлыг хөндлөнгөөс гаргаж тавихад хүргэсэн. Учир нь энэ хойгт, Симферополь хотод флотын командлал, төв штаб байрладаг. Үүндээ флот бол Украины нутаг дэвсгэрийн боомтод байрлаж байгаа. Үүнийг Украин иш үндэс болгодог. Гэтэл Орос түүх сөхөж, Украиныг түүхэндээ хэзээ ч флоттой байгаагүй, Хар тэнгист байрлах Оросын флот байсан бөгөөд олон тулалдаанд Орос л энд үндсийг үүрч ирснийг Турктэй дайтсан түүхээр жишээлэн танилбарладаг. Удтал маргаж, бас ухаан зарж харилцан буулт хийсний ачаар хоёр тал 3 жилээр уг асуудлыг хойшлуулж, энэ хоёронд флотыг хамтдаа эзэмших хамтарсан командлал томилох шийдвэр гаргажээ. Гурван жилийн дараа гэхэд "Нийгэм маань амгартээсээ ангижирсан, бодит байдал маань өөр болсон байна" гэж Ельцин ирээдүйг төсөөлж байлаа. Тэр 3 жилийнх нь хугацаа 1995 онд дуусах ёстой. Байдлыг хэрхэн зохицуулах бол? 80:20 хувиар хуваах хувилбараар ойролцоогоор шийдэх бололтой.

Крымын хойг хэнийх вэ? гэдэг дараагийн нэг бэрхшээлтэй асуудал бий. Түүх сөхвөл XVIII зуунд Орос-Туркийн дайны шийдсэн гол асуудал Крым байжээ. Энэ дайны дараа Орос Хар тэнгист нэвтрэх үүд хаалгаа нээсэн. Орос, Украин хоёр хоёулаа Зөвлөлийн эрхийг бүгд найрамдах улсууд байсан 1954 онд слав туургатан хоёр их хөршийн 300 жилийн найрамдал, эв нэгдлийг бэлгэдэж Крымыг Оросоос Украинд "бэлэглэжээ". Энэ тухай тэр үеийн СССР-ийн Дээд Зөвлөлийн шийдвэр бий. Үүнийг огт өөрчлөхгүйгээр, уг шийдвэрийг цуцлалгүйгээр өнөөг хүрсэн бөгөөд СССР-ийн задарч байх үед энэ асуудлыг бодох сөхөөтэй хүн байсангүй. Харин ТУХН үүссэн цагаас энэ асуудал дэвшигдэн гарч, хоёр орны харилцааг хурцатгах аян шалтаг болж ирлээ. Оршин суугчидыг нь бодвол гол төлөв оросууд зонхилсон, гэвч 1954 оны шийдвэрийг үндэслэн Украин тус хойгийг хэнтэй ч хуваалцахгүй, Оросыг өгөхгүй гэж зүтгэж байна.

ТУХУ-ын задралын өмнөхөн 1991 оны есдүгээр сард Крымын төрийн бүрэн эрхт байдлын тухай тунхаглал крымчууд амжилт

гаргажээ. Тэд ингэхдээ ирээдүйгээ Орос даатгахаар шийдсэн хэрэг. 1992 оны тавдугаар сард Бүгд Найрамдах Крым Улсын тусгаар тогтнолыг тунхаглав. Хожим нь 1994 оны зургадугаар сард Крымын төр улсын Үндсэн хуульт үндсүүдийг дагаж мөрдөх тухай тогтоол гарчээ. Гэтэл эдгээр гол баримт бичгийг Украины Дээд Зөвлөл өнөөг хүртэл хүлээн зөвшөөрөхгүй байна. Украины үзэж байгаагаар Крым нь Украины бүрэлдэхүүнд багтах өөртөө засах улс. Крымын асуудал цаашид даамжирахад тэнд болсон ерөнхийлөгчийн сонгууль хүчтэй нөлөөлжээ. Орос, Украин хоёр хоёул энэ сонгуульд их анхаарсан бөгөөд гол өрсөлдөгчид нь болох Ю.Мешков, Н.Багров хоёр түүний бодит тусгал болж байлаа. Сонгуульд оросын үндсэрхэг үзэлт Мешков түвэггүй ялсан төдийгүй энэ ялалт Крым дэх улс төрийн хямралын эхийг тавьжээ. Тэрээр Крымыг Орос нэгтгэх тухай ярьдаггүй боловч Оростой цэрэг-улс төрийн (холбоотны) гэрээ байгуулахыг зорьжээ. Энэ бол Украинд томхон шахалт үзүүлэх тийм гэрээний тухай ярьж буй хэрэг. Гэвч олон улсын хуулийн субъект биш Крым үүндээ тийм амархан хүрэхгүй. Нөгөө талаас Мешковын ялалт, түүний дараах нөхцөл ялангуяа тэндхийн парламент дэх олон үндэстний спектр, гүйцэтгэх засаглалын механизм тааж хэлэх аргагүй байдлыг бий болгоод байна. Мешков өөрөө тийшиг шиг ерөнхийлөгчийн хүчтэй засаглал тогтоохыг зорьсон. Гэтэл түүнтэй крымчууд бүгд эвлэрээгүй, эцэст нь Мешков өөрөө Крымын Сайд нарын Зөвлөлийг устгах тухай зарлиг гаргасан. Дараа нь удирдлагын бүтцийг өөрчилж, засгийн газаргүй 5 яам байгуулж, 3-ынх нь сайдаар Москвагаас хүн томилуулжээ. Сүүлд нь томилогдсон ерөнхий сайдтайгаа тохироогүй. Улс төрийн аллагаар сүрдүүлсэн. Энэ бол асуудлын нэг тал нь.

Асуудлын хамгийн эмзэг тал нь энд Умард Ирландтай төстэй, эсвэл Нагорно-Карабах шиг мөргөлдөөний голомт бий болох вий гэдэг түгшүүр. Украиныг хамгийн их түгшээж буй асуудал бол энэ юм. Тус хойгийг Украинаас таслан салгах гэсэн кампани яван явсаар тийм байдалд хүрэхийг үгүйсгэх аргагүй. Крымыг Орос түлхэж, шөвөгдөж байгаа мэтээр Украины албан ёсны төлөөлөгч зөвлөлд, үүндээ Оросын улс төрийн нөлөө бүхий зүтгэлтнүүдийг нэр зааж байсныг энд дурдах хэрэгтэй. "Хэрэв Крым тусгаар тогтнох зам сонгох авбаас цус асгарахад хүрнэ" гэж Кравчук сануулсныг бас энд иш татмаар байна. Оросын дэд ерөнхийлөгч байхдаа Руцкой үүнийг эсэргүүцэж Крымыг Орос авах ёстой гэж сөргөж байсан удаатай. Одоо болохоор Оросууд Крымын асуудлыг хэлэлцэхээс булзаж, тэнд амьдардаг орос хүмүүсийн хувь заяа, эрх ашиг гэдгийг их ярьж байна. Крымын асуудалд Оросын янз бүрийн нутгаар оршин суудаг казакууд (хасаг биш) хутгалдан орж, дайнч авир гаргаж байсныг бас мартаж болохгүй.

Крымын татарын асуудал бол Украин, Крымын хувьд хамгийн хөндүүр газрын нэг. Крымын орос удирдлага татаруудыг Крымд

шэртөө засах бүгд найрамдах улсын хувиар хамтран аж төрөхөд
лөмждөг боловч Татарын үндэсний зөвлөл-Межлисийг анхны хоёр
хүлээн зөвшөөрдөггүй 1944 онд Сталины шийдвэрээр Украин
уугуул иргэд болох татаруудыг хүчээр тараасны дараа Украин
татаруудын асуудал үүсчээ. Тэднийг германы нацистуудын
хуйвалдсан гэдэг ял тулгаж хоморголон хэлмэгдүүлсэн юм. Тэд
1960 онд цагаатгагдах хүртлээ их зовлон амсчээ. Тэгээд ч тэднийг
"Зөвлөлтийн палестинчууд" гэж албан бусаар нэрлэдэг нь
үндэсгүй зүйл биш. Татаруудын итгэл үнэмшил, хүсэл тэмүүрэн
орчлон байгуулалтын үр дүнд биелэх боломжтой болжээ. Гэвч
"Зөвлөлтийн удирдлага дэндүү оройтож байж (1990 он) шийдвэр
гаргасан тул асуудлыг хагас дутуу түүхийрүүлж орхиход хүрсэн
байна. Татарууд эх нутагтаа эргэж очих эрхээ аваад удаагүй
байтал ЗХУ таржээ. Ингээд Орос хариуцлагаас булзаж, Крымын
татарууд таран суудаг Дундад Азийн шинэ улсууд тэдний
асуудлыг шийдэх манатай байна. Эцэст нь тэдний талд Украины
үндсэрхэг үзэлтнүүд л зогсчээ. Сүүлийн 3 жилд ердөө 200 мянган
татар эх нутагтаа эргэж ирсэн нь 2.5 сая хүн амтай Крымд
дорвитой нөлөө үзүүлэх хүч биш юм. Хэдэн зуун мянган татар хүн
Дундад Азид ацан шалаанд орчихоод яаж ч чадахгүй байна.
Тийгээд үндэсний цөөнхи хэвээрээ байгаа татаруудын хувьд
шиьж буй шаардлага нь бодит байдалтай зөрөөд байдгийн учир
яандаа олдох байх. Тэд Крымын парламент хоёр танхимтай байх,
хоёрдугаар танхимд Крымын уугуул ард түмэн төлөөлөлтэй байж,
бүх хууль тогтоомжид хориг тавьдаг эрх эдлэхийг заасан Үндсэн
хуулийн төсөл санал болгожээ. Гэвч түүнийг олонхи болсон
оросууд хүлээн авсангүй. Татаруудад төр улсаа төвхнүүлэх боломж
олгох тухай Кравчукийн мэдэгдэл (хэрэг дээрээ амлалт-Зох), Крым
Украиных байсан цагт татарууд эрхээ сэргээх боломжтой тухай Ук-
раины талын мэдэгдэл, Туркээс Крымын уугуул иргэдийг дэмжиж
байгаа зэрэг бодолцох өчнөөн төчнөөн хүчин зүйл энд бас бий.
Эцэст нь 1783 онд Оросын хатан хаан Екатеринагийн шадар туслах
П. Пютемкин Крымын хойгийг "хамар дээр гарсан үү" хэмээн нэрлэж
бийсныг энд эргэж дурдах нь зүйтэй бизээ.

Молдов

Молдов бол ТУХН-ийн хувьд "хамар дээр гарсан үүтэй"
дүирлүүлэх бас нэг маргаантай асуудал. Молдов улс хэрхэн бий
болсон түүхийг эргэж саная. 1940 оноос өмнө Молдов гэж бие
шавсан улс байгаагүй. Днестр мөрний хоёр эргийн дагуу хоёр өөр
дэлг захиргаа 1940 хүртэл байсан. Бессарабийг Румын дэлхийн
шалдугээр дайны дараа Оросоос салгаж авсан, Днестрийн зүүн
эргийн дагуу Зөвлөлт засаг тогтож, 1924 онд Зөвлөлт Украинийн
пүрэндэхүүнд ЗСБНАвтономит Молдав Улс байгуулагдсан. Хүн
амын ихэнх буюу 50 хувь нь украин, 30 хувь нь молдов, 10 хүрэнгүй
хүн нь оросууд байлаа. Өөрөөр хэлбэл, оросууд тийшээ бүрэн

гүйцэд нэвтрээгүй байсан цаг. 1940 онд Сталин-Гитлерийн хуйвалдааны дагуу Улаан арми Бессарабыг авах байлдааны ажиллагаа явуулсан. Түүний дүнд Румыны мэдэлд байсан нутгийг 1940 оны зургадугаар сард чөлөөлж, сар гаруйн дараа ЗСБНМолдав Улсыг тунхаглажээ. Ийнхүү Днестрийн хоёр эргийг нэгтгэж, Украины бүрэлдэхүүнээс гаргажээ. Энэ бол түүхэн учир шалтгаан. ЗХУ задарсны дараа Молдавыг тойрсон хямрал гарахад нөлөөлсөн нэгэн бодит хүчин зүйл.

Нөгөө нэг хүчин зүйл нь ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалт. Түүний үрээр түүхэн үнэн сэргэж, урьд нь ам хамхиастай явж ирсэн олон асуудал шийдлээ хүлээсэн хэрэг. Гол нь түүхий шийдэж, олон зүйлийг орхигдуулж ирсний уршиг байсан гэхэд хилсдэхгүй. Жишээ нь молдовчуудыг румынээс огт хамааралгүй мэт төсөөлөл, нэгдмэл "зөвлөлт үндэстний" тухай хөнгөн хуумгай дүгнэлт энд нөлөөлсөн. Өөрчлөн байгуулалтын үрээр үг хэлэхтэйгээ болсон молдовчууд 1940 онд Бессарабийг чөлөөлснийг хууль бус гэж үзсэн шийдвэр 50 жилийн дараа парламентаараа гаргуулж дөнгөсөн юм. Энэ нь ЗСБНМУ байгуулсныг хууль эрхийн үндэсгүй гэж үзсэн хэрэг байв. Энэ бол хүн амын олонхи болох молдовчуудын үзэл бодлын илрэл. Гэтэл үүнтэй орос, украинчууд санал нэгдсэнгүй, тэд дээрх шийдвэрийг тэр улсаа булшлах эхлэл гэж үзэн, өрх тусгаарлах замд оржээ. Хүн амын дотор ч уугуул оршин суугч, эзлэн түрэмгийлэгч, цагаачлагч, ажиллахаар ирэгсэд гэх мэт ангилал зохиомлоор бий болжээ.

Молдов хүн амын дотор бас олон янзын спектр (ялгарал) үүслээ. ЗХУ-ын задрал, ТУХН-ийн эхэн үед газар авсан Румынтэй нэгдэх хийрхэл сүүл рүүгээ намжих төлөвтэй болов. Энэ асуудлаар санал хураалт явуулсныг бодоход асуудал ямар хэмжээнд хүрсний жишээ, 4.3 сая хүн амын (Днестрийн зүүн эргийг оруулж тооцоод) 2.3 сая нь санал өгсний 90 гаруй хувь нь Молдовыг тусад нь байлгая гэж шийджээ. Ингээд Румынтэй нэгдэн нийлэх тухай яриа алга болов. Өөрсдийгөө "Днестрийн бүгд найрамдах улс" гэж зарласан орос, украинчууд санал өгсөнгүй, Молдовын өмнөд хязгаарт аж төрдөг христос шүтлэгт туркууд өөртөө засах тохинох эрхтэй байхаар санал өгчээ. Үүний үрээр Гагаузын салан тусгаарлах аюул ариллаа.

Гэтэл салан тусгаарлахаар эрс шийдсэн Днестрийнхэн гэжүүд байр сууриа орхихгүй өдий хүрчээ. Тэд 1990 оны намар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тухай хууль, тунхаглал гаргасан боловч түүнийг Молдов өнөө хүртэл хүлээж зөвшөөрөөгүй байна. Тэр үед ЗХУ-ын ерөнхийлөгчид хүсэлт тавьж тусгаар байдлаа хүлээн зөвшөөрүүлэхийг зорьсон нь бүтээгүй. Гагаузын бүгд найрамдах улс, Днестрийн бүгд найрамдах улсыг тунхагласан нь хуулийн үндэсгүй гэж Зөвлөлтийн удирдлага үзсэн юм. 1991 оны наймдугаар сарын үймээний үед тэд дахин дэмжлэг хүлээх гэж оролдсон боловч Москвагийн зүгээс няцаагджээ. Үймээний дараа

Молдав бүрэн тусгаар тогтносноо зарлаж, днестрчүүдийг тунгшгүй мөхөөв. Тэгээд ч хуучин ЗСБНМолдав улсын алдлагаа ч болохоор эргэлтгүй шийджээ. Улсын нэрийн хувьд ч хоёр улс гарч ирэв. Хуучин Молдав нь Молдов гэсэн нэртэй болов. Днестрийн шинэ "улс" Днестр дэх Молдавын бүгд найрамдах улс гэж нэрлэгджээ. Тэнд Оросын 14-р арми байсныг ашиглан днестрчүүд тун зоримог ажиллав. 1992 оны зун тэмцэл дэвч цэгтээ туллаа. Олон удаа ширүүн байлдаж, эцэст нь Оросын энхийг сахиулагчдын тусламжаар гол зогсоожээ. Руцкой Днестр айлчилж, тэндхийн хүн амыг дэмжинэ гэсэн итгэл хүлээлгэсэн нь байдлыг хурцатгах нэг шалтаг болжээ. Руцкойн болчимгүй мэдэгдэл Молдовын удирдлагыг түгшүүлэв. Румыны тал ч хариу арга хэмжээ авчээ. 1992 оны тавдугаар сард Румыны ерөнхийлөгч И.Илиеску Кишиневт ирлээ. Европт румыны тусгаар тогтносон хоёр улс зэрэгцэн орших тухай номлолыг Румын, Молдовын ерөнхийлөгч нар дэвшүүлэв. 1992 оны долдугаар сард Молдовын ерөнхийлөгч М.Снегур Москвад айлчилж, мөргөлдөөнийг эв зүйгээр шийдвэрлэх үндсэн зарчмуудыг тогтоосон хэлэлцээрт Ельциний хамт гарын үсэг зуржээ. Энэ бол хямралыг намжаасан томхон алхам болсон боловч гол асуудал өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Тажикистан

Дундад Азийн тусгаар тогтносон энэ улсыг хамарсан иргэний дайн, хилийн мөргөлдөөн өнөөг хүртэл намжихгүй байна. Энэ юуных вэ? Энэ бол 20-иод оноос хэрэгжүүлсэн боловч шийдэлгүй үлдээсэн Зөвлөлтийн үндэстний бодлогыг үр хөврөл, цаашлаад бүс нутгийн хоцрогдол, лалын шашны нөлөө, Орос болон ТУХН-ийн орнуудын хөндлөнгийн оролцооноос үүдсэн хямрал юм. Эндхийн байдал хэр ноцтой хэмжээнд хүрснийг хохиролын тоо хэмжээ хэлж өгнө. Энд ТУХН-ийн бусад аль ч орныг бодоход хавьгүй их хүн үхэж үрэгдсэн бөгөөд сунжирч байгаа байдал, Афганистантай хиллэдэг 2000 км зурвасын дагуухи хилийн дайн, ТУХН-өөс ямар хүч зарж түүнийг хамгаалдаг, түүнд Орос хэр их ачаа үүрч буй зэргийг бодвол Тажикистаны мөргөлдөөнийг олон улсын шинжтэй бүс нутгийн шинэхэн голомт гэж тооцохоор байгаа юм.

Тус орны тухай хэдхэн баримт сөхье. 1989 оны (түүнээс хойш тооллого хийх зав гараагүй) мэдээгээр 5.1 сая хүн амтай, 3.2 сая тажик, 1.2 сая узбек, хагас сая орос, бусад үндэстэн ястан оршин суудаг, бүс нутагтаа хамгийн хоцрогдсонд тооцогдох эдийн засагтай, хүн амын 70 гаруй хувь нь хөдөө оршин суудаг. 60 амт хувь нь үгээгүй ядуу, лалын шашны суннит чиглэлийг голлон сүсэглэдэг. Түүхэнд тажикийн төр улс гэж байгаагүй, олон үүрэг турш Бухарын хаант улсад харъяалагдаж байсан. 1918-1920 онд Улаан арми тэнд Зөвлөлт засаг тогтоохын тулд үндэстэн

эсэргүүцлийг дарсан, 1924 оноос Узбекийн бүрэлдэхүүнд өөртөө засах эрхтэй орж, 1929 онд Зөвлөлтийн нэг бүгд найрамдах улс болжээ. Гэхдээ энэ бүхнийг тажикууд өөрсдөө бус Москвагаас тулгаж хийлгэсэн юм. Ийм байдалтай 90-ээд оныг хүрчээ. Гэвч өөрчлөн байгуулалт тажикийн ард түмэнд "гэрэл гэгээ" бус, омог-аймгийн шинжтэй мөргөлдөөн дагуулж иржээ. Энэ мөргөлдөөн улс үндэстнийг нь мөхөөхөд дөхөж очсон үе бий. Гагцхүү тэнд Оросын цэрэг, ТУХН-ийн хамтарсан хүч байгаа учраас төр мөхлийг тойрч гарсан юм.

Тус оронд 1990 оноос хойш гурав дахь удаагаа үхэл хагацал гамшиг дагуулсан сонгууль явуулж, төрийн тэргүүнээ сонгожээ (4 жилд 3 удаа). Гэвч сонгууль бүр хүн амын улс төрийн байр суурийг илэрхийлж чадаагүй. Сонгууль бүр шуугиан дэгдээж, булхай нь хожим илэрдэг. Бас нутаг довоороо талцах хуваагдах явдал түүнд нөлөөлдөг. Жишээ нь сүүлчийн ерөнхийлөгч Э.Рахмонов гэхэд л тус орны тавны нэгийг гөлөөлөх төдий Куляб мужид дэмжлэг хүлээсэн, бас сөрөг хүчин бүхэлдээ сонгуульд огт оролцдоггүй, нутаг дэвсгэрийн бүх хэсэгт засгийн газар хяналт тавьж чадахгүй байгааг бодвол байдал тун хэврэг мэт санагдана.

Нөгөө талаар иргэний дайн хагас сая дүрвэгч (хүн амын 10 хувь) бий болж 150 мянган хүн Афганист хиллэдэг. Пянь голын хөвөөгөөр майханд аж төрөхөд хүргэжээ. Энэ бол тус орны удирдлага хэр бодитой байр суурь баримталж ирснийг харуулна. Тэндхийн байдлыг хоёр дахь Афганистантай зүйрлэж байгааг энд бас дурдах хэрэгтэй. Ийм нөхцөлд тажикистан дахь одоогийн дэглэмийг тогтвортой байлгах, иргэний дайныг шатлан өргөжүүлэхгүй нэг хэмжээнд хав барьж байхад ТУХН-ийн энхийг сахиулах бодлого оршиж байна. Энэ бол 100 хувь амжилт олно гэж найдахад хэцүүхэн зүйл. Оросын хилийн цэрэг ТУХН-ийн ерөнхий командлалтай (одоо бол байхгүй болсон) тохирсоны эцэст хилийг нь хамгаалж байна. Нурекийн усан цахилгаан станц, Явань дахь химийн завод, Вахшийн аж үйлдвэрийн бүсийг оросын мотобуудлагын дивиз манаж байна. ТУХН-ийн тусламжтайгаар тажикийн өөрийн зэвсэгт хүчнийг бий болгосон. Гэвч энэ бүхэн ихээхэн хохирлыг давж байж бүтсэн ажил. ТУХН-ийн энхийг сахиулах ажиллагаа сөрөг хүчнийг зайлуулах, орон нутгийг тэднээс цэвэрлэх явдлаас эхэлсэн нь харамсалтай. Ийм зорилгоор хийсэн зөвхөн нэг сарын байлдаанд 20 мянган хүн алагдаж байсан баримт бий. Ийм нөхцөлд Тажикистанд (төрсөн нутагтаа) ялагдаж хөөгдсөн сөрөг хүчнийг Афганы тажикууд ивээлдээ авсан нь нууц биш. Үүнийг нэг талаас буруугтаж болдог юмаа гэхэд зөвтгөх бодитой учир шалтгаан бас бий.

Кавказ

Кавказын мөргөлдөөнийг Умард ба Өвөр Кавказын гэж хоёр ангилж болно. Умард Кавказын мөргөлдөөнд Кавказын нурууны ар бэлээр нутагладаг жижиг улсууд хамрагдана. Эд бүгд Оросын

Холбооны Улсын бүрэлдэхүүнд багтдаг. Өвөр Кавказад Нагорно-Карабах тухайн үедээ ЗСБНХУ-ын өөрчлөн байгуулалтын эмзэг цэг болсон бол Умард Кавказ нь Ардчилсан Оросын хувьд бас нэг эмзэг цэг нь болоод байна. Владикавказыг оролцуулан Умард Осетийн хэсэг нутгийг Ингуш шаардсанаас энэ дайн эхэлсэн түүхтэй. Орос өөрийн нутаг дэвсгэрийн салшгүй хэсгийн хувьд тийш нь цэрэг илгээж байдлыг намжаасан. Гэтэл асуудалд Чечень хөндлөнгөөс орсон. Ингуш руу илгээсэн Оросын цэргийн замд Чечень хөндөлдсөн. Үнэн алдартны шашинт осетийг Орос дэмжиж, лалын шашинт ингушийн эсрэг байна гэдгээр шалтаглан Чечень ингэснээ зөвтгөж байсан. Үхэл хагацал, дүрвэгсэд, эд материалын хохирлын тухай энд бичихээ больё. Нөгөө талаар Чечениэс бусад жижиг улсуудыг хуучин коммунист удирдагчид нь удирдаж байна. Тэд ардчилал, зах зээлийн харилцаанд бараг бэлтгэлгүй орсон, ерөөсөө энэ талаар хэлэх юмгүй шахуу сууж байна. Улс төрийн хуучин тогтолцоо нийгмийн зөрчлийг шийдэх хөшүүрэг болж чадахгүй. Үүний сацуу хуучинсаг коммунист захиргаа үндсэрхэг зам руу шилжиж байна уу гэлтэй. Чеченд ч ялгаагүй хууль ёсыг хөсөрдүүлсэн олон баримт дурдаж болно. Ельциний саналаар боловсруулж гарын үсэг зурсан Холбооны гэрээнд (1992 он) Чечениэс бусад бүх улс нэгдсэний дотор эндхийн жижиг улсууд байгаа юм. Эднийг тусгаар тогтнолоо зарламагц нь дэлхий дээр 4 улс (Эстон, Иран, Литва, Турк) хүлээн зөвшөөрснийг бас эргэж санах ёстой.

Энэ бүхэн олон жил их оросын нөлөөнд автаж явсан жижиг үндэстнүүдийг нойрноос сэрээсэн байж болох талтай. Дагестан, Кабардин - Балкар, Карачаев - Черкесс, Адыгейд Чеченийн оч халд-варлахгүй, Осетийн гашуун түүх давтагдахгүй гэх баталгаа алга. Ийм учраас Орос энд 1993 оноос идэвхтэй ажиллаж эхэллээ. Эхлээд ерөнхий сайдын орлогч, дараа нь Үндэстний хэрэг эрхлэх Улсын хорооны дарга байсан С.Шахрайг Умард Осет, Ингушийн засаг захиргааны тэргүүнээр томилжээ. Тэрээр тэр хоёрын хооронд гарсан нутаг дэвсгэрийн маргааныг зохицуулах арга зам сүвэгчлэх үүрэг хүлээжээ. Эндхийн асуудал дөнгөж намжиж байтал Чечень олон улсын анхаарлын төвд оров. Орос ч тэндхийн байдал хүндэрсэнд зохих хариуцлага хүлээх ёстой. Ардын депутатуудын үймээнийг толгойлоод ял эдлэх ёстой байсан чечень үндэстэн Хасбулатовыг Чеченд чөлөөтэй ажиллах боломжоор Орос хангасан. Чечень дэх дэглэмийг эсэргүүцэгч Автурханов гэгчийг зэвсэглэж дэмжиж түлхсэн хариуцлагыг Орос бас хуваалцах ёстой. Учир нь түүнийг болон Хасбулатовыг чеченьчүүд хүлээн аваагүй, гэтэл 1994 оны өвөл Чеченд байлдах үеэр Москвад Чеченийн үндэстний сэргэн мандлын Засгийн газрыг байгуулсан.

Оросын албаны хүмүүсийн мэдэгдэж байгаагаас үзвэл Умард Кавказ дахь эдгээр хямралыг Орос өөрийн дотоод хэрэг гэж үзэх ба Оросын нөлөөний хүрээнд байх ёстой гэнэ. Тэгээд ч Оросын

гадаад болногод Умард Кавказын улс түмэнтэй харилцах асуудал байр эзлэхгүй, энэ бол хууль сахиулах байгууллагын ажил гэж мэдэгдэж байна.

Энэр Кавказад бол мөргөлдөөний хоёр том голомт анхаарал татна. Эхнийх нь улиг болж гүйцсэн Нагорно - Карабах, нөгөө нь Гүрж юм. Гүржийн бие даасан эхний үед засгийн эрхийн төлөө гэмцэл ноцтой хурцаар тавигдсаныг дээр өгүүлсэн. Тэр үеэр түлхэгдэн унасан Гамсахурдиаг Баруун Гүрж, Мингрел дэмжиж, үүний сацуу Өмнөд Осетийн өөртөө засах муж салж бутрах аюул үүсгэжээ. Гэтэл энэ хоёроос гадна Абхаз хажуугаас нь гай удаж эхэлжээ. Оросын цэрэг Абхазыг хамгаалж байсанд маргааны нэг шалтгаан оршино. Орос хөрш зэргэлдээ бие даасан (тэр үед ТУХН-д элсээгүй байсан) улсын дотоод хэрэгт оролцож, өөртөө засах нэг улсыг нь дэмжиж байсанд Гүржийн удирдлага ихээхэн дүргүйцэж байлаа. Оросын ийм ажиллагааг Гүржийн удирдагч Э.Шевардназе түрэмгийлэлтэй адилтган үзсэн нь бий. Хэрэв Гүржийн доторхи байдлыг зохицуулж хүчрэхгүй, өөрөөр хэлбэл, Оросын хөндлөнгийн оролцоог зогсоохгүй бол энэ асуудлыг ТУХН-ийн хүрээнээс гаргаж ярихыг Гүрж хүссэн юм. Энэ зорилгоор 1992 онд Шевардназе НАТО-ийн төлөөлөгчдийг тийш нь урьж, НҮБ болон АНУ-аас дэмжлэг хүсчээ. АНУ-ын ерөнхийлөгч Ж.Буш Гүржийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг дэмжихээ илэрхийлсэн нь Шевардназегийн чармайлт зохих үр дүнд хүрснийх. Гэвч Абхаз бие даасан улс шиг гэжсөөр байлаа. Ингээд гал зогсоох, хүнд зэвсгийг цэргийн хамт гэдрэг татах тухай 5 баримт бичигт Гүрж, Абхаз хоёр гарын үсэг зуржээ. Гэтэл аль алиных нь буруугаас энэ тохиролцоо хэрэгжсэнгүй. Байлдаан дахин эхэлж, оросын цэрэг татагдан оржээ. Шевардназе тийш нь ТУХН-ийн энхийг сахиулагчдыг бус, НҮБ-ын хүчнийг оруулахыг шаардаж байна.

Карабахын тухайд энд дэлгэрэнгүй бичихгүй. Тэртээ тэргүй хэвлэлд их бичсэн, сүүлдээ улиг болж, шийдэх эсэх нь тодорхойгүй байгаа асуудал. Карабахын хямрал хичнээн удаан хугацаагаар үргэлжлэхийг хэн ч тааж мэдэхгүй. Лав ойрын хэдэн жилдээ өөрчлөлт гарахгүй бололтой. Ер нь эндхийн байдлыг шашин - үндэстний мөргөлдөөнд олон жил нэрвэгдсэн Ливантай зүйрлэж байгаа юм. Хүн амын ихэнх нь армянчууд, тэд Азербайжаны хууль ёсны засгийн газрын эсрэг зогсож байна. Гэтэл энэ нутаг Азербайжаны эзлэхгүй хэсэг. Одоогоор тэнцхийн армянчуудаас бүрдэх зорилгоо хамгаалах хүчин азербайжаны үндэстний армитай тулалдаж байна. Армений болон Карабахын армянчуудын зорилго нь өөр хоорондоо холбогдох зуртас гаргах, үүний тулд азербайжаны зарим хөл суурийг эзэлж авах. Азербайжаны зүгээс бүслэн хаахыг зогсоох (Арменийн Туркменсээс шалдан хий авдаг), харин азербайжаны зорилго нь нутгаа эзлэхгүй байх явдал. Энд байрлаж байсан коммунистийн цэрэг урьд нь байлдааныг шатлан өргөжүүлэх болгомж олгоогүй. Гэсэн ТУХН байгуулагдсаны дараа

тэндээс Оросын цэргийг гаргаж одоо тэдэнд саад болох хэн ч байхгүй болжээ.

1992 оны жишээн дээр олон улсын ямар зохицуулалт хийсэн, тэр нь хэр үр дүнд хүрсэн тухай дээр бичсэн. Карабахын хямралд сэтгэл түгшихгүй улс, олон улсын байгууллага Европт бараг үгүй болж гэхэд хилсдэх нь юу л бол. ТУХН-ийн томхон гишүүд (жишээ нь Орос, Казахстан), АНУ, НАТО-ийн гишүүд, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал, НҮБ, лалын орнууд бүгд ийшээ анхаарал хандуулж байна. Азербайжаны дотоод улс төрийн хямрал ч үүнд бас их нөлөөлсөн. 1991 оноос хойш тус орон төрийн тэргүүнээ хэд хэдэн удаа сольж, төрийн эргэлт хийх аюултай удаа дараа тулгарч байгаа.

Карабахыг тойрсон асуудал ийнхүү мухардсан учраас Каспи, Хар тэнгисийн сав газрыг хамтран ашиглах, худалдаа-эдийн засгийн хэвийн харилцаа тогтоох асуудал мөн бүдгэрч алга болжээ. Жишээ нь 1991 онд Хар тэнгисийн эдийн засгийн бүсийн орнуудын бага хурал хийсэн. Түүнээс хойш юу шийдэв? Тоймтой хариулт байхгүй. ЗХУ-ын үед бие биеэ нөхдөг байсан эдийн засаг улс задарсны дараа бас нурлаа. Жишээ нь Туркмений шатдаг хийгүйгээр Армен хэдэн өвлийг ардаа хийлээ. Туркмен бол асар их нефттэй, шатдаг хийн нөөцөөр ТУХН дотор Оросын дараа ордог. Гэтэл Армен руу эрчим хүч нийлүүлэхэд нь Азербайжан садаа хийж дөнгөсөөр байна. Каспийн нефтийг хамтран ашиглах тухай Орос-Азербайжаны тохиролцоо хоосон цааснаасаа хальж гарсангүй, тэгээд ч Кавказ дахь дайн дажин энэ хоёрын зам тээвэр-худалдааны харилцааг нэг бус удаа тасалдуулж байна. Хар тэнгист эдийн засгийн томхон нөлөө үзүүлэх учиртай Турк, мөн Иран лалын шашинт хөршүүдээ дэмжихийн хамт туркмений байгалийн баялаг дээр бараг уралцах нь холгүй байна. Энэ байдлаар Кавказ болон хоёр тэнгисийн дундах зурвас газар олон эрх ашиг, олон зөрчил, мөргөлдөөний төвлөрөл болох дөхжээ.

Цөмийн зэвсэг

Урьд нь нэгдмэл хяналтад найдвартай хянагдаж байсан цөмийн зэвсэг өнөөдөр дэлхий дахины сэтгэлийг түгшээдэг нэгэн зовиуртай асуудал болжээ. Яагаад ийм байдалд хүрэв? гэдэгт хэд хэдэн учир шалтгаан хэлж болно. Энэ аюултай, хөнөөл тарьж мэдэх зэвсэг «юуны өмнө улс төрийн байнгын хямралтай, тогтворгүй бүс нутагт байгаа билээ. Улс төрийн систем бүх чиглэлээр хямарч, амьдрал доройтож, үхэл зовлон тарьж буй газар хүн амын тогтвор суурьшил алдагдаж, хариуцлага сахилга сулардаг нь жам. Алдахаас айхгүй цайчихсан хүмүүс олшрох тусам цөмийн мөргөлдөөнд өдөөн турхирах, түүнийг гэмт хэргийн бүрдэл болгох, дамлах, хулгайлах, хил давуулах, цөмийн зэвсгээр барьцаалж дээрэм тонуул хийх гэж оролддог. Эцэст нь хэлэхэд хуучин Зөвлөлтийн цөмийн зэвсгийн технологийн хоцрогдол,

элэгдэл энэ зэвсгийг бүрэн хянаж, хадгалж байх боломжийг алдагдуулж байна. Бас цөмийн зэвсэгтэй үлдсэн ТУХН-ийн гишүүн орнуудын хувийн атгаг санаа (гадаад нэр хүндээ дээшлүүлэх, цөмийн зэвсгээр барьцаалж зээл тусламж хүртэх гэх мэт) онд бас нөлөөлснийг нэмж хэлмээр байна. Тэд хэрэг дээрээ цөмийн зэвсэг хураалгах ажлаа даян дэлхийд даатгаж орхиод, түүнийхээ төлөө нөхөн төлбөр авах, аюулгүй байдлын баталгаа гаргуулах бодолтой байна. Жишээ нь цөмийн зэвсгийн талаар этгээд байр суурь баримтласны төлөө Украин олон улсын тавцанд нэг хэсэг ганцаардаж үзлээ. Украины парламент энэ талаар их гэжжээ. Ерөнхийлөгч болон засгийн газар нь Цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх тухай 1968 оны гэрээнд нэгдэх бодолтойгоо аль эрт зарласан боловч парламент нь хэдэн жил цааргалжээ. Эцэст нь 1994 онд энэ гэрээнд нэгджээ.

Тэгвэл Белорусс, Казахстан хоёр цөмийн зэвсгээ хэл үггүй Орост тушаахаар болжээ. Гэхдээ Казахстан энэ бүхний төлөө АНУ-аас асар их төлбөр шаардсан юм. АНУ бол ТУХН-ийн орнуудын өмнө цөмийн зэвсэг харилцан хорогдуулах томхон гэрээтэй улс. СТАРТ-1, СТАРТ-2 гэрээгээр хоёр талын стратегийн довтолгооны зэвсэглэл, тэдгээрийг байнд хүргэх зөөгч хэрэгсэлийг хорогдуулах томхон үүрэг хүлээсэн. Жишээ нь Б.Ельцин, Ж.Буш нарын гарын үсэг зурсан СТАРТ-2 гэрээгээр (1993 он) хоёр тал 2003 оны наана цөмийн зэвсгийн сангаа гуравны хоёроор (20 мянга гаруй нэгж), түрүүчийн СТАРТ-1 гэрээнд тохиролцсон түвшинтэй харьцуулахад хоёр дахин хорогдуулахаар тогтжээ. Энэ тохиролцоонд урьдын ЗХУ-ын хэсэг байсан Украин, Белорусс, Казахстан бас хамрагдана. Үүний сацуу АНУ тэр 3 улстай тус тусад нь цөмийн зэвсгийн асуудлаар хэлэлцээ хийж байна. Украинаар жишээлж ярихад нутаг дэвсгэртээ буй цөмийн зэвсгийн сангаар дэлхийд гуравдугаарт орох зэвсэг ЗХУ-аас өвлөж үлджээ. АНУ-ын зүгээс анхаарч буй асуудал бол их хүч чадалтай СС-24, СС-18 пуужинг устгах, түүний төхөөргийг задлан буулгах, цөмийн цэнэгт хошууг нь Орос руу ачуулж, Орост устгуулах, пуужингийн уурхай цооногуудыг цэвэрлэх зэрэгт хөрөнгө олгож байна. Энд мөн Ук-раины цэргийн үйлдвэрүүдийг иргэний зориулалттай болгох, халагдсан офицеруудыг харж үзэх төсөв, цөмийн зэвсгийн үлдэх санг хамгаалах, тээвэрлэлтэд хяналт тавих, хулгай дээрмээс сэрэмжлэх зориулалттай хэдэн сая доллар тусад нь төсөвлөжээ.

АНУ-ын сенатч Сэм Нанн, Ричард Лугар нарын саналаар АНУ-ын Сенатад баталсан хуулийн дагуу 1994 онд 400 сая доллараар Украин, Казахстан, Белоруссыг ийнхүү харж үзсэн юм. Тэгээд ч америкчууд хуучин Зөвлөлтийн цөмийн цэнэгт хошууны хувь заяанд сэтгэл түгшиж, тэдгээрийг задалж буулгасны дараа бусад орны мэдэлд орох вий гэдгээс ихэд болгоомжилж буйн илрэл энэ билээ. Америкийн энэхүү болгоомжлол бас ч үгүй зөвтгөх үндэстэй бөгөөд Зөвлөлт шиг АНУ-ын оршин тогтноход заналхийлэхгүй ч

цөмийн зэвсгээр хөөцөлдөж, араасаа баахан үргүй зардал шаардаж мэдэх гэжүүд улс орон 80, 90-ээд оны заагт бүс нутагт гарч ирсэн юм. Тэдгээр нь АНУ-ын эрх ашигт нөлөөлж мэдэх Ирак, Иран, БНАСАУ, бас Ливи байлаа. Гурав дахь ноцтой асуудал бол цөмийн зэвсэг хяналтгүй тархах, алан хядагчдын гарт орох, түүнээс үүдэх болзошгүй аюул. АНУ чухам эдгээр 3 асуудлыг цогц байдлаар авч үздэг бөгөөд энд ТУХН-ийн цөмийн зэвсэг эхнийхэд явааг эрхбиш анхаарах ёстой. Гол нь хэр зэрэг сэтгэл түгшээх хэмжээнд байгаа нь илт байна. Энэ утгаар хөршүүдийнхээ цөмийн зэвсгийн талаар Оросын зүгээс баримталж буй байр суурийг дэмжих ёстой. 1993 он хүртэл ТУХН-ийн эдгээр 4 улс нийтийн тохиролцоонд хүрэлгүй хий маргаж, Украины зүгээс элдэв болзол тавьж байсныг одоо эрхбиш засах байх.

Эдийн засгийн харилцаа

ТУХН-ийн дотор талцах явдал гарч, бие биедээ эдийн засгийн дарамт үзүүлэх оролдлого хийсэн тухай дээр өгүүлсэн. Ер нь ингэхэд эдгээр орны өөр хоорондын харилцааг бодитой болгох, материалагжуулах гол нөхцөл-эдийн засгийн хамтын ажиллагаа хэрхэн хөгжиж ирэв ээ? Энэ бол хүндхэн асуудал юм. Гишүүн орнуудын эдийн засаг, валют-санхүүгийн салбарт зохицуулалт хийж байх шаардлагатай гэсэн санаа ТУХН байгуулах хэлэлцээрт бий. Гэвч энэ хэлэлцээрийг улсуудын парламент батлахдаа түүний үг үсэг, зүйл ангийг үндэсний сонирхолдоо нийцүүлэн дур зоргоороо засч өөрчилсөн юм. Энд Украиныг жишээлж болох байна. Хамгийн наад захын жишээ нь рублийн бүсийн тухай тохиролцоогоо зөрчиж, тус тусдаа мөнгөн тэмдэгт гүйлгээнд оруулсан явдал. Үүнийг Украин эхлүүлсэн. Орос дахь реформын аяыг бусад нь гүйцэж чадахгүй болохоор ингэсэн байж ч болох талтай. Нөгөө талаас дээд хэмжээнд хэлэлцэн тохирсон бүх тохиролцоо доод шатанд, үйлдвэрлэл дээр очоод дампуурах буюу завхарч байна. Өнөөгийн байдлаар ТУХН-ийн улсуудын дээд хэмжээний уулзалт дээр гарын үсэг зурсан эдийн засгийн хэдэн зуун хэлэлцээрээс нэг нь ч биелсэнгүй гэхэд бараг хилсдэхгүй. 1992 он буюу ТУХН-ийн гарааны жилээр авч үзвэл худалдаа - эдийн засгийн (эдийн засгийн гэж ёс төдий оруулав -Зох) тохиролцооны биелэлт 40-50 хувь, зарим нэр төрлийн барааны нийлүүлэлт 13 хувь, тодруулбал зэс 4 хувь, гянт болд 2 хувь, зарим нь огт нийлүүлж эхлээгүй байдалтай байжээ (100 хувиар авч ярьж байна). Энэ бол Оросоос бусад түншүүддээ нийлүүлэх ёстой байсан бүтээгдэхүүн. Бусад нь хий амлаад Орост юу ч өгөөгүй, жишээ нь тэр жил Орос Белоруссаас авах ёстой бензиний 6 хувийг, Туркменистанаас авах ёстой нефть бүтээгдэхүүний 10 хувийг, Украинаас авахаар гэрээлсэн сүүн бүтээгдэхүүний 2 хувийг дөнгөн данган хэл үгтэй авчээ. Ийм байхад "эдийн засгийн хамтын

ажиллагаа” гэсэн нэр томъёо энд хэрэглээд байх нь утгагүй юм биш үү.

Ийнхүү хэт тэнцвэргүй, урвуу интеграц явагдаж байгаа нь бас ч хүндэтгэж үзэх учир шалтгаантай юм. Доорхи бодит үндэслэлийг шалтгаан гэж үзлээ. Үүнд:

- ЗСБНХУ-ын гишүүн байсан улсуудын ижил төсгүй байдал ба эдийн засгийн хэт тэнцвэргүй хөгжлийн үр дагавар;
- ТУХН-ийн орнууд дотоодын зөрчил, бэрхшээл, зарим нь дайн дажинд нэрвэгдээд хамаг хүч нөөцөө тийшээ чиглүүлэх болсон;
- Орос, Украин мэт том орнууд нь бусаддаа тусалдаг өгөөмөр уламжлалаасаа татгалзсан;
- Орос, Украины тусламж хүртэхээ больсон Дундад Азийн улсууд ТУХН-ийн хилийн гадна уламжлалт биш түнш хайж, баахан цаг алдсан;
- Гишүүн орнууд дахь эдийн засаг улам бүр мафичлагдаж, эдийн засгийн гэмт хэрэг, хар зах “сүүдрийн эдийн засаг” өсч, удирдлага нь потроо эв түнжингүй байгаа
- Реформын хурд харилцан адилгүй, тодорхой хэлбэл Балтийн орнууд, Армен, Кыргызстан радикал (эрс), Украин, Казахстан болгоомжилсон, Узбекистан, Тажикистан хуучинсаг загвараар реформ хийж байна;
- Харилцан нийлүүлж буй барааны үнийн зөрүү, жишээ нь Оросоос хөршүүддээ нийлүүлдэг эрчим хүч дэлхийн зах зээлийн үнээс дээгүүр атал Дундад Азиас авдаг хөвөн, сахарын үнэ хэт доогуур гэх мэт гадаад худалдааны тэнцвэргүй байдал;
- ТУХН-ийн гишүүд үндэсний ашиг сонирхлоо урьтал болгоод хөрш улсуудынхаа доторхи суб’екттэй харилцахыг сонирхох болсон, жишээ нь Украинаас Якуттай, Казахстанас Башкортостан, Татарстантай гэх мэт тодорхойлж хэлэхэд хэцүү харилцаа үүсч байна.

ТУХН-ийн доторхи эдийн засгийн төдийгүй улс төрийн харилцааг будлиантуулахад энэ мэт шалтгаан нөлөөлж байгаа юм. Ялангуяа ТУХН-өөс гадаад орнууд, олон улсын байгууллагатай харилцахад ихээхэн бэрхшээл удаж байгааг анхаарах ёстой. Гадаадын зээл тусламж, гадаадад тавьсан өр, түүнийг төлөх асуудал гээд олон асуудал энд гарч ирнэ.

Дүгнэлт

ТУХН-ийн гишүүн орнууд бие дааж улс төрийн бодлогоо явуулах бэлтгэл нөөц боломжоор хомсхон байсныг дээрх баримтууд бэлхнээ хэлж өглөө. Эднийг чухам юу гээч ид шидийн хүчин ховсдон нэгтгэж байсан хэрэг вэ? гэж эргэж бодох үе ч бишгүй ирэх юм. Өөр хоорондоо ижил төсгүй үндэстэн ястны улс задран унасан нь цөмийн сүйрлийн аюулаас илүү "аюул занал" бий болголоо. Үүнийг нотлохын тулд доорхи дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Урьдын Зөвлөлтийн, одоогийн ТУХН-ийн нутаг дэвсгэр тэр чигтээ хямрал мөргөлдөөн, дайн дажны талбар болохын даваан дээр ирлээ. Энэ нь зөвхөн гишүүн улсууддаа бус, хөрш бүх улс, цаашлаад Христосын болон Лалын хоёр том соёл-иргэншилд нөлөөлж мэдэх уршигтай.
2. Тусгаар улс байж үзээгүй эдгээр орны удирдлага дахь үндэсний давилуун ихэрхүү санаа ТУХН-ийн ажил хэргийг цэгцлэхэд ихээхэн садаа болж байна. Энэ бол хямралын нэг уг сурвалж
3. ТУХН-ийн орнууд дотоодын элдэв бэрхшээл зовлондоо түүртээд гол асуудлаасаа хазайчихаа юу гэлтэй. Тэр нь улс төрийн ардчилал, хүний эрхийг дээдлэх, зах зээлийн чөлөөт харилцаанд эргэлтгүй шилжих явдал билээ.
4. Ардчиллыг гуйвуулах, буруугаар тайлбарлах, хуучнаа санагалзах, гудамжны популист авир гаргах явдал ялангуяа Орост ихээхэн газар авлаа. Түүний уршиг нь Улсын Думын сонгуульд нөлөөлсөн. Одоо ерөнхийлөгчийн сонгуульд нөлөөлөхгүй гэх баталгаа алга. Энэ бол Оросын ардчилалд нөлөөлөх хамгийн том аюул.
5. ТУХН-ийн доторхи үндэстэн-ястан, шашин шүтлэг, омог-аймгийн мөргөлдөөнд хандах хоёр хандлага ажиглагдав. Энэ нь урьдын коммунист захиргааны аргаар хандах; нөгөө нь их гүрний дээрэнгүй үзлээр хандах явдал. Энэ хоёр хоёул өнгөрсөн хэдэн жилд хангалттай нотлогдсон. Үүнийг засах ухаалаг хувилбар одоо хүртэл алга.
6. Эцэст нь хэлэхэд ТУХН-ийг интеграц биш, дезинтеграц хөтлөх болох нээ.

ТАВ. ТУСГААР УЛСУУДЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Энд бас л баярлуулах юм бичихгүй. Урьд бичсэн зүйлээ баяжуулах баримтжуулах хэлбэрээр хэтийн төлөвийг нь гаргана. Бас таамаглал дэвшүүлнэ. Энэ бол зохиогчийн байр суурь болохоос Монгол Улсын засаг, төрийн бодлого биш. Энэ утгаараа би зарим зүйлийг нэлээн "хатуухан" хэлье.

Орос орон: задрах уу, эвсэх үү?

ТУХН-ийн дотор Оросын эзлэх байр, нөлөөний тухай дээр өгүүлсэн. Үнэхээр бусадтай нь харьцуулахад тус орон үндэс угсаагаар салан тусгаарлах лай ланчигийг хамгийн их үүрч байгаа. Энэ нь үндэстэй юм. Оросын нутаг дэвсгэр дээр одоо бүгд найрамдах улс гэж нэрлэгддэг 21 өөртөө засах улс, нэг өөртөө засах муж, 10 өөртөө засах тойрог бий. Өөртөө засах улсуудын 16 нь Зөвлөл засгийн үед, нэг нь (Ингуш) ЗХУ-ын дараа Оросын парламентын шийдвэрээр байгуулагдсан улс. Мөн 4 улс мужаас улс болж төмөрчээ. Энэ тоон үзүүдэлтийн цаана улс төрийн систем дэх төвийг үгүйсгэх, төвөөс зайлсхийх хандлага, дезинтеграц нуугдмал байна.

Нутгийн орос хүмүүсийн бунд олон жил гэдэс цатгалан, сэтгэл амар явсан үндэстнүүд төр улсаа эмхлэн байгуулахтай тунсрахтайн аалтэрэг залвал ес юм шиг салан тусгаарлах замд орж байна. Хэрэв орон нутгийн төлөө бүхий улс төрийн хүчнүүд үүнийг дэмжвэл дийлдэшгүй, шийдэшгүй юмтай заавал учруулдаг боллоо. Үүнийг Чечень ягштал харуулав. Гэтэл орос оршин суугчид нь улс төрч төлөөлдөг газар ийм асуудал үүсдэггүй бололтой. Жишээ нь Саха Якут, Коми, Удмурт, Буриадыг энд нэрлэе. Эдгээр нутаг Москвад улс төрийн аюул учруулахгүй, гэвч нийгэм-эдийн засгийн хоцролдол, соёлын түвшин доогуур, экологийн асуудал гээд сэтгэл зориох өөр асуудал мундахгүй бий. Гэхдээ Чечень, Татарстан шиг аймгах нь юу бол. Эдэнд Холбооны гэрээнд гарын үсэг зурахгүй байх нөхцөл байгаагүй. Жишээ нь байгалийн баялгаа хянах шилжилтэвч тавьж буй Якутэд өөртөө засах эрх гээд байх юм юу байгаагай. Гэтэл Чечень, Татарстан хоёр Оростой хоёр талын үндсэн дээр харилцахыг хүсч байна. Татарстан баахан болгоомжилж, хэт даарч мэдлээс булзаж чадсан бол Чеченьд үүнийг өөгшүүлсэн. Үүнтэй хэв хожив. Татарууд хавьгүй хожсон. Эдийн засгийн хувьд Орос түүрхтэй байр эзлэх, ТУХН-өөр нэг гарсан татаруудын нөөцийг ашиглах, мөн лалын хүчин зүйлийг ашиглах гээд Оросоор зөвшөөрүүлж чадаж байгаа юмыг энд дурдах хэрэгтэй. Үндэстэн ястнаас гадна орон нутгийн салан тусгаарлах үзэл Орост учирч буй бол нэг аюул мөн. Байгалийн нөөц баялгаар гайхуулдаг, тэгэхдээ ихэвчлэн орос үндэстэн оршин суудаг нутагт, жишээ нь

Свердловск мужийн зөвлөлөөс "Уралын бүгд найрамдах улс" зарлан тунхаглаж байсныг дурдъя. Мөн тэнгисийн хавийн (Приморье) улс бий болох шахсан Энэ бол азаар цаасан дээр үлдсэн санаа.

Оросыг ийнхүү салан тусгаарлах саа өвчинд дайруулахад тус оронд урьд хожид дэлгэрч байгаагүй их оросын үндсэрхэг үзэл их нөлөөлж байна. Өнгөрүүлсэн 70 гаруй жил маань үндэсний гэсэн аль олигтой өв уламжлал, соёлыг коммунист гуйланч сургаалийн доогуур хийснийг бид мэднэ. Тэр дундаа Ленин, Сталин болон тэдний хамсаатан орос биш үндэстний удирдагчид энэ талаар уучлах аргагүй нүгэл үйлджээ. Эдийн засгийн хувьд бусдаасаа хувьгүй давуу, газар нутаг том, байгалийн баялаг ихтэй, ажиллах хүчний нөөц их, тэргүүний боловсон хүчинтэй гээд Орост давуу зүйл их байсан. Энэ бүхэн нь бусад хоцрогдсон бөглүүд улсуудын эдийн засгийн цоорхойг бөглөх, улсын төсвийн алдагдал, захиргааны их зардал, цэргийн төсвийг нөхөх хавсарга болсон нь нууц биш. Үүнд орос хүмүүсийн дүргүйцэж байгаа нь зүй ёсны үзэгдэл. Ийм хоёр шалтгаанаас гадна Орос орон, орос хүмүүс дэлхий хоёр дайнд хамгийн их хохирол амссан. Энэ бүхнийг ил тодын үүднээс гаргаж тавихыг үгүйсгэх аргагүй. Гэвч энэ бүхний цаана өс хонзон өвөрлөсөн, их гүрний дээрэнгүй үзэл түгших хэмжээнд цухалзаж байгаад хэргийн учир оршиж байна.

Үндсэрхэг үзэл оросуудын дунд идээлж, буглахад ЗХУ-аас хойш Оросын хилийн гадна өөрийн мэдэлгүй үлдсэн 25 сая орос иргэн, орос хэлийг эх хэлээ гэж үздэг 11 сая хүн ихээхэн шалтга болсон юм. Тэднээс олонхи нь онцгой хүнд нөхцөлд аж төрж, нэлээд нь тэнүүчилж явна. Энэ бол Оросын удирдлага, улс төрийн хүчнүүдийг ихээхэн түгшээж буй асуудал. Тэднийг Балтийн улсууд илэрхий адлаж, иргэний харъяаллыг хасах, эрхийг нь хязгаарлах зэргээр хэрдээ зовоосон. Молдовад үүнээс дээрдэх юм алга. Дайн болж буй Кавказад тэндхийн оросууд хэдэн жил ямагт дүрвэгсдийн байдалд явж байна. Лалын шашинт Дундад Азид оросуудыг ялгаварлан хавчих хандлага гарсан. Тажикистанд иргэний дайны хөлд олон орос хүн золиос болов. Арай гайгүй гэмээр дүр зураг Казахстанд бий. Белорусс, Украин хоёр слав туургатан ах дүүсээ бусдаас дээгүүр үздэг. Оросуудад хандах ийм олон янзын үзэл бодлоос гадна ТУХН-д энхийг сахиулах нэрээр илгээж буй Оросын цэрэг бусдаас хувьгүй илүү хохирол амсч байгаа.

Энэ бүхэн "ертөнцийн аль өнцөг булан бүрт оросуудыг хамгаалах" нэрээр хийрхэл дэгдээж, түүгээр далимдуулан улс төрийн хожоо хайх, ардчилал зах зээлд шилжих шилжилтийг эсэргүүцэх боломж бүрдүүлжээ. Үүний нэг тодорхой жишээ нь 1993 оны арванхоёрдугаар сарын Оросын парламентын сонгууль болжээ.

В.В.Жириновский

Оросын ард түмний түүхэн сонголтын үед тодрон гарсан улс төрийн шинэ маягийн зүтгэлтэн бол Оросын либерал-ардчилсан намын удирдагч энэ хүн билээ. Нам нь нэрэндээ хэр зохицсон эсэхийг энд ярихаа азная. 1933 онд Германд засгийн эрх авсан Германы ажилчны үндэсний-социалист нам мөн л нэрнээсээ хол хадуурсан бодлого явуулсан. Түүнтэй Жириновскийн намыг зүйрлүүлсэн явдал бийг дуръя.

Гэвч Жириновский Оросын түүхнээ мэндэлсэн, тэр ч бүү хэл түүний нам Улсын Думд олон суудалтай болсонд гайхах зүйл надад алга. Яагаад гэвэл энэ бол зүй ёсны үзэгдэл, нийгмийн жам хууль байлаа. Жириновский хүний санаанд оромгүй хачин жигтэй юм үе үе ярьж, баахан шуугиан дэгдээдэг, бичсэн ярьсанд нь түгшмээр болгоомжилмоор юм бишгүй бий. Гэвч энэ бол ганц түүний үзэл биш, өлсөж цангаж, тэнүүчилж, гуйлгачилж яваа түг түмэн орос хүний үзэл бодлын тусгай билээ. ЗХУ-ын задралаар бүх нөхцөл нь бүрдсэн Орос дахь нийгэм-улс төрийн хямрал, эдийн засгийн дампуурал тийм үзэл бодлыг Оросын хүн амын тодорхой хэсгийн дотор бий болгоод байна. Тагцхүү түүнийг илэрхийлсэн явдалд ганц Жириновскийг буруутгах өсгүй.

Жишээ нь түүний бичсэн "Өмнө түг сүүлчийн удаа ухасхийнэ" гэдэг ном байгаа. Зарим хуудсыг сөхөж үзье.

"... Оросын арми Дундид Ази, Кавказ, Молдовын сайн эрчүүдтэй тооцоо дуусгаж, Оросын өмнөд хилийг шинэчлэн тогтоож байж л сэргэн шинэчлэгдэнэ.

... Лалын аюулаас хүн төрөлхтөнийг аврахын тулд лалын ертөнцийг хагалах нь олонхийн хүсэл зоригт нийцнэ. Бусад шашин өнөөдөр санваартны дайнд мордох чадваргүй байна.

... Төр улс маань Орос орон гэж өөрийн нэртэй, эңэ нь түүхэн талаасаа ч, геополитикийн хувьд ч үнэн юм. Энэ нь ... евразийн бүхэл бүтэн тив, 22 сая ам дөрвөлжин км. Энэ бол умард хилийг минь угаасаа Хойд мөсөн дайлай, Алс Дорнодод Номхон далай, Хар тэнгис Балтийн тэнгисээр дамжаад Атлантын далай, сүүлчийн "өмнийн дайралтаа" хийсний дараа өмнө талдаа Энэтхэгийн далай гэсэн үг".

Жириновскийн эдгээр санаа цаасан дээр байгаа ч олон орос хүний сэтгэлийг эзэмдэж, хүсэл тэмүүллийг нь бадрааж яваа гэдэгт эргэлзэх юм алга. Энэ номд буй олон зүйлтэй би санал нийлэхгүй. Гэвч өрнөдийнхнийг түгшээсэн тэр хэсгийг нь тайлбарлахад дараагийн нэг бүлэгтээ тусгай зай үлдээлээ.

Дэг журам алдагдсан, гэмт хэрэг, хахууль өссөн, улс төр мафичлагдсан зэргийг Жириновский ардчиллаас боллоо гэж үзсэн нь олон сонгогч, улмаар социалист хөдөлмөрийн ахмадууд, ахмад дайчид (Зөвлөлтийн сталинчдын холбоо гэх мэт олон нийтийн байгууллага), чөлөөнд болон бэлтгэлд буй офицерууд, гудамжны люмпен пролетариудын сэтгэлд яв цав нийцсэн. Бас хил

хязгаарын бөглүүд хоцрогдсон нутагт түүнийг ихэд дэмжиж байна. Энэ бүхэн 1993 оны тэр сонгуульд шууд нөлөөлсөн билээ. Тэр бас 1991 онд Оросын ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхдөө 8 сая гаруй хүний санал авсныг (авсан саналаараа Ельцин, Рыжковын дараа гуравдугаарт орсон) бодолцвол улс төрийн тавцнаа хүлээн зөвшөөрөхөөс аргагүй зүтгэлтэн болж таарна. Хамгийн харамсалтай нь Оросын шинэ залуу, хөл дээрээ тогтож ядаж байгаа ардчиллыг эзэнт гүрний сүйрэлтэй холбож, Оросын ардчилсан хүчнийг АНУ-ын тагнуул туршуул мэтээр гүтгэж, хөрш бүх орноо занан зүхэж, бүс нутгийн дайн мөргөлдөөнд хошуу дүрж, арьс өнгөний үзэл дэвэргэж байгааг нь Оросын хүн амын тодорхой хэсэг дэмжиж, Оросын эв нэгдлийг авч үлдэх, улмаар хөгжиж дэвжих ирээдүйгээ түүний ийм үйл ажиллагаатай холбож байгаад би санаа зовж байна. Хэрэв Оросын ард түмэн ерөнхийлөгчийн дараагийн сонгуульд түүний төлөө санал өгөх аваас 1933 оны Герман давтагдахгүй гэх баталгаа алга.

Хямрал үргэлжлэнэ

Дээрхи хоёр гарчигтай танилцаад Оросоор жишээлэн бутрал, хямрал үргэлжлэнэ гэсэн дүгнэлт хийвэл үнэнд илүү ойртоно. Орос болон ТУХН-ийн орнууд дахь дотоодын бэрхшээлт хүчин зүйлүүд тэртээ тэргүй хямралыг төрүүлэгч ундарга. Түүнийг засах талаар ойр мөддөө олигтой үр дүнд хүрэхгүй. Учир нь ТУХН-ийн хаана ч гэсэн байнга тогтвортой ажиллаж буй *Улс төрийн бүтэц, механизм* алга. Тэр ч бүү хэл Туркменистанд ардчилалтай эрс харшлах нэг хүнийг тахин шүтэх үзэгдэл эрчээ авсан. Тэндхийн ерөнхийлөгч С.Ниязовыг эзэн хаан буюу шах, эмир гэж нэг өдөр өргөмжлөхөд гайхах зүйл алга. Нэг хүний дарангуйлах нөлөө, нэг хүний үүргийг хэт үнэлэх явдал ТУХН-ийг (ялангуяа Дундад Ази) нэг хэсэгтээ л зовооно. Ерөнхийлөгчийн болон гүйцэтгэх хүчтэй засаглалыг улс бүр шүтэж, парламентын үүргийг түүнээс доогуур үзэж байгаа (парламентын ардчиллын тухай ярих нь эрт байна) зэрэг олон баримт үүний жишээ. Ийм байхад иргэний ардчилсан нийгмийн тухайд нэг хэсэгтээ уриа лоозонгоор хязгаарлаж байхаас яахав. Балтийн 3 улс, Арменаас бусад бүх газар засгийн эрх найдвартай биш байна. Улс төрийн хүчний тэнцвэр ч гэж алга. Үүнээс үүдэн хэврэг улс төрийн систем бий болж хэлж таах аргагүй уршиг дагуулж мэдэх юм. Ийм тогтворгүйгээс олон түмний улс төрийн идэвх унажээ. Хүн амын толгой эргэж гүйцээд манан дунд төөрчээ. Ийм нөхцөлд улс төрийн бүтцийн эсрэг талд нийт хүн ам бөөгнөрч, бүгд сөрөг хүчин болох, эсвэл эмх замбраагүй байдал ноёлж, гэмт хэрэг цэцэглэх, яваандаа төр улс мөхөх ийм ирээдүй хүлээж байна. Төр засаг хяналтаа алдах тохиолдол бүрт дороос гарсан нийгмийн хөдөлгөөн, тухайлбал, Оросын үндсэрхэг үзлийн илрэл-казакийн хөдөлгөөн, цэргийнхний болон цэрэгжсэн, фашист,

хэт даврагчид, террорист байгууллагууд идэвхжиж байгаа нь мэдээж.

ТУХН-ийн гишүүдэд бараг албан ёсны болчих гээд байгаа үндсэрхэг үзэл угаасаа тохиолдлоор үүссэн ч юм биш. Тэр бол коммунист догматик сургаалийг, ЗХУКН-ын албан ёсны үзэл суртлыг орлож гарч ирсэн юм. Учир нь энэ хоёр үзэл суртал бол хоёул ардчиллын үнэт зүйлийг гэхээсээ нийгмийг нэгтгэх, нийгмийн анги бүлэг элементүүдийг нэг дор бөөгнүүлж хянаж байхыг гол болгодог юм. Энэ утгаар бол энэ хоёр сурталд олон намын тогтолцоо, засгийн эрхийг ухаалгаар хуваах, хүний эрх, хувийн өмчийг хүндэтгэх, хуулийг дээдлэх, зах зээлийг эдийн засгийн гол зарчим болгох явдал бүгд харш. ТУХН-ийн орнууд шилжилтийн үедээ будлиад удаад байгаа нь үүнтэй л холбоотой. Нөгөө талаас үндсэрхэг үзэлд эерэг зүйл бий. Жишээ нь 1991, 1993 оны үймээнийг чухамдаа үндсэрхэг үзэл л дарсан. Хэрэв ардчилал ганцаараа түүнтэй тэмцээд үндсэрхэг үзэл нь сугарч үлдсэн бол ялалт Зөвлөлтийн эзэнт гүрнийг сэргээх талынханд өмчлөгдөх байсан нь мэдээж. Бас үндсэрхэг үзэл тогтвортой байдлын нэг хүчин зүйл болж байна. Үүнийг жишээг Казахстан, Узбекистан, Кыргызстан, Туркменис- танаас харж болно.

ЗХУ-ын Төрийн далбааг Кремлийн цамхагаас буулгасны дараа 70 сая хүн өөрийн үндсэн нутаг дэвсгэрийн гадна үлдсэн. Үүнийг орос үндэстнээр төлөөлүүлсэн баримт дээр бий. Эдгээр олон сая хүн ТУХН-д өдөр ирэх тусам бэрхшээл удаж байна. Бэрхшээлийг гэтлэн давах бүх ородлого бүтэлгүйтэж байна. Үүнийг хэн хэндээ ашигтай, харилцан буулт хийхээр шийдэж чадах хувилбар алга. Энэ бол ТУХН-ийн ирээдүйг баргар төсөөлөх нэг баримт. Тэгээд ч үндэстний цөөнхийн асуудлаас үүдэж түүхэнд олон хямрал тохиолдож байсан баримт бэлхнээ бий. Үндэстний цөөнхийг дагалдаад *нутаг дэвсгэр-хил хязгаарыг хянаж үзэх асуудал* гарч ирдэг. Өнөөдөр ТУХН-ийн бүх оронд энэ асуудал будлиантай, эгзэгтэй байна. 1991 онд ЗХУ задрахдаа улс төр-эдийн засгийн олон нөхцөл шалтгаанаар нөхцөлдсөн нь мэдээж боловч түүнийг хуулийн дагуу (жишээ нь Чех, Словак хоёр эв зүйгээр салдаг шиг) шийдээгүйгээр мөргөлдөөн, хилийн бөөн маргаан үлдэж хоцорсон юм. Тэгээд ч 15 улс бие дааж салахдаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалаа хамгаалах асуудлыг эхэлж тавьсан. Ерөөсөө нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал бол тусгаар тогтнол, төрт ёсны бэлгэ тэмдэг юм.

ЗХУ-ын дотоодын хил хязгаар нь улс төрийн онц ач холбогдолгүй, засаг захиргааны хуваарийн шинжтэй байснаас энэ асуудал будлиантай үндэс тавигдсан. Ингээд *хилийн статус* улс хоорондын асуудал болж 1991 онд тавигдахад олонхи нь түүнийг хууль ёсных гэж хүлээн аваагүй. Түүний тодорхой жишээ бол Нагорно-Карабах, Өмнөд Осет, Абхаз, Днестрийн хавийн нутаг. Орос-Украины хооронд Крымээс гадна оросууд олноороо оршин

суудаг Дорнод Украин маргаан тарьж мэднэ. Бас хүн амын бүтцийг нь харгалзвал Казахстаны умард, зүүн хойд нутаг Орос-Казахстаныг хооронд нь хэрэлдүүлж болзошгүй. Дундад Азид маргаантай нутаг бүр ч их бий. Балти хавьд Орос-Эстониин хооронд, Литва-Белоруссын хооронд хилийн маргаан дэгдсэн. Бүр хатуу үгээр харилцан дайрах хэмжээнд хүрч байсан. Балтийн улсуудад Калининград муж гэж "хамар дээр гарсан үү" бий. Тэндхийн оршин суугчид Жириновскийг дэмжсэнийг бодвол маргаан бүр ч хурцаар тавигдана. Балтийн улсууд Балтийн ассамблейгээс (парламентын гишүүдийг нэгтгэдэг) Калининградыг цаашид цэрэгжүүлэхгүй байх тухай тогтоол баталсанд Орос их бухимдаж байна. Германд Калининградын асуудалд оролцох хүчин гарч ирж байна. Тэд Потсдамын хэлэлцээрийг хянаж үзэх, энэ асуудлаар Орос-Германы хооронд хэлэлцээ хийх асуудлыг сэдэж байна.

Энэ мэт хилийн асуудалд оролцох орнууд ТУХН ийн гадна бас бий. Өмнөд Курилын арлуудыг Япон хойшдоо ч аливаа түншлэлийн болзол болгон тавьсаар байх болно. ЗХУ-аас хойш оросууд энэ маргаантай нутгийг шилжүүлж магадгүй гэсэн японы горьдлого тасрахгүй бололтой. Бас дэлхийн хоёрдугаар дайны өмнө ЗХУ аас баруун зүгт явуулсан геополитикийн алхмууд хилийн маргаан дэгдээх үндэс болж байна. Финланд Орос, Польш, Белорусст, Польш, Румын, Словак Украинд нутаг дэвсгэрийн "өнгөлзлөг" тавихыг хэн байг гэхэв. Хэрэв түүхийн хар цагаан толбыг арилгах, дайны өмнөх коммунист-фашист хуйвалдааны хор уршгийг илчлэх тухайд шударгаар хандъя л гэвэл ийм асуудал зайлшгүй гарч ирнэ. Өнөөдөртөө хурцаар яригдаагүй ч Хятадаас Орос, Казахстанд, Афганистанаас Тажикистанд, Туркээс Азербайжанд хилийн маргаан дэгдээж болох талтай. Үүнд шашин шүтлэг нь ч нөлөөлөх биз ээ.

ТУХН-ийн ирээдүйг бүрхэгдүүлж буй бас нэг асуудал бол цэргийн асуудал юм. Зөвлөлтийн нэгдмэл зэвсэгт хүчнийг үндэсний арми болгож хувиргах шилжилтийн тухай ярьж буй хэрэг. Энэ шилжилт дайн дажинтай хамт явагдаж байгаад хэргийн учир, бэрхшээлийн гол нь оршиж байна. Зөвлөлтийн батлан хамгаалах потенциалын ноён нуруу болж байсан Орос эхэндээ ийм шилжилт хийхийг хүсэхгүй байсан. Түүний шалтгаан ч тодорхой. Бодитой байж байгаа, түүнийг бий болгох гэж их зардал чирэгдэл гаргаснаа бодоод амархан нурж унах вий гэдгээс Орос болгоомжилсон хэрэг. Тэгтэл бусад нь ТУХН-ийн зэвсэгт хүчнийг Москвагийн нэгдсэн командалд хав барьж авах нээ гэж болгоомжилсон. Түүнээс үүдэн тэр бий болоогүй мөртлөө бодитой байж байсан зэвсэгт хүчнээ юу гэж нэрлэх (нэгдсэн, хамтарсан, нийтийн гэх мэт) талаар баахан маргасан. Бас хардлага сэрдлэг, талцах, хуваагдах явдал ч дагалдсан. Ийм маргаан зөвхөн ТУХН-ийг зовоож байсан юм биш. Европ, өрнөдийнхнийг түгшээсэн. Учир

нь зэвсэглэл, зэвсэгт хүчинтэй холбогдсон олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн хувь заяа үүнээс шууд шалтгаална. Ер нь "Хүйтэн дайныг" эцэслүүлсэн олон алхам зэвсэгт хүчнийг хорогдуулах асуудалтай холбоотой. Энэ утгаар ТУХН-ийн орнууд зэвсэгт хүчинтэй байдаг юмаа гэхэд тэр нь хамгийн доод түвшинд байх ёстой. Гэтэл нөхөрлөл дэх хямрал, дайн дажин тэгэхийг зөвшөөрөхгүй. Гэхдээ ТУХН 1992 оны Ташкентын хэлэлцээрээр Атлантын далайгаас Уралын нуруу хүртэл зэвсэгт хүчнээ хорогдуулах талаар тохиролцсон. Ингэж хорогдуулах нь ТУХН дэх онцлогтой нягт хослох ёстойг дэлхийн хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрч байна. Харин удаашралтай байгаад шүүмжлэл гардаг.

Украин, Белорусс хоёр нутагтаа байсан Зөвлөлтийн армийг үндэсний болгож чадлаа. Энэ нь Зөвлөлтийн цэргийн номлол Европ руу хэт их төвлөрч байсных. Бусад нь хагас дутуу, тэр ч бүү хэл зарим нь бүдүүлэг хэлбэрээр үүнийг хийж байна. Тэнд байсан Зөвлөлтийн арми үндэсний болж чадаагүй үедээ зэвсэгт мөргөлдөөнд шууд татагдан орсноос ингэсэн хэрэг. Тэгж байлдаж байгаа улсуудын, жишээ нь Кавказынхны практикаас харахад хуучин Зөвлөлтийн армийг нутагтаа хэд хэдэн зорилгоор ашиглах бодолтой нь харагдав. Тухайлбал, тэдний хүчээр эсрэг талдаа цохилт өгөх, зэвсэг техникийг мэдэлдээ бүрэн авах, эцэст нь Оростой харилцахдаа хэрэгсэл болгож ашиглах (барьцаа болгох, улс төрийн хожоо олох гэх мэт) хандлага ажиглагдав. Нөгөө талаас Орос өөрөө шийдмэг бус, дотроо зөрчилтэй байгаа нь үүнд их дэм болж буй бололтой. Хамгийн түгшүүртэй нь Зөвлөлтийн армийн ихээхэн зэвсэг техник гэмт хэрэгтнүүдийн гарт орж, хүн амын дунд хяналтгүй тархаж байгаа явдал. Цэргийн сахилга суларсан, байлдааны бэлэн байдал алдагдсан, цэргийн ар гэр хохирсон тухайд энд ярихаа азная.

ТУХН-ийн статус

Энэ бол ярих ёстой нэг асуудал. ЗСБНХУ-аас ТУХН-д шилжих үйл явц замын бэлчирт байна гэх үү дээ. Төгс төгөлдөр болох өдий байна. Яагаад гэвэл ТУХН-ийн эрх үүрэг, статус тодорхойгүй, бий болсон улсууд нь жинхэнэ бие даасан бүрэн эрхт улс болоход дэндүү хол, ерөөсөө тэдгээр орны тусгаар тогтноё гэсэн тэмүүлэл араасаа өдий төдий асуудал дагуулж байна. ЗХУ-ыг тарааж байх үед ТУХН ашигтай нь харагдсан байх. Хооронд нь байлдуулалгүй салгаж чадсан тухайд тэр л дээ. Гэтэл олон улсын харилцааны хуучин систем шинээр солигдох үетэй давхцсаны хувьд тэр ашиг нь харагдахгүй байна. Тэрхүү шинэ системд зохицон ажиллах чадвар нь дутаад хий идэвхи л үлдэж дээ. ТУХН урьдын ЗХУ-ын бууриар хэнтэй ч харилцаж чадахгүй, тэгэхийг ч Украин, Молдов, Азербайжан, Туркменистан зэрэг "хэт бие даагчид" хүлээн зөвшөөрөхгүй. Дахиад ч хэт их томдсон төр улсын бүтэц, үндэсний тусгаар тогтнолыг дарж нухсан, ёс төдий болгосон тийм бүтцийг

ер нь хэн ч хүсэхгүй. Энэ утгаар ТУХН бол оролцогчдынхоо маргааны сэдэв байсаар байх болно. Жишээ нь Казахстаны ерөнхийлөгч Н.Назарбаев хамтын нөхөрлөлөө конфедерац болгож бэхжүүлэх санал уйгагүй тавьж байна. Түүнийхээр бол "Евразийн орон зай" гэгч бий болох аж. Тэр нь 3 үе шаттай.

1. Эдийн засгийн (Назарбаевынхаар одоо хэрэгжиж байна)
2. Хүмүүнлэгийн (хүний эрх хамгаалах, соёл, шинжлэх ухааны солилцоо)
3. Капиталист (тэр нь тодорхойгүй) гэж байх гэнэ.

Хэрэв ТУХН бэлэн биш бол Оростой эхлээд ийм конфедерац байгуулах бололтой. ТУХН-ийн дотор эдийн засаг, батлан хамгаалах, гадаад бодлогыг уялдуулж байх зорилготой нэг бүтэц бий болгох, стратегийн асуудал хэлэлцэж байх төр, засгийн тэргүүн нарын зөвлөл байгуулах, дараа нь нэгдсэн парламентын сонгууль хийх, ЭЗХТЗ-ийн нарийн бичгийн дарга нарын газар маягтай Гүйцэтгэх зөвлөл байгуулж, түүнийг НҮБ болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд ажиглагч статустай оролцуулах гэх мэт үзэл суртлын нэр хүнд олох зорилгоор Назарбаевын дэвшүүлсэн үл гүйцэлдэх олон саналыг жагсааж болох байна. Тэдгээрийг ТУХН-ийн гишүүд хүлээн аваагүй нь мэдээж. Энд Украин, Белорусс, Дундад Ази дахь 3 хөрш нь бүр эсэргүүцсэн. Орос бол интеграцын шинэ хэлбэр бий болгохыг үгүйсгэхгүй ч улс үндэстний эрх ашиг хохирох ёсгүйг сануулж байгаа.

Асуудал ийм маргаантай, нэг мөр болоогүйгээс ТУХН өөрөө олон улсын харилцаанд статусаа тогтоож чадахгүй, ядаж юу гэж оноож нэрлэхэд ч түвэг удаж байна. Үнэндээ бол, олон улсын байгууллага, нэгдэл холбоо аль ч утгаараа биш, ерөөсөө олон улсын хуулийн субъект болж чадах уу гэсэн асуудал ч тавьж болно. Энэ талаар хуульчид маргасаар байх биз ээ. Бас Дундад Азийн бүс нутгийн хамтын нийгэмлэг ТУХН дотор байгуулах оролдлого гарч байсныг (1993 оны эхээр) эргэж саная.

Ийнхүү статус нь тодорхойгүй байгаагаас энэ нөхөрлөлтэй харилцдаг улс орнууд, олон улсын байгууллагууд харилцах арга хэлбэрээ зөв тогтоож чадахгүй өнөөг хүртэл эрлийн замд явцгааж байна. Тэгэх тусмаа өрнөдийнхнийг нэн зовоож байгаа. Яагаад гэвэл тэдний үзүүлж буй зээл тусламж хаашаа явж байна вэ? Үр дүн аль вэ? гэдэг ноцтой асуудал гарч ирнэ. (Энд ТУХН болон түүний гишүүд эргүүлж зээлээ хэрхэн төлөх вэ? гэдгийг бүр орхиё) Жишээ нь Орост зээл олгох дээр Олон улсын валютын сан тун хөшүүн хандаж байгаа. Оросын эдийн засаг, улс төрийн бодлого гуйвж дайвсаар байгаа цагт ер нь яах болж байна. Ялангуяа эдийн засгийн бодлого эргэж буцсаар байгаад зээлдүүлэгчдээ бүр хашрааж орхив. Зээл тусламж хүртэх нэг үндэс бол өгөх хүний өгөөмөр сэтгэлээс гадна тухайн орны эрх баригчид эдийн засгийн ирээдүйгээ зөв харах, энэ талаар нэгдмэл үзэл баримтлалтай байх

явдал. Рублийн ханш сэхээ сэтээгүй унаж байхад түүнийг тогтворжуулах ямар ч татаас нэмэр болохгүй. Ингээд сүүлдээ өрнөдөд ийм тусламжийг танах хасах талынхан эрх баригчидтайгаа зөрчилдөх байдалд хүрч байна. Энэ зөрчил нь засгийн эрхийн асуудал ч нөлөөлж мэдэх юм. 1994 оны арваннэгдүгээр сард АНУ-д явагдсан конгрессын сонгуульд Бүгд найрамдах нам ялалт байгуулсныг үүнтэй холбож болох юм. Шинээр сонгогдсон буюу улирсан олон сенатч ТУХН рүү илгээж буй их зардал үргүй өнгөрч буйг анхааруулж, үүнд нь АНУ-ын засаг захиргаа ч бодит тайлбар өгч байгаа. Энд АНУ-ын дэд ерөнхийлөгч А.Горын хэлснээс иш татъя. "Хэрэв Орос дахь үйл явц буруугаар эргэвэл манай орон ямаршуу зардал гаргахыг тооцох, ирээдүйг угтан харахад нэг их ур ухаан шаардагдахгүй. Байдал өөрөөр эргэж цөмийн сэргөлдөөн сэргэвэл, хэрэв дарангуйлалд буцаж орох чиглэлээр явбал юу болох вэ? Тэр бүхний үр дагавар ямар байх вэ?" гэж тэрээр хэлжээ. Энэ бол Орос болон ТУХН дэх нийт тогтворгүй байдал дэлхий дахиныг цаашид хямруулахгүй гэсэн баталгаагүйг хэлж байна гэсэн үг. Энэ утгаар өрнөдийн зээл тусламжийн бодлого "тогтоон барих" нэг хэрэгсэлийн үүрэг гүйцэтгэж байна гэж дүгнэмээр байна.

Дүгнэлт

ТУХН-тэй холбогдох олон асуудал дараагийн бүлгүүдэд орох нь мэдээж. Гэвч энэ бүлэгт бичсэнээ доорхи байдлаар дүгнэж байна. Үүнд:

1. ТУХН-ийн үүсэл хөгжлийн эхний үеийг (1991-1994 он) авч үзвэл, хуучин ЗСБНХУ-ын нутаг дээр маш тогтворгүй бүлэг улс бий болжээ. Тэндхийн хямрал мөргөлдөөн, дайн дажин 30-40 жил үргэлжлэх төлөвтэй гэсэн зарим улс төр судлаачдын дүгнэлтийг энд зориуд иш татах нь зүйтэй.
2. Эдгээр орнуудын эдийн засгийн харилцан хамаарал, бие биегүй оршин байх чадваргүй зэрэг нь дезинтеграцийг улам гүнзгийрүүлэхээс биш зогсоож чадахгүй бололтой. Харин ч хамтдаа цуг унах түлхүүр болж мэдэх юм.
3. ТУХН-д лалын шашны нөлөө улам нэмэгдэх бололтой. Лалын шашинт гэр бүл орос айлынхаас 3 дахин олон хүүхэдтэй, 2020 он гэхэд ТУХН-д төрөх хоёр хүүхдийн нэг нь лал мөргөлтөн байна гэсэн тооцоо бий. Одоо нийт хүн амын 52 хувийг бүрдүүлдэг оросууд ирэх зуунд үндэстний цөөнх болох байдал бүрдэж байна. Оросууд Кавказ, Дундад Азид ихээхэн оролцоод байгаа нь ТУХН-ийн дотоодын асуудал биш, слав-христос соёл-иргэншлээ аврах оролдлого болов уу. Тэгээд ч энэ хэзээ нэгэн цагт илэрхий болж, ТУХН дотор шийдэхэд бэрх байдал үүсгэж болзошгүй (Зөвлөлтийн цэрэг Афганистанд орж, ЗХУ Иран-Иракийн мөргөлдөөнд сэтгэл түгшиж байсныг бас ингэж тайлбарлан)

4. ТУХН дэх хямрал дэлхий дахинд шинэ нөхцөл байдлыг тулгалаа. Үүнээс үүдэн батлан хамгаалах, аюулгүй байдлаа бэхжүүлэх, хэрэг дээрээ зэвсэглэлээр хөөцөлдөх, цэргийн зардал нэмэхийг зарим улс орон шаардаж байна. ТУХН-тэй хил залгаа бүс нутаг (ялангуяа Европ), жижиг улс үндэстнүүд ойртон нягтрах замд эргэлтгүй орох боллоо. Дорнод Европын жишээн дээр үүнийг бүр сайн нотолж болох байна.

Холбогдох ном, хэвлэл

1. Три "Да" президенту, "Московский рабочий", 1993.
2. Правда о Приднестровье, Тирасполь., 1992
3. Горбачев. Августовский путч. М, "Новости", 1991.
4. Феномен Жириновского, М, "Контроллинг", 1992.
5. Государственный визит Президента РФ Б.Н.Ельцина в США. М, "Международные отношения", 1992.
6. Анатолий Лукьянов. Переворот мнимый и настоящий, М, "Пелея", 1993.
7. Александр Яковлев. Предисловие, обвал, послесловие. М, "Новости", 1992.
8. Владимир Барановский. Конфликтное наследство Советского Союза., Ежегодник СИПРИ. Москва "Наука", 1993.
9. Владимир Жириновский. Өмнө зүг сүүлчийн удаа ухасхийнэ, УБ., 1994.
10. Концепция Внешней политики Российской Федерации, "Дипломатический вестник" Январь 1993.
11. Шолпан Жаксыбекова. Новые государства Центральной Азии: состояние и перспективы экономического развития, "Казахстан и мировое сообщество" №1 1994.
12. Стратегические проблемы экономической реформы в России (Информационно-аналитический бюллетень, №1,2) Российский Институт Стратегических исследований, М., 1993, 1994
13. Sipri yearbook 1993. World Armaments and Disarmament, Oxford University press. 1993.
14. Sipri yearbook 1994. World Armaments and Disarmament, Oxford University press. 1994.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТУСГААР УЛСУУДЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛ БА ОЛОН УЛСЫН ШИНЭ ХАРИЛЦАА

ТУХН байгуулагдсанаар олон улсын харилцаанд нэлээд өөрч-лөлт гарч, дэлхий нийтийн болон бус нутгийн чанартай асуудлууд хувьсан өөрчлөгдөж байна. ТУХН дэх олон улсын маргаантай асуудал дэлхий нийтийн уур амьсгалд шууд ба дам байдлаар нөлөөлөх хандлагатай байна. Энэ талаар түрүүчийн бүлэгт цухас дурдаж бас зарим дүгнэлт таамаглал хийсэн байгаа. Үнэндээ ЗСБНХУ-ын задралыг угтан тосч, хүлээж бэлт- гэж байсан улс орон ховор. Тэр дундаа "Хүйтэн дайны" төмөр хөшигний хоёр талаас энэ улстай олон арван жил цусгүй дайн хийж ирсэн өрнөдийн түншүүд нь ч үүнийг тэгтлээ хүсээгүй. Тэдэнд бат тогтвортой, найдвартай түнш (эсвэл өрсөлдөгч) хэрэгтэй байснаас бус задарч бутарсан, эв түнжингүй, хяналтгүй түнш хэрэггүй. Энэ утгаараа ЗХУ-ыг сулруулахыг олон жил зорьж ирсэн АНУ ба өрнөдийн орнууд эргээд амаа барих явдалтай бишгүй тохиолдож байна. Тэдний зорьж хүсч ирсэн тэр хүсэл тэмүүлэл, социализмтай хийсэн урт удаан хугацааны нөр их тэмцэл эцсийн бүлэгт ийм юманд (ЗХУ-ын задрал ба түүнээс үүссэн бэрхшээл) хүргэнэ гэж санаагүй байх. Зэвсэглэлээр хөөцөлдөхийн түмэн зовлонг амссан европчууд, Европын аюул-гүй байдлыг өөрийнхөө зардлаар батлан дааж ирсэн америкчууд эргээд хуучин замдаа орно гэж хүсээгүй. Гэвч хясал ирж, тэд ТУХН-өөс үүдэх мөргөлдөөн хямралдааны уршгаас сэргийлэхээс өөр аргагүйд хүрч байна. Дахиад л цэргийн зардал урсгах, олон сая цэрэг байнга бэлэн байдалд барьж байх шаардлага тулгарлаа. Энэ дүгнэлтээ нотлох үүднээс ТУХН-д өрнөдийнхөн ямар байр сууринаас хандаж байгааг баримтаар өгүүлье.

НЭГ. ТУХН-АНУ-НАТО-ЕВРОП

ТУХН ба АНУ

АНУ-ын түрүүчийн засаг захиргаа ч, өнөөгийн ерөнхийлөгчийн засаг захиргаа ч ялгаагүй ТУХН, ялангуяа Оросыг их дэмжсэн. Хөлөө олж ядан тэнтэр тунгар яваа Оросын ардчиллыг хөхүүлэх, хүний эрхийг баталгаатай болгох, зах зээлийн харилцаанд аль болох хохирол багатай шилжихэд нь энэ дэмжлэг чиглэж ирсэн. Хэдхэн баримт дурдъя ТУХН-тэй харилцаагаа бэхжүүлэхэд зориулж АНУ-ын засаг захиргаа 1992 оны санхүү-гийн жилд 235 сая, 1993 онд 417 сая доллар зарцуулжээ. Үүний сацуу

1992 онд Орос, Армен, Гүрж, Молдов, Белорусс, Кыргызстан, Туркменистанд тусад нь хүнсний буцалтгүй тусламж - жинд 412 сая доллар олгожээ. Энэ бол бага тоо биш. Бас Олон улсын валютын сангийн шугамаар зөвхөн 1992 онд 12 тэрбум доллар олгосны 6 тэрбумыг ТУХН-ийн орнуудын мөнгөний ханшийг унагахгүй байлгах зорилгоор өгчээ. Энэ хэдхэн тоо баримт л АНУ-аас ТУХН-д хандах хандлага, байр суурийг илтгэнэ. Зөвлөлтийн аюулаас сэргийлэхийн тулд олон арван жил хэдэн зуун тэрбум доллар батлан хамгаалахдаа зарцуулж байсан айл одоо болохоор тэр "дайснаа" тогтвортой байлгах гэж мөн л олон тэрбум доллар урсгаж байна. Эдийн засгийн баг бэх холбоо тогтоох найдвар тун бага, ТУХН дэх шинэ улсуудад стратегийн ямар ч сонирхол байхгүй атлаа ингэж туслаад байдгийн учир юунд байна вэ? Тэгээд бас тусламж хүртэж буй улсуудын байдал эргэлзээтэй, тухайлбал нийгэм-эдийн засгийн хямрал, хүний эрхийг ноцтой зөрчиж буй зэргийг ажваас АНУ-ын тусламж цагаа олоогүй гэх үү, ямар ч атугай өөрийгөө зөвтгөж чадахгүй байна. Гэвч АНУ-ын засаг захиргаа үүнд шантралгүй ямар нэг горьдлого тээсээр тусалсаар байна. АНУ-ын тусламж хүртэж байгаа байдлаар ТУХН-ийн орнуудыг хэд хэд ангилж болмоор санагддаг. Үүнд:

1. Оросын Холбооны Улс өрнөдийнхний анхаарлын төвд байр суурьтай байна. Орос дахь тогтвортой байдлаас ганцхан ТУХН төдийгүй Европ тив, улмаар дэлхий нийтийн уур амьсгал ихээхэн шалтгаална. Гэвч одоогоор цэрэг-стратегийн гэхээсээ эдийн засаг-хүмүүндэгийн чиг хандлага АНУ-ын тусламжийг нөхцөлдүүлж байна.
2. ТУХН дэх цөмийн зэвсэгтэй Украин, Казахстан хоёр Оросын дараа орох байх. Энд Белоруссыг оруулсангүй. Учир нь Белоруссын эдийн засгийн реформын явц АНУ-ын хүссэн хэмжээнд хүрэхгүй, Оросоос хэт хараат, дээр нь Белоруссын хуучинсаг байр суурь нөлөөлж байна. Орос, Украин, Казахстаны хувьд АНУ-ын оролцож буй салбар хүрээгээ аажмаар тэлсээр байна. Үйлдвэрлэл, маркетинг, санхүү, өмч хувьчлал, шинэ пүүс байгуулж хөл дээр нь босгох гэх мэт олон чиглэлээр Москва, Киев, Алма-Ататай хамтран ажиллаж байна. АНУ эдэнтэй орлогын давхар татвараас зайлсхийх тухай хэлэлцээр байгуулжээ. АНУ цэрэг-стратегийн хувьд ч эдийн засгийн нөөц хүчний хувьд ч байгалийн баялаг, зах зээлийн боломжийн хувьд ч эдгээр орныг үнэхээр сонирхож байна.
3. АНУ-ын тусламж авдаг гурав дахь хэсэг улс бол Армен, Кыргызстан, мөн Балтийн улсууд. Арменд үзүүлж буй тусламж энд онцгой байр эзэлнэ. АНУ дахь армяны лобби (армян гаралтай нөлөө бүхий хүмүүс, зүтгэлтэн, бас армийн цагаачдын байгууллага гэх мэт), Армений өөрийн нь улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн радикал реформ, түүний зарим үр дүн, лалын ертөнцийн хүрээлэлд оршино.

Азербайжаны зүгээс эдийн засгийн хөрш тавьсан гэх мэт олон хүчин зүйл энэ тусламжийг нөхцөлдүүлж байна. Кыргызстаны хувьд "туршилтын талбар" маягтай юм. Нутаг дэвсгэр бага, хүн ам цөөн, харьцангуй тогтвортой, удирдлага нь (ерөнхийлөгч А.Акаев) прагматик бодлого явуулдаг гэх мэт тусламж хүртэх таатай нөхцөл бий. Тэгэх туемаа Кыргызстан бол Дундад Азийн орнууд дотор зах зээлийн харилцаанд хамгийн богино хугацаанд эрс шийдэмгий шилжиж буй орон юм.

4. ТУХН дэх үлдсэн орнуудын тухайд дотор нь айхтар зааглаад байх шаардлагагүй. Тэгээд ч зарим нь (жишээ нь Тажикистан) тусламж хүртэх боломж тун бага. Энд хүмүүнлэгийн тусламжийн (дайнд хэлмэгдсэн энгийн тайван хүн амд наад захын тусламж үзүүлэх) тухай л ярина уу гэхээс эдийн засгийн түншлэл арай холдох болов уу.

Үүнээс гадна АНУ-аас ТУХН-д хандаж байгаа байдал, байр суурийг ТУХН-ийн Европын болон Азийн хэсэгт гэж хоёр ангилж үзэж болох мэт. Европын хэсэг гэдэгт ТУХН-ийн бүрэлдэхүүнд ордоггүй Балтийн улсуудыг бас оруулна. Ер нь ЗХУ-ын задралын дараахь АНУ-ын бодлого эндээс эх үүсвэрээ авсан. ЗХУ-ыг задлах тухай хэн ч төсөөлөөгүй байхад эндхийн 2 улсад анх тусгаар тогтнох хөдөлгөөн өрнөсөн. Тэдний тусгаар тогтнолын төлөө тэмцлийг АНУ анхнаас нь гэрхий ажиглаж, сүүлт рүүгээ дэмжих замд орсон. Гэвч дараа нь санхүүдгүй асуудлуудтай тулгарсан. Тэндээс Оросын цэргийг гаргахыг дэмжиж байтал тэндхийн орос үндэстний цөөнхийн эрхийг хорвоон явдал гарсан. Үүнд АНУ бэлэн байгаагүй, ингээд үл асуудал орон улсын маргааны шинжтэй болмогц АНУ-ын байр суурь бүдгэрч, Оросыг дэмжих аястай болсон.

АНУ-Украины харилцааны зах зухаас түрүүчийн бүлэгт дурдсан АНУ бол Орос, Украины хооронд томхон маргаан дэгдэхээс ихэд болгохжижж байгаа үнэ. Цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээнд Украины нэгдэх үү, үгүй юу гэдэг асуудал АНУ-ыг нэлээд түгшрүүлж боддог нэг санаа амрав боллоотой. Орос-Украины цэрэг стратегийн маргааныг олон улсын асуудал болгож, ТУХН-ийн хүрээндээ гаргах, түүнд АНУ болон өрнөдийн томхон орнуудыг татан оруулах, энэ асуудалд Украины Европ дахь жижиг хөршүүдийг хөшүүрэг болгон ашиглах гэх мэт америкийн дипломат бодлогод ажигнигдаж байгаа зүйл бий. Нөгөө талаас Орос, Украины аль алинд түгшрүүлэх болон хууль тогтоох засаглалын амжилт зөрж, тэр нь өнөө улсын үйл хэрэгт бишгүй нөлөөлсөн. Үүнд АНУ ихээхэн эмзэг ханддаг байна.

ТУХН-ийн Азийн хэсгийн тухайл АНУ-ын гадаад бодлогод Казахстан эхний байрт орно. Энэ талаар дээр өгүүлсэн Тус орон өс төдий цөмийн зэвсэгтэй гэж төсөөлдөг. Хойшдоо түүнийг эзэмшиж байх бололцоо мэдвар нь мөхсөно. Ийм учраас

Казахстан цөмийн зэвсэгтэй Орос, Хятад, АНУ-аас цөмийн аюулгүй байдлын баталгаа хүсч байна. Энэ 3 улс ирээдүйд цөмийн мөргөлдөөн дэгдээлээ гэж төсөөлбөл Казахстан гарцаагүй хөлд нь үрэгдэнэ гэдгийг үндэс болгож ийм асуудал тавьж байна. Нөгөө талаас Дундад Ази дахь тогтворгүй байдал. Энэтхэг, Пакистан, Афганистан, Иран гээд хүчтэй өрсөлдөгчид гарч ирж буй нь Казахстаны байр суурьт нөлөөлж мэдэх юм. Гэхдээ Казахстаны хувьд гол аюул Хятад байх болно гэж үзэж байна. Тийм учраас Хятадтай дипломат харилцаа тогтоохдоо үндэстний асуудлаа хил давуулахгүй (Шинжаан руу халдварлуулахгүй гэсэн үг-Зох) гэсэн амлалт өгч байсныг эргэн саная. Энэ утгаараа Хятадад нөлөөлж чадах хоёрхон гүрэн Казахстанд тусална. Тэр нь Орос, АНУ хоёр юм.

Кавказын улсуудын тухайд бол АНУ-ын эдийн засгийн ашиг сонирхол гэх юм бас л бага. Яагаад гэвэл энэ бүс нутаг ТУХН дотроо хамгийн тогтворгүй нь. Ийшээ хөрөнгө оруулах, зах зээлийг хөхүүлэх тухайд ярихад дэндүү эрт байна. Тэгэхдээ АНУ эндхийн бүх улстай дипломат харилцаа тогтоож, байдлыг ажиглаж, ялангуяа армен-азербайжаны мөргөлдөөнд сэтгэл түгшиж байна. Дээрээс нь Чечень нэмэгдэв бололтой. Эндхийн асуудлаар АНУ холбоотон - Түрктэйгээ санал зөрөлдөж байгаа нь хэдийнэ ил болсон. Учир нь АНУ нутагтаа буй армяны цагаачдаар дамжуулан энэ мөргөлдөөнд нөлөөлж болдог юмаа гэхэд Азербайжаныг яаж ч хүчрэхгүй байна. Түүний цаана Түрк гэж хүчтэй оролцогч гарч ирлээ.

Гүржийн дотоод асуудалд бэрхшээл гарсаар байна. Гүрж-Америкийн харилцаа сайжирсан боловч Гүржийн дотоодын мөргөлдөөнд Орос оролцож шинэ бэрхшээл бий болгож байна. Ингээд эцсийн эцэст АНУ-аас ийшээ явуулж буй гадаад бодлогод тогтвортой байдал л чухал болохоос бус, тэндхийн үндэстэн - истан, шашин, газар нутгийн маргаан чухал биш болжээ. Ер нь ийшээ хэт гүнзгий хутгалдан орох нь АНУ-д ямар ч ашиг өгөхгүй. Ийм учраас ТУХН-ийн Дундад Ази, Кавказ дахь АНУ-ын бодлогыг илгэл үнэмшил бус (өөдрөг үзлийн тухайд бүр болъё) болгоомжлол гадорхойлж байна гэж дүгнэхэд болох талтай.

Вашингтон - Москва: юугаар түншлэх вэ?

Энд Орос-Америкийн харилцааг тусгай хэсэг болгож оруулна. АНУ-аас ТУХН-д чиглүүлэн явуулж буй бодлогыг Оросгүйгээр төсөөлөх аргагүй, энэ талаар дээр олонтой тэмдэглэсэн. Гэвч цавхардуулалгүй өгүүлэх зүйл байна. Оросын дотоодын хямрал, ТУХН дэх өөр хоорондын харилцаан дахь бэрхшээлийг харгалзан Оросын байдлыг хяналтаасаа гаргачихгүй байх гэсэн санаа АНУ-ын бодлогод илт цухалзаж байна. Нөгөө талаас Оросын олон улсын стратегийг харгалзан түүнтэй аль талаас нь харилцах, юунаас эхлэх, юүг удирдлага болгох, ямар механизмаар тэр харилцаагаа

хэрэгжүүлэх гэх мэт Вашингтоны сэтгэлийг зовоож буй олон асуудал энд орно.

Эдгээр асуудалд хариулах үүднээс доорхи үндэслэл дэвшүүлж болох юм. Тухайлбал:

- АНУ Оросыг олон улсын харилцааны системд барьж байхыг зорьж байна. Орос ямар ч утгаараа олон улсын хамтын нийгэмлэгийн гадна гарах ёсгүй бөгөөд тийм нэгдсэн системд байж, тодорхой үүрэг гүйцэтгэж байж олон улсын идэвхтэй харилцаанд оролцоно. Үүнд НҮБ, Европын олон улсын институт (байгууллага) нь хамтын ажиллагааны гол хэлбэр болох ёстой. Орос бол ЗСБНХУ-ын хууль ёсны залгамжлагчийн хувьд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн. Энэ маань олон улсын үйл хэрэгт Оросыг байнга татан оруулах гол нөхцөл, бас Оросыг олон улсын зүгээс хянаж тандаж байх нэг боломж. Орос нь бүр хяналтаас гарчихсан гэж би хэлэх гээгүй. Гэхдээ ингэж болгоомжлох бүх үндэс өнөөгийн Оросын улс төрийн амьдралд байна. НҮБ-аас гадна Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал, НАТО хоёр Орост чухал нөлөөтэй. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны механизм бол Европын аюулгүй байдалд гол үүрэгтэй нийт европын гол бүтэц, НАТО-г Балтийн орнууд, Дорнод Евро-пынхноор өргөжүүлбэл Орост шууд нөлөөлөх нэг боломж бүрдэж болох юм. Тэгэхдээ энэ бүх асуудал судлагдах шатан даа яваа, боловсроогүй байгаа. Энэ тухай хожуу өгүүлнэ.
- ТУХН-ийн бүс нутгийн бүтцийн хүрээнд Оросыг авч үзэх бас нэг хандлага АНУ-д бодлогод ажиглагдаж байна. ТУХН-ийн интеграц эргэлт буцалтгүй гэж Орос өөрөө мэдэгдэх атлаа түүнд саад хийхгүй байхыг АНУ-аас хүсдэг. ТУХН-ийн гишүүн бүртэй АНУ хоёр талын харилцаатай байхыг Орос тэр бүр зөвшөөрөхгүй байна. ТУХН нь Европын аюулгүй байдлын нэг систем болохоос бус цэвэр бүс нутгийн чанартай байгууллага биш гэдгээр үүнийгээ тайлбарлаж байна. Энэ утгаар ТУХН өөрөө манан будан дунд, Орос бас өөрөө ТУХН дотор манан будан дунд төөрч, үүнээс үүдэн АНУ яаж харилцахаа тодорхойлж чадахгүй, ТУХН-өөр дамжуулан Оростой харилцах гэсэн байр суурь нь боловсролгүй шахуу байна гэж үзэж болох юм.
- Энхийг сахиулах ажиллагаанд Оросыг татан оруулж, дэлхий дахинд энх тайвныг хамгаалахад түүний цэрэг-улс төрийн хүч нөөцийг ашиглах хэлбэрээр Оростой нягт хамтран ажиллахыг АНУ сонирхож байна. Гэхдээ Оросын энхийг сахиулах ажиллаган НҮБ-ынхаас ялгаатай, АНУ НҮБ-ын нэр дор НАТО-гийн командлалыг энэ хэрэгт оролцуулах, НАТО-гоор энхийг сахиулах үүрэг гүйцэтгүүлэх бодолтой байхад НАТО-гийн оронд НҮБ-ын цэргийн штабын хорооны механизм бий болгохыг

Орос зорьдог. Оросоос Молдов, Гүржид явуулсан энхийг сахиулах ажиллагааг АНУ хүлээн зөвшөөрч, хариуд нь Гаитид АНУ-ын явуулсан үйл ажиллагааг Орос дэмжсэн. Гэтэл Боснид зөрчилтэй байна. Орос НҮБ-ын өмнө хүлээх үүргээ ойлгож байгаа боловч слав туургатан сербтэй тогтоосон харилцаагаа анхаарлаасаа гаргадаггүй. Оросын Думд олон суудалтай ОЛАН, түүний удирдагч Жириновскийн байр суурь АНУ болон НАТО-гийнхныг их балмагдуулсан. Үүнээс үүдэн Орост хандах хандлага нь дахиад ээдрээтэй, тодорхойлж хэлэхэд хэцүү болсон. Энэ тухай тодорхой баримтаар хожуухан өгүүлнэ.

- Ардчилал, хүний эрхийн асуудлаар Америк-Оросын харилцаа ойртох хандлагатай байгаа. Энэ бол Орос, Америк хоёрыг холбож байх нэг гол шижим. Уг нь АНУ-ынхаар бол хамгийн гол нөхцөл нь. Гэтэл Орос дахь нөхцөл байдал ийм байлгах үндэс алга. Орост улам бүр газар авч буй үндсэрхэг үзэл ардчилалтай эрс харшилна. Орост болж буй бүс нутгийн мөргөлдөөн, түүнийг шийдэх арга барилд хүний эрхийг ноцтой зөрчсөн баримт олон байна. Үүнд Чеченьд явуулсан байдлаан том сургамж. Оросын улс төрийн хямрал хэт сунжруу, ардчилсан хүчний төлөвшилт удаан, үндсэрхэг, хуучинсаг, большевик, фашист хүчин хүрээгээ тэлж байгаа нь АНУ-ыг их түгшээж байна. Орос орон уг нь АНУ-ынхаар ТУХН дотор "Ардчиллын үзмэр", "үлгэр жишээ" болох ёстой. Оросоос бусад хөрш нь үлгэр авах буюу нөлөөнд нь автаж мэдэх учраас тэр л дээ. Гэтэл Орос ингэж оройлж чадахгүй байна.
- Зэвсэг хураах үйл явцын хүрээнд Оростой харилцах өргөн боломж бий. Энэ талаар уламжлал, туршлага аль алинд нь байгаа. Гэвч тодорхой үр дүнгийн хувьд харзнахаас өөр аргагүй. Зэвсэг хураах нь хоёр орны харилцаанаас хальж өргөн хүрээг хамрах асуудал юм. Орос, АНУ хоёр бусад улсаас илүү их зэвсгийн нөөцтэй ч бусад орны стратегийн байр суурийг бодолцох ёстой. Зэвсэг хураах салбарт эдэнтэй барьцаад хөдөлж өгөхгүй байгаа том улс бий. Бас цөмийн зэвсгийн туршилт хийж, сансрын программ уйгагүй боловсруулж байга Хятад мэт ирээдүйд "халгаатай" хөрш эдний орон зайг бөглөж гарч ирэхгүй гэх газаргүй. Үнэндээ өнөөг хүртэл Орос-АНУ-ын хооронд цөмийн зэвсгийн зарим төрлийг эс тооцвол зэвсэгт хураах салбарт хийчихсэн бодит ажил алга.
- Хоёр орны хооронд өргөн хэлхээ холбоо тогтоох, түүнийгээ гэрээ хэлэлцээрээр баталгаажуулах хэлбэрээр Оростой харилцаагаа хөгжүүлднэ гэж АНУ-ын засаг захиргаа тооцоолж байна. Энэ зорилгоор дээд хэмжээнд хэд хэдэн удаа айлчилж, лав л гарын үсэг зурсан баримт бичгийн тоо 100 хол давжээ. Энэ бол чамлахаар тоо биш. Гэвч үр дүн хаа байна вэ? гэсэн ноцтой асуудал бий. Учир нь Оросын талд их үүрэг хариуцлагын ногдож байгаа юм. Оросын удирдлагын өндөрлогүүн

(Ерөнхийлөгч, засгийн газар, ГЯЯ, парламент) энэ асуудлаар хоорондоо зөрж, хоёрдмол байр суурь баримтлах буюу дотоодынхоо асуудалд хэт их анхаарч байгаагаас олон улсын гэрээ хэлэлцээрээр авсан үүрэг амлалт нь бүдгэрэх буюу хэрэгжихгүй хоцорч байна. Жишээ нь Чеченийн хямралын босгон дээр АНУ-ын дэд ерөнхийлөгч А.Горын айлчлах үед В.Черномырдинтэй хамт гарын үсэг зурсан олон баримт бичгийн биелэлт хаа байна вэ? гэхэд хариулах хүн бараг олдохгүй.

Энэ мэт үндэслэл дэвшүүлж тайлбарлахын хамт Орос-Америкийн хооронд ямар зөрчил байгааг анзаарахгүй өнгөрч болохгүй. Ер нь энэ хоёр гүрэн ямар асуудлаар ноцтой зөрж байна вэ? гэвэл их өргөн хүрээг хамруулан ярьж болно. Гэвч энд би АНУ-ын болгоомжлол гэх үү, Оросоос шалтгаалж хоёр улсын харилцаанд нөлөөлж мэдэх хувилбарыг авч үзье. АНУ-ын улс төрийн туршлагатай ахмад зүтгэлтнүүд, Зөвлөлт-Оросыг судлаачид энэ талаар янз бүрийн таамаг дэвшүүлдэг юм. Жишээ болгож тэднээс хоёрыг нь нэрлээ. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Генри Киссинжер, ерөнхийлөгчийн үндэс-ний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн туслалц байсан Збигнев Бжезинский нар энэ асуудлаар олонтаа бичиж сануулж байна.

Жишээ нь, Киссинжерийн үзэхээр, олон улсын харилцааны дайны дараахи үе дуусч, үзэл суртлын асуудал хөөцөлдөхөө больсон шинэ үе иржээ. Гэвч энэ шинэ үе хэрхэн дуусахыг хэн ч хэлж мэдэхгүй аж. Оросоос (урьдын Зөвлөлт) энэ шинэ үеийг эхлүүлсэн боловч төгсгөлийг нь Орос өөрөө ч тааж мэдэхгүй. Орост коммунизмын үзэл суртлын үеийг дуусгаагүй байтал Оросын түрэмгийлэн эзлэх түүхэн уламжлалын аюул зэрэгцэн гарч ирлээ. Энэ бол тааж хэлшгүй тэр төгсгөл гээчийг нөхцөлдүүлж байна гэж Киссинжер үзжээ.

Үнэндээ ч Орос болон урьдын Зөвлөлтийн түүхийг сөхөж үзвэл аль нэг хаан буюу ардын комиссар, намын ерөнхий нарийн бичгийн дарга нар хөрш орнуудтайгаа зэрэгцэн орших аятай нөхцөл бүрдүүлж байсан тохиолдол маш цөөхөн. Дэлхийн янз бүрийн бүс нутагт өрнөж байсан бүс нутгийн мөргөлдөөнөөс өнөөгийн Орос орон холдсон мэт сэтгэгдэл төрж болох юм. Энэ бол дотоодын (Оросын Холбоо дотроо задрах) ноцтой асуудал- даа түүртээд бүс нутгийн хэрэг явдлаас түр хөндийрснийх болохоос бус тэндэх ашиг сонирхлоосоо Москва ухарлаа гэж ойлговол гэнэн хэрэг болно. АНУ чухам ингэж л үздэг учраас бүс нутагт санаачилга авахаар багагүй хүч зарж байгаа юм. Нөгөө талаар урьдын ЗХУ-ын үед коммунист суртлыг уйгагүй номлосны ачаар дэлхийд олон тооны дэмжигчидтэй болсноо Орос хэзээ ч мартахгүй, тэднийг зөнд нь хаяхгүй гэж АНУ үзэж байна. Оросын дотоодын бэрхшээл арилмагц, эсвэл засгийн эрх коммунист

хуучинсаг, үндсэрхэг хүчний гарт шилжвэл энэ нь аяндаа сэргээд ирнэ. Үүнийг Боснийн асуудал битүүхэн хэллээ, Оросын улс төрийн зарим хүчин Ливи, Иракийг дэмжиж байсан баримт ч бас үүнийг нотолно.

Бжезинскийн үздэгээр, Оросын аюул Дорнод Европ, Балти хавийн ардчилсан улсуудад илүү тусч магадгүй гэнэ. Орост амилан сэргэсэн үндсэрхэг хонзогнох үзэл ийм дүгнэлт хийхэд хүргэж байна. Оросын уламжлалт их гүрний үзэл үндсэрхэг үзэлтэйгээ холилдоод ирэхийн цагт Оросын ардчилал хумигдаж болзошгүй гэж Бжезинский анхааруулж байна. Чеченьд явуулсан байлдаан ардчилал, хүний эрхтэй эрс харшилсныг АНУ болон Өрнөд Европынхон анхааруулж байсан нь үүний нэг нотолгоо болсон мэт санагдав. АНУ туншийн хувьд Оросын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх нь мэдээж боловч цус урсгах явдал хэрээс хэтэрч, устган сүйтгэх хэмжээнд хүрмэгц Чеченийн талаар Оростой зөрж эхэлсэн. Тэр ч бүү хэл АНУ-ын конгресст Орост үзүүлэх тусламжийг түр зогсоох тухай шаардлага цухалзсан.

АНУ 1994 оны гадаад бодлогоо дүгнэхдээ, СТАРТ-1 гэрээг батламжилж, хоёр орон нутаг дэвсгэрээсээ тив хоорондын баллистик пуужин онолохоо больсныг гол амжилт гээд, түүнийг залгаад Балтийн орнуудаас Оросын цэрэг гарсныг оруулсан байгаа. Үүнийгээ АНУ-ын гадаад бодлогод хамаарах асуудал гэж үзжээ. 1995 оны тухайд, АНУ дэлхийн цэрэг-эдийн засгийн зонхилох гүрнүүдтэй оновчтой харилцахыг эрмэлзэнэ гээд, хамгийн түрүүн Оросыг оруулжээ. "Бидний эрх ашиг нийцэж байгаа газар Оростой хамтран ажиллана, эрх ашиг зөрж байгаа тийм хүрээг хараандаа байнга байлгахыг эрмэлзэнэ" гэж АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга У.Кристофер мэдэгджээ. Энэ бол ойлгож цөхөх юмгүй ил шууд хэлсэн үг. АНУ Оростой тогтоосон харилцаандаа сэтгэл дундуур байхын сацуу басхүү болгоомжлох үндэстэйг харуулж байна.

1993 оны Оросын сонгууль ба Вашингтон

Энэ бол ганц АНУ-д хамаатай бус, түүний Европ дахь холбоотнуудад адил хамаарах асуудал. Тэгэхээр Европын асуудлыг энд хөндөж таарна. 1993 оны тэр сонгуулийн талаар түрүүчийн бүлэгт дурдсан, бас сонгуульд амжилттай оролцсон улс төрийн зарим хүчний байр суурийг жишээлэн тайлбарласан. Энэ хэний тухай, юуны тухай ярих нь тодорхой юм.

Оросын талаар аядуу, алгуур бодлого явуулж байсан АНУ болон Өрнөд Европын улсуудыг энэ сонгууль огцом цочирдуулсан төдийгүй заримыг нь бүр балмагдуулсан. Энд Дорнод Европынхныг нэгэн адил хамруулж болно. Сонгуулиар голорхой дэмжлэг хүлээж, улс төрийн бодлогод нөлөөлөх хэмжээнд очсон СЛАН, түүний удирдагч Жириновскийн байр суурь нэгэн цочирдон балмагдах үндэс болсон хэрэг.

Түүнийг Оросын Улсын Думд орж ирэх хүртэл хэн ч анзаардаггүй буюу анзаарсан ч элэг доог хийх төдийнхөөр өнгөрдөг байсан. Хэрш орнуудынхаа талаар занаж зүхсэн. сурдүүлсэн үг яриа, АНУ-ыг шүүмжлэлийн жадныхаа үзүүрт өлгөдөг бүхнийг үгүйсгэдэг гэжүүд хэгжүүн авирыг нь хэлж байна л даа. Үнэндээ барих барьцгүй, тодорхой үндэслэлгүй атлаа бүхэн рүү үсчсэн, зарим талаар галзуу солиотой гэмээр олон мэдэгдэл хийдэг. Хэрэв тэр Оросын парламентад байр эзлээгүй бол мөн тохуу хийгээд өнгөрөх байсан биз. Гэтэл түүний үндсэрхэг, их гүрний дээрэнгүй зан авир сонгогчдын тодорхой хэсгийн итгэл үнэмшил болж гарч ирсэнд хэргийн учир оршиж байна.

1993 оны намар ардын депутатуудын үймээнийг ааглан дарсан Ельцинд ардчиллыг дэмждэг дэлхийн хүн бүх ард талархаж байлаа АНУ-ын хүнд 1993 оны аравдугаар сарын үйл явдал Орос дахь улс төрийн хямралын төгсгөл мэт ойлгогдсон. Одоо бүх юм цэгцэрлээ гэж тэд амьсгаа авахтайгаа болсон хэрэг. АНУ-ын холбоотнууд ч мөн ингэж сэтгэл хууртсан. Гэтэл 1993 оны арванхоёрдугаар сард бүх юм хараар эргэх нь тэр. Үзэж чаддаггүй буюу хүсээгүй "зочин" нь Оросын парламентад олон суудал эзэлсэн улс төрийн намын дарга болоод зогссонгүй өөрийгөө дэлхийн хамгийн том намын дарга, учир нь Орос бол дэлхийн хамгийн том орон, дэлхийн том орны парламентад олонхи болсон намын дарга хүн дэлхийн хамгийн том намын дарга байх ёстой гэх маягийн үг хэлэв. Хэлсэнээ нотолсон мэт 1991, 1993 оны үймээн дэгдээгчдийг бүгдийг нь суллуулж, тэднийг тосч авахаар өөрөө шоронгийн хаалганы дэргэд очжээ. Үүнийг дэлхий нийтээрээ гайхшран харж билээ. Эрүүл саруулаар сэтгэдэг хэнд ч, тэр дундаа Оросын ардчиллыг анхнаас нь дэмжиж, Ельцинд итгэл өгч байсан хүн бүхэнд хамгийн ойлгомжгүй оньсого мэт юм энэ л байлаа.

Жириновский Гитлер шиг нүүрээ нууж гарч ирээгүйд хамгийн гол аюул байна гэж боддог. Хэрэв тэр хүний чихэнд чимэгтэй юм ярьдаг, өөрийгөө соёлтой авч явдаг, улс төрийн боловсролтой хүн гэдгээ харуулж байгаад хожим нь гэнэдүүлсэн бол Оросын сонгогчид эндүүрчээ гэж уучилж болохсон. Гэтэл тэгээгүй. Тэрээр Орост ЛАН байгуулагдсан цагаас л зүүд зэрэглээ шиг юм ярьж, үе үе шуугиан дэгдээж, 1991 онд Оросын ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж байхдаа ярьдаг юмаа л ярьж явсан. Түүнд гайхаад байх зүйлгүй. Харин 1993 онд гэнэт гараад ирнэ гэж хэн ч санаагүй, хэн ч хүсээгүй. Гэтэл хүсээгүй юм хүзүүгээр татжээ.

Үндсэн асуудалдаа эргэж оръё. Жириновскийн гарч ирсэнд АНУ-ын засаг захиргаа бүхнээс илүү цочирдсон билээ. Учир нь их Оросын дээрэнгүй үзлийн хөлд нэрвэгдэж мэдэх жижиг буурай үндэстнүүд бүгд л АНУ-д аюулгүй байдлаа даатгахыг оролдоно. Ялангуяа туурга тусгаар улс гэж мэдэрсэн өдрөөсөө Оросын хөлд талхигдаж, тусгаар тогтнолоо устгуулж байсан (эх орныг нь хэсэглэн хувааж, тэр улсыг нь устгахад олон удаа оросууд

оролцсоныг яс махандаа шингээж явдаг польшууд) хөрш улсууд, дэлхийн хоёрдугаар дайнаас эхлэн сталинч туршилтын талбар болж, Европын соёл иргэншлээсээ салж будилсан Төв, Дорнод Европын болон Балтийн орнууд АНУ, НАТО-д шууд хандсан юм. Эдгээр орон Жириновскийн хараал зүхлийг цаасан дээр ханатлаа амсаж байгаа.

Урьд нь эдгээр орон НАТО-д элсэх, Европын Холбоонд нэгдэх тухай хий ярихаас хэтэрдэггүй буюу ер нь яаравчилдаггүй байсан. Гэтэл Оросын сонгуулийн дараа гэнэт ухаарсан мэт баруун зүг огцом эргэв. Эдний итгэлийг ганц НАТО, Өрнөд Европ дахь шинэ түншүүд нь биелүүлж хүчрэхгүй. Бүхнийг Вашингтонд шийдэх ёстой. Ингээд АНУ-ын ерөнхийлөгч төлөвлөөгүй айлчлалаа Дорнод Европоор хийлээ. Тэрээр Москвагаас эхлэн ТУХН-ийн болон Балтийн зарим орон, Дорнод Европт очжээ. Дараа нь НАТО-ийн холбоотнуудтайгаа зөвлөл-дөж, танил болсон "Энхийн төлөө түншлэл" гэгчээ томъёолжээ. Энэ тухай дараа өгүүлнэ.

АНУ-ын ийм балмагдлыг Ельцин ба Оросын засгийн газар аргацааж намжааж л байна. Орост ардчиллын гэгээ болж үлдсэн "Оросын сонголт" хэмээх улс төрийн нам Жириновскийг Гитлертэй зүйрлүүлж, шууд л фашист гэж нэрлэдэг. Оросын улс төрийн системийн онцлог гэх үү, ямар ч атугай парламент нь засгийн газартаа тэгтлээ нөлөөлөхгүй, ерөнхийлөгчид бол бүр ч хавьтахгүй шахуу байна. Ийм учраас Улсын Думд олон суудалтай ОЛАН тэр, засгийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрээгүй, удирдагчийн нь овилгогүй мэдэгдлүүд цаасан дээрээс хальж гарсангүй. Үүнд л АНУ болон дэлхий нийт сэтгэл амар байгаа. Үүний сацуу Оросын ерөнхийлөгч ардчилалд үнэнчээ байнга нотолж, реформын чиг шугамаасаа ухрахгүй байгаад сэтгэл тайвшрах нэг үндэс бий. Гэвч ерөнхийлөгчийн дараагийн сонгуульд хэн ялах вэ? гэдэг тааж хэлэхэд амаргүй асуудал үлдээд байгаа. 1996 онд Оросын хоёр дахь ерөнхийлөгчийг сонгоно. Түүнд ялах магадлал тодорхойгүй ч Жириновскийн үзэж байгаагаар, өрсөлдөөн Руцкой тэр хоёрын хооронд болж өнгөрөх ажээ. Үүнийг анхаарлынхаа гадна орхихгүй байх нь чухал болов уу. Юмыг яаж мэдэх вэ? гэж бас нэг балмагдах юмтай учирч болох юм.

Орос-Америкийн харилцааны тогтуун үе хэр удаан үргэлжлэх бол гэдэгт америкчууд бүхнээс илүү зовниж байна. Оросын 1993 оны дуулиант сонгуулиас хойш америкчууд Оросыг сонирхох нь багасч байх шиг санагдав. Ялангуяа зээл тусламжийн биелэлтэд хяналт тавих, тэр ч бүү хэл хасч танахыг шаардаж, ерөнхийлөгч Клинтон^{ыг} Оросын талаар алсын хараагүй бодлого явууллаа гэж зэмлэх нь ихэсч байна. Урьд нь тийм зэмлэгчид хэвлэл болон олон нийтийн санал асуулгаар л цухалздаг байсан бол одоо конгресст (1994 оны конгрессын сонгуулиар) олноороо сонгогджээ. Дээр иш татсан Киссинжер энэ талаар буурьтай үг хэлж байна. Оросын дотоодын хэрэг явдалд хэт хутгалдаад дараа нь эргэж гаргах

аргагүй мухардалд орчих вий гэж анхааруулаад, алс хэтээ бодож, стратегийн томхон бодлого боловсруулж түүнээ баримтлах, Оросын дотоодын ажил хэргээс хөндийрөхийг тэрээр уриалж байна. 1993 оны сонгуулиас хойш Дорнод Европын өмгөөлөгчийн дүрд Бжезинский илэрхий тоглох болж, НАТО-гийн ажиллах хүрээг Орос хүртэл тэлэхийг уриалан дуудаж байна.

Энэ бүхэнд үндэсгүй юм байхгүй. Үнэндээ ч АНУ-ын сэтгэл харамгүй өгч буй зээл тусламжийг "хулганы хавханд тавьсан нөөшнөөс өөрцгүй" (Руцкойн хэлсэн үг) гэж зүйрлэх буюу "америкчууд залилаж байна, америкчууд биднийг өмд гутал, зажилдаг бохиор л зэвсэглэж байна" (Жириновскийн хэлсэн үг) гэхчлэн үнэлж байгаа бол америкчуудын бухимдаж, мөнгөндөө харамсах нь арга ч үгүй. Эсвэл энхийг сахиулахад зарж буй хүч чармайлтыг нь хаа сайгүй гугаан доромжилж, сэргүүлж элдэв сүрдүүлэг хийж хийрхэж байгаа нь хэнд аятайхан байх билээ. Жишээ нь Жириновский Ирак, Ливи, Босни, Умард Солонгост зүгээр нэг зочноор очоогүй. АНУ тай сэргэлдэх тодорхой хүч Орост бий бөгөөд тэр нь зохих дэмжлэгтэй гэдгийг АНУ-д харуулах гэснийх юм болов уу. Ялангуяа Боснид хийсэн мэдэгдэлүүд нь америкчуудын үрмыг хугалах шахсан юм. Түүний ярьснаар, тодорхой хэлбэл хүснэнээр, эсрэг туургатны нэгдсэн төр улс байгуулж, нэгдсэн цэргийн хүчээр өрнөдийнхний зүрхийг чичрүүлэх юм гэнэ. Бас сербүүдийг хамгаалахын тулд "онцгой аюултай зэвсэг хэрэглэнэ. Орост шинэ төрлийн 3 аймшигт зэвсэг бий, Оросын хөлсний офицерууд түүнийг туршиж үзсэн, бид турших зөвшөөрөл өгсөн, үр дүн харагдсан" гэхчилэн хачин жигтэй юм яриад, "Хэрэв Боснийн хотууд дээр нэг л бөмбөг хаях аваас Орост дайн зарласан хэрэг гэж бид үзэн хариуд нь өрнөдийнхнийг залхаан цээрлүүлнэ" гэж сүрдүүлжээ. Түүний энэ хийрхлийг Каражич, Младич зэрэг Боснийн хямралын буруутнууд дэмжиж "дайран дээр нь давс нэмж" байснаас үзсэн ч Жириновскийн гадаад бодлого АНУ-ынхтай гал ус мэт харшилж байна. НҮБ-ын энхийг сахиулах бүх үйл ажиллагааг тэр яг ингэж үздэг бөгөөд НҮБ-ыг тараана гэж байнга ярьсаар л. Түүний үздэгээр Ойрхи Дорнодын улс түмэн Оросыг олон улсын цагдаа болгохыг хүсч гуйж байгаа бололтой. Энэ нь эргээд нөгөө л "Энэтхэгийн далайн бүлээн усаар орос цэрэг гутлаа угаах" тухай номлолтой нь холбогдож байна. Энэ мэт баримт жагсаавал их зай эзэлнэ. Үүнийг азнаад дараагийн асуудалдаа оръё. Тэнд ч мөн Оросын үндсэрхэг үзлийн тухай яригдана.

"Энхийн төлөө түншлэл"

НАТО-гийн талаар энд өгүүлэх бөгөөд би дээр цухас дурдаад өнгөрсөн. Үүнийг Оросын 1993 оны сонгуулийн дүнтэй холбохын хамт ерөөсөө Европ, Орос, ТУХН-д өрнөж буй үйл явдалтай холбож авч үзнэ. "Энхийн төлөө түншлэлийг" НАТО-гийн "шинэ стратеги"

гэж нэрлэж байгаа. Яагаад шинэ гэж үзэв. 1994 оны нэгдүгээр сард НАТО-гийн Зөвлөлийн онц чуулган чуулах үед энэ шинэ программыг гаргаж иржээ.

Ийм чуулган хуралдуулж, тийм чухал программ дэвшүүлэхэд юу нөлөөлөв. НАТО 1949 онд байгуулагдсанаасаа хойш анх удаа шинэ эрин үеийг тунхагласан, XXI зуунд хандсан чухал алхам хийлээ (жишээ НАТО-гийн тэр үеийн ерөнхий нарийн бичгийн дарга М.Вернерийн дүгнэснээр) гэж нийтээр үнэлсэн. Ийм алхам хийхэд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд:

- Европт "Хүйтэн дайн" дуусаад тодорхой хугацаа өнгөрсөн;
- Европын их гэр бүлдээ эргэж нэгдэхийг хуучин социалист орнууд хүсэн хүлээж, түүнийгээ энэ хугацаанд нотолсон, мөн Унгар, Польш, Чех зэрэг ардчиллын чиглэлд зоримог алхам хийсэн орнуудыг тусалж дэмжих талаар өрнөдийн орнууд хангалттай хүч чармайлт тавиагүй;
- Хуучин Югослав хяналтаас гарах дөхөж, Боснийн дайн дэлхийн хоёрдугаар дайнаас хойш Европт дэгдсэн хамгийн ноцтой мөргөлдөөн болон даамжирсан;
- Герман нэгдсэнээр Европын улс төрийн тогтолцоонд өөрчлөлт гарсан;
- Эцэст нь Оросын парламентын сонгуульд хэт үндсэрхэг, хуучинсаг хүчин өрсөлдөгчдөө давамгайлан гарч ирсэн, тэр нь Оросын реформд нөлөөлөх аюултай зэргийг нэрлэж болох байна.

Базаж хэлбэл, Орос дахь улс төрийн хямрал, ТУХН дэх тогтворгүй байдалд нийт европоороо сэтгэл түгшиж, Жириновский мэтийнхний хараал зүхлийг хөрш жижиг орнууд нь ханатлаа сонсож, аймшиг түгшүүрийг ёрлох болсон зэрэг тодорхой үндэслэл юм л даа. Тэгээд ч Польш, Унгар, Чех, Балтийн орнууд НАТО-д бүрэн эрхт гишүүнээр элсэх тухай шууд ярих болсон юм. Гэтэл үүний эсрэг нь Орос НАТО-гоос бэргэж, Польшийг НАТО-д элсүүлчихвэл Орос Европоос хөндийрнө гэж болгоомжлон НАТО-гийн хил хязгаарыг дорно зүг тэлж өргөжүүлэхийг эсэргүүцэж байгаагаас санаа авах хэрэг НАТО-д тулгарсан билээ. Тэгэхээр энэ хоёрт зэрэг хариу өгөх ёстой. Эхнийх нь НАТО-д элсэхийг үнэн голоосоо хүсч буй жижиг орны хүсэлт, дараагийнх нь цөмийн зэвсэгтэй, хүчирхэг гүрний болгоомжлол. Оросыг гомдоох хэлбэрээр хөршүүдийг нь дэмжиж болохгүй. Орост ая тал засах байдлаар бас жижиг хөршүүдийг нь хөсөр хаяж болохгүй. Энэ хоёрыг л харгалзан ийм "түншлэл" гэгч номлол боловсруулжээ. Тэгээд ч НАТО-гийн зүтгэлтнүүд энэ түншлэлээ "ухаалаг хариулт" гэж үзсэн. Жишээ нь Францын тэр үеийн ерөнхийлөгч Ф.Миттераны хэлснээр, энэ программ нь Төв болон Дорнод Европын орнуудыг аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ Оросын ардчилсан үйл явцдаа саад болохгүй ухаалаг хариулт болох юм гэнэ. Умард Атлантын

эвсэл Дорнод Европын орнуудын хувьд яваандаа (аажмаар) нээлттэй болох, тэгэхдээ Оросын ардчилсан реформд саад болохгүй байхуйцаар харилцах тухай Их Британийн ерөнхий сайд Ж.Мейжор ч анхааруулж байв.

Энд АНУ-ын ерөнхийлөгчийн хэлснийг тусад нь иш татъя. НАТО-гийн Зөвлөлийн тэр чуулган дээр, "Дорнод Европын орнуудын ардчилсан өөрчлөлт амжилт олохгүй бол Өрнөд Европын орнууд эх захгүй байдал, хүчирхийллийн давалгаанд татагдан орно. Ийм аюулын эсрэг тэмцэх шилдэг стратеги бол хуучин социалист орнуудыг өрнөдийн ардчилсан хамтын нийгэмлэгтэй интеграцчилж, тэдний эдийн засаг цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал мөн. Үүнд л энхийн төлөө түншлэх программ чиглэж байна" гэж Клинтон хэлжээ.

Ер нь НАТО-гийн удирдагчдын үзэж байгаагаар, нийтийн дайсны аюулаас айх хэрэггүй ч олон улсын тавцанд шинээр гарч буй өөрчлөлтийн явцад манай гаригийн энх тайван, аюулгүй байдалд заналхийлэх шинэ шинэ аюул, ухаандаа үндэстэн хоорондын мөргөлдөөн, үндэсний хувьд үл хүлцэх явдал өсөн нэмэгдэж байна. Тийм байдлыг ганцхан НАТО-гийн хүчээр засч залруулах боломжгүй, түүнд Орос ба хуучин ВГБ-ын бүх орон оролцох ёстой. Гэхдээ энэ нь НАТО-г дорно зүгт тэлж тухайлбал, Орос, Украин, Белоруссыг хүртэл элсүүлж авна гэсэн үг биш бөгөөд бас тэдний оролцоогүйгээр аюулгүй байдлын систем бий болгохгүй гэсэн санаа юм.

Дорнод Европын зарим орон, жишээ нь, Польш Оросын аюулаас гадна нэгдсэн Германы аюулыг үндэслэл болгож байна. Үнэндээ ч тус орныг хоёр талаас нь ямагт хэмлэж ирсэн түүхтэй. Польшийг НАТО-д элсүүлэхэд ямар нэг саад хийхгүй гэж Оросын ерөнхийлөгч Ельцин мэдэгдэж байсан үе бий. Гэтэл хэд хоногийн дараа (Ельцин Варшавт айлчлахдаа ингэж мэдэгдээд, Москвад буцаж ирсний дараа өөрөөр эргэснийг хэлж байна -Зох) Оросын цэргийн дээдчүүлийн даралтад орж, мэдэгдлээсээ няцсан. Польшоор НАТО-г тэлэхийг дэмжсэн М.Вернер болон ХБНГУ-ын Батлэн хамгаалах Яамны сайд Ф.Рюэ нар Ельциний байдлыг ойлгож байр сууриа өөрчилсөн. Ер нь ингэж тэлнэ гэдгийг НАТО-гийн хэн нь ч амлаагүй. "Энхийн төлөө түншлэл"-урилга, "Умард Атлантын Зөвлөлийн төр, засгийн тэргүүн нарын уулзалтын Тунхаглал" (Брюссель, 1994 оны нэгдүгээр сарын 10-11) гэсэн баримт бичигт ийм амлалт байхгүй, түүнээс хойш баталсан баримт бичгүүдэд ч мөн тэгж заагаагүй. Оросын сонгуулийн дүн болон ТУ ХН дэх хямралд сэтгэл түгшсэн нэг ч үг өгүүлбэр оруулаагүй. Харин энх тайвныг дэмжин сахиулахын төлөө НҮБ болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын хүч чармайлтыг дэмжиж, тэдгээрийн ивээл дор хамтран ажиллах тухай, түүндээ Дорнод Европ, Оросыг татан оруулах тухай ерөнхий заалт бий. Тэгэхдээ Чех, Польш, Унгар, Балтийн орнуудтай энхийг сахиулах

дасгал сургууль хийх тухай төлөвлөсөн юм бий. Ер нь энхийн төлөө түншлэлд оролцох улсуудын хувьд үндэс болгочихмоор нэгдмэл үнэт зүйл нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах, ардчилал, энх тайван, шударга ёс байх ба НАТО хэнд ч нээлттэй, хэнтэй ч хамтран ажиллах боломжтой гэж дээр дурдсан чуулганы хавсралт баримт бичигт зааж өгчээ. Энэ бол НАТО-той хамтран ажиллах орнуудад тавьж буй нэг ёсны болзол, НАТО-гийн гишүүн байх эсэхийн шалгуур болов уу. Ийм шалгуурыг удирдлага болговол түншлэлд оролцох орнуудын тоо аяндаа хязгаарлагдах болно.

НАТО-гийн шинэ ерөнхий нарийн бичгийн дарга В.Клас Вернерийг бодоход бүр ч болгоомжилсон байдалтай байна. Түүхэн учир шалтгааны улмаас үл итгэх үндэс байна гэдгээ тэр нуудаггүй, харин ч НАТО-г дорно зүгт тэлж, Оросыг хамруулбал НАТО-гийн мөн чанарын тухай асуудал гарч ирнэ гэж үзэж байна. Оросыг НАТО-д элсүүлэх тухай учир битүүлэг яриа гараад багагүй хугацаа өнгөрсөн ч өнөөг хүртэл тэр асуудал оньсого мэт байгаа. Орос нь Европын орон мөн боловч нутаг дэвсгэрийнх ихэнх хэсэг Азид ордог, хэрэв Орос НАТО-д нэгдэх аваас НАТО-гийн аюулгүй байдлын үзэл баримтлалыг үндсээр нь өөрчлөх хэрэг гарна. Тэгээд Хятад НАТО-той хиллэх асуудал гарч, НАТО-гийн стратеги маргаантай болно. Энэ бол алс хэтийн асуудал л даа. Гэхдээ энд дурдахад илүүдэхгүй.

НАТО-г дорно зүг өргөжүүлэх асуудлаар Оросын байр суурийг тодруулах шаардлага одоо Умард Атлантын эвслийн удирдлагыг зовоож байна. Ерөөсөө Оросын байр суурь тодорхой бус, байнга гуйвж дайвж, хэлснээсээ буцах мэтээр бусдыг төөрөлдүүлж байгаагаас Брюссельд "16+1" гэсэн томъёоллоор бас нэг шинэ баримт бичиг боловсруулсан. НАТО-г тэлдэг юмаа гэхэд яагаад, яаж гэдэг асуудал бий. Одоо 16 байгаа гишүүдийн хооронд ч маргаантай асуудал бишгүй байгаа. Гэтэл 17 дахь, дараа нь 18 дахь гишүүн гарч ирвэл яах вэ? Төсвийн асуудал шийдвэрлэхэд бас хялбаргүй. Энэ мэт бэрхшээлээс үүдэн НАТО лав л 1995 онд эгнээгээ тэлэх асуудлыг шийдэхгүй ажээ.

НАТО ба Европ

Энхийн төлөө түншлэлийн талаар бид бага ч боловч ойлголт авлаа. Одоо уг асуудлыг Европын дэвжээн дээр авч үзье. НАТО бол өрнөдийн соёл иргэншил, үнэт зүйлийг (Умард Америкийн ба Баруун Европын гэсэн үг -Зох) нэгтгэсэн цэрэг-үлс төрийн цорын ганц бүтэц гэдгийг юуны өмнө ойлгох ёстой (Энд Туркийг жич өгүүлнэ). НАТО-гийн энэ бат бэх, цул нэгдмэл байдлыг гишүүд нь эвдэхийг хүсэхгүй. Гэтэл нэгдэн нийлье гээд байгаа Дорнод Европын шинэ түншүүдийн тухайд янз янз. Болгар, Румын (энд Югославыг оруулсан ч болно-Зох) Орост илүү ойр гэх үү, бусад нь түүхэн учир шалтгаанаар хүссэн хүсээгүй өрнөдийн соёл

иргэншилд ойр юм. Балтийн орнууд бас энд орох байх. Өрнөдөд ойр байдаг хэсэг нь олон зууны турш газар зүйн хувьд, оюуны соёлын хувьд ч роман-католиг ертөнцөд багтаж, бас нэлээд хэмжээгээр "германчлагдсан". Энэ үндэс нь тэднийг Өрнөд Европ руу хандуулаад байж болох талтай. Гэтэл Оросын тухайд ингэж үзэх ямар ч үндэс алга. Орос түүхэндээ Европын байсан үе эднийг бодвол харьцангуй бага. Тэгэхээр НАТО-гийн тэлэлт хаа хүрэх нь тодорхой болж байна.

Нөгөө талаас дээр цухас дурдсан нэг шалтгаан бий. Хэрэв Орос эзэнт гүрний санаархалдаа эргэж хөтлөгдвөл Дорнод Европын, Балтийн тэдгээр жижиг орон өөрийгөө хамгаалах хүчин мөхөс, энэ байдал нь НАТО-д аргагүйн эрхэнд элсүүдэх гөл нөхцөл. Туслах чанарын нөхцөл нь Вышеградын бүлэг (Польш, Чех, Словак, Унгар) түүхэндээ Австри-Унгарын эзэнт гүрэнд харъяалагдаж, хоёр дайны хооронд Зөвлөлт - Өрнөд Европын хооронд завсрын бүс болж байсанд оршино. Тэгэхээр эд НАТО-д зүгээр элсэх төдий бус, НАТО-г шууд дагалдсан эрс тэс байр суурь баримтлаад байдгийн учир ийм юм. Бас нэг шалтгаан бий. Германы нэгдсэн улс бий болсноос эхлэн Европ даяар хий сүүдэр мэт түгшүүр тархсан. Германы жанжлал сэргэх вий гэж өрнө, дорногүй болгоомжилсон. Энэ шалтгаан дээрх хэдэн орныг НАТО-той хөдбону. Бас соёл иргэншлийн хувьд Европт огт хамаарахгүй Турк мэт орон өнөөг хүртэл НАТО-д хууль ёсны эрхтэй байгаад сэтгэл гонсгор байх үндэс бий. Турк бол тохиолдлоор, "Хүйтэн дайны" үеийн тодорхой шалтгаанаар НАТО-д элссэн болохоос олон асуудлаар холбоотнуудтайгаа зөрдөг. Тухайлбал, курд цөөнхийг алан хядаж, хүний эрх зөрчиж, лалын фундаментализмыг өөгшүүлж, хөрш Гректэй өнөөг хүртэл нутаг дэвсгэрийн асуудалтай, Киприйн умард нутгийг эзлэн авч, Туркийн бас нэг бүгд найрамдах улс тунхагласан гээд олон юм бичиж болно. Лалын ертөнцөд удирдах үүрэг хүлээх гэсэн Туркийн давилуун зан НАТО-гийн гишүүдийг хүйтэн хөндий хандахад хүргэж байна. (Түүх сөхвөл туркууд Европын зүрхэнд хүртэл давшиж, христосын соёл иргэншлийг заналхийлж, Балканы хойгийг эрхшээлдээ барьж байсан удаатай). Ийм учраас Турк-НАТО-гийн хооронд хачин жигтэй гэмээр уур амьсгал тогтож болзошгүй.

Үүний сацуу далайгаар дамжин Турктэй харилцаж байсныг орлох хуурай газрын түншүүд НАТО-гийн хувьд дараа дараалан гарч ирсэн. Энхийн төлөө түншлэлд нэгдсэн орнуудыг авч үзвэл Вышеградынхан шиг шууд элсэхгүй ч нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа авч үлдэхийн тулд НАТО-д хандсан хэсэг улс байгаа. Румын, Словак, Болгар, Украин, Молдов, Азербайжан, Албани, Словен, Хорват, Финландыг энд оруулъя. Эд бол 1993 оны Оросын сонгуулийн дараа огцом цочирдсон нөгөөх улсуудын нэг хэсэг. Ингээд бодоход НАТО-гийн гадна хэн үлдэн Төв Европын төвийг сахисан ганц хоёр улс, Шведийг эс тооцвол Европт хэн ч

үлдсэнгүй. Ийм учраас түүний үйл ажиллагаа нийт Европ тивийг хамарсан шинжтэй болж байна. Тэгэхдээ энэ уудам нутагт НАТО энхийг сахиулж чадах чадвартай гэсэн үг биш. Ирак, Боснид явуулсан байлдааны ажиллагаа энэ эвслийн хэдэн орны дотор нийтийн тохиролцоо (консенсус) хийх боломжгүйг харуулсан. Одоо 52-т хүрээд байгаа Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын гишүүдийн дотор мөн тийм тохиролцоо бий болгож чадах уу? Жишээ нь Молдов дахь Днестрийн асуудлаар консенсус хийе гэж бодъё. Тэнд НАТО-гийн цэнхэр дуулгатнуудын очихыг Орос, Украин зөвшөөрөх үү?

Тэгэхээр хоёр л хариулт байна. Эхнийх нь НАТО-гийн үйл ажиллагаа үнэхээр өмнөхөө бодвол тэлж, олон талтай болжээ. Дараагийнх нь НАТО-гийн энэ тэлэлт түүний хүчийг саармагжуулж, урьдын бат цул байсан бүтцийг нь сулруулах хандлагатай болжээ. НАТО-г өргөжүүлэхгүй цааргалаад байгаа нь ч үүнээс үүдэлтэй. Харин би үүнийг нэлээд хожуу гаргаж тавилаа.

Неоатлантизм

Европын улс төрийн тогтолцоо өөрчлөгдсөн хийгээд НАТО-гийн үүрэг хувьсаж байгааг дагалдан ийм шинэ нэр томъёо үзэгдэх болов. Үүнийг санаачлагч ба гардан хөргөжүүлсэн орон бол АНУ. Тус орон яагаад ийм шинэ асуудал сэдэх болов. Үүнд хэд хэдэн шалтгаан бий. Тухайлбал,

- Германы нэгдэл. Герман нэгдэхээс өмнө АНУ Европт голлох үүрэгтэй байсан, тэгэх тусмаа ХБНГУ-ын аюулгүй байдлыг АНУ л батдан дааж байсан. Гэтэл тийм шаардлага одоо амин чухал биш болжээ. Германы нэгдлийг дагалдан Европын интеграц улам эрчээ авсан. Өнөөдөр Европ АНУ-гүйгээр аж төрөх чадвартай боллоо.
- Социализмын задралаар эхэлсэн үндсэрхэг үзлийн дон. Үндсэрхэг үзлийн тэсрэлт ч гэж хэлж болно. Ийм үзэл бүс нутгийг хамрах (жишээ нь балканчлах аюул, Кавказ дахь лалын шашны нөлөө гэх мэт) шинжтэй болж ирсэн нь европт төдийгүй дэлхий дахинд халдварлах уршигтай байна.
- Европын социалист гэгдэж байсан орнуудын хоорондын эвлэршгүй мэтгэлцээн, өс хонзон. Польшууд Зөвлөлт-Германд араараа тавиулснаа үглэн ярьж, унгарууд 1920 оны Трианоны гэрээг ухаж сөхөн, чехууд Мюнхен, Ялтын тохиролцоонд гоморхож, словакууд өөрсдийн нь хэзээ ч бие даасан үндэстэн гэж үзэж байгаагүйд хорсолтой байгаа жишээ татъя. Энэ бол жишээ болохоос бус цааш нь жагсаая гэвэл ТУХН, Балканаас олон баримт цуглуулж болно.

Энэ бүхэн нийлээд АНУ-ын Европ дахь үндсэний эрх ашигт шууд нөлөөлөх болсноос үүдэн алдаж буй байр сууриа хэрхэн нөхөх тухай арга саам сэдэж эхэлсэн хэрэг. АНУ-ын санаачилгаар Умард

Атлантын хамтын ажиллагааны Зөвлөл байгуулснаар АНУ-ын Европ дахь нөлөө нь тогтож үлдэх ёстой болжээ. Энэ зөвлөлд аюулгүй байдлын асуудал хэлэлцэх үед хуучин социалист байсан бүх улс, ТУХН-ийн гишүүн орнууд оролцож, шийдвэрийг НҮБ ба Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын эрх олгосноор НАТО-гийнхан гаргаж, шаардлага-тай гэж үзвэл, жишээ нь Боснид байлдааны ажиллагаа явуулбал НҮБ-ын хяналтаас гарна гэхчлэн тодорхой бус юм энд бий.

НАТО-д АНУ-ын үүрэг багасахын хэрээр түүний нөгөө талд Герман-Францын үүрэг өсч байна. Герман-Францын хамтарсан "Еврокорпус" гэгч нь НАТО-д бус, Өрнөд Европын холбоонд харъяалагдаж байна. АНУ-ын цэрэг Европт тийм олноороо байх эсэх тухай ч европынхон ярилцах болжээ. Ялангуяа иймэрхүү зүйлийг францууд мэр сэр цухуйлгаж байна. Европын комиссыг олон жил удирдсан францын улс төрийн нэр зүтгэлтэн Жак Делор эхэлж ингэж дуугарчээ. Ер нь АНУ-ын талаар ч, НАТО-гийн талаар ч Өрнөд Европт Франц этгээд гэмээр байр суурьтай. Саяхнаас ч ингэсэн хэрэг биш, аль 60-аад оноос яригдах асуудал. АНУ-ын хувьд Атлантизм гэгч нь шинэ зүйл бас биш. 1963 онд АНУ-ын ерөнхийлөгч Ж.Кеннеди "Twin-Pillar" номлол дэвшүүлэхдээ, анхлан энэ ойлголтыг гаргаж иржээ. Нэгдсэн Европын хүрээнд Атлантын түншлэл хэрэгжүүлэх тухай санаа түүнд агуулагдсан байв. 1973 онд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Г.Киссинжер "Атлантын түүхэн Харти" гэсэн үг хэлэхдээ мөн үүнийг давтаж байлаа. Энэ бүгд нь холбоотнуудаа хохироохгүйгээр АНУ-ын Европ дахь байр суурийг бэхжүүлэхэд чиглэсэн байв. Дэлхийн хоёрдугаар дайны дараа дэлхийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 40 хувийг дангаараа гаргаж байсан үе АНУ-ын хувьд бий. Ийм давамгайл байдал аажим аажмаар арилж. Европ, Япон хөл дээрээ босч ирэх тусам АНУ-ын эрх ашгийн хүрээ хумигдаж ирсэн билээ. Ингээд америктай америкгүй "хувиа бодож довоо шарлуулахтайгаа" болжээ (АНУ-ын цөмийн халхавчийг энд оруулаагүй -Зох).

Америкчуудыг неоатлантизм сэдэхэд хүргэсэн гол орон Францын хандлагыг энд тухайлан авч үзэх хэрэгтэй. Ер нь тус орон Умард Атлантын эвсэлтэй харилцах талаар Европтоо онцгой байр суурь баримталдаг. Яагаад онцгой гэж нэрлэв гэхээр нь Франц нь аль 60-аад онд АНУ-ын Атлантизмын бодлоготой зөрчилдмөгцөө (хэрэг дээрээ цөмийн зэвсэгтэй болмогцоо) 1966 онд НАТО-гийн цэргийн байгууллагаас сайн дураараа гарсан улс. Ингээд АНУ түүн амриггүй батлан хамгаалж чадахаа харуулсан төдийгүй цөмийн амригийн хэмжээгээр АНУ, ЗХУ-ын дараа гуравдугаарт орж, цэргийн стратегийн том гүрэн болохоо нотолжээ. 70-аад онд сүүнээр "Пүүжингийн хямрал" дэгдэж, АНУ Европт ашиг сонирхлоо татаж боловцоо гарчээ. Америкийн дунд тусгалын пүүжин байрлуулж, Зөвлөл АНУ хоёр хий мэтгэлцэж байхад Франц огт ажрахгүй байсан. Пүүжингийн хямрал арилсан ч Франц

цөмийн хүчнээ хэвэнд нь барьж, хэнээс ч дугахгүй зэвсэглэсээр өнөө хүрчээ.

Гэвч 90-ээд онд Европ тивд геополитикийн гүнзгий өөрчлөлт, лихц дэвшил гарав. НАТО-той харилцахдаа дорвитой өөрчлөлт гаргах, тэгэхдээ энэ асуудлыг ихээхэн ултай авч үзэхийг шинэ нөхцөл шаардлаа. Гол нь алс хэтийн ирээдүйгээ харж харилцахыг хэлж байгаа хэрэг. "Хүйтэн дайн" түүх болсон үед батлан хамгаалах, аюулгүй байдлын бодлогодоо НАТО, Европын холбоо, Баруун Европын холбоо харилцан бие биеэ дэмжих үүрэг гүйцэтгэнэ гэдгийг үүнд иш үндэс болгох ёстой. Үүнтэй уялдуулж (Европын геостратегийн өөрчлөлт) НАТО-гийн үүргийг шинээр томъёолохыг Франц санал болгож байна. Францын үзэж байгаагаар, НАТО-гийн дорнод хөршүүд болох хуучин социалист хэдэн орон өнөөдөр энэ эвслийг даган дууриах үлгэр загвар, магадгүй халамжлан асрамжлагч, маргаашийн хувьд бол зарга гаслагч хэмээн үзэх (миний бодоход яг бодит байдал болчихоод байна-Зох) хандлагатай байна. Үнэндээ эдгээр орны хувьд НАТО хаанаас гарал үүсэлтэй нь падгүй болж, энх амгалан байдлыг нь зөрчих аливаа этгээдийг үр нөлөөтэй тогтоон барьж л байвал болох бололтой.

НАТО-гийн талаар Франц ингэж үздэг боловч америкийн үүргийг бүрмөсөн таягдан хаях санаа өвөрлөөгүй. Европынхон улс төрийн хувьд наад захын нэгдэлд хүрч (нийт Европоор ярьж байна-Зох) харьцангуй ч атугай хүчний тэнцвэртэй байдал тогтоох системтэй болох хүртэл АНУ-ын цэрэг, зэвсэг Европт байх ёстой гэж Франц үзэж байна. Яг одоо АНУ-ын цэрэг, зэвсгийг Европоос бүрэн гаргаж, НАТО-д АНУ-ыг оролцуулахаа больё гэж төсөөлье. Тэгээд ямар орон зай гарах вэ? Цөмийн зэвсэгтэй, дэлхийд хамгийн хүчирхэг армитай, дээрээс нь тогтворгүй, баталгаагүй Оросын өмнө Европ яаж ч хүчрэхгүй. Энд англи, францын цөмийн тогтоон барих хүч ямар ч үүрэг гүйцэтгэхгүй.

АНУ-ын неоатлантизмын өөр нэг зорилго бол Европианизм гэгчийг сэргүүлэх явдал. Ер нь Европчлох оролдлого урт удаан түүхтэй. Дайнаас хойш шинэ шатанд гарсан. Маастрихтын түүхт хэлэлцээрээр Европын холбоо интеграцын шинэ үедээ орлоо. Хүрээ нь тэлж байна. Тэгэхээр энэ их хүч (потенциал) Умард Атлантын хамтын ажиллагааны Зөвлөлд оролцож баймааж нь үр ашгаа өгнө гэж АНУ үзэж байна. Европын саланги зожиг байдал энэ тивийн үүр амьсгалд таагүй нөлөөлж байсан түүх бэлхнээ бий бөгөөд түүнээс үүдсэн уршгийг арилгах гэж америкчууд хүндийг үүрч ойлсан билээ. Тэр утгаар Атлантизм чухал болох ажээ.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал

Энэ талаар тусад нь өгүүлэх ялдамд нэр томъёоны талаар сэнналаа эхлэн хэлье. Монголын хэвлэлд "Европын аюулгүй байдал

хамтын ажиллагааны асуудлаархи Зөвлөлгөөн" гэж хэвшсэн. Би ч мөн энэ жишгийг дагаж түүрүүчийн номдоо ("Олон улсын харилцаа XX зуунд) "Зөвлөлгөөн" гэж бичсэн. Энэ нь орос хэлнээс "Совещание" гэдэг үгийг махчлан орчуулсны монгол орчуулга. "Бага хурал" гэж өөрчилсөн шалтгаан гэвэл, нэгдүгээрт англи хэлний "Conference on Security and Cooperation in Europe" буюу товчлоод "CSCE" гэдгийг шинээр орчуулах, хоёрдугаарт "CSCE" нь олон улсын байгууллага болж өргөжсөнд байгаа юм. Өрнө, дорно нийт Европт анхнаас нь бага хурал гэж нэрлэж тогтсон. Тэдний жишгээр нэрлэх нь зүйтэй гэж би үзлээ. Одоо "Совещание" гэдэг орос үг "Организация" болж, албан ёсоор "ОБСЕ" гэж товчлон нэрлэдэг болжээ.

"Хүйтэн дайны" төгсгөл, ЗСБНХУ-ын задралаар Европын аюулгүй байдалд учрах аюулын шинж чанар өөрчлөгдсөн тухай дээр тодорхой өгүүлсэн. Европ руу гаднаас гэнэт халдах аюул арилж, харин оронд нь дотроос, тухайлбал, улс орны дотоодын мөргөлдөөний аюул гарч ирсэн билээ. Яг одоо ийм шинэ аюулыг арилгах, ядаж сэрэмжлэх тийм үнэмлэхүй оновчтой механизм Европт алга. Европын олон улсын олон талт институтууд бүгд шилжилтийн гэмээр үед байна. "Хүйтэн дайны" үед ажиллаж хэвшсэн байдлаа шинэ нөхцөлд тохируулан өөрчлөн шинэчлэх ёстой. Тэдгээр институтын дотор дээр дурдсан Бага хурал орно.

Бага хуралд оролцогчид Парисын уулзалтаас (1990 он) хойш хэд хэдэн удаа хуран чууллаа. Гэхдээ ялгарах онцлог бий. Тоон үзүүлэлтээр авч үзэхэд, Парист Европын 32 улс, АНУ, Канадын удирдагчид цугласан бол хамгийн сүүлд 1994 онд Будапештэд 52-уулаа цуглажээ. Гишүүдийн тоо даруй 20-иор өсчээ. Энд Югослав хасагдаж, Македон орж амжаагүй байсныг тооцоолоод 52 болж байна. Бас урьд нь тогтмол ажилладаггүй байсан шинэ механизм бий боллоо. Тэр нь Бага хурлын байгууллага юм.

Ванкуверээс Владивосток хүртэл бүх нийтэд зориулсан ардчилал, хөгжил цэцэглэлтийн бат бэх үндэс суурь Парисын уулзалтаар тавигдсан. Ялангуяа аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах баттай механизм бий болов. Нийтлэг үнэт зүйл болох ардчилал, төрт ёс, олон ургальч үзэл, зах зээлийн эдийн засгийн талаархи ялгаа зөрүү хойшид арилах эхлэл тавигдсан. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг дээдлэх, ялангуяа үндэстний цөөнхийг эрхийг хүндэтгэх бүх нөхцөл тэр уулзалтаар тунхаглагдаж билээ.

Үүний сацуу улс орнуудын түүхэн улс төр-нийгмийн тогтолцоог зөвхөн дотоодын асуудал гэж зориуд тэмдэглэсэн байгаа. Энэ үтгаараа Европын орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох эрх хэнд ч байхгүй гэсэн үг. Гэтэл энэ тунхаглал яагаад хэрэгжихгүй байна вэ? Үүнд европыг төдийгүй дэлхий дахиныг түгшээж буй хямрал мөргөлдөөнүүд хариу өгөх

ёстой. ТУХН ба хуучин Югославын тухай дахин ярих нээ гэж уншигчид бодож байгаа. Тэр зөв.

Өнөөдөр европчуудыг улс хоорондын харилцаа бус улс орны доторхи хэрэг явдал, тухайлбал, хүний эрх болон тодорхой үндэстэн ястан, шашны бүлгийн эрхийг зөрчих явдал л түгшээж байна. Энэ бүхэн шинэ мөргөлдөөний эх ундарга, шалтгаан болж байна. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын бүтцийг авч үзвэл энэ бүхнийг зохицуулах арай боломжтой нь НАТО, Баруун Европын холбоо юм. Энэ хоёрын үр ашигтай байх, нөлөөлөх чадвартайг шалгасан шалгуур чухам ТУХН, Югославт олонтаа тохиолдсон юм. Одоо ч үргэлжилж байна.

1992 оны нэгдүгээр сард Бага хуралд оролцогч орнуудын ГЯЯ-ны сайд нарын Прагад болсон Зөвлөлийн чуулганаар хуучин Зөвлөлтийн бүх бүгд найрамдах улсад "гишүүн-улсын" статус олгожээ. Гишүүн орны тоо нэмэгдэнэ гэдэг нь шийдвэрлэх зорилтын хүрээ өргөжнө гэсэн үг. Бас шинэ шинэ асуудалтай тулгарна гэсэн үг. Бага хурлын хүрээнд урьд нь хамтын ажиллагаанд оролцож байгаагүй, тусгаар тогтнолын талаар туршлагагүй, огт өөр соёл иргэншилтэй (лалын шашныг хэлж байна) шинэ залуу орнууд нэгдэн нийллээ. Одоо Европын дэвсгэр дээр явцуухан авч үзэх аргагүй болов. Үйл ажиллагааны хүрээ тэлж Ази, Алс Дорнодтой хаяа нийллээ. Ийм учраас ерөнхий байсан зорилгоо дотор нь задалж, ялгавартай болгох, түүнийгээ хэрхэн ямар замаар хэрэгжүүлэх гэх мэт шинэ асуудал тулгарлаа.

Ялангуяа Зөвлөлтийн задралаар үүссэн ТУХН дэх хямралт байдал энэ зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн түвэг удах төлөвтэй байна. ТУХН-ийн бүх орон урьд ЗСБНХУ-ын хүлээсэн үүрэг амлалтыг бүрэн хүлээн зөвшөөрснөө илэрхийлсэн. Тэдгээр үүрэг амлалтын дотор ердийн зэвсэглэл хорогдуулах, мөн хүний эрх, ардчиллын асуудлаар хүлээсэн үүрэг бий. Үүнийг өнөөдөр ТУХН-ийн гишүүн орнууд биелүүлж байна уу? Үүнд, түрүүчийн бүлэгтээ тодорхой хариу өгсөн гэж бодож байна.

Бага хурлын гишүүн Европын соёлжсон орнууд, эхлээд том эндүүрэл хийжээ. Тэд тоталитари дэглэмд удаан хугацаагаар байсан орнуудыг ардчилалд шилжихэд нь туслах, төрт ёс төлөвшүүлэх, улмаар шашны фундаментализмаас сэргийлэх тухай бодсон бололтой. Энэ талаар 1992 оны долдугаар сард Хельсинкэд дээд хэмжээнд уулзахдаа тунхаг шинжтэй шийдвэр гаргасан. Тэгтэл бүх юм санасны эсрэгээр эргэжээ. ТУХН болон хуучин Югославын дотоодын мөргөлдөөнийг зөвхөн дотоодын хэрэг гэж үзэх аргагүй болов. Дотоодын хэрэг гэхээр тэнд хүний эрх, цөөнх үндэстний эрхийг балмадаар хөсөрдүүлж байдаг, хүний эрхийг нь хамгаалъя гэхээр Хельсинкийн Төгсгөлийн баримт бичгийн (1975 он) ҮI зарчим (дотоод хэрэгт оролцохгүй) зөрчигдөх гээд байна. Ийм л ацан шалаанд Бага хурлын байгууллага орчихоод байна. Иг ийм эгзэгтэй байдлыг ашиглан Босни болон ТУХН-ийн зарим

хэсэгт байлдааныг шатлан өргөжүүлсэн байж магадгүй. Тэгэхээр 20 жилийн тэртээ зарла- сан хуучин зарчмыг шинэ нөхцөлд тохируулан шинээр тодорхой- лох шаардлага зүй ёсоор гарч байна. Улс түмэн бие дааж эзэн мэдэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа хадгалах эрхийг ч Төгсгөлийн баримт бичигт шинээр зааж өгөх буюу шинээр тайлбарлах ёстой гэж үзэж байна. Тухайлбал, хоёр Герман нэгдсэн, Чехословак эв зүйгээрээ салсан, ЗСБНХУ, Югослав хоёр задарч, олон улсууд оронд нь гарч ирсэн, өнөөдөр Орос, Гүрж мэт орнууд дотроо ийм аюултай тулгараад байгаа зэрэг олон баримт бэлхнээ байна. Ийм үйл явцыг Төгсгөлийн баримт бичигт урьдчилан хараагүй. Тэгэхээр одоо юу гэж ойлговол зохих вэ? Чеченд хангалттай цус урсгасан, дахин ингэхгүй гэх баталгаа тэнд алга. Орос ч ийм баталгаа өгөх хүсэлгүй. Гэтэл энэ бүхэн нь Бага хурлын үзэл санаатай зөрчилдөж, уур амьсгалд нь нөлөөлж байна.

Үүний сацуу нэгдмэл цул байсан Бага хурлын бүтэц шинэ нөхцөл байдлаас үүдэн хэтэрхий олон салбарлаж, тархах, саармагжих хандлагатай боллоо. Үүний зэрэг, сөрөг талыг ялгах гэж яарахаа азная. Европ-Атлантын байсан энэ хамтын нийгэм- лэгийг өөрөөр нэрлэе гэсэн санал ч цухалзаж байна. Хил хязгаар нь Номхон далай, Төв Ази, Дундад Ази хүртэл тэлчихээд байхад ингэж явцуу нэрлэж таарахгүй. Бас дотор нь бүс нутгийн, салбар бүс нутгийн шинжтэй олон бүлэг институт бий болоод байна. Энд НАТО, Баруун европын холбоо, Европын холбоо, цаашлаад салбарлавал Вышеградын бүлэг, Төв Европын санаачилга, Умардын Зөвлөл, Хар тэнгисийн хамтын ажилла- гааны байгууллага гэх мэт олон бүтэц бий болжээ. Цааш хэд задрахыг таах аргагүй.

Энэ бүхнийг дагалдаад гэх үү, ямар ч атугай шинэ нөхцөлд аюулгүй байдлын асуудлын мөн чанар өөрчлөгдлөө. Урьд нь энэ асуудлыг зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих явдлаар хязгаарлаж байсан. Гэтэл 1992 оноос огт өөр юмаар орлууллаа. Одоо аюулгүй байдал гэвэл болзошгүй зэвсэгт мөргөлдөөнөөс сэргийлэх, бий болсон хямралыг хянах гэдгээр төсөөлж байна. Зэвсэглэлд хяналт тавих тухай 20 жилийн тэртээх зорилт- утгаа алдсан. Байлдаж буй талуудыг эвлэрүүлэх буюу тэдэнд зэвсэг өгөхгүй байх, эсвэл аль хүч султайг нь зэвсэглэх асуудал гэж өөрчилбөл ямар вэ? гэсэн тээнэгэлзэл бий болжээ.

Дүгнэлт

Бид ТУХН бий болсноор Европын улс төрийн тогтолцоо хэрхэн шинэчлэгдэж байгаа байдлыг тал бүрээс нь, тэгэхдээ цэрэг-улс төр, стратегийн талаас нь авч үзэхийг оролдлоо. Европтой холбогдох өөр олон асуудал дараагийн бүлгүүдэд тусгагдана. ЗСБНХУ задарч, ТУХН үүссэний нөлөө Европт хэрхэн тусч байгааг энд голчлон гаргахыг хичээсэн. Гэвч үлдэж хоцорсон олон асуудал бий. Тэр бүхнийг энд багтаах боломж алга.

Бичсэнээ эргэж дүгнэхдээ ойрын ирээдүйг төсөөлөхийг зорилоо. Юуны өмнө Европ гэдэг нь газар зүйн ойлголт байхаа болиод удсаныг хэлэх байна. Хэрэв газар зүйн ойлголт бол Европ нь Атлантаас Уралын нуруу, Скандинаваас Хар тэнгис. Гэтэл энэ ойлголт Уралыг аль хэдийн давжээ. Ийм өргөн нутагт христосын болон лалын соёл иргэншил, өрнөдийн болон дорнодын итгэл үнэмшил үнэт зүйл, олон зуун үндэстэн ястан, цагаан, шар арьстан холилдсон Европын тухай ярих болох нээ. Энэ бол механик ойлголт. Гэвч ийм адил төсгүй байдал юунд хүргэх бол гэдэг гол асуудал бий. Үүнийг би урьдчилан хэлж чадахгүй. Гэвч дүгнэлт болгон доорхи зүйлийг хэлэх байна. Үүнд:

1. Европ тив шилжилтийн их үед, тодорхой хэлбэл шилжилтийн их давалгаан дүнд байна. Европчууд ийм давалгаанд орно гэж урьдчилан хараагүй, хүсээ ч үгүй. Социализм системийн хувьд сүйрснээр бүх юм хэвийн болно гэж бодож байснаас бус энэ сүйрэл өөрсдөд нь юу тулгахыг тооцоогүй юм. Тэгээд ч урьдчилан бэлтгээгүй гэнэт тулгарсан шинэ нөхцөл байдал цаашид хаашаа эргэх нь тун бүдэг байна. Ийм учраас шилжилт удах төлөвтэй.
2. Шилжилтийг дагалдаад Европын улс төрийн тогтолцоо, олон улсын институтууд хөдөлгөөнд орлоо. Хуучин меха- низм, шийддэг арга, зарчим үйл явдлыг хөөж гүйцэхгүй буюу цаг үетэйгээ авцалдахгүй байна. Олон улсын хууль хүчгүйдэж, зөвхөн хүч л асуудлыг шийдэж байна. Хэлэлцэн тохирсон зүйл, хүлээсэн үүрэг амлалт зөрчигдөж (зарим нь шууд хөсөрдүүлж - Зох) түүнийг засч залруулдаг, хянадаг механизм үгүйлэгдэж байна. Үүнийг ТУХН, хуучин Югославын жишээн дээрээс харж болно.
3. Түгшүүртэй байдлын элдэв голомт, мөргөлдөөнөөс олон жил хол хөндий, амар жимэр оршиж ирсэн европчууд одоо түүнтэй нүүр тулах аюултай тулгарав. Түүнд Европ даяараа сэтгэл түгших болжээ. Түүнийг хэрхэн зохицуулах, болзошгүй аюулаас хэрхэн сэрэмжлэх талаар Европын цэрэг-улс төр, эдийн засгийн бүх институт ажиллаж байна. Ийм нөхцөлд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал аюулгүй байдлын ямар нэг байгууллагын үүрэг гүйцэтгэж чадахгүй байна. Европын улс үндэстнүүд тус тивд Югославын маягийн хямралаас сэргийлэх зорилгоор 1995 оны гуравдугаар сард "Тогтвортой байдлын гэрээнд" Гадаад явдлын Яамны сайд нарын хэмжээнд гарын үсэг зурсан нь "Хүйтэн дайны" ул мөр болсон хуваагдмал байдлыг гэтлэн давах шинэ итгэл төрүүлснийг бас дурдах ёстой.

ХОЁР. ЗСБНХУ-ЫН ЗАДРАЛ БА АЗИ

Сэдвийн гарчиг томдсон байж болохыг уншигч Та юуны өмнө болгооно уу. ЗСБНХУ задарч, ТУХН үүссэнээр түүнтэй газар зүйн хувьд залгаа орших хоёр тивд олон улсын харилцааны ямар шинэ хандлага ажиглагдав гэдгийг өгүүлж байгаа болохоор ийм гарчиг сонголоо. Гэхдээ энд бичих зүйл Европыг бодвол бага зай эзэлнэ. Энэ нь түүхэн учир шалтгаантай бөгөөд түүнээс үүдэн хамрах орон зайн хувьд ч хязгаарлагдмал байх болно. Бас Ази гэсэн ойлголтоор эндхийн бүх бүс нутаг, орныг хамруулан авч үзэхгүй. Учир нь ЗХУ ба ТУХН-өөс нөлөөлж байсан буюу нөлөөлж буй хүрээ хязгаар Азид тэгтлээ тэлээгүй. Мөн Ойрхи Дорнод, Зүүн өмнөд Азийн асуудлыг жич өгүүлэх тул энд оруулахгүй. Эцэст нь хэлэхэд "Азийн онцлог" гэж нэгэн учир битүүлэг зүйл бий. Тэр онцлог миний бичих асуудалд ихээхэн үүрэгтэй гэх үү, ямар ч атугай харгалзан үзэхээс өөр аргагүй.

40 гаруй жил ЗСБНХУ-АНУ гэсэн хоёр туйлтай байсан олон улсын харилцааны систем 90-ээд онд төгсгөл болсон билээ. "Хүйтэн дайн" хэдийгээр төгсгөл болсон ч дэлхий дахинд энэ бат бэх энх амгалан байдал тогтоох баталгаа бүрдээгүйг Европоор тодорхой өгүүлсэн. Азийн хувьд "Хүйтэн дайны" төгсгөл Европынх шиг тэгтлээ сүрхий нөлөө үзүүлээгүйг юуны өмнө хэлэх ёстой. Эндхийн олон орны стратегийн бодлогод эдийн засаг тэргүүлэх байр эзэлж ирсэн, одоо ч мөн тийм байна. Дэлхийн тэмцлийн гол талбар эдийн засгийн салбар боллоо гэж азичууд үзэж байна. Учир нь 40 гаруй жил хэт сунжруу харилцан сөргөлдөж, зэвсэглэлээр хөөцөлдөхөд хамаг хөрөнгөө барсан тул ЗХУ аргагүйн эрхээр тамирдан унаж, АНУ ч нэлээд сульдсан мэт тэдэнд ойлгогддог. Тэгээд ч америкийн засаг захиргаа солигдохыг Азийн олон оронд дан ганц эдийн засагтай нь холбож үзэж байна. Энэ утгаараа Азийн улсууд олон улсын харилцааг арай өөр хэмжүүрээр авч үздэг. Тэдэнд аюулгүй байдал, ардчилал, хүний эрх олон улсын харилцааны гол асуудал биш. Гэхдээ энэ нь улс хоорондын харилцаагаа гаргуунд гаргадаг гэсэн үг бас биш.

Аюулгүй байдлын хувьд Азийн орнууд АНУ-ын хараат болоогүй (Өрнөд Европтой харьцуулахад), бас Зөвлөлтийн аюулаас ч нэг их сүрдэж байгаагүй. Ийм учраас Азид хүчний харьцаа тогтоож тэнцүүлэхэд АНУ-ын шууд оролцоо Европтой харьцуулахад тийм их шаардлагатай байгаагүй юм. ЗХУ ч Азид Монгол, Афганистан, Энэтхэг хятадын хойгийг эс тооцвол цэрэг-стратегийн давуу байдал тогтоож чадаагүй. Өмнөд Солонгосыг тооцохгүй бол Азийн хэмжээнд америкийн цэрэг онц шаардлагатай газар алга. Оросын тухайд бол хил хязгаараа л Хэл үггүй манаж байхаас өөр ариун үүрэг алга. Тадагш нь цэрэг

илгээгээд эцэст нь юунд хүргэдэг гашуун туршлага бэлхнээ Афганистан байж байна.

Зөвлөлтийн үлдээсэн өв

ТУХН ба Азийн орнуудын хоорондын харилцаа, шинээр бүрэлдсэн нөхцөл байдлыг тайлбарлахын өмнө Зөвлөлтөөс Азид явуулж байсан бодлогыг сөхөж үзье (Миний түрүүчийн номд үүнийг цухас дурдаад өнгөрсөн). Зөвлөлтийн хувьд ч, одоо Оросын хувьд ч Азид чиглэсэн тодорхой бодлого, үзэл баримтлал байхгүй явж ирсэнд гол асуудал оршиж байна. Өнөөдөр төгс төгөлдөр болчихсон Азийн бодлого Орост алга. ТУХН, түүний дотор Оросын хувь заяа, хэтийн төлөв тодорхойгүй байгаагаас ийм бодлого боловсруулж завдахгүй байна. ТУХН дэх 12 улс холбоотнууд уу? Аюулгүй байдал хамтынх уу? Эсвэл бие биеэ дайсан гэж үзэх үү? гэдэг ацан шалаа Азид ч тусч байгаа хэрэг. Гэхдээ энэ бол зөвтгөж болох шалтгаан. Орос, ТУХН-рүү бурууг тохож болохгүй. Гол буруутныг хайя гэвэл ЗХУ-ыг л нэрлэх байх. Тийм учраас би Зөвлөлтийн үлдээсэн өв гэж гарчигласан юм.

Ер нь Оросоос Алс Дорнодод (Ази гэж томруулах утгагүй - Зох) явуулсан бодлогыг хэд хэдэн шатаагаар авч үзэж болно. Үүнд:

1. Бүр өнгөрсөн зуунд Хаант Орос Аляск, Калифорни, Номхон далайн зарим арлыг эзэмшиж байсан үеийг эхний үе болгоё. Энэ бол эзлэн түрэмгийлэл биш, газар зүйн их нээлтүүд, далайн аялал хөгжсөний үр дүн байлаа. Тэгээд ч Хаант хасаг тэнд ямар нэг үүрэггүй байсны жишээ Аляскийг худалдсан явдал болсон юм. Хэрэв төрийн тодорхой бодлого байсансан бол ийм алхам хийхгүй.
2. Өнгөрсөн зууны сүүлээр Азийн талаархи Оросын бодлогын хоёр дахь үе эхэлсэн. Оросын колониуд (нүүдэллэн суугчид) Австрали, Шинэ Зеланд, Гонконг хүрч, Хятад, Солонгост тодорхой байр суурьтай болж бэхжив. Гэтэл Орос-Японы дайнаар Оросын Ази дахь бодлого сүйрэв.
3. Зөвлөлт засаг 1917-1945 онд Азид Хаант Оросыг орлох ямар ч бодлого явуулсангүй. Энэ үед үндсэндээ Азиас шахагдан гарсан юм.
4. 1945-1965 онд "Азийн социализмын алтан үе" ирж, ЗХУ-ын Ази дахь бодлого хэзээ ч байгаагүйгээр сэргэжээ. Урьд нь Оросын улс төрийн нөлөө тусч байгаагүй цоо шинэ олон газар Зөвлөлтийн байр суурь бэхжиж чаджээ. Гэтэл энэ цэцэглэлтийг нь 3 хүчин зүйл мөхөөжээ. Тэр нь Вьетнамын дайн, Индонезийн хувьсгалын сүйрэл, Зөвлөлт-Хятадын харилцааны хямрал билээ.
5. 1965-1985 онд ЗХУ Азид хамгийн харалган мугуйд бодлого явуулав. Тэр үед Азид социализмын нэр хүнд унаж, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн суларчээ. Түрүүчийн үед нь ЗХУ эдийн засгийн талаар бэхжиж авах боломжоо алдсан бөгөөд хойшил

эндхийн бүх үйл хэргийг үзэл суртлын үүднээс авч үзэн эвсэл холбооны дотор хэмждэг байлаа. Брежневийн "Ази дахь хамтын аюулгүй байдлын үзэл" гэгч нь Азийг урьд хожид байгаагүй ихээр зэвсэглэв. Бүс нутгийн эдийн засгийн интеграц, улс төрийн хамтын ажиллагааг ЗХУ зөвхөн нэг талаас нь цэргийн эвсэл мэтээр (жишээ нь АСЕАН) дүгнэж байлаа. Азид бөөгнөрүүлсэн Зөвлөлтийн хуурай замын асар их цэрэг Хятад руу чиглэж, тэнгисийн цэргийн хүч нь АНУ-тай халз сөргөлдөх хэмжээнд хүрэв. Афганистанд цэрэглэн орж, зэвсэглэлээр хөөцөлдөж байсан нь хүчээр түрээ барих замаар бодлогоо хэрэгжүүлэх гэсэнтэй нь холбоотой. Гэтэл үүний цаана нэг чухал зүйл байсныг анзаарсангүй. Юу гэвэл ЗХУ зөвхөн цэрэг байрлуулснаар сэтгэл ханасан бол АНУ өөрөөр ажилласан юм. Энд мөн америкийн цэрэг олноороо байсан, одоо ч байна. Гэхдээ АНУ улс төр, эдийн засаг, соёл зэрэг бүх салбарт нөлөөтэй байсан юм. Дайн дуусмагц Зөвлөлт, АНУ хоёр хоёул Азид бэхжиж авсан. Гэвч америкчууд эдийн засгийн сонирхолдоо их ач холбогдол өгсөн. Тэгвэл Зөвлөлт Азид цэрэг, зэвсэг бөөгнөрүүлснээс өөр юм хийсэнгүй. Зөвлөлтийн эдийн засгийн сонирхол Монголоор хязгаарлагдаж байсан гэхэд хилсдүүлэлт болохгүй. АНУ Азитай хуурай газраар хил нийлдэггүй. Гэтэл ЗХУ хуурай газраар асар их хилтэй, түүнийг ашиглах талаар юу ч хийгээгүй. Жишээ нь Сибирь бол ЗХУ-ыг Ази, Номхон далайтай холбох гүүр байх учиртай байтал ингэж хандаагүй. Ердөө л түүхий эдийн хавсарга, колони, хагас колони байдлаар түүнийг ашигласан. Зөвлөлтийн үндэсний орлогын гуравны нэгийг эндээс бүрдүүлдэг байснаас тэр л дээ.

Яг ийм эвгүй үед М.С.Горбачев гарч ирсэн билээ. 1985 оноос Азийн талаар явуулсан бодлогын дараагийн үе эхлэх байх. Гэвч энэ үе шууд л амжилтаар эхлээгүй. Эхлээд Горбачев түрүүчийн удирдагчдынхаа Азид явуулсан бодлогын алдааг засах ёстой. Энэ бол 1988 он хүртэл үргэлжилсэн завсрын үе юм. Тэгэхдээ Горбачев юунаас эхлэх вэ? гэдэг дээр эргэлзэж, баахан цаг алдсан. ЗХУ Азид байр сууриа бүрэн алдсан, нэр хүнд нь дээд цэгтээ тултал унаж доройтсон, гарах аргагүй зэвсэгт мөргөлдөөнд татагдан орсон, асар их зардал үргүй урсгасан ийм үед чухам яалтай билээ гэж эргэлзэх нь ч бас зөв. Үүний сацуу удирдлага дахь өвгөрсөн большевик удирдагчид, сөрөг хүчнээ аюулгүй болгож байж үүнийг хэрэгжүүлнэ. Үнэндээ эдгээр бэрхшээл нь ЗХУ-ыг өөрийг нь боймлоод Азид нэвтрүүлэхгүй байх тэр үед Азид "эдийн засгийн гайхамшиг" гэгч бий болоод удсаныг хэн ч мэдсэнгүй. Ази бол дотроо дэндүү олон янз, хөгжил эрс тэс, соёл иргэншил нь харилцан адилгүй учраас ангийн, их гүрний, аюулгүй байдлын аль ч бодлогын үүднээс харилцах аргагүй

байлаа. Ингээд Азийн талаархи бодлогын хуучин тогтолцоо эвдэх бэлтгэл хийсээр 1988 он хүрчээ. Эндээс эхлэн аажмаар буулт хийж эхэллээ. Афганистан, Зөвлөлт-Хятадын харилцаа, Энэтхэг-хятадын хойгт олон жил ягштал баримталж байсан гэжүүд бодлогоосоо ухарлаа. Азид АНУ-тай хамтран ажиллах нүх сүв эрэлхийлэв. Даан ч хол байлаа. Эдийн засгийн хэлхээ холбооны тухай уриа тунхагийн шинжтэй юм ярьж баахан цаг алдав. Энэ талаар ярьсан нь их, бүтсэн нь бага. Тэгэхдээ санаачилга авах нөхцөл бүрдүүлж өгөөд Горбачев өөрөө огцорсон юм. Бодлогоо хэрэгжүүлж амжаагүй, эхлүүлсэн зүйлийнхээ үр дүнг үзэж чадаагүй үедээ ЗХУ тарлаа.

7. Оросын Холбооны Улс ЗХУ-ыг Азид орлох бодлого явуулж эхэлсэн 1992 оноос сүүлчийн үе эхлэнэ. Орлож чадсан эсэх тухайд ч эргэж бодох асуудал. Жишээ нь ЗХУ Дундад Дорнод, Афганистанд эрх ашгаа ямар нэг хэмжээгээр хамгаалж байсан. Гэтэл өнөөдөр Орос ингэж чадахгүй байна. Зөвлөлт - Японы харилцаа сайжрах төлөвтэй байсан бол Орос-Японы харилцаа түүний хэмжээнд хүрэхгүй байна. Солонгосын хойг, Зүүн өмнөд Ази, Энэтхэгт Орос хэр үр дүнтэй хамтран ажиллаж байна вэ гэвэл үр дүн тодорхойгүй. Гэтэл Горбачев ямар нэг байдлаар сэдэж хөөцөлдөж байсан юм бий. Гэх мэт харьцуулалт хийвэл ярих юм бишгүй байна.

Өнөөдөр Орост Ази-Номхон далайн бодлого илт үгүйлэг- дэж байгаа бөгөөд түүнийг боловсруулж хэрэгжүүлэх талаар тун хойрго ажиллаж байна. Тэгэхдээ үүний төлөө ганц Ельцин, Черномырдин хоёрыг буруутгаж болохгүй. Ерөөсөө Орос гэж хэн бэ? Өрнөд үү, дорнод уу? гэдгээ ч одоо болтол эцэслэн тогтоож чадаагүй байна. Биеэ биетэйгээ эсрэгцсэн олон пирамид (өндөрлөг) дор дороо амбиц (хэт дээгүүр санаархал) дэвшүүлж, түүндээ хөтлөгдөн гадаад бодлогоо үймүүлсээр өнөө хүрчээ. Түрүүчийн Ардын депутатуудын их хурал, Дээд Зөвлөл энд том алдаа гаргасан гэж үздэг. Одоо БХЯ, ГЯЯ, Парламент, түүний хоёр танхим, бүс нутгийн засаг захиргаа бүгд л амбицдаа хөтлөгдөж байна. Тэр ч бүү хэл ерөнхийлөгчийн гадаадад айлчлахдаа гарын үсэг зурахаар авч явсан баримт бичгийн төслийг засгийн газар мэдэхгүй, хариуцахгүй байх явдал ч тохиолдсон. Жишээ нь 1992 онд Ельциний БНСУ-д айлчлах үед гарын үсэг зурсан 23 том төслийн хувь заяа ийм байдлаар дуусчээ. Одоо Орост Өмнөд Солонгосын сонирхол уначихаад байна. Энэ мэт бүтэлгүйтэлээс болоод Ази дахь хөршүүд нь Орост маш итгэлгүй хандаж байна.

Зөвлөлтийн орон зайг хэн бөглөх вэ?

Дээр бичсэнээс урьдын ЗХУ Азид ямар нэг байр суурь нөлөөтэй байжээ, харин Орос түүний халааг авч, тэр дайтай ажиллаж чадахгүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор. Ямар ч

атугай ЗХУ задарснаар энэ өргөн уудам бүс нутагт тодорхой хэмжээний хий орон зай (ваакум) гарсан юм. Тэр орон зайг хэн нэг нь бөглөж таарна.

Ер нь Ази бол Европоос их ялгаатай тив. Энэ тивд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын байгууллага шиг тивийн хэмжээний бүтэц бий болгох боломж байхгүй, хэзээ ч бий болохгүй гээд таамаглачихад болох байх. Тэгэхээр тэр ялгараад байгаа ялгаа онцлогийг эхлэн авч үзье. Азийн улс орнуудыг ангилан авч үздэг хэд хэдэн янзын ангилал байдаг. Тухайлбал, эдийн засагчид Зүүн Азийг: (Ази-Номхон далайн бүс нутагыг):

- 1) Өндөр хөгжсөн Япон;
 - 2) Азийн барууд;
 - 3) Зүүн өмнөд Азийн шинээр аж үйлдвэржиж буй орнууд;
 - 4) Австрали, Шинэ Зеланд мэтийн ямагт дунд зиндаанд явдаг уламжлалт аж үйлдвэржсэн орнууд
- гэсэн 4 ангилал хийдэг.

Улс төр, цэрэг-стратегийн талаасаа Хятад Азид дээгүүр орох бөгөөд Энэтхэгийг мөн хааш нь оруулах тухайд маргаан бий. Шашин шүтлэгийн хувьд Ази нь бүр ч эрээвэр хураавар ангилалд багтана. Лалын шашинг орнууд энд нэг бүлэг болно. Бусдын нь шашнаар харгалзан ангилж болохгүй. Ядуу буурай, байгалийн эрхшээлд байдаг орон энд олон бий. Хүн амын хэт их өсөлт Азийнхнийг ялангуяа Зүүн Ази, Өмнөд Азийнхныг маш их түгшээж байна.

Хамгийн сүүлийн жишгээр, Азийн нутаг дэвсгэрийг доорхи байдлаар ангилсан байх юм. Тэгэхдээ энд тив-газар зүйн талаас нь явцууралгүй улс төрийн хүчин зүйлийг нь харгалзжээ. Үүнд:

- 1) Европ гэдэг ангилалд Уралын нуруунаас Камчатка хүртэл нутаг оржээ.
- 2) Лалын ертөнц гэдэгт Пакистанаас Марокко хамрах бөгөөд Газар дундын тэнгис хүртэл Азийн хэсэг энд орсон байна.
- 3) Зүүн хойд Азид Амар мөрнөөс Гималайн уулс орж байна. Монгол энд орох нь гарцаагүй.
- 4) Өмнөд Азид Кашмираас Шри-Ланк хүртэл нутаг хамрагдаж байна.
- 5) Эх газрын эргийн дагуухи Ази гэдэгт Япон, Солонгосын хойг, зүүн өмнөд Ази оржээ. Энэ бол нэлээд оновчтой ангилал байж болох юм.

Нэрлэж туй сэдвийн дагууд авч үзвэл ТУХН энд хаана ямар өмнөд орнох вэ? ЗХУ нэгдмэл байх үед зөвхөн улс төр-нийгмийн өмнөд орноор л үүнийг авч үзэхээс өөр аргагүй байсан. Гэтэл бүтэрснээ дараа олон улсын харилцааны олон туйл үүслээ. ТУХН дээрхи 5 шигшлэйн эхний хоёрт хуваагдан орох болов. Дундад Азийн 5 улс, Азербайжан бол лалын ертөнцийн салшгүй хэсэг. Гэтэл Орос түүнийг гол болгож үздэггүй. Орос өөрөө Евразийн

гүрэн. Гэтэл энэ ангиллаар бол Европт илүү харъяалагдана. Хуучин тодорхой байр эзэлж байсан ЗХУ-ын орон зайг Орос, Дундад Азиас Казахстан хоёр л өнөөдөртөө бөглөх чадалтай юм. Туркменистаны хувьд байгалийн баялаг, шатдаг хийн нөөц нь тус орныг эрхбиш тодорхой зай эзлүүлнэ. Бусад нь бүс нутагтаа нөлөөлөх, ядаж өөрийгөө бие даан авч явах ямар ч боломжгүй байна.

Ийм онгорхой цоорхой алаг цоог байдал нь сайн муу (зэрэг, сөрөг) хоёр талтай. Сайн тал нь гэвэл ийм сул дорой байдлыг нь ашиглан бүс нутагт Зөвлөлтийн орон зайг хэн нэг нь эзлэн авах боломжтой. ТУХН-ын хувьд Орос нь толгой мэдэн бусдадаа бодлогоо тулгаж байх нөхцөл бүрдэнэ. Муу тал нь гэвэл зай гарсан сул орон зайд олон улсын харилцаа хяналтаас гарах, лалын шашны нөлөө бэхжих, фундаментализм газар авах, цөмийн зэвсгээр хөөцөлдөх зэрэг сөрөг үзэгдэл гарч ирэх явдал. Сайн, муу энэ хоёр талыг зохицуулж тэнцүүлж байх үүрэг хэн хүлээх вэ? Энэ бол АНУ-д ногдсон шинэ үүрэг. Энэ тухай дараа өгүүлнэ.

"Евразинизм"

ТУХН дотор Азид хамгийн их нөлөөтэй байгаа орон ОХУ-ын хувьд "Евразинизм" ("Eurasianism") гэгч шинэ бодлого Азид явуулах бүс нутгийн стратегийн бодлогын үндэс болж мэдэхээр байна. Энэ бол олон улсын харилцаанд цоо шинээр гарч ирсэн нэр томъёо биш. Хаант Орос, дараа нь Зөвлөлт Орос, ЗХУ-аас явуулж ирсэн геополитикийн үргэлжлэл. Түүний зорилго нь Азийн өргөн уудам нутагт тус орны нөлөө, байр суурийг бэхжүүлэх, нөлөөний хүрээг хадгалах, ашиг сонирхлыг нь хам- гаалж байх явдал байсан, одоо дэвшүлж буй "Неоевразинизм" энэ л зорилгыг агуулж байна. Харин Оросын төрийн гадаад бодлогын хүрээнд ийм нэр томъёо хэрэглэхгүй байгаа. Гэхдээ явуулж буй бодлогод нь ажиглагдаж байна. Оросын улс төрийн хүчнүүд энэ асуудлаар хоорондоо ноцтой санал зөрдөггүй. Парламентад суудалтай улс төрийн бүх нам Евразийг хамарсан геостратегийн бодлого явуулахыг чухалчилж байна. "Евразиниз- мын" шинэ хувилбар дэвшигдэн гарч ирсэнд гайхах юм алга. Аль ч их гүрэнд геостратегийн бодлого хэрэгтэй. Нөгөө талаасаа үүнийг Оросын өөрийнх нь дотоод нөхцөл байдал тулгасан юм. Оросын нийгмийг хямралаас хэрхэн гаргах арга зам, хэлбэрийн тухай маргаан өнөөг хүртэл үргэжилж байна. Үнэмлэхүй зөв хувилбарыг хэн ч олж тогтоогоогүй. Ийм маргаан мэтгэлцээний явцад "Неоевразийн" номлол дэвшүүлж байна. Ер нь Оросын улс төрийн амьдралыг ажиглахад хямралаас гарах (геостратегийн талаас нь авч үзвэл) 3 хувилбар. (3 янзын туйлшрал ч гэж хэлж болно) ажиглагддаг. Тэр нь:

1) Өрнөдтэй бүх талаар гүн гүнзгий интеграцчилах;

- 2) Европ хэзээ мөнхөд Оросын дайсан байсан, хойшид ч байх болно, тийм учраас Азид (юуны өмнө Хятадад) түшиглэн Европтой ширүүн тэмцэл хийх;
- 3) Европ-Азийн хооронд "синтезийн" үүрэг гүйцэтгэх, энэ хоёр тивийг холбох гагнаас, гүүр болох тухай хувилбар юм

Гэвч энэ талаар тогтчихсон, нэг мөр болчихсон цэгц үзэл баримтлал байхгүй. Тэгээд ч энэ асуудлыг саяхнаас, ердөө 1992 оноос эхлэн тавьж тойрон маргаж байна.

Оросын улс төрчид, эрдэмтдийн үзэл бодлыг ажваас тэд "Евразийн" үзлээ эдийн засгийн, улс төр-олон улсын гэсэн хоёр чиглэлээр авч үзэж байгаа бололтой. Орос оронд өрнөж буй эдийн засгийн реформыг амжилттай хэрэгжүүлэх, үр ашигтай зах зээлийн эдийн засаг бий болгох, түүндээ өрнөдийн зах зээлийн шилдэг тэргүүний арга туршлагыг өөрийн онцлогтоо (газар зүйн их орон зай, орон нутгийн онцлог) тохируулан нэвтрүүлэх, улмаар энэ их орон зайгаа Европ, Ази, Америк 3 тивийн хооронд худалдаа-эдийн засаг, тээвэр хөгжүүлэх судас болгох явдал эдийн засгийн чиглэлд оржээ. Дорнод Европ, Өрнөд Европ, Зүүн Азийг нэгдмэл нэг соёл иргэншилд нэгтгэсэн "Евразийн нийгмийн орон зайн" тухай үзэл энд бас орно. Энэ маань ингэхэд хэр бодитой, биелэх үндэстэй (жишээ нь Хятад, Франц хоёрыг нэг соёл иргэншилд холбох) вэ? Энэ мэт үндэсгүй, тунхаг шинжтэй олон асуудал энд тусгагдсан байгаа. "Евразийн эдийн засгийн орон зай бий болгох" анхны алхам болгож Түмэн голын сав газрыг ашиглах төслийг тойрон хэдэн жил үр дүнгүй маргалаа. Үүнээс өөр олон улсын шинжтэй алхам хийгээгүй байна.

"Евразийн" улс төр-олон улсын чиглэлд ярьж хэлж, төлөвлөж буй юм их бий. Гэвч М.С.Горбачевын Владивосток, Красноярскийн саналуудыг орлох дорвитой үг хэлээгүй байна. Горбачев санаачилга авах зорилгоор дайчин давшингүй байр суурь (алдаатай ч гэсэн) баримталж байсан бол өнөөгийн ОХУ-ын удирдлага хярсан, болгоомжилсон, зарим талаар мухардмал гэмээр байр суурьтай байна. Хаант Оросын үед Азийг Европын христосын соёл иргэншилд учрах гол аюул занал мэтээр төсөөлдөг байсан. 100 жилийн тэртээх тэр битүү сэжиг өнөөгийн Орост ч байх шиг санагддаг. Тэгэхдээ энэ бол үндэсгүй зүйл биш. Хятад дахь асар их ажиллах хүчин, Японы тэргүүний технологийг хослуулбал Азид энэ хоёрыг дийлэх ямар ч хүч байхгүй болно. Гарч ирэх магадлал юу л бол. Урьд Зөвлөлт нь цэрэг-стратегийн давуу байдлаа ашиглан Азид улс төрийн нөлөөний хүрээтэй байсан. Эдийн засгийн сул талыг нь тэр хүчин зүйл нөхөж байсан гэсэн үг. Гэтэл өнөөгийн Орост улс төрийн ч, эдийн засгийн ч давуу байдал тогтоох боломж алга.

Нөгөө талаас Азийн хоёр том гүрэн Хятад, Япон хоёр, шинээр аж үйлдвэржиж буй орнууд хөгжлийнхөө жамыг дагалдан түүхий эдийн хямралд орж эхэлж байна. Энэ утгаар авч үзвэл хүн ам

Цөөн байгалийн баялаг, түүхий эдийн нөөцөө хангалттай ашиглаж чаддаггүй байгаа Сибирь, Монгол (зарим талаар Австрали, түүнчлэн өмнөд Азийн зарим хэсэг) аяндаа анхаарлыг төвд орно. Энэ аятаар тусгайлан авч үзье. Хятадын хувьд Ало Дорнодын талаар аж явдал дараахи хүчин зүйлээр нөхцөлдсөн. Үүнд:

1. Энэ гарсны дараа Хятадын эдийн засаг-улс төрийн нөхцөл байдал нэмэгдсэн;
2. Хятад, Японы хөгжлийн эрч далайцыг дагалдан эдийн засгийн хувьд АНУ энэ бүс нутгаас аажмаар шахагдан гарч буй.
3. Оросын Сибирь, Ало Дорнодын төвөөс зайлах хүч үйлчилж, биецнэх хандлага газар авсан зэргийг тооцож үзэж болох юм.

Ийм нөхцөлд Хятадын өсөн нэмэгдэж буй далд нөлөөний өмнө, нутаг дэвсгэрийн маргаанаас үүдэн Орос өнөө хүртэл өмнөд хүйтэн хандаж буй Японы бодлогын улмаас Орос нь ажиллаж ирсэн (Хятадад буулт хийсэн) бодлого явуулахаас өөр аргагүй. Гэхдээ л эргэж нэвтрэх арга зам сүвэгчилж идэвхтэй дипломат эрэлхийлэл хийсээр байгааг мартаж болохгүй. Үүнтэй уялдан Евразийн холбооны тухай Казахстаны санал анхаарлын таван дахин өрөв бололтой. 1995 оны нэгдүгээр сард Москвад Орос, Казахстаны дээд хэмжээний уулзалт болох үед гарын үсэг зурсан 17 баримт бичиг бүгд энэ үзэл санааны үндсэн дээр хийгдсэн гэж Н.Дарбаев үзэж байгаа. Орос анхандаа энэ үзэл санааг ойшоохгүй байснаас сүүл рүүгээ хоёр талын үндсэн дээр хүлээн авсан бөгөөд ТҮХН-ийг Евразийн холбоо болгож өөрчлөхийг бусдадаа уриалан дуудаж байна. Тэгэхдээ нэр солихоос гадна агуулгыг нь өөрчилж, гэрэндээ тохирсон холбоо болгохын тулд асар их ажил хийх ёстой. Үүнийг цаг хугацаа харуулах бизээ.

"Евразийн" үзэл санааг Орос улс төрийн бүх хүчнүүд дэмжин байлааж байгааг дурдсан. Үнэндээ ч олон үеийн турш нийгмийн хамгийн тэргүүний анги давхрага хэсгийнхний үзэл бодол болж ирсний хувьд ийм байхаас аргагүй. Тэгэх тусмаа өнөөдөр Оросын хэт үндсэрхэг, хуучинсаг коммунист большевик хүчний хувьд энэ бодлого Ази дахь гадаад улс төрийн бодлогын цөм болоо юу галтэй. Жишээ болгон мөнөөх Жириновскийг авч үзье. Түүний болчимгүй мэдэгдэл Азийнхныг мөн нэгэн адил цочроосныг хэлмээр байна. Түүний гадаад бодлогод баримталдаг "өмнө зүг тэмүүлэх" номлолд Азийн асуудал хамгийн их зай эзэлдэг. Тэрээр номдоо: "... Нөлөөллийн хүрээг хуваарилахдаа хойноос урагшаа гэсэн зарчим баримтлах нь зүйтэй. Япон, Хятад хоёр доошоо. Зүүн өмнөд Ази руу, Филиппин, Малайз, Индонез, Австралийг, Орос урагшаа; Афганистан, Иран, Туркийг, Өрнөд Европ урагшаа; Африк тивийг, Канад, АНУ хоёр урагшаа, Латин Америкийг гэж хуваах юм бол хэнийгээ ч гомдоохгүй тэнцүү болно" гэж томъёолжээ.

Жириновский энэ томъёоллоо "Орос орны тавилан, үйлийн үр", үүнийг хийхээс өөр аргагүй, энэ бол их геополитик, үүнийг Оросын хөгжил шаардаж байна гэж үздэг. "Кабулаас Стамбул хүртэл, Энэтхэгийн далайгаас Хойд мөсөн мөсөн далай хүртэл хүний эрх хүн бүхэнд адилхан үйлчилдэг, бүгд Орос улсын иргэн байх юм" гэсэн бас нэг мөр бий. Эндээс үзвэл Оросын хэт үндсэрхэг үзэлтнүүд Азийн бодлогодоо лалын шашинт өмнөд хөршүүдээ илүү их анаж тооцож байгаа бололтой. Жириновскийн хараал зүхлийг Алс Дорнод дахь хөршүүд нь ч их амссан. Японы байнгын зөвлөх болсон "Умард нутгийн асуудлаар" Орост хэн ч буулт хийх хүсэл алга. Ялангуяа үндсэрхэг үзэлт Жириновский эдгээр арлыг буцаан өгөх нь бүү хэл, Японы умард Хоккайдо арлыг авах тухай ярьж, цөмийн зэвсгээр сүрдүүлж, тэнгисийн цэргээр Японыг арал дээр нь бүслэх тухай сэдэж байгаагаа нуугаагүй. Ганцхан Хятад, Умард Солонгос хоёр энэ хүнд арай өөрөөр ойлгогдов бололтой. Харин ардчилсан Монгол түүний тооцоонд орсон. Үүнийг ноцтой хэмээн үздэггүй хүн Монголд олон байдаг. Монголчууд сэтгэл амарлингуй байгаа явдалд өөрсдөө буруугүй. Гэвч гай таарч, Оросын үндсэрхэг үзлийн аюулд өртөж болохыг би үгүйсгэмгүй байна. Дээр иш татсан Жириновскийн номыг дахин сөхөж үзье.

"... Бидэнд өөр хил хэрэгтэй. Бид нэг бол Номхон далай, Энэтхэгийн далайн эрэгт гарах, эсвэл өмнөд этгээдийг Хятадын цагаан хэрмээр хязгаарлах ёстой байна. ...Ганцхан хувилбар, "Өмнө зүг ухасхийх эцсийн дайралт" гэсэн байлдааны ажиллагаа хийх л үлдлээ.

"... Хятадын эсрэг дайн зарлахыг зориглох хүн олдох болов уу даа, гэтэл Монгол ч юмуу, Түвдийн эсрэг бол зүрхлэнэ дээ"

Энэ хоёр мөр Оросын улс төрийн нөлөө бүхий хүчний, цаашлаад Ельциний реформд унаж доройтож яваа түг түмэн жирийн орос иргэдийн санаа бодлын тусгал гэж би ойлгож байна. Нөгөө талаас бараг бий болсон цагаасаа геополитикийн санаархал хэрэгжүүлж ирсэн их Оросын дээрэнгүй үндсэрхэг үзлийн нэг хувилбар гэж үзэж байна. Одоохондоо албан ёсны гадаад бодлого болоогүй ч (Ерөнхийлөгчийн дараагийн сонгууль шийднэ) түүний эд эс ямар нэг байдлаар цухалзсаар л ирсэн шүү дээ. Үүнийг номынхоо багахан зайд зориуд оруулсныг минь уншигчид болгооно уу.

Лалын фундаментализм

Энэ бол газар зүйн хувьд асар уудам нутгийг (Пакистанаас Марокко хүртэл) хамарч ярих асуудал. Гэхдээ би энд ЗСБНХУ-ын задралаар нөхцөлдсөн, өнөөдөр Дундад Ази, Дундад Дорнод хавьд газар авч буй тэр асуудлыг авч үзнэ. Нэгдмэл Зөвлөлтийн үеийн Дундад Ази, ТУХН-ийн үеийн Дундад Азийг эхлээд харьцуулж үзье. Энэ хавийн газрыг Москва-Мекка хоёрын дунд

хавчуулагдсан цөөнхи үндэстний нутаг гэж америкийн нэгэн сэтгүүлд бичсэнийг санаж байна. Миний бодоход онож хэлсэн нэр болов уу. Мекка гэдэг нь лалын мөргөлтнүүдийн ариун шүтээн орших газар, Саудын Аравт бий.

Урьд албан ёсны шашингүй байсан ЗСБНХУ-ын нэг хэсэгт (ухаандаа Дундад Ази) лалын шашинтан гэсэн нэр зүүх нь зохисгүй байсан хэдий ч өргөн утгаар нь тэднийг ингэж нэрлэхээс өөр аргагүй байсан юм. Яагаад гэвэл тэд өнө удаан жил өөрсдийгөө "Аугаа их Уммын тасархай" гэж үзэж ирсэн. Гэвч үндэс угсаагаа, шашнаа гэсэн аливаа илрэлийг коммунист суртал дарсаар торгоосоор байлаа. Зөвлөлтийн өмнөд хилтэй залгаа олон зуун сая хүнтэй лалын орнууд оршдог нь цөмийн дайны аюулаас илүү сэтгэлийн зовлон болж байсан. Иран дахь лалын хувьсгал (1979 он) бүс нутгаас Зөвлөлтийн гол өрсөлдөгч АНУ-ыг шахан гаргасан боловч оронд нь лалын хэт даврах фундаментализмыг бэхжүүлснээрээ ноцтой аюулын голомт бий болгожээ. Афганистанд Зөвлөлтийн цэргийг оруулахдаа тэр орны хувьсгалын үйл хэргийг дэмжихээс гадна тус орныг тусгаарлах (лалын шашны нөлөөг нэвтрүүлэхгүй байх) бодлого давхар гооцоолсон. Энэ мэт лалын шашны нөлөөнөөс сэргийлэх түүхэн шалтгаан олон бий.

Яг ийм шалтгаанаас үүдсэн маргаан ид өрнөж байх явцад нэгдмэл энэ гүрэн задран салсан. Афганистаны дайны хор хөнөөлийг арилгах, энэ дайнаас болж лалын ертөнц, олон улсын хамтын нийгэмлэгт унасан нэр хүндээ сэргээх, дотооддоо Дундад Ази, Кавказад газар аваад байсан шашин-үндэстэн, омог аймгийн мөргөлдөөн, газар нутгийн маргааныг зохицуулах эхлэлийн шатанд ЗХУ тарсан билээ. Гэхдээ асуудлыг шийдэх ямар нэг найдвар сул, бугшсан асуудал зарим газар чинээндээ тулсан яг тэр үед ингэж тарсан. Тэртээ тэргүй нурж унасан коммунист догматик үзэл, түүний суурин дээр тэнцэж ядан гарч ирсэн ардчилал хоёр үндсэрхэг, шашны хэт даварсан үзлийн өмнө хүчгүйтсэн нь мэдээж. Дундад Ази, Кавказад Горбачевын өөрчлөн байгуулалт, ил тодын байдлын гэрэл гэгээ хамгийн бүүдгэр туссан бөгөөд зөвхөн нам, төрийн дээд аппарат, үзэл суртал-хэвлэлээр шуугиад өнгөрсөн билээ. Энэ бүс нутагт ардчиллын үрийг суулгаж чадаагүй буюу суулгасан нь удаан насалсангүй. Ийм л газар бүс нутгийн түгшүүртэй байдлын голомтууд буглаж эхэлсэн юм. Хурц хэсэг нь удалгүй илрэв. Үүнд Тажикистаныг жишээ болгож болох юм. Энэ бол ТУХН-ийн дотоодын асуудал. Гэтэл гаднаас учрах уршиг түгших хэмжээнд хүргэж байна. Урьд нь нэгдмэл Зөвлөлт гүрний үед шашны бодлогоо далд хэлбэрээр ч явуулж чаддаггүй байсан орнууд ил хэлбэрээр явуулах болж, түүнд үндэс-угсаа, хэл-соёл, эдийн засгийн хөшүүрэг зэрэг аль байдаг боломжийг ашиглах болов.

Нэгдмэл гүрэн задарснаас түүнийг залгамжлагч ТУХН-ийн орнууд бүс нутагт жиндээ тохирсон байр эзэлж амжаагүй. Орос

эндхийн үйл хэргээс хол байгаа зэргийг харгалзан бүс нутгийн орнууд гадаад бодлогоо зохицуулж байна. Энд Афганистан (бүр хэт даварсан хэлбэрээр), Иран (лалын фундаментализм), Турк (андуу атлаа буурьтай хэлбэрээр) гол байр эзэлнэ. Туркээс эхлэн баримтаар ярьж

Турк бол улс төр-эдийн засгийн хувьд Өрнөд Европын салшгүй нэг хэсэг. Гэтэл ТУХН бий болсноор түүний гадаад бодлогод шинэ маргийн "Остполитик" хэрэгжиж эхлэв. Энэ нь Дундад Азийн тусгаар тогтносон 5 улс, Азербайжан руу чиглэсэн бүс нутгийн шинжтэй бодлого юм. Өрнөдийг баримт жаалсан Туркийн бодлогод алдаа эндэгдэл мэр сэр буйг дээр цухас дурдсан. Тэр алдааг одоо шинээр дэвшүүлж буй "Остполитик" нөхөх учиртай. Бас Туркээс хөрш орнуудтай тогтоосон харилцаанд үлгэр дууриал үзүүлэх зорилго агуулсан байж болох талтай. Жишээ нь Курдистаны ажилчны намын удирдсан зөвсөгт босогчидтой Турк өөрөө удтал тэмцэж, цус урсгаж, хүний эрх зөрчиж байгаа. Курдын асуудал Сири, Иран, Иракт адил хамаарна. Туркчууд курдын асуудлаа Нагорно-Карабах, Боснийтой адилтгаж мөн л ноцтой хэмжээнд авч үздэг.

"Хүйтэн дайн" дууссанаас хойш Балканд хойг Туркод нээгдсэн шинэхэн бүс нутаг. Ийшээ нөвтрөх нүх сүв гэнэт нээгдсэн боловч Туркийн гол анхаарал өнөөдөр Боснийн лалын шашинт хүн ам дээр төвлөрөөд байна. Турк нь "Остполитик" гэгчдээ ялгавартай хандаж, Дундад Азийнхныг дотор нь зааглаж байна. Жишээ нь Тажикистан хэл-соёл, шашны урсгалын хувьд Иран, Афганистанд илүү ойр. Гэтэл үлдсэн 4 улс турк хэлтэн, угсаа язгуур нэг. Азербайжан мөн энэ ангилалд орно. Тийм учраас 5 улсад нэг янзаар, нэг улсад өөр нэг янзаар хандах байдал ажиглагдсан. Жин нөлөөгөөр нь авч үзвэл улс төрийн талаасаа Азербайжан нь Туркийн хамгийн чухал түнш, Казахстан, Туркменстан хоёр эдийн засаг худалдааны талаасаа чухал түнш, Тажикистан аль ч талаасаа чухал биш түнш гэсэн ангилал хийж байна. Эдийн засаг-худалдааны харилцаа, зээл тусламж бүгд л энэ ангилалаар хэмжигдэж байна. Орос-Хятадын хооронд оршдог, Цөмийн зэвсгийн статустай, байгалийн их баялагтай Казахстаныг дайнд нэрвэгдсэн, тогтворгүй, сул дорой Тажикистангаас ялгаж үзэх нь юуны буруу байх билээ.

Төгвөл **Ираныг** Турктэй адилтган авч үзэж болохгүй. Иран бол ТУХН-тэй холбогдох олон шалтгаантай. Түүхэн талаасаа ч, үндэстний талаасаа ч Иран, Азербайжан хоёр нэг үндэстэнд харьяалагдана. Азербайжан гэдэг нь Ираны хэсэг мужийн түүхэн нэр. Ираны янз бүрийн эх сурвалжаас үзвэл, одоо Иранд 20 орчим сая азербайжан хүн байна. Анхлан Азербайжан нь баруун (Урмия нийслэлтэй), зүүн (Тебриз нийслэлтэй) гэж хоёр хуваагдсан.

Умард, өмнөд гэдэг ангилал Зөвлөлт засгийн үед бий болсон. Умард гэдэг нь ЗСБНАзербУ-ыг, өмнөд гэдэг нь Ираны умардын хоёр мужийг нэрлэсэн хэрэг. ТУХН-Ираны өнөөгийн 2500 км урт хил өнгөрсөн зуунд Орос-Ираны хооронд болсон дайны дүнд тогтсон бөгөөд Азербайжаныг салгасан буруутныг хайя гэвэл Хаант Оросыг нэрлэдэг.

Зөвлөлт засгийн үед Зөвлөлт-Ираны харилцаа хэвийн хөгжсөн. Хил хязгаар нь хамгийн тайван гэж тооцогддог байлаа. 1979 онд Иранд лалын хувьсгал ялсны дараа хоёр орны харилцаа хүйтэрсэн. Учир нь Ираны лалын хувьсгалын удирдагчид Ойрхи болон Дундад Дорнодоор лалын хувьсгалаа экспортлох зорилго тавьж, улмаар хөрш Ирактай дайтсан юм. Шашны ёсонд нь харшлах сурталтай ЗХУ Ираны дайсны тоонд зүй ёсоор орж байв. Афганистанд Зөвлөлтийн цэрэг орсны дараа Иран нь Зөвлөлтөд үхлийн ял оноосон лалын цорын ганц орон болов. Удтал ийм харилцаатай байсны эцэст Ираны лалын хувьсгалын удирдагч Хомейни нас нөгчиж, харилцаа аажмаар хэвийн болжээ. Гэтэл харилцаа бүрэн хэвийн болж амжаагүй байтал социализм сүйрэв. Энэ сүйрлээр учирсан хямралаас гарах цорын ганц зөв зам бол лалын хөгжлийн зам сонгох явдал гэж Иран номлож байлаа.

Үүнтэй уялдан Ираны лалын хувьсгалын стратегид хуучин Зөвлөлтийн лалын шашинт улсууд байр эзэлсэн юм. Ингэж анхаарал тавихад ч Азербайжанд өрнөсөн үйл явдал зүй ёсоор нөлөөлсөн билээ. 1989-1990 оны зааг дээр Нахичеваниас Иран руу дүрвэн гарах гэсэн ородлого гарч, тэр нь эмх замбраагүй байдалд хүргэсэн. Тэр үед Бакуд Ардын фронтын зохион байгуулсан цуглаанууд дээр Ирантай залгаа хилээ нээх, умард өмнөд хоёр Азербайжаныг нэгтгэх шаардлага дэвшүүлж улмаар хүн амын зохих хэсгийн дэмжлэг хүлээсэн юм. Арментэй хийсэн зэвсэгт мөргөлдөөн газар нутаг, мөн лалын шашнаа хамгаалах уриан дор явагдсан. Энэ бүхнийг Иран зүгээр ажиглан суусангүй. Юуны өмнө лалын фундаментализмын стратегидаа эдгээр бүс нутгийг багтаах ёстой. Дундад Ази ч үүний гадна үлдэх ёсгүй. ТУХН үүссэний дараа Ираны лалын ариун дайны (жихад) шинэ номлол бүхэнд ил боллоо. Энэ номлолын дагуу нэг том тойрогт багтах лалын эвсэл бий болох ажээ. Эхний жижиг тойрогт Ойрхи Дорнод, Дундад Ази, түүний гадуур хүрээлэх дунд тойрогт Умард Африк, Өмнөд Ази, гурав дахь том тойрогт Зүүн Ази, лалын үлдсэн бүх ертөнц оржээ. Өөрөөр хэлбэл, Ираны хувьд ТУХН дэх лалын орнууд эхний тэгэхдээ бүр тэргүүлэх байр эзлэв. Гэвч энэ бол одоохондоо хэрэгжээгүй байгаа зүйл. Иран нь Турк шиг эдийн засаг-худалдааны идэвхтэй хамтын ажиллагаа тогтоогоогүй (энд Туркменстаныг эс тооцвол) байна. Азербайжан ах дүүсээ авран хамгаалах талаар ч дорвитой дэмжлэг үзүүлээгүй. Гэхдээ энэ бол яарах зүйл биш гэж Иран үзсэн бололтой.

ТУХН-тай тогтоосон харилцаанд юуг чухалчлах вэ? гэдэг дээр Ираны тал ганцхан зэвсгийн наймааг л тэргүүнд авч үзэж байна. Нэгдмэл зэвсэгт хүчнээс хэдэн тийшээ хяналтгүй тархсан зэр зэвсэг, цэргийн технологи, нэгдмэл хяналтаас гарсан цөмийн болон стратегийн зэвсэг Ираны анхаарлыг зүй ёсоор татсан юм. Ирактай хийсэн олон жилийн дайнд ихэд суларсан, тэнгисийн эргийн талаас АНУ-ын шахалт хавчилтад орсон, мөн Ирак-Кувейтын дайнаас сургамж авсан зэрэг олон шалтгаанаар Иран зэвсгийн эрэлд гараад байна. Ханган нийлүүлэгчийн тоонд Орос, Казахстан, Хятад, БНАСАУ тэргүүн байрт орж байна. Ялангуяа эдийн засгийн хямралд орж, өрөнд баригдсан Орос орон Иранд нууж хаах юмгүй болжээ. Оросын цэргийн үйлдвэрүүдийг иргэний зориулалттай болгож өөрчлөх нь амаргүй зорилт төдийгүй эргээд ашгаа нөхөхгүй учраас бүтээгдэхүүн нийг нь бэлнээр зарж борлуулахаас өөр зөв арга байхгүй бололтой. Одоо цөмийн эрчим хүчний салбарт Орос-Ираны хооронд тогтоогоод байгаа хамтын ажигллагаа ихээхэн сэжиг төрүүлж байна. Ираны тал Оросын тусламжаар атомын цахилгаан станц барьж байгаагаа "Улс төрийн том ялалт" гэж мэдэгдэж байгаа нь ингэж сэжиглэх нэг шалтгаан болж байна.

Афганистан бол Турк, Иран хоёроос бүр ч этгээд байр суурь баримталдаг. Энэ орны дотоодын мөргөлдөөний тухай хожим өгүүлэх тул энд их юм бичихгүй. Афганистан нь Тажикистанд иргэний дайн дэгдэх хүртэл ТУХН-ийн дотоод хэргийг анхаардаггүй байсан улс. Гэтэл одоо Тажикистанаас давж, бүр Оросын гүн рүү орж ирсэн нь Чеченийн хэрэг явдлаар харагдсан. Афганистанд засгийн эрхийн төлөө шашны хэт даврагч бүлгүүдийн тэмцэл, үндэстэн ястны зерчил туйлдаа хүртэл хурцадсан хэдий ч хөрш Тажикистаныг өдөөн хатгах чадалтайгаа нэг бус харуулав. Тажиктэй гарал үүсэл нэг хэсэг нь үндэс угсаа, шашин шүтлэгээ өмгөөлөн хамгаалах эрхтэй гэж үздэг төдийгүй урьдын өс хонзонгоо мартаж чадахгүй байна. Зөвлөлтийн цэрэг тэнд арваад жил байлдахдаа багагүй хэмжээний үхэл хагацал, гай гамшиг тарьсны хор одоо Тажикистаны хил дээр гарч байгаа бололтой. Тажик-афганы мужахедууд ар талаасаа хүчтэй дэмжүүлэн хилийн энэ дайныг үргэлжлүүлсээр байна. Харин хэдий хугацаагаар үргэлжлэх, хэрхэн төгсөхийг тааж хэлэхэд эртдэх бизээ.

Аюулгүй байдал

ЗХУ задарч, ТУХН үүссэнээр түүнтэй хил залгаа нутагт аюулгүй байдлын шинэ орчин бүрэлдэж байна. Тэгэхдээ ингэж бүрэлдэх үйл явц эхлэлийн шатандаа, нэг орчноос нөгөө орчинд шилжих шатандаа байгаа бололтой. Энэ асуудлыг нэг мөр болгож дүгнэж цэгнэх нь эртдэнэ. Учир нь ТУХН, ялангуяа Оросын дотоодын нөхцөл байдал ингэж дүгнэх боломж өгөхгүй байгаа

төдийгүй ихээхэн асуудлыг шийдэх түлхүүр болж байна. Тухайлбал, нэгдмэл ЗХУ-ыг бутаргасан салан тусгаарлах, бүрэн эрхт байдлаа тунхаглах үзэгдэл ОХУ-ыг хамрахгүй гэх баталгаа алга. Өмнөх бүлэгт Чечень, Татарстаны жишээн дээр тайлбарласан үйл явц Оросын бусад хэсэгт шууд биш гэхэд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлж байгаа. "Алс Дорнодын", "Тэнгис хавийн", "Амар мөрөн хавийн" улсууд цуван бий болбол Алс Дорнод, Зүүн хойд Азийн бүс нутаг улс төр-олон улсын, эдийн засгийн талаасаа эрс өөрчлөгдөх нь мэдээж. Үүнийг өнөөдөр хэн ч хүсэхгүй, гэвч таамаглаж буй хүн олон бий.

Дундад Азийн хувьд нэгдмэл ЗХУ задарснаар өөрийгөө бие даан хамгаалж чадахгүй олон жижиг улс үүссэн. Ийм нөхцөлд Оросын цэрэг-стратегийн нөлөө энд урьдын адил байх бололтой. Нэгдмэл ЗХУ-ын үед түүний цэргийн аюулаас айж хулгаж байсан. Хятад гадаад бодлогоо идэвхжүүлэх бололцоотой болсон. Бүс нутагт БНХАУ-ын явуулж буй гадаад бодлого хоёр чиглэлтэй байх шиг санагддаг. Тэр нь :

1. Хятадын реформыг хэрэгжүүлэхэд таатай гадаад нөхцөл бүрдүүлэх;
2. Ази, Номхон далайн бүс нутагт хятадын байр суурийг бэхжүүлж, нөлөөг тэлэх явдал юм.

Тийм учраас Орос урьдын Зөвлөлтийн далайцаар эндхийн асуудалд оролцохыг Хятад илт хүсэхгүй. Орос-Хятадын харилцаа хэдий тогтвортой хэвийн байгаа ч хоёр орны (улмаар Дундад Азийн орнуудын) үндэсний эрх ашиг мөргөлдөхгүй гэх баталгаа алга гэж Хятад үзэж байна. Хилийн маргаантай асуудал зохицуулах, цэрэг хорогдуулахад Орос, Казахстан, Кыргызстан, Тажикистантай хамт-ран ажиллаж байгаа боловч Хятадын тал нутаг дэвсгэрийн түүхэн санаархлаасаа татгалзлаа гэж үзвэл том эндүүрэл болох бизээ. Хятадын гадаад бодлогын хоёр дахь чиглэл хэр зэрэг ахицтай байх эсэх нь тус орны цэрэг-стратегийн хүч чадлаас шалтгаална. Ази, Номхон далайн бүс нутагт их гүрнүүдийн оролцоог тогтоон барих арга бол Хятадыг зэвсэглэх, олон сая цэрэг бэлэн байлгаж байх явдал. ЗХУ-ын цэрэг-улс төрийн хуучин нөлөөг түүний залгамжлагчид бүрдүүлж амжаагүй үед Хятад нь батлан хамгаалах хүчнээ бэхжүүлэх зорилт шийдэж байна. Үүнд зэвсгийн наймаа гол байр эзэлнэ. ТУХН-ийн орнуудын эдийн засгийн бэрхшээлийг ийм наймаандаа ашиглан, энэ хэдэн жил багагүй зүйлийг амжуулав. Урьдын Зөвлөлтийн эдийн засгийн үндэс нь цэрэг-аж үйлдвэрийн хүчирхэг хамслууд байсан бөгөөд зах зээлийн чөлөөт харилцаанд шилжих үед түүн шиг тээртэй юм алга. Ийм учраас эдийн засгийн хямралд орсон Орос, Белорусс мэт нь зэвсэг наймаалах замаар хүнд байдлаас гарахыг чухалчилж байна. Ингээд Хятадтай цэргийн салбарт нягт хамтран ажиллахыг дэмжихийн сацуу Хятад бол Зөвлөлтийн гэгдэж байсан орнуудад эдийн засгийн хөгжил дэвшлийн үлгэр дууриал гэж үзэх болов

Хятад нь цэргийн хамтын ажиллагааны салбарт ТУХН-ийн томхон түнш юм. Жишээ нь Белоруссын ерөнхийлөгч А.Лукашенко 1995 оны эхээр БНХАУ-д айлчлахдаа 12 сая долларын цэргийн хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Эдгээр баримт бичигт зааснаар, Белорусс нь зэвсэглэл, хиймэл дагуул, сансар судлалын дуран авай Хятадад өгөх аж. Хятад нь тус орны хувьд худалдааны 6 дахь том түнш болсныг үзсэн ч хамтын ажиллагааны цар хүрээ хэр байгаа нь илт.

Алс Дорнодод Орос, Хятад, Япон, АНУ-ын үндэсний эрх ашиг нэгэн зэрэг төвлөрч байгаа нь бүс нутгийн цаашдын өрнөл хөгжилд шууд нөлөөлнө. Энэ бүс нутагт цэрэг-улс төрийн эвсэл бүрдүүлэх боломж байхгүй, бүгд л хоёр талын гэрээ хэлэлцээрээр (АНУ-Япон, АНУ-Өмнөд Солонгос гэх мэт) аюулгүй байдлаа батлан дааж байна. Ийм учраас энд Европынх шиг хамтын аюулгүй байдлын тогтолцоо бүрдээгүй.

Европтой харьцуулахад эндхийн улс орнуудын хоорондын харилцаанд нутаг дэвсгэрийн асуудал бишгүй бий. Хятад-Орос, Япон-Орос, Хятад-Япон, Хятад-Умард Солонгос, Өмнөд Солонгос-Япон, хоёр Солонгос, Хятад-Тайванийн харилцааг энд жишээлж болох бөгөөд хэтдээ Монгол-Оросын хооронд хилийн асуудал дэгдэхийг үгүйсгэж болохгүй. Нутаг дэвсгэрийн эдгээр асуудал дотор түүхэн учир шалтгаантай, олон жил бугласан, шийдэх оновчтой хэлбэр олоход бэрх тийм асуудал олон бий. Энэ бол аюулгүй байдалд нөлөөлөх бодит хүчин зүйл гэж үзэж байна.

ЗХУ задарсны дараа анхаарлын төвд орсон шинэ асуудал бол БНАСАУ-ын цөмийн программ юм. Тус орон ийм задралыг хүсээгүй нь мэдээж. Өмнөд Солонгосыг ганцаардуулах гэсэн тэдний санаархал талаар болж, холбоотон байсан бүх орон нь Сеултэй албан ёсны харилцаа тогтоосны дараа БНАСАУ-ын цөмийн асуудал гарч ирсэн нь анхаарал татдаг. Тус орон олон жилийн турш цөмийн нууц судалгаа хийж байсан. Гэтэл тэр нь олон улсын хэмжээний маргаан болж 90-ээд онд сэдэрсэн. Энэ юуных вэ? Энэ бол ЗХУ-ын задралаар бүс нутагт үүссэн хий орон зайг бөглөх давилуун санаархал болов уу. БНАСАУ ийм асуудал дэгдээхгүйгээр ганцаардал мухардлаасаа гарах аргагүй. Ийм асуудлаар түрээ барьж, айлгаж баймааж нь зогсчихоод байгаа Зөвлөлтийн хуучин тусламжийн нөхвөрийг олно. Энэ бол зүй ёсны үзэгдэл.

Аюулгүй байдлын асуудал хөндсөн далимд *Монгол Улсын аюулгүй байдалд холбогдох асуудлыг* товчхон авч үзье. ЗХУ задарсны дараа Алс Дорнодод бүрэлдэн бий болсон шинэ нөхцөл байдал Монгол Улсад ихээхэн хамаатай билээ. Манай улс ийм шинэ нөхцөл байдалд тохируулан гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, цэргийн номлолоо боловсруулсан нь үнэхээр цаг үеэ олсон чухал ажил боллоо. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд зааснаар, манай аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг учруулах аюулын магадлалаар

нь бодит болон болзошгүй гэж ангилсан байгаа. Миний ойлгож байгаагаар ийм болзошгүй магадлал манай умард хөршид бий болоод байна. Чеченийн дайн, Тажикистаны хил орчмын мөргөлдөөн үүний дохио сануулга болов. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлийг бүс нутаг буюу салбар бүс нутагт, манай улс оронд нөлөөлөхүйц зөрчил хямрал үүсч дайнд татагдан орох, хил залгаа орнуудын хоорондын зөрчил тэмцэл, мөргөлдөөнд татагдан орох, тэдгээрийн дотоод зөрчил, хямралын уршигт нэрвэгдэх гэж зааж өгсөн байгаа. ТУХН-ийн зарим оронд ийм хямралт байдал бий болоод удлаа. Харин түүнийгээ хил давуулахгүй, бүрмөсөн хяналтаасаа гаргачихгүй торгоож байгаа нь сайн хэрэг. Гэвч үүнийг хэр удаан хадгалах бол. Үүнд баталгаа алга. Хөрш орноос дүрвэгсэд олноор орж ирэх, хууль бусаар хил нэвтрэх, хилийн зөрчил гаргахыг сөрөг нөлөө үзүүлэх гадаад хүчин зүйлд оруулсан. Энэ бол болзошгүй хүчин зүйл байж болохыг үгүйсгэж болохгүй. Хүн амынх нь тоотой харьцуулбал Монгол Улс хэт том нутаг дэвсгэртэй, бас ашиглагдаггүй зэлүүд газар их бий. Үүнийг хоёр хөрш маань далд тооцоолж байхыг хэн байг гэхэв. Ялангуяа өмнөд хөршид будлиан самуун дэгдвэл бид өмнөд хилээ өөрийн хүчээр хамгаалж байх хүчин мөхөдөнө. Урьдын "Соёлын хувьсгалын" үед бид Зөвлөлтийн цэргийн хүчээр хил хязгаар нутаг дэвсгэрээ хамгаалж байсан. Гэтэл одоо манай батлан хамгаалах хүч хэр бэлтгэлтэй, боломжтой байгаа билээ.

Бидэнд Хятадын тогтвортой байдал юу юунаас илүү чухал. Умард хөрш маань ч дотооддоо эв түнжинтэй, хагарал бутралгүй баймааж нь манай улсын аюулгүй байдлыг баталгаатай хангана. Харамсалтай нь Орост интеграцын үйл явц урвуу хэлбэрээр явагдаж цаашид хэрхэх нь тодорхойгүй байна. Монгол нь урьд дэлхийн халуун цэгүүдээс их хол оршдог байсан. Үүний сацуу Зөвлөлтийн цэрэг манай аюулгүй байдлын батлан даагч болж ирсэн. Энэ хоёр хүчин зүйлээс болоод бид халуун цэгүүд, бүс нутгийн мөргөлдөөний талаар тодорхой ойлголтгүй, санаа амар явж иржээ. Гэтэл одоо хүсээгүй юм хүзүүгээр гэгчээр ийм ноцтой голомтууд умард хөршид маань үүсчээ. Тэр нь энэ орны нутаг дэвсгэрээр нийтэд нь тархах аваас манай аюулгүй байдал хэцүүхэн сорилттой тулгарна. Энэ бол одоохондоо магадлал төдий зүйл. Гэвч бид сэтгэл зүй-материаллаг талаас бэлтгэлтэй байх ёстой. Монгол Улс бүс нутгийн чанартай мөргөлдөөнд татагдан орохгүй байх гол нөхцөл бол хоёр оронтой итгэлцэл бэхжүүлж, сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх ёстой. Тэгэхдээ юуны өмнө үндэсний ашиг сонирхол, ялангуяа үндэсний язгуур ашиг сонирхлоо зохих ёсоор харгалзан тусгаж байх, хэрэв энэ язгуур ашиг сонирхлыг хөндөөгүй бол хоёр хөршийн хоорондын маргаанг эс оролцож, төвийг сахих бодлого баримтлахыг манай үндэсний

аюулгүй байдлын үзэл баримтлалд чухалчилсан юм. Монгол Улс аюулгүй байдлаа баталгаатай байлгах бас нэг нөхцөл бол олон түнштэй байх, олон улсын харилцааг улс төрийн бодит байдлаас харах, аюул занхал учраагүй нөхцөлд эвсэлд үл нэгдэх бодлого явуулах, нөлөө бүхий орнуудын стратегийн сонирхлыг Монголд бий болгох явдал гэж мөн энд заажээ. Энэ утгаар Орос, Хятадаас гадна манай ардчилал, шинэчлэлийг тууштай дэмждэг Япон, АНУ, Өрнөд Европын зарим томхон орны стратегийн сонирхлыг Монголд бий болгон төвлөрүүлэх нь зүйтэй юм. Үүнд хөрөнгө оруулалт, хамтарсан үйлдвэр, банк-санхүү, томхон уурхай зэрэг хөрөнгө хүч их зарсан, эргээд хамгаалахаас өөр аргагүй, хэрэв маргаантай асуудал дэгдвэл олон улсын томхон асуудалд хүргэж мэдэх тийм объектыг оруулах ёстой. Бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрэнтэй улс төр-эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар аливаа нэг том улсаас хэт хамааралтай байхаас байнга сэрэмжилж байх нь чухал болов уу.

Дүгнэлт

Зөвлөлтийн эзэнт гүрэн задарсны дараа Ази болон Дундад Ази, Дундад Дорнодод ямар нөлөө үзүүлсэн, ямар сул орон зай гарч, түүнийг хэн хэрхэн бөглөхөөр завдаж байгаа асуудлыг хөндөн бичлээ. Гэвч энд бичигдээгүй олон асуудал бий бөгөөд үйл явдлын өрнөлт хөгжилт тийм асуудлыг таамаглан бичих боломж олгохгүй байна. Ямар ч атугай Зөвлөлтийн нөлөө, аюул алга болмогц энэ өргөн уудам бүс нутаг хөдөлгөөнд орсон нь гарцаагүй. Далайц хамрах орон зайн хувьд Европын хэмжээнд хүрэхгүй ч шууд хил нийлэх хөрш зэргэлдээ орнууддаа их бага хэмжээгээр нөлөөлсөн. Энэ үйл явц олон улсын харилцаанд шинээр олон асуудал бий болгосон. Жишээ нь дээр өгүүлсэн лалын хүчин зүйлийг өнөөдөр олон улсын харилцаанд харгалзан үзэхгүй байх нөхцөл алга. Урьд нь үүнийг улс төрийн асуудал гэж тэгтлээ ойшоодоггүй байсан. Гол нь лалын аюул Зөвлөлтийн хилийг давж чадаагүй юм.

Зөвлөлтийн орыг авсан ТУХН-ийн орнуудын шилжилтийн үеийн түр саатлыг ашиглан цэрэг-стратеги, эдийн засгийн талаар бэхжиж авахыг зорьсон Хятад мэтийн улс гарч ирсэн нь анхаарал татаж байна. Цаашид энэ бүс нутагт Хятадын жин нөлөө тасралтгүй нэмэгдэх бөгөөд энэ нь эргээд Оросыг хүнд байдалд оруулахыг үгүйсгэж болохгүй. "Хүйтэн дайны" үед Зөвлөлт-Америкийн хооронд хүчний харьцааг тогтоон барьж чадаж байсан бол Орос энэ үүргийг өөртөө дааж чадахгүй байна. Харин Зөвлөлтийн байр суурийг Хятад аажимдаа нөхөж мэдэхээр юм. Хятад ийнхүү хүчирхэгжиж чадвал хүчний харьцааг тэнцүүлэх, адаглаад ойртуулахад их бэрхшээл учирна.

АНУ Азид нэгэнт үүргээ гүйцэтгэсэн тул аажмаар холдох байх. Америк Японы эдийн засгийн өрсөлдөөн өсөх хандлагатай, бас үүн тулгар АНУ Японтой худалдааны асуудлаар санал нийлэхгүй байна. Японы нисэх мэт хурдаар урагшилж буй эдийн засгийн хүч чадлыг нь америктай, америкгүй тус орон бие даан өөрийгөө батлан хамгаанах нөхцлийг бүрдүүлнэ. Урьд нь Японыг Зөвлөлтийн аюулнаас АНУ-ын "цөмийн шүхэр" хамгаалж байсан. Одоо Орос ийм аюул учруулах хэмжээнд хүрч очоогүй байна. Ийм нөхцөлд АНУ-ын орон ший Япон, Хятад хоёр нөхөхийг оролдох бизээ. Үүнийг Зүүн Ази, АСЕАН-ны орнуудад энэ хоёр улсын явуулж буй бодлого, Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад (хойшид АПЕК гэж бичнэ) баримталж буй байр суурь битүүхэн харуулж байна.

"Хүйтэн дайны" төгсгөл ба ЗХУ-ын задрал бүс нутгийн шинжтэй антагонизм дайсангалцал төрүүлсээр байна. Үүнийг Ойрхи болон Дундад Дорнод, Персийн булан, Зүүн өмнөд Азийн зарим жишээн дээр харж болно. Солонгосын хойг үүний хамгийн том жишээ. БНАСАУ-ын цөмийн сэжиг бүхий программыг тойрсон маргаанд АНУ, Япон, Орос, Хятад, Өмнөд Солонгос бүгд татагдан орлоо. Олон жил их гүрнүүдийн сүр хүчинд дарагдан, чимээгүйхэн нэвсэн Умард Солонгос, Ирак голтойгоо өндийлгөх гэж оролдож байна.

Гол аюул-ЗХУ алга болсноор хүн ам нь хэмжээнээсээ хэтэртэл өсч буй Хятад хүн ам зүйн бодлогоо гадагш хил давуулж мэдэхийг анхаарах ёстой. Хүн амын хэт их өсөлт бол Ази-Номхон далайн бүс нутгийн эмзэг асуудлын нэг билээ.

Энэ мэт дүгнэлт хийхдээ одоо бий болчихоод байгаа бодит байдлыг бус, ирээдүйд бий болж мэдэх болзошгүй байдлыг таамаглан бичлээ. Олон улсын харилцаа судлаачид болон улс төрчид үүнтэй адил төстэй буюу ойролцоо бодолтой байгаа учраас энд оруулсан юм.

Холбогдох ном, хэвлэл

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Ардын эрх" 1994.07.26. №145 (844)
2. Г.Төмөрчулуун. Олон улсын аюулгүй байдал ба Монгол Улс, "Дорно-Өрнө" 1992. №3,4 (30,31)
3. Б.Баабар. Төв Азийн аюулгүй байдлын бүс, УБ., 1994
4. Ж.Баясах. Төв Ази: Монголын стратегийн ач холбогдлыг түүх, газар зүйн үүднээс үнэлэх нь, "Монголын аюулгүй байдлын орчин" (Э/ш илтгэлүүдийн эмхтгэл) УБ., 1995
5. Tumurchuluun G. China's Foreign Policy After the Collapse of the USSR: Changes, Challenges and Opportunities, "The Mongolian Journal of International affairs" 1994, №1
6. Владимир Жириновский. Өмнө зүг сүүлчийн удаа ухасхийнэ. УБ., 1994

7. Концепция Внешней политики Российской Федерации, "Дипломатический вестник" Январь 1993
8. Збигнев Бжезинский. Геополитическое положение после распада СССР. "Казахстан и мировое сообщество" №1, 1994
9. Проблемы внешней и оборонной политики России (Сборник статей) Российской Институт Стратегических исследований, М., 1994
10. Новая Евразия: Отношения России со странами Ближнего Зарубежья (Сборник статей №1,2) М., 1994
11. Проблемы Безопасности России: Концепция, стратегия, приоритеты (Сборник статей) М., 1993
12. Богатуров А.Д., Дребенцов В.В., Исакова И.В. Вашингтон и постсоветские государства, "США: Экономика, политика, идеология" №12, 1993, №1, 1994
13. Самуйлов С.М. Будущее НАТО: интересы США и интересы России, "США: Экономика, политика, идеология" №1, 1994
14. Давыдов Ю.П. Россия между Западной Европой и США, "США: Экономика, политика, идеология" №8-9, 1994
15. А.А.Мурадян. "Евразийская" концепция-модель общественного развития России? "Проблемы Дальнего Востока" №1-2-3, 1992
16. Sipri Yearbook 1994, World Armaments and Disarmament, Oxford University press. 1994,
17. Eurasianism: A New Russian Foreign Policy? by Francoise Thom, "Uncaptive Minds", Summer 1994, Vol. 7 no. 2 (26)
18. Contours of A New World (Change in Asia and Europe since 1989) Freidrich - Naumann - Stiftung, National Institute for Policy Studies, Institute for Strategic and Development Studies, Manila., 1992.
19. Richard Schifter. The Conference on Security and Cooperation in Europe: Ancient Hisfory or New Opportunities? "The Washington Quarterly" Autumm 1993
20. Partnership for Peace: Declaration of the Heads of State and Government Participating in the Meeting of the North Atlantic Council (10-11 January, 1994)
21. NATO' s Partnership for Peace - Report on Eastern Europe (Vol.3, №12, 25 [iii] 1994)
22. G.Lee Williams: The Logic of Diversity (Occasional Paper №56, Institute for European Defence and Strategic Studies)
23. Philip Robins. Between Sentiment and Self Interest: Turkey 's Policy towards Azerbaijan and the Central Asian States, "Middle East Journal" (vol. 47, №4, Autumm 1993)
24. Philip Robins. Turkey 's Ostpolitik: Relations with The Central Asian States, (Royal Institute of International Affairs, April, 1994)
25. Y.Bodansky. The Grand Strategy of Iran, "Global Affairs" (vol.8, №4, 1993)

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ПОСТКОММУНИЗМ БА ИХ ШИЛЖИЛТ

Хуучин социалист байсан орнуудад өрнөж буй ардчилалд шилжих үйл явцыг тусгайлан бүлэг болгож оруулах нь зүйтэй гэж үзлээ. Энэ бол нэг талаасаа асар өргөн, сонирхолтой, нөгөө талаасаа бичихэд түвэгтэй, маргаантай сэдэв. Миний түрүүчийн номд дэлхийн социалист системийн үүсэл хөгжил, хямрал, төгсгөл, түүний олон улсын үр дагаварын тухай тодорхой өгүүлсэн. "Хүйтэн дайны" төмөр хөшгөөр дэлхий ертөнцийг хоёр хуваахад социализм нөлөөлсөн хэрээрээ "Хүйтэн дайны" төгсгөл энэ системийн сүйрлээр тайлбарлагддаг тухай баримтаар үндэслэлтэй гаргасан байгаа. Эдгээр асуудлыг ухаж ойлгосон хэнд ч одоо энд бичих зүйл тодорхой болно биз ээ.

Хуучин социалист ертөнц маань өнөөдөр ямар нэг хэмжээгээр хөдөлгөөнд орчихоод байгааг юуны өмнө тэмдэглэх ёстой. Хэмжээ далайцаар нь олон янз ангилж болох боловч байсан байдлаа өөрчилж нийтээрээ хөдөлж байгааг хэлж байна. Нэг хэсэгт нь нийгмийн хувьсгал гарлаа. Тоталитари дэглэмээс ардчилал руу, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн харилцаа руу, нэг намын дарангуйллаас олон намын тогтолцоо, олон ургальч үзэл рүү шилжиж байгаа болохоор хувьсгалтай зүйрлэж байна. Тэгээд ч энэ үйл явцыг "Их шилжилт" гэж нийтээрээ нэрлэж байна. Энэ шилжилт бид бүхнийг ямар нэг гэрэлт ирээдүй рүү хөтлөн аваачих ёстой нь мэдээж боловч одоогоор хямрал бэрхшээл, бартаатай зам туулан зугуухан урагшилж, шинэ шинэ асуудал гаргаж мухардуулах үе бишгүй тохиолдож байна. Социализмын сургааль нь анхнаасаа үл гүйцэлдэх номнол (утопизм) дээр тулгуурласан, хэрэгжүүлсэн арга зам нь шинжлэх ухааны үндэсгүй, үлдээсэн үл мөр нь ноцтой байсан болохоор ийм бэрхшээл тохиолдох нь зүйн хэрэг.

Шилжилтийн асуудлаар бичдэг судлаач нийтлэлчдийн (жишээ нь АНУ-ын З.Бжезинскийг юуны өмнө нэрлэе) үзэж байгаагаар, энэ үйл явц социалист байсан, одоо социалист гэж өөрийгөө нэрлэдэг орнуудын хувьд хэд хэдэн онцлогтой ажээ. Тухайлбал, коммунизм сүйрсний дараа 4 янзын дүр зураг эдгээр оронд бүрдээд байна. Тэр нь:

1. Улс төр, эдийн засгийн шинэчлэлийн аль алин нь амжилттай (ээрэг) яваа;
2. Улс төр нь эерэг, эдийн засаг нь сөрөг нөлөө үзүүлж буй;
3. Улс төр нь сөрөг, эдийн засаг нь эерэг;
4. Улс төр, эдийн засгийн аль алин нь бүтэлгүй байгаа гэсэн дүр зураг юм. Эдгээрийг улс тус бүрээр авч үзвэл,

1. Тоталитари дэглэмтэй тэмцэж ирсэн түүхэн уламжлал, туршлагатай, эдийн засгийн бат бэх үндэс суурьтай, социализмд шилжихээс өмнө европын хөгжингүй капиталист орны тоонд орж байсан, социализмд шилжээд хөгжлийн түвшингээр ухарсан Чех, Польш, Унгарыг энд жишээлж болох юм. Үүн дээр Германы зүүн хэсэг (хуучин БНАГУ), Эстон, Словакийг нэмж болно. Эдгээр орон шилжилтийг хохирол багатай давах найдлагатай, өрнөдийн тусламжийг үр дүнтэй ашиглаж чадна гэж тооцогддог. Энэ утгаараа Европын холбоо, НАТО-д нэгдэх бодит боломж бусдаасаа түрүүлж бүрдэх юм. Гэхдээ эдгээр орны дотоодын бэрхшээлийг тооцохгүйгээр ирээдүйг урьдчилан таамаглаж болохгүй. Хэдийгээр улс төрийн ардчилал, хүний эрхийн талаар ахиц дэвшил байгаа хэдий ч өрнөдийн баян тансаг орнуудад дөхөж очиход их зай байна. Өөрөөр хэлбэл, амьжиргааны стандартын зөрүүг арилгахад маш олон жил хэрэгтэй, гэхдээ үүнээсээ шантарч болохгүй. Жишээ нь ХБНГУ, Австрийн хөгжлийн түвшинд зөвхөн үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлтээр хүрье гэхэд Чех 30 жил, Унгар 46 жил, Польш 63 жил уйгагүй хөдөлмөрлөх ёстой гэсэн тооцоог ЗБЖезинский хийжээ. Үүнийг огт үндэсгүй зүйл гэж би үзэхгүй байна.
2. Энэ ангилалд орох орнуудад ойрын арваад жилд одоогийнхоос ялигүй ахиц дэвшил гарч магадгүй, гэвч эдийн засгийн хямрал нэг хэсэгтээ салахгүй. Энд Монголыг оруулсан судалгааг өнөө хүртэл би олж үзээгүй, гэхдээ үнэлгээгээр бол багтах нь гарцаагүй. Болгар, Хорват, Литва, Латвийг энэ ангилалд оруулдаг бөгөөд Орос болон ТУХН-ын зарим орон ямар нэг хэлбэрээр багтаж болмоор санагддаг. Гэвч эдгээр орны тогтворгүй байдал, бүс нутгийн мөргөлдөөн, засаглалын хямрал тодорхойлох боломж олгохгүй байна. Монголыг Болгар, Хорват, Литватай механикаар зүйрлэх нь утгагүй. Гэвч улс төрийн ардчилал, хүний эрхийн зарим үзүүлэлт нь адил төстэй байгаа юм. Эдийн засгийн хувьд энэ жагсаалтад бичигдсэн 4 орон бусдаасаа түрүүлэх байх. Нүсэр том эдийн засагтай, түүхий эдээр гол экспортоо хийдэг Орост эдийн засгийн эмх замбраагүй явдал үргэлжилж, үр дүнтэй мөнгө зээлийн бодлого хэрэгжүүлэх боломжгүй, мөнгөний ханшны уналт ер бусын өндөр, ажилгүйдэл байнга өсч, засгийн газар хөтөлбөрөө хязгаарлагдмал орчинд хэрэгжүүлж (зөвхөн төв суурин газар үйлчилж, нийт улсдаа хэрэгжихгүй гэсэн үг) эдийн засгийн бодлогын уялдаа холбоо сул байсаар ирэх зуунтай золгох гэж байна.
3. Улс төрийн ардчилал хязгаартай, түүнийг хүлээн авдаггүй атлаа эдийн засгийн радикал шинэчлэлээрээ бусдад үлгэр жишээ болж буй Хятад, Вьетнам болон Дундад Азийн шинэ тулгар зарим орныг судлаачид нэг ангилалд авч байна. Эдийн

засгийн үнэлгээгээр бол эдгээр орон тогтвортой, тэр байдлаа нэг хэсэгтээ хамгаалж чадах чадвартай, хүн амын амьдралын түвшин тасралтгүй дээшилж байгаа сайн тал бий боловч улс төрийн ардчилалгүйгээс үүдэн улс төр-нийгмийн олон асуудал бугшиж байна. Тухайлбал Хятадад эдийн засгийн гэмт хэрэг, хээл хахууль газар авч, хүнд суртал өсөхийн хэрээр захиргааны зардал байнга өсч, эдийн засагтаа эргээд дарамт учруулахыг үгүйсгэх аргагүй. Ер нь энэ бүлэгт багтах орнуудыг хооронд нь жиших, харьцуулахад тун хэцүү. Хятад, Вьетнамд зах зээлийн социализмыг өөрийн онцлогт тохируулан байгуулж байгаа бол Туркменистан, Кыргызстан, Узбекистан, Казахстан зах зээлийн чөлөөт харилцаанд ихээхэн зөрчилтэй замаар шилжиж байгаа билээ.

4. Улс төр, эдийн засгийн бүх үзүүлэлтээр сөрөг (баргар) дүн үзүүлэх Серби, Албани, Македони, Босни, Тажикистан, Куба, БНАСАУ-ыг нэг бүлэг болгон авч үзэж болох юм. Румыныг зарим үзүүлэлтээр энэ бүлэгт оруулдаг. Гэхдээ би энд бүгдийг нь нэг самбар дээр тавьж шууд адилтгахыг яарахгүй. Хоорондоо ялгарах олон зүйл бий. Коммунист тоталитари дэглэмд үнэнч буй БНАСАУ-ыг цус асгаруулсан тэмцлээрээ тийм дэглэмийг мөхөөсөн Румынтэй зүйрлэж яахан болох билээ. Эдгээр орон дорвитой радикал өөрчлөлт хийж чадахгүй бол ойрын 10-20 жилд ахиц дэвшилд хүрэхгүй гэж тооцогддог. Гэхдээ эдийн засгийн хэр зэрэг үндэс суурьтай вэ? гэдгээс их зүйл шалтгаална. Улс орноо үйлдвэржүүлэх үндэс тавьсан Румын, БНАСАУ, угийн бат бэх эдийн засагтай байсан Сербийг Албани, Тажикистантай зэрэгцүүлэх нь утгагүй хэрэг. Гэхдээ ийм давуу тал нь улс төрийн ардчилалгүй буюу ардчилал сул байгаа нөгөө нэг сөрөг үзүүлэлтээрээ энэ бүлэгт яах аргагүй оруулж байна.

Ийнхүү социалист гэгдэж буй, хуучин социалист байсан орнуудыг 4 хэсэгт ангилахдаа өрнөдийн судлаачид ямар аргачлал, хэмжүүрийг үндэс болгов. Энд үндсэн 3 хэмжүүр байдаг аж. Энэ нь:

1. Улс төрийн төгс боловсронгуй ардчилал;
2. Хүний эрхийн найдвартай баталгаа;
3. Зах зээлийн чөлөөт харилцаанд эргэлтгүй шилжсэн байх явдал.

Энэ 3 хэмжүүр бүрдсэн газар хямрал бэрхшээлийг хамгийн хохирол багатай давж болох бөгөөд шилжилтийн зурвас үе нь харьцангуй богино хугацаанд явагдана. Энэ 3 хэмжүүрийн аль нэг нь доголдох буюу илт үгүйлэгдвэл хийж буй реформ шинэчлэл заавал ямар нэг ил далд асуудал үлдээнэ. Жишээ нь Босни болон ГУХН-ийн зарим нэг оронд өнөө хүртэл дайтсаар байгааг чухам үүгээр л тайлбарлах ёстой. Босни бол хуучин Югослав дотроо дунд

зэрэг хөгжилтэй, хүн амын амьдрал элбэг хангалуун байсан харьцангуй тогтвортой орон. Гэтэл улс төрийн ардчилалыг жинхэнэ ёсоор тогтоож чадаагүйгээс үндэстний цөөнхийг үл хүндэтгэж, хүний эрх зөрчин тэр нь даамжирсаар дайнд хүргэсэн. Хятадад эдийн засгийн өвөрмөц хэлбэрийн реформ хийж ихээхэн үр дүнд хүрч байгаа ч эхний хоёр хэмжүүрээр авч үзвэл олон улсын маргааны сэдэв болох нь зүйн хэрэг. Энэ 3 хэмжүүрийг алийг нь ч хүлээн зөвшөөрдөггүй БНАСАУ-д нааштай өөрчлөлт гарна гэхэд тун хэцүү байх жишээтэй.

Энэ 3 хэмжүүрээс гадна улс орон тус бүрийн, бүс нутгийн онцлогийг харгалзан туслах чанарын олон хэмжүүр гаргаж болох байх. Гэхдээ энэ 3 хэмжүүр бол ардчилсан, өндөр хөгжилтэй АНУ, Өрнөд Европын орнуудын олон жилийн практикаар үнэн зөв болох нь нотлогдсон, цаашид үүнийг тойрч гарах аргагүй зүй тогтол болсонд гол учир байна. Тийм учраас ардчилсан төрт ёс бүхий зах зээлийн эдийн засагтай шинэ нийгэмд шилжигч гэвэл үүнийг зүй ёсоор харгалзан үзэх ёстой.

Ингэхэд бид бүхний туулж буй шилжилтийн энэ зурвас үе хэр удаан хугацаа шаардах бол гэж сонирхож болох юм. Бидэнд тухайлбал улс бүрт тохирох бэлэн жор гэж алга. Жишээ нь Монгол, Албани, Дундад Азийн орнуудад капитализм байгуулж байсан туршлага байхгүй. Бүхнийг цоо шинээр хийж эхлэх болж байна. Ийм учраас энд би тийм орон гэж зах зээлд орно, тийм нь төдөн жилийн дараа шилжилтийг дуусгана гэж урьдчилан таамаглаж чадахгүй. Ерөнхий дүр зургийг нь ойролцоогоор, баримжаагаар үечлэн гаргахыг хичээе. Үүнийг дараах хүснэгтэд буулгалаа.

Нэгдүгээр үе 15 жил үргэлжлэх ба улс төрийн хувьд шинэчлэл, эдийн засагтаа тогтворжуулалтыг гол болгоно. Дотроо 4 үндсэн салбарыг хамрах бөгөөд салбар тус бүрийн зорилго нь:

Улс төр	Хууль тогтоомж	Эдийн засаг	Өрнөдийн тусламж
Ардчиллын үндэс тавих, чөлөөт хэвлэл бий болгох, нам-төрийг зааглах, нэг намын тогтолцоог хянах, ардчилсан хүчнийг эвсэл байгуулах	Төрөөс арбитрын байгууллагад тавьсан хяналтыг цуцлах	Үнэ чөлөөлөх, хамтрал нэгдлүүдийг тараах, хувьчлалыг эхлүүлэх	Мөнгөний ханшийг тогтвортой байлгах, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгох

Хоёрдугаар үе 3-10 жил (Улс төрийн тогтвортой байдлыг хангах эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах мөртөө түүнийг реформ рүү чиглүүлэх явдлыг гол болгоно)

Улс төр	Хууль тогтоомж	Эдийн засаг	Өрнөдийн тусламж
Шинэ Үндсэн хууль, сонгуулийн шинэ хууль батлах, шинэ сонгууль явуулах, төвлөн удирдах ёсыг халах улс төрийн шинэ элит бий болгох	Өмчийн болон бизнесийн үйл ажиллагааг хуулиар зохицуулах	Банкны систем тогтоох, бага дунд хувьчлал хийх, эдийн засгийн монополийг халах, эдийн засгийн шинэ анги (элит) бий болгох	Дэд бүтцэд зээл олгох, техникийн болон менежментийн тусалцаа, худалдаанд хөнгөлөлт үзүүлэх, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих

Гуравдугаар үе. 5-15 жил (Улс төрийн хувьд эв нэгдэлтэй байх, эдийн засгийн хувьд аажим есөлтийг хангахыг гол баримжаа болгоно)

Улс төр	Хууль тогтоомж	Эдийн засаг	Өрнөдийн тусламж
Ардчилсан намуудыг төлөвшүүлэх, улс төрийн ардчилсан соёлд бүрэн суралцах	Бие даасан шүүх засаглал тогтоож, эрх зүйн соёл төлөвшүүлэх	Их хувьчлал хийх, капиталист лобби төрүүлэх, эдийн засгийн жинхэнэ соёл төлөвшүүлэх	Томхон хөрөнгө оруулалт, Өрнөдийн олон улсын байгуул лагуудад (Европын холбоо, НАТО гэх мэт) элсүүлэх

Энэ хүснэгт нэлээд тоймлосон бүдүүвчлэл төдий зүйл. Хүснэгтийн заалт бүртэй улс орнууд тэр бүр тохирох албагүй. Гэхдээ энэ 3 үеийг дамжиж байж л бид хүрэх ёстой өндөрлөгтөө хүрнэ. Харин хэн нь түрүүлж, хэн нь сүүлдэж хүрэхийг энэ бүлгийн эхний хэсэгт битүүхэн ойлгуулсан байх. Ер нь яагаад ийм алаг цоог дүр зураг гарч ирэв, хэрэв ийм их ялгаатай зөрүүтэй бол заавал хамтатгаж үзэх хэрэг юу байна гэсэн асуудал гарч болохыг үгүйсгэхгүй. Үүнд хариулах зорилгоор доорх дэд бүлгүүдийг бичлээ.

НЭГ. ПОСТКОММУНИЗМ ЕВРОПТ

Ардчилсан тайван хувьсгалын замд анхлан хөл тавьсан Төв болон Дорнод Европын хэсэг орныг энд эхлэн авч үзье. 90-ээд онд энэ бүс нутгийг хамарсан ихээхэн өөрчлөлт гарсан. Энэ өөрчлөлт *түүхэн ба геополитикийн гэсэн хоёр үндсэн онцлогтой. Түүхэн талаасаа* бол Европын их гэр бүл, нийтлэг соёл-иргэншилцээ эргэж нэгдэх хандлага давамгайлж, харин *геополитикийн талаасаа* идрал тэр онцлогийг нь тодорхойлж байна. Бүхэлд нь Европээр

авч үзвэл *нэгдэл - задрал* хоёр 90-ээд оны гол үзэгдэл болжээ. Дорно зүгт задрал, өрнөдөд нэгдэл - интеграц хүчтэй өрнөв. Энэ үзэгдэлийн хүрээнд Төв ба Дорнод Европыг авч үзвэл

1. Европтоо жинтэй байр эзлэх Чехословакийн холбооны улс хоёр хуваагдлаа. Гэхдээ энэ задрал тайван замаар, соёлтой, хууль зүйн үндсэн дээр явагдсан нь бусдаас ялгарах онцлог болж байна.
2. Балканы хойгийн хамгийн хүчирхэг Югославын холбооны улс хэд хэд задарсан бөгөөд энэ задрал дуусаагүй байна. Цаашид Босни болон Югослав өөрөө (Серби, Черногор, Косово, Воеводина) задрах аюултай нүүрлээд байна.
3. Орос, Украин, Молдов болон Кавказ хавьд ийм аюул нэг хэсэгтээ намжихгүй. Гэхдээ ТУХН дэх нөхцөл байдал Европын орнуудынхаас эрс ялгаатай, эдгээрийг хооронд нь шууд адилтгах нөхцөлгүй.
4. Румын энэ жагсаалтад нэмэгдэх магадлал бүрдэж байна. Тус оронд оршин суудаг унгар цөөнхийн асуудал Румыны удирдлагын сэтгэлийг нэг хэсэгтээ түгшээх бололтой.

Хэрэв эдгээр задрал буруугаар эргэх буюу олон улсын маргааны төвд орвол Европын нийт улс төрийн уур амьсгалд шууд нөлөөлөх болно. Учир нь Европ бол газар зүйн орон зайн хувьд маш бага, хэт шигүү суурьшилтай, цэрэг - стратегийн сонирхол бүхий олон орны эрх ашгийг хөндөж мэдэх, бас тэгээд дэлхийн хоёр том дайны голомт болсны хувьд эгзэгтэй бүс нутаг. Энэ утгаараа Өрнөдийн хувь заяа Дорнодод шийдэгдэнэ гэсэн шинэ ойлголт бий болжээ. Тийм учраас Дорнодод орших тэдгээр бүлэг улсыг өрнө - дорнын хоорондын гүүр маягтай ойлгож болох юм. Учир нь АНУ болон Өрнөд Европ энэ гүүрээр дамжин ТУХН-тэй харилцана. Энэ гүүр хэр зэрэг бат бэх, найдвартай байхаас тэдний бодлого амжилт олох эсэх нь шалтгаална. Хэрэв өрнөдийн тал санаачилга алдахгүй байя гэвэл энэ гүүрийг анхаарлаасаа гаргаж болохгүй. Хэрэв дэлхий дахинд шинэ дэг журам тогтоож чадахгүй санаачилга алдвал энэ үүргийг өөр нэг том гүрэн буюу лалын ертөнц авч мэдэх юм. АНУ, Өрнөд Европ хоёр соёл иргэншлийн үндсэн үнэт зүйлүүдийг амжилттай хамгаалж чадахгүй байгаа нь Европын салшгүй хэсэг - Балканы жишээн дээр харагдаж байна. Европ дайнаас хойшхи түүхэндээ, "Хүйтэн дайны" ид хурц үед Босни шиг иймэрхүү шийдэхэд амаргүй асуудалтай тулгарч байгаагүй. Өнөөдөр энэ мөргөлдөөн хуучин Югославын багахан хэсгийн хамарч байгаа мэт боловч маргааш нийт Балканыг хамрахгүй гэх баталгаа байхгүй. Хөрш Македони руу хил давж ороход л Балкан дарьтай торх болж хувирна.

АНУ, Өрнөд Европын зүгээс Дорнод руу явуулах бодлогод ардчиллын төлөө хүлээх хариуцлага чухал байр эзлэнэ. Учир нь өрнөдийнхөн эдгээр оронд өрнөсөн ардчилсан хөдөлгөөнийг

анхнаас нь талархаж, сэтгэл санаа - эд материалын асар их дэмжлэг үзүүлсэн. Үүнээсээ л бүү ухраасай гэсэн санаа илэрхийлж буй хэрэг. Ухарч байна гэсэн зэмлэл биш ч, эргэж бодох юм бишгүй гарч байна. 80, 90-ээд оны зааг дээр тэр үеийн Европын социалист орнуудад аяндаа өрнөсөн ардчилсан тайван хувьсгалын цаашдын төлөвийг урьдчилан харах чадвар хаа хаанаа дутсан. Засгийн эрхийг ардчилсан хүчинд шилжүүлж, коммунист тоталитари дэглэмийг унагавал бүх юм дардан шулуун зам дээрээ гарчих мэтээр төсөөлсөн. Гэвч хэдэн жилийн дараа юу болох вэ? Ардчилсан тайван хувьсгалаар засгийн эрхийг шилжүүлсний дараа ямар бэрхшээл тохиолдох вэ? гэдгийг тооцсон нь юу л бол. Үүнийг доорхи шалтгаанаар тайлбарлаж болох юм. Үүнд:

- 1) Төв болон Дорнод Европын орнуудыг ардчилсан хөгжлийн замд оруулсны дараа Европын их гэр бүлд нь эргүүлж авчрахад үүсэх бэрхшээлүүдийг урьдчилан тооцоогүй. Энэ нь амьдралын хэт их зөрүү, технологийн хөгжлийн тэнцүү биш байдал, хүмүүсийн үйлдвэрлэл эрхлэх арга барилын хоорондын ялгаа, дэд бүтцийн хэт хөгжил ба хоцрогдол зэргийг дурдаж болох байна.
- 2) Дорнодод сайн ч, муу ч үүргээ гүйцэтгэж ирсэн цэрэг-улс төрийн бүтцийг (Варшавын гэрээний байгууллага) эвдэн нураахад өрнөдийнхөн тодорхой үүрэг гүйцэтгэсэн хэрнээ эргээд аюулгүй байдлаа хамтдаа хариуцах гэсэн байр суурийг нь олигтой дэмжихгүй байна. Зарим орныг НАТО-д элсүүлэх тухай одоо ярьдаггүй юмаа гэхэд Оросоос үүдэж мэдэх аюулын өмнө балмагдаж байгаа үед нь дэмжих тухайд хойрго хандаж, Оросын амыг их харж байна.
- 3) Үүнтэй нэгэн адил ЭЗХТЗ дампуурсны дараа Өрнөд Европын интеграцид нэгдэх гэсэн Дорнодынхны хүсэл тэмүүлэл урам хугалахаар хариутай тулгарч байна. Зөвхөн эдийн засгийн хоцрогдол, амьдралын түвшингийн ялгааг гол болгоод ингэж хандах нь хэр бодитой вэ? Дорнод Европын түншүүдээс хэн нь илүү боломжтой вэ? гэдгийг тооцоолж болно. Интеграцийн энэ эрчимтэй үед эдгээр орон түүний гадна хоцрох ёсгүй, Европын холбоонд биш юмаа гэхэд өөр нэг хэлбэрийн интеграцид хамрагдах ёстой.
- 4) Дорнодынхон ч өөрсдийгөө хуурсан тал бий. Тэд ардчиллыг хуульчилж, засгийн эрхийг коммунистуудаас цэвэрлэчихвэл бусад нь аяндаа бүтнэ гэж үзсэн, тэгээд ч социализм системийн хувьд тарангуут шууд НАТО, Европын холбоонд элсэх тухай мэдэгдэх болсон нь эртэдсэн хэрэг юм. Энэ хооронд ямар нэг завсрын үе байх ёстой гэж тооцоолоогүй.
- 5) Дорнодынхон улс төрийн тогтолцоогоо өөрчлөх зурвас үед яваа бөгөөд ардчиллыг дөнгөж төлөвшүүлж эхлэх шатандаа байна. Энэ үед засгийн эрх хуваарилах асуудал өрнөдийнхний санаанд багтамгүй хурдан, адаармаатай өөрчлөгдөж байгаа

- нь болгоомжлох харзнах нэг нөхцөл болж байна. Жишээ нь олон оронд хуучин коммунистууд социалист, социал - демократ, зүүний хүчний хэлбэрээр эргэж гарч ирлээ. Ингэж өөрчлөгдөж байгаа нь сайн хэрэг боловч энэ шинэ хүчнүүд ардчилал хөгжсөн өрнөдийн орнуудын улс төрийн намын зиндаанд хүрч төлөвшихөд их зай байна. Асуудал шийдэж ирсэн хуучин коммунист арга барил, нөгөөх л тусгай хангамж, эрх ямба, захиргааны аппарат гэх мэт зөрөх юм бишгүй бий. Ер нь олон намын ардчилсан зөв тогтолцоо бүрдэх үйл явц орон бүрт харилцан адилгүй (жишээ нь Унгарт үлгэр жишээч, Румын, Польшид ихээхэн ээдрээтэй, Чехэд зогсонги гэх мэт) байгаагаас засгийн эрхэнд гарч буй нам, хөдөлгөөнийг таниж мэдэх, баримжаа авахад түвэгтэй байна.
- 6) Хуучнаа санагалзах, хуучиндаа эргэж орох гэсэн хандлага өрнөдийнхнийг ихэд тэвдүүлж байгаа нэг үзэгдэл юм. Ийм үзэгдэл Германы зүүн хэсэг, Болгар, хуучин Югославын зарим улс, ТУХН-д түгээмэл ажиглагдаж байна.
- 7) Хуучин социалист байсан бүх орон шилжилтийн үедээ эдийн засгийн их бага хямралд нэрвэгдэж, нийгэм нь задралд орж байна. Энэ бэрхшээл харилцан адилгүй үр дагавартай бөгөөд бэрхшээлийг арилгах хэр найдвартай вэ? гэдгээс өрнөдийнхний үзүүлэх зээл тусламж шалтгаалж байна. Энэ бол бас л харзнах, шийдэмгий бус ажиллах нэг бодит нөхцөл мөн.
- 8) Эцэст нь ардчилалд шилжих үйл явц эдгээр орнуудад харилцан адилгүй асуудал шийдэж өгснийг хэлэх ёстой. Тухайлбал, ардчиллын ачаар зүүн германчууд эх орноо нэгтгэж, нэгдсэн гэр орноо төвхнүүлсэн бол Балтийн улсууд тусгаар тогтнолоо олж, харин их үндэстний дэргэд дарагдан суусан Словак болон Югославын үндэстнүүд бие даах боломж олж авчээ. Тэгвэл Унгар, Болгар, Польш ердөө л Зөвлөлтийн нөлөөнөөс гарч, жинхэнэ ардчилсан эрх чөлөөгөө бататган бэхжүүлсэн юм. Нэгдмэл нэг үндэстний сонгон авсан ардчилал, олон үндэстэн ястны улсын сонгон авсан ардчиллын хооронд ихээхэн ялгаа зөрүү байгааг энд бас хэлэх хэрэгтэй. Бас урьд нь капитализмд байгаад коммунист шатыг туулан дахин капитализмдаа шилжиж буй орнууд, феодализм, хаант ёс, хагас колониос коммунизмаар дамжин капитализм руу шилжиж буй орнуудын хоорондын ялгааг ч мартаж болохгүй. Төв болон Дорнод Европ, Балканы хойгт болж буй шилжилтийн үе нь ардчиллын ачаар жинхэнэ ардчилалд хүрэх нэг түүхэн үзэгдэл; ардчиллын ачаар тусгаар тогтнолоо олж авах өөр нэг түүхэн үзэгдэл; ардчиллын ачаар их үндэстний дарлалаас (Их Орос, их Серби гэх мэт) чөлөөлөгдөх бас нэг үзэгдлийг агуулсан байх бөгөөд өмнөө тавьсан зорилго, түүнийг шийдэх арга зам нь орон тус бүрт харилцан адилгүй

байгаагаас ийм алаг цоог, ижил төсгүй, тааж хэлэх аргагүй дүр зураг бий болгосон юм. Товчхон дүгнэвэл, Европ дахь посткоммунизм 3 үндсэн замаар хөгжиж байна Энэ нь:

1. Ардчиллаар дамжин ардчилалд хүрэх зам
2. Ардчиллаар дамжин либерал капитализмд хүрэх зам
3. Ардчиллаар дамжин тусгаар тогтнолд хүрэх зам ажээ.

Хөгжлийн загварын эрэл

Эдгээрээс гадна ер нь Төв болон Дорнод Европ нь дэлхийд ямар байр эзлэх, урагш хөгжихийн тулд нийгмийн хөгжлийн ямар зам сонгон авах, тэр нь улс бүрт хэр ялгаатай гэсэн асуудалд би хариу өгсөнгүй. Ерөнхийд нь тоймлон бичихдээ өөр хоорондоо ялгарах олон шинж чанар агуулсныг дурдлаа. Улс төр судлаачдын үзэж байгаагаар, эдгээр орны туулж өнгөрүүлэх завсрын зурвас үе бас л харилцан адилгүй байх бололтой. "Дорнод нь Өрнөд рүү явахыг оролдож байна. Гэтэл Дорнод өмнө зүгт оршиж байна" гэсэн Польшийн сөрөг хүчний нэгэн зүтгэлтний ("Эв санааны нэгдлийн" Б.Геремек) зүйрлэн хэлснийг энд иш татъя. Энэ санаа бол олон үзүүлэлтээр эдгээр орон хөгжиж буй орны хэмжээнд байна гэсэн үг. "Умард-Өмнөд" гэдэг нь хөгжингүй орнууд ба хөгжиж буй орнуудыг нэрлэсэн нэр (Энэ талаар зургадугаар бүлэгт тодорхой өгүүлнэ). Зах зээлд шилжих шилжилт ихээхэн хөндүүр байгаа, Европын хоёр хэсгийн байдал асар их ялгаатай, ажилгүйдлийн түвшин өндөр зэргийг бодолцвол үнэхээр хөгжиж буй орны дүр зураг харагдах мэт. Энэ нь миний дээр дурдсан капитализмд шилжих үйл явц түүний эртний загварыг хэлээд байх шиг. Эртний гэдэг нь үнэт зүйлгүй, соёлгүй капитализмыг (Орос, ТУХН, Балканы зарим орон сонгодог загвар нь) хэлсэн санаа юм. Капиталын хуримтлал бий болгохын оронд эрх мэдэлтэй болох хэрэглүүр болгож мөнгийг зарж дуусч байх жишээтэй. Ингэснээр мөнгөний ханшны уналт хэрээс хэтэрч, эдийн засагт хар зах, хээл хахууль, мафийн жин нөлөө өсч байна. Ийм учраас бүрэлдэн бий болж буй эдийн засгийн шинэ тогтолцооны гол цөм нь шинэ төрөх элит биш (хөрөнгөтөн гэсэн үг), харин мафи болох хандлагатай.

Унгар, Чех, Польш, Балтийн улсуудад ийм зэмлэл яг адилтган нялзааж болохгүй нь мэдээж. Тэнд ямар ч атугай капитализмын сонгодог хэлбэрийн хөрс нухлагдан дарлагдаад үлдсэн юм. Бас Польш, Унгарт хувийн хэвшил оршсоор байсан. Хувьчлал явуулсан ч хохирол багатай өнгөрөх нөхцөл бий. Гэтэл Болгар, Румын, Албанид ийм үндэс байгаагүй, шинээр бий болгож амжаагүй шилжилтэд хамрагдсан. Тэдгээр орон урагш хөгжихийн тул алхам ухрахаас өөр замгүй. Тэр ухралтыг уналт гэж нэрлэдэг. Уналт гарцаагүй бөгөөд хэр хурдан унах вэ? гэдгээс эргээд хэр хурдан өндийж ирэх вэ? гэдэг нь шийдэгдэнэ. Тэр ухралт ба уналтын зурвас үед авторитари маягийн (Болгарын ерөнхийлөгч Ж.Желевийнхээр бол фашист байсан ч болно) дэглэм тогтоож

сонгодог капитализм руу шилжинэ гэсэн үзэл бодол байдаг. Үүнийг хэр бодитой болохыг би урьдчилан хэлж мэдэхгүй, ямар ч атугай Орос, ТУХН-ийн зарим оронд хүчээ авч буй хэт үндсэрхэг, их гүрний дээрэнгүй үзэл, түүнийг илэрхийлэгч улс төрийн хүчнүүдийн байр сууриас харахад авторитари дэглэм тогтох бодит магадлал бий болоод байна.

Сонгодог капитализмын хөрс суурь байгаагүй газар бүдүүлэг капитализмын эртний хэлбэр бий болж, мафийг дагуулж, тэр нь цаашлаад гэмт хэрэг, улс төрийн аллага нийгмийн бусад хямралыг араасаа дагуулдаг жамтай. Ийм үзэгдлийг ардчилал засч хүчрэхгүй бөгөөд авторитари буюу цэргийн дарангуйлал тэр үүргийг өөртөө хүлээж болох юм. Яагаад гэвэл тийм орнууд хувийн өмчийг эс тооцвол капитализмын ямар ч үр хөврөл байхгүй коммунизмд шилжсэн байдаг. Тэднийг ардчилал, зах зээлийн жам хууль бус, ямар нэг хаан, цэргийн дарангуйлагч, эсвэл коммунист дарангуйлагч захирч байсан учраас аливаа диктатурт захирагдахдаа амархан, захиргаадуулж байж хөдөлдөг болчихсон байдаг тал бий. Өөрөөр хэлбэл, ард түмэн олон зуун жил ямагт боолын байдалд, барьцааны байдалд явж ирсэн гэсэн үг. Тэд өмнө нь хэн нэгний боол байсан бол коммунизмын үед мөн л төржсөн намын боол болж, хэзээ ч бие хүн жинхэнэ утгаараа байж үзээгүй. Коммунизм нь нэг дарлалыг нөгөөгөөр (ганц хүний дарангуйллыг хамтын-намын дарангуйллаар) сольсон болохоос хүний төлөө хийсэн юм тун бага. Бас ямагт өөрийнхөө төлөө амиа аргацаан хөдөлмөрлөж ирсэн хүмүүсийг хэний ч төлөө бус, нийтийн төлөө (нийтийн гал тогоо) гэсэн дадалд хүчээр албадан сургаж, залхуу хойрго, хөдөлмөрийн бүтээмжгүй болгосноос гадна эдийн засгийн хөшүүрэг, эдийн засгийн сонирхол гэж огт байгаагүй зэрэг олон хүчин зүйл хуучин социалист орнуудын цаашдын хөгжилд нөлөөж байна. Энд бичсэн зүйл Румын, Болгар, Албани, хуучин Югославын хоцрогдсон зах хязгаар - Черногор, Косово, Македони, ТУХН-ийн зарим улсын амьдралаар нотлогдсоор байна.

Ийм бэрхшээлүүдээс үүдэн Төв болон Дорнод Европын орнууд нийгмийн хөгжлийн ирээдүйн загвараа янз янзаар төсөөлж байгаа юм. Эдэнд үлгэр болох хамгийн ойрын жишээ нь Скандинавын социализм болж байх шиг байна. Ажилчны хөдөлгөөний түүхэн уламжлалтай, социализмын олон элементийг агуулсан байдал нь ингэж даган дууриах нөхцөл юм. Унгар, Болгар, Словак, Польшид засгийн эрх зүүний хүчин, социалистуудад шилжсэний нэг шалтгаан үүгээр тайлбарлагдана.

Угаасаа эдийн засгийн суурь муутайгаас хямрал газар авах тусам төрийн зохицуулалтыг илт үгүйлж, улс төрийн ардчиллаа хойш нь тавих гэсэн бас нэг загвар бий болж байна. Энэ загварын сонгодог жишээ нь, Дундад Ази юм. Тэдэнд Өрнөд Европ гэхээсээ Арабын баян орнууд болон Хятад даган дууриах баримжаа нь юм. Дундад Азийн орнууд улс төр-гадаад бодлогын хувьд Европын

бүтцэд нэгдсэн боловч эдийн засгийн хувьд энэ бүс нутагт нэгдэж, ядаж дөхөж очих үндэслэл тун бага байна. Орост ч төрийн хатуу зохицуулалт, ерөөсөө хатуу гар хэрэгтэй байгаа тухай их ярих болов. Ингэхэд Украин, Белорусс, Молдов, Кавказын улсууд эднээс дээрдэх баримжаатай болчихсон, хөгжлийн загвараа сонгочихоод байгаа хэрэг биш л дээ.

Чехословакийн задрал

Би энд хуучин социалист байсан хоёр орныг жишээ болгоё. Түүний эхнийх нь нэгдмэл байсан энэ улс юм "Хүйтэн дайныг" төгсгөлд Төв Европт тохиолдсон олон улсын анхаарал татах үйл явдал бол холбооны энэ улсын тайван задрал билээ. Өмнөх бүлгүүдэд ЗСБНХУ-ын задралыг хангалттай бичсэн бөгөөд хоёр төрлийн энэ задралыг харьцуулж дүгнэлт хийгээсэй гэж үүнийг бичлээ. Бас дараа нь залгаад Югославын задрал ба Балканы хойгийн байдлыг бичнэ.

Чехословакийн холбооны улс Европын улс төрийн газрын зурагнаас арилахдаа түүхэн нарийн түвэгтэй асуудлаа соёлтой, тайван, туйлбартай шийдэхийн жинхэнэ үлгэр дууриалыг хүн төрөлхтөнд үлдээлээ. Энэ дүгнэлт хэт том байж болох боловч хойшид гэрч мэдэх болрохгүй магадлалыг харгалзан ингэж байгаа юм шүү. Энэ хоёр улс 74 жил хамтдаа аж төржээ. Ийнхүү салах үйл явц түүхэн учир шалтгаантай байсан нь мэдээж боловч яг социализм сүйрсний дараа тэгнэ гэх үндэслэл тун бага байсан юм. Энэ хоёрыг түүх бус, өнгөрсөн нийгмийн байгуулалт нь бус, гадны хүч бус, ерөөсөө л улс төрийн олон намын тогтолцоо, ердөө 1992 онд явагдсан хэдхэн үйл явдал салгасан билээ. Хэрэв Чехословакийн Коммунист Нам засгийн эрхэнд тэсч үлдсэн бол ийм явдал тохиолдохгүй байсан.

Чех, Словак хоёр ийнхүү учир зүйгээрээ салахдаа ТУХН-ийн орнууд шиг Зөвлөлтийн өмчийг булаацалдаагүй, Орос шиг ганцаараа ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч гэж хэн нэг нь түрүүлж зарлаагүй, өөр хоорондоо хил гаалийн дайн, эдийн засгийн маргаан дэгдээсэнгүй, үндэстний олонхи цөөнхийн асуудал сэдэсэнгүй. Үүнийг л би соёлтой салалт гэх гээд байна. Хэн нь түрүүлсэн бэ? гэдэг дээр ярих юм бий. Словакийг нэр цохмоор байна. Словакийн төрийн тусгаар тогтнолын тухай меморандум анхлан Братиславаг гарсан. 1992 оны зургадугаар сард Чех, Словак хоёрт нэг зэрэг холбооны парламентын сонгууль явагдахад улс төрийн хоёр өөр нам ялсан. Чехт В.Клаус тэргүүтэй Иргэдийн ардчилсан нам, Словакт В.Мечъяр тэргүүтэй Ардчилсан Словакийн төлөө үндэсний эх оронч хөдөлгөөн тус тус хамгийн олон санхүү авсан. Ингээд тус тусдаа засгийн газар байгуулж, тэр нь үндэсний холбооны улсад багтаж байх үеийн орон нутгийн эрх мэдэлтэй засгийн газар төдий байсан. Үүнээс гадна холбооны шийтгэлтэй газар газар байгуулагдаж, түүнд хоёр талаас адил тэнцүү үйлдвэрлэл

орсон. Гэтэл долдугаар сард Словакийн парламент түрүүлж бүрэн эрхт байдлаа тунхаглаж, үүнээс үүдэн холбооны ерөнхийлөгч В.Гавел огцорчээ. Есдүгээр сард Словакийн Үндсэн хууль батлагдаж, хоёр тал ЧСХБНУ оршин тогтнохыг зогсоох тухай хуулийн төсөл бэлтгэжээ. Уг хуулийн дагуу 1992 оны арванхоёрдугаар сарын 31-нээс тус улс тарах болжээ. Улс тарахаас өмнө Чехийн парламент тус орны Үндсэн хуулийг баталж, Чехийн нутагт засгийн бүх эрхийг авчээ. Ингэх явцдаа В.Клаус, В.Мечъяр нарын хооронд хожмын хамтын ажиллагааны тухай 16 хэлэлцээр байгуулсан нь цаашид үүсэж мэдэх олон асуудлыг урьдчилан зайлуулсан юм.

Гэхдээ бүх юм хэвийн тайван явагдсан гэвэл үнэнд арай нийцэхгүй. Салах санаачилгыг Словак эхлэн гаргасан нь ч санаандгүй зүйл биш. Словакийн удирдагчийн Чехт нэр хүндгүй байсан, ерөөсөө Чехийн аж үйлдвэрийн хүчирхэг бааз, Словакийн хөдөө аж ахуйгаар гол болгосон хоцрогдмол эдийн засгийн хоорондын ялгаа зөрүү, асуудал шийдэхэд чех үндэстэн давамгайлж, голлох үүрэгтэй оролцож ирсэн зэрэг шалтгаан байсан юм. Гол нь хоёр улсын цаашдын хөгжлийн сонгож авах зам харилцан адилгүй. Чех нь хөгжлийн түвшин, газар зүйн байрлал, уламжлалаа дагаад өрнөд рүү тэмүүлэх хандлагатай байхад Словакт нь ТУХН-ийн орнуудтай хамтран ажиллаж реформ хийх бодолтой юм.

Югославын хямрал

Чех, Словакийн соёлтой салалтыг нэг туйл гэж үзвэл нөгөө туйл нь Югослав болох биз ээ. Югославын задрал тус орны коммунист дарангуйлагч Титог нас барах үед л эхэлсэн. Ерөөсөө Тито бол өөрөө Югославын үндэстэн хоорондын зөрчлийн бэлгэ тэмдэг байсан гэхэд хилсдэхгүй. Тито-Кардель-Бакаричийн гурвал бол тус орны нам төр, засгийн ноён оргил нь байсан бөгөөд эд хорват-словенийн элитийг бүрдүүлж, түүхнээсээ өстөн серби-черногорчуудыг өндийлгөхгүй байлаа. Үүнээс үүдэн Европын соёл-иргэншилд илүү ойр, өндөр хөгжилтэй Хорват, Словен хоёр, Туркийн дарлалаас чөлөөлөгдсөн хөгжил дорой хоцрогдсон бөглүүд өмнөдийн улсууд, завсарт нь дундаж хөгжилтэй Серби, Босни тогтсон юм. Энэ тэнцүү биш байдал, үндэстний асуудлыг ганц хүний үзэмжээр шийдэж, хэлмэгдүүлэлт хийсэн зэргээс Югославын өнөөгийн хямралын үндэс тавигджээ. Энэ хямрал бол ганцхан Боснийн дайнаар илэрч байгаа юм биш, нийт энэ том газар нутгийг хамарч, улам бүр архагших шинжтэй болж байна.

Босни-Герцеговин бол ХБНСЮУ задарсны дараа тусгаар тогтнолоо олж авсан дөрөв дэх улс билээ. Үүний өмнө Словен, Хорват, Македони энэ замыг сонгосон юм. Босни дахь үндэстэн ястнуудын хоорондын ноцтой маргааны явцад ийнхүү энэ улс Белградаас тусгаарлажээ. Эндхийн хүн амын олонхи болох

сербүүд нь Сербитэй нийлж шинэ Югославыг байгуулахыг зорьсон бол лалынхан болон хорватууд тусгаар Боснийн төлөө байсан юм. Энэ бол 1991 оны аравдугаар сарын үйл явдал. 1992 он гармагц маргаан чинээндээ тулж, 1992 оны хавар гэхэд тус улсын нутагт Хорват-лалын нэг улс, Сербийн бас нэг улс үүсчээ. Зун гэхэд хорватууд тусдаа Герцог-Боснийн хорватын улс байгуулснаа зарлажээ. Ийнхүү 3 тийшээ харсан салан тусгаарлагчид эхлээд Сараево хот орчим, сүүлдээ нийт Босни даяар тархан байлдсаар дөрөв дэх жилтэйгээ золгоод байна. Сербийн (Белградын) дэмжлэг болон байлдах чадвар, зэвсэг техник, хүн хүчээрээ давамгайлсан сербүүд нутаг дэвсгэрийн 70 орчим хувийг хяналтдаа авчээ. Мөргөлдөөн эхэлсэн ба үргэлжилсэн түүх бол ердөө л энэ. Үүний цаана олон улсын маргааны сэдэв болж буй олон асуудал бий. Олон улсын хамтын нийгэмлэг энэ хямралд татагдан орсон тухайд гэхэд л НАТО түүхэндээ анх удаа НҮБ-ын энхийг сахиулах, хориг арга хэмжээ хэрэгжүүлэхэд оролцож байна. "Хүйтэн дайнаас" хойшхи олон улсын шинэ нөхцөлд шинэ дэг журам тогтоох нэг ёсны дасгал сургууль энэ боллоо. НАТО эндээс нэлээд ч туршлага хуримтлууллаа. Гол нь Европын нутагт дайнаас хойш энэ дайтай зэвсэгт мөргөлдөөн гараагүй. Эндхийн хохиролын гоо хэмжээ нийт ТУХН-д болсон зэвсэгт мөргөлдөөний хохиролоос хол даваад байна. Хэрэв нийт Югославаар авч үзвэл өнөөдөр манай гаригт болж буй мөргөлдөөнүүдийн хамгийн ноцтой нь болох биз ээ.

Югославын холбооны улс задрахыг Серби хүсээгүй бөгөөд энэ хэрээрээ Сербийн засгийн газар шинээр тусгаар тогтносон хөршүүдээ хүлээн зөвшөөгүй юм. Түүгээр ч үл барам салан тусгаарлах гэсэн оролдлогыг Югославын ардын армийн хүчээр дарахыг зорьсон нь олон хүний амь нас бусниулсан, ихээхэн сүйтгэл тарьсан бүс нутгийн дайн дэгдээсэн билээ. Энэ дайн эхлэн Хорватад дэгдэж дараа нь Босни руу халдварласан. Энд байлдаан болсон хоёрхон газрын тухай ярьж байгаа ч хямрал нийт Югославыг доргиулжээ.

Сербид өөрт нь ч үндэстэн хоорондын асуудал ноцтой хэмжээнд хүрээд байна. Боснийн дайнаас үүдэн НҮБ-аас тус орны эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ зарласан нь тус орны нийгэм-эдийн засгийн амьдралыг бүр ч хурцатгав. Ялангуяа үндэстний цөөнхи бөөгнөрөн аж төрдөг Косово, Воеводинад байдал тэсрэх аюултай байгаа төдийгүй түүнд хөрш Албани, Унгар хоёр татагдан орох магадлал улам бүр бодитой болж байна.

Косовод удаан хугацааны турш ийм аюул нүүрлэсээр иржээ. Хэдийгээр энэ хязгаар газар зүйн хувьд Югославын өмнөд халхавч мэт боловч тэндхийн үндэстний бүтэц (хүн амын 90 хувь албаничууд, нийт 2.5 сая албани хүн) Сербийг баярлуулахаар биш юм. Косово ийнхүү албанижиж байгааг зогсоох зорилгоор Белградаас 1989 онд өөртөө засах эрхийг нь хязгаарлаж оноог

хүртэл онц байдал тогтоогоод байна. Мөн удирдлагыг нь хүчээр сольж сербижүүлжээ. Гэтэл түүнийг эсэргүүцсэн албаничууд санал хураалт явуулж бие даасан тусгаар улс байгуулахаа зарлаж, бас нууц сонгуулиар сүүдэр парламент, сүүдэр ерөнхийлөгч сонгожээ. Нөгөө талаас угийн ядуу хоцрогдсон бөглүүд энэ хязгаар эдийн засгийн хувьд тун хэцүү байна. Ажилгүйдэл хэт их, хөрш Босниос үй олон дүрвэгсэд ирж суурьшсан, эргэн тойрон нутаг дэвсгэр-үндэстний өдий төдий асуудал бугшсан зэрэг нь тэсрэх аюултай гэж дүгнэхэд хүргэж байна. Косовод дэгдэх ямар нэг мөргөлдөөн Албанийн оролцоогүй өнгөрөхгүй нь мэдээж. Албани нь салангид буй үндэстнээ нэгтгэхийг өнө удаан жил хүсэн мөрөөдөж ирсэн бөгөөд нутаг дэвсгэрийн асуудлаар Югославтай зөрөлдсөөр байна. Албаничууд их бага хэмжээгээр үндэстний цөөнхи нь болдог Македони, Грек, Болгар, Черногор энд татагдан орохыг үгүйсгэх аргагүй. Черногор бол Сербийн хэзээний холбоотон учраас ардаа дэмжлэгтэй, түүндээ эрдэн Албанийн нутгийн хойд хэсэгт санаархаж байгаа айл юм. Энэ байдлаар Косово нь Балкан дахь мөргөлдөөний нэг голомт болжээ.

Сербийн өөр нэг хязгаар *Воеводинад* үндэстэн хоорондын асуудал хэзээ хэзээгүй мөргөлдөөнд хүргэх дөхжээ. Хэдийгээр эндхийн хүн амын 60 гаруй хувь нь сербүүд ч цаана нь унгар, хорват, словак, румын, украин зэрэг олон үндэстэн ястан оршин суудаг. Гэтэл сүүлийн үед үндэстний бүтэц алдагдаж, мөргөлдөөн болж буй газраас сербүүд үй олноороо дүрвэн ирж суурьшив. Бас Европ руу цувж буй дүрвэгсэдийн цуваа үүгээр дайран өнгөрдгөөс шинэ шинэ бэрхшээл бишгүй тохиолдож байна. Дүрвэн ирсэн сербүүд Белградын засгийн газрын дэмжлэгээр үндэстний цөөнхийн эсрэг (ялангуяа хорват, унгарчуудын эсрэг) дур зоргоороо авирлав. Унгарын засгийн газар арга барахдаа НҮБ-д хандаж Югослав дахь унгар үндэстний эрхийг хамгаалах асуудал тавьсан юм. Энд одоогоор Белградын засгийн газар онцгой эрх эдэлж байгаа боловч хэрэв Югослав сулрах аваас Воеводина нь олон жижиг хэсэг болж задрах аюул бодитой оршиж байна. Энд цөөнхи болж буй жижиг үндэстний цаана Унгар, Хорват, Румын, Словак, Украин бий бөгөөд тэд хэзээ нэгэн цагт эндхийн нутагт өнгөлзөх, эсвэл дотоод хэрэгт нь оролцохыг хэн байг гэхэв.

Үлэмж их аюул учруулж мэдэх бүс нутаг бол *Македони* гэж үздэг. Энэ бол тус орны түүхэн хоцрогдлоос үүдсэн асуудал. Серби дэх гол зах зээлээ алдаж, Грекийн зүгээс бүслэгдсэн (хориг арга хэмжээ) тул эдийн засаг нь бүрэн дампуурчээ. Харин үндэстэн хоорондын зөрчил дэгдэхгүй байгаа шалтгаан нь Серби, Грек, Албанийн сонирхол яг тэнцчихээд байгаад гэж үзэж байна. Үүний сацуу хэзээнээсээ энд хамаатай байсан Болгар хожим тодрон гарч ирэхийг мартаж болохгүй. Турк хэзээний өрсөлдөгч Грекээ сулруулахын тулд Македонид өвөрмөц бодлого явуулж байна. Бүс нутаг дахь Грекийн байр суурийг сулруулах, нөлөөг нь хумих

зорилгоор Турк нь Македонийг хамгийн түрүүн хүлээн зөвшөөрч, НҮБ-д элсэхэд нь хүртэл (Македони нь улсын нэрээ албан ёсоор тогтоогоогүй, төрийн далбаа ч үгүй байхад) дэмжжээ. Ер нь түүх сөхвөл Серби, Македони хоёр л дайн эхлэх шалтаг болж байсан билээ.

Хорватын тухай жич өгүүлэх ёстой. Учир нь эндээс Югославын хямрал эхэлсэн, өнөөдөр ч Боснид шууд хамаатай улс. Асуудлын гол нь бие биеэсээ алслагдсан хоёр хязгаар дээр төвлөрдөг. Энэ хоёр хязгаарт (Славон ба Далмац) сербүүд аж төрдөг, тэд Хорватын нутагт байдаг атлаа Загребын захиргаанд ордоггүй. Тэд Хорватын дотор өөртөө засах эрх эдлэх, улмаар Сербид нэгдэх бодолтой. Гэтэл Ф.Тужманы тэргүүлдэг хорват засгийн газар дан хорватаас бүрдсэн нэгдмэл үндэстний төр улс байгуулахыг зорьдог. Гол зөрчил үүнд л байна. Түүх сөхвөл эндхийн сербүүдийг аймаглан устгаж байсан тохиолдол цөөнгүй. Хэдийгээр хорватын тал энэ бүхний төлөө уучлал гуйж, түүхийн хар цагааныг ялгасан ч эндхийн сербүүд хоёрдугаар сортын хүн гэдгээ мартдаггүй, салан тусгаарлах үзлээсээ ухрах бодолгүй байна. Хорват бол Югославын ардын армиас ихээхэн юм өвлөн авсан улс учраас бусдаасаа илүү хүчтэй. Түүндээ эрдэн 40 гаруй мянган зэвсэглэсэн хорват цэргийг Боснид оруулан дайтуулж байна. Тэд хэдийгээр сербитэй байлдах зорилготой ч заримдаа лалын шашинтнуудтай мөргөлдөж, энэ дайныг 3 талын дайн болгож даамжруулсан бурууг Сербитэй хамт хүлээх ёстой.

ХОЁР. ПОСТКОММУНИЗМ АЗИД

Ази дахь посткоммунист ба одоогоор коммунизмдаа үнэнч байгаа хэдэн улсын тухайд тэгтлээ их юм бичихгүй биз ээ. Тэгээд ч энд коммунизм тэгтлээ хүчтэй нэвтрээгүй, одоо бол үе нь өнгөрч байна. Энд тавхан улсын тухай ярих нь мэдээж бөгөөд энэ 5 улс бүгд өөр өөрийн онцлогт тохирсон хөгжлийн зам сонгожээ. Ардчилсан гэдэг утгаараа Монгол Улс бусдаасаа ялгардаг бол социализмын хүрээнд зах зээлийн эдийн засгийн өвөрмөц хэлбэрийг сонгон авсан Хятад, түүний жишээгээр хөгжиж буй Вьетнам, мөн Лаос, эдгээрийн алийг ч хүлээн зөвшөөрдөггүй зожиг замаар хөгжиж буй БНАСАУ гэж гурав ангилж болмоор мэт. Гэхдээ энэ ангилал бол туйлын ерөнхий, яг ийм тийм гэж ойлгож болохгүй зүйл. Ер нь Азийн өргөн уудам нутагт ардчилсан гэдэг утгаараа эрх чөлөөгөө жинхэнэ ёсоор олж авсан гуравхан орон байдгийн нэг нь Монгол юм. Тус орон нэг намын тоталитари дэглэмийг халж, ардчилсан Үндсэн хууль баталж, коммунизмыг эцэс болгоод одоо зах зээлийн чөлөөт харилцаа руу бэрхшээл

туулан зугуухан урагшилж байна. Энэ онцлогийг Азийн социалист бусад орныхтой адилтгаж болохгүй нь мэдээж.

Хятад, Вьетнам хоёр социалист нийгэм байгуулах зорилгоо өөрийн үндэсний онцлогтойгоо айхтар уялдуулсан төдийгүй эдгээр оронд үндсэрхэг үзэл нь урагш нь хөгжих нэг хөшүүрэг болж байгаа юм. Ер нь "Хүйтэн дайн" дууссанаар Европоос хүчээр тулгасан коммунист догм энэ тивээс бүрмөсөн арилав. Хятад энэ сургаалийг ихээхэн засварлаж, өөрийнхөө үзэмжээр хүлээн авсан улс. Тэр нь их гүрний үзэл, их хан үндэстний үзэл, марксизм, хувьсгалт романтизм, экстремизм зэргийг хольж хутган гаргаж авсан "Мао Зэдуны үзэл санаа" билээ. Вьетнамд коммунист сургааль тэглээ хүчтэй нэвтрээгүй, аль ч социалист оронд байсан шиг үсэгчлэн цээжлэх явдал Вьетнам, Лаосыг тойрч гараагүй. БНАСАУ-ын тухайд огт өөр Тэнд нэг хүнийг тахин шүтэх явдал, үндсэрхэг үзэл, өөрийн онцлогтой социализм байгуулах тухай чучхейн сургааль, утопизм нийгмийн ухамсрыг тодорхойлсоор ирэв.

Үүний сацуу "Хүйтэн дайны" уршгаар гэх үү, ямар ч атугай Москвагийн шууд оролцоотойгоор эдгээр орныг өөр хооронд нь эвдрэлцүүлж мэтгэлцүүлж байсан далдын хүчин зүйл алга болсноор зөрчил нь нэмжиж, ойртож эхэлжээ. Гэхдээ эд өөрийн өвөрмөц нөхцөлдөө тохирсон гаднын найдвартай өмөг түшиг эрж хайж байгаа нь мэдээж. Ялангуяа олон улсын тавцанд ганцаардаж, гарах аргагүй мухардалд орсон сталинч Умар Солонгос ингэхээс өөр зам байхгүй. Тэд Хятадын хоёрдмол байр суурьтай зохицон ажиллаж чадахаа больсон бөгөөд Оросын улс төрийн хүчнүүдээс түнш хайж байгаа нь илт боллоо. Н.Андреева, В.Анпилов, В.Жириновский нар Пхеньяны хүндэт зочноор очсон нь үүний нэг нотолгоо.

БНАСАУ-ын үзэл сурталчдын үзэж байгаагаар, дэлхийн хувьсгалын төв нүүдэллэсээр Ази, Солонгосын хойгт ирсэн бололтой. Энэ төв өнгөрсөн зуунд Өрнөд Европт үүсээд хоёр зууны заагт Орост шилжиж, улмаар дорно зүг тархсаар одоо Пхеньянд төвлөрсөн гэнэ. Дараа нь Номхон далай гатлан Латин Америк руу явах ажээ. Энэ номлол бол зөвхөн солонгосчуудын өөрсдийн нь сэдэж гаргасан зүйл ч биш, үүнтэй Н.Андреева, В.Анпилов нар санал нэг байгаа. Эд бол Оросын коммунистуудын хамгийн хуучинсаг, большевик, сталинч хэсгийг төлөөлсөн улс. 1992 оны хавар коммунист ажилчны 132 намын төлөөлөгч оролцсон томхон уулзалт Пхеньянд зохион байгуулж Пхеньяны алдарт тунхаглал гэгчийг батласан. Тэр тунхаглалд "Империализмын мөхөл хаяанд ирлээ!" гэсэн заалт бий. Энэ тунхаглалд гарын үсэг зурсан ихэнх намын төлөөлөгч нь Андреева мэтийн тодорхой төлөөлөлгүй, улс орондоо ямар ч байр суурь нөлөөгүй, зарим нь хэсүүл тэнүүл улс байсан юм. БНАСАУ-ын удирдлагын коммунист суртлын сонгодог дүр зураг иймэрхүү л байна.

Азийн социалист орнуудыг тойрсон бүс нутгийн шинжтэй элдэв антагонизм "Хүйтэн дайны" төгсгөлөөр эцэс болсон тухай дээр дурдсан. Гэтэл тийм антагонизмыг БНАСАУ зориуд дэгдээсээр байна. Учир нь энэ дэглэмд гаднын зохимол аюул хэрэгтэй, тийм аюулаар далимдуулан ганцаар захирах дэглэмээ бэхжүүлж байх цэрэг, цагдаагийн хүчийг барьж байх ёстой. Ард түмнээ харанхуй манан дунд хуурч мэхлэн саатуулж байх нь энэ дэглэм цаашид удаан тэсч байх гол нөхцөл. Солонгосын хойгоос өөр бүс нутагт ийм антагонизм түүх болон үлджээ. Жишээ нь ивээн тэтгэгч, зоригжуулагч систем нь нурмагц Камбожийн асуудал аяндаа шийдэгдэж, мөнхийн гэж хэлмээр байсан Вьетнам-АСЕАН-ны дайсагналцал алга болжээ. Үнэндээ Вьетнамын коммунизм АСЕАН-ны орнуудад хэзээ ч аюул учруулж байгаагүй, гагцхүү Вьетнамын цаана Москва гэж шордон хатгагч байснаас тийм аюул оршиж байсан хэрэг.

БНХАУ

БНХАУ дахь эдийн засгийн реформ дэлхий нийтийн анхаарал татсан амжилтуудаар дүүрэн хэдий ч бэрхшээл бүтэлгүйтэл дагуулж байгааг хэлэх ёстой. Гадаадын судлаачид Хятадын реформыг дүгнэхдээ хэд хэдэн зүйл дээр тулгуурлаж авч үздэг. Үүнд:

1. Хүн амын хэт өсөлт. Хятадын хүн ам 1 тэрбум 200 саяыг даваад байгаа энэ үед тус орны эдийн засгийн гол гол үзүүлэлтийг энэ тоонд нь харьцуулж үзвэл зарим нэг нааштай үнэлгээ гарна. Энэ олон хүнийг хооллож хувцаслах асуудлыг шийдэж чадсан тэр ухаалаг механизмын тухайд ярьж буй хэрэг.
2. Хятадын өнгөрсөн түүх ба өнөө үеийг харьцуулбал ингэж үнэлэхэд хүрнэ. "Соёлын хувьсгалын" жилүүдэд бүхнийг дайчилж, бүхнийг хэт төвлөрүүлж, улс төрийн хийрхэлд автаад байсан нэг үе, реформ хийсэн өөр нэг үе өөр хоорондоо эрс ялгаатай нь мэдээж.
3. Хуучин социалист байсан Орос болон ТУХН-ийн орнуудтай жишиж үзээд ингэж дүгнэдэг. Оросын хямрал, эдийн засгийн урвуу дэвшил, хүн амын аж байдлын доройтол, гэмт хэрэг, мафийн дүр зургийг Хятадынхтай механикаар холбож болохгүй. Үүнийг нь Хятадын тал ч няцааж элдэв тайлбар тавьдаг.
4. Хүн амын өсөлт нь хэрээс хэтэрсэн Энэтхэг, Өмнөд Азийн орнуудад үлгэр болгох гэж Хятадын реформыг зориуд онцлон авч үздэг тал бий.
5. Дэлхийн худалдааны өнөөгийн байдал Хятадад ингэж анхаарал хандуулах шалтаг болж байна. Хятадын чанар чансаа муутай, хямд бараа АНУ, Өрнөд Европын зах зээл рүү ил далд хэлбэрээр нэвтэрч, их бага алин боловч эрэлт хэрэгцээтэй байгаа нь анхаарал татдаг. Бас Хятадын бараанд гаалийн

хориг тавих гэснээс үүдэн АНУ-Хятадын хооронд худалдааны хэрүүл намждаггүй. Гадаадын нэр хүндтэй пүүсийн барааг Хятадад дууриалган хуурамч шошготой бараа үйлдвэрлэх явдал газар авч байгаа нь хэрүүлтийн шалтаг болсоор байна.

6. Эцэст нь ирээдүйгээ харж Хятадыг их судалж байна. Ирэх 20 жилийн дотор Хятад нь эдийн засгийн хувьд дэлхийн хоёрдахь том гүрэн болж магадгүй гэсэн тооцоо бий. 2010 он гэхэд Японы аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн Хятадынхаас доогуур орж магадгүй.

Энэ бүхэнд үндэслэн Хятадын реформ үр дүнтэй гэсэн ерөнхий дүгнэлт хийдэг бөгөөд дотор нь задалж авч үзвэл өөлөх шүүмжлэх юм хангалттай байгаа. Энд жишээ болгож Хятадын реформын явцыг сүүлийн 5 жилээр авч үзье. Хятадын реформ 80-аад оны дунд үед гайхам амжилт олж байсан. Гэтэл 80-аад оны сүүлээс хямралын эхний шинж тэмдэг мэдэгдэж эхэлсэн юм. Үүнд гадны нөлөөлөл, тухайлбал тэр үед ЗХУ-д өрнөж байсан өөрчлөн байгуулалт халдварлаж эхэлсэн бөгөөд ер нь Хятадад Зөвлөлтийн зүгээс ингэж сүрхий нөлөөлөх юм гэж Хятадын удирдлага бодоогүй байх. 1989 онд Тяньаньмэнийн талбайд болсон нийтэд тодорхой хэрэг явдал Зөвлөлтийн өөрчлөн байгуулалтын замаар орох уу, эсвэл өөрийнхөө онцлогийг хадгалах уу, реформыг либерал хэлбэрээр хийх үү, эсвэл хүнд суртал-захиргааны аргаар хэрэгжүүлэх үү гэдгийн шийдэл болсон билээ.

1989 он гэхэд Хятадын гадаад дотоод бодлогод либерал хандлага илт давамгайлах байдалтай байлаа. Ху Яобан, түүний халааг авсан Жао Зыян нар "Шувууг торонд нь хаших" (энэ нь социализмын хүрээнд зах зээлийг хав барих гэсэн санаа -Зох) тухай ахмад хувьсгалчид, хуучинсаг хүчний (гол төлөөлөгч нь Чэн Юнь) зөвлөлгөөг сөрөн зоригтой шинэчилж байв. Эдийн засгийн заримдаг реформ улс төрийн эрх чөлөө, ардчилалтай хослоогүй цагт заавал сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн ойлголт хятадад газар авч байв. Ийм шаардлага тавьж Тяньаньмэнийн хэрэг явдал дэгдсэн юм. Түүнийг хэрхэн хүлээн авах вэ? гэдгээс Хятадын удирдлага дахь либерал реформист, хуучинсаг хүчний хоорондын тэмцэл шийдвэрлэгдэх ёстой болов. Хятадын удирдагчид сүүлчийнхийг нь сонгон авчээ. Засгийн эрхэнд хуучинсаг хүчний төлөөлөгчид (хэрэг дээрээ Зөвлөлтийн өөрчлөн байгуулалтаас үхтлээ айж балмагдсан хэсэг хүн) гарч ирэв. Мао Зэдуны үзэл санаа мухардалд орж, коммунист суртлыг хэн ч итгэхээ больжээ. Тэд Зөвлөлт ба Дорнод Европт өрнөсөн ардчилсан тайван хувьсгал, шинэчлэлийг Горбачевын санаатай явуулж буй бодлого гэж төсөөлсөн учраас 1989-1990 онд Зөвлөлттэй тогтоосон харилцаагаа түр зогсооход хүрсэн юм. Асуудалд ингэж хандах нь Хятадад юу ч өгөхгүйгээс гадна цаг хугацаа түүнийг хүлээн авсангүй.

1990 оны хавар БНХАУ-ын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн Москвад айлчилж харилцаа сайжрав. Гэхдээ Хятадын тал Зөвлөлтийн удирдлагад нөлөөлөх, Горбачевыг ятгах, ингэснээр социализм руу нь эргүүлнэ гэж гэнэн төсөөлжээ. Тэр ч бүү хэл Зөвлөлтийн удирдлагыг дотор нь зааглан нэг нэгээр нь ятгах гэж оролдсон юм. Жишээ нь Хятадын намын төлөөлөгчдийг дагуулж очсон Динь Гуангэнь дэд ерөнхийлөгч Г.Янаевтай уулзахдаа Горбачевыг шүүмжлэв. ГКЧП-д хожим нь холбогдсон Болдинтой уулзаж, хуучинсаг Полозков, Фалин нарыг Хятадад урьж аваачив. Хятадын удирдлагын энэ бүтэлгүй ажиллагаа 1991 оны ГКЧП-истуудын үймээнийг дуустал үргэлжилсэн юм. 1991 он гараад Горбачевт нөлөөлөх зорилгоор ХКН-ын шинэ удирдагч Зянь Зэмин Дэн Сяопиний даалгаваар Москвад очлоо. Армитай эвсэж дэг журам тогтоохыг зөвлөв. Гэвч хятадын талын ятгалга биелэх үндэс муутай байлаа. Тэр зундаа Хятадын удирдлага Москвагаас нүд салгасангүй. Холбооны гэрээ байгуулах ажил тэдний анхаарлыг зүй ёсоор татжээ. Олон үндэстний нэгдмэл социалист улс тарах нь Хятадын хувьд хүсүүштэй зүйл биш. Гэтэл хятадыг тэнгэр ивээж, наймдугаар сарын үймээн дэгдлээ. Хятадын 15 удирдагч Янаевт баяр хүргэж амжилт ерөөснийг Москва дахь элчин сайд нь гардуулав. Янаев 3 өдөр төр барихдаа гадаадын ганцхан элчин сайдыг хүлээн авсан нь Хятадын элчин сайд байлаа. Үймээн дарагдмагц Хятадын идэвхтэй байр суурь зогслоо. Эндээс эхлэн ЗХУ тарахыг хүртэл Хятадын тал балмагдлын байдалд оров.

ЗХУ-ын задрал Хятадын удирдлагад нэгийг бодогдуулах шиг болов. Бодлого чиглэлээ өөрчлөхийг шаардав. Хуучинсаг хүчний явуулсан хоёр жилийн гадаад бодлого дампуурлаа. Тэд социализмыг хамгаалах гэж гадагшаа бодлого явуулаад нэмэргүй нь харагдлаа. Харин өөрийнхөө социализмыг л хамгаалж байх үлдлээ. Реформоо тууштай хэрэгжүүлж байж л энэ зорилгыг хангана. Хятадын реформ 1989-1991 онд замын бэлчирт тулж зогсов. Тяньаньмэнийн хэрэг явдал хятадын гадаад дотоод байдалд нөлөөлсөн учраас чиглэлээ алджээ. Зөвлөлтийн задралын дараа эргээд хэлбэр дүрсээ олж эхлэв. Дэн Сяопин хуучинсаг хүчинд итгэл хүлээлгээд нэмэргүй нь харагдав. Хоёр жил чимээгүй байсан энэ удирдагч гэнэт ил гарч, эдийн засгийн тусгай бүс - Шэньжэньд очиж реформыг зоригтой үргэлжлүүлэхийг уриалав. Өөрөөр хэлбэл, капиталист маягийн туршилтаа зоригтой хийхийг хятадуудад ятгажээ. Удирдлага дахь хуучинсаг өвгөрсөн нөхдөө зайлуулж эхэллээ. Улсын дарга Ян Шанкунь энэ жагсаалтад эхлээд оржээ.

Эдийн засагт ахиц дэвшил үзэгдэж эхэллээ. Мөнгөний ханшны уналтыг зогсоож, эдийн засгийг тогтворжуулав. Ингээд олсон амжилтаа дүгнэх, цаашдын зорилтоо тодорхойлох зорилгоор 51 сая коммунистыг эгнээндээ нэгтгэдэг ХКН-ын ээлжилт XIV их хурлыг зарлан хуралдуулах боллоо. Энэ их хурал 1992 оны

аравдугаар сард хуралдаж, Хятадад реформ хийсэн 14 жилийн ажлыг дүгнэж, онол-практикийн олон асуудалд хариу өгчээ. Их хурал Хятадад өөрийн онцлогтой социализм байгуулж байгааг нотлохын хамт социализмын эхний шатанд яваа, энэ шат дор хаяад 100 жилийн уйгагүй хөдөлмөр шаардана гэж заажээ. Хятад нь эдийн засгийн реформоо үргэлжлүүлэн, улсын үйлдвэрүүдийг зах зээлтэй холбож, нээлттэй бодлогоосоо ухрахгүй боловч хөрөнгөтний олон намын систем, парламентаризмыг нэвтрүүлэхгүй гэдгээ мэдэгдэв. Тэгэхдээ социализм нь капитализмаас давуутай байхын тулд аж ахуйг хөтлөн удирдах капиталист тэргүүний арга барилаас суралцахыг үгүйсгэсэнгүй. Үүний сацуу хүний эрхийн асуудал бол аль нэг орны бүрэн эрхийн асуудал, түүгээр далимдуулан дотоод хэрэгт оролцохыг шийдвэртэй эсэргүүцнэ гэдгээ мэдэгдсэн байна. Энэ их хурал олон улсын харилцааны шинэ нөхцөл байдал, "Хүйтэн дайны" төгсгөл хийгээд социалист систем, ЗХУ-ын сүйрлийн талаар ямар нэг тайлбар дүгнэлт хийгээгүй. Хийсэн бол нууц байдалд, удирдлагын явцуу хүрээнд хийсэн байж болох юм. Гэхдээ их хурлын материалд ЗХУ, социалист систем задарснаас хойш дэлхийн хувьсгалын хувь заяа Хятадын гарт орлоо гэж дүгнэв үү гэлтэй үг өгүүлбэр олон бий. Тухайлбал, намын үндсэн ниг шугам бол олон зуун жилийн өмнөхийг олж харсан, социализмын эхний шат дор хаяад 100 жил үргэлжлэнэ; нөхөр Дэн Сяопин хятадын онцлогтой социализм байгуулах онол боловсруулахад түүхэн хувь нэмэр оруулсан бөгөөд үүгээр марксизм нь шинэ үедээ орлоо; социализм байгуулах тухай Дэн Сяопиний сургаалиар зөвсэглэсэн нам шийдвэрлэх үүрэгтэй; социализм бол капитализмыг халах зүй тогтолтой; Хятадын онцлогтой социализм байгуулах салбарт олсон гайхамшигт амжилтууд бол дэлхийн социализмын үйл хэрэг, хүн төрөлхтөний дэвшилд оруулсан чухал хувь нэмэр мөн гэхчлэн дүгнэжээ.

Энэ их хурал түрүү түрүүчийн үзэл сурталжсан, ёслолын байдалд болж өнгөрдөг их хурлуудаас нэг их ялгарах юмгүй. Илтгэл хэлсэн үг нь хэт ерөнхийлсөн, программын чанартай, гол төлөв заалтаар дүүрсэн зэрэг нь үнэхээр Хятадын онцлогийг тусгажээ. Хүн төрөлхтний хөгжлийн зүй тогтол хаашаа явж байгаа, өөрсөдтэй нь адил замаар хөгжиж байсан социалист орнууд хэрхэн сүйрэв гэдгээс сургамж авахыг огт бодсонгүй. Бас 100 жилийн дотор социализмын үндэс тавих тухай заалт нь ч хэр бодитой, алсын тооцоотой нь эргэлзээтэй. Зөвхөн зах зээл биш, өөр олон хүчин зүйл нийлж байж тэр баялаг хангалуун, соёлжсон, эрх чөлөөт нийгэмд хүргэнэ. Үүнийг маш ерөнхийлөн бүдүүвчилж, гэнэнээр авч үзсэн байна. Гол нь их хурлын заалт дүгнэлтүүд Хятадын бодит байдалтай хэр авцалдаж байна вэ? гэдгийг сайтар бодох ёстой. Эдийн засагт хувийн секторын өсөлт улсынхаас түрүүлж байгаа ч эдийн засгийн тэнцүү биш байдал улам бүр газар авах төлөвтэй. Микро түвшинд авч үзвэл баярламаар олон тоо

баримт дурдаж болно. Эдийн засгийн тусгай бүс, цагийн хөвөөгөөр оршдог мужуудад эдийн засаг хурдан хөгжиж байна. Гэтэл макро түвшинд нийт Хятадыг хамруулан авч үзвэл хилийн алслагдсан бөглүүд нутгууд үүнээс эрс өмнөө байгаа. Төсвийн алдагдал, гадаад өр өсч байна. Зарим тооцоогоор гадаад өр үндэстний нийт бүтээгдэхүүний гуравны нэг рүү дөхсөн бололтой. Баян өмнөд, ядуу умард гэсэн нэг том зааг, үндэстний цөөнхи оршин суудаг хоцрогдсон хязгаар ба төв гэсэн бас нэг зааг де-факто бүрдээд байна.

Хээл хахууль-хүнд суртал олон түмнийг ХКН-аас аажмаар хөндийрүүлж, улс төр-үзэл суртлаас залхааж байна. Хүн амын өсөлт төлөвлөсөн заагаас давлаа. ХКН-ын XII их хурал хүн амаа 2000 он гэхэд 1 тэрбум 200 сая дээр барина гэж заасан нь даруй 5 жилээр зөрүүлсэн болж таарч байна. Хятадын оюутан залуусын тэн хагас нь социализмыг ойшоохгүй байгаа нь ноцтой баримт. Үндэстний асуудал эмзэг, гадны нөлөө тусч мэдэх Түвд, Шинжаан (магадгүй Өвөр Монгол) хойшдоо яах нь тун бүрхэг байна. Засгийн эрхийн төлөө уламжлалт тэмцэл, нэг хүнийг тахин шүтэх практикийг дахин сэргээх оролдлого, коммунист догм болсон хиймэл суртал, энэ бүхэн нийлээд энэ том орныг хааш нь хөтлөхийг тааж хэлэхэд хэцүү юм.

БНАСАУ

Хятадыг бодвол дэлхийн социализмын сүйрлээс илүү их ноцтой сургамж авсан орон бол Умард Солонгос билээ. Сургамж авна гэдэг нь тоталитари дэглэмээ тогтоон барьж байх тухайд тэр шүү дээ. Хятадад эдийн засгийн реформ хийснээр өлсгөлөнгийн аюулыг арилгаж, ард түмнийг улс төрийн хоосон хийрхлээс холдуулсан. Гэтэл БНАСАУ-д аль алин нь алга. Улс төрийн хийрхэл шинэ шатандаа гарав уу гэлтэй. Уг нь Горбачевын өөрчлөн байгуулалтыг хамгийн түрүүн дэмжсэн орны нэг бол энэ л дээ. Горбачев засгийн эрхэнд гараад түрүүчийн удирдагчдаа эрс шүүмжилж байхад Ким Ир Сенд их таатай байлаа. Солонгос-Зөвлөлтийн харилцааг Хрущев муутгаж, сэргээн хөгжүүлэх талаар Брежнев, Андропов нар юу ч хийгээгүй. Ийм учраас Брежневийн зогсонги үеийг уудлан илчлэх нь Пхеньянд хэрэгтэй байсан юм. Гэтэл Москва - Кремльд "ревизионистууд" гарч ирсэн нь илэрчээ. Ингээд тулгарч болзошгүй байдалд бэлтгэж эхэлжээ. "Албани мэтийн орон 30 жил бүслэлтийн нөхцөлд тэссээр ирсэн юм чинь, жолоодогч Ким Ир Сений удирдлагаар, чучхейн үзэл сандлааар зэвсэглэсэн бид түүнээс ч удаан тэснэ" гэж Ким Чен Ир хэлж байсан. Ингээд Умард Солонгосын удирдагчид Горбачевыг шүүмжилж үнэмлэж оржээ.

Өмнөд Солонгосыг оролцуулан "Азийн баруудтан" түжиг асуудлыг ЗХУКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо 1987 оны эхээр хэлэлцээд, хөрш зэргэлдээ социалист орнууд нь төлөвөрсөн

туршлагыг судлах тухай зөвлөмж гаргасан үед Зөвлөлтийн өөрчлөн байгуулалт Ким Ир Сений дэглэмд адлагдаж эхлэн Албан ёсоор айлчлах тухай урилга авсан Дээд Зөвлөлтийн Тэргүүлэгчдийн дарга, өвгөрсөн большевик А.А.Громнык айлчлалаа товлоод байсан үед огцорч, Пхеньяны голыг харлуулжээ. Зөвлөлтийн удирдлагыг талдаа татах гэсэн эхний оролдлого ийнхүү бүтэлгүйтлээ. Горбачев түүний орыг авах тийшээ очсонгүй. 1989 онд Горбачевыг Бээжинд айлчлах үед БНАСАУ-д айлчлахыг элчин сайдаараа дамжуулан дахин урьсан боловч очилгүй, харин 1991 онд Өмнөд Солонгосын ерөнхийлөгч Ро Дэ У-тай уулзахаар Чезудо аралд очив. Зөвлөлт-БНСУ-ын хооронд албан ёсны харилцаа тогтоох тухай ид ярилцаж байсан 1990 онд хэрэв Ро Дэ У-гийн дэглэмийг зөвшөөрвөл Балтийн Зулсыг БНАСАУ зөвшөөрнө гэж Пхеньянаас Москва руу хоёр ч удаа сүрдүүлэг хийжээ. Тэр үед Москва дахь БНАСАУ-ын ЭСЯ-нд Ким Чен Ирийн захирамж очиж, Зөвлөлтийн удирдагчидтай тогтоосон хэлхээ холбоогоо зогсоохын хамт эдийн засаг - цэргийн тусламж хүртэхийг эрмэлзэх (аль болох их юм салгах гэсэн үг -Зох) чиглэл өгчээ. Үүний сацуу Зөвлөлтөд гарч мэдэх цэргийн аливаа эргэлтийг дэмж гэж зөвлөжээ Ингэхийн тулд эргэлт хийхээр зөхөж байгаа цэргийнхөнтэй ажиллахыг чухалчилсан байна. Үүний дагуу ЭСЯ зарим офицер, генералуудтай нууц харилцаа тогтоож, Горбачевын өөдөөс түлхэж байлаа. 1991 оны наймдугаар сарын үймээн тэдний хувьд эцсийн найдвар болов. Цэргийн хүчээр төрийн эргэлт хийх гэсэн оролдлогод Хятадын нэгэн адил баярлан талархжээ.

Ингээд ЗХУ-ын задрал залгаж, шинээр төрсөн ТУХН-ийн орнууд БНАСАУ-ыг анхаарлынхаа гадна орхиж, бүгд л Өмнөд Солонгос руу хуйлран одох хандлагатай байна. Гэтэл үлдсэн цорын ганц холбоотон Хятад 1992 онд Сеулыг хүлээн зөвшөөрөв. Ингээд БНАСАУ гадаад орчноосоо бүрэн таслагдлаа. Хэдийгээр Өмнөд Солонгос нь Орос, Хятадыг БНАСАУ-аас зориул хөндийрүүлж таслахыг хүсээгүй ч бүх юм аяндаа шийдэгдэв. Уг нь Сеулынхээр бол БНАСАУ тэр хоёр хөрштэйгээ ойр дөт холбоотой байвал тогтвортой байдлыг нэг хэсэгтээ хангаж, ядаж хяналтад байлгаад байх боломжтой. Ингээд хуучин хоёр холбоотон нь тус орны талаар баримтлах чиглэлээ шинээр тогтоохоос аргагүй болжээ 1992 онд Ельцин Сеулд очихдоо, Орос нь хойшид довтолгооны зэвсэг БНАСАУ-д нийлүүлэхгүй ба урьд байгуулсан Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах тухай гэрээний цэргийн холбоотны заалтыг дангаараа цуцалж, харин Орос-БНСУ-ын хооронд цэргийн хамтын ажиллагаа тогтоосон тухай мэдэгдсэн нь Пхеньянд гэнэтийн цохилт болсон юм Хятадын тал ч өнгөн дээрээ БНАСАУ-ыг дэмжсэн байдал үзүүлж, цаанаа цэрэг-улс төрийн салбарт зөвлөлдөхгүй, үзэл суртлын чиглэлээр хоёр Солонгосын маргаанд орохгүй, Умард Солонгост орчин үеийн

зэвсэг техник нийлүүлэхгүй, Өмнөд Солонгос, Умард Солонгост цэргийн аюул учруулаагүйг хүлээн зөвшөөрнө гэхчлэн тодорхой шийтгэл бүхий чиглэл гаргажээ.

Ийнхүү хоёр гол холбоотон нь нүүр буруулснаас үүдэн БНАСАУ дахь ганцаар захирах дэглэм аяндаа хямралд орлоо. Эдийн засгийн гол экспорт хумигдаж, импорт (гол нь нефть, шатахуун) багаслаа. Нүүр буруулсан хоёр гэмтэн, жишээ нь Хятад "Олон улсын коммунист хөдөлгөөн дэх шинэ урвагч" болж, Орос үүнээс дор хараал зүхэл амсч байна. Нурж унасан социализм шингөдог хэлбэрээрээ Солонгосын хойгт л үлдсэн бололтой. Урьд нь залхтал ярьдаг байсан Чучхейн сургаалиа түр хойш тавиад социализм, марксизмыг хамгаалах тухай их ярих болж, онолын өнгөрхөй цоорхойг бөглөх гэж Ким Чен Ир шинэ бүтээлээ туурвиж байна. "Социализм байгуулалтын түүхэн туршлага ба манай намын илэнгэний шугам", "Социализмыг гүжирдэн гүтгэж болохгүй" гэсэн түүний хоёр жижиг ном, Н.Андреевагийн Пхеньянд хэвлүүлсэн "Социализмын үйл хэрэг ялагдашгүй" гэдэг товхимол тус орны коммунистуудын ширээний ном болжээ. Эдгээрт даян дэлхийд социализмыг сэргээн босгох арга заам зааж өгсөн тухай, коммунист хөдөлгөөний өмнө Ким Чен Ирийн байгуулсан их мөчлөлийн тухай, Зөвлөлт ба Дорнод Европ социализмаас урвасан тухай хангалттай бичжээ. Ингэхдээ дээрх орнуудад болсон үйл явдлыг догматик, субъектив байр сууринаас судлахыг оролдсон байна. Гагцхүү хийсэн дүгнэлт нь хэт өрөөсгөл юм.

Энэ бүхнийг угсаа залгамжлах асуудалтай давхцуулан хийсэн бөгөөд энэ үеэр сэжиг бүхий цөмийн программын нууц илэрч, олон улсын харилцаанд бөөн шуугиан дэгдээсэн билээ. Энэ шуугиан хийгээд дээрх онолын бүтээлүүд Ким Чен Ирийн байр суурийг бэхжүүлэх зорилго агуулсан гэж үзэж байна. Ингэж байж л ганцаардсан, түгжигдсэн энэ дэглэмийг олон улсын тавцанд хүлээн зөвшөөрүүлнэ.

Цөмийн программын тухайд бол энэ асуудалд олон улс татагдан орсон. Холбоотон - БНСУ-ынхаа аюулгүй байдал хийгээд Зүүн Азийн байдалд ноцтой сэтгэл түгшиж буй АНУ хамгийн идэвхтэй хүч чармайлт тавьж байна. Хэрш Япон, Орос, Хятад, НҮБ ба Олон улсын атомын эрчим хүчний агентлаг, эцэст нь Өмнөд Солонгос энэ асуудлын гадна хоцрох ёсгүй. Хэрэв түүх сөхвөл энэ асуудлыг эхлэн сэдсэн буруутан нь ЗХУ юм. Умард Солонгост коммунист дэглэм тогтсон цагаас цөмийн судалгааны ажил эхэлжээ. Тэр үед Зөвлөлт өөрөө ураны хүдрийн эрэлд мордоод байсан учраас тийм геологийн ажлыг хамтран хийж, ЗХУ-руу экспортолж эхэлжээ. Солонгосын дайн ид өрнөж байсан 1952 онд атомын зэвсэг хийхийг БНХАУ-аас Умард Солонгост илэрхий уриалан дуудаж байв. Дайн дууссаны дараа солонгосын мэргэжилтнүүд Дубна болон Хятадын Лоб нуурын цөмийн судалгааны төвд дадлага хийж, 60-аад оноос цөмийн зарим

туршилт дээр байлцдаг болов Одоо шуугиулаад байгаа Йонбен (Ненбен гэж бас бичдэг) дэх атомын эрдэм шинжилгээний төв 1964 онд байгуулагдаж, 1965 онд ЗХУ-аас анхны атомын реактороо авчээ. Ийнхүү БНАСАУ өөрийн цөмийн зэвсэг бүтээх эхлэлээ тавжээ. Энд техникийн бусад тоо баримт дурдалгүй олон улсын маргаан болсон талаас нь товчхон өгүүлье.

Тус орон 1977-1993 онд Олон улсын атомын эрчим хүчний агентлагийн хяналтад цөмийн програмаа байлгасан бөгөөд 1985 онд Цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээнд нэгдсэн юм. 1992 онд цөмийн бүх байгууламжаа тус агентлагт шалгуулах үүрэг хүлээжээ. Үйлдвэрлэж буй плутонийн хэмжээг нуун дарагдуулсан сэжиг шалгалтын явцад илэрмэгц 1993 онд тус улс 1968 оны тэрхүү олон улсын гэрээнээс гарах болсноо НҮБ-ын Аюлгүйн зөвлөлд мэдэгджээ. Ингэснээрээ уг гэрээг орхин явсан дэлхийн анхны орон болжээ. Ингэсэн шалтгаанаа Өмнөд Солонгост жил бүрийн хавар болдог АНУ-Өмнөд Солонгосын хамтарсан "Тим спирит" хээрийн сургуулиар тайлбарлаж байгаа боловч хэрэг дээрээ огт өөр зүйлээс болсон гэж үздэг. Юу гэвэл энэ ганцаардсан дэглэм 1993 он гэхэд эдийн засгийн хүнд хямралд орсон нь илэрхий болсон бөгөөд түүнийгээ ч хүлээн зөвшөөрсөн. Эдийн засгийн хямралыг ирийлэх бодит боломж байхгүй тул гаднаас зохиомол бэрхшээл эрж түүгээр ам таглах ёстой. Нөгөө талаас АНУ-аар буулт хийлгэх замаар олон улсын нэр хүндээ сэргээх, улмаар санхүүгийн тусламж хүртэх нэг зам нээгдэнэ. Энд хэдхэн байгууламжийн тухай ярьж буй хэрэг биш, тус орны цөмийн зэвсгийн программ ба тийм зэвсгийг байнд хүргэх дунд тусгалын пуужингуудын тухай, цаашлаад бусад улсад муугаар нөлөөлж заримыг нь өөгшүүлж мэдэх олон улсын далд дипломат бодлогын тухай цогцолбор асуудал яригдана. Тийм учраас асуудлыг дэвэргэж хурцатгахаас өөр зам байхгүй. Тэр ч бүү хэл НҮБ-аас гарах тухай мэдэгдэл хийж үзсэн юм. Байдал чинээндээ тулсан үед АНУ, БНАСАУ хоёр хэлэлцээний ширээнд суулаа. Олон жил АНУ-тай шууд хэлэлцээ хийх гэж зорьсон нь ийнхүү хэрэгжжээ. 1994 оны зургадугаар сард АНУ-ын энхийн элч ерөнхийлөгч асан Ж.Картер Пхеньянд ирж, Ким Ир Сентэй уулзсанаараа цөмийн программын асуудлаар дэгдсэн ээдрээтэй мараанд зуучилсан юм. Ингээд Женев хотод хоёр талын төлөөлөгчид БНАСАУ-ын цөмийн байгууламжуудыг энхийн зорилгоор ашигладаг болгон өөрчлөх техникийн асуудлыг хэлэлцэж эхэлжээ.

Яг ийм эгзэгтэй явцын эхэнд Ким Ир Сен таалал төгсчээ. Дэлхийд хамгийн удаан (1948-1994 он) хугацаанд ганцаар захирах дэглэмийн толгойд суусан хүн ийнхүү өнгөрчээ. Түүний халааг өвлөх, хоосон албан тушаалыг бөглөх асуудал санаснаас ихээхэн удсан нь тус орны дотоод байдлаас үүдсэн хэрэг биз ээ. Ямар ч атугай эрх баригч СХН-ын ээлжит их хурал (1980 оноос хойш) хуралдахгүй удсаныг үзвэл энэ дэглэм дотроо нэлээд хямралд

орсон буюу олон улсын шинэ нөхцөл байдалд нэгэвчлэн байгаагүй байгаагийн нотолгоо мөн.

Куба

Посткоммунист ертөнцийг хамарсан их өөрчлөлт, төлөлт олон арлын жижиг энэ орныг тойрч гараагүй. Куба бэл бэлтгэл үрээс ойлголтоор эрх чөлөөний арал, бөмбөрцөгийн баруун талд империалист хүрээлэлд социализмыг гардан байгуулж буй цэрлэг ганц орон, дөл бадарсан тивийн оч бадраасан ганц төлөлт. Өнөөгийн төсөөллөөр зул нь бөхөж буй ганцаар гэгддэг дарангуйлагч дэглэм, мөхлөө хүлээж буй дэлхийн социализмын сүүлчийн голомт. Энэ дэглэм БНАСАУ-ын нэгэн адил шинэ төлөлт байдалд дасахгүй, дасахыг ч хүсэхгүй байгаа бөгөөд иймд социализмын сүйрлийг зүй тогтлоороо тохиосон гэж үздэггүй. АНУ-ын тагнуулын төв газрын оролцоотойгоор Горбачев, Ельцин нар хийсэн ялт хэрэг мэт үзэж байна. Кастрогийн өөрийн нэгжигдэж, социализмын амь насанд халдсанаас бус, устаж үгүй болохгүй социализм мөхөх нь болоод мөхөөгүй, удирдагчид нь бололт үл төрийн намууд нь түүнийг хамгаалах чадваргүй болсон учраас социализмыг ар нуруу руу нь хутгалан хөнөөсөн ажээ. Хямрал Солонгост ч мөн ингэж үздэг.

Ивээн тэтгэгч -ЗХУ болон ЭЗХТЗ-өө алдсанаас хойш Каривали тэнгис дэх арлын жижиг энэ орон эдийн засгийн тавралт нэрвэгджээ. Хямрал гүнзгийрч улс орноо урьдын адил авч явах боломж хумигдлаа. Ард түмнийг хувьсгал, социализмын гүхэн хоосон лоозонгоор хуурч байх бололцоо барагдав. Хямралыг гэтлэн давах, улмаар эсэргүүцлийн давалгаа дэгдээчихгүйн түвшин шинэчлэл хийхийг нөхцөл байдал зүй ёсоор шаардав. Төвлөрсөн төлөвлө-гөөтэй, захиргааны эдийн засгийн тогтолцоо төлөж байсан аль ч оронд тохиолддог тэр үзэгдэл Кубыг дайрчээ. Хатуу валютын орлого эрс хумигдаж, үндэсний мөнгөн тэмдэгт гүйлгээнд хэрэгцээт хэмжээнээсээ хэтэрч, хар зах тэлж, инфляци хяналтаас гарав. Хүнсний үйлдвэрлэл буурч, нишэнгийн үржэлт алдсаны улмаас өлсгөлөнгийн аюул нүүрлэсэн юм.

Кубын 11 сая ард түмэн эдийн засгийн хямралыг өдөр тутмынхаа амьдралд улам бүр мэдрэх болсон үед хожуу ч гэсэн эдийн засгийн шинэчлэл хийхээр болжээ. Технократуудаар захирал газрыг бэхжүүлж, доллар зэрэг хатуу валют куба иргэд эзэмшиж, хориглож байсныг болиулж, аж ахуйдаа гадаадын хөрөнгийг оруулалт хийх, аялал жуулчлал хөгжүүлэх, гадаадын жуулчид хүлээн авахдаа арай зөөлөн хандах алхам хийж эхэлжээ. Мөнгө санхүү, татвар, гааль, мөнгөний ханшны талаар арай зөөлөн хандах алхам хийж эхэлжээ. Мөнгө санхүү, татвар, гааль, мөнгөний ханшны талаар арай либерал бодлого явуулж, хямралын төлөөлөгч гэсэн зах зээлийн механизм бий болгосноор эдийн засгийн өөрчлөлт татна гэж үзсэн юм. Тус орон ЭЗХТЗ-ийн гишүүн болж үүсн

баримталж байсан Зөвлөлтийн загварын хөшүүн, үр дүн багатай эдийн засгийн бодлогоосоо ийнхүү аажим ангижирч эхэллээ. Бас гаднаас өөр холбоотон хайх, Зөвлөлт болон социалист хамтын нөхөрлөлийн эзэлж байсан орон зайг хэн нэгнээр бөглүүлэх замаар холбоотонтой болж, улмаар тэдний ивээлд багтах гэж оролджээ.

Тэр холбоотноор нь БНХАУ тодорсон нь гайхалтай. Учир нь Хятад олон жилийн турш Кубын суртал нэвтрүүлгийн хараал зүхлийг амсаж, хангалттай зэмлүүлсэн билээ. Өмнөх үеийн тэр суртлаар бол Хятад - кубын хооронд ах дүүсэг харилцаа хэзээ ч тогтохгүй юм шиг байсан. Мэдээж энд үзэл суртал нөлөөлсөн нь дамжиггүй. Гэвч эргээд гуйлга гуйна гэдгээ тооцоогүй. Түүнийг урьдчилан харах чадвар дутсан. Ингээд Хятадын маоизмын эсрэг хатуу бодлогоосоо 180 градус эргэжээ. Хятад - Кубын хооронд тасраад удсан дээд хэмжээний хэлхээ холбоо сэргэлээ. 1993 оны намар АПЕК-ийн (Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага) дээд хэмжээний уулзалт АНУ-ын Сиэтл хотод болсны дараа түүнд оролцсон БНХАУ-ын дарга, ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Зян Зэминь албан ёсны айлчлал хийхээр Гаванад очив. Түүнийг яг л Брежнев, Горбачев нарыг хүлээн авдаг дайтай хүлээн авч, Брежневийг шагнасан төрийн дээд шагналаар шагнажээ. Үүний хариуд Хятадын зүгээс Кубын эдийн засагт дэмжлэг үзүүлэх, экспортын бүтээгдэхүүнийг худалдан авах, худалдаа хөгжүүлэх зэрэг амлалт өгсөн байна. Хямрал гүнзгийрч, дэлхийн олон нийтийн зүгээс эрс шүүмжлүүлэх болсон үед энэ айлчлал Кубад аврал мэт байлаа. Энд Куба, Хятад хоёрыг ойртуулах бодит хүчин зүйл байгааг бас олж харах хэрэгтэй.

Куба нь олон намын тогтолцоо, сөрөг үзэл бодлыг үл тэвчдэг, хүний эрхийг үл хүндэтгэдэг бөгөөд Хятадын нэг адил коммунизмын ялалтад догматикаар итгэдэг. Харин холимог зах зээлийн эдийн засгийг байгуулах талаар ихээхэн хөшүүн хандаж байгаа. Тэгээд ч Хятадын эдийн засгийн реформыг тухайн цагтаа "Улаан туг мандуулсан жинхэнэ капитализм" гэж зүхэж байсан. Одоо хүссэн хүсээгүй эдийн засгийн шинэчлэлийн босгонд тулж ирлээ. Үүнд нийгмийн систем, коммунист намын эрх дархыг хөндөхгүй реформ хийсэн Хятадын туршлага чухал юм. Хятадын төрийн тэргүүний тэрхүү айлчлал Хятад-АНУ-ын харилцаанд мөн хамаатай. АНУ олон жилийн турш Кубыг эдийн засгийн талаар бүслэн хаах, ганцаардуулах бодлого явуулж байна. Тухайн цагтаа Хятад ч үүнд тэгтлээ дургүйцдэггүй байсан. Гэвч одоо, дэлхийн социалист систем сүйрсний дараа Кубыг дэмжихээс өөр аргагүй бөгөөд тэгж дэмжиж байгаагаа нотлохын тулд АНУ-аас шууд Куба руу очсон ажээ.

Куба нь Хятадаар суларсан орон зайгаа бөглүүлэхийн сацуу Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, испани хэлтэй орнуудын эвслээр мөн ийм үүрэг гүйцэтгүүлэх бодолтой байна. Куба нь ЭҮНХ-д

уламжлалт байр суурьтай байсан. Гэвч энэ хөдөлгөөний заяаны жишээ болсон социалист систем үгүй болсон учраас жин нөлөө нь шиндээ багасчээ. Бас уг хөдөлгөөний гишүүн орнуудын хөрөнгийн үзэл суртлын ялгаа зөрүү арга болж, эдийн засгийн хэн хэнши нь ялгаран товойх болсон учир хямралд нэрвэгдсэн Куба нөлөөгөө алдаж байна. Испани, Португал болон Латин Америкийн нийт 23 оны төр, засгийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтад Куба оролцож, төгсгөлийн баримт бичигтээ Кубын талаар худалдааны хориг тавьсан АНУ-ыг шүүмжилсэн үгс оруулж байсан цаг саяхан. Түүнийг Кубын ятгалгаар хийж, тэр үед Кастро ялагч мэт байлаа. Гэтэл түүнээс хойш Кубын байр суурь энэ хүрээлэлд байссаар бараг гадна нь гарчээ. Ялангуяа Гаитид цэргийн дэргэдүлэгч дэглэмийг зайлуулсны дараа энэ тивийнхэн бүгд л Кастрог шүүмжилж байна. Гаитийн хямралыг зохицуулсны дараа Америк тивийн орнуудын дээд хэмжээний уулзалт АНУ-д болох үед Кубын удирдагчдыг урьж оролцуулаагүй. Учир нь хуралд оролцогчдынхоор Кастрогийн дэглэм бол ард түмнээсээ цонгогдоогүй гэж үзжээ. Ийм дээрээ тултал ганцаардаж байхад Кастро АНУ-тай хэл амаа ололцох талаар хатуу байр сууриа зөвлүүлэхгүй мугуйдаар зүтгэсээр байна. Харин ч АНУ-д дүрвэх гэсэн хүмүүст ногоон гэрэл асааж өгснөөр АНУ-аар буулт хийлгэнэ гэж санах бололтой. Гэтэл тэр нь бүтсэнгүй, шийдэх аргагүй олон асуудал, олон улсын маргаан дэгдээжээ. Куба яг ийм ацан шинлаанд орчихоод байна. Цаашид хэрхэхийг цаг хугацаа харуулна. Энэ дэглэм хэр удаан тогтох, тэгэхийн тулд хэр ухаан зарах, эсвэл нлагдлаа хүлээгээд сайн дураараа огцрох хоёрхон л зам үлдлээ.

ГУРАВ. ПОСТКОММУНИЗМ БА КОММУНИСТ ХӨДӨЛГӨӨН

Хэрэв посткоммунизмын хувь заяаны талаар өгүүлж буй бол энэ асуудлыг тойрч гарахгүй нь мэдээж. Ерөөсөө уг асуудлыг цэглээ гэсэн бодол зохиогч надад нэлээн дээхэн төрсөн юм. Уг нь дэлхийн социализм, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөн, үндэсний-эрх чөлөөний хөдөлгөөн нийлээд дэлхийн хувьсгалын 3 том хүч гэгдэж байсан цаг нэг их холдоогүй байна. Эд тус тусдаа олон улсын хуулийн бүрэн эрхт субъект гэж бид үздэг байсан. Тэгж үнэлэгдтэлээ үүрэг гүйцэтгэж байсан гэж бид итгэж явлаа. Гэтэл хэдхэн жилийн дараа газрын гаваар орчих вуу гэлтэй сураг нь тусарчээ. Олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний талаар хэллэлд бичихээ болиод удлаа. Ерөөсөө энэ хөдөлгөөн дэлхийн олон оронд хүн ардын сэтгэлийг эзэмдэхээ больсон бололтой. Үг жинхэнээрээ эзэмдэж байсан эсэх, эсвэл тэгж байна гэж бид өөрсдийгөө хуурч байсан тухайд эргэж бодох асуудал. Дэлхийн 19-

оронд эгнээндээ 90 гаруй сая коммунистыг нэгтгэсэн 100 гаруй нам ажиллаж байсан арваад жилийн тэртээх баримтыг эргэж саная. Энд ЗХУКН, социалист орнуудын эрх баригч намаас хөндийрсэн ХКН ба түүний олон сая коммунистыг оруулж тооцоогүй. Бас зожиг тасархай, троцкист, маоист намуудыг энэ хөдөлгөөний гадна авч үздэг байсан. Хэрэв эднийг бүгдийг нь нийлүүлж тооцсон бол хавьгүй их хүч болох байсан биз. Одоо бол эднийг өөр хооронд нь зааглах буюу зөв бурууг нь тогтоох нь утга алга. Өмнөө тавьсан зорилгоо биелүүлж чадалгүй түүхийн жам ёсоор ухарцгаасан учраас коммунист хөдөлгөөний түүх ухаж, хар цагааныг ялгаж байх шаардлагагүй. 90-ээд онд "Хүйтэн дайн" эцэс болохын хэрээр энэ хөдөлгөөн бүдгэрсээр бүдгэрсээр алга болжээ. Учир нь эднийг ивээн тэтгэж, санхүүжүүлж, араас нь шордон хатгаж байсан социалист систем нурж унасан. Дэлхийн коммунист ажилчны хөдөлгөөний дайчин манлай отряд-социалист орнуудын эрх баригч намууд улс төрийн тавцнаас зайлцгаасан.

Одоо МАХН, ХКН, СХН, ЛАХН, ВКН, ККН, засгийн эрх барьж буй, дээр нь Балбын коммунист нам засгийн эрхэнд хэдхэн сар байсан нь дэндүү алаг цоог эргэж нэгдэх боломжгүй, нэгдлээ ч ямар үнэт зүйлээр нэгдэх вэ? гэх мэт олон бэрхшээл бий болгож байна. Ерөөсөө эднээр нэг отряд бүрдүүлж гэх зоригтон алга. Жишээ нь ардчилал, зах зээлийн харилцаанд эргэлтгүй орсон монголын шинэчлэгдсэн коммунистуудыг (өрнөдөд МАХН-ыг шинэчлэгдсэн коммунист нам гэж үздэг юм билээ -Зох) куба, умард солонгосын утопист фанатик коммунистуудтай адилтгах арга байхгүй. Гэвч энэ нь МАХН эднээс хол түрүүлчихлээ гэсэн үг биш. Ерөөсөө эрх барьж үлдсэн эдгээр орны бүх нам онолын хямралд орчихоод байна. Жишээ нь МАХН шинэ байдалд дасах гэж элдэв суртал руу хальтарч, гол юмаа барьж авч чадахгүй удлаа. Нагаржунайн сургааль, төвч ёсны үзэл, үндэсний - ардчилал, либерал - ардчилал гэх мэт энэ намын удирдагчдын ярьдаг олон үзлээс яг аль вэ? гэдэг дээр тогтоогүй байна. Өөрөөр хэлбэл, онолын эрэлд мордоод байна. Уг нь хэлбэр дүрсээ хурдан өөрчилж, зоригтой хөдөлбөл Дорнод Европын хуучин коммунист, өнөөгийн соёлжсон социал - демократ намуудын дайнд хүрчихэж болно л доо. Тэгэх зориг МАХН-ын өнөөгийн удирдлагад алга. Тэгсэн хэрнээ намын гадаад харилцаа хөгжөөд байна гэж гишүүдээ төөрөлдүүлж байдаг. Ингэж нотлох баримт тун бага бий шүү дээ.

Угаасаа коммунист хөдөлгөөний цөм нь ЗХУКН-ыг тойрсон Дорнод Европын эрх баригч хэдэн нам, мөн Өрнөд Европын коммунист хэдэн нам байсан билээ. Эд л задрал хямралд орвол энэ хөдөлгөөн аяндаа ганхана гэж тооцож байсан нь үнэний шалгуураар шалгагдлаа. ЗХУКН-ын суурийг хэн залгамжлав гэдгээс эхлэн ярья. Орост парламентад олон суудалтай Г.Зюганов тэргүүтэй хүчирхэгжиж байгаа нэг нам бий. Гэтэл үүний сацуу

И. Андреева, В. Анпилов нарын тэргүүлдэг өөр хоёр ч нам төрсөн. Эдгээрээс гадна иймэрхүү чиглэлтэй өөр хэдэн нам төрөх вэ? Гэжэн эгзэгтэй асуудал бий. Оросын өнөөгийн улс төрийн хямрал, шинэ засгийн уналт, бэрхшээл, үндэстэн хоорондын мөргөлдөөн, бүс нутгийн салан тусгаарлах явдлыг ажвал ямар ч нам хөдөлгөөн үүсч мэдэхээр байна. Гол нь эдний цаана зах зээлийн шуурганд уруудаж яваа нийгмийн эмзэг хэсгийн сэтгэхүйгээр тоглох попulist этгээдүүд элдэв хаяг зүүж, жишээ нь коммунист большевик гэх мэт нэрээр гарч ирж буйд хэргийн учир оршиж байна. Эд мөн л социализм хүчээ шавхаад нурж унасан гэж үздэггүй. Горбачев - Ельциний бүлэг АНУ-ын ТТГ-ын дэмжлэгээр түүнийг устгасан гэх маягтай юм ярьж, хуучин ЗХУ-ыг дахин өргээх, энд тэндгүй орос үндэстнийг өмгөөлөн хамгаалах тухай уриалж, гудамжны энгийн үг яриагаар гул барин, олныг араасаа дагуулах санаатай. Ер нь амьдрал дорой газар ардчилал хөгжих суурь бага, харин хуучнаа санагалзах явдал их байдаг бололтой. Энэ утгаар, Дундад Азид олон намын систем одоо болтол хөлөө олохгүй, явагдсан сонгуулиудад гол төлөв хуучин коммунистууд илж байгаа нь тийм учиртай. Намын төлөвшилийн хувьд ЗХУКН-ын өд эс болж байсан Балтийн 3 орны намууд л зөв төрхөө олжээ. Тэд төлөлтөл хүчээр нэгтгэгдэхээс өмнөх социал-демократ үзэлдээ өргөж орсон бөгөөд нийгмийн баримжаа бүхий зах зээлийн харилцаа хөгжүүлэх зорилго тавьсан нь ард түмний дэмжлэг хүлээх үндэс юм. Литва үүний тодорхой жишээ. Харин ТУНХ-ийн коммунист бусад нам нэгдмэл хөдөлгөөн болж төлөвштөлөө ихээхэн зам туулах биз ээ (Бараг л үгүй болов уу).

Дорнод Европт коммунизм нэгэнт улирч одсон тухай дээр өгүүлсэн. Тэгэхээр улирч одсон тэр нийгмийг удирдаж байсан нам өөрөө шинэ байдалд төлөвших ёстой. Тэгж төлөвшсөн сонгодог жишээ бол хуучин УАСН, одоогийн ерөнхий сайд Д. Хорн тэргүүтэй Унгарын социалист нам мөн. Болгарт мөн ийм жишээ болох БСН төрлөө. Германы зүүн хэсэгт сталинч өвөөсөө бүр алсан Ардчилсан социализмын нам хүчтэй болж байна. Польш, Чех, Словак, Румын, Албанид хуучин коммунистууд социалист, социал-демократ болж төлөвших шилжилтийн үедээ байна. Дээр бичсэнээс үзэхэд хуучин социалист орнуудын намуудын ерөнхий дүр зураг тодорхой байна. Эднийг нэгдмэл нэг хөдөлгөөнд нэгтгэж, нэг том отряд болгох боломж байна уу? Ер нь тэгэх гэж оролдох ч хэрэг алга. Гол нь үүнийг ойлгодоггүй буюу төөрөлдөж явна хүн олон байдаг тул үүнээс дүгнэлт хийгээсэй гэсэндээ бичиж байна.

Олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний хоёр дахь том отряд нь тухайн цагтаа капиталист ертөнцөд ажиллаж байлаа. ЗХУКН улс орныхоо үндэстний баллгийн мөн ч их хэсгийг тэдэн рүү урсгасан байх. Сэтгэл санаа эд материалын дэмжлэг гэж түүнийг нэрлэж байсан. Зөвлөлтийн эвслийн бусад орон ч (жишээ нь

БНАГУ) мөн багагүй зардал гаргасан. Гэтэл үр дүн хаа байна вэ? Тэгж тусалж тусалж юутай үлдэв? Хэн ч хариулж чадахгүй мухардуулах асуулт бол энэ. Ер нь түүх сөхвөл капиталист орнууд дахь коммунист намууд Октябрийн үйл явдлын дараахан хоёр зам замаар үүссэн байдаг. *Нэг нь* тэдгээр оронд ажиллаж байсан социал - демократ ба социалист хөдөлгөөн, намууд хоёр хуваагдсанаас зүүний хэсэг нь Москвагийн тал баримтлалын Коминтернийн гишүүн большевик намууд болж салсан, *нөгөө зам нь* Москва - Коминтернийн шууд оролцоотойгоор хувьсгалын экспортлох зорилгоор зориуд бий болгосон ийм хоёр зам юм. Нэгдмэл социал-демократ хөдөлгөөн даян дэлхийн ажилчдын хөдөлгөөнийг удирдаж явсан түүхэн цаг үе бий бөгөөд дэлхийн нэгдүгээр дайны өмнө Ленин тэргүүтэй авантюрист хэсэг нь олонхи болж ОАСДН-д "большеństwo буюу большевик" фракцид төрүүлж, харин социал-демократизмдаа үнэнч хэсэг цөөнхи болж "меньшинство буюу меньшевик" гэгчид үүсчээ. 80 гаруй жилийн өмнөх түүх ухаж байгаадаа хүлцэл өчихийн хамт коммунистууд маань тэртээх дүгнэлтээр өнөөг хүртэл явж ирсэн ба өнөөдөр ч манай оронд МСДН-ыг яг тийм байдлаар ойлгож, хараал зүхлийн амт үзүүлж байна. Илүү ойлгомжтой болгохын тулд сэдвээсээ бага зэрэг хазайчихлаа.

Өрнөдийн коммунист намуудын хувь заяанаас дүгнэлт хийх болов уу гэж үзээд хэдэн баримт оруулъя. Улс орныхоо парламентад зохих суудал эзэлсээр ирсэн, хувьсгалт тэмцлийн баялаг уламжлалтай зарим намыг авч үзье. Эхлээд 1994 онд болсон (1995 онд нэмэлт) Европын парламентын сонгуулийн дүн нэгийг хэлэх байх. Европын холбооны 15 улс төлөөлж буй улсаараа бус, харин улс төрийн намуудынхаа нийтлэгээр суудал эзэлдэг энэ өвөрмөц парламентын тухай дараагийн нэг бүлэгт өгүүлнэ. Энэ парламент 626 гишүүнтэйгээс социал - демократууд ба коммунистууд дээд доод хоёр туйл нь болжээ. Эхнийх нь 29% сүүлийнх нь арваадхан хүнээс бүрдэх зүүний эвслийн дотор 10% суудал авах шиг болов. Гэтэл энэ хсёр туйлын хооронд улс төрийн 9 намын бүлэг байгаа бөгөөд коммунистууд орон нутгийн жижиг намуудын эвсэл, технократууд, тэр ч бүү хэл дөнгөж байгуулагдаад анх удаа өрсөлдсөн Италийн нийгмийн хөдөлгөөн Францын радикалуудын төлөөлөгчдийн ард хоцорчээ. Европын улс түмэн коммунист хөдөлгөөн, коммунизмыг хэр үнэлж тоож байдгийн сонгодог жишээ бол энэ болов уу.

Тодорхой нэг намын жишээн дээр авч яривал энэ бүс нутгийн хамгийн том нам болох Италийн коммунист нам уруудсаар уруудсаар нэг гуужиж, хэлбэрээ өөрчилсөн боловч бараг тараал байна. Тус нам өрнөдийн орнууд дахь 25 намын дотор хамгийн том нь, нийт 3 сая коммунистын тэн хагас нь энэ намд харъяалагдаж байсан цаг бий. Гэтэл коммунизм сүйрч эхлэхийн хамт энэ нам гишүүдийнхээ ихэнхийг алдаж, эгнээ нь сэлбэгдэхээ больж,

ануучууд нийт гишүүдийн гуравхан хувийг эзлэх болсон юм. Италийн парламентын хоёр танхимд нийт 280 гаруй коммунист депутаттай байсан намын тухай ярьж буй хэрэг л дээ. Коммунист намын удирдагч нас барахад Итали даяар үндэсний гашуудал ширлаж байсныг нь ч эргээд бодвол үнэхээр хүчтэй байж дээ. Гэтэл нийт оноос Италид "коммунизмын хямрал" эхэлж, одоо тус орны үндс төрийн амьдралаас коммунистуудыг бүрэн шахан зайлуулаад байна. Коммунист намын суурин дээр үүссэн Зүүний ардчилсан нам (МАХН шиг шинэчлэгдсэн) Европын парламентад өрсөлдөөд нийгдал хүлээсэн тул түүний удирдагч Акилле Оккетто, түүний сонгуулийн холбоотон Ардчилсан холбооны удирдагч бүгд огцорчээ.

Францад 4 коммунист сайд Миттераныг ерөнхийлөгч болсны өмнөхний хэдэн жил засгийн газар сайдаар ажиллаж байсан үе бий. Гэхдээ 44 сайдаас дөрөвхөн нь шүү дээ. Гэвч энэ бол Өрнөд Европтоо анхны тохиолдол байсан. Үүнийг бид их л олзуурхаж билээ. Гэтэл юу болов. Тэр үед Францын 4-5 иргэний нэг нь энэ намын төлөө санал өгч байсан бол 10, түүнээс дээш хүнээс аль нэг нь болж цөөрсөн байна. Испанид байсан олон коммунист намын тухайд бол эднийг ингэж бутаргахад Москвагийн оролцоо байсан бөгөөд ерөөсөө Испани, Итали, Францын намууд ЗХУКН-тай оюул-практикийн олон асуудлаар зөрж, либерал маягийн "Евро-коммунизм" гэгч рүү шилжиж ороод байв. Тэд засгийн эрх хэзээ ч авч чадахгүйгээ ухаарсан төдийгүй Зөвлөлтийн маягийн захиран тушаах сталинч коммунизмаас арга буюу татгалзаж, парламентын хүрээнд тэмцэх замд орсон нь ингэж зөрөлдүүлжээ. Тэмцлийн энэ хоёр замын алийг сонгох, ЗХУКН ба социалист орнуудын намуудтай хэрхэн харилцах гэдгээс үүдэн Шведийн коммунистуудын зүүний нам, Финландын коммунист нам хуваагдаж, өөр олон шалтгаанаар ихэнх нам хуваагдаж задарчээ. Зарим оронд коммунистууд олон нийтийн, сайн дурын жижиг байгууллагаас (жишээ нь пиво сонирхогчдын холбоо гэх мэт) ялгарах юм алга. Европын ахмад, уламжлалт коммунист нам-Их Британийн коммунист нам 60-аад онд 30 мянган гишүүнтэй байснаа цөөрсөөр 10-ээд он гэхэд 7000 болсон, одоо байгаа эсэхийг олж мэдэхэд хэцүү байна. АНУ-ын коммунист нам даргынх нь хэлснээр арваад жилийн тэртээ 20 гаруй мянга байсан (хэрэг дээрээ 10 мянга) гэхэдээ гишүүдийнх нь ихэнх нь ТТГ, Холбооны тагнан мөрдөх Товчооны (ДЯЯ-тай төстэй) туршуулууд байсан нь илэрчээ. Тэгээд ч энэ махан тоог нь хүн амтай нь харьцуулбал 0.000 004 хувь болж байна. Ийм улсад ажилчны ангийн эрх ашгийг хамгаалж, коммунист суртлыг түгээх нь бүү хэл өөрийгөө хэл үггүй авч авна гэх баталгаа байна уу? Тэгээд ч өнөөдөр хөгжингүй өрнөдийн орнуудад коммунист хөдөлгөөнийг хэн төлөөлж байна вэ? гэдэг асуулт тавих нь утгагүй болж байна. "Элсэн дотроос зүү хайхтай

адил" эднийг эрж хайж, олж тогтооно гэвэл зориг мөхсдөх биз ээ? Яагаад ийм байдалд хүрэв ээ?

Олон улсын коммунист ажилчны намууд 1969 онд Москвад, Европын коммунист намууд 1976 Берлинд, Латин Америкийн коммунистууд 1975 онд Гаванад уулзаж зөвлөлдсөнөөс хойш их хугацаа өнгөрчээ. Гэтэл энэ хугацаанд эдэнд уулзаж ярих зүйл байв уу? гэвэл хангалттай байсан шүү дээ. Ядаж социализмын сүйрлийн өмнө ч юмуу, эсвэл Зөвлөлтийн задралын өмнө уулзаж болох байсан. Харин яагаад тэгээгүйг түүхийн жам зүй тогтооно өөрөө хэлээд өглөө. Коммунизм ирээдүйгүй, үл гүйцэлдэх сургаальд үндэслэсэн, оршин байх чадваргүй гэдгээ харууллав. Үүнийг ч тэдгээр хөгжингүй орнуудын коммунистууд аяндаа ойлгох шиг боллоо. Угаасаа ойлгоод биднээс зөвхөн мөнгө салгаж байхын тулд л хуурамч жүжиглэж байв уу, итгэл үнэмшлийнхээ төлөө Хонеккер шиг амьсгал хураатлаа тэмцэв үү? гэдгийг одоо ялгаж салгах нь оройтжээ. Эцэст нь ийм харамсалтай байдалд хүрснийг доорхи хэдэн үндэслэлээр тайлбарлъя. Үүнд:

- Дэлхий дахинд болж буй нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийг зөв үнэлэх мэдрэх мэлмий коммунистуудад дутжээ. Бодит байдлыг хуучин байр сууринаас харж, "Империализм бол капитализмын эцсийн дээд шат мөн" гэсэн ойлголттой хандсан. Лениний зааж үлдээсэн догматик сургаальд социализм бол капитализмын дараах, улам боловсронгуй нийгэм, Тэр утгаар коммунистууд өнөөгийн хөгжингүй капиталист орнуудад социалист хувьсгал ялах цаг зайлшгүй ирэх ёстой мэт гэнэн ойлгож, тэр гэрэлт мөчийг хүлээсээр цөхрөнгөө барав.
- Коммунистуудын нийгмийн гол бааз-ажилчин ангийн чанар эрс өөрчлөгдсөнийг хүлээж аваагүй. Өнөөгийн өрнөд дэх ажилчин анги бол "гинжнээсээ өөр алдах юмгүй" хүмүүс бишээ. Тэд өндөр мэдлэгтэй, оюуны болон биеийн хөдөлмөр хосолсон, амьдрал ахуй нь хангалуун, үйлдвэрлэл зохион байгуулах, ашиг орлого хуваахад оролцдог, амьдралын найдвартай баталгаатай нийгмийн хэсэг юм.
- Коммунистууд нийгмийн тодорхой программгүй, уриа лоозон, тунхаг хэлбэрээр үзэл суртлын ажил хөөцөлдөж байсан нь явуургүй юм. Үүнийг элэг доог хийж, хүндэтгэхгүй байснаар үл барам ажил цалгардуулах, хутган үймүүлэхээс өөр юу ч хийдэггүй гэсэн төсөөллийг олон оронд үлдээсэн.
- Социал - демократуудыг Лениний үеийн нүдээр харсанд том алдаа оршино. Ингэснээр тэднийг өөрсдөөсөө бүрмөсөн холдуулж, хамтран тэмцэгч байх боломж олгосонгүй. Гэтэл энэ хооронд Скандинавын социализм цэцэглэж, Европ, Австрали, Израиль, Шинэ Зеландад түүхэн гавъяатай гэж үнэлэгдэхээр олон зүйлийг чухам тэд л хийж бүтээсэн.

- Дэлхий нийтийн чанартай олон асуудал дэлхийн хувьсгалын үйл хэргээс илүү чухал болжээ. Зэвсэглэлд хяналт тавих, бүс нутгийн мөргөлдөөн, экологийн хямрал, улс орнуудын интеграц, задрал, Умард-Өмнөдийн харилцаа гээд олон асуудал хуримтлагджээ. Эдгээрийг хэдхэн намын эрх ашгийн үүднээс шийдэж болохгүй.
- Эцэст нь дэлхийн социализм түүхэн шалгуурыг давж чадалгүй сүйрч унаснаар тэдний зорин тэмүүлж буй нийгмийн мөн чанарыг ягштал харуулав. ЗХУКН-ын сүйрэл бол олон орны коммунистуудын зүрхийг үхүүлсэн том сургамж болж өглөө.

Энд бичсэн зүйл олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний гурав дахь том отряд гэгдэж байсан үндэсний - эрх чөлөөний намуудын тухай дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагагүй болголоо. Угаасаа тийм хүчтэй нам, хөдөлгөөн байсан эсэх нь ч маргаантай юм. Социалист чиг баримжаа, капиталист бус хөгжлийн зам зөв зүйтэйгээ нотлон харуулж чадаагүйгээс хойш (одоо хөгжлийн ийм замыг сонгон авсан нэг ч улс байхгүй) олон юм бичих хэрэггүй. Зөвлөлт болон түүний эвслийн орнуудтай арай ойр байсан Ангол, Мозамбик, Этиоп, Өмнөд Йемен, Камбож, Никарагуа болон Арабын зарим орны өнөөгийн дүр зургийг харъя. Нмар орон социализмаар замнаж, ямар нам ажиллаж байна вэ? Хариулт байхгүй. Бид зарим үед алан хядагчид, бүс нутгийн жанжлагчид, лалын экстремистуудийг коммунистуудтай зүйрлэж, өндөр шагналаа хайрлаж, зэвсэглэж, турхирч байсандаа хүлцэл өчих ёстой болоод байна. Жишээ нь Монголын төрийн дээд одонгоор энгэрээ мялаалгасан Менгисту Хайле Мариам, Али Насер Мухаммед нар аллага хядлагынхаа төлөө олон улсын шүүхэд шилжих дээр тулсан. Эдний толгойлсон намын тухайд бичих хэрэггүй. Арай дөнгүүр үлдсэн нь социал-демократ үзлийг сонгон авсан Анголын МПЛА, Мозамбикийн ФРЕЛИМО хоёр л байх шиг байна. Бусад нь газрын гаваар оржээ. Сэргэх эсэхийг улирах цаг харуулаг.

Дүгнэлт болгож хэлэхэд, дэлхийн коммунист хөдөлгөөнд өөрийн гэсэн "алтан үе" байсан байх, эсвэл байсан гэж сэтгэлээ хуурч болох юм, гэвч түүхэнд юу хийж бүтээв гэвэл хэлэх юмаар тун ядмаг билээ. Энэ хэрээрээ дэлхийн улс түмэнд үнэлэгдэж, дүгнэгдсэн юм. Тийм учраас оршин байх чадвараа алдаж, сүйрчээ. Харин эднийг 70 гаруй жил үзэл суртлаар хөөцөлдөж, ангийн гэмцлээр хийрхэж явах хооронд эдний ангийн дайсан гэгдэх капиталистууд юу бүтээв. Өнөөдөр дэлхий дээр амьдрал хамгийн хангалуун, баталгаатай газар хаа байна вэ? Хэн хамгийн их тусламж үзүүлдэг хандивлагчид вэ? Хэн даян дэлхийг энх тайвныг сахиулж түүний төлөө цуцалтгүй зүтгэж явна вэ? Энэ бол ухаан сорих асуулт биш. Энэ үүргийг өөртөө авах гэсэн давшилуун санаа өвөртлөөд юу болж хоцров. Коммунизмын үлдээсэн онцгой

нутгийн мөргөлдөөний голомтууд, үндэстэн-ястан, шашны дайсагнал, улс үндэстний хагарал бутрал, хямрал энэ бүхэн дэлхий дахиныг дахин шинэ түгшүүртэй үе рүү түлхэж болзошгүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТИЙН ОРОНД

Агуулгадаа томдох энэ гарчгийн дор бүхнийг урьдчилан харж зөгнөх боломж байхгүй. Тэгээд ч олон орны хувьд одоогийн шилжилтийн зурвас үе тааж хэлэх аргагүй оньсого таавар бий болгосон юм. Бас ямар хэмжүүр, үндэслэл баримтлан цаашдын төлөвөө урьдчилан дүгнэх вэ? гэдэг дээр ч маргаантай байгаа. ТУ ХН-ийн гишүүн орнууд интеграцид нэгдэх гэж ямар их бартаатай зам туулж байгааг бид бэлхнээ харж байна. Бусад бүс нутгийн хувьд эргэж нэгдэх буюу шинээр тийм хамтын ажиллагаа тогтоох гэсэн оролдлого ажиглагдсан. Гэвч бүх юм эхлэлийн шатандаа, тодруулбал эрлийн замдаа яваа болохоор бэлэн жишээ иш татан дурдах боломжгүй. Гарчиг сонгохдоо ирээдүйн төлөвийг нь шууд гаргачихна гэж амлаагүй юм. Гэхдээ боломжийн хэрээр урьдчилан төсөөлөхийг хичээсэн болно. Тэгж төсөөлөхдөө өнгөрсөн хэдэн жилийн түүхэн туршлагаа бас эргэж харах хэрэгтэй болох байх.

1. Эдийн засгийн хувьд посткоммунист орнууд эргэж нэгдэх боломжоо бараг алдчихаад байна. Урьдын ЭЗХТЗ-ийг орлох тэр байгууллагын тухайд шүү дээ. Түүнийг бүрдүүлж байсан орнууд нь эдийн засгийн гэхээсээ улс төр-үзэл суртлын хэмжүүрийг гол болгож, хоорондоо ижил төсгүй 3 тивийн 10 орныг эг. дор хамруулж байсан. Тэсээд, хүрээгээ төлээд байсны учир нь эдийн засгийн хамтын ажиллагаандаа бус, эрх баригч намуудын удирдлагын бодлогод байсан нь нууц биш. 80, 90-ээд оны зааг дээр гишүүн орнуудын улс төрийн амьдрал, эдийн засгийн системд гарсан өөрчлөлтүүд ЭЗХТЗ-ийн үйл ажиллагааг хууль зүйн дагуу зогсоохыг зүй ёсоор шаардсан юм. 1991 оны зургадугаар сарын 28-нд Будапештэд энэ зөвлөлийн чуулганы төсгөсгөлийн 46 дугаар хуралдаан болох үед түүнийг татан буулгах тухай протоколд нийтээрээ гарын үсэг зурж билээ. Түүнээс хойш багагүй хугацаа өнгөрсөн боловч энэ байгууллагын орыг орлуулах талаар хэн ч зориг гаргаж дуугарсангүй. Бие биеэ нөхвөрлөх, харилцан солилцох юм бишгүй байгаа ч хэн хэн нь халгаад ийм байдалтай байна. Энэ юуных вэ? Үүнийг нарийвчлан задлан шинжлэх шаардлагагүй. Тухайн цагт нь эдийн засагчид хангалттай бичсэн Гол шалтгаан бол улс төр-эдийн засгийн тодорхой зарчимд үндэслэж байсан олон үндэстний хамтын ажиллагааны бүтэц үндсээрээ өөрчлөгдсөнд байгаа юм. Өөрчлөгдөх өөрчлөгдөхдөө тэр бүтэц нь цагийн шалгуурыг давж

чадалгүй сүйрч унасан гэх үү, дэлхийн эдийн засгийн өрсөлдөөнд нлагдаж, цаашид оршин байх чадвараа алдсан билээ. Жишээ нь Куба, Вьетнам (магадгүй Монгол) хоёрт энэ байгууллага эдийн засгийн гэхээсээ, улс төрийн ашиг хонжоо өгсөн. Бас ЭЗХТЗ-д нэгдсэнээр энэ мэт ашиг олсон орон байсан бол энэ байгууллагад хүлэгдэж, гадагшаа хамтран ажиллах боломжоо алдаж, эдийн засаг-санхүүгийн хохирол хүлээсэн орон бий. Ингээд үзэхэд ЭЗХТЗ аль ч утгаараа олон улсын, дэлхийн, бүс нутгийн төгс боловсронгуй байгууллага байгаагүй мэт.

Цаашид иймэрхүү чиглэлийн хамтын ажиллагааны ямар хэлбэр байж болох вэ? гэвэл, лав л ингэж 3 тив дамнасан байгууллага гарч ирэх магадлал тун бага (бараг байхгүй). Бүс нутгийн явцуу хүрээнд бий болох магадлал харин бий. Үүнийг ЭЗХТЗ тарж байх үед Төв болон Дорнод Европын орнууд илэрхийлж, шинэ арга зам сүвэгчилж байсан. Тухайлбал, Унгар, Польш, Чех хамтын ажиллагаагаа Дорнод Европоор хязгаарлах санал дэвшүүлж байсан. Тэгэхдээ эндхийн орнуудын хөгжлийн түвшингийн ялгааг олж харах ёстой. Тэд бүс нутгийн хамтын ажиллагааны ийм хэлбэр сонгон авахдаа Монгол, Куба, Вьетнамыг эндээ хамруулахгүй байхаар бүр тэр үед шийдсэн юм. Энэ нь огт туслахгүй гэсэн үг биш л дээ. Гэхдээ урьдын адил бусдаар тэжээлгэж байх боломж үгүй боллоо гэсэн үг. Энэ үг Монгол, Куба хоёрт илүү хамаатай. Вьетнам хэзээнээсээ ЭЗХТЗ-д өөртөө ашигтай хэлбэрээр прагматик хандаж байснаас (дайн шархаа анагаах, Зүүн өмнөд Азид олон улсын байр сууриа бэхжүүлэх, Хятадтай сөргөлдөхдөө дэмжлэг авах) бүс түүнийг тэгтлээ их ойшоож үзээгүй. Тэгээд ч ЭЗХТЗ тармагц эдийн засгийн хямралд оролгүй, зах зээлийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж чадсанаар барахгүй АСЕАН-ы хамтын ажиллагаанд нэгдлээ. Монгол Улсын хувьд ЭЗХТЗ-ийг орлох олон улсын хамтын ажиллагааны шинэ хэлбэр илт үгүйлэгдэж байна. Монголын гадаад бодлогын гурав дахь чиглэлд тус орон АПЕК-ийн байгууллагад элсэн орохыг зорино; бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ гэсэн заалт бий. Энэ бол ойрын үед хэрэгжих амар хэлбэр зүйл биш. Хөршүүд маань манай эдийн засагт хэр нөлөөлөх вэ? Газар зүйн ямар байрлалд байгаа билээ гэдэг бас нэг адармаатай асуудал байгаа.

Энэ бүхнийг эргэж дүгнэвэл, эдийн засгийн хамтын ажиллагааны хэд хэдэн бүс үүсч болох мэт. Жишээ нь Балтийн 3 улс Умард Европын орнуудтай нэгдээд, эсвэл дангаараа хамтран ажиллах эвтэйхэн хэлбэрээ олж байна. Вишеградын орнууд хамтын ажиллагааны нэгэн бүс болох төлөвтэй. Дундад Азийнхан тэр хавьдаа лалын ертөнцтэй нэгдсэн эдийн засгийн бүс байгуулахыг зорьж байна. Орос - Украин, Орос-Белорусс, мөн Орос - казахстаны хооронд өвөрмөц хэлбэрийн интеграц эхлэлээ тавьсан. Вьетнам

АСЕАН-тай эргэлтгүй нэгдэнэ. Аажмаар АПЕК-тэй ойртох байх. Хятад бол хэнтэй ч хамтран ажиллаж чадна. Куба, БНАСАУ хоёр мухардчихаад байна. Ийм л эрээвэр хураавар дүр зураг үлджээ.

2. *Улс төрийн хувьд* посткоммунист орнуудыг нэгтгэх хүчин зүйл, хэмжүүр нэг хэсэгтээ бий болохгүй. Бий боллоо ч олон улсын өөр институт рүү (жишээ нь НАТО, Европын холбоо гэх мэт) хандаж бүс нутгаа дагаж бий болно. Урьд нь Варшавын гэрээгээр (1955 он) цэрэг-улс төрийн эвсэлд нэгдсэн хэсэг улс Европт байсан. Гэвч түүний оньсон түлхүүр, гол чиглэл хуучин БНАГУ дээр төвлөрч байсан нь нууц биш юм. БНАГУ бол Европ дахь Зөвлөлтийн цэргийн гол холбоотон байсан учраас ВГБ зөвхөн энэ холбоотны харилцааг дэмжих, бах бэх ар тал нь болох зорилгоор нөхцөлдөж байсан. Гэтэл тэр харилцаа БНАГУ татан буугдсанаар арилж, 1994 оны Оросын цэрэг Германы нутгийг бүр мөсөн орхисноор ул мөргүй алга болов. БНАГУ татан буугдсаны дараа ВГБ 1991 оны дөрөвдүгээр сард үйл ажиллагаагаа албан ёсоор зогсоосон. Дорнод Европын орнууд Варшавын гэрээг бүгд цуцалж хүчингүй болгосон. ЗХУ тэгэх завдал болоогүй, эсвэл зориуд хүсээгүй. Тэр нь Германд зөвлөлтийн цэрэг үлдсэнтэй холбогдох асуудал. Тийм учраас уг гэрээг ЗХУ тасны дараа ОХУ-ын Дээд Зөвлөл 1992 онд цуцалж хүчингүй болгоход хүрсэн юм. Цэрэг - улс төрийн хувьд Европт хуучин социалист орнуудыг багтаасан хоёр чиглэлийн хамтын ажиллагаа ажиглагдаж байна. Вишеград, Балтийн орнууд НАТО-д нэгдэх, ТУХН-ийн орнууд дотооддоо нэгдсэн аюулгүйн системд нэгдэх хандлагатай байгаа бол Балканы орнууд алмайрлын байдалд орчихоод байна. Балканаас Словен, Хорват, Румын, Болгар улсууд түрүүлж НАТО-руу тэмүүлэх байх. Бусад нь их удна. Куба, Монгол, БНАСАУ, Хятад, Вьетнамын хувьд ингэж ангилан бичээд байх нь утгагүй юм. Угаасаа эд "шуудайд хийсэн үхрийн эвэр" лугаа хэдэн тийшээ харчихаад сөргөлдөөн, зожиг тасархай байдлаар бие биеээ харж байсан. Монгол Улс уг нь ТУХН, Дорнод Европтой холбогдох уламжлал харьцангуй ихтэй. Гэвч өнөөдөр Монголын хувьд Дорнод Европ гадаад бодлогын тэргүүлэх чиглэл биш болжээ. "Эдгээр улстай харилцахдаа өмнөх харилцааны нааштай өвийг бататгахыг чухалчлахын хамт харилцаагаа шинэ нөхцөлд зохицуулан хөгжүүлэх бодит боломжийг харгалзан уян хатан хандана" гэсэн заалт Гадаад бодлогын үзэл баримтлалд байгаа. Улс төрийн ардчилал, хүний эрхийн асуудлаар бид тэдэнтэй оройтож болох авч энэ нь бат бэх хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэх хөрс болохгүй. Ер нь хөгжингүй орнууд эдийн засгийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн посткоммунист орнуудыг дотор нь эрс зааглаж байгаа нь тодорхой юм. Энэ л бидний хувьд байнга анхаарч байх ёстой нэг хүчин зүйл.

Посткоммунист орнууд өөр хоорондын харилцаагаа цоо шинэ маягаар тогтоон хөгжүүлэх эхний шатанд яваа (Жишээ нь ОХУ-ын ГЯЯ-ны сайд ийм байр суурьтай байна -Зох) нь хамтын ажиллагаа

хөгжүүлэхэд учирч буй гол бэрхшээл юм. Ялангуяа Орос, ТУХН-өөс Дорнод Европтой тогтоосон харилцаанд олон юмыг байхгүйгээс эхлэх буюу заримыг нь бүр орвонгоор нь өөрчлөх ёстой болсон юм. Түүхийн хар, цагаан толбуудыг арилгах, үндсэрхэг үзлийг гэтлэн давах, ардчилал, зах зээлийн нийтлэг үнэт зүйлүүдээ нэгтгэх, хий хоосон ярианаас ажил хэрэг рүү орох зэрэг олон асуудлыг нэг тийш болгоогүй цагт бидний хооронд эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагаа бий болохгүй.

Энэ бүлгийн эхэнд шилжилтийн зурвас үеийн туулах зам, хугацааны талаар хүснэгт нийтэлснийг энд дахин давтах хэрэггүй. Тэндээс ажиглалт хийсэн хүнд улс орнуудын хөгжлийн цаашдын төлөв төсөөлөгдөх байх. Тэнд заасан зорилтуудыг хэр биелүүлэв гэдгээр хэн нь удаан хөгжих, хэн нь бусдаа хошуучлахыг эрхбиш цаг хугацаа харуулаад өгнө.

Холбогдох ном, хэвлэл

1. Давыдов.Ю.П, Приходько.О.В, Смирнов.П.Е, УстиноваЕ.В, Югославский кризис: интернационализация или интервенция? "США: экономика, политика, идеология" №8 Август 1993
2. Давыдов В.Ф.Вызов международной безопасности: Северная Корея и ядерное оружие, "США: экономика, политика, идеология" №10 Октябрь 1993
3. О.Богомолов. Россия и Восточная Европа, "Международная жизнь" №1 1993
4. Восточная Европа и Россия (Дискуссия в Совете по внешней политике МИД России) "Международная жизнь" №1 1994
5. Дашдоржийн Баярхүү. Посткоммунизм ба их шилжилт, "Засгийн газрын мэдээ" 1995. 03.25
6. Цзян Цзэминь. Ускорить процесс реформы, расширения внешних связей и модернизации, добиться более значительной победы строительстве социализма с Китайской спецификой (Доклад на XIV Всекитайском съезде КПК) 12.10.1992. Пекин
7. Suh Dae-Sook. North Korea under Kim Jong-il, "KOREA FOCUS" on current topics, 1994, July-August vol.2, No.4
8. Ivan Bernik. The Emergence of Post-Socialist Societies: Structures and Actors (A Preliminary Account) "Contours of A New World", Manila, 1992
9. Zbigniew Brzezinski. The Great Transformation, "The National Interest" Fall, 1993

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ БА ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

4

"7-ГИЙН БҮЛЭГ" ("G-7") БА ДЭЛХИЙН
ЭДИЙН ЗАСАГ

5

ЕВРОПЫН ХОЛБОО

6

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ
"ГУРАВ ДАХЬ ЕРТӨНЦ"

ЦОРОВДУГЭЭР БҮЛЭГ. "7-ГИЙН БҮЛЭГ" ("G-7") БА ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Дэлхийд эдийн засгийн шинэ дэг журам тогтоох тухай их ярьдаг. Гэрриад хэзээ, юунаас эхэлсэн, ямар зорилгоор хэн сэдсэн, хэрхэн шийдвэрлэж ирсэн тухай энэ бүлэгт өгүүлнэ. Эхлээд өрнөдийн (хэрэг дээрээ дэлхийн) эдийн засгийн томхон институт болох "7-гийн бүлгийн" үйл ажиллагааг дэлхийн эдийн засгийн системтэй холбож тайлбарлахыг оролдъё. Монголын хэвлэлд төдийлөн бичиж байгаагүй сэдэв болохын хувьд эхлээд үүх түүхээс нь товчхон өгүүлнэ. Англиар "The group of seven" гэж нэрлэснийг товчлоод "G-7" гэж хэвшсэн, харин Зөвлөлтийн албан ёсны орчуулгад анхнаас нь "Большая семерка" буюу "Их 7", "Том 7" гэж буулгасан байдаг. 90-ээд оноос өмнө бид "7-гийн бүлгийн" талаар тун бүрхэг, ихэнхдээ хэт өрөөсгөл мэдээлдэг байснаас үүдэн дэгс төсөөлөл бий болж, ихэнхдээ анхаарлын гадна үлддэг байв. Манай дипломат ажилтнуудын гарын авлага болсоор ирсэн "Дипломатический словарь" 3 боть номд "Большой семерки совещания" гэсэн гарчиг бий. "Их 7-гийн" гишүүн орнуудын хоорондын империалист зөрчлийг намжаах, дэлхий дахинд капитализмын байр суурийг бэхжүүлэх зорилгоор ийм зөвлөлгөөн хийдэг тухай, ингэж уулзлаа ч оролцогч орнуудын хоорондын хурц зөрчлийг шийдвэрлэж чадахгүй нь харагдаж буй, АНУ-аас ЗХУ-тай сөргөлдөх бодлого баримталснаас түүний дарамтыг түншүүд нь үүрч, түүндээ цухалдаж буй тухай энд бичсэн байдаг. Энэ лавлах номын сүүлчийн хэвлэлд арваад жилийн тэртээ ингэж бичиж байлаа. Өнөөгийн байр сууринаас авч үзвэл ингэж дүгнэсэн нь бодит байдлаас хол зөрнө. Гэвч "7-гийн бүлгийн" талаархи ийм дүгнэлтээ засч залруулсан, асуудлыг бодитой харахыг оролдсон дорвитой ном бүтээл хараахан гарчихаагүй байна. Тэгээд ч Оросын Холбооны Улс уг асуудалд их гүрний байр сууринаас хандах учраас ямар ч ном хэвлэгдлээ гээд тэр бүр монголчууд бидний танин мэдэхүйн хэрэгцээг хангахгүй байх. Бид жижиг буурай орны хувьд "7-гийн бүлгийн" үйл ажиллагааг хөндлөнгөөс ажиглаж байхаас өөр аргагүй. Гэвч тэдний дотор хандивлагчид маань бий. Тэд манай ардчилал, шинэчлэлийн үйл явцыг ажиглаж, дэмжиж байдгийг бодолцон эрх биш наад захын ойлголттой байх ёстой. Миний энд бичих зүйл тийм ойлголт өгөх зорилготой.

НЭГ. "7-ГИЙН БҮЛГИЙН" ҮҮСЭЛ, ТӨЛӨВШИЛТ

Албан ёсны мэдээгээр "7-гийн бүлэг" 1975 онд Рамбуйед (Парисын ойролцоох) үүссэн байдаг. Дээд хэмжээний анхны уулзалт болсон он, газрын нэрээр "Рамбуйегийн клуб" гэж ч нэрлэдэг. Гэхдээ миний ойлгосноор "7-гийн бүлэг" бүрэлдэн бий болох үйл явц дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи түүхэн нөхцөл шалтгаанаар нөхцөлджээ. Энэ бол тодорхой он цаг, газар усны нэр заахгүйгээр үйл явдлын явц дунд нь авч үзэх түүхэн үзэгдэл юм. 1944 онд АНУ-ын санаачилгаар өрнөдийн санхүү-валютын систем үүссэнийг бид мэднэ. "Бреттон-Вудсын систем" ("Bretton Woods system") гэж түүхэнд нэрлэгдсэн энэ тогтолцооны дагуу Олон улсын валютын сан, Дэлхийн банк байгуулагдаж, хатуу валютыг хөрвүүлдэг алт-долларын стандартыг (баталгаа) бий болгосон юм. АНУ Бреттон-Вудсын хэлэлцээрээр нэг унц алтыг 35 доллартай тэнцэхээр хөдлөшгүй тогтоож, илүү эрх дарх эдлэх болсон. Олон улсын төлбөр тооцооны алт - валютын энэхүү тогтолцоо сүүлдээ амьдралын шалгуурыг давж чадаагүй. Учир нь энэ тогтолцоо Бьеннамын дайны үед зөрчилд орж, АНУ валютынхаа нэлээд нөөцийг алдсан. Франц, ХБНГУ, Швейцарын банкинд асар их доллар хуримтлагдаж, АНУ эргээд доллараа алтаар худалдан авах хэрэг тулгарчээ. 1971 он гэхэд америк долларын ханш дөрөвний нэгээр унаж, Бреттон Вудсын хэлэлцээрээр олж авсан илүү эрхээ алдав. Энэ үеэр франц франкийн ханш өсч, доллартай өрсөлдөх хэмжээний болж, алт-франк гэсэн нэг янзын стандарт үйлчилж эхлэв. Францын хуучин колони-Африкийн орнуудад долларын гүйлгээг шахаж, валют солих, төлбөр тооцоо хийхдээ франкийг хэмжүүр болгожээ. Тийм учраас тэр үеийн францын ерөнхийлөгч Шарль де Голлийг Бреттон Вудсыг нураасан хүн гэж үзэх нь хөлгүй байдаг. Энэ мэт хүчин зүйлээс шалтгаалан уг систем хориодхон жил үйлчлээд зогсчээ. Ингээд Олон улсын валютын сангаас олон улсын аливаа төлбөр тооцоог алт-валютын стандартаар хийхээ зогсоож, оронд нь "зээлжих тусгай эрх" гэгчийг нэвтрүүлжээ.

Яг ийм нөхцөл бүрдээд байсан үед 1973 оны "нефтийн хямрал" ("Нефтийн шок буюу нефтийн дайрлага" ч гэсэн яахав -Зох) дэгдэж, тэр үеийн капиталист эдийн засгийн системийг бүхэлд нь донсолгов (Энэ тухай хожим тодорхой өгүүлнэ). Ийнхүү өмнө хуримтлагдсан зөрчил дээр шинэ шинэ зөрчил нэмэгдсэн тул өөр хоорондын эдийн засгийн харилцааг уялдуулан зохицуулах, үнэ ханш, инфляц, эдгээрээс үүссэн ажилгүйдэл, нийгмийн бусад асуудал хэлэлцэх шаардлага хойшлуулшгүй чухлаар тавигдав. Эхлээд энэ асуудлыг шууд төр, засгийн дээд хэмжээнд авч үзэхийг урьтал болгоогүй. Сангийн яамны сайд нар, томхон банкны

ажиргуудын хэмжээнд хэлэлцжээ. Сангийн яамны сайд нарын анхны уулзалт хийх бэлтгэл 1971 онд, АНУ Бреттон - Вудсын хэлэлцээрээр олж авсан эрх дархаа нг алдах үед эхлээд байв. Тийм учраас уг уулзалт "Нефтийн хямралаас" өмнө болжээ. 1973 оны гурвандугаар сард АНУ-ын тэр үеийн Сангийн яамны сайд Ж. Шульцийн урилгаар Их Британи, Франц, ХБНГУ-ын сайд нар (тэдний дотор ирээдүйн дээд хэмжээний уулзалтыг санаачлагчид П. Жискар де Эстен, Г. Шмидт нар) Вашингтонд цуглаж, дэлхийн мөнгөний системийн ирээдүйн төлөвийг хэлэлцжээ. Тэд Цагаан орны номын санд хуралдсан тул "Номын сангийн бүлэг" гэж нэрлэгдэв.

Тэр үед тэдний хэнд нь ч өөрсдийнх нь үүсгэн байгуулсан энэ бүлэг хэтдээ олон улсын эдийн засгийн харилцаанд зонхилох нөлөөтэй институт болно гэсэн итгэл байгаагүй бололтой. Валютын ханшийн хэлбэлзэл (exchange rate) засгийн газрын хяналтын гадна гарч, олон улсын санхүү-бизнес эмх замбраагүй байдалд орох аюул нүүрлээд байсан үед ийм байхаас ч яахав. Хүнд байдлаас гарахын тулд улс орнууд Вашингтоны уулзалтын дараа дор дорос арга саам бодож эхлэв. Мөнгөний ханшны хэлбэлзэл огцом өөрчлөгдөж буйг зогсоох зорилгоор "Арвын бүлэг", "Хорийн хороо" гэх мэт олон улсын бүлгүүд олон улсын санхүү, худалдааг тогтворжуулах арга хэлбэр сүвэгчилж байхад зарим оронд мөнгөний ханшийг үнэ зохицуулаг гээд зөнд нь орхижээ. Өрнөд Европын орнууд хамтран чармайнс дунд тогтворжих эхний шинж тэмдэг мэдэгджээ. Америк болон Өрнөд Европын (Ялангуяа ХБНГУ) хооронд хатуу үгээр бие биенээ хэсэг зэмлэсний эцэст асуудлыг хэлэлцэхийн тулд дахин цугларах болжээ. Гэхдээ Японы Сангийн яамны сайдыг уг уулзалтад нэгдэх хүртэл дэлхийн хэмжээний санхүүгийн асуудлыг тэгтлээ нарийвчлан хэлэлцээгүй юм. "Номын сангийн бүлэг", "5-ын бүлэг" ("G - 5") болон тэлж, 3 талын механизм (АНУ Өрнөд Европ - Япон) бий болжээ. Үүнийг олон улсын харилцаанд "Трилатеризм" ("Trilateralism") гэдэг. Энэ бол зөвхөн дээрхи 5 орны Сангийн яамны сайд нарын хүрээнд бий болсон механизм гэж ойлгож болохгүй. Эдгээр орон 1973 онд "Гурван талын комисс" гэдгийг байгуулж, бүрэлдэхүүнд нь нөлөө бүхий бизнесмен, эрдэмтэн, банкны эзэд зэрэг 200 орчим хүн оруулсан юм. Энэ комисс тогтмол чуулж, засгийн газрууддаа зөвлөмж бэлтгэж, түүнийг нь дээд хэмжээнд хэлэлцдэг уламжлал төгтжээ. Нөгөө талаас энэ комиссыг байгуулж ажиллуулах болон "5-ын бүлэг" бүрэлдэхэд Японы тавьсал чармайлтыг мартаж болохгүй. Юу гэвэл 70-аад оны эхэн үеийн санхүүгийн хямрал, 1973 оны нефтийн хямрал Японы эдийн засаг т гэнэтийн дайрлага болж, улс төрийн бодлогод нь нөлөөлсөн. Тэр үед Япон - АНУ-ын хооронд худалдааны маргаан хүрчигдэв. Энэ маргаан хожим нь худалдааны "дайн" болж даамжирсан. Энэ маргаан байдлаас үүдэн Япон нь ирээдүйн "7-гийн бүлгийн" бүрэлдэхүүнд

тавихад хоцрох ёсгүй байлаа. Тал талаасаа чармайсны эцэст валютын солих ханшийг тогтворжуулж чаджээ. Ямар ч атугай нэгийнх нь ханшийг хэт унагачихгүй, нөгөөгийнх нь ханшийг хэт өсгөчихгүй баланс бариад байхтай болсон бололтой. Гэвч энэ бол түр зуурын шинжтэй, хэврэг үзүүлэлт байсан тул Сангийн Яамны сайд нараас дээш төр засгийн дээд хэмжээнд уг асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх шаардлага зүй ёсоор тулгарчээ. Нөгөө талаас тийм дээд хэмжээнд уулзаж байж санхүүгийн төдийгүй цэрэг - улс төрийн асуудал хэлэлцэх ёстой. Эдгээр асуудлыг хэлэлцэж байж тэдгээр орныг эдийн засгийн хямрал сүйрлээс сэрэмжилнэ. Үүнийг 1973 оны аравдугаар сарын Араб - Израилийн дайн харуулсан. Гурав дахь шалтгаан бол дөнгөж шинээр томилогдсон АНУ-ын ерөнхийлөгч Ж.Форд уг асуудлын гадна байсан гэх үү, өөрөө асуудлын гүнд орж биеэр нөлөөлөх ёстой гэж үзсэнээс дээд хэмжээний уулзалт хийх шаардлага тулгараад байлаа.

Ийнхүү дээд хэмжээнд уулзах бодит нөхцөл 1975 оны зун гэхэд бүрдээд байлаа. Дээр хэлсэнчлэн "Номын сангийн бүлгийн" хоёр гишүүн төр засгийн дээд албанаа дэвшээд байсан нь дээд хэмжээний уулзалт хийх бас нэг боломж болжээ. Гэхдээ эхэндээ уг уулзалтад АНУ-ыг оролцуулахгүй байхаар де Эстен, Г.Шмидт хоёр шийдсэн бололтой. Тэр хоёр Их Британи Японы ерөнхий сайд нарыг урьжээ. Гэвч Японы тал АНУ-ын шинэ ерөнхийлөгчийг оролцуулахыг санал болгосноор 5 орны удирдагчид Парисын ойролцоо цуглав. Үүгээр "7-гийн бүлгийн" институтын эхлэл албан ёсоор тавигдлаа.

Гайхалтай нь энэ уулзалтад Югославыг урьж оруулах тухай яригдаад, коммунист дэглэмтэй гэдгээр уг санал няцаагдсан баримт бий. ЕХН-ийн гишүүн, Өмнөд Европын хамгийн том орны хувьд Италийг урьсан боловч тэр жил парламентын сонгуульд Италийн Коммунист Нам ялчих нөхцөл бүрдсэн тул түүнээс болгоомжлон Италийг бас хойшлуулжээ. Хоёр дахь уулзалтаас Канадын ерөнхий сайд нэмэгдэж, гурав дахиаас нь ЕХН-ийн комиссын ерөнхийлөгч оролцож эхэлжээ. Гэхдээ хаалттай хуралдаанд тэрээр суух эрхгүй. Ийнхүү олон улсын эдийн засгийг зохицуулах нэг том механизм бий болжээ. Түүнээс хойш уг механизм үүргээ гүйцэтгэж байна. Дээд хэмжээний уулзалт жил бүрийн түүн оролцогч 7 оронд ээлжлэн болдог бөгөөд түүнд төр засгийн удирдагчдаас гадна Европын комиссын ерөнхийлөгч (урьд нь ЕХН), оролцогч орнуудын гадаад харилцаа, санхүү, эдийн засгийн сайд нар, томхон банк - санхүүгийн эзэд, зарим тохиолдолд цэргийнхэн, сэтгүүлчид зэрэг олон зуун хүн оролцдог учраас үнэхээр тэр өндөө томхонд тооцогдох үйл явдал болдог. Дээд хэмжээний уулзалтад санхүү-мөнгө, валют, худалдааны асуудал голлон хэлэлцдэг нь мэдээж боловч тухайн цагийн олон улсын уур амьсгалыг дагалдан цэрэг улс төр, аюулгүй байдлын асуудал хэлэлцэх явдал бишгүй тохиолддог юм. Ялангуяа бүс нутгийн

шинжтэй мөргөлдөөний голомтууд (Ойрхи Дорнод) тэдгээрийг зохицуулах асуудал 80-аад онд шинээр нэмэгдсэн. Үүнийг 70-аад оны сүүлээр дэгдсэн "нефтийн хоёрдугаар хямрал" нөхцөлдүүлсэн юм. Иранд шахын дэглэм унаж, лалын хувьсгал ялснаар Персийн булангаас нефть тээвэрлэх явдал саатсан, дараа нь Иран - Иракийн дайн дэгдэж энэ хямрал бүрч даамжирчээ. Энэ бүхэн нь дэлхийн нефтийн зах зээлийг хямрааж, үнийн тогтвортой байдалд нөлөөлжээ. Учир нь 1978 онд Боннд "7-гийн бүлгийн" ээлжит уулзалт болох үед АНУ дотоодын нефтийн үнэдээ хатуу хяналт тогтоох замаар үнийн зөрүүг арилгана гэж ХБНГУ, Япон хоёрт амласан юм. Энэ амлалт тэрхүү хямралаар хөсөрдөх дээр гүлжээ.

Бас 70, 80 оны зааг дээр олон улсын харилцаа бүхэлдээ хүрцадсан (Зөвлөлт Афганистанд цөмрөн орсон, Европуужингийн хямрал, Польшийн хямрал Энэтхэг-хятадын хойгийн байдал гэх мэт) учраас хэлэлцэх хэргийн дотор улс төрийн асуудал томхон байр эзлэх болжээ. Энэ бүхэн "7-гийн бүлэгт" бүтцийн өөрчлөлт хийх, зохицуулах байнгын бүтэц бий болгох, "7-гийн бүлгийг" Европын хамтын нийгэмлэг, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) зэрэг чухал институттэй уялдуулах шаардлага зүй ёсоор дэвшүүлэн тавьжээ. Энэ утгаараа "7-гийн бүлэг" нь дэлхийн чанартай, цогцолбор асуудал хэлэлцэх механизм болох учиртай.

Энд "7-гийн бүлгийн" үйл ажиллагаанд өнгөрсөн 10 жил ямар нөлөө үзүүлснийг дурдалгүй өнгөрч болохгүй. Тэгээд ч түүхэн энэ цаг үе дэлхий дахинд бүхэлд нь нөлөөлсөн. Үнэндээ Зөвлөлтөд тэр үед эхлүүлсэн өөрчлөн байгуулалт, гадаад бодлогын шинэ сэтгэлгээ их үүрэг гүйцэтгэсэн билээ. Зөвлөлт - Америкийн харилцаа аажмаар хэвийн болж, дунд болон ойр тусгалтай пуужингийн асуудлаар харилцан буулт хийж, бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулах талаар Зөвлөлтийн бодлого, байр суурьт нааштай эхлэл гарсан тэр үеэс "7-гийн бүлгийн" уулзалтад шинэ шинэ асуудал дэвшигдэн гарч ирэв. Бас тэдний өөр хоорондын зөрчил намжсан тул (жишээ нь 1984 онд нефтийн үнийг буулгаж чадсан) зөвхөн эдийн засгийн зохицуулалтын асуудал хэлэлцэх нь явцуу болж АНУ, Их Британи, ХБНГУ, Францын удирдагчид санал нэгтгэйгээр дэлхий нийтийн чанартай асуудал хэлэлцэхэд шилжжээ. Шинээр нэмэгдсэн асуудлын дотор Өрнө-Дорнын (Зөвлөлт-Америкийн) харилцаа, олон улсын терроризм, зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих асуудал оржээ. Бас нэг анхаарах зүйл бол Р.Рейган, М.Тэтчер, Ф.Миттеран, Г.Колли нарын улс төрийн зүтгэлтнүүд улиран сонгогдож, улс төрийн тавцнаа алдар хүнд олсноор уг уулзалтын шинж чанарт өөрчлөлт гарав. Чухам энэ үед хэлэлцэж буй асуудлын цар хүрээ, оролцож буй бүрэлдэхүүнээрээ "7-гийн бүлгийн" уулзалт нь дэлхийн томчуулын чуулга уулзалт гэгдэх болсон юм. Өрнөдийн олон үндэстэн

институт ба олон улсын хамтын нийгэмлэгийн хооронд (жишээ нь "7-гийн бүлэг" ба НҮБ) хамтран ажиллах эхлэл тэр үед тавигджээ. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн дотор уг бүлгийн нөлөө бүхий орнууд байсан явдал ч энд нөлөөлсөн байх. 80-аад онд ажиглагдсан бас нэг чухал үзэгдэл бол ХБНГУ, Япон хоёр "7-гийн бүлэгт" АНУ-ын дараа орох хүчирхэг орон болохоо харуулсан явдал юм. ХБНГУ Европт шийдвэр гаргах гол орны нэг болжээ. Европын хамтын нийгэмлэгт Германы эзэлсэн байр суурийг энд хэлж байна. Япон нь Ази-Номхон далайн бүс нутагт мөн ийм эрх дархтай болжээ. Ийм учраас уг бүлгийн дотор "3-ын бүлэг" гэгч бий болж дэлхийн эдийн засгийг жолоодож эхэлсэн нь тодорхой боллоо. Германы Бундесбанк Европын төв банкны үүрэг гүйцэтгэх болж 80-аад оны дундуур Европын валютын ханшийн механизм бий болсноор Герман нь Европ дахь бусад түншүүдээсээ илт ялгарсан юм. 1987 оны аравдугаар сарын "Хар даваа гариг" гэгчээр АНУ-ын долларын ханш илт унаж, ханш нь унасан долларыг Бундесбанк бөөнөөр худалдан авч санхүүгээ бэхжүүлжээ. Бас Японы иен энэ үеэс эхлэн доллартай харьцах ханшаа тасралтгүй өсгөх замаа тавьсан юм. Энэ үеийг "биржийн тэсрэлтийн үе" гэж тодорхойлсон нь уг үйл явдал хэр их нүргээнтэй байсныг гэрч. 1988 оны эхээр "7-гийн бүлгийн" Сангийн яамны сайд нар цуглаж, долларын ханшийн доод хязгаарыг тогтоож, түүнээс хэтрүүлэхгүй байхаар тогтсон юм.

Зөвлөлт болон социалист бусад орон сүүлчийнхээ боломжийг шавхаж, эдийн засаг - нийгэм нь хямралд орсон үед эдгээр орны реформыг дэмжих асуудал "7-гийн бүлгийн" анхаарлын төвд оров. "Хүйтэн дайны" үеийн үзэл суртлын тэмцэл шувтарсан болохоор социалист орнуудын зүгээс тэдгээр орныг шүүмжлэх, ялангуяа эдийн засгийн харилцаа, санхүү-валютын зөрчлийг өөлж, гоочлох явдал арилав. Тэгээд ч олон жилийн турш явуулсан шүүмжлэл, нийгэм-улс төрийн аль байгуулал, аль эвсэл давуутай болох тухай мэтгэлцэл утгаа алдав. Гэвч Зөвлөлтийн хэвлэлд "7-гийн бүлгийг" ангич байр сууринаас авч үзсэн шүүмжлэл 1989, 1990 он хүртэл тасраагүй.

ЗХУ болон социалист бусад оронд болж буй үйл явдлыг ажиглах, энэ талаар байр сууриа зохицуулах, шинээр бий болж мэдэх болзошгүй нөхцөлд хэрхэн дасах, ямар хариу өгөх тухай зөвлөлдөх нь дээд хэмжээний уулзалтын хэлэлцэх хэргийн нэг боллоо. Үнэндээ социалист орнууд, тэдгээрийн олон улсын эдийн засгийн нэгдэл-ЭЗХТЗ дампууралд орсноор дэлхийн эдийн засгийг удирдан жолоодох үүрэг "7-гийн бүлэгт" бүрэн шилжжээ. Гэхдээ ЗХУ болон социалист бусад орноос дэлхийн эдийн засагт эзэлж байсан орон зай, ЭЗХТЗ алга болсноор бий болсон хоосон орон зайн тухай асуудлыг хойшлуулалгүй шийдэх, эдгээр орны реформыг дэмжих зорилгоор "7-гийн бүлгийн" үйл ажиллагаанд ЗХУ-ыг татан оруулах ёстой. Энэ бол дэлхий нийтийн нийтлэг жам,

зах зээлийн чөлөөт харилцаанд дэлхийн томхон гүрнийг татан оруулах тухай асуудал юм. Бас энэ том гүрэн, социалист системээс хөгжиж буй орнуудад эзэлж байгаад алдсан сул орон зайг бөглөх асуудал яригдана. Тэгээд ч 80-аад оны хоёрдугаар хагасаас бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулах эхлэл тавигдмагц шинэ тулгар хөгжиж буй орнуудад заналхийлж байсан дайн мөргөлдөөний аюул аажмаар арилж, харин өр зээл, тусламжийн асуудал босч ирсэн байв. Ийм учраас 80-аад онд "7-гийн бүлгийн" анхаарлын төвд энэ асуудал нэмэгдэж орсон билээ. Ингээд үзэхэд үнэхээр дэлхийн эдийн засгийг бүхэлд нь хамармаар дүр зураг харагдана.

Дорнод Европ дахь коммунизм сүйрч, ЗХУ нийгэм-улс төрийн байгууллын хувьд сүйрэх нь гарцаагүй болсон 1991 онд Лондонд "7-гийн бүлгийн" удирдагчид "Хүйтэн дайны" дараахи анхны уулзалтаа хийжээ. Түүнд Зөвлөлтийн ерөнхийлөгч М.С.Горбачевыг урьж оролцуулав. Түүнийг "7+1" гэсэн томъёоллоор илэрхийлдэг. Тэр уулзалт ирээдүйн ТУХН-д (тэр үед ЗХУ тарах нь тодорхой болсон) үзүүлэх тусламжийн асуудал хэлэлцсэн юм. Үүгээр "8-ын бүлэг" төлөвшин тогтох эхлэл тавигджээ. Түүнээс хойш өнөөг хүртэл Орос, ТУХН-д үзүүлэх тусламжийн асуудал, тэдгээр орныг Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт (GATT), одоо бол Дэлхийн худалдааны байгууллагад байр сууриа эзэлж, дэлхийн зах зээлд хөлөө олоход нь туслах асуудал байнга яригдсаар ирэв. 1992 онд Мюнхен хотод болсон ээлжит уулзалтад ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч ОХУ-ын ерөнхийлөгч Б.Ельцин оролцов. Тэрээр ОХУ-ыг "7-гийн бүлгийн" бүрэн эрхт гишүүн болгох гэсэн хүсэлт тавьсныг өрнөдийн түнш нар нь няцааж харин тусламж хүссэнийг нь хүлээн авчээ. Мөн энэ уулзалтад Европын аюулгүй байдлын асуудал, тэр үед эрчээ авсан Боснийн асуудал хэлэлцэх хэргийн дотор орсон юм. Энэ асуудал мөн л өнөөдрийг хүртэл байнга яригдсаар байна. Энэ мэт худалдаа-эдийн засгийн асуудлаас гадна ТУХН-ийн гишүүн зарим орны цөмийн эрчим хүчний (жишээ нь Украин) асуудал, хүний эрхийг ноцтой зөрчсөн Гаити, Руандын байдал, Палестин - Израилийн эвийн хэлэлцээний үйл явц, лалын фундаментализ-маас сэрэмжлэх, терроризмыг хөхүүлэн дэмжигч орнуудын эсрэг НҮБ-ын хориг цээрийг үргэлжлүүлэх, цөмийн сэжиг бүхий будлианд оролцсон БНАСАУ-ын тухай, хөгжиж буй орнуудыг өр төлбөрөөс хөнгөвчлөх, байгаль орчин гэх мэт дэлхий нийтийг түгшүүлж буй цаг үеийн асуудал хэлэлцдэг болжээ. Энэ жагсаалт юу өгүүлэв гэхээр, "7-гийн бүлэг" нь 1973 онд анх Сангийн яамны 4 сайдын хэмжээнд үүссэн үеийнхээ дүр төрхийг хэдийнэ өөрчилсний нотолгоо болж байна. Тийм учраас "7-гийн бүлгийн" түүх 90-ээд онд төгссөн гэсэн дүгнэлт тааралддаг. Шууд ингэж дүгнэх нь бодит байдалд хэр нийцэх бол. Гэхдээ шинэ нөхцөл байдалд үйл ажиллагааг нь үр бүтээлтэй болгох зорилгоор уг институтын бүтцийг өөрчлөх гэсэн санал бодол байхыг үгүйсгэх ёсгүй. Ялангуяа өрнөдийн эдийн засагчид, эрдэмтдийн лүгд ийм

санал солилцоо, маргаан мэтгэлцэл бишгүй байгаа. Энэ нь доорхи бодит шалтгаанаар нөхцөлдсөн бололтой. Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын институтын үүрэг дахин нэмэгдэв. Учир нь посткоммунист орнууд шинэчлэл реформын хувь заяагаа эдгээр банк сангуудад дантгасан; хөгжиж буй орнуудын ер төлбөр тэдгээр орныг өөрийн эрхгүй эдгээр олон улсын сан, томхон банк руу хандуулсан зэрэг бодит нөхцөл шалтгаан бүрэлдэв. Бас 1992 онд Европын хамтын нийгэмлэгийн Маастрихтын хэлэлцээрт гарын үсэг зурснаар Өрнөд Европын орнуудын интеграцийн үйл явцыг шинэ үе шатанд гаргажээ.

1993 онд Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК) анхныхаа дээд хэмжээний уулзалтыг хийж, 1989 оноос ажиллаж эхэлсэн бүс нутгийн шинжтэй нэгэн том институтыг зарлав. Энэ байгууллагад АНУ, Япон, Канад ("7-гийн бүлгийн" 3 гишүүн) жинтэй байр эзэлж байна. "Хүйтэн дайнаас" хойш бий болсон эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйн хэрэг.

Эцэст нь 1991 оноос "7+1" томъёоллоор жил бүрийн дээд хэмжээний уулзалтад тасралтгүй оролцож буй ОХУ-ын байр суурийг дурдах ёстой. Энд бяцхан түүх сөхье. 1986 онд ЗХУКН-ын XXVII их хуралд тавьсан Төв Хорооны улс төрийн илтгэлд "Орчин үеийн империализмын 3 үндсэн төвийн" тухай, "Гурван хүчний төвийн дотоод зөрчил", "капиталист хүчний төвүүд гарч ирэх тухай" үндэслэл нотолгоотой өгүүлсэн байдаг. Дашрамд хэлэхэд арваад жилийн тэртээ М.С.Горбачевын дэвшүүлсэн тэрхүү "онолын нээлтийг" орлох дүгнэлт ОХУ-д дээд хэмжээнд хэн ч хийгээгүй гээд хэлчихэд айхтар хилсдүүлэлт болохгүй байх.

Харин ч ОХУ-д улам бүр хүчээ авч буй үндсэрхэг, хуучинсаг, коммунист хүчнүүд дэлхийн эдийн засгийн өнөөгийн хөгжлийн явцыг тэртээх "Гурван төвийн" бүдүүвч-лэлээр харж байна уу гэлтэй. Үүнд өнөөгийн Оросын удирдлагын хуучин сэтгэлгээ бас их нөлөөлсөн байж болох юм. Хэдийгээр "империализм", "капиталист" гэсэн нэр хаягийг нь өөрчилсөн ч "7-гийн бүлгийг" харах "Гурван төвийн" тухай ойлголт бүрэн арилаагүй байна.

Европын холбоо, НАТО-г дорно зүг тэлбэл шинэ дайны аюул үүсч магад гэсэн хий хардлага, дэлхийн эдийн засгийн системд өнөөгийн ОХУ зөв байраа олохгүй цаг алдаж, орчин үеийн үйл явцтай алхаагаа нийлүүлж чадахгүй байгаа зэрэг нь хөгжингүй орнуудын дотор Орос өөрөө өөрийгөө ганцаардуулах магадлал төрүүлж байна. Ийм дутагдлаасаа шалавхан салахгүй бол дэлхийн эдийн засгийн дүр төрхийг шинэчлэх үйл явцад тус орон зүй ёсны үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ гэж өрнөдийн түншүүд нь зовинож байгаа нь нууц биш юм.

Дээр бичсэнээ эргэж дүгнэвэл, "7-гийн бүлгийн" үйл ажиллагааг хэд хэдэн үе шат болгон авч үзнэ. Үүнд:

1. 1944-1950- иад оны эцэс хүртэл нэг үе . Энэ үед өрнөдийн (уг улс дэлхийн) санхүү-валютын механизмын үндэс тавигдсан. Гэхдээ давамгайлах үүрэг АНУ-д ноогдож, Европ, Япон нь доонож хөл дээрээ босч байсан цаг. Үүнийг Бреттон-Вудсын систем үйлчлэх бэлтгэл үе гэж үздэг.
2. 1959-1971 он бол энэ систем яг номоороо үйлчилсэн үе. АНУ өрнөдийн болон дэлхийн эдийн засагт нөлөөтэй хэвээр байсан ч Францад де Голль засгийн эрхийг барьснаар тус орны эдийн засаг огцом өсч, алтны нөөц нь нэмэгдэж, дэлхийд байр эзлэх хэмжээнд дөхөж очсон юм. Европиг хүчирхэг өрсөлдөгч бий болсон нь тодорхой боллоо.
3. 1971-1973 онд Франц, ХБНГУ, мөн Их Британи дайны өмнө эзэлж байсан их гүрний статусаа эргүүлж тогтоов. Вьетнамын дайнаар АНУ эдийн засаг - санхүүгийн хувьд суларч, дэлхийн эдийн засагт давамгайлах байр сууриа мөн сулруулсан юм. Москва - Вашингтоны хооронд Япон улс нь зөв байраа олов. 1968 онд Япон АНУ-ын хооронд худалдааны анхны зөрчил үүсэв. Эдгээр байдлаас үүсэн АНУ Бреттон Вудсын системээр олж авсан эрх дархаа алдаж эхэлжээ. Үүнийг засаж залруулах талаар АНУ арга чарга сүвэгчилж хөршүүдээ тандаж эхэлсэн. АНУ санаачлан өөрсө алт долларын баталгааг цуцалж үүгээр Бреттон-Вудсын систем ч тэгсхийгээд зогсчээ.
4. 1973-1975 он. "7-гийн бүлгийн" үйл ажиллагаа Сангийн яамны сайд нарын хэмжээнд эхэлжээ. "Номын сангийн бүлгийн" үе гэдэг. Гэтэл нефтийн хямрал дэгдэж дэлхийн эдийн засагт хүнд цохилт үзүүлэв. Үүгээр дэлхийн санхүү-валют, эдийн засгийг зохицуулах асуудлаар дээд хэмжээний уулзалт хийх бүх нөхцөл бүрджээ.
5. 1975 оноос "7-гийн бүлгийн" эхний 7 жил (албан ёсоор ингэж үздэг) эхэлнэ. Уг эвсэл бүрэн төлөвшиж, дээд хэмжээний уулзалт тогтмолжиж, үүгээр олон улсын эдийн засгийн томхон институт бий болсныг дэлхий дахинд харуулав. Энэ үед өрнөдийн эдийн засаг санхүүгийн механизм шинэ үедээ орсон бөгөөд нефтийн хямралаас үүссэн бэрхшээл, валютын ханшийн хэт хэлбэлзлэлийг зохицуулж чадсан юм.
6. 1982 оноос хоёр дахь 7 жил эхэлж байна. Уг эвслийн бүх оронд засгийн эрх солигдож, өмнөх үеийн удирдагчдын халааг "Рейган - Накасонэ - Коль - Миттеран - Тэтчерийн шинэ эрин үе" авсан байлаа. Бас дэлхий дахины улс төрийн уур амьсгалтай холбогдсон улс төрийн асуудал тэргүүлэх байранд зэрэгцэн гарч ирэв. Тэд байгаль орчин, сансар судлал, терроризм, хөгжиж буй орнуудын өр төлбөр гэх мэт олон асуудал хэлэлцэж шийдэх үүрэгтэй болжээ.
7. 1989 оноос гурав дахь 7 жил нь эхлээд 1995 онд дуусах учиртай. Дэлхий дахиныг цочроосон олон үйл явдалтай "7-гийн бүлэг" тулгарлаа. "7+1" гэсэн шинэ эвсэл бүрэлдэн

төлөвшив. "Хүйтэн дайн төгсгөл болж, Дэлхийн худалдааны байгууллага байгуулагдаж, 1993 онд Швейцарын Давост дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт болсноор "7-гийн бүлэг" түүхийн хувьд төгсгөл болох эхлэлээ тавилаа гэсэн дүгнэлт байдаг. Үүний сацуу эдийн засгийн үүднээс авч үзвэл, "7-гийн бүлэг" жинхэнэ утгаараа дэлхийн эдийн засгийг удирдан зохицуулах үүрэг хүлээв.

8. Эцэст нь дөрөв дэх 7 жилээр нь (1996 оноос эхлэх) энэ институтын ирээдүйг дараагийн зууны эхэн үе хүртэл төсөөлж болох юм. Хэрэв БНХАУ-д улс төрийн таатай нөхцөл бүрдвэл хэтдээ дээд хэмжээний уулзалтад урьж, "9-ийн бүлэг" болгохыг байг гэх газаргүй. Тэгвэл дэлхийн хамгийн гол зохицуулах механизм бий болно. Энэ 9 улс дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг дангаараа гаргах болно (Одоо "7-гийн бүлэгт" 64 хувь ногдож байна). Дэлхийд эдийн засгийн талаар зонхилох, хандивлах, тусламж үзүүлэх, зохицуулах, энх тайвныг сахиулах гол үүрэг эдгээр оронд ногдох бөгөөд олон улсын харилцааны олон талт институтууд энэ хэдийн байр сууринаас ихээхэн хамаарна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ ДЭГ ЖУРАМ.

Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш тогтсон дэлхийн эдийн засгийн системийг өрнөдийн ном хэвлэлд эдийн засгийн шинэ дэг журам гэж нэрлэдэг юм. Олон улсын эдийн засгийн дэг журам ч гэж нэрлэж болно. Энэ системийг АНУ хүчлэж байж тогтоосон хэрнээ эргээд өөрөө нурааж байна гэсэн шүүмжлэл бий. Энэ талаар энд хөндөн бичнэ. Тэгэхээр эдийн засгийн дэг журам гэдэгт:

1. Улс хоорондын валютын харилцааг зохицуулж байдаг олон улсын валютын систем;
2. Нийт дэлхийн хэмжээний худалдааны дэг журам. Өөрөөр хэлбэл олон улсын таваар-мөнгөний үйлчилгээ;
3. Улс хоорондын харилцаанд хэрэгжүүлдэг татварын хууль зүйг тодорхойлдог татвар ногдуулах зарчим багтдаг.

Энэ 3 бүрдэл хэсгээс бүрдэх тэрхүү шинэ дэг журам дайнаас хойш дэлхийн эдийн засагт хэрэгжиж байгаад сүүлийн 20-иод жил сулрах тийшээгээ хандаж байна. Өөрөөр хэлбэл анх тогтоосон дүрэм журам нь шинэ нөхцөлтэй авцалдахаа больж, хий орон зай үүссэн гэсэн үг. Энэ орон зайг бөглөхийн төлөө тэмцэлд хэн хэн хошуучилж яваа талаар би цухас дурдсан. Энд ч мөн зарим зүйл давтагдана.

Олон улсын валютын системийн өөрчлөлтөөс дэлгэрүүлэн авч үзье. Дэлхийн эдийн засаг, олон улсын валютын системийг тогтворжуулахын тулд АНУ-ын хэрэгжүүлсэн бодлогын нэг үр дүн бол энэ систем юм. Гэхдээ үүнд Их Британийн оруулсан хувь нэмрийг орхигдуулж болохгүй. Бреттон-Вудсын бага хурал зарлан хийлгэж, түүгээр валют-санхүүгийн систем байгуулахад Английн эрдэмтэн бөгөөд төлөөлөгчдийн тэргүүн Кейнсийн оруулсан хувь нэмрийн тухай ярьж байна. Урьд нь (1870-1914 он) олон улсын валютын систем (алтан стандарт буюу баталгааг английн фунт орлож байсан үе) тогтоож байсан туршлагатай, хоёр дайны хооронд валютын ханшийг зөнд нь хаяж, дараа нь ялгаварлан гадуурхах зовлон амссан орны хувьд Английн хувь нэмэр байхаас аргагүй. Ингээд Олон улсын валютын санг үндэслэхдээ АНУ, Англи хоёр уг санд элссэн орнуудад дунд хугацааны зээл олгох, мөн гишүүн орнуудынхаа валютын ажиллагаа, валютын бодлогод хяналт тавих, тэгснээр үндэсний бүх валютын хатуу ханш хөтөлбөргүй тогтооно гэж шийдсэн юм.

Дайнд суларч доройтсон европын зарим оронд ОУВС 1946 оноос санхүүгийн тусламж олгож эхлэв. Гэвч энэ нь удсангүй зогсов. Сангийн валютын нөөц хязгаартай учирч дундарч, цаад орнууд нь ч үүнээс их тусламж шаардсан юм. Ингээд энэ онгорхойг "Маршаллын төлөвлөгөө" бөглөв. 1956 оноос сангийн тусламж дахин сэргэжээ. 1958 он гэхэд Европын орнуудын валют хөрвөх чадвартай болж эдийн засаг нь бүрэн сэргэжээ. Дэлхийн эдийн засгийн хөгжлийн хурдац тогтворжиж, үнийн өсөлтийг нэг түвшинд (доод) барьж чаджээ. Эдийн засгийн ийм тааламжтай нөхцөл 60-аад оны дунд үе гэхэд гацаж зогсчээ. Хөрөнгө оруулалтын маягаар америкийн асар их капитал гадагш үрсаж, гадаадын банкууд, иргэдийн гарт асар их долларын хуримтлал бий болжээ. Энэ нь алт-долларын стандартад итгэх итгэлийг сулруулж, яг үүнтэй Вьетнамын дайн давхацсан юм. Ингээд өнгөрсөн хойно Бреттон-Вудсын системийг хаа сайгүй шүүмжилж, халах тухай ярих болжээ. Дайны шархыг анагаах, дайны төлбөр төлүүлэхэд энэ систем чухал үүрэг гүйцэтгэснийг бүгд мартсан хэрэг. АНУ-ын гадаад худалдааны алдагдал, инфляци, түүнээс үүссэн долларын их өр үнэндээ ч тэр системд итгэх байх эсэхэд нөлөөлсөн. Харин түүнийг орлуулж янз бүрийн онол дэвшүүлсэн нь тухайн цагтаа аль нь ч шалгарч үлдээгүй юм. Ингээд валютын ханшийг хүчээр тогтоон барьсан зохиомол системийг халж, "зээлжих тусгай эрх" тэгч бий болгожээ.

1971 оны наймдугаар сарын 15-нд долларыг алтаар сольж байсан системийг зогсоосноор Бреттон-Вудсын санхүүгийн тогтолцоо өндөрлөв. (1945 онд 25 тэрбум долларын нөөцтэй байсан АНУ 1971 онд 10.5 тэрбум доллар болж хорогдсон, 1971 онд зөвхөн нэг 7 хоногт францын банк 300 сая доллар хуримтлуулж, Японы банк зарим өдөр 690 сая долларын орлоготой

болсон байв. Энэ тоо өссөөр 3 тэрбумд хүрэх магадлал бодитой болоод байсан үед АНУ-ын ерөнхийлөгчийн шийдвэрээр ингэж зогсоосон юм) 1971 оны сүүлээр Вашингтонд хөгжингүй 10 орны Сангийн яамны сайд нар цуглаж, валютын хатуу ханш тогтоосон боловч тэр нь нэг жил үргэлжлээд дахин урсгалдаа оржээ. Энэ байдал үргэлжлээд 1973 оны "Номын сангийн бүлгийн" уулзалттай залгасан, түүнээс цаашхийг энд давхардуулан бичих хэрэггүй. Үр дүн нь гэвэл валютын хатуу ханш өнөөг хүртэл тогтоож чадсангүй, гэвч томхон хямралд хүргэсэнгүй, валютын ханшийн хэлбэлзэл үргэлжилсээр (1995 оны дөрөвдүгээр сард Токиогийн бирж дээр 1 доллар 79 иен хүрсэн баримт бий) байна.

Дэлхийн худалдааны шинэ дэг журам, түүний төгсгөлийн тухай тусад нь ярих ёстой. Үүнд мөн АНУ-ын үүрэг асар их. Олон улсын худалдааны салбарт нийтээрээ хүлээж авах таатай нөхцөл бүрдүүлэхийн төлөө АНУ-ын тавьсан хүч чармайлтыг би тэгж үнэлж байна. Тус орон бүр анхнаасаа л Олон улсын худалдааны байгууллага байгуулах гэж зорьсон. Гэвч дайны дараа тийм байгууллага бий болох нөхцөл бүрдээгүй нь харагджээ. Худалдааны зөрчил, худалдаанаас үүсэх мөргөлдөөнийг шийдвэрлэх, үүний дүнд олон талт чөлөөт худалдаа хөгжүүлэх нь америкчуудын эртний мөрөөдөл байсан юм. Гэвч Британийн хамтын нөхөрлөлийн дотор Английн эдлэлж буй эрх дархыг цуцлахгүйгээр үүндээ хэзээ ч хүрэхгүй. Ийм учраас худалдааны тарифыг багасгах үүрэг бүхий доод шатны завсрын байгууллага байгуулахаас эхлэх ёстой. Тэр нь 1947 оноос ажилласан Тариф, -худалдааны ерөнхий хэлэлцээр (GATT) юм. Дэлхийн хэмжээний худалдааны байгууллага байгуулагдмагц GATT үйл ажиллагаагаа зогсооно гэж төсөөлж байв. Гэтэл тэр байгууллага нь байгуулагдахгүй байсаар дэлхийн худалдаанд дайнаас хойшхи дэг журам тогтоосон гол тулгуур нь GATT болсон юм, Тэгэхээр энэ байгууллага зөвхөн тарифаар хөөцөлдөөд байгаагүй, зохих үүрэг гүйцэтгэсний нотолгоо юм. Жишээ нь худалдаанд тааламжтай нөхцөл олгох, импортын бараанд хязгаарлалт хийхгүй байх талаар хийсэн юм зөндөө бий. GATT-ын хэлэлцээний эхний шатанд АНУ тарифыг багасгах, импортод тавих хязгаарлалтыг зөөлрүүлэх талаар чармайлт тавьж үр дүнд хүрсэн. Гэвч 50, 60-аад онд дэлхийн худалдаа огцом хөгжсөнөөр шинэ шинэ асуудал хуримтлагдав. 1973-1976 онд явагдсан зургадугаар үе шатны хэлэлцээ эдгээр асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Үүнийг "Кеннедийн үе шат" гэж нэрлэдэг. Худалдааг либералчлах чиглэлд их зүйл хийсэн бөгөөд үүний дүнд дэлхийд олон талт чөлөөт худалдааны дэг журам тогтсон юм. Гэвч энэ зам цаашид дардан үргэлжлээгүй. АНУ-ын худалдааны алдагдал, зах зээлийн өрсөлдөөнөөс үүдэн элдэв саад бэрхшээл бишгүй тохиолдов. АНУ энэ системийг үүсгэн байгуулагчийн хувьд давуу эрх эдлэх гэж бүр анхнаас нь оролдсон. 50-иад онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд GATT-ын

дүрмийг хэрэглэхгүй байхыг, мөн японоос хөвөн нэхмэл барааны экспортоо хязгаарлахыг шаардаж байв. 70-аад онд төмөр ган эдлэлийн экспортоо багасгахыг Япон, өрнөд Европын орнуудаас шаардаж, эдгээр алхамаараа GATT-ыг сулруулж, удирдах үүргийг нь унагасан юм. Ийм учраас 70-аад онд дэлхийн худалдааны өсөлт саарчээ. Үүнд нефтийн хоёр удаагийн хямрал ч нөлөөлсөн байх. 70-80-аад оны зааг дээр АНУ худалдааны ялгаварлан гадуурхах бодлогоосоо арга буюу татгалзсан боловч удалгүй 1985 оноос дахин хуучин арга барилдаа эргэж оров. Учир нь 1986 он гэхэд тус орны гадаад худалдааны алдагдал 170 тэрбум долларт хүрсэн юм. Ингээд дэлхийн худалдааны шинэ дэг журмыг АНУ өөрөө алдагдуулахаас өөр аргагүй болжээ. 1986-1994 онд GATT-ын хамгийн удаан хэлэлцээ явагдсан нь түүхэнд Уругвайн үе шат гэж мөнхрөв. Энэ хэлэлцээний дүнд олон улсын худалдаан дахь саадыг гэтлэн давав. Гол нь 50 гаруй жилийн тэртээ АНУ-ын мөрөөдөл болж, цаасан дээр үлдсэн тэр байгууллага бий боллоо. Энэ байгууллагад дэлхийн 120 гаруй орон одоогоор багтаж байна. Гэвч төгс төгөлдөр болчихсон байгууллагын тухай биш, GATT-аас Дэлхийн худалдааны байгууллага руу шилжиж буй шилжилтийн үеийн Уругвайн хэлэлцээний төгсгөлд оролцсон орнуудын тухай ярьж буйг уншигчид эрхбиш ойлгох биз ээ. Ер нь GATT үүргээ гүйцэтгэж чадахаа больмогц бүс нутгийн хүрээнд түүнийг орлуулах хандлага гарсныг дурдалгүй өнгөрч болохгүй. АНУ-ын санаачилгаар Умард Америкийн чөлөөт худалдааны бүс (NAFTA), Европт Европын чөлөөт худалдааны холбоо (EFTA), Зүүн өмнөд Азид АСЕАН зэрэг олон байгууллага ажиллаж, илүү чухал үүрэг гүйцэтгэж байсан, байсаар ч байна.

Татвар ногдуулах олон улсын дэг журмын тухайд. Энэ салбарт АНУ давуу эрх эдэлсээр ирснийг бид мэднэ. Энэ нь 1. Татвараас орж ирэх орлогыг шударга хуваарилах. 2. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зорилгоор давхар татвараас зайлсхийх, ийм хоёр шалтгаанаар нөхцөгдсөн байв. Тухайн үедээ АНУ нь эдийн засгийн цорын ганц хүчирхэг гүрний хувьд хамгийн том хөрөнгө оруулагч байсан юм. Дайны сүүл рүү, дайн дууссаны дараа АНУ хөгжингүй гэж үзсэн гол гол оронтой давхар татвараас чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулж, төлөвлөснөө хэрэгжүүлж эхэлжээ. Гэвч дайнаас хойш олон улсын худалдаа өсч, хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь тааж хэлэх аргагүй шинэ нөхцлийг бий болгов. АНУ-ын хилийн гадна ажиллаж байсан буюу АНУ шууд хөрөнгө оруулсан үйлдвэр аж ахуйнууд олон үндэсний болж томров. Гэтэл олон үндэсний тэдгээр нэгжүүд татвар төлөхөөс зайлсхийх гэж оролдох болсон юм. Ийм байдлыг засахын тулд 60-аад оноос нэлээд хатуу хязгаарлалт тогтоожээ. Гэхдээ үүнийг АНУ ганцаараа хэрэгжүүлж хүчрэхгүй. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаар (OECD) дэмжүүлэхийг зорьсон юм. Учир нь түүний гишүүн хөгжингүй орнууд мөн АНУ-ын нэгэн адил

татварын бэрхшээлтэй тулгараад байлаа. 1963 онд тус байгууллага татвар ногдуулах тухай гэрээ боловсруулж, түүндээ татвар төлөх олон улсын үндсэн зарчмуудыг тусгажээ. Уг гэрээ АНУ-ын таашаалыг зүй есоор хүлээсэн бөгөөд тэр үед татварын бодлогоор АНУ оргилдоо хүрсэн гэж үздэг. Гэтэл 70-аад он гараад дээрхи гэрээ үйлчлэхээ больж, 1977 онд түүнийг өөрчлөхөөс өөр аргагүй болжээ. Гэхдээ л тэр үед эхэлсэн татварын системийн хямрал үргэлжилсээр бараг өнөөг хүрээд байна. Рейганы засаглалын үед татвараас орж ирэх орлогыг нэмэх гэж оролдсон боловч тэр нь бусад түншүүдтэй нь зөрчилдөж, улмаар эдийн засагт нь нөлөөлсөн. Япон, ХБНГУ татварын системдээ өөрчлөлт хийснээр эдийн засгийн өсөлтөө хангасан. Эцэст нь АНУ эргээд татварын орлогын өсөлтийг зогсооход хүрсэн. Учир нь үүний нөгөө талд төсвийн алдагдал өссөн юм. 1984, 1986 онд татварын хуульдаа эрс өөрчлөлт хийсэн бөгөөд 1990 он гэхэд зөвхөн гадаадын иргэд, гадаадын пүүс компанитай холбоотой өөрийн иргэдээс авах татварыг хязгаарлах журам тогтоов. Энэ мэт олон дахин өөрчилснээр татвар төлөх ёстойгоос өр болж үлдсэн нь хуримтлагдсаар тус орныг дотоодын өрөнд ороож авсан юм. Энэ юу хэлэв гэвэл, АНУ өөрийнхөө тогтоосон олон улсын татварын системээ хяналтаасаа гаргасныг харуулж байна.

Энэ мэт 3 гол салбарт (валют-санхүү, худалдаа, татвар) бий болсон бэрхшээл дайнаас хойш АНУ -ын тогтоосон дэлхийн эдийн засгийн шинэ дэг журмыг үндсэнд нь сүйрүүлж орхив бололтой. Эдийн засагчийн байр сууринаас бус, олон улсын харилцаа судалдаг хүний үзэмжээр өгүүлэхэд ийм л зүйл хэлэх байна. Дараагийн дэд бүлгүүд болон шинэ бүлгүүдэд энд бичсэнээ бас хөндөх болно.

ГУРАВ. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Дэлхийн эдийн засагт АНУ-ын эзэлж ирсэн байр суурь, дайны дараа тогтоосон эдийн засгийн системээ өөрөө хэрхэн хяналтаасаа алдсан тухай дээр өгүүлэв. Дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүнийг 40 хувийг дангаараа гаргаж, "Хүйтэн дайны" үед өрнөдийн соёл-иргэншлийг бараг ганцаараа хамгаалж, үүний сацуу дэлхийн банкны үүрэг гүйцэтгэж, дэлхийн найдвартай зээлдүүлэгч бөгөөд эдийн засгийн гол хандивлагч байсны хувьд ингэж алдсан нь үнэхээр харамсалтай хэрэг. 70-аад он гэхэд дээрхи 40 хувь нь 25 болж буурав. Түүний алдсан тэр хувийг Өрнөд Европ, Япон нөхсөн төдийгүй уламжлалт хөгжингүй орнуудаас гадна цоо шинээр аж үйлдвэржсэн (жишээ нь Өмнөд Европт Испани, Португали, Латин Америкт Мексик, Бразил, мөн Зүүн Азийн "барууд" гэх мэт) орнууд хурдан хөгжиж, олон улсын эдийн засгийн харилцаанд оролцож эхэлсэн юм. Тэгэхээр энэ нь АНУ

дэлхийн зах зээлд олон өрсөлдөгчтэй нэгэн зэрэг шахуу халз тулна гэсэн үг. Ийм учраас бүх асуудлыг урьдын давуу эрх эдэлдэг байсан тэр аргаар шийдэж хүчрэхгүй нь олон талаар харагдав. Тэгэхээр харилцан буулт хийх, эсвэл зарим үед ухрахаас өөр аргагүй. Тэгж байж нөгөө өрсөлдөгчөөрөө буулт хийлгэнэ. Тэд ч мөн зах зээлд АНУ-тай халз тулж таарна.

Ийм тулгаралтаас сэрэмжлэх үүднээс улс бүр тус тусын эдийн засгийг хооронд нь уялдуулан зохицуулах ёстой. Тэгээд ч улс орнуудын үсрэнгүй хөгжил тэдгээрийн эдийн засгийн бие даасан байдлыг алдагдуулж улс орнуудын харилцан хамаарлыг өөрийн эрхгүй бий болгосон юм. Дэлхийн эдийн засагт гадаад худалдааны эзлэх жин нэмэгдэж, зах зээл тэлснээр тийм харилцан хамаарал бүр зүй тогтол болж бүрэлдсэн хэрэг. Тэгэхээр ийм зүй тогтлыг улс орнууд ганц нэгээрээ давах аргагүй. Ийм учраас тэд өөрийн эрхгүй хамтрах, хорших хэлбэр рүү шилжжээ. 60-аад оныг интеграц бүс нутгийн хэлбэрээр төлөвшсөн үе гэдэг. Түүхий эдийн эх сурвалж, үйлдвэрлэлийн хоршилт дагналт, хөрөнгө оруулалт зэрэг хэлбэрээр ийм интеграц эхэлсний тодорхой жишээ нь ЕЭЗХН билээ. Эдийн засагт чөлөөт худалдаа хөгжүүлэх, хөгжиж буй орнуудад өрнөдийн орнуудаас үзүүлэх тусламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүс нутгийн шинжтэй нэгэн байгууллага 1961 онд бий болсон нь OECD билээ. (Энэ тухай дараа бүлэгт өгүүлнэ) 60-аад оноос ийм зохицуулалт хийж, янз бүрийн арга саам сүвэгчилсээр өнөөг хүрсэн бөгөөд энэ үе бол АНУ-ын эдийн засгийн стратегийн хувьд шинэ үе болсон юм.

Тэгэхээр дэлхийн эдийн засгийн системд АНУ-ын эзэлсэн байр суурь, явуулсан бодлогыг дотор нь бас хэд хэд ангилж болмоор санагдана. Үүнд:

1. 60-аад он хүртэл АНУ дангаараа эдийн засгийн хувьд дэлхийд нөлөөлөх хэмжээнд байжээ. АНУ-ын эдийн засгийг аюулгүй байдалтай нь ягштал хамтатган ойлгох шаардлагагүй байсан хэрэг.

2. Гэтэл 60-аад оноос дэлхийн эдийн засаг дахь тэргүүлэх үүргээ тэгш эрхтэй түншүүдтэй хуваалцахаас өөр аргагүй байдлын өмнө тулж ирэв. Энэ маань олон улсын эдийн засгийн харилцааг улам баялаг агуулгатай болгоно гэсэн үг.

Урьдын механизмууд хуучирлаа. Тэдгээрийг өөрчлөх ёстой. Олон улсын худалдаанд ялгаварлан гадуурхах үзэгдэл, худалдааны барьер, актив, сальдо бий боллоо. Олон улсын чөлөөт худалдааны зарчмууд алдагдаж эхэллээ. Энэ бүхнээс үүдэн АНУ-ын үндэсний эрх ашгийн асуудал, цаашлаад үндэсний аюулгүй байдлын асуудал гарч ирнэ. Тийм учраас 60-аад оноос АНУ өөрийн эрхгүй дэлхийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг үнэмлэхүй аюулгүй байдалтайгаа холбож үзсэн юм. Эдийн засгийн аюулгүй байдал үүний цөм нь.

3. Дэлхийн эдийн засгийн өрсөлдөөн эрс ширүүссэн сүүлийн хориод жилд АНУ эдийн засгийн бодогынхоо бас нэгэн үеийг туулж байх шиг. Энэ бол XXI зууны босгон дээрхи эдийн засгийн бодлого юм. АНУ одоо гол анхаарлаа шинжлэх ухааны салбарт төвлөрүүлжээ. Үүнийг АНУ дэлхийн эдийн засагт тэргүүлэх чиглэлээ хадгалж байх шийдвэрлэх хүчин зүйл гэж үзэж байна. Хэрэв энэ салбарт анхаарал төвлөрүүлэхгүй бол америкийн эдийн засгийн аюулгүй байдал хүнд сорилттой тулгарна. Тооцоолон бодох техник, биотехнологи, шинэ төрлийн зэвсэглэл гээд олон салбарт хэнийг ч урьдаа гишгүүлэх ёсгүй гэж АНУ-ын эдийн засгийн шинэ стратеги үзэж байна. Энэ бол сүүлийн хэдэн засаг захиргааны эдийн засгийн бодлогын онцлог байлаа. Өрсөлдөх чадвараа хадгалж, дэлхийн зах зээл дээр шинэ өндөрлөгт хүрэх, экспортоор далайлгах бодлогоо тэлэхийг америкийн нийгмийн дотоод асуудал шийдэх гол элемент гэж үздэг. Энэ бол дэлхийн эдийн засаг, түүний дотор "7-гийн бүлгийн" дотор АНУ-ын баримтлах гол зарчим юм.

Өнөөдөр америкчуудын хамгийн их эмзэглэж буй зүйл бол дэлхийд хэт их гүрний статусаа хэр удаан хадгалж байх вэ? гэдэг асуудал юм. Жишээ нь америкийн судлаачдынхаар, Япон, Хятад хоёр ойрын ирээдүйд эдийн засгийн талаар тэднийг нэлээд "зовоох" бололтой Ойрын 20 жилээр авч үзвэл АНУ нь Японд байр сууриа тавьж өгөхгүй. ШУТ-ийн ололтыг үйлдвэр-лэлд нэвтрүүлэх салбарт АНУ хэнд ч байраа тавьж өгөхгүй гэж үзэж байна. Гэтэл технологийн энэ давуу тал нь цэргийн хүч чадлыг нь аажим сулруулж магад гэсэн болгоомжлол бас байдаг. Ингэж болгоомжлох, таамаглах болсон нь бас ч бодит шалтгаантай юм.

Хэрэв ингэж нэг талаар бэхжээд, нөгөө талаар сул орон зай гаргавал АНУ-ын эдийн засгийн бас нэг шинэ үе эхэлнэ. Харин түүнийг урьдчилан засч залруулах нь Клинтонь засаг захиргааны үүрэг болжээ. АНУ Рейган, Бушийн засаглалын үед эдийн засгаа үлэмж сулруулсан гэж үздэг. Ялангуяа 80-аад онд төсвийн болон төлбөрийн алдагдал огцом өссөнөөс тийм сулралыг амссан ажээ. Энэ нь явсаар АНУ-ын эдийн засгийн тэргүүлэх үүрэг рольд сөв суулгаж мэдэхээр болжээ. 60-аад онд эхэлсэн эдийн засгийн ухралтын үргэлжлэлийн тухай ярьж байна. Хэрэв макро түвшинд авч үзвэл АНУ-ын суларсан байдлыг шууд олж харах аргагүй. Эдийн засгийн микро түвшинд түүний хор хөнөөл илт мэдэгдэж байв. Бүгд найрамдах намын хоёр удаагийн засаг захиргаа татварын алдаатай бодлого явуулж, Японтой худалдааны асар их алдагдалтай наймаа хийж байсан, АНУ-ын мөнгөн тэмдэгтийн ханшийн хэлбэлзэл зэрэг нь АНУ-ын нийгмийн зааг ялгааг илт ихэсгэсэн юм. Нийгэмд ямагт олонхи болсоор ирсэн дунд давхарга Бүгд найрамдах намаас холдож хөндийрсөн бөгөөд цөөнхи дээдчүүд л Рейган, Бушэд талархаж хоцорсон юм. Бас "Хүйтэн дайны" төгсгөлөөр бий болсон дэлхийн шинэ дэг журмыг

урьдчилсан харах чадвар Бушийн засаг захиргаанд дутсан тал бий. Буш АНУ-ын гадаад бодлого, аюулгүй байдалд хэт анхаараад эдийн засгийн ширүүн өрсөлдөөн дунд АНУ-ын эдийн засгийг шинжлэх өөрчлөх талаар дутмаг ажилласан гэж өрсөлдөгчид нь шүүмжилж байлаа. Тийм учраас Клинтон түүний халааг авахдаа АНУ-ын гадаад бодлого, эдийн засаг, аюулгүй байдлыг бүгдийг нь цогц ёцон үзэхийг зорьсон юм.

4. Клинтонь засаг захиргааны гадаад бодлогыг дэлхийн эдийн засагтай холбож тайлбарлъя. Энэ бол миний дээр хэлсэн дараагийн нэг үе. Тэгээд ч 90-ээд оны америкийн бодлогын гол онцлогийг төсөөлөхөд хэрэгтэй болов уу. "Клинтонь номлол" гэж албан ёсоор нэрлэхгүй ч, түүний бодлогод илт ажиглагдах хэсгийг нь энд томъёолов. Дэлхийн дэг журам тогтоох гол фундамент-ардчилал, ардчиллын туйлын зорилгод үндэслэсэн дипломат бодлого явуулах үзэл санаа бол ганц Клинтоньх биш, АНУ-ын засаг захиргааны уламжлалт бодлого. Үүний сацуу шуурхай ажиллагаатай хүчирхэг батлан хамгаалах нөөц хүчнийг хадгалж байх нь бас л уламжлалт бодлого. Харин АНУ дэлхий дээрхи цорын ганц хэт их гүрэн хэвээр байх нь Клинтонь амлалт ба зорилго. Сэдвээсээ бага зэрэг хазайя.

Дэлхийн бодлогын талаас АНУ-ыг авч үзэх нь хөндөж буй сэдвийг улам ойлгомжтой болгох болов уу. Тус орон 90-ээд он хүртэл "7-гийн бүлэгт" тодорхой зорилго, чиглэлтэй (дэлхийн эдийн засаг, санхүүгийн асуудал) оролцож ирсэн бөгөөд "Хүйтэн дайн" дууссанаар тус орны олон улсын байр суурийг улам ч олон талтай болгосон юм. Хоёр системийн сэргэлдөөн арилж, ЗХУ задарснаар АНУ дэлхийд ганцаараа "хэт их гүрний" статусаа хадгалж үлдлээ. Ингэж тодорхойлж байгаа нь доорхи 4 бодит нөхцлийг (хүчин зүйл) харгалзасан хэрэг. Энэ нь:

1. АНУ нь эдийн засгийн хувьд их гүрэн хэвээрээ үлдлээ.
2. АНУ нь цэргийн хувьд их гүрэн хэвээр байна.
3. АНУ нь соёл-иргэншлийн хувьд нөлөөлөх хэмжээтэй байна.
4. Эдгээр 3 хүчин зүйл дээрээ тулгуурлан АНУ нь дэлхийд улс төрийн хамгийн нөлөөтэй гүрэн юм.

Өнөөдөр дэлхийд өөр нэг ч улс гүрэн хүчтэйгээ илтгэх ийм 4 нөхцлийг хангаагүй байгаа. Жишээ нь, АНУ-тай харьцуулахад Орос нь стратегийн хүч нөөцтэй орон. Гэтэл үлдэх 3 үзүүлэлтээр АНУ-тай өрсөлдөх боломж алга. Япон болон Герман эдийн засгийн хувьд (худалдааг бас нэмье) АНУ-тай өрсөлдөж чадна. Бас л үлдэх 3 үзүүлэлтээр бараадахгүй. Хятад эдгээр 4 нөхцлийг хариуцан хангасан боловч "хэт их гүрний" статуст дөхөж очтол хол байгаа. Тэгэхээр хойшид их гүрнүүдийн өрсөлдөөн гэдэг ойлголтыг санахад энэ 4 нөхцөл, үзүүлэлтээр харьцуулж авч үзсэн ч болохоор гэнэт на.(Энд ярьж буй сэдвийн дагуу "7-гийн бүлгийн" хүрээнд шүү дээ.)

Энэ бол Клинтоны засаг захиргааны үед бүрэлдэн бий болсон гарцаагүй бодит нөхцөл, үүнийг я бэхжүүлж хэвээр нь хадгалах явдал АНУ-ын өнөөгийн үүрэг юм. Энэ үүргийг Клинтон цоо шинэ номлол бодлогоор хангахгүй. Уламжлал, шинэчлэлийг хослуулж байж хангана. Клинтон 60 жилийн тэртээ ардчилсан намын ерөнхийлөгч Ф.Рузвельтийн эмхлэн байгуулж байсан Үндэсний эдийн засгийн зөвлөлийг сэргээснээрээ Рузвельтийн "шинэ чиг шугамыг" өвлөн хэрэгжүүллээ. Түүний цөм нь 1929-1933 оны дэлхийн эдийн засгийн хямралыг хохирол багатай гэтлэн давсан түүхэн туршлага юм. Зөвлөлийг сайдын эрх бүхий эдийн засгийн бодлогын тусгай зөвлөх нь тэргүүлэв. Зөвлөлийн гол үүрэг нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг дэмжин хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх явдал. Бас ерөнхийлөгч Картерийн "Хүний эрхийг хамгаалах дипломат бодлого", Рейганы "Хүчтэй Америкийн" тухай бодлогыг уламжлал болгожээ. Ийм учраас судлаачид АНУ-ын 90-ээд оны гадаад бодлого 3 шинжийг агуулсан байж болохыг таамаглаж байна. Картерийн засаг захиргаанд дээгүүр тушаалд ажиялсан хашир туршлагатай хэсгийг нь *идеалистууд* гэж үздэг. Кристофер, Лейк, Вергер нар "Хүний эрхийг хамгаалах дипломат бодлогын" талынхан гэнэ. Их Британид боловсрол эзэмшсэн Хопкинс, Жонс, Мандельбаум нар *прагматик* хэсгийнхэн, Гамильтон зэрэг төлөөлөгчдийн танхимд нөлөө бүхий нэг хэсэг нь энэ хоёрын дундахыг завсрын хэсэг аж. Ер нь Клинтоны засаг захиргааны гадаад бодлого төлөвшсөн эхний үеийг ажиглахад яг ингэж эрс тэс ойлгохгүй ч бас няцааж болохгүй мэт. Жишээ нь АНУ-ын эдийн засгийг сэргээн босгоно гэдгээ тэргүүн зорилго болгон дэвшүүлэх атлаа түүнийхээ дараагийн алхамд АНУ-ын цэргийн стратегийг "Хүйтэн дайны" дараахи шинэ нөхцөлд тохируулан өөрчлөх, тэгээд даян дэлхийд ардчиллыг хөгжүүлэхэд туслана гэж тунхаглажээ. Ерөнхийлөгч байх 4 жилдээ багтааж, АНУ-ын батлан хамгаалах зардлыг 100 тэрбум доллараар хорогдуулах зорилт дэвшүүлсэн нь АНУ-ыг хүчирхэг байлгах тухай үзэл санаатай нь авцалдах уу? Гэсэн атлаа бүс нутагт аюулгүй байдлыг хангахад хүч чармайлт тавихын тулд олон улсын яриа хэлцээний системийг бэхжүүлэх тухай ярьж байна. Үүндээ Япон, ХБНГУ мэт холбоотнуудаа ашиглахыг гол болгож байна. Клинтон ерөнхийлөгч болохоосоо өмнө дэвшүүлж байсан нэгэн санал бий. Жишээ нь Япон, ХБНГУ хоёрыг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн болгож энх тайвныг хамгаалагчийн үүрэг хүлээлгэх тухай. Тэр нь бодит амьдралд харшлаад, гол нь Япон өөрөө тэр үүргээс булзаад хэрэгжих нөхцөлгүй байна. Дэлхийн улс төрийн уур амьсгал бүрэн намжаагүй, шинэ шинэ бэрхшээл бий болж (гол нь ТУХН бас хуучин Югославаас) байхад АНУ-ын батлан хамгаалах төсвийг хасч танахыг АНУ-д тэр бүр сайшаахгүй байгаа. Хүний эрх зөрчиж, Иранд цөмийн технологи худалдахаар улайрч, НАТО-г хардаж

сэрдэж, үүгээрээ өөрийгөө тусгаарлаж байгаа Оросын талаар Клинтоны баримталж буй байр суурь америкчуудад учир битүүлэг санагдаж байна.

Тэгэхээр америкчууд (америк сонгогчид) "хэт их гүрний статусыг" нь хадгалж байх нөгөөх 4 хүчин зүйлээр л Клинтонтой тооцоо хийнэ. Үндэсний эдийн засгаа сэргээх хүчин чармайлтаа дэлхийд цорын ганц хэт их гүрэн хэвээр үлдэх хүсэл тэмүүлэлтэйгээ хослуулах ёстой. Түүнийг л Клинтонгоос шаардана. АНУ ганцаараа олон улсын харилцааны цорын ганц туйл байх боломжийн тухай ярьж байна. АНУ өнөөдөр дэлхийд цорын ганц үлдсэн хэт их гүрэн хэвээр байгаа явдал бол дэлхийн бүх үйл хэргийг мэдэж шийдэх эрхийг дангаараа өмчил гэсэн үг биш. Харилцан хамааралтай, бас олон улсын харилцаанд өөр олон туйлууд гарч ирэх магадлал бодитой болсон өнөө үед дэлхий дахинд тогтвортой энх тайвныг тогтооход тэднийг татаж оруулна гэсэн үг юм. Үүндээ АНУ дараахи 5 нөхцөлийг харгалзан үзэж байжээ. Үүнд:

1. АНУ хэт их гүрний хувьд олон улсын үйл хэрэгт идэвхтэй оролцоно;
2. Нэгдмэл Европыг улс төрийн хувьд үүнд татан оруулна;
3. Тогтвортой ардчилсан Орос энд бас их үүрэгтэй;
4. АНУ-тай улс төрийн (бас цэргийн) нягт харилцаатай Японыг татан оруулна;
5. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд өөрийн хүч нөөцөө улам бүр харуулах цэцэглэн хөгжсөн Хятад мөн энд татагдан орно;

Энэ бол одоо хэрэгжчихсэн бодит практикийн тухай бус хэтдээ, магадгүй ирэх зуунд хэрэгжих ирээдүйн төсөөлөл юм. Америкчуудынхаар эдгээр 5 нөхцөлийг бүрдүүлсэн бол дэлхий дахинд дайн мөргөлдөөн, хямрал намжих ажээ. Ирэх 20 жилд бат бэх энх амгалан тогтоох гол нөхцөл гэж З.Бжезинский үүнийг үнэлж байна.

ДӨРӨВ. ЯПОН

Дайны дараахи дэлхийн эдийн засгийн шинэ системд Япон улс олон эзэлсэн байр суурь, жин нөлөөг энд дэлгэрүүлэн авч үзье. 1946 онд үндэсний нийт бүтээгдэхүүнээс хүн ам тутамд ногдох орлого нь хорьхон долларт хүрч байсан орон чухам Ямар ид шидийн хүчээр ийм их баялгийг (дээрхи үзүүлэлт 1993 онд 31450 доллар болсон) бүтээдэг билээ. Энэ бол эдийн засагчдын сонирхдог гол чухал сэдэв. Японы өөрийнх нь судлаачдын үздэгээр, өнгөрсөн жил жилийн хөгжлийг 3 үед хуваадаг. Энэ нь:

1. Дайны дараахи сэргээн босголтын үе 1945-1952 он,
2. Эдийн засгийн өсөлтийн хамгийн эрчимтэй үе 1953-1973 он

3. Нефтийн хямралын дараахи үе 1973 оноос өнөөг хүртэлх үе.

Үүнээс гадна олон улсын эдийн засгийн шинжлэх ухаанд Японы хөгжлийг аж үйлдвэржүүлэх бодлогод нь үндэслэн арав арван жилээр үечилсэн судалгаа бий. Жишээ нь 50-иад оныг аж үйлдвэржүүлэлт, 60-аад оныг олон улсын өрсөлдөөн, 70-аад оныг бүтцийн өөрчлөлт, 80-аад оныг шинээр баримжаа гаргах, 90-ээд оныг дэлхий дахинчлах (Globalization) үе гэж тодорхойлсон байдаг.

1. Дайны дараа ямар Япон орныг япончууд өвлөн авсан билээ. 2 сая хүн алагдаж, хотуудын 40 хувь нь балгас нурам болж, аж үйлдвэрийн боловсруулах салбар дайны өмнөх үеийн долооны нэг хувьд, ган төмөрлөгийн үйлдвэрлэл аравны нэгд дөнгөн данган хүрч байсан юм. Ийм орныг өөд нь татаж чадна гэж хэн ч итгэх аргагүй байв. Инфляц, төсвийн алдагдал эдийн засгийн хамгийн эмзэг асуудал байлаа. 1949 онд америкийн нэгэн банкны эзэн Жозеф Дож Японы санхүүгийн гол зөвлөхийн үүрэг гүйцэтгэж, эдийн засгийн бие даасан байдал тогтоох, санхүүгийн бэрхшээлийг гэтлэн давах анхны туршилт хийж үзжээ. Ингэснээр доллар-иенийн солих ханш (тэр үед 1 доллар = 360 иен) тогтоож, санхүүгийн тогтвортой бодлого хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Дайны дараахи сэргээн босголтод санхүүгийн болон аж үйлдвэрийн бодлого гол үүрэг гүйцэтгэв. Үүнээс хамгийн үр дүнгээ өгсөн нь гэвэл:

- 1) Үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг системчилсэн;
- 2) Экспорт-импортын банк, Хөгжлийн банкуудыг байгуулсан;
- 3) 1953 онд санхүүгийн хөрөнгө оруулалт, зээлийн систем тогтоосон явдал гэж үздэг.

Үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл тогтоохдоо аж үйлдвэрийн боловсруулах салбар, хөдөө аж ахуйг гол болгосон. Ингэхдээ санхүүгийн нэлээд нөөцийг нүүрс олбордох, ган цувимал, эрчим хүч, хөлөг онгоц, бордооны үйлдвэрлэлд оруулсан. Энэ бүхэн нь дайнаар сүйрсэн үйлдвэрлэлээ сэргээхэд чиглэгдсэн юм. Энэ бүхнийг хүчтэй банкгүйгээр хийх аргагүй. Тийм учраас 1950, 1951 онд тус улсын санхүүгийн гол гол байгууллагыг бий болгосон юм. Татвар, хөрөнгө оруулалт, шинэ техник, технологи, хувийн жижиг дунд үйлдвэрлэл гэх мэт эдийн засгийн орчин үеийн систем тэр үед л сууриа тавьжээ. АНУ-аас ч сэтгэл харамгүй тусласан, тэгэхээс өөр аргагүй байв. 1954 он гэхэд хүн ам тутамд ногдох орлогын үзүүлэлтээр дайны өмнөх түвшнээсээ давж гарсан төдийгүй дайны шарх сорвио бүрэн анагааж чаджээ. Энэ нь: 1. Эдийн засгаа бүрэн сэргээн босгосон; 2. Эдийн засгийн хувьд бие дааж чадсан гэсэн үг. Үүний дараагийн шатны зорилт бол эдийн засгийн үзүүлэлтээр аж үйлдвэржсэн хөгжингүй орны түвшинд

хүрэх явдал. Үүний тулд үйлдвэрлэлд шинэчлэл хийх, хүнд болон химийн үйлдвэрлэл, тухайлбал машины, нефтьхимийн салбарууд нэмэгдэх ёстой. Бас эдгээрийг санхүүжүүлэх, хөрөнгө оруулах асуудлыг Дэлхийн банктай нягт харилцан холбоотойгоор хийнэ. Экспортыг хөгжүүлэхийн хамт төлбөрийн балансын алдагдал, гадаад худалдааны бэрхшээлийг арилгах ёстой. Тийм учраас мөнгө зээлийн хатуу бодлого баримтлаж, гадаад валютын нөөцөө зузаатгана. (Тэр үед ердөө 2 тэрбум доллар хүрч байсан) Дээр дурдсан хоёр гол банк энэ үед ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Энэ бүхэн дээр үндэслэн эдийн засгийн эрчимтэй хөгжлийн шат руу шилжжээ.

2. Энэ шат бол олон улсын эдийн засгийн системд өрсөлдөх үе юм. Энэ өрсөлдөөний явцад Япон нь эдийн засгийн хувьд дэлхийн нэг томхон гүрэн болж төлөвших ёстой. Үүнийг 60-аад онд хэрэгжүүлжээ. Тус орон үндэсний орлогоо хоёр дахин өсгөх программ 1960 онд дэвшүүлэв. Мөн 5 жилийн дотор хүн ам тутамд ногдох үндэсний орлогын үзүүлэлтийг бас хоёр дахин өсгөнө гэж зарлажээ. Энэ жилүүдэд японы экспорт тасралтгүй өсч, техникийн нарийвчилсан чиглэлийн үйлдвэрлэл огцом хөгжсөн юм. Экспорт, импортыг либералчлан, элдэв хөнгөлөлт үзүүлэхийг хуульчилж, техникийн дэвшил хийхэд гол анхаарлаа хандуулжээ. 1955-1970 онд тус орны эдийн засгийн өсөлтийн дундаж хурдац дээд үзүүлэлтдээ хүрч, 10 хувиас давжээ. Үйлдвэрлэлийн хэмжээ их болсон тул дотоодын зах зээлийг хөгжүүлэх ёстой. 1964 онд Токиогийн олимпийг зохион байгуулснаар эдийн засгийн гайхамшиг гэгчээ дэлхий дахинд харуулж чаджээ. 20 доллар (1946 он) байсан хүн ам тутмын бодит орлогыг 844 долларт хүргэв. 1968 он гэхэд энэ тоо 1000-д хүрч, эдийн засгийн бүх үзүүлэлтээр ХБНГУ-ыг гүйцэж түрүүлжээ. 1960 онд дэвшүүлсэн эдийн засгийн зорилт ийнхүү биеллээ.

1962 онд тэр үеийн Японы ерөнхий сайд Д.Икэда капиталист ертөнцийн 3 баганын тухай номлол дэвшүүлснээр "Трилатеризм" үүссэн билээ. Үнэхээр ч 60-аад онд хөгжингүй орнуудын эдийн засгийн уялдаа холбоо чухал болсон юм. Эдийн засгийн үсрэнгүй хөгжил бусад өөр асуудал дагуулдаг. Агаар ус, байгаль орчны бохирдол, түүхий эдийн хангамж, хот хөдөөгийн хүн амын харьцаа, нийгмийн бусад асуудал хуримтлагдав. Бас нүүрлэж буй валютын ханшийн хэлбэлзэл, дэлхийн нефтийн хямрал зэргийг урьдчилан харах ёстой. Үүгээр Японы эдийн засгийн хөгжлийн дараагийн үе шат эхэлж байна.

3. Япон ийнхүү сааталгүй хөгжсөөр 70-аад онтой золгожээ. Гэвч нефтийн хямрал тус орны хувьд том дайрлага боллоо. Химл түүхий нефть импортолсоор ирсэн нь японы эдийн засгийн өсөлтийг хангах нэг хүчин зүйл болж байсанд хэргийн үндэр оршино. Гэтэл 1973 оны намрын тэр өдрүүдэд нефтийн үнэ 4 дахин өссөнөөр дэлхийн эдийн засагт том хохирол учирчээ. Энэ үед

гадаад худалдааны алдагдал, хэвийн бус инфляц (жилд 35 хуви), үйлдвэрлэлийн уналт гэсэн үг. Эрчим хүчийг хязгаарлах шатахуун түгээгүүрийг олноор нь хаах, нийтийн тээвэр зогсох, нийгмийн ажил саатах гэх мэт олон уршиг дагавар үүнийг дагалдана. Ингэж 1974 онд Японы эдийн засаг анх удаагаа сөрөг үзүүлэлт үзүүлжээ. Энэ бол эдийн засгийн сул талыг харуулна гэсэн үг. Японы эрчим хүчний үйлдвэрлэлд нефть гол эх сурвалж болж байсан учраас энэ хямрал бүр ч хүнд тусчээ. Ийм учраас нефть орлуулах өөр түүхийг эд бодож олох, эсвэл эрчим хүчийг хязгаарлахаас өөр зам байхгүй. Нефтийн хэрэглээ ч эрс багаслаа. Үндэсний нийт бүтээгдэхүүнд нефтийн хэрэглээ 60 хувиар буурчээ. Ингэж бууруулж чадсанаар тус орон 1979-1980 оны нефтийн хоёрдугаар хямралыг хохирол багатай давж чадсан юм. Түүнээс гадна 60-70-аад оны зааг дэлхийн валют-санхүүгийн системд нөлөөлсөн валютын ханшийн хэт хэлбэлзэл японы эдийн засагт ашиг, хохирол аль алиныг нь авчирчээ. Тус орон иенийн ханшийг бэхжүүлэхдээ АНУ-тай тогтоосон худалдааны харилцаан дахь активаа (нөгөө талд нь алдагдал) ашигласан юм. Ийм актив тус оронд зөвхөн нэг жилд л хэдэн тэрбум зарим үед зуу гаруй тэрбум долларын ашиг өгчээ. Тийм учраас Япон -Америкийн хоорондын худалдааны алдагдал валютын ханшил шууд нөлөөлсөн юм. Тэр үед 1 доллар = 240иен байсан бол 1988 он гэхэд 120 болж буурч, ашиг олохоосоо алдаж эхэлсэн байна. Учир нь иений ханш өснө гэдэг нь японы эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийхийг шаардана. Ямагт гадагш чиглэж ирсэн экспортын бодлогоо өөрчилж, дотоодын хэрэгцээг харгалзана гэсэн үг. Ийм өөрчлөлтүүдийг 80-аад оны сүүлээр хийжээ. Энэ бүхнийг "7-гийн бүлгийн" хүрээнд нягт уялдуулж хийсэн нь мэдээж. Энэ талаар өмнө нь дурдсан.

Ерөнхийд нь авч үзвэл, Японы эдийн засаг доорхи хэдэн нөхцлөөр ийм өндөр үзүүлэлтэд хүрсэн гэж үздэг. Үүнд:

1. Дээд зэргийн арвилан хэмнэлт;
2. Дээд зэргийн хөрөнгө оруулалт (Үндэсний нийт бүтээгдэхүүнд хувийн компаниудын оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ 20 хувиас давсан бол АНУ 10 хувьтай байна);
3. ШУТ-ийн дэвшлийг үйлдвэрлэлд нэвтрүүлж буй байдал;
4. Эдийн засаг нь шинэ нөхцөлд хурдан дадах чадвар;
5. Удирдлагын тогтвортой, үр бүтээлтэй систем зэргийг нэрлээ.

Энэ бүхэн дээр Японы өөрийнх нь үндэсний онцлог (улс төрийн хувьд дэлхийн хамгийн тогтвортой орон, хүн амын бараг 90 хувь нь дунд давхаргад багтдаг, гадны нөлөө бараг үгүй, ард түмний цул нэгдмэл байдал, зах зээлд аль ч улсаас эрт шилжсэн явдал, үндэстний ажилсаг чанар зэрэг) нөлөөлсөн бөгөөд "Хүйтэн дайны үед бусад аль ч улстай харьцуулахад хохирол амсаагүй, харин ч америкийн "цөмийн шүхрийн" халхавч дор аюулгүй байдлаа даатгасан юм.

Өгөөдөр Япон нь дэлхийн хамгийн том хандивлагч, дэлхийн томхон банк, эдийн засгийн хоёр дахь том гүрний хувьд "Гурван талын комиссын" хүрээнд идэвхтэй бодлого явуулж байна. Олон улсын харилцаа, дэлхийн бодлогод Японы үзүүлэх нөлөө 3 том үзүүлдэлтээр (гол хандивлагч, худалдааны томхон түнш, эдийн засгийн хоёр дахь гүрэн) нөхцөлдөг. Эдийн засгийн хөгжлөөр АНУ-ын дараа байр эзлэх болсон 60-70-аад оны зааг дээр "Гурван талын комисст" Японы гүйцэтгэх үүргийн тухай их ярих болсон юм. Өөрөөр хэлбэл Япон нь орчин үеийн дэлхийн эдийн засгийн 3 гол талын баримжаалах үнэт зүйл, дэлхийн эдийн засагт баримтлах стратегиа хамтран боловч руулахад шилжсэн гэсэн үг. Ийм учраас энэ үеэс японы гадаад бодлогод "дэлхийн хэмжээний хариуцлагын тухай", "дэлхийн хэмжээний үндэсний эрх ашгийн тухай" ярих болжээ. Энэ "Гурван талын" системийн хүрээнд Ази-Номхон далайн сав газар ажиллах эрхээр өргөн хангагджээ. Уг комиссын даргын үүргийг Японы томхон банкны эзэн (Дэлхийн хэмжээний санхүүгийн 5 том төвийн 4 нь Японд бий) Т.Ватанабэ удтал гүйцэтгэж байсан. Энэ комиссын илтгэл зөвлөмж "7-гийн бүлгийн" дээд хэмжээний уулзалтад мухал бэлтгэл болж өгдөг.

Миний энэ хэсэгт бичсэн зүйл АНУ, ХБНГУ-ынхаас ялгаатай. Би Японыг магтах чиглэлийн гол бэлтгэгчгүй. Гэвч дайнд сүйдсэн 50 гаруй жилийн төртөөх бодит байдалтай нь харьцуулж үзвэл үнэхээр үсрэлт гэж үүнийг гэх хэлэх байх. Нөгөө талаас Японы эдийн засаг ямагт шулуун дардан замаар геометрийн прогрессоор өсөөд байсан юм биш. Бэрхшээл байсан, одоо ч байна. Гэвч тийм бэрхшээлийг гэтлэн давах хэр оновчтой механизмыг олж тогтоосон бэ? гэдэг асуудал бий. Бас нэг анхаарах зүйл бол Японы гадаад бодлогын цөм нь эдийн засгийн аюулгүй байдал нь болдог. Үндсэн хуулиараа зэвсэгт хүчинтэй байхгүй гэсэн үүрэг хүлээж, батлан хамгаалах зардлаа үндэсний нийт бүтээгдэхүүний нэг хувь дээр барина гэдэг нь нэг бол америкийн цөмийн шүхэр дор амь зуух, эсвэл аюулгүй байдлаа эдийн засгийн хүчин зүйлээр хангах (өөр замын нэгийг сонгоно гэсэн үг. Япон нь энэ хоёрыг хоеуланг нь хослуулж байна. Гэвч яваандаа (бараг өнөөдөр) хоёр дахь нь давамгайлж үлдэх болов уу.

Япон нь "7-гийн бүлэгт" нэгдсэн цагаасаа тус эвслийг зөвхөн ханхүү-эдийн засгийн чиглэлтэй байлгахыг (Гэхдээ "7+1" бий болох цагаас Орост "Умардын нутаг дэвсгэрийн" асуудлыг шургуу тавьж байна) зорьж ирсэн улс. Энэ нь "7-гийн бүлэгт" тус орны эзэлж ирсэн байр суурийг илтгэх нэг онцлог нь. Тэгээд ч АПЕК, Европын олоос, NAFTA нэгдсэн хилтэй болж, Дэлхийн худалдааны байгууллага байгуулагдсан. Зүүн өмнөд Азид шинээр аж йлдвэржсэн орнууд өрсөлдөх хэмжээнд дөхөн очиж, Хятад үчирхэгжиж байгаа зэрэг бодит нөхцлүүд Японы гадаад бодлогыг зам бүр эдийн засагжуулахыг шаардаж байна.

ТАВ. ХБНГУ

Энд ХБНГУ-ын тухай бичихдээ, АНУ, Япон хоёроос ялгарах талыг нь гаргахыг хичээе. Тус орон Европын холбооны нэг гол гишүүн болохын хувьд дараа уг сэдвийг мөн хөндөнө. ХБНГУ бол дэлхийн аж үйлдвэржсэн тэргүүлэх орны нэг. Эдийн засгийн нийт үзүүлэлтээр дэлхийд гуравдугаарт, харин дэлхийн худалдааанд эзлэх байраар хоёрдугаар (АНУ-ын дараа) орно. "7-гийн бүлгийг" санаачлагчдын нэг, түүнд идэвхтэй оролцогч нөлөө бүхий орон.

Японтой хослох нийтлэг зүйл нь гэвэл тус орон мөн л дэлхийн дайны дараа үнс нурам, балгас дотроос босч ирсэнд байгаа юм. Тийм учраас японы нэгэн адил эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн гайхамшиг гээчийг үзүүлж чадсан улс. "Хүн төвтэй эдийн засаг" Германаас ч эх авсан байж магад. Германы хөгжлийг доорхи байдлаар үечилж болох байх. Үүнд:

1. 1949-1955 он бол тус орны гадаад дотоод бодлого төлөвшсөн, зүг баримжаагаа олсон үе;
2. 1955-1966 онд хамгийн чухал зүйл болох нийгмийн чиг баримжаа бүхий зах зээлийн эдийн засгийг хөгжүүлж, үндэсний хөгжил цэцэглэлтийг хангасан үе;
3. 1966-1969 "Их эвслийн үе" буюу дотооддоо улс төрийн харилцан буулт хийсэн шилжилтийн үе (ГСДН-ыг засгийн эрхэнд оруулах бэлтгэл үе);
4. 1969-1982 онд шинэ нөхцөлд (намжмал байдал, дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь) баримжаагаа азах оролдлого хийсэн үе;
5. 1982-1990 онд Европын хурцадмал байдлаас намжмал байдал руу, "Хүйтэн дайнаас" түүний төгсгөл рүү шилжсэн үе;
6. 1990 оноос өнөөг хүртэлх үе буюу Герман дахин шинээр нэгдсэн үе юм.

Ингэж ангилахдаа дан ганц эдийн засгийн өсөлтийг харгалзсангүй. Герман нь Японыг бодоход олон улсын харилцааны маргааны төвд удтал оршиж ирсэн ("Хүйтэн дайны" фронтын тэргүүн шугам), улс төрийн нугачаа, бэрхшээлтэй олонтаа гүлгарсан, гол нь хуваагдмал байсан зэргийг үндэс болгов. Тийм учраас ингэж ангилахдаа гадаад дотоод бодлогын хоорондын харилцаа, харилцан хамаарлыг харгалзсан юм.

1947 онд Өрнөд Герман дахь АНУ, Английн хяналтын бүсэд эдийн засгийн нэгдмэл орон зай үүссэнийг "Бизон" гэж нэрлэдэг. Дараа нь франц энэ бүсэд өөрийн хяналтын бүсээ нэгтгэснээр "Тризон" үүсчээ. Энэ бол ирээдүйн ХБНГУ-ын эдийн засгийн анхны элгийн хоршилт байлаа. Дараа нь энэ бүсдээ дойч маркийг гүйлгэхэд оруулсан. Энэ бол дайны дараахи анхны валютын реформ. Гэрүүн Гөрлинг хэдэн талаас нь бүслэн хааж, өлсгөлөнөөр буулган авах гэж оролдсон үед эдийн засгийн энэ

бүс болон холбоотнууд л аминд орсон. "Маршаллын төлөвлөгөө" тус орны сэргээн босголтонд шийдвэрлэх түлхэц үзүүлэв. Түүний хүрээнд ХБНГУ 1948-1952 онд 1.4 тэрбум долларын тусламж хүртжээ. Энэ үед ХБНГУ-ын эдийн засгийн стратеги төлөвшсөн нь хожмын "Нийгмийн баримжаа бүхий зах зээлийн аж ахуйн" загвар юм.

Эзлэгдсэн орны статусаа аажмаар халж, олон улсын идэвхтэй хамтын ажиллагаанд нэгдэж эхэлсэн нь GATT болон Европын нүүрс, гангийн хамтын нийгэмлэгт элссэн явдал болов. 1951 онд холбоотон 3 гүрэн ХБНГУ-тай дайны байдлыг цуцалсантай энэ үйл явдал давхцав. Энэ мэтээр 1955 онд хүртэл олон улсын тавцанд чиг баримжаагаа зөв гаргах аюулгүй байдлаа бэхжүүлэхэд гол анхаарал хандуулсан юм.

Дараагийн шатанд юуны өмнө ЗХУ-тай дайны байдлыг цуцлах ёстой. Гэвч яг энэ үеэр Европт "Хүйтэн дайны" шинэ үеийг эхлүүлэв. ХБНГУ НАТО-д элсэж, ВГБ бий болсныг энд хэлж байна. Залгаад Унгарын хэрэг явдал, Баруун Берлинийг суллаж өгөхийг шаардсан Хрущевын тулган шаардлага, "Хиймэл дагуулын балмагдал" (1957 онд ЗХУ сансрын хиймэл дагуул хоөргөснөөс үүдсэн шуугиан) дэгдэв. Энэ мэтээр ХБНГУ эдийн засагтаа гол анхаарлаа төвлөрүүлэх боломж нэг л оүрдэж өгөхгүй байлаа. Гэвч тус орон дайны шархыг хурдан хугацаанд анагаасан төдийгүй зугуухан урагшилж байв. 1952 онд тус орны экспорт импортоосоо давж, улмаар энэ нь дойч маркийн хөрвөх чадварт нөлөөлсөн юм. Ингэхдээ улсын нуруунд үүрэх ачааг ямагт хөнгөлөх, хувийн санаачлагыг хөхүүлэх, үйлдвэрлэлийн хэмжээг зах зээлээр зохицуулах хэлбэрийг гол болгосон. Зах зээлийн механизм зөв ажиллах эсэхийг өрсөлдөөн зохицуулна. Харин зах зээлийн харилцааны явцад бий болох элдэв бэрхшээлийг улсаас төсөв, татвар, нийгмийн бодлогоороо зохицуулсаар иржээ. [Эхний шатанд хүн амын хүнс тэжээл, өргөн хэрэглээний барааны хуваарилалтад карт хэрэглэж, түүнд төрөөс хяналт тавьж гол гол түүхий эдийг (нүүрс, нефть, төмрийн хүдэр, арьс шир гэх мэт) төр хатуу хяналтдаа барьж байв. Тэгсэн атлаа үнэ, цалинг чөлөөтэй тавьсан юм. Мөн экспорт импортыг хяналтдаа байлгахын хамт экспортын үнийг хатуу тогтоож, бас гадаад валютад хязгаар тогтоожээ. Үүний дүнд хар захын сүүдрийг тойрон гарч, хүн амын хөдөлмөрлөх идэвхийг сэргээж, инфляцийг хохирол багатай давав. ХБНГУ-ын Эдийн засгийн яамны анхны сайд Л.Эрхардын дэвшүүлсэн "Эдийн засгийн гайхамшигийн" тухай номлол энэ үед хэрэгжиж эхэлжээ. Энэ сургаальд нийгмийн баримжаа бүхий, нийгмийн хамгаалалттай, нийгмийн түнштэй зах зээлийн эдийн засгийг чухалчилсан байдаг. Дайнаас хойш засгийн эрх барьж буй улс төрийн хоёр гол нам (Христосын ардчилсан холбоо, Германы социал-демакрат нам) энэ сургаалиас гажилгүй түүшгэн хэрэгжүүлсээр ирсэн юм. Уг сургаальд эдийн засгийн бодлогын

гол зорилт бол ажилгүйдлийг хорогдуулах явдал бөгөөд хөрөнгө оруулалтыг түлхүү хийснээр ажлын орон тоог нэмэх тухай заасан байдаг. Германд ажлын үндсэн болон нэмэлт хөлс аль ч орныхоос дээгүүр байдаг нь үүнд л оршино. Ингэж авч үзэхдээ эдийн засгийн хөгжлийн амин чухал 4 асуудлыг (Энэ нь: 1. Үнийн тогтвортой байдлыг хангах; 2. Ажлаар хангах; 3. Гадаад эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах; 4. Энэ бүхнээ эдийн засгийн байнгын тогтвортой есөлтийг хангах үндсэн дээр хослуулах) төр, засаг байнга анхаарч байхыг гол болгодог. Тийм учраас Германы засгийн газарт эдийн засгийн маш хүчтэй аппарат ажиллаж, жил бүр тайлангаа бундестаг, бундесратад тавьж хэлэлцүүлсээр ирсэн жишээтэй.

Герман улс эдийн засгийн бодлого хэрэгжүүлэхдээ дэлхий дахин руу (Японыг бодоход) ямагт харж, анхнаасаа интеграцыг чухалчилсан. Тэгээд ч юун дээр онож, юун дээр алдаж яваагаа ямагт бусадтай жишиж харьцуулдаг. 1957 оны Ромд Европын хамтын нийгэмлэг байгуулах гэрээнд оролцогч болсны хувьд, 1977 онд Францтай хамтран Европын валютын системийг (Г.Шмидт, В.Жискар де Эстен нарын саналаар) үндэслэгчийн хувьд дэлхийн эдийн засгийн системд Өрнөд Европын жин нөлөөг бэхжүүлэхэд тус орон хамгаас илүү зүтгэсэн гэж үздэг. Тэгээд ч 50-иад онд хэн ч төсөөлөөгүй байсан эдийн засгийн тэрхүү аварга том бүтэц (өнөөгийн Европын хөндөө) бий болоход ХБНГУ "зүтгүүрийн" үүрэг гүйцэтгэсэн юм.

Гэвч германчууд гүйцэтгэсэн үүргээ бус, дутагдаж доголдож буй асуудлаа эхлэн авч үздэг. OECD байгууллагын гишүүн өрнөдийн хөгжингүй орнуудын дотор Герман нь дэлхийн худалдаанд эзлэх жин нөлөөгөөрөө тэргүүлж (АНУ-ын дараа хоёрдугаарт) байна. Гэвч электроны зарим салбарт, тухайлбал хагас дамжуулагч, ахуйн техникийн хувьд хоцорч байна. (Би АНУ, Японтой харьцуулж байна) Тэгэхдээ байгаль орчныг хамгаалах технологийн хувьд дэлхийд тэргүүлж байна. Биотехнологи, оптик, хими, эрүүлийг хамгаалах салбарт бас тэргүүлэх байдалтай байгаа. Олон улсын валют-санхүүгийн системд ХБНГУ-ын эзэлж ирсэн байр суурь, санхүүгийн бодлогын талаар өмнө нь өгүүлсэн тул бичиж буй зүйлээ цааш нь нурушихаа азная.

ХБНГУ-ын эдийн засгийн цэцэглэлтийн талаар судлаачид доорхи дүгнэлт хийдгийг энд иш татъя. Үүнд:

1. ХБНГУ нь эдийн засгийн хувьд сэргэмэгц экспортдоо гол анхаарал төвлөрүүлснээр (3 хүн тутмын нэг нь энэ салбарт ажиллаж байна) валютынхаа нөөцийг эрс нэмэгдүүлж чаджээ.
2. Худалдааг хэт либералчилсан. Энэ нь худалдааны элдэв саад бэрхшээл барьер, сөргөлдөөнийг тойрон гарч, улмаар гадаад худалдаанд таатай нөхцөл үзүүлсэн. Дашрамд хэлэхэд, Европ дахь бүх түнш нь германтай хийж буй худалдаанд алдагдалтай байна.

3. Гадаадын хөрөнгө оруулалтыг хамгийн оновчтой зөв ашигласан. Гэхдээ гадагш гаргаж буй хөрөнгө оруулалт ба гадаадаас орж ирэх хөрөнгө оруулалтын харьцааг зөв тогтоосон. (250:150 тэрбум марк)
4. Эдийн засгийг хүн рүү их ойртуулж, хүмүүнлэг болгож өгсөн. Энэ бол Германаас дэлхийд гайхуулах үлгэр жишээ юм.
5. Германы нутагт оршин байсан өмнөх улсуудыг бодвол өнөөгийн Герман нь хөрш орнуудтайгаа бат бэх найрсаг харилцаа тогтоож, хөгжих аятай гадаад орчныг бүрдүүлж чадсан.
6. Эцэст нь тэмдэглэхэд Японы нэг адил хөгжиж буй орнуудад туслах чиглэлийг хөгжлийнхөө нэг үзүүлэлт, батлагаа болгосонд байгаа юм.

ЗУРГАА. ИХ БРИТАНИ

Их Британийг "шархадсан арслантай" зүйрлэдэг. Энэ зүйрлэл санаандгүй зүйлээс үүсээгүй. Английн алтан-стандартын систем XIX зууны хоёрдугаар хагасаас дэлхийн нэгдүгээр дайн хүртэл тасралтгүй, маш ашигтай хэрэгжиж ирсэн. Дэлхийн дайн тус орны хүч чадлыг сүрхий ганхуулсан. Дайны явцад дээрх систем үйлчлэхээ больж, дайны дараа сэргээх шаардлага тулгарч, 1925 он гэхэд дөнгөж түүндээ хүрчээ. Гэвч энэ үеийн англи фунт алттай харьцах эрх дархаа алдсан байлаа. Дэлхийн нэгдгээр дайн харин америк долларыг бэхжүүлж өгсөн юм. Ингээд дайны дараа олон улсын алтан-стандартын систем хэврэгхэн фунт-долларын хоёр туйлд үндэслэх болов. Өчүүхэн шалтгаар доллартай харьцах фунтын үнэ унаж энэ гачлантай байлцмагс гарахын тулд мөнгөн тэмдэгтээ алтаар сольж авсаар, нэг мэдэхээр ангийн алтны төөц дундарчээ. Ингээд 30-аад он гэхэд алттай стандарт бүрэн хөгсөв. Дэлхийн валютын задрал явагдаж, худалдааны өмнөд хийх боломж хумигдаж, дэлхий эдийн засгийн их хямралтай залгав. Энэ хямрал яв явсаар дэлхийн хоёрдугаар дайн эхлүүлэх нэг шалтгаан болсон билээ.

Дайн Их Британийг дахин хүнд шархдуулжээ. Одоо фунт гэж хүчтэй валют байхгүй болж, дэлхийн мөнгийг доллар орлох болов. Түүнээс хойшхи үйл явдлыг түрүүчийн дэд бүлгүүдэд тодорхой бичсэн байгаа 60-аад онд америк доллар гадаадын банкуудад хуримтлагдаж, дараа нь алт-долларын стандартыг эвдсэн нь Их Британид дахин сэхэх бололцоо олгосон юм. Гэвч дайны дараахи Их Британи сэхэл авах боломжоор муу байлаа. Дэлхийн аж үйлдвэрийн үйлдвэрлэлд британийн эзлэх жин хоёр дахин буурч (10-5 хувь), хөгжлийн түвшингээр Японоос хоцроод зогссонгүй ХБНГУ, Францыг урдаа оруулчихав. Хүн ам тутамд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүнээр аж үйлдвэржсэн орнуудын дотор

арваннэгдүгээр байр руу ухарчээ. Тухайн цагтаа тэргүүлэх байранд байсныг харьцуулбал энэ нь уналт гэсэн үг.

1979 он гэхэд Британийн эдийн засгийн уналт хэд хэдэн шалтгаанаар улам гүнзгийрэв. Энэ нь тус орон дэлхийн дайны дараа бүрэлдэн бий болсон шинэ нөхцөлд удаан дассан, дэлхийн эдийн засаг-улс төрийн системд зөв байраа олохгүй цаг алдсан, бас социализмыг баримжаалсан лейборист засгийн газрын алдаатай бодлого, нефтийн хоёр удаагийн хямрал, хүчтэй өрсөлдөгчдийн бодлого зэрэг бүгд хослосон байв. Ингээд хүн ам тутамд ногдох орлогын үзүүлэлтээр хорьдугаар байр руу ухарч, урдаа Норвег, Бельги, өөрийн колони байсан Австрали, Канадыг хүртэл оруулжээ. Хөдөлмөрийн бүтээмж томхон орнуудынхаас хоцорлоо. Хамгийн өндөр хөдөлмөрийн хөлс авдаг газар түүнээ өгч хүчрэхээ больж, түүнийхээ гуравны хоёрт дөнгөн хүрч, хүн амын дургүйцэл өсчээ. Энэ бүхэн английн эдийн засгийн хүч нөөцийг дахин хүндрүүллээ. Гэтэл тэр үед "7-гийн бүлгийн" хүрээнд, Европын холбооны хүрээнд хямралыг зохицуулах талаар Британи сүүл барьж байв. Яг ийм хүнд үед Их Британид засгийн эрх солигдож, Тэтчер тэргүүтэй консерватив хүчин гарч ирсэн юм. Тэгэхээр энд Британийн хөгжлийн үе шатыг Засгийн эрх солигдсон байдлаар ангилахыг оролдъё. Учир нь Их Британид засгийн эрх ээлжлэн барьж буй хоёр гол нам улс орны хөгжлийг тодорхойлдог ба хоорондоо нэлээд ялгардаг. Дайнаас хойш:

1. Ерөнхий сайд Эттлийн лейборист засгийн газар 1945-1951 онд засгийн эрх барьсныг эхний үе гэж үзнэ. Энэ үед Их Британи нь дайны шарх сорвио анагаах, олон улсын шинэ нөхцөлд шинээр чиг баримжаагаа тогтоох, "Маршаллын төлөвлөгөөнд" идэвхтэй нэгдэх, НАТО-д элсэх алхамуудыг хийв.
2. 1951 онд Черчилль эргэж засгийн эрх авснаар бас нэг үе эхэлнэ. 1955 оноор үүнийг заагладаг. "Хүйтэн дайны" ид хэцүү энэ үед дайны дараахи АНУ-Их Британийн харилцааны өнөөгийн дүр зураг бүрэлдсэн юм. Бас Европын холбооны интеграцийн эхний үе.
3. 1955-1964 онд мөн л консерваторууд засгийн эрх барьсан. Гэвч энэ үед Британийн империализм хамгийн сүүлчийн боломжоо алдсан юм. Суэцын будлианд татагдан орж, үлдсэн колонио алдав. Английн хүчирхэг байсан үе өндөрлөлөө.
4. 1964-1970 онд лейбористуудын засаглал ирлээ. Тэд Өрнөд Европын социал-демократуудын дотор хамгийн зүүний гэмээр бодлого (социализм байгуулах) явуулжээ. Тэд шведийн социализмын загварыг Британид хэрэгжүүлэх гээд бүтэлгүйтжээ.
5. 1970-1975 онд Хит тэргүүтэй консерваторууд дахин засгийн эрх авлаа. Хитийн үед английн эдийн засаг хямралыг давж чадсангүй. Харин Умард Ирландын мөргөлдөөнд улам гүнзгий

татагдан оржээ. Гэвч нэг том ололт байсан нь Францын эсэргүүцлийг давж Европын холбоонд нэгдсэн явдал байв.

6. 1975 онд социализмыг туйлын зорилгоо болгодог лейбористууд дахин гарч ирлээ. Энэ 5 жилд Британид социализм байх эс байх эсэхийг шийдсэн улс төрийн ширүүн тэмцэл болсон юм. Британийн сонгогчид түүнийг няцааснаар лейбористууд зайгаа тавьж өглөө.
7. 1979 онд хатагтай Тэтчер засгийн эрх авснаар Английн хөгжлийн шинэ үе иржээ. Энэ үе өнөөг хүртэл үргэлжилж байна. Хугацаагаараа хамгийн удаан жил тус нам засгийн эрх барьсан нь энэ үе билээ.

Ийм хялбар ангилал хийхдээ, зөвхөн олон улсын эдийн засгийн харилцааг гол болгоогүй. Учир нь тус орны улалт үргэлжилсээр байсан нөхцөлд тийм хэмжүүр барих нь хангалттай бус. Гол нь тус орон дэлхийн бодлогод хэр нийцэж холбогдож ирэв, олон улсын тавцанд ямар байр эзлэв, олон улсын интеграцид хэр нэгдэн оров гэдгийг бодох ёстой. Бас энд ярьж буй сэдвийн дагуу "7-гийн бүлэгт" эзэлж ирсэн байр суурь нь чухал. Энэ бүлгийн дотор АНУ-тай холбоотны хувьд хамтран ажиллаж, америкийн үгээр л явсан гэнэхвэл айхтар буруутахгүй. Ялангуяа энэ нь Тэтчерийн засаглалын үед тэр үеийн АНУ-тай хоёр ерөнхийлөгч Рейган, Буш нартай тогтоосон харилцаанаас илт харагдсан юм.

Тэтчерийн засгийн газар монетаризм буюу неоконсерватизм (хожим нь тэтчеризм гэх болсон) гэгч бодлого хэрэгжүүлэх оролдлого хийсэн нь английн эдийн засагт гарсан шинэ нээлт шахуу болж үлджээ. Уг нь монетаризм бол АНУ-ын эрдэмтэн М.Фридманы онол. Түүнээс Тэтчер парламентын сүүдэр тан-химын ерөнхий сайд байхдаа бүтээлчээр суралцажээ. Эдийн засагт хяналт тогтоож, улсын зардлыг хязгаарлаж, ОУВС-ийн шахалтаар хэрэгжүүлж байсан мөнгөний бодлогыг өөрчлөх нь Тэтчерийн зорилго байв. Тэтчер энэ зорилгодоо прагматик аргаар хүрнэ гэж үзжээ. Мөнгөний хуримтлалд хатуу хяналт тавихгүйгээр инфляцийг тогтоох аргагүй. Төрийн аппаратыг цөмхөтлөхгүйгээр улсын зардлыг хасч чадахгүй. Бас татвар ногдуулах системийг өөрчлөн, хүний хувийн санаачилга, эрхийг нэмэх замаар коллективизмыг ямарваа хэлбэрээр няцаах ёстой. Ингэснээр өмч эзэндээ ойртоно. Тийм учраас Тэтчер өөрийн шинэ бодлогоо "өмчийн ардчилал" гэж нэрлэсэн юм. Түүний хувьд шинэ бодлогын туйлын зорилго нь "хувийн өмчтөнүүдээс бүрдсэн ардын капитализм" ажээ. Энэ бол 80-аад онд Их Британийн эдийн засгийн бодлогын цөм болж байлаа. Энэ зорилгод ганцхан дотроо тэмцээд хүрэхгүй. Дэлхийн эдийн засагт тус орны оролцоог нэмэгдүүлж, зөв байрыг нь эзлүүлж байж үүнийг биелүүлнэ. Бас хэзээний холбоотон АНУ-тай маш дотно харилцаатай байх ёстой.

Лейбористууд тийм маягийн харилцаа тогтоож чадаагүй. Ер нь Тэтчерийг хүртэл лав сүүлийн 40 орчим жил (Черчиллис хойш) тийм харилцаа бий болоогүй байсан. Тийм учраас Тэтчер ернэдийн орнуудын дотор Рейганы засаг захиргаатай хамгийн ойр дөт харилцаа тогтоосон гавьяатан болжээ. 70,80 оны зааг дээр олон улсын харилцаа ноцтой хямрахад ийм харилцаа английн аюулгүй байдлыг бэхжүүлсэн нь гарцаагүй. Харин Европ дахь гүншүүдтэйгээ хүйтэвтэр, бусдыгаа ганцаараа сөрсөн харилцаа бий болгосон юм. Би ЕХН-ийн гишүүн орнуудыг хэлж байна. Тэр үед Европт социал-демократууд хүчтэй байсан, дараа нь социалист Миттеран Францын ерөнхийлөгч болсон, ЕХН-ийн комиссыг социалист хүн толгойлох болсон зэргээс үүдэн тэдний хооронд учир битүүлэг тэмцэл үүсчээ. Британид социализм байгуулах гээд санасандаа хүрэлгүй зайлцгаасан лейбористуудыг үзэн ядах сэтгэл нь үүнд нөлөөлсөн биз. Лейбористууд Европын нэгдлийг болгоомжлон ажиглаж байсан бол консерваторууд сөрөг хүчин байхдаа түүний төлөө байгаагаар илэрхийлж, Хитийн үед ЕХН-д элссэнээ олзуурхдаг байлаа. Ийм нөхцөлд Тэтчер сонгогдсон нь европынхонд том олз болжээ. Тэгээд ч олон асуудлаар ойртоно, тэр үед хурцдаад байсан хөдөө аж ахуйн бодлогоор тохиролцоонд хүрнэ гэж гэнэн төсөөлөв. |этэл |этчер европын социалистуудын өмнө буулт хийхгүй гэж шуудхан мэдэгдэв. Тэтчерийг ЕХН-ээс ихийг хүртээд, багыг өгөх хүн гэж тэр үед болгоомжилж байсан нь зөв байжээ. ЕХН-ийн орнууд тус байгууллагад өгөх хувь хандиваа нэмэхийг Британиас шаардав. Хариуд нь Тэтчер тэр хандивийг нэг тэрбум фунтээр хорогдуулахыг шаардав. Энэ утгаараа гар татаад олигтой мөнгө өгөөгүй лейбористуудаас дорджээ. Энэ мэт хахир бодлого явуулсан нь тухайн цагтаа английн санхүүг арвижуулах нэг нөхцөл байсан байж магадгүй. Ямар ч атугай англичууд түүнийг эх орныхоо эрх ашгийг ягштал хамгаалж байна гэхээр ойлголт авсан юм. Тэтчерийн энэ шийдмэг зан "7-гийн бүлэгт" АНУ-ын дэмжлэгийг зүй ёсоор хүлээж, үнэхээр де Голлийн хэлснээр ЕХН-т АНУ-аас оруулж ирэх "Трояны морь" гэхээр байлаа. Ингээд ЕХН-ийн жижиг орнууд англитай ярилцахаас шантрах (жишээ нь бельгийн нэгэн дипломатын хэлснээр Тэтчертэй хэлэлцэн тохирох нь Иерихоны цайзыг эвдэхээс хэцүү байсан) болжээ. 60-аад оноос хойш Европт хатуу, тэгээд бас эмэгтэй националист "де Голль" гарч ирсэн нь тодорхой боллоо. 1982 онд Аргентинтай хийсэн дайнд британичууд ялалт байгуулснаар түүний цол гуншин дээр "төмөр хаталтай" гэсэн шинэ нэр нэмэгдэв.

80-аад оны дунд үеэс ЕХН-ийн интеграцын үйл явц шинэ шат руу орлоо. 1992 оны дараахи жил хязгааргүй Европын тухай" илтгэлийг Грюссельд тусгай комисс бэлтгэжээ. Гай таарч түүнийг Британиин гол төрд Кокфилд удирдан хийлгэжээ. Тэтчер Европын нэгдлийг бүрэн эрхт улсуудын хоорондын хамтын ажиллагааны энгийн нэг хэлбэр байлгах гэж зүтгэв. Тэр ч бүү хэл Британийн

мөнгийг европчууд сул авах мэтээр жиргэж эхлэв. Ингээд түүнийг Европын "гол тормоз", "хагагтай үгүй" гэхчлэн нүд үзүүрлэж огцрохыг нь далдуур хүсэх болжээ. Ингэж үлэв Европын төв банк бий болно гэдгийг өөрийнх нь засаглалын үйл цуглуулсан хөрөнгийг үрэн таран хийх ёроолгүй уут гэж бичигжээ бололтой. Европ дахь түншүүд нь "Британигүй нэгдмэл валютгүй байх, эсвэл Тэтчертэй цуг Европыг байгуулах" хоёрын аль нэгийг сонгож авах сонголтын өмнө тулгарав. Британигүй Европ гэдэг бол англичуудад өөрсдөд нь сэтгэшгүй хэрэг. Хүн ам ч дургүйцэж, нэг нам дахь нөхөд нь тухайлбал өөрийг нь анх итгэж засгийн газартаа ажиллуулсан Хит, өөрийнх нь засгийн газрын ГЯА-ны сайд Д.Хэрд нар түүнээс зааглаж холдов. Ийм нөхцөлд огцрохоос өөр зам байсангүй. Энд би Британийн эдийн засгийн бодлогыг дотоодын улс төрийн амьдрал, Европ дахь түншүүдтэй нь тогтоосон харилцаан дээр гаргахыг оролдлоо. Энэ талаар "Европын холбоо" гэсэн дараагийн бүлэгт бас өгүүлнэ.

"7-гийн бүлгийг" төлөөлүүлж АНУ, Япон, ХБНГУ, Их Британийг авч үзэхэд доорхи хэд хэдэн хандлага ажиглагдаж байна. Үүний дүгнэлтийг төлөөлүүлэн ойлгоно уу.

1. Хэт их гүрний статусаа хадгалсаар буй АНУ, ийм статусаа олж авахын төлөө тулштай ажиллаж буй Япон, ХБНГУ, ийм статусыг алдсаар өнөө хүрч, одоо хориглолтод орсон Их Британи гэсэн 3 янзын харилцан адилгүй дүр зураг энд харагдав.

2. Эдгээр орны хөгжлийн зам харилцан адилгүй хоёр чиглэлээр явжээ. Дайны буруутан бөгөөд ялагдал хүлээсэн Герман, Япон хоёр прогресс хэлбэрээр урагшилж, ялсан АНУ, Их Британи хоёр эрх мэдлээ цувуулан алдсаар иржээ.

3. АНУ дэлхий нийтийн бүх үйл хэрэгтэй зууралдаж, бүх асуудалд орж, ХБНГУ, Их Британийг дайны дараахи Европын тогтолцоо түгшээж, харин Япон дан ганц эдийн засагтаа бүх анхаарлаа төвлөрүүлсэн 3 янзын төлөв ажиглагдаж байна.

4. Америкчуудыг олон арван жил шаналгаж ирсэн дэлхийн эдийн засгийн шинэ дэг журам өнөөг хүртэл бүрэлдэн тогтож чадаагүй байна. Цаашдаа тийм дэг журмыг хүн төрөлхтөн тогтоож хүчрэх эсэх тухай асуудал ч маргаантай.

5. "7-гийн бүлэг" эдийн засгийн гэсэн шинж чанараа улам бүр өөрчилж, дэлхийн улс төрийн амьдрал руу орж байна. Үйл ажиллагаа, хэлэлцэх асуудлын хүрээ тэлсээр байна. Энэ утгаараа цаашид дэлхийд ямар нэг асран хамгаалагч, тэжээн тэтгэгч, зарга таслагч болж мэдэхээр байна.

6. Дэлхийд өрсөлдөн гарч ирж буй аж үйлдвэржсэн орнуудын өмнө "7-гийн" зарим орон хүчгүйтэж өрсөлдөөнд тамирдаж, зах зээлээ алдаж болох магадлал бүрэлдэв.

7. "Хүйтэн дайн" дууссаны дараа "7-гийн бүлэг" олон улсын харилцааны шинэ нөхцөлд чиг баримжаагаа гаргаж байна.

Энэ эвсэл өөрөө хөдөлгөөнд оржээ. Тэгэхдээ шинээр бий болсон, бий болж байгаа геополитикийн шинэ орчин, цэрэг-улс төрийн нөхцөлд тэр бүр хурдан дасч чадахгүй байна.

Холбогдох ном хэвлэл

1. Ё.Накасонэ, Я.Мураками, С.Сато, С.Нисибэ. После "холодной войны" (Совместное исследование) М, "Прогресс", "Универс"., 1993
2. В.И.Попов. Маргарет Тэтчер: Человек и политик, М, "Прогресс"., 1991
3. В.Стунденцов. Мировая экономика в 1993-1994гг: распогодилось? "Мировая экономика и международные отношения" № 1, 1995
4. А.Пороховский Россия и современный мир "Вопросы экономики" № 1. 1995
5. W.R.Smyser. Goodbye, G-7, "The Washington Quarterly" Winter, 1993
6. G.J.Irenberry. Salvaging the G-7, "Foreign Affairs" (Vol. 72. No.2, 1993)
7. H.Jager. The Global Exchange Rate System in Transition, "De Economist" 139, NR.4, 1991
8. W.Tims. The IMF and the World Bank: from stability and development to adjustment and transition, No 13, International Finance, "Clingendael", The Hague, Netherlands
9. A.I.Macbean and P.N.Snowdon: The Main Institutions, "International Institutions in Trade and Finance" London, 1991
10. The Political Economy of Japan. Volume 2. The Changing International Context, Edited by Takashi Inoguchi and Daniel I.Okimoto, Stanford University Press, California

буруушаасан билээ. Жак Делор хэлэхдээ, "Тэтчерийн буруушаагаад байгаа шийдвэрүүдийг ЕХН-ийн зөвлөл санал нэгтэй гаргасан. Тэр үед Тэтчер өөрөө ч байж байсан. Энэ бол өөрийнх нь хийсэн ажил" гэж няцаажээ. Маастрихтын гэрээнд гарын үсэг зурсан засгийн газрын тэргүүн Ж.Мейжор олон талаасаа дайралт эсэргүүцэлтэй зэрэг тулав. Өөрийнх нь тэргүүлдэг эрх баригч нам дахь "Европт үл итгэгчид" болон сөрөг хүчнийхний сацуу Европын интеграцын хэтийн төлөвийн талаар эргэлздэг сайдууд нь ч түүнд багагүй садаа болжээ. Олон нийтийн санал асуулгаас англичууд Маастрихтын гэрээ гэж юу болох талаар тодорхой төсөөлөлгүй байгаа нь харагдаж, энэ нь байдлыг яггүй хүндрүүлсэн юм. Ийм эгзэгтэй байдал Их Британийн парламентад санал хураахад нөлөөлж болзошгүй байлаа. Хэрэв Маастрихтыг эсэргүүцэж байсан өөр нэг арлын орон Данид эсрэг санал өгсөн бол Европын холбоо баян тансаг Их Британийг бараг алдах байсанд эргэлзээ алга. Данийн социал-демократ засгийн газар уг гэрээг батлуулах гэж хоёр удаа үндэсний санал хураалт явуулжээ. Ерөөсөө Маастрихтын гэрээ хүчин төгөлдөр болсонд Данийн байр суурь ихээхэн нөлөөлсөн гэж үздэг. Учир нь Дани бусаддаа нөлөөлөх ёстой байсан бололтой. Даничуудын дэмжинэ, дэмжихгүй гэдэг нь дараахи учир шалтгаанаар тайлбарлагдаж байв. Энэ бол Европын бусад улс түмэнд нэгэн адил хамаарах нийтлэг асуудал учраас энд жишээ болгоё.

- Хүйтэн дайн" эцэс болсон учраас ардчилсан, тогтвортой, энх амгалан Европыг байгуулахад саад болох зүйлгүй;
- Уг гэрээ эдийн засгийн өсөлтийг хангаж, ажилгүйдлийг бууруулах ба хэрэв дэмжихгүй гэвэл эдийн засагт хохиролтойгоос гадна үндэсний валютын ханш унаж мэднэ.
- Дани нь бүрэн эрхт байдлаа хамгаалах үүднээс Европын холбоонд өөрийн гэсэн жин нөлөөтэй болж, санал өгөх эрх эдэлнэ. Ингэж баймааж нь ирээдүйн бодлого боловсруулж, шийдвэр гаргахад оролцох эрхтэй болно;
- Хэрэв гэрээг эс дэмжвэл Европын холбооны бусад гишүүд Данийг ганцаардуулах талаар нэгдэж, ЕХН-ээс гаргахыг шаардаж болзошгүй;
- Данийн хөрш Скандинавын орнууд, Дорнод Европын орнууд хүртэл Европын холбоонд нэгдэхээр хөөцөлцөж байгаа учир шалтгааныг бодолцох;
- Эцэст нь Дани нь өөрийн онцлог боломжийг харгалзан Европын холбооны зарим хамтын ажиллагаанд оролцохгүй байх эрхтэй гэдгээр тэрхүү дэмжих ёстой шалтгаан гэдгээ томъёолжээ.

Дэмжихгүй байх учир шалтгаан гэвэл:

- 5.1 сая хүн амтай өчүүхэн Дани германчууд, франчууд олонхи болсон 340 сая хүн амтай холбооны бүтцийн хүрээнд бүрэн эрхт байдлаа хамгаалахаас өөр аргагүй болно;

- "Хүйтэн дайны" үед зөгнөл мэт байсан Маастрихтын гэрээ нь Европт хэт нүсэр зэвсэглэсэн их гүрнийг бий болгоно;
- Бүх эрх Брюссельд шилжих учраас уг гэрээ ардчилсан гэхээсээ илүү хүнд суртлын шинжтэй;
- Уг гэрээ бизнесийг эрчимтэй хөгжүүлэх ашиг сонирхлыг бий болгож, тэгснээрээ Данийн одоогийн амьжиргааны өндөр түвшин, байгаль орчин хэлмэгдэх болно;
- Маастрихтын гэрээ нэг хэсэгтээ үр дүнд хүрэхгүй баахан удаж цаг алдана;
- Данийн эдийн засаг Маастрихттэй, Маастрихтгүй хүчтэй хэвээр үлдэнэ гэсэн үндэслэл байжээ.

Энэ бүхнийг зэрэг, сөрөг хүчин зүйл гэж үзвэл аль ч талаас нь аваад үзсэн Маастрихтэд гарын үсэг зурсан бүх оронд адилхан хамаарах мэт. Эдгээр шалтгааныг үндэс болгож эхний санал хураалт явуулахад Данийн хүн амын олонхи нь эсрэг санал өгч, Европынхны зүрхийг зүсэх (яагаад гэвэл интеграцын үйл явц гэнэт тасарсан мэт байлаа -Зох) шахжээ. Гэвч Данийн засгийн газар үл шантран хоёр дахь санал хураалтыг явуулжээ. Тэгэхдээ хүн амын дургүйцээд байгаа бодит шалтгааныг харгалзсан юм. Нэгдмэл валют, хамтын аюулгүй байдлын асуудлаар Данийг оролцохгүй байхыг ГЯЯ-ны сайд нарын хэмжээнд хийжээ. Дараа нь 1992 оны сүүлээр Эдинбургт болсон дээд хэмжээний уулзалтаар валютын холбоо болон батлан хамгаалах, аюулгүй байдлын хамтын ажиллагаанд оролцох албагүй гэсэн онцгой статус Данид олгожээ. Энэ нь Маастрихтын гэрээний талаар бүх ард түмний санал хураалт дахин нэг явуулах боломж олгосон хэрэг болов. Парламентад намуудын хооронд харилцан буулт хийж, үүний дүнд улс төрийн 8 гол намын 7 нь Европын интеграцад оролцохыг даничуудад хандан уриалжээ. Ингээд хоёр дахь шатны санал хураалтаар дэмжигчдийн тоо давж, Европын 12 орны сэтгэл уужирсан юм. Тэгээд ч тэд энэ санал хураалтын дүнд улс төрийн онцгой ач холбогдол өгч байлаа. Санал хураалтын дүн Европын интеграцын эсрэг хүчтэй зогсож буй Британид бодитой нөлөөлнө гэж тэд үзжээ. Даниас гадна Их Британи, ХБНГУ хоёр уг гэрээг батлаагүй байсан тэр үе шүү дээ. Гэвч нэгэнт Дани уг гэрээг сайшаасан болохоор Британийн парламент уг гэрээг батлах зам нь шуударчээ. Германы парламентын хоёр танхим засгийн газар нь уг гэрээнд гарын үсэг зурсан тэр 1992 ондоо гэрээг баталсан боловч Европын холбоог эсэргүүцэгчид түүнийг Үндсэн хуульд нийцэхгүй гэж зүтгэсээр Үндсэн хуулийн шүүхээр хориг тавиулж дөнгөсөн байв. Тийм учраас ХБНГУ-ын үндсэн хуулийн шүүх нааштай шийдвэр гаргахад Данийн байр суурь бас нөлөөлжээ.

Эдгээрээс гадна холбооны төсвийг нэмэгдүүлэх асуудал сэтгэл зовоов. Ерөөсөө түүнгүйгээр Маастрихтын гэрээнээс үүсэн гарах үүрэг зорилтыг биелүүлж чадахгүйд хүрнэ. Европын

комиссын тооцоолсноор 1999 он гэхэд холбооны зардал 86 тэр бум ЭКЮ хүрнэ. Энэ бол наад захын хэмжээ. Ингээд еөрт нь илүү дарамт ногдоно гэж үзсэн баян орнууд зардлыг тэгж нэмэхийг сайшаахгүй байлаа. Зардлыг буулгаж 79 тэрбум болгохыг Их Британи санал болгосон боловч уг төслийг Испани, Португал, Грек, Ирланд эрс эсэргүүцжээ. Валютын холбоо байгуулах асуудал ч сунжирч мэдэхээр төлөв тэр үед ажиглагдаж байв. 12 улсын дийлэнхи нь зохих болзлоо хангачихсан бол 1997 оноос валютын холбоо ажиллаж эхэлнэ гэж төлөвлөсөн. Үүний наана гишүүн бүх улс инфляц, зээлийн хүүгийн хэмжээ зэрэг үзүүлэлтээр Маастрихтын гэрээний шалгуурыг биелүүлсэн байх ёстой. Гэтэл ер төсвийн алдагдал зэрэг ноцтой бэрхшээлтэй тулгарч буй улс бий. Ийм учраас 1997 он гэдгийг 1999 он гэж залруулахыг зарим улс битүүхэн хүссэн байж магад. ОУВС-гийн илтгэлд зааснаар, төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувьтай тэнцэх ёстой атал 4 хувь хүрч мэдэх, мөн гишүүн орнуудаас лав 4-5 нь 1996 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 60 хувиас давсан өртэй байх бололтой. Энэ бол гэрээ хэрэгжихээс өмнө хийсэн таамаглал. Ийм бодит бэрхшээлүүд байсан хэдий ч уг гэрээ заасан хугацаандаа хүчин төгөлдөр болсон юм.

Маастрихтын гэрээний хэрэгжилтийн явцад урьд нь шинээр гишүүнээр элсэх хүсэлтээ тавьсан 3 оронтой хийсэн хэлэлцээ амжилттай дууссан билээ. 1993 онд Австри, Финланд, Шведтэй эхлүүлсэн хэлэлцээ жилийн дараа үр дүнд хүрч, энэ 3 улс Европын холбоонд орох болзлыг хүлээн авсан юм. Мөн эдэнтэй зэрэг шахуу хэлэлцээнд суусан Норвег ч уг болзлыг хүлээн авч, дөрвүүлэнг нь хамтатган 1994 оны тавдугаар сард Европын парламент зөвшөөрөл өгч, эцсийн үгийг эдгээр орны ард түмэн хэлэх л үлджээ. Тэр үед төсөөлснөөр Европын холбооны гишүүд 16-д хүрэхээр байв. 1994 оны зургадугаар сард Австрид, аравдугаар сард Финландад, арваннэгдүгээр сард Шведэд санал хураалт явуулж хүн амын ихэнх нь Европын холбоонд нэгдэхийн төлөө саналаа өгчээ. Хамгийн сүүлд Норвегт явуулсан санал хураалтаар хүн амын ихэнх нь эсрэг санал өгөв.

1995 оны нэгдүгээр сарын 1 бол Европын холбоо хил хязгаараа тэлж, ам бүл нэмсэн өдөр юм. Одоо Финландын зүүн хилээр Оростой, мөн Австриар хуучин Югославын нутаг, Дорнод Европын орнуудтай хил залгах боллоо. 1986 оноос (12-уулаа байсан үе) хойш Европын холбооны нутаг дэвсгэр гуравны нэгээр, хүн амын тоо 6.2 хувиар, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 7 хувиар нэмэгдэж, дэлхийн худалдаа-эдийн засгийн том эвсэл болжээ. Хэдийгээр АНУ газар нутгийн хувьд Европын холбооноос 3.2 сая ам дөрвөлжин километрээр илүү (4 дахин их газар нутагтай байсан бол одоо 3 дахин болж буурсан) байгаа ч дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр 10 хувиар дутуу байна. Бас хүн амын тоогоор АНУ, Япон хоёр нийлээд Европын холбоог гүйцэхгүй

болов. Япон Европын холбооноос олон үзүүлэлтээр ард нь орлоо. Хойшдоо Европын холбоонд Кипр, Мальт хоёр элсэхээр өргөдөлөө өгснийг Европын комисс Европын холбооны зөвлөлд уламжлаад байна. Туркийн өргөдлийг судалж байна. Дорнод Европын ихэнх орон Европын холбоотой "Европын гэрээ" байгуулжээ. Орон тооны бүс гишүүн маягтай элсэхийг эдгээр орон эхний ээлжинд тавих болов уу. Энэ бол хэтийн төлөвийн тухай асуудал.

Ямар ч утгаар авч үзсэн өнөөгийн Европын холбоо бол дэлхийн эдийн засагт чухал байр эзлэх бүс нутгийн нэг томхон бүтэц билээ. Энэ бол ирээдүйд, алс хэтдээ нэг том нэгдсэн субъект болж төлөвших анхны бүтэц нь гэлтэй. 1995 онд 15 орны 7 нь хилийн хяналтыг буулгаж, энэ бүлэг орны нэгдсэн гадаад хилийн хяналтыг (Үүнийг товчхоноор "Шенгенийн виз" гэж нэрлэдэг) бэхжүүлжээ. Ла-Маншийн хоолойгоор нүхэн зам тавьж, байнга зорчих болсноор Британийн арлыг геополитикийн хувьд хойг гэж үзэхээс өөр аргагүй. Нэгдсэн дотоодын зах зээл, нэгдсэн үнэ, нэгдсэн санхүү-валют, мэргэжлийн дипломын талаархи нэгдсэн стандарт, нэгдсэн гадаад бодлого, нэгдсэн аюулгүй байдал зэрэг бүх салбар "нэгдсэн" байна гэдэг нь интеграцын цар хүрээ хэр байхыг илтгэнэ.

ГУРАВ. ИРЭЭДҮЙН ТУХАЙ ТӨСӨӨЛӨЛ

Европын холбооны түүхийг товчхон авч үзлээ. Энэ түүх цаашдаа шинэ шинэ агуулга хэлбэрээр байжин үргэлжлэх нь дамжиггүй. Тэр талаар одоо өгүүлье. Энэ холбооны статусын асуудлаас эхэлье. Энэ холбоо бол анх улс төрийн шинжтэй үүсээгүй, тийм учраас улс төрийн яг загварчилсан нэгдлийн (эвсэл) тухай, тийм нэгдлийн олон улсын статусын тухай яриа арай эртдэнэ. Тэгээд ч холбоог байгуулагчид "Улс төрийн шинжтэй Европын" төлөө тэмцээгүй, хэрэв тийм Европыг эмхлэн байгуулъя гэсэн бол АНУ-ыг анх үүсгэн байгуулсан загвараар (федерализм) явах ёстой байсан. Тэгэхээр Европын холбоо маань улс төрийн хувьд хэтдээ нэг бүтэц болж чадахгүй. Федерализмын оронд өргөн консенсус дэвшигдэн гарна. Энгийнээр хэлбэл хэн юу хийх вэ? гэдгийг европчуудад холбоо зааж чиглүүлнэ, харин яаж хийх вэ? гэдгийг заах албагүй гэсэн үг. Тийм учраас нэгдсэн шинэ европыг байгуулагчдын хувьд гол зорилт нь Европын нэгдсэн эрх зүйн баримт бичиг (1986 он), Маастрихтын гэрээг (1992 он) хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх явдал. Орчин үеийн дэлхий дахинд энэ гэрээ үлгэрлэн нөлөөлөх талаасаа ч, анхдагч болсны хувьд ч түүхэн үүрэгтэй. Өнөөгийн дэлхий хэдийгээр "Хүйтэн дайны" мөсийг хайлуулж байгаа боловч янз бүрийн, эрс ширүүн гэмцлийн талбар хэвээр байна.

Бараа таваар, хөрөнгө мөнгө, үйлчилгээ, иргэд чөлөөтэй шилжиж байх "Дөрвөн эрх чөлөөний" тухай дээр өгүүлсэн. Тэр эрх

чөлөө л үндсэндээ европчуудын хэрхэн ажиллах вэ? гэдгийг заах түлхүүр болно. Тийм учраас Европын холбоог цааш нь тэгнэ, ингэнэ гэсэн хатуу загвар хүснэгт, нарийвчилсан томъёо байх албагүй.

Нэгэнт 15 улс нэг холбоонд олон талаар нэгдсэн учраас захирах захирагдах ёсны зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх вэ? гэсэн асуудал гарна. Тухайлбал улс үндэстний ба үндэстнээс дээгүүрх институтын хоорондын эрх хэмжээг хэрхэн зааглах тухайд. Үүнд Европын парламент хариу өгөх байх. Энэ талаар дараагийн хэсэгт өгүүлнэ. Хамтаараа шийдэх нь ашигтай бол холбооны хэмжээнд шийдэж болно. Хэрэв үндэстний хэмжээнд юмуу, орон нутгийн хэмжээнд шийдэх нь ашигтай бол холбоо түүнд оролцохгүй, холбооны үйл ажиллагаа үйлчлэх албагүй. Үүнийг Маастрихтын гэрээнд тусгаж өгсөн. Энд Европын комисс их үүрэгтэй. Энэ бол "Европын барилгын инженерийн" үндсэн үүрэг гүйцэтгэх байгууллага юм. Энэ талаар мөн дараагийн хэсэгт өгүүлнэ. Ер нь энэ мэтээр бичвэл орон нутгийн (улс бүрийн) онцлогийг европын нэгдэлтэй хэрхэн холбож хослуулах тухай асуудалд цогц хариу өгөх болно. Энэ бол миний хувьд хэт ахадсан тулгалт. Хэтдээ ч европчуудыг нэлээд зовоох асуудал байж магад.

Бас нэг асуудал бий. Тэр бол Европын үлдсэн улс үндэстэнг Европын холбоотой хэрхэн холбох тухай юм. Өөрөөр хэлбэл 13 улсын интеграцын ололт амжилтыг үлдсэн европчууд нь хэрхэн үнэлэх цэгнэх тухай ярьж байна. Жишээ нь Швейцар ч юмуу, Исландад түүнийг ажрахгүй байх. Норвег, Кипр, Мальт хэтдээ нийлдэг юм гэж бодъё. Гэтэл Дорнод Европ, Балти хавьд Европын холбоонд хувь заяагаа даатгах гэсэн олон улс байна. Тэр асуудлыг 1996 онд шийдэх болов уу. Нэгдмэл Европын нийтлэг институтуудын бүтэц, бүрэн эрхийн асуудлаар засгийн газар хоорондын бага хурал 1996 онд хийхээр төлөвлөж байна. Бага хурлын хүрээнд Маастрихтын гэрээний хэрэгжилтийг хэлэлцээд, эргэж харах зарим зорилтыг бага хурал тавих байх. Тэр үед гишүүдийн тоо 20 дөхсөн, шийдэх хэлэлцэх асуудал бишгүй хуримтлагдсан байх нь магад.

Европын комиссыг бараг арваад жил толгойлсон Ж.Делор эдгээр асуудалтай холбогдуулан "Их Европын" тухай үзэл баримтлал дэвшүүлснийг дурдах ёстой. 1990 онд Дорнодод болсон түүхэн үйл явдлыг харгалзан Европын нэгдлийн асуудалд ихээхэн болгоомжтой, цэнэж хандахыг тэр үед Делор уриалж байсан. Социализмын цэрэг-улс төр, эдийн засгийн эвсэл задарснаар бүлэг орон өөрсөд нь хандана гэдгийг ойлгож байсан хүн бол Делор юм. Тэр үед Дорнод Европын орнуудыг өрнөдийн институудад элсүүлэхийг шаардагчид ч олон байсан биз. Ялангуяа Орос болон ТУХН-ийн Европын хэсгийн орнуудын талаар Делорын болгоомжилсон байр суурь одоо ч үнэ цэнээ алдаагүй байна. Тийм учраас "Их Европын" номлолдоо Европт өөр нэгэн бүтэц бий болгохыг санал болгосон юм. "Их Европын" эхний шат нь Европын

холбооны орнуудаас гадна EFTA-ийн гишүүн орнууд, мөн Балтийн болон хуучин Югославын зарим орныг нэгтгэн нэг эвсэлд оруулах, дараагийн шатанд үлдсэн хэсэг орныг үе шатчилан оруулах ажээ. Энэ бол үнэмлэхүй зөв шийдэл биш гэж Делор өөрөө хүлээн зөвшөөрсөн. Энэ бол харилцан хүндэтгэх, хамтран ажиллах, харилцан туслах үндсэн дээр бий болох шинэ Европ. Тэгэхдээ харилцан буулт хийж байж үүнд хүрнэ. Харин тийм зориг европчуудад хэзээ бүрдэх вэ? гэвэл өөр асуудал болно. Бас "Их Европ" байвал "Бага Европ" байх (Антант ба Бага антант гэж байсан шиг) ёстой. Бага европын хүрээнд интеграц хийгээд түүнээ ихтэй нь нэгтгэж бас болно. Ер нь энд нэгтгэнэ гэдэг ойлголтыг яг бичсэнээр нийлчэхнэ гэснээр төсөөлж болохгүй. Би интеграцын тухай, хамтын нийгэмлэг бүхий Их Европын тухай ярьж байна. Тэгэхдээ улирч одсон "Нийтийн зах зээлтэй" яг төстэй гэсэн үг биш. Улс бүр өөрийнхөө бүрэн эрхт байдлыг хамтран хэрэгжүүлдэг, тэгэх нөхцөл нь хамтарсан бодлого нь болдог (жишээ нь хөдөө аж ахуйн бодлого, эдийн засаг нийгмийн нэгдэл, ШУТ технологийн хамтарсан судалгаа зэрэг) байх тухай яриа юм.

Энд европын удирдагчид, улс төрчдийн сануулдаг зүйл бол энэ асуудалд ямарваа туйлшрал гэж байх ёсгүй бөгөөд ямагт прагматик байх нвдал. Энэ бол өнөөдөр ч, алс хэтдээ ч Европын холбооны шийдвэр гаргах гол зарчим байх болов уу.

ДӨРӨВ. ЕХН-ИЙН ИНСТИТУТУУД

Европын холбооны түүхчилсэн намтраас танилцууллаа. Энд гарчгаа ЕХН гэж авсныг болгоох биз ээ. Би "хамтын нийгэмлэг" гэж 1992 оны өмнөх бүтцээр нь нэрлээгүй, ерөөсөө нийт Баруун Европын хамтын нөхөрлөл гэсэн санаагаар хэлсэн юм. Одоо жинхэнэ албан ёсны нэр нь Европын холбоо. Европын холбооны гол 3 институтын тухай товчхон ойлголт өгье. Дээр бичсэн зүйлд Европын хамтын нийгэмлэгээс гадна өөр олон институтын нэр гарсан.

Европын парламент

Европ хэр интеграцчилагдсаны нэг бэлгэ тэмдэг бол Европын парламент билээ. Зохиогч миний бие 1994 оны тав, зургадугаар сард Нидерландын олон улсын харилцааны институтэд мэргэжил дээшлүүлээд дараа нь Европын олон улсын байгууллагуудаар явж, танилцах ладлага хийх завшаан тохиолдсон юм. Тэр үед Брюссельд Европын парламентад зочилсон явдал надад хамгийн өндөр сэтгэгдэл үлдээсэн бөгөөд "Засгийн газрын мэдээ" сонинд (1994.08.23. №63) энэ тухайгаа дурсан бичсэн. Европын парламент бол Европын холбооны хууль тогтоох байгууллага. Анхлан ЕХН-ийн

төсвийн төсөл хэлэлцэн батлах явцуухан үүрэгтэй байгуулсан. Энэ нь ч тухайн үедээ аргагүй байв. Учир нь Европын холбоонд хандивлах мөнгөний асуудлаар улс бүрт улс төрийн намууд хурц тэмцэл хийж байлаа. 1979 онд анхны сонгууль явуулахад гишүүн 9 орныхоо хүн амын тоонд тохируулан 410 депутат сонгож байлаа. Дараа нь Өмнөд Европын 3 орон шинээр элссэнийг харгалзан гишүүдийн тоог 518-д хүргэсэн. Гэтэл дахиад л (12-уулаа байсаар атал) гишүүдийн тоог өсгөх шаардлага 1994 оны сонгуулиар харагдсан юм. Учир нь уг сонгууль Маастрихтын түүхт гэрээ хүчин төгөлдөр болсны дараахи анхны сонгууль байсан бөгөөд Германы нэгдэл (хуучин БНАГУ-ын ард түмнээс сонгогдох ёстой), ер нь хамтын ажиллагааны эрч далайц нэмэгдсэн, олон улсын нөхцөл байдал өөрчлөгдсөн, шийдэх асуудал өргөжсөн зэрэг тодорхой нөхцөл үүнд нөлөөлсөн. Ингээд гишүүдийн тоог 567 болгожээ. Гэтэл энэ бүрэлдэхүүнээр удаан явсангүй. 1995 онд дахин 3 гишүүн улс нэмэгдлээ. Депутатын тоог дахин нэмэхээс аргагүй боллоо. Одоо уг парламент 626 гишүүнтэй байна. Жин нөлөөг нь харгалзаад ХБНГУ-д хамгийн олон буюу 99 суудал өгдөг. Дараагийн байрт Франц, Итали, Их Британи тус бүр 87 гишүүнтэй байх эрхтэй. Хамгийн жижиг улс Люксембург 6 суудалтай, бусад нь энэ хоёр заагийн дунд тус тусан байр эзэлнэ. Энэ бол тэр орны жин нөлөө хэр байхыг илтгэнэ гэсэн үг биш. Энд улсын нөлөө гол биш, харин тэр улсад оршиж үйл ажиллагаагаа явуулдаг улс төрийн намын нөлөө гол юм. Парламентад улсаа төлөөлөх журамгүй учраас аль улсын хэдэн депутат сонгогдох нь тус улсад онцын хамааралгүй. Улсаасаа улс төрийн аль нэг нам бүлгийг төлөөлж сонгогддог ба шийдвэр гаргахдаа улс төрийн намуудын эвсэл л үүрэг гүйцэтгэнэ. Энэ л тус парламентыг өвөрмөц, дэлхийд өөр хаана ч байхгүй гэж тодорхойлох нөхцөл юм.

Маастрихтын гэрээгээр тус парламентыг өргөн эрх эдлүүлэхээр тогтсон. Европын нэгдсэн зах зээл, байгаль орчин, санхүү-мөнгөнөөс эхлээд гадаад бодлого, аюулгүй байдал, хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, мэргэжлийн дипломыг харилцан хүлээн зөвшөөрөх, иргэд чөлөөтэй зорчих зэрэг олон асуудал энэ парламентын ажлын хүрээнд орно. Эдгээрийг 19 байнгын хороогоороо дамжуулан хийж гүйцэтгэнэ. Мөн Европын холбооны гүйцэтгэх байгууллага-Европын комиссын ерөнхийлөгчийг батлах явдал шинээр нэмэгдсэн үүрэгт орж байна. Парламентын үйл ажиллагааны бас нэг өвөрмөц тал нь 3 газар ажилладагт байгаа юм. Францын Страсбург хотод сар бүр гишүүн 7 хоног цугларч, өргөтгөсөн хуралдаан хийнэ, гэтэл 19 хороо нь Европын комисс, Европын Зөвлөлтэй ажлаа зохицуулах үүднээс сард хоёр 7 хоногоор Брюссельд цугларна. Улс төрийн намын бүлгүүд энэ хоёр газар ихэвчлэн ажлаа явуулна. Парламентын нарийн бичгийн дарга нарын газар болон улс төрийн намын ажилтнууд нь

Люксембургт байрлана. Намын бүлгийн хувьд (хамгийн сүүлийн хоёр сонгуулиар жишээ авав) Европын социалист намын бүлэг ямагт олонхи болж байна. Одоо 626 гишүүний 222 нь социалист, социал-демократ, лейборист намыг төлөөлж байна. Дараагийн байрт Европын ардын намын бүлэг (христосын ардчилсан бүлэг) тогтвортой яваа. Тэд 180 гишүүнтэй. Гуравдугаар байрыг либерал болон ардчилсан-реформист бүлэг эзлэх ба энэ 3 бүлэг бол Европын улс төрийн амьдралд гол нөлөөтэй улс төрийн намуудын нэгдэл юм. 1995 онд дахин 3 гишүүн орон Европын холбоонд нэгдсэнээр социалистууд бүр ч бэхжлээ. Энэ мэт жагсаавал улс төрийн 10-11 намын бүлэг дараалан суудал эзлэнэ. Энд 1984 оны сонгуулиар гэнэт нэмэгдсэн бүлэг бол Италийн засгийн эрхийг тэр үед барьж байсан хэт барууны "Итали орон урагшаа!" хэмээх нийгмийн хөдөлгөөн, Францын радикалууд юм.

Европын холбооны зөвлөл ба Европын зөвлөл

Өмнө бичсэнд зөвлөл гэсэн нэр нэлээд гарсантай холбогдуулан энэ хоёр байгууллагыг хольж хутгахгүй байх үүднээс товчхон тайлбар хийе. ***Европын Зөвлөл*** бол Европын холбооны гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн, Европын комиссын ерөнхийлөгч (зарим үед I НН-ны сайд нар, Комиссын гишүүд орно) нараас бүрддэг, жилд хоёр удаа чуулдаг уулзалтын механизм юм. Энэ зөвлөл 1974 оноос үүргээ гүйцэтгэж ирлээ. Уулзалтын явцад Өрнөд Европын хувьд тухайн үед хамгийн чухлаар тавигдаж буй гадаад бодлого, аюулгүй байдал, эдийн засаг, санхүү-валютын асуудал хэлэлцэж, удирдамж чиглэл, онолын баримжаа гаргаж өгдөг юм.

Европын холбооны зөвлөл нь гишүүн улс бүрийн сайд нараас бүрддэг. Хэлэлцэх асуудлаас шалтгаалан янз бүрийн салбар хариуцсан сайд нар цуглардаг. Хөдөө аж ахуйн сайд нар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ тарифын асуудлаар, ажлаар хангах асуудлаар Хөдөлмөрийн сайд нар, эсвэл эдийн засгийн сайд нар уулзах жишээтэй. Хэрэв Европын холбооны гадаад бодлого хэлэлцвэл мэдээж ГЯЯ-ны сайд нар цугларна. Цугладаг гол газар нь Европын холбооны нийслэл -Брюссель хот, эсвэл зарим үед Люксембургт уулзана. Гишүүн улс бүр зургаа зургаан сараар ээлжлэн зөвлөлийн ерөнхийлөгч маягтай ажиллах ба зөвлөлийн байнгын ажиллагааг хангах үүрэг бүхий нарийн бичгийн дарга нарын газар ажилладаг юм. Энэ зөвлөл бол байнгын ажиллагаатай гол байгууллагын нэг Европын холбооны тухай гэрээний дагуу засгийн газар хоорондын хамтын ажиллагааг шууд хариуцахаас гадна шийдвэр гаргахад нөлөөлөх гол санал боловсруулж Европын комисст оруулдаг.

Европын комисс бол 1992 оноос ийм шинэ нэрээр ажиллаж эхэлсэн ЕХН-ийн гол байгууллага. Түүний гол үүрэг бол Европын холбооны засгийн газрын үүрэг гүйцэтгэх. Энэ талаар түрүүчийн

хэсэгтээ цухас дурдсан. Гүйцэтгэх хүчтэй засаглал байна гэсэн үг. Тэгээд ч ЕХН-ийн комиссын ерөнхийлөгч "7-гийн бүлгийн" удирдагчдын жил тутмын дээд хэмжээний уулзалтад 8 дахь зочин болж оролцсоор ирснийг эргэж саная. Маастрихтын гэрээ- гээр энэ комисст өргөн эрх олгосон. Жишээ нь, гэрээний зарим заалт, зөвлөлийн баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд шийдвэр гаргах, тэдгээрийг зохицуулах; улс тус бүрийн засгийн газар, фирмүүдтэй холбогдох тодорхой асуудлаар гэрээний заалтыг нарийвчлан хэрэгжүүлэх (жишээ нь Европын парламентаас гаргах шийдвэр хэрэгжүүлэхэд зарим үед даралт шахалт ч үзүүлж болно); бас гэрээ хэлэлцээрийн заалт хэрхэн биелж буй, түүнийг хэрхэн хангаж байгаа талаар хяналт тавих; хамтын нийгэмлэгийн сан хөмрөгийн асуудал энд бас орж байна.

Комиссын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэд хэдэн хороод- той, Зөвлөхүүдийн хороогоор дамжуулан гишүүн улсуудын төлөө- лөгчдийн санал бодлыг комисс хүлээн авна. Гэвч тэдний зөвлөмж бодлого боловсруулахад ноцтой нөлөө үзүүлэхгүй. 1986 оны нэгдсэн эрх зүйн баримт бичигт зааснаар зөвлөхүүдийн хороо дотоодын нэгдмэл зах зээл бий болгоход нэлээд үүрэгтэйг заасан. Хоёр дахь салбар болох удирдлагын хороод анх 1962 онд хөдөө аж ахуйн зах зээл байгуулах асуудлаар үүсч, ажиллаж эхэлжээ. Энэ бол комиссын ажлыг голлон нугалдаг хэд хэдэн салбар хорооноос бүрдэх нэг механизм юм. Шийдвэрийг олон- хийн саналаар гаргана. Гаргасан шийдвэрийг хооронд нь уял- дуулах, салбар салбарт тохируулан хэрэгжүүлэхэд зохицуулах хороо гол үүрэгтэй. Эдгээр 3 төрлийн хороодоос гадна тусгай продюссер гэж бий. Энэ бол хэрэгцээтэй зарим үед тухайн тодорхой шийдвэр хэрэгжүүлэхэд ажилладаг байнгын бус нэгж юм.

Европын комисс бол ЕХН үүссэн цагаас эхлэн практикийн явцад хэлбэр дүрсээ олж төлөвшсөн байнгын ажиллагаатай байгууллага. Зүйрлэбэл хуучин социалист орнуудын ЭЗХТЗ-ийн нарийн бичгийн дарга нарын газартай төстэй. Гэхдээ гол ажлаа Европын холбооны зөвлөлтэй нягт уялдуулж явуулдаг. Өөрөөр хэлбэл, "комисс-гишүүн улсуудын сайд нар" гэсэн яриа хэлцээ- ний механизмаар дамжуулж үүргээ гүйцэтгэдэг гэсэн үг. Уг зөвлөлөөр хэлэлцэх хэргийн бүх төсөл, гаргах баримт бичгийн төслийг комисс сайд нарын өмнө тавина. Одоо комиссын өмнө Европын холбоонд шинээр нэгдсэн 3 улсыг интеграцчилах, нэгдсэн валютад шилжих, холбооны бүтцэд өөрчлөлт хийх зорилт тулгарч байна.

Аливаа гүйцэтгэх засгийг сонгодоггүй атал Европын комиссыг 4-5 жилийн хугацаагаар Европын парламент сонгоно. Энэ бол 1992 оноос хэвшсэн шинэ практик. Комиссын ерөнхийлөгчөөр Жак Делорын дараа Люксембургийн Жак Сантер ажиллаж байна. Комисс нь Франц, Герман, Итали, Испани, Их Британи зэрэг Европын холбооны томхон орон тус бүрээс хоёр, бусад гишүүн орнуудаас тус бүр нэг нийлээд 20 гишүүнээс бүрдэнэ.

Комиссын гишүүд өөрийн улсын засгийн газраас үл хамааран, зөвхөн хамтын нийгэмлэгийн нийтлэг эрх ашиг. Европын парламентын хууль тогтоомжид нийцүүлэн ажиллах ёстой. Бүх шийдвэрийг хамтаараа гаргаж, эцэст нь хамтаараа хариуцлага хүлээнэ. Гэхдээ энэ хэдэн хүн комиссын бүх ажлыг үүрч явдаг гэвэл арай тийм биш. Энэ хэдэн гишүүдэд хүч хавсрах олон зуун хүн Брюссельд Европын холбооны төвд ажилладаг. Гэхдээ эдний аппаратын зардал нийт хамтын нийгэмлэгийн төсвийн дотор өчүүхэн хувь эзэлдэг. Комиссын харъяа хороод, хэлтэс газрууд, ерөнхий газарт (нийт 30 орчим) нийт 17 мянган ажилтан Брюссель Люксембургэд хуваагдаж ажиллаж байна.

ТАВ. ЕВРОПЫН ХОЛБОО БА ПОСТКОММУНИСТ ОРНУУД

Өнөөдөр хуучин социалист байсан олон орон, ялангуяа шинээр тусгаар тогтносон ТУХН-ийн зарим орон олон үзүүлэлтээр хөгжиж буй орнуудын хэмжээнд яваа гэдгийг түрүүчийн нэг бүлэгт тэмдэглэсэн байгаа. Үнэндээ ч хөгжлийн түвшин, эдийн засагт учирч буй элдэв бэрхшээл, шилжилтийн үйл явцын хурд зэрэг нь урьдын ЭЗХТЗ-ийн гишүүн байсан, эсвэл зожиг тасархай байсан Албани мэтийн орнуудыг гэдрэг ухрааж, шинээр аж үйлдвэржсэн бүү хэл, цоо шинээр аж үйлдвэржиж буй олон орны ард оруулсан билээ. Энэ тухай дараагийн бүлэгт цухас дурдана. Тэгэхээр Европын холбооноос посткоммунист орнуудад явуулж буй бодлого энэ үндэслэлийг харгалзахаас өөр аргагүй. Тийм учраас Европын харьцангуй өндөр хөгжилтэй хэсэг оронд (жишээ нь Унгар, Польш, Чех, Балти хавийн) хандах өөр нэг бодлого, Европын үлдэх хэсэг оронд хандах өөр нэг бодлого, эцэст нь ТУХН ба Монголд хандах тусдаа өөр нэг бодлогын тухай ярьж байна. Харин энд хэн бүхний мэдэх болсон ТАСИС хөтөлбөрийн тухай өгүүлье. ТУХН ба Монголд зориулсан энэ хөтөлбөр Европын холбооноос хөгжиж буй орнуудад явуулдаг хөгжлийн бодлогын нэг хэсэг билээ. Энэ бодлогын ерөнхий зорилт нь:

1. Хөгжиж буй орнуудын эдийн засаг-нийгмийн хөгжилд тус нэмэр болох;
2. Хөгжиж буй орнуудыг дэлхийн эдийн засгийн системд татан оруулах;
3. Ядууралтай тэмцэх явдал байдаг.

Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хамтын ажиллагааны хүрээнд техникийн ба санхүүгийн тусламж үзүүлэх, хүнсний яаралтай тусламж үзүүлэх, худалдааны хөнгөлөлт олгох зэрэг олон төрлийн төсөл боловсруулжээ. Хөгжлийн хамтын ажиллагааны үндэс нь Ломейн конвенц. Энэ бол Ази-Номхон далай, Африк,

Латин Америкийн орнуудад Европын холбооноос явуулах бодлогыг тодорхойлдог. Монгол Улс нь аль ч утгаар авч үзсэн (хөгжлийн түвшин, газар зүйн байрлал) энэ конвенцийн хүрээнд туслалцаа авах учиртай. 1989 онд Монгол Улс ЕХН-тэй албан ёсны харилцаа тогтоосон бөгөөд олон хүчин зүйлээр ингэж харилцах үндэс тэр үед бүрэлдээд байсан юм. Жишээ нь 80-аад онд дэлхийн эдийн засагт Азийн орнуудын эзлэх жин нөлөө эрс нэмэгдсэн. Нөгөө талаас Монгол Улс нь Азийн төвд геополитикийн хувьд Азийн хүчирхэг хоёр гүрний дунд орших учраас энэ байдал нь Европын холбооны сонирхлыг татсан байх. Ялангуяа эдийн засгийн үсрэнгүй давшилт хийж буй социалист Хятад, улам бүр нуран унаж буй ЗХУ, түүнээс салж гарч шинээр тусгаар тогтнох улсууд руу явуулах ирээдүйн бодлогыг Монголгүй төсөөлөх аргагүй.

Үүнээс гадна Монголын өөрийнх нь дотоодын нөхцөл байдал ч Европын холбоо, улмаар бүх хандивлагчдын анхаарлыг зүй ёсоор татсан. Тухайлбал, газар зүйн онцгой өвөрмөц байрлал, улс төрийн ардчиллыг Азидаа үлгэр жишээ болохуйцаар тайван замаар хэрэгжүүлсэн, улс төрийн тогтвортой байдал, Монголын ардчилсан шинэ Үндсэн хууль, нэгдмэл цул үндэстэн, эцэст нь тусламж хүртээд үр дүнг үзүүлэх найдвар (байгалийн баялаг, байгаль орчны онгон ариун байдал, хүн ам цөөн гэх мэт) зэргийг энд дурдаж болох юм. Энд зөвхөн эдийн засгийн хүчин зүйлийг тоочоогүйг анхаарах хэрэгтэй. Европын холбооноос хөгжиж буй орнуудад тавих гол 3 зорилтыг дээр дурдсан. Тэр гурвыг дотор нь задалбал энх тайвныг дэмжин сахиулах, хүний эрхийг хамгаалж, ардчиллыг хөгжүүлэх, хүний хүчин зүйлийг хөгжүүлэх, өөрийгөө тэтгэх эдийн засгийн чадавхитай болгох, байгалийн баялгийг тэнцвэртэй ашиглах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах гэх мэт олон зорилго хамтын ажиллагааг тодорхойлох ёстой.

Ломейн анхны конвенцийг 1975 онд Тогогийн нийслэл Ломе хотноо тэр үеийн ЕХН-ийн 9 орон, Ази-Номхон далай, Африк, Карибын сав газрын 46 орон хамтран баталсан, хамгийн сүүлд дөрөв дэх конвенцийг 1989 онд Европын холбооны 12 улс, хөгжиж буй 68 улс баталсан бөгөөд конвенцийн үзэл санааны дагуу ЕХН-ийн комиссоос АЛА хөтөлбөрийг батлажээ. Монгол Улс 1989 онд Европын холбоотой харилцаа тогтоомогцоо АЛА хөтөлбөрт автоматаар нэгджээ. 1992 оноос Европын холбоотой хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, АЛА хөтөлбөрийн хүрээнд мал эмнэлэгийн салбарт зарим төсөл хэрэгжүүлсэн юм.

Гэвч энэ байдал удаан үргэлжлээгүй. Монгол Улс Ази, Африк, Латин Америкийн орнуудтай нэг хөтөлбөрт нэгдэх үндэслэл бүрхэг байв. АЛА хөтөлбөрийг анх боловсруулахдаа Европын холбооны орнууд хуучин өөрсдийнх нь колони, хараат байсан орнуудад тусламж үзүүлэхийг гол болгосон. Гэтэл Монгол нь Европоос олон зуун жил тасархай түгжирхий явж ирсэн. Нөгөө талаас Монгол бол Зөвлөлтийн маягийн эдийн засгийн тогтолцоонд 70 гаруй жил

хөгжсөн (хэрэг дээрээ дагуул орон байсан), Оростой шууд хил залгаагаас гадна Зөвлөлтийн хуучин Дундад Азийн орнуудтай ижил төстэй, нийтлэг тал нь илүү, хөгжлийн түвшин ойролцоо, шилжилтийн үеийн хямрал бэрхшээлийг адил замаар туулж, хандивлагчдын зээл тусламж-жийг мөн адил хэмжээнд нэг хэмжүүрээр хүртэж буй зэрэг нийтлэг зүйл олон. Энэ бүхнийг харгалзвал Монголыг АЛА хөтөлбөрт бус ТАСИС хөтөлбөрт оруулах нь зүйтэй мэт сэтгэгдэл хаа хаанаа төрсөн юм. Тэгээд ч ТАСИС хөтөлбөр яг цагаа олж хэрэгжиж эхлээд байсан үе. Тийм учраас 1992-1993 онд ТАСИС хөтөлбөрт Монголыг багтаах асуудлаар Европын холбоонд яриа хэлцээ явагджээ. Монгол Улсын засгийн газар ч зээл тусламж-жийн үр өгөөжийг бодож, ТАСИС хөтөлбөрт нэгдэх хүсэлтэй байв. Уг асуудлыг хэлэлцсэний эцэст Их Британи, Франц хоёр Монголыг ТАСИС-т оруулах асуудлаар эсэргүүцсэн, ХБНГУ, Нидерланд, Дани дэмжсэн дүн гарсан юм. Ингээд эцсийн бүлэгт Монголыг ТАСИС-т багтаахаар шийджээ. 1993 оны сүүлээс Монгол улсыг ТАСИС-т нэмж оруулав. 1994 оноос бид тус хөтөлбөрийн хүрээнд зарим төсөлд оролцож байна.

Өнөөдөр Европын холбоотой Монголыг холбож буй гол шугам, техникийн болон бусад салбарт тусламж хүртэх боломж нь ТАСИС болоод байна. ТАСИС хөтөлбөрийг зохицуулагч Европын комиссоос томилогдон Монголд ажиллаж манай Үндэсний хөгжлийн газар уг асуудлыг Монголын талаас хариу-цан зохицуулж байна. Зохиогч миний бие 1994 оны хавар Европын холбоонд (Брюссель) зочлохдоо ТАСИС хөтөлбөрийг хариуцсан гол гол мэргэжилтнүүдээс мэдээлэл авсан бөгөөд тэр талаар сонирхсон хэнтэй ч түүнээ хуваалцахад бэлэн байгаагаа дашрамд дурдъя.

ТАСИС хөтөлбөр үүссэн үүх түүхээс товчхон дурдъя. 1990 он. Дэлхийн социализм сүүлчийнхээ хүчийг шавхаж дууссан жил. 1990 оны арванхоёрдугаар сард (Германы нэгдэл ба нэгдсэн Германы анхны чөлөөт сонгуулийн дараа) Ром хотноо Европын зөвлөлийн уулзалтаар (дээд хэмжээний) ЕХН-ээс Зөвлөлтийн эдийн засгийн реформд дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргажээ. Энэ бол тухайн үедээ Горбачевын хэрэгжүүлж байсан реформын тодорхой салбарт техникийн тусламж үзүүлэх асуудал байлаа. Ийнхүү ТАСИС хөтөлбөр нэгдмэл ЗХУ-ын үед эхэлжээ. Тэгэхдээ зөвхөн техникийн гэж явцууралгүй зах зээлийн эдийн засагт шилжих, ардчилсан нийгэм байгуулахад нь тусална гэж үзсэн юм.

Энэ зарчимд үндэслэн 1991 оны долдугаар сард 1991-1992 онд ТАСИС хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизм болон хууль зүйн үндсийг зааж өгсөн дүрэм Европын зөвлөлөөс баталснаар уг хөтөлбөр хэрэгжиж эхлэв. ЗХУ задарсны дараа ТАСИС-ыг шинэ нөхцөлд тохируулан дахин шинэчлэжээ. 1992 оны хоёрдугаар сард ТУХН-ийн гишүүн орнууд болон Гүржийг (тэр үед Гүрж нь ТУХН-д

элсээгүй байсан) оролцуулан ирээдүйн хамтын ажиллагааны тухай протоколд Европын комисс гарын үсэг зуржээ. 1992 оны сүүлээр ТУХН-тэй хамтран ажиллах дүрэм Зөвлөлөөс баталж, 1993 онд түүнийг дахин шинэчилж, тэр дүрмийн дагуу өнөө хүртэл техникийн тусламжийн асуудлыг шийдэж байна. ТАСИС-ийн дагуу ТУХН ба Монголд 1993-1995 онд Европын холбооноос үзүүлэх техникийн тусламжийн хууль зүйн үндэсийг зохицуулж хэрэгжүүлнэ. Энэ хооронд тусламж хүртэх улс тус бүрт тусламж үзүүлэх систем тогтож хэвшсэн байх учиртай. Тусламжийн төсвийг жил бүр баталдаг тул заавал урт хугацааны байх албагүй. Тусламжийн ерөнхий чиглэл нь ТУХН-ийн гишүүн орнууд болон Монголын одоогийн онцлог, гол нь эдийн засгийн бэрхшээл, шилжилтийн үйл явцын ялгаа зөрүүг харгалзах ёстой. Жишээ нь ТУХН-ийн гишүүн 12 улс, Монголыг тус тусад нь жагсаагаад 6 гол салбарт алин нь ямар тусламж илүү авах ёстойг авч үздэг. Орос Украин хоёр эдгээр 6 салбарт зэрэг тусламж хүртэх ёстой гэж оржээ. Гэтэл Армэнд үйлд-вэрийг шинэчлэх, хүний хүчин зүйлийг хөгжүүлэх, эрчим хүчний гэсэн 3 салбарт, Беларусс үйлдвэрлэлийн шинэчлэл, хүнсний үйлдвэрлэл түүний хуваарилалт, тээврийн салбарт, Узбекистан үйлдвэрлэлийн шинэчлэл, хүний хүчин зүйл, хүнс тэжээлийн салбарт тусламж авахаар төлөвлөжээ. Энд би 5 салбарыг дурдлаа. Зургаа дахь нь харилцаа холбоо юм. Энэ жагсаалтад Монгол, Тажикистан хоёр хожуу нэмэгдсэн. 1993 онд хоёр жилээр төлөвлөгөө боловсруулж байх үед энэ хүснэгтэд 11 орон орсон байгаа. Эдгээр 6 салбараа гол, бусад тэргүүлэх гэж дотор нь хуваадаг. Армений хувьд эрчим хүчний гачаалд орсон тул түүнийгээ гол гээд бусдыг нь тэргүүлэх гэж үздэг. ОХУ-ын хувьд үйлдвэрийн шинэчлэл, хүчний хүчин зүйл голлох, хүнс тэжээлийн үйлдвэрлэл хуваарилалт, эрчим хүч, тээвэр, харилцаа холбоо тэргүүлэх байх жишээтэй. Эдгээр салбарт тусламж үзүүлэхдээ тухайн орны тухай бүх судалгааг удирдамж болгоно. Эдийн засгийн реформын явц хэр байгаа, юун дээр алдаж онож буй, эдийн засгийн гол гол үзүүдэлт, засгийн газар нь юун дээр илүү анхаарч, ямар бодлого явуулдаг, өр шир, урьд үзүүлсэн тусламжийн үр дүн, биелэлт, ОУВС, Дэлхийн банк, Европын шинэчлэл хөгжлийн банк, цаашлаад Европын холбооны улсуудтай тогтоосон хоёр талын харилцаа, хандивлагч орнуудтай хийж буй зохицуулалт гээд бүгд энд орно. Оросын хувьд газар зүйн аль бүсэд нь илүү туслахыг ч авч үздэг. 1993 оны төсвөөр Урал болон Баруун Сибирьт гол тусламжийг хаяжээ. Гэхдээ энд "тусламж" гэдэг үгийн утгыг хөөж Европын холбоо бол ердөө л тэжээн тэтгэгч, ерөөсөө тэжээх үүрэгтэй гэж мухар сохроор ойлгож болохгүй. Бас тусламжийн үр дүнг Европын холбооноос өөрөөс нь эрж хайж таарахгүй. Тэгэх тусмаа байгаа юмыг яг байгаагаар нь ойлгож хэвшсэн монголчуудын хувьд үүнийг хамааруулан ярьж байна. Бид өнгөрсөн 70 гаруй жилд тэжээн тэтгүүлж ирсэн урьдын

тогтолцоогоо, тухайлбал Зөвлөлтийн тусламжийг хандивлагчдын тусламжтай яг адилтгах, улмаар тэгж адилтгаад сэтгэлд нь хүрэхгүй бол чамлах гээд байдаг. Хандивлагчид, түүний дотор Европын холбоо монголчуудад цай даалимба нийлүүлэх албатай биш. Эсвэл байгалийн гамшиг тохиолдсон нутагт өвс тээвэрлэх асуудлыг хариуцах ёсгүй. Бид Европын холбооны дэргэд суугаа элчин сайдаараа дамжуулан Европын холбооноос хүнсний (жишээ нь цөцгийн тос) тусламж хүсч амаа таглуулж байсан. ТАСИС хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тусламж авах тухайн орны тухай бүх судалгааг хийсэн байдаг гэдгийг дээр дурдсан. Тэрчлэн Монголын тухай хангалттай лавлах тэнд бий. Монгол хэдэн сая хүн амтай, хэдэн сая толгой малтай, үүнээс сүүний чиглэлийн үнээ хэд, махны чиглэлийн хэд гэхчлэн судалгаа тэдэнд байгаа. Монголын талын хүсэлтийг авч үзэхдээ хүн амыг нь малын тоо толгойд хувааж үзээд, үүнээс нэг хүн ам тутамд хэдэн үнээ ногдохыг гаргаж, Монгол нь Европын холбооноос цөцгийн тос хүсэх ямар ч үндэсгүйг тогтоожээ. Ингээд манай хүсэлт няцаагдах жишээтэй. Үүнийгээ тэд юу гэж тайлбарлав гэхлээр, Монголд хүнсний тусламж үзүүлэх шаардлагагүй, Монгол бол АНА хөтөлбөрийн шугамаар тусламж авдаг Ази, Африкийн ядуу буурай орнуудтай адилгүй, Монголд хүнсний үйлдвэрлэлийг зохион байгуулах ба хуваарилах асуудал л байна гэсэн юм.

Сэдвээсээ хальж ийм жишээ татсаныг болгооно бизээ. Энэ жишээ Монголоос гадна ТУХН-ийн зарим оронд мөн адил хамаарах байх. Монголыг зах зээлийн засгийн харилцаанд аль болох хохирол багатай шилжүүлэхэд туслах, Монголын боловсон хүчин бэлтгэхэд туслах, менежментийг хөгжүүлэх, зах зээлийн эдийн засгийн харилцааны орчин бий болгох хууль зүйн сайн үндэс төлөвшүүлэх зэрэг бидний хувьд цоо шинэ гэмээр тусламжийн хэлбэр ТАСИС хөтөлбөрт орж байна. Тэр л биднийг цаашид хөтлөх учиртай. Гэхдээ Азийн орнуудтай харилцах үндсэн чиглэлийг тусгасан Азийн стратеги гэдэг баримт бичгийг 1994 онд Европын холбоо баталсан. Түүндээ Монгол, Лаос, Камбож мэтийн орнуудад ядуурлыг арилгахад нь тусална гэсэн заалт оруулсан. Энд Дорнод Европын орнуудын тухай өгүүлсэнгүй. Тэр талаар дараагийн дэд бүлэгт үргэлжүүлэн үзнэ үү.

ЗУРГАА. ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА (OECD)

Номын "Европын холбоо" гэсэн бүлэгт энэ байгууллагын тухай өгүүлэхээс өөр аргагүй байна. Юу гэвэл, Европын эдийн засгийн системийн тухай өгүүлж байгаа бол энэ байгууллагыг тойрон гарах учиргүй билээ. Өнөөдөр дэлхий дээр 200 орчим улс (НҮБ-ийн

гишүүн 185 орон) байлаа гэж үзэхэд хүн амын 16 хувь, харин үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний гуравны хоёр, экспортын тавны гурав, хөгжиж буй орнуудад үзүүлдэг туслам-жийн тавны дөрвөн хувь энэ байгууллагын гишүүн 24-хөн оронд ногдож байдаг юм. (Англиар: *The Organisation for Economic Cooperation and Development*)

Үүх түүхээс нь сөхөж үзвэл, энэ байгууллага мөн л дэлхийн хоёрдугаар дайны дараахи Европ дахь шинэ нөхцөл байдлын бодит тусгал, үр дүн болон гарч ирсэн юм. Чухамдаа дайнд сүйдсэн Европын орнуудад тусламж үзүүлэх асуудлыг тухайн үедээ зориглон хариуцах олон улсын байгууллага, сан юу байлаа. Дайнд сүйрсэн аж ахуй нь ямар байв, дэлхийн хуурай газрын хэдэн хувь нь колони, хагас колони байдалтай байв гэхчлэн асуулт тавибал энэ байгууллага үнэхээр цагаа олж бий болсон гэлтэй. Энэ бол үндэс нь "Маршаллын төлөвлөгөөгөөр" тавигдсан олон улсын институтын нэг. Анхандаа ганцхан Европын бүс нутгийн эвсэл маягтай үүссэн. 1948 онд Европын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагыг дээрхи төлөвлөгөөний үндсэн дээр бий болгосон. Тэр нь явсаар 1960 онд OECD-ийн тухай конвенцээр ийм байгууллага болж өргөжсөн юм. Тийм учраас 1948-1960 онд Европын байгууллага байсан гэж үздэг. Анх 20 хүрэхгүй гишүүн түүнийг үндэслэсэн бол эгнээгээ тэлсээр эдүгээ 24 болжээ. (АНУ, Канад 1960 онд, Япон 1964 онд, Австрали 1971 онд, Шинэ Зеланд 1974 онд түүнд нэгджээ) Тухайн цагтаа Югослав түүнд тусгай статустай оролцож байсан. Тийм учраас түүнийг дан ганц өрнөдийн (жишээ нь бүрэлдэхүүнд нь Австрали, Шинэ Зеланд зэрэг далайн орон, Турк орсон) гэж үзэх аргагүй. Харамсалтай нь Югослав тэр аятайхан боломжоо хожим алдсан юм.

Дэлхийн эдийн засгийн хөгжил дайны дараа америкчуудын төсөөлснөөр (Бреттон Вудсын системээр) яваагүй гэдгийг дээр тэмдэглэсэн. Гэвч АНУ болон Өрнөд Европын орнууд дэлхийн эдийн засагт тогтвортой байдлыг хангах, үйлдвэрлэлийн өсөлтийг нэг хэмжээнд тогтвортой өсгөх, олон улсын валют-санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, чөлөөт худалдаа хөгжүүлэх чиглэлд олон зүйл санаачилан хийж байсны дотор бидний энд ярьж буй байгууллага ордог юм. Голлон эдийн засаг, нийгмийн салбарт засгийн газрын хоорондын хамтын ажиллагааг зохицуулах, өргөжүүлэх асуудлыг OECD эрхэлдэг. Ингэхдээ доорхи зорилтуудыг шийдэж иржээ.

Үүнд:

- Ажлаар хангах асуудлыг хамгийн түрүүн анхаарсан.
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийг нягт холбоотойгоор авч үзсэн.
- Хөгжиж буй орнуудад тусламж үзүүлэх асуудлыг зохицуулж ирсэн.

- Олон талт, шахалт хавчилтгүй эдийн засгийг дэлхийн хэмжээнд өргөжүүлэхийг зорьсон юм. Эдгээр зорилт бол стратегийн гэж үзмээр гол шугам бөгөөд тус байгууллагыг шинэчлэх, олон улсын нөхцөлд тухай бүр тохируулах хувьсал хийхэд өөрчлөгдөөгүй ирсэн зорилтууд юм.

Нэгэнт дэлхийн хэмжээний зорилт шийдэж байгаа учраас ажлын цар хүрээ нүсэр бөгөөд түүнийг доорхи бүтцийн хүрээнд зохицуулан гүйцэтгэж байна.

Үүнд:

- Эдийн засаг ✓
- Тоо бүртгэл ✓
- Худалдаа ✓
- Санхүүгийн зах зээл ба татвар ✓
- Гадаадын хөрөнгө оруулалт ба түүний орчин ✓
- Өрсөлдөөн ба хэрэглээ ✓
- Эрчим хүч ✓
- Хүрээлэн байгаа орчин ✓
- Хүнс тэжээл, хөдөө аж ахуй, загасны аж ахуй ✓
- Боловсрол, ажлаар хангах ба хөдөлмөр, нийгмийн асуудлууд
- ШУА ба аж үйлдвэр
- Хөгжлийн тусламж
- Гишүүн бус орнуудтай харилцах харилцаа
- Төрийн удирдлага

Дээр жагсаасан нь тус байгууллагын анхаарах гол салбарууд. Ийм нүсэр зорилт шийдэж байгаа учраас 24 орон төдийгүй, Европын холбоо, түүний комисс, ОУВС, Дэлхийн банк бүгд энд харилцан хамаатай оролцдог.

1990 он хүртэл OECD нь биднээс хэт алслагдсан, хүршгүй хаалттай эвсэл маягтай байсныг нуух юун. Үнэндээ дэлхийн эдийн засгийн системд социалист орнууд зөв байраа олохгүй будилсаар эцэст нь дампуурч, хамтын байгууллага -ЭЗХТЗ нь нурж унасны дараа л ийм ид шидтэй байгууллага байсныг олж мэдсэн билээ. Тэр үеийг хүртэл тус байгууллага ч бидэнтэй хамтран ажиллах боломжоор тун хомс байлаа. Социализм дэлхийн системийн хувьд нуран унаж байсан 1990 оны хавар OECD-ийн Зөвлөл Европ болон дэлхий дахинд бий болсон шинэ нөхцөлд зохицуулж тус байгууллагыг бэлтгэх шийдвэр гаргасан юм. Тухайн үеийн байдлыг судалсны эцэст OECD-ийн хуримтлуулсан туршлага мэдлэг нь посткоммунист орнуудыг зах зээлийн харилцаанд шилжихэд тусламж үзүүлж хүрэлцэхүйц гэсэн дүгнэлт хийжээ. Гагцхүү ингэж туслахын тулд өөр нэг бүтэц бий болгох ёстой. Тийм бүтэц болох OECD-ийн ерөнхий нарийн бичгийн даргын орлогчийн ахласан *Шилжилтийн эдийн засаг бүхий орнуудтай хамтран ажиллах төв*

удалгүй ажилдаа оржээ. Энэ төвийн үйл ажиллагааны хүрээнд посткоммунист орнуудыг хоёр хэсэг болгон тусламж дэмжлэг үзүүлж байна. Үүнд:

1. Төв болон Дорнод Европын орнууд: Албани, Болгар, Чех, Эстон, Унгар, Латви, Литва, Польш, Румын, Словак, Словен - нийт 11 улс;
2. ТУХН-ийн гишүүн 12 улс ба Монгол Улс (ТАСИС хөтөлбөртэй яг дүйж байна)

1990 онд тус төвийг нээхдээ Европын орнуудад тусламж үзүүлэх гэж явцуухан утгаар нэрлэж байсан бол ТУХН үүссэн, Югослав задарсан зэрэг шалтгаанаар 1993 оноос "Европын" гэсэн тодотголыг хэрэглэхээ больжээ. Тэгэхдээ тусална гэдгийг санхүүгийн хүрээнд авч үзэх ёсгүй. Уг төв ч тэр, ерөөсөө OECD өөрөө санхүүгийн байгууллага, мөнгөний эх ундарга биш юм. Өнөөдөр Монгол мэтийн посткоммунист орнууд мөнгө-санхүүгээр гачигдаж дутагдаад байгаа нь үнэн. Гэвч энэ онгорхойгоо OECD-гээр нөхүүлэхийг оролдох нь бүтэшгүй хэрэг. Өнөөдөр бидэнд хамгийн их дутагдаж байгаа, зах зээлийн эдийн засагт хэрэгтэй хууль эрхийн үндсийг (орчин) бий болгоход туслах бодлого барьж байна. Энэ зорилгоор дээрхи төв байгууллагынхаа бусад нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулж, эрэл хайгуул хийж, судалгаа явуулж байна.

Тус байгууллага посткоммунист орнуудад тусламж үзүүлэхдээ хоёр хэсэг болгон харилцаж байгааг яг тэр чигт нь ойлгож боломгүй. Хөгжлийн түвшин, газар зүйн байрлал, шилжилтийн явцыг харгалзан дотор нь бас ангилал хийж байна. Ажлын ерөнхий программын хүрээнд бүгдийг нь хамруулан авч үздэг ч "Шилжилтийн түншүүд" гэдэг тусгай программд Чех, Унгар, Польш, Словакийг, "Тусламжийн программ" гэдэгт шинээр тусгаар тогтносон улсуудыг оруулах жишээтэй. Дундад Ази, Өвөр Кавказын орнууд Молдов, Монголыг энд нэг бүлэг болгон харилцах нь тус байгууллагын хувьд илүү оновчтой байгаа бололтой. Эдгээр орны төлөөлөгчдийг оролцуулсан уулзалт зөвлөлгөөн хийж, гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засаг дахь хувийн секторыг хөгжүүлэх асуудлаар ярилцсан. Эдгээр орны хувьд OECD-ээс үзүүлэх гол тусламж нь зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэн дэмжих хууль эрх зүйн тогтолцоо бий болгох, шинэчлэгдэж байгаа буюу хувьчлагдаж байгаа аж ахуйн газруудыг зүг чигээ олоход нь туслах, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн бодлого, зах зээлийн эдийн засгийн эрх ашигт нийцсэн найдвартай зайлшгүй мэдээлэл статистикаар хангах, ТУХН-ийн зарим орны хувьд цэргийн үйлдвэрийг иргэний зориулалттай болгон өөрчлөхөд туслах, цөмийн эрчим хүчний аюулгүй байдал, байгаль орчны асуудалд чиглэгдэж байна.

Мөн "СИГМА" гэдэг программын хүрээнд тус байгууллага болон дээрх төв Европын холбооны тусламжийн программтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж байна. Энэ нь Төв болон Дорнод Европын орнуудын төрийн удирдлагын бүтэц, системийг шинэчлэхэд чиглэсэн программ юм. Шинэ төвийн "бүртгэл" гэсэн бас нэг ажлын чиглэл байдаг. Посткоммунист орнуудад хандивлагч-орнууд, олон улсын байгууллагаас үзүүлдэг тусламжийн тухай мэдээллийн үндсэн дээр тэр нь бий болж хэрэгждэг чиглэл юм. Эцэст нь сургалтын асуудлыг авч үздэг.

Сургалтыг эрхлэн явуулах төвүүдийг Анкара, Будапешт, Хопенхаген, Вена хотод нээгээд посткоммунист орнуудын залуу эдийн засагчид, бизнесмен, хуульч, төрийн удирдлагын ажилтнуудыг бэлтгэж байна. Гэхдээ энд анхаарах нэг зүйл бий. OECD-ийн үзэж байгаагаар, үйлдвэрлэл, маркетинг, хуваарилалтын чиглэлээр хүмүүс бэлтгэх, тийм чиглэлийн мэдлэг мэдээллээр хангахад хялбар, харин тийм мэдлэгт түшиглэсэн эдийн засгийн орчин бий болгоход (ялангуяа гадаад хөрөнгө оруулалт авахад) илүү хэцүү гэнэ. Мэдлэг дотроо зах зээлийн эдийн засгийг удирдах үр өгөөжтэй арга чухал. Энэ бол Монгол мэтийн зах зээл рүү цоо шинээр хөл тавьж орнуудад хамаарах зүйл. Урьд нь улсын төвлөрсөн төлөвлөгөөтэй байсан орнуудад улсын секторын үүрэг ролийг шинээр тодорхойлох шаардлага тулгарч байна. Ингэснээр хөгжиж буй, бас өрнөдөөс тусламж хүртдэг олон оронд туршлага болох ач холбогдолтой ажээ. Жишээ нь тусгаар тогтнолоо олж аваад удаагүй, үндэсний эдийн засагтай байгаагүй, ядуу буурай олон орон замын бэлчирт байгаа. Европын холбоо OECD-ийн аль алин нь энд ТУХН-ийн зарим орныг нэрлэж байгаа. Тийм орнуудад хөрөнгө оруулалтыг үр дүнгүй цацаж болохгүй. Тийм учраас хөрөнгө оруулалт хийх тааламжтай нөхцөл бүрдүүлэхэд анхаарах ёстой. Энэ бол бидэнд тэдгээр хандивлагчид, олон улсын байгууллагаас тавьж буй нэг ёсны шаардлага гэж үзэж байна.

ДОЛОО. ПОСТКОММУНИСТ ЕРТӨНЦИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Европын холбоо болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тухай егүүлсэн түрүүчийн дэд бүлгүүдэд хуучин социалист байсан орнуудын хөгжлийн төлөв, цаашлаад тусламж хүртэх болсон учир шалтгааныг цухас дурдлаа. Энд уг асуудлыг арай тодруулна. Тэгээд ч Европт 90-ээд он хүртэл оршин тогтнож олон улсын эдийн засгийн нэг томхон эвсэл болж байсны хувьд ЭЗХТЗ-ийн дампуурсан шалтгааныг бас тайлбарлах ёстой.

ЭЗХТЗ-ийн гишүүн байсан орнууд (Вьетнам, Кубаас бусад нь) Европын холбоо, OECD-ийн аль алинтай нягт харилцаатай байгаа.

Гэхдээ харилцаж буй олон улсын тэр хоёр байгууллага, хөрш, түншүүд маань посткоммунист орнуудын эдийн засагт бий болсон бодит байдал, саад бэрхшээлийн учрыг олох гэж биднээс дутахгүй чармайлт гаргаж, хойшид тусгаж авууштай зөв зүйтэй дүгнэлт хийж байгаа гэдгийг тэмдэглэх ёстой. Тэдний хийсэн дүгнэлтүүд олон жилийн өмнө манай нийгэм-эдийн засгийн систем, хамтын ажиллагааны арга хэлбэрийг дүгнэж байснаасаа айхтар хол зөрөхгүй байна. Бид ХХ зууны нийгмийн дэвшлийг социализмтэй зүй ёсоор холбох ёстой гэж үздэг байсан бол тэд ШУТ-ийн ололт, түүнээс нийгэм-эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө, улс орон ард түмэн, бүс нутгуудын харилцан хамаарал зэргийг энэ зууны хөгжил дэвшилтэй холбож ирсэн. Бид ангийн тэмцлийг энэ зууны гол үйл явдал, зөрчлийг нөхцөлдүүлэх уг сурвалж гэдэг байсан бол тэд хөгжил хамтын ажиллагааг эрхэмлэсэн.

Үнэхээр хүн төрөлхтөний гуравны нэгээс илүү нь бөгөөд хүний болон нийгмийн оюун санаа, зан суртахууны нөөц боломжийг бүх талаар нээх замаар замнаж байгаа гэж тооцогдсон 15 орон байлаа. Энд нийгмийн дарлалыг бүх талаар халсан мэт байсан. Хоцрогдсон, дайнд сүйрсэн аж ахуйг өөд татаж, үй олон сая хүнийг өлсгөлөн гуйланчлалаас аварч, бичиг үсэгт сурган гэгээрүүлсний хувьд социализмын ач тусыг мартаж болохгүй. Гэхдээ олсон амжилтдаа сэтгэл уужирч, гавъяагаа дөвийлгөх маягаар хөгжил дэвшилдээ хандсан нь буруу. Социализм байгуулах явц төгсгөлгүй олон хувилбар, шат дамжлагатай байх тухай К.Марксын угтан хэлснийг догматикаар хүлээн авч, түүнээ социалист орон бүрт загварчлан тогтоож, тэгээд энэ сургаальдаа хамтын ажиллагаагаа сохроор захируулсан явдал социалист интеграцын штаб-ЭЗХТЗ-ийн гол алдаа. Ингэхдээ өөртөө хэт томдсон захиргааны аппарат, янз бүрийн хороод, комиссыг байгуулж, ажлаа захиргаа-үзэл суртлын аргаар явуулж, эдийн засгийн хөшүүрэг, санаачилга, улс бүрийн өвсгоо самбааг хумигдуулсан юм. ЭЗХТЗ-ийг социалист байгуулалтын туршлага солилцох суваг мэтээр ойлгож байсан нь ч том эндүүрэл болжээ. Хамтын ажиллагаагаа эдийн засгийн хүчин зүйл дээр бус дээрх орнуудын эрх баригч намуудын улс төрийн хамтын ажиллагаан дээр үндэслүүлсэн болохоор (амин сүнс нь байсан) суурь нь буруу бол давхарга мөн буруутдаг жамаар бүх зүйл буруугаар эргэсэн юм. Онолын алдаатай үндэслэл (даян дэлхийд коммунизм байгуулах, дэлхийн хувьсгал гэх мэт) эдийн засгийн интеграцыг бүр эхнээс нь урвуу хэлбэрээр удирдан жолоодов. Ийм учраас ЭЗХТЗ үүсэхдээ бөөн маргаан дагуулсан юм. Жижиг түншүүд нь том түншдээ өр тавьж, том нь жижигтээ үр дүнгүй хөрөнгө урсгаж, эргээд тооцоогоо дэлхийн жишгээс өөрөөр хийж (шилжих рублийг хэлж байна) энэ явцад эдийн засгийн үрэлгэн механизм бүрэлдэж, тэр нь элдэв хэлбэрээр баяжиж байлаа. Хамгийн гол нь хараат ба хараат бус эдийн засгийг бий болгосон юм. Социалист эдийн

засгийн интеграцын сонгогдсон жишээ-Монголоор л жишээлэн авч үзэхэд бид улс төрийн хувьд тусгаар тогтносон, эдийн засгийн хувьд тусгаар тогтнож чадаагүй, хараат эдийн засагтай улс юм. Ер нь Монгол мэтийн байгалийн баялаг ихтэй, хүн ам цөөн, хүн амын хэрэглээ явцуу, дэд бүтэц муутай, үндэсний технологигүй улс ЭЗХТЗ дотор түүхий эдийн хавсарга (Дундад Ази, Сибирьтэй адил) болж хувирсан нь одоо ч балаг тарьсаар байна.

Үүнээс гадна социалист аль ч орны жам хууль-тоо баримт, тайлан тооцоог дээш дэгсдүүлж мэдээлдэг, тоо бүртгэлд хөтлөгдөн, түүгээр үр дүнгээ тооцдог, гавъяа шагналыг хавтгайруулдаг саа өвчин ЭЗХТЗ-ийг тойрч гараагүй. Одоо ч түүний гишүүн асан зарим оронд үүний их бага илрэл ажиглагдсаар байна. Ерөөсөө хөгжлийнхөө хэмжүүрийг анхнаасаа буруу тогтоосон. Нүүрс, нефть, шатдаг хийн нөөц, төмрийн хүдэр болон бусад ашигт малтмал, ойн баялаг зэрэг нь хөгжлийн гол нөхцөл, гайхуулах зүйл байсан билээ. Жишээ хуучин ЗХУ-ын өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн гүрэн болохыг тодорхойлдог үзүүлэлт нь тус орон дээрх асар их баялгийг өөртөө эзэмшсэн, дэлхийн модны дөрөвний нэг нь энд байдаг, усны эрчим хүчний дэлхийн нөөцийн бараг талыг эзэмшсэн гэдгээр хэмжигдэж байв. Тийм учраас түлш эрчим хүчний цогцолбор нь энэ орны эдийн засгийн фундамент болж байлаа. Тэгэхээр Зөвлөлтийн (цаашлаад ЭЗХТЗ-ийн орнуудын) эдийн засгийн хөгжил дэвшил зөвхөн энэ фундамент дээр суурилж, түүнийг тойрсон туслах чанарын аж ахуйг байгуулж хөгжүүлэхэд чиглэнэ. Энэ нь Монголын жишээн дээр тод харагдсан. Хэрэв дээрх хэмжүүрийг (баялаг, түүний нөөц, бас газар нутгийн том жижиг) гол болговол ЭЗХТЗ-ийн ойлголтоор Өрнөд Европын орнууд, Зүүн Азийн аж үйлдвэржсэн орнууд ямар үнэлгээ авах вэ? Хоцрогдсон, хөгжил дорой гэж үзэх нээ. Түүнээс гадна 1988 онд Европын холбоог хүлээн зөвшөөрөх хүртлээ ямагт өө сэв эрж, дутагдалтай талыг нь гол болгоод ололттой талыг (хамгийн гол нь ирээдүйг нь) зөв харж чадаагүй. Тийм учраас "Нийтийн зах зээл" гэж ерөнхийлөн нэрлэж, жинхэнэ мөн чанарыг нь таниагүй юм. Ер нь ЗХУКН-ын XXVII их хурлын тайланд дурдсан шиг (ердөө арваадхан жилийн тэртээ) орчин үеийн империализмын 3 үндсэн төв, тэдгээрийн өөр хоорондын өрсөлдөөн зөрчил гэдэг явцуу утгаар авч үзсэн.

Яг ийм байдалтай 90-ээд онтой золгосон. ЭЗХТЗ хэрхэн тарсан тухай номын гуравдугаар бүлэгт дурдсан. Түүнийг давтахгүйгээр үлдэж хоцорсон зарим асуудлыг авч үзье. Социалист байсан орнуудыг одоо хөгжлийн түвшин, реформын явц, үр дүнгээр дахин ангилахаас өөр аргагүй. Үүнийг бас гуравдугаар бүлэгт тодорхой тайлбарласан. Европын холбооны тооцоолсноор, ТУХН-ийн орнуудын эдийн засгийн төлөв байдал Дорнод Европын орнуудыг бодвол тодорхойгүй, өөдрөг санаа төрүүлэхгүй байгаа гэдгийг хаа хаанаа нэгэн зэрэг анхааруулж байна. Тэгэх тусмаа

Азербайжан, Армен, Гүрж, Молдов, Тажикистанд дордох байдалтай байна. Энэ нь өнөөгийн олон нөхцөлөөр нөхцөлдсөн нь мэдээж боловч гол шалтгаан нь нөгөө социалист эдийн засаг гэгчид байгаа болов уу. Төвлөрсөн төлөвлөлт ба хангалт нь зах зээлийн механизмыг үгүйсгэдэг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас асар их алдагдал, чанарын доод түвшин, ядмаг хэрэглээ, барааг бараагаар тулж сольдог бартерийн арилжаа, хар зах, коррупц одоо үлдэж хоцроод байна. Бас төрийн нүсэр том эрх мэдэл, тэгээд тэр төр нь дотроо эсрэг тэсрэг байр суурьтай байгаа зэрэг олон дутагдлыг энд нэрлэж болно. Тэгэхээр энэ бүхнийг юугаар халах ёстой вэ? Энэ талаар Европын холбоо, OECD аль алин нь зөвлөмжөө өгсөн. Тэр нь дотоод, гадаадын үр өгөөжтэй, орлого оруулах хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөл бүрдүүлэх явдал. Тэр орчин гээд байгаа нь чөлөөт үнэ, мөнгөний реформ, эдийн засгийн макро түвшингийн тогтворжилт, чөлөөт худалдаа, санхүүгийн салбарын шинэтгэл, улсын секторын монополи байдлыг эвдэж, хувьчлах, цаашлаад хувийн өмчийг баталгаа- жуулах, эцэст нь хууль дүрмээ цэгцэлж, хууль үйлчилдэг болгохыг хэлж байгаа юм. Энэ бүхнийг гүйцэлдүүлж эс чадваас гадаадын хөрөнгө оруулалт нэг л өдөр зогсоно. Харин ингэж амжуулахад манай социалист эдийн засгийн хуучин сэтгэлгээ, арга барил ихээхэн саад тотгор болж байна. Зарим баримтаар бол социализмын үед ажиллаж байсан нийт үйлдвэрүүдийн гуравны нэг нь дампуурахаас өөр замгүй болж байна. Энэ бол ТАСИС хөтөлбөрт хамрагдаж буй орнууд дээр жишээлж ярих зүйл.

Тэгээд ч ТУХН (зарим талаар Монгол ч орох байх) цаг нөхцөөсөн, гал унтраасан аргацаасан бодлогоороо гадаадын зээл тусламжийн үнэ цэнийг унагаж байгаа. Үүнийг "мөчлөгийн бодлого" гэж нэрлэдэг. Жил бүрийн эхний сард инфляцийг хазаарлан барих талаар эрс хатуу арга хэмжээ авдаг атлаа хаврын шувтаргаар эрч нь сулардаг. Парламентын шахалтаар хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн зарим салбарт зээл олгодог. Намар болохоор дэвэргэн зорилгоосоо татгалзаж, рублийн ханш буурч, инфляц өсч, төсвийн алдагдал нэмэгддэг. Энэ бол ТУХН-ийн орнуудад түгээмэл буй зүйл. Тэр ч бүү хэл хөрөнгө оруулалт гэж юуг ойлгох, түүнийг яаж зарах талаар дотроо санал нэгдээгүй байна. Оросын хувьд өрнөдөөс хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэл нь төвлөрсөн дэд бүтцийг бий болгох явдал. Үүний дагуу хөрөнгө оруулалтын талаас илүү хувийг нийгмийн хэрэгцээ: жишээ нь 20 гаруй хувь нь орон сууц барихад, тус бүр 10 хүрэхгүй хувь нь тээвэр, түлш-эрчим хүчинд ногдож байна. Агропром гэж урьд нэрлэдэг байсан аж ахуй бүтцэд 15 хувийг зарцуулах ёстой. Гэтэл салбар салбар хариуцсан яамдууд энэ хуваарилтад сэтгэл дундуур төдийгүй булаацалдаж хий мэтгэлцдэг. Энд тоочсон бэрхшээлүүд ТАСИС хөтөлбөр, OECD-ийн тусламжийн бодлогын хувь заяанд

нөлөөлж магадгүй гэсэн болгоомжлол төрүүлж байгаа учраас энд арга буюу бичлээ.

Холбогдох ном, хэвлэл

1. В.Горский, Е.Черботарева. Маастрихт и Россия, "Международная жизнь" Март, 1993.
2. Roy Pryce. The European Community: A Chronology 1945-1992
3. John Pinder. Creating the Community: Nation State and Federal Idea
4. Jeffrey Harrop. Organisational Stepping Stones: Free Trade, the Customs Union and Internal Market. The Political Economy of Indegration in the European Community (Edward Elgar, 1992)
5. M.Cwik. Economic and Monetary Union (EMU) and The Maastricht Treaty. II-1, 19.04.1993, European Commision
6. Jack C.Plano, Roy Olton. The International Relations Dictionary. Santa Barbara, California, Oxford, England
7. OECD: Assisting Economic Reform in Central and Eastern Europe and The New Independent States, Centre for co-operation with the economies in transition, Paris., 1993
8. Working Together The Institutions of The European Community by Emile Noei, New Edition 1993, European Documentation
9. TACIS: Summary of Indicative Programmes 1993-1995, TACIS Information Office, D.G.I. Commission of the European Communties
10. John Sloman. Economics (21.International Trade, 21.4.The European Community), The University Press, Cambridge, 1991

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ "ГУРАВ ДАХЬ ЕРТӨНЦ"

НЭГ. АНГИЛАЛ БА ХЭМЖҮҮР

Дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь, бүх дэлхийн аж ахуйд оруулж буй үйлдвэрлэлийн хэмжээ, эдийн засгийн статус, хүн ам тутамд ногдох бодит орлогын хэмжээгээр дэлхийн улс орнуудыг ангилсан ангилал байдаг. Ийм олон арван ангилал бий бөгөөд ингэж ангилахдаа баримталдаг хэмжүүр шалгуур гэж мөн харилцан адилгүй. Эдгээрээс нэлээд түгээмэл хэрэглэгддэг нэг ангиллыг энд авч үзье. Хөгжлийн түвшингээр буюу эдийн засгийн үзүүлэлтээр:

1. Хөгжингүй орнууд;
2. Хөгжиж буй орнууд;
3. Буурай хөгжилтэй орнууд;
4. Нэн буурай хөгжилтэй орнууд;
5. Ядуу (гуйлгачин) орнууд гэж 5 бүлэгт ангилжээ.

Эхний орнуудын тухайд энд боломжтой олон "7-ийн бүлэг", Европын холбооны орнууд, ОАЭ, Швейцарим орнууд энд оруулах байх. Бас Израиль, ОАИ, НҮ-д (энд үнэ Африк тивийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 40 орчим хувийг талцаараа гаргадаг) энд оруулах ёстой.

Хөгжиж буй орнуудад шинжлэх үнэмлэхүй орно, эсвэл энэ зорилтыг шийдэх замаар урьдчилж төлөх, өдөр ОНЕК-ийн (Нефть экспортолдог орнуудын байгууллага) гишүүн бичиг орнуудыг оруулна.

Буурай хөгжилтэйд хөгжих боломжтой, хөгжиж гэмээг шинж тэмдэг илэрсэн, зохих нөөц баялагтай, эрүүл үнэмлэхүй байгууллага, хандивлагчдын зүгээс дэмжлэг авах боломжтой, үр шүүг нь үзэж чадах орнуудыг тооцдог.

Нэн буурай хөгжилтэйд нь үнэмлэхүй хүчний хөгжлийн түвшин доогуур, дэд бүтэц сул, хоцрогдсон байгууд гэвч байгалийн зохих баялагтай, түүхийн эдийн засагтай, хэрдээ тохирсон натурал аж ахуйтай, олон олон түвшинд гэрээг дчихгүй орнууд багтана.

Үлэмж хоцрогдсон, эрд түмэн нь бичиг үсэгт бүрэн тайлагдаагүй, иргэний дайна, хэргийн хүн хуучин гэмшигт нэрвэгдсэн, зөвхөн олон улсын хүмүүнлэгийн түслэмж дээр тогтож буй, мөхөж яваа гэмээр улс үндэстнүүд идүү орнуудад орно.

Тэгэхдээ энэ 5 бүлэгт дэлхийн бүх улс орныг яг загварчлан зоох аргагүй юм. Тэгэх тусмаг ШҮТ-ийн дэвшлийн энэ эрин үед хөгжил дэвшил нь "гэрлийн хүрдлэр" яваа орнууд олширсон нь ингэж айхтар зааглах боломж олгохгүй. Нөгөө талаар хуучин

социалист гэгдэж байсан хийгээд ЗХУ-ын халааг авч бий болсон ТУХН-ийн орнуудыг ийм ангилалд хуваахад нэн түвэгтэй байна. Жишээ нь Монгол юмуу, Куба, эсвэл Албани бол ойлгомжтой. Гэтэл Чех, Унгар, Польш, эсвэл Балтийн улсуудыг хааш нь оруулах вэ? Эдийн засгийн асар их нөөц хүчтэй Хятад, эсвэл хуучин социалист эдийн засгийн лут бүтцийг хадгалж үлдсэн Оросыг аль бүлэгт оруулах вэ? Энэ бол үнэхээр адармаатай асуудал. Тийм учраас би энэ ангилалыг үнэмлэхүй зөв гэж үзэхгүй байгаа бөгөөд ташаа авах, эсвэл бүтээлч маргааны сэжүүр болж магад гэсэн үгээр энд оруулсан юм.

Хүн ам тутамд ногдох бодит орлогын хэмжээгээр хамгийн дээд амжилтыг Швейцар улс хангасан. 1993 оны байдлаар тэнд нэг хүн тутамд 36 410 доллар ногджээ. Мөн онд хамгийн доод үзүүлэлт Мозамбикт (80 доллар) ногдсон юм. Тэгэхээр "36 410 : 80" гэсэн хоёр үзүүлэлтийн хооронд дэлхийн бүх улсыг жагсаах уу? гэсэн асуудал байж болно. Хэрэв ингэж жагсаавал дэлхийн хамгийн ядуу 42 оронд хүн амын дундаж орлого нь 290 доллараас доош, хөгжингүй 25 улсад дундаж орлого нь 10 000 доллараас дээш байна. Энэ хэмжүүрээр авч үзвэл, дэлхийн хүн амын дөрөвний гурван хувийг (дэлхийн хүн амын 75 хувь) бүрдүүлдэг "Гурав дахь ертөнцөд" дэлхийн орлогын 20 орчим хувь ноглох жишээтэй. Тэгэхдээ энд Ази, Латин Америкийн зарим аж үйлдвэржсэн орнуудыг тэр 20 хувьдаа заавал хамруулах албагүй.

Дэлхийн эдийн засагт гүйцэтгэх үүргээ тасралтгүй нэмэгдүүлж (өрсөлдөж чадна гэсэн үг) бусдаасаа эдийн засгийн олон үзүүлэлтээр тасархай яваа байдал, хөгжлийн цаашдын хандлага, ШУТ-ийн дэвшлийг үйлдвэрлэлд нэвтрүүлж буй байдлаараа "Гурав дахь ертөнцөд" тэргүүлж буй хэсэг орон бий. Тийм учраас ийм үзүүлэлтэд үндэслэн хоёр үндсэн ангилал хийж болно. Гэхдээ дотор нь бас дэд хэсгүүдэд ангилна. Хөгжингүй болон посткоммунист орнуудыг хасаад дэлхийн 130 гаруй орныг ингэж ангилж үзье.

1. Дээд давхарга ("echelon") нь дотроо 4 бүлэг орноос бүрдэнэ. Тэдгээр нь:

а/ Латин Америкийн үлэмж хөгжилтэй орнууд. Энд Аргентин, Уругвай, Чили, Мексик, Бразил, Венесуэл орох болов уу.

б/ ОПЕК-ийн гишүүн орнууд нэг бүлэг болно. Нефтийн асар их бөөмж, газар зүйн онцгой байрлал, хөрөнгө хуримтлуулах боломжон ашигласаар ирсэн Саудын Арав, Арабын Нэгдсэн Эмирт Улс, Кувейт болон Персийн булангийн зарим орон энд орно.

в/ Газар зүйн тааламжтай нөхцөлд байрласан гадаадын хөрөнгө оруулах боломжтой, олон улсын хөдөлмөрийн хуваарьт ашигтай байрлал олсон, гэвч байгалийн баялаг хязгаарлагдмал Азийн дөр үндэслэжсэн орнууд ("Азийн барууд") нэг бүлэг болж байна.

г/. Хүн ам тутамд ногдох орлогоороо дээд үзүүлэлтэд хүрсэн боловч дэлхийд эзлэх байр нь жижиг, бага буурай орнууд энд орно. Жишээ нь Гваделуп, Мартиник, Антиллын арлууд, Суринам гэх мэт. Эд үйлдвэрлэл явуулахаасаа аялал, жуулчлал, үйлчилгээгээр их хөлжсөн байдаг.

2. Доод давхарга нь дотроо 3 бүлэг орноос бүрдэнэ. Үүнд:

а/. Орчин үеийн аж үйлдвэрийн салбаруудыг байгуулсан, аж үйлдвэржиж байгаа, олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцдог, гэхдээ хүн ам хэт их, хүн амын өсөлтийн талаар төрийн хатуу бодлого явуулах шаардлагатай орнууд. Жишээ нь Энэтхэг, мөн Пакистан, Индонез, Заир, Бангладеш гэх мэт.

б/. Байгалийн зохих нөөц баялагтай боловч газар зүйн байрлал, үйлдвэрлэх хүчний хөгжил сул зэргээсээ шалтгаалан ерөнд баригдан хөгжлийн дүр төрхөө удаан олж буй орнууд бий. Энд Африкийн нэлээд орон орох байх.

в/. Байгалийн баялгаар ядуу, газар зүйн байрлал нь туйлын тохиромжгүй буюу байгалийн гамшигт их нэрвэгдсэн, иргэний дайн мөргөлдөөнд олон жил татагдан орсон Африкийн голдуу улсууд бий. Жишээ нь Бурунди, Руанда, Сомали, Лесото, Мавани, мөн Бутан, Балбыг энд оруулж болох байх.

Ингэж ангилахдаа ямар арга зүйг гол болгов? Бид энд НҮБ-ын, мөн АНУ-ын Харвардын их сургууль, Английн Кембрижийн их сургууль, эцэст нь Орос, Зөвлөлтийн эрдэмтдийн судалгааны аргачлалыг харьцуулж үзье л дээ. Жишээ нь НҮБ-ын хэмжүүр аргачлалаар, нефть экспортолдог ба экспортолдоггүй гэдгийг үндэс болгодог, бас төр улсынх нь шинж чанар, нутаг дэвсгэрийг нь харгалздаг, мөн хүн амд ногдох орлогын түвшингээс хамааран ангилдаг байх юм. Тэгвэл Харвардынхаар, нийгмийн хөгжлийн сонголт, эдийн засгийн потенциалын түвшин, түүхий эд, хөгжингүй орнуудаас хэр зэрэг хамааралтай, тийм хамаарлын шинж чанар, зорилго зэргийг харгалздаг. Оросын эрдэмтдийнхээр бол, дэлхийн аж ахуйд эзлэх байр хөгжлийн түвшин, үйлдвэрлэх хүчний бүтэц, түүхий эдийн нөөц, хүн ам тутамд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, эрчим хүчний хэмжээ, бичиг үсэгт хэр тайлагдсан, хүн амын ажил эрхлэлт, тэр ч бүү хэл 1000 хүнд ногдох телефон, төрөх хүүхдийн тоо зэргээр авч үздэг ажээ.

Кембрижийн их сургуулиас хэд хэдэн удаа хэвлэсэн Ж.Сломаны "Эдийн засаг" (Economics) номд хөгжиж буй орнуудын ялгаа зөрүүг гаргахын тулд "Ядуурлын хэмжүүр" тогтоосон байдаг. Тэнд:

1. Нутаг дэвсгэрийн хэмжээ ба хүн амын нь харьцаа;
2. Байгалийн баялаг, цаг агаарын нөхцөл;
3. Дэд бүтцийн хөгжлийн түвшин;
4. Соёл-нийгмийн хүчин зүйл;
5. Аж үйлдвэржсэн, хотжисон байдал;

6. Хөгжингүй орнуудтай тогтоосон харилцаа;
7. Улс төрийн бүтцийг нь гол болгох ёстой гэж үзжээ.

Энэ 4 аргачлалыг би ягштал баримтлах ёстой гэж үзэхгүй байна. Зөвхөн жишээ болгож авч үзлээ. Эдгээрээс өөр өдий төдий аргачлал бий. Тэр болгоныг энд дурдах албагүй юм. Тийм учраас өдийн засгийн үзүүлэлтээс гадна тухайн орны өөрийнх нь онцлог, дэлхийн хамтын нийгэмлэгт хэр анхаарал татаж, тусламж дэмжлэг хүлээж буй, ямар түнштэй, ямар гадаад орчинд оршдог, логоодын ямар орчин бүрдүүлсэн зэргийг харгалзан үзэх ёстой байх. Олон улсын байгууллага цаашлаад олон улсын тавцанд хэр нэр хүндтэй зэрэг нь ч энд нөлөөлнө. Соёл-нийгмийн хүчин зүйл гэдгийг энд бас гол болгох ёстой. Ерөөсөө XIX зууны босгон дээр цаг үетэйгээ хэр хөл нийлүүлж яваа, хүн төрөлхтөний нийтлэг жам хуулиас хазайх уу, эс хазайх уу гэсэн шалгуур ч байж болох мэт.

Хөгжин дэвжихэд нутаг дэвсгэрийн хэмжээ, байгалийн нөөц баялаг гол нөхцөл биш гэдгийг "Азийн баруудын" туршлага харууллаа. Казахстан хөгжлийнхөө уг сурвалжийг тус орны газрын хөрсөнд Менделеевийн үелэх хүснэгтийн бүх элемент байдгаар тайлбарладаг. Энэ бол субъектив ойлголт. "Алтан дээр сандайлсан гуйлгачингийн үлгэр" бий. ТУХН-ийн зарим орон хөгжил гэдгийг их бүдүүн тоймоор ойлгож байгаа учраас энэ жишээг татлаа. Байгалиас заяасан түүхий нефтийн асар их нөөцөө борлуулах замаар баялаг хангалуун амьдралыг цогцлуулсан арабын орнуудыг (тэнгэрийн хишиг гэж үздэг) тийм амьдралыг хүч тэнцвэргүй дайн тулалдааны явцад, үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ 25 хувийг батлан хамгаалахдаа зарцуулж байж бүтээсэн Израильтай адилтгах нь хэр бодит вэ? Эсвэл байгалийн баялаг, түүх эд, тэр ч бүү хэл цэвэр усаар гачигддаг Гонконг, Сингапурыг (газар нутаг давчуу хүн ам хэт өссөн) үнэлэхдээ зөвхөн энэ хэдээр нь хэмжүүр хийх үү? Мал сүрэг гэх юм байхгүй атлаа хүнсний хангамжийн асуудлыг хамгийн ухаалгаар шийдсэн орон олон бий. Энэ мэтчилэн авч үзвэл дээр жишээлсэн 4 янзын аргачлал аль нэгийг нь тохиромжгүй мэт. Ерөөсөө "гурав дахь ертөнц" гэсэн нэр томъёо ч цаг үеэсээ хоцроод байна. Ийм учраас хөгжиж буй орнуудыг өөр хооронд нь ангилал буюу жишихдээ шал өөр хэмжүүр үндэстэн тогтоох хэрэгтэй. Зүүн Азийн шинээр аж үйлдвэржсэн орнууд болон Латин Америкийн өндөр хөгжилтэй орнуудыг энэ ангилалд хамруулах шаардлагагүй болов уу. Бас ОПЕК-ийн болон Арабын зарим орныг хасч болно. Харин энэ ангилалд ТУХН-ийн зарим орон, Албани, Югославаас салсан Македонийг оруулахад болох мэт санагдана.

ХОЁР. "УМАРД-ӨМНӨДИЙН" ХАРИЛЦАА

Дэлхийн хоёрдугаар дайны дараа *нэг талаас* дэлхийн колонийн системийн задрал эхэлсэн, *нөгөө талаас* хоёр туйлт болон олон улсын харилцааны систем тогтсоноос үүдэн дөнгөж шинээр тусгаар тогтносон орнуудын хувьд нэгэн түүхэн сонголт тулгарсан нь дэлхийд бий болсон улс төр-эдийн засгийн хоёр эвслийг сэргүүлж гурав дахь эвсэл бий болгох явдал байсан юм. Тийм эвсэл бий болох явц 60-аад он хүртэл үргэлжилсэн. 1960 он колонийн системийн сүйрлийн жил болж Африкийн орнуудын тэн хагас нь 60-аад онд тусгаар тогтнолоо тунхагшижээ. Ийм бодит боломж бүрэлдэхээс өмнө 1945-1960 он хүртэл хөгжиж буй орнуудын дэлхийн хэмжээний бүтцийн үндэс ташигдвал байв. Ази, Африкийн 29 орны төлөөлөгчид нэгдэн хамтран, хамтын ажиллагаа, харилцан туслах бэлгэдэл болж 1955 онд Бандунгийн бага хуралд цугларсан тэр мөчөөс дэлхийн улс төрийн гүрэн дахь том хүч нэгдэж эхэлсэн билээ. Эдгээр гишүүд нь 112 г хүрээд байгаа ЭУНХ-ний үндсэн зарчмууд нь Бандунгийн 10 зарчмаар тодорхойлогддог. Бандунгийн зарчмуудыг хүлээн зөвшөөрч түүнийг хамгаалах хүсэл эрмэлзэлтэй орнууд 1961 онд Белградэд анхны бага хурлаа хийснээр "Гурав дахь ертөнцийн" нэг том эвсэл ЭУНХ байгуулагджээ. Гэвч тухайн цагийн улс төрийн уур амьсгалыг тусгасан улс төрийн зорилтуудыг өмнөө дэвшүүлсэн учраас эдийн засгийн асуудал орхигджээ. Хөгжиж буй орнууд НҮБ-ын хүрээнд хамтран тэмцэх явдлыг мөн энэ үед чухалчилж байлаа. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (ЮНКТАД) тэрпан хуралдуулахын төлөө тэмцлийг хөгжиж буй орнуудыг эдийн засгийн хувьд нэгтгэх нэг түлхүүр гэж үзэж байлаа. Энэ зорилгоор НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХҮИИ чуулганаар "75-ын тунхаглал" батлуулжээ. Энэ бол дэлхийн аж ахуйн асуудлыг цогцолбороор авч үзэх гэсэн "Гурав дахь ертөнцийн" орнуудын анхны оролдлого болжээ. 1964 онд Женевт болсон НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын явцад эдгээр 75 улс дээр гүрэн нэмэгдэж, нэг хасагдаж "77-гийн бүлэг" үүсчээ. Энэ бүлгийн бүрэлдэхүүн эдүгээ 130 гаруй болж тэлжээ. Тэр үед Женевт нийгүүлсэн баримт бичигт "Дэлхийн эдийн засгийн шинэ шударга дэг журмын" тухай нэр томъёо орсон байдаг. Түүнийг дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд АНУ-аас дэвшүүлсэн "Дэлхийн эдийн засгийн шинэ дэг журмын" тухай ойлголттой хутгаж ойлгож болохгүй.

"77-гийн бүлэг" үүссэнээр "Умард-Өмнөдийн харилцааны" асуудал олон улсын харилцаанд бий болжээ. Баян умардад OECD-ийн гишүүн орнууд (тэр үеийн "Хоёр дахь ертөнц" буюу ЗХУ тэргүүтэй дэлхийн социализмын орнууд тусдаа статус эдэлж байсан) харин ядуу өмнөдөд Ази, Африк, Латин Америкийн орнууд багтсан юм. Тэгэхээр энд 3 талын харилцааны (OECD-ийн гишүүд буюу "нэгдүгээр ертөнц", "Хоёр дахь ертөнц", "Гурав дахь ертөнц")

асуудал яригдах болно. "Умард" нь гол анхаарлаа "Өмнөдөд" Зөвлөлтийн нөлөөг тогтоон барих, хувийн болон олон үндэстний худалдаа хөрөнгө оруулалтыг нээлттэй болгохыг зорьсон. "Өмнөд" нь "77-гийн бүлэг" байгуулснаар "Умардыг" сулруулж, дэлхийн баялгийг тэнцүүхэн хуваах, улмаар бие даан хөгжих боломжтой болно гэж тооцоолсон. Гэвч энэ хоёр тооцооны алин ч бүрэн хэрэгжээгүй өнөөг хүрчээ.

Үүнд өрнө-дорно хоёул буруутай. Тэгэх тусмаа дэлхийн социалист систем хөгжиж буй орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийг будлиантуулж саатуулсан хариуцлагаас хуваалцах ёстой. Колоничлолын эсрэг тэмцэлд улс төрийн тусгаар тогтнолоо олсон боловч өнгөрсөн үеэс үлдэж хоцорсон хүнд уршиг-хоцрогдол, ядуурал, гуйланчлалыг даван туулахын төлөө олон орон хүнд бэрх тэмцэл хийсээр байна. Тэдгээр орны ядуурал, өрширийн асуудал бол дэлхий нийтийн хөгжлийн ерөнхий хандлагад нөлөөлөхгүй байх арга алга. Хоёр тэрбум гаруй хүн ард оршин суудаг өргөн уудам бүс нутаг бүхэлдээ ядуурлын бүс гэж нэрлэгдэж байгааг энд дурдах хэрэгтэй. Харин ингэж ядуурснаа саяхан болтол хэт өрөөсгөлөөр тайлбарлаж ирснийг эргэн саная. "Империализмын тонон дээрэмдэх, мөлжих бодлого", "өрөөр дөрлөж авах", "хүчээр түрээ барих оролдлого" гэх мэтээр үздэг байсан. Энэ бол нэг үзэл номлолоор бүхнийг хэмжиж байсны илрэл. Тэгээд ингэж ядуурч доройтсон, төрх байдлаараа харилцан ижилсэхгүй бүхэл бүтэн ертөнц хөгжлийнхөө замыг эрэн хайж, шилэн сонгож байхдаа замын бэлчирт ирж, өрнөдийн маягийн, эсвэл зөвлөлт маягийн хоёр байгууллын нэгийг сонгох ёстой гэж үздэг байв. Үүнээс үүдэн социалист чиг баримжаа, капиталист бүс хөгжил, капитализмыг алгасан харайх тухай онолын бүдүүвчлэл бий болжээ. Гэвч эдгээр нь түүхийн шалгуурыг давалгүй сүйрсэн юм.

Хөгжиж буй орнуудыг дэлхий нийтийн нийтлэг замаар замнуулах түгээмэл арга зам эрж сүвэгчлэх талаар өрнөдөд их зүйл хийснийг одоо үгүйсгэх аргагүй болжээ. Үүний сонгодог жишээг АНУ үзүүлсэн юм. XIX зууны эхээр шахуу "Жеймс Монрогийн номлол" (АНУ-ын тав дахь ерөнхийлөгч) дэвшүүлж байхдаа "Умард-Өмнөдийн" асуудлыг эхлэн сэдсэн байж болох юм. Үүнийг Латин Америкт америкийн колоничлолын эрх ашгийг хамгаалах зорилгоор бий болгосон мэтээр бид олон жил шүүмжилж ирсэн. 1889 онд Америк дундын холбоо байгуулж, 18 улс орон нэгдэж Европын томхон гүрнүүдийн нөлөөг энэ бүс нутагт хумиж чадсан. Хэрэв АНУ колоничлох санаа өвөрлөсөн бол Латин Америкаас Испанийг гаргаж орыг нь түвэггүй эзлэх байсан байх. Гэтэл Латин Америкийн шинэ тулгар улсуудыг Европын колонийн том гүрнүүдээс хамгаалж, Карибийн сав газраас Испанийг хөөж гаргасан баримт юу хэлж вэ? (Үүнийг Латин империализмын эрин үеийн эхлэл гэж нэрлэдэг) Энэ бүхнийг өгүүлэхдээ тэр үеийн дэлхийг

дахин хуваахын төлөө их гүрнүүдийн хийсэн өрсөлдөөнийг зөвтгөж байгаа хэрэг биш.

Хожим нь В.Вильсон олон улсын харилцаанд либерал интернационализмын номлол дэвшүүлэхдээ АНУ хуучин ертөнцөөс (хөгшин Европыг хэлж байна) тусгаарлагдсан шалтгаанаа Европын колоничлогч гүрнүүдийн бодлоготой холбож тайлбарлажээ. Тийм учраас Үндэстнүүдийн холбоо байгуулах тухай саналдаа хуучин ертөнц-шинэ ертөнц гэсэн хоёр туйл бий болгох замаар дайны дараахи цоо шинэ ертөнцийг төлөвшүүлэх санаа сэджээ. Энх тайван тогтоох нөхцөл болгож Вильсоны дэвшүүлсэн 14 зүйлт саналд чөлөөт худалдаа хөгжүүлэх, гаалийн хоригийг цуцлах гэх мэт Версалийн гэрээнд биелэлээ олж, Үндэстнүүдийн холбооны үйл ажиллагаанд хэрэгжиж байсан олон шинэлэг зүйл хожмын практикаар зөв зүйтэйгээ нотлон харуулсан. Вильсоны энх тайванч саналыг сэргүүлж Лениний дэвшүүлсэн пролетарийн интернационализмын сургаальд "Умард - Өмнөдийн" асуудал мөн тусгалаа олсон. Гэвч тэр нь үлэмж хоцрогдсон, сулдаж доройтсон Орос орны хувьд хэрэгжих үндэслэл мүүний, үзэл суртлын тунхаг шинжтэй байсан юм.

30-аад онд дэлхий дахинга доройсон эдийн засгийн их хямралын үед Ф.Рузвельт ерөнхийлөгчийн сонгуулийн явцад уг хямралыг стандартын бус аргаар шийдэх тухай санал дэвшүүлж, эдийн засгийн салбарт ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрийг олон улсын практикаас хасахыг уриалж байв. Нийгмийн чиг баримжаа бүхий зах зээлийн эдийн засгийн тухай үзэл баримтлал нь түүнийг ерөнхийлөгч болсны дараа хэрэгжжээ. Энэ бол өнөөгийн бидний ойлголтоор "ардчилсан хүмүүнлэг, энэрэнгүй нийгмийн" тухайн үеийн нэг загвар юм. Дэлхийн хоёрдугаар дайны үүсэл, түүний гол шалтгааныг Рузвельт дэлхийн колонийн системээс эрж хайсан юм. Тэгээд ч дайны дундуур Гитлерийн эсрэг эвсэл бүрэлдэхэд, дайны явцаас гадна дайны дараахи дэлхийн шинэ дэг журамд их анхаарч байсныг гэмдэглэх ёстой. Колонийн дэглэмүүдийг халах, дэлхийн бэллгийг тэнцүү хуваах, колониос чөлөөлөгдөх орнуудыг олон улсын үгээс халамжлан асрамжлах тухай асуудлыг чухамдаа Рузвельт илгүүрүүлж хөнджээ. Тийм учраас АНУ-ын саналаар бий болсон Бреттон Вудсын систем, НҮБ уг асуудлыг бүр тэр үеэс авч үзэж байлаа. Ганцхүү хэрэгжээгүй шалтгаан нь "Хүйтэн дайнтай" холбоотой. Дайнаас хойш шинэ шинэ улсууд тусгаар тогтнох тусам "Умард-Өмнөдийн" харилцааны асуудлыг олон улсын хэмжээнд улам бүр өргөн авч үзсэн юм. Энд социалист орнуудын байр суурийг нуршихгүй Ердөө "Гурав дахь ертөнцийг" социализмын нөөц хүчин мэтээр олгож, залж чиглүүлж байсан гээд орхиё.

1960 оноос "Гурав дахь ертөнцөд" нэг ёсны нийгмийн тэсрэлт ("Африкийн жил") гарлаа. Дэлхийн колонийн систем үндсэндээ сүйрлээ. *ХБНГУ-ын улс төрийн нэрт зүтгэлтэн В.Брандт "Умард-*

Өмнөдийн" асуудлаар өөрийн гэсэн өвөрмөц үзэл баримтлал тэр үед дэвшүүлсэн хүн. Тэр үеийн ("Хүйтэн дайн" ид эрчээ авсан) "Өрнө-дорнын" харилцааны асуудал цаашдаа "Умард-Өмнөдийн" асуудалд үелэн хуваагдана гэж Брандт үзжээ. Ингэж үелэн хуваагдах үндэс нь "Бага алхамын хослол" болох аж. Энэ нь хоёр үе шатаар: итгэлцэл бэхжүүлэх замаар хамтран ажиллах; улмаар тэр нь хоёр системийн сөргөлдөөнийг сулруулах маягаар хэрэгжинэ. Энэ практикаа баян умард, ядуу өмнөдийн нийтлэг ашиг сонирхлыг хослуулах замаар "Умард-Өмнөдийн" харилцаанд нэвтрүүлэхийг Брандт чухалчилжээ. Гэвч тухайн үед Баруун Берлиний бургомистр байсан хүнд үүнийг олон улсын практикт хэрэгжүүлнэ гэдэг зүүд зэрэглээ байсан биз. Харин хожим нь ХБНГУ-ын холбооны канцлер болоод "Өрнө-Дорнын" харилцааг үндсээр нь эргүүлсэн юм. Дайнаас хойш хуваагдсан Европт "Хүйтэн дайны" мөсийг хайлуулах анхны оролдлого хийсэн тухайд ярьж байна. Хөгжиж буй орнуудын хувьд ч НҮБ-д дэвшүүлсэн түүний "Бүх нийтийн аюулгүй байдлын" үзэл баримтлал их хамаатай. Европчуудын ярьдгаар хүн төрөлхтөн нэг дээвэр дор хамтдаа аж төрөх тухай сургаалийг тэрээр ингэж томъёолохдоо, "Төвийг сахисан улс", "Гурав дахь ертөнц" гэсэн хийсвэр, хуурмаг ойлголтыг төгсгөл болгох ёстой гэж үзэж байв. "Хүн төрөлхтөний оршин тогтнох нийтлэг сонирхлын тухай", "Хөгжингүй улс гүрэн, буурай хөгжилтэй орнуудын ашиг сонирхол харилцан холбоотой", "Хүн төрөлхтөн өөрийгөө устгалгүй аж төрөх, цаашид хөгжин дэвжих нийтлэг сонирхолтой байх ёстой" гэсэн олон санаа энд тусгалаа олжээ.

Брандт Нобелийн шагнал хүлээн авах ёслол дээр, "Өлсөж туйлдсан хүн манай аж төрөх хэвшилд сэтгэл гонсгор байх болно", "Хаана өлсгөлөн байна, тэнд бат бэх энх тайван байх боломжгүй, дайны эсрэг хэн тэмцэж байна, тэрээр өлсгөлөнгийн эсрэг бас тэмцэх ёстой" гэж хэлсэн нь "Умард-Өмнөдийн" асуудалд хандсан уриа дуудлага байлаа. Өөрөөр хэлбэл "Умард - Өмнөдийн" харилцааны амин сүнс нь "Өмнөдийн" улс түмний нийгмийн хурц асуудлыг шийдвэрлэх явдал гэж тэрээр олонтаа анхааруулж байв. Ерөөсөө "Умард-Өмнөдийн" хөгжлийн түвшинг ойртуулах явдлыг Брандт зүй ёсны шударга үйл хэрэг, хүмүүнлэг энэрэнгүй өрөвдөх сэтгэлийн илрэл төдийгүй дэлхий дахиныг дайн дажингүй амар жимэр байлгах нөхцөл, дэлхийн оршин тогтнох нэг үндэс гэж үзсэн юм. Тийм учраас хаана өлсгөлөн байна, тэнд дайн гарцаагүй, хаана ядуурал байна тэнд ангийн тэмцэл зайлшгүй гэсэн философи үүнээс урган гарч байна. (Ангийн тэмцэл гэдгийг энд анхаарч үзээрэй)

Брандтын энэ санаа түүний тэргүүлсэн "Умард-Өмнөд" гэдэг бие даасан комиссын удаа дараагийн илтгэл баримт бичигт цэгц номлол болж төлөвшсөн юм. Эдгээр баримт бичигт чухам ямар учраас баян умард ядуу өмнөдөд туслах болов, яагаад хөгжингүй

орнууд буурай хөгжилтэй орны хөгжлийн эрч далайцыг хэмжих болов (санаа зовох гэж ойлгоно уу) гэхчилэн асуудалд хариу өгсөн юм. Буурай хөгжилтэй орнуудын байгалийн баялгийг үр өгөөжтэй ухаалгаар ашиглах асуудал бол зүй ёсны үзэгдэл. Учир нь бид дэлхий гэсэн нэг л гэр бүлд аж төрж байгаа. Тэгэхээр ядуу буурай орон хөгжинө гэдэг нь "Умардад" ашигтай, нөгөө талаас бас баян умардын өндөр хөгжил, баялаг хангалуун амьдрал "Өмнөдийн" хөгжилд хэрэгтэй. Өөрөөр хэлбэл 70-80 оны зааг дээр "Умард-Өмнөд" гэдэг ойлголтыг ангийн тэмцлийн үүднээс дэнслэх, эсвэл хөгжиж буй ертөнцийг бүхлээр нь нэг дор хамруулж авч үзэж, тодорхойлох нь бүрэн утгаа алдсан байв. Тийм учраас энэ хоёрын заагийг арилгах учиртай хамтын ажиллагааны асуудал зүй ёсоор тавигдсан юм.

70-аад оны дунд үе гэхэд хөгжиж буй орнуудын дотор хөгжлийн олон янзын спектр (зааг ялгаа) үүсч, энэ ертөнцийг бүхэлд нь ядуурлын гэж үзэх үндэсгүй болсон байв. Ядуурлын эсрэг тэмцлээ гол болгосон хэсэг орон, гол төлөв Африкийн орон, мөн ядуурлыг мартаад удсан өөр нэг хэсэг орон (Азийн барууд, ОПЕК-ийн орнууд), дундуур нь яваа орнууд (Өмнөд Ази, Латин Америк) гэж ялгарчээ. Ядуурлыг давж гараад хөгжлийнхөө дардан замд орсон орнуудын хувьд "Умардтай" түншлэх боломж бүрдэж хамтын ажиллагаа жинхэнэ утгаар хэрэгжих эхлэл тавигджээ. Гэтэл ядууралдаа байгаа орнуудын хувьд хамтын ажиллагаанаас илүү тусламж чухлаар тавигдаж байлаа. Энэ хоёр хэсэг орны эхнийх нь НҮБ, дэлхийн чанартай бусад байгууллагыг гэхээсээ бүс нутгийн өөртөө тохирсон байгууллагыг эрхэмлэх хандлага энэ үед бүрнээ ажиглагдав. Сүүлийнх нь орнуудын хувьд НҮБ-ын Хөгжлийн Программ (ЮНДП), ЮНКТАД гол үүрэгтэй үлджээ. Учир нь эдийн засгийн тусгаар тогтнолоо бүрэн олж аваагүй, тогтворгүй, хэт алаг цоог орнуудад НҮБ-аар дамжин нөлөөлөх ёстой. Ийм хоёр хандлага олон улсын харилцааны хоёр туйлт системийн төгсгөл ойртох тусам улам бүр илэрхий болж байлаа. Ийм ялгаатай хоёр хандлага урсгалын дунд ЭҮНХ, "77-гийн бүлэг" төвийг захиж, үйл ажиллагааны эрч далайц нь аажмаар суларч эхэлсэн юм. Ингэхээс ч өөр аргагүй. Учир нь эдгээр байгууллага "Хүйтэн дайнаар" нөхцөлдөн тухайн үеийн улс төрийн зорилтуудыг дэвшүүлсэн. Гэтэл тэдгээр зорилт нь цагийн эрхээр хуучирч, үүрэг нь бүдгэрэв. Тийм учраас ЭҮНХ ядуурлын эсрэг тэмцлийг эрчимжүүлэх, "Умард-Өмнөдийн" хөгжлийн хол заагийг арилгах гэсэн цэвэр эдийн засгийн үүрэгтэй болжээ.

Баян умардаас "Өмнөдийн" бүс нутгийн байгууллагыг илүүд эрхэмлэх болсон тухай дээр дурдсан. Үнэндээ ЭҮНХ, "77-гийн бүлэг" дэлхийн бодлогод жинтэй нөлөөлөхгүй байгаа үед үүнийг буруутгах аргагүй. Харин эдний дэргэд бүс нутгийн байгууллагуудын (АСЕАН, ОПЕК зэрэг) үүрэг илүү нөлөөтэй болж байна. Европын холбоо, OECD, НАФТА, АПЕК-аас эдгээр байгууллагад

хандаж байгаа, жишээ нь Европын холбооны ГЯА-ны сайд нарын 1994 оны уулзалтаар (ХБНГУ-д болсон) Европын холбоо ба АСЕАН-ны хоорондын харилцааны шинэ чиг хандлагыг тогтоохоор заасан. Энэ заалтын дагуу хоёр байгууллагын төлөөлөгчид 1995 оны тавдугаар сард Сингапурт уулзлаа. 1996 онд хоёр байгууллагын гишүүн орнуудын дээд хэмжээний уулзалт хийхээр шийдвэрлэжээ. АСЕАН болон ОПЕК-ийн хооронд мөн ажил хэрийн холбоо тогтоосон нь үүнийг бэлхнээ нотолно.

ГУРАВ. ӨРИЙН ДАРАМТ

Гадаад өрийн тухай асуудал дэлхийг хамарсан шинжтэйг юуны өмнө хэлэх ёстой. 80-аад онд дэлхийн эдийн засагт хэд хэдэн хандлага ажиглагдсаны нэг нь гадаад өрийн өсөлт (Бусад нь: эдийн засгийн хөгжлийн хурд ерөнхийдөө саарсан; Африкт эдийн засгийн өсөлт буурч, үндэсний орлогын үйлдвэрлэл эрс багассан; тэр үеийн социалист орнуудын гадаад өр нийтэд ил тод болж, тэдгээр орон зогсонги үедээ орсон; Азийн шинээр аж үйлдвэржсэн орнууд, Японы эдийн засгийн өсөлт өрнөдийн эдийн засгийн системд хүчтэй нөлөөлсөн зэрэг). 80-аад он хүртэл өр ширийн тухай асуудал (дайны төлбөрийг эс тооцвол) дэлхийн хэмжээнд тэгтлээ сүрхий яригдаж байсан түүх байхгүй. Заавал 80-аад онд үүссэн нь ч санаандгүй зүйл биш. Эсвэл хуримтлагдсаар яг тэр зурвас үед тэсэрч гарсан юм биш. Энэ бол дэлхийн эдийн засгийн системд цохилт болсон нефтийн хоёр удаагийн (1973, 1978-1980 он) хямралын шууд бүтээгдэхүүн билээ.

1971-1973 онд хөгжиж буй орнуудын төлбөрийн баланс хэвийн тогтвортой байв. 1973 онд нефтийн анхны хямрал дэгдэхэд түүний нөлөө олигтой тусаагүй. Харин хөгжингүй орнууд үлдэж балмагдсан. Гэвч тэд эдийн засгаа эвдэж бусниулалгүй уг хямралыг тойрч гарсан бөгөөд 1975 оноос хуучин хэвэндээ эргэж оржээ. Гэтэл 1975 оноос хөгжиж буй орнуудын эдийн засаг хямарч эхлэв. Учир нь нефтийн үнэ нэмсэн ОПЕК-ийн орнууд хөгжиж буй ертөнцөд багтах учраас ОПЕК-ийн эсрэг явуулсан хариу алхамд энэ эвсэл бүхэлдээ цохилт амссан юм. Ялангуяа эдгээр орны экспортыг хязгаарлаж, зээл тусламж өгөхөө багасгасан нь ийм байдалд хүрэх нөхцөл болжээ. Гадаад худалдааны алдагдал нь эргээд асар их хөрөнгийг оруулалт шаардав.

1978-1980 онд хоёр дахь хямрал тохиолдов. Энэ үед хөгжиж буй орнуудын импорт хэл бич, экспортын ихэнх нь өрийн төлбөр явсан юм. Энэ бол нефтийн хямралтай холбогдох тодорхой нөхцлөөр бий болсон шалтгаан.

Гол шалтгаан нь өнөөгийн дэлхий ертөнцийн харилцан хамаарал, улс орнуудын хамтын ажиллагаатай холбоотой. Ерөөсөө улс бүр өртэй байх нь хэвийн ердийн үзэгдэл болоод байна.

Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлж, олон улсын хөдөлмөрийн хуваарьт өргөн оролцох нь тухайн орны хөгжлийг хурдасгах гол нөхцөл, боломж юм. Гэтэл 70-80-аад онд хөгжиж буй дийлэнх орны эдийн засагт хөгжлийн эрчимгүй арга давамгайлж, дээр нь "Хүйтэн дайны" үеийн хоёр системийн тэмцэл нөлөөлж байснаас эдийн засгийн гадаад харилцаанд нь зохисгүй үр дагавар үлджээ. Харилцан хамааралтай дэлхий ертөнцөд улсууд нэг нь нөгөөгөөсөө хөрөнгө мөнгө зээлэх нь зүйн хэрэг. Харин зээлээ эргүүлж төлөх чадвар, санхүүгийн боломж бол өөр хэрэг. Авсан зээлээрээ дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах замаар өрийг барагдуулах ёстой. Хамгийн энгийн наад захын зүйл ярьж байна. Гэтэл хөгжиж буй өртэй орнууд (ялангуяа Африкийн орнууд) ингэж чадаагүй. Харин ч гадаад худалдааны алдагдалд орсон. Нөгөө талаас эдийн засгийн объектуудыг хугацаанд нь ашиглалтад оруулдаггүй буюу цаг зуурын бэрхшээлд (дайн дажин, байгалийн гамшиг) түүртээд авсан зээлийнхээ үр дүнг үзэхгүй буюу зээлээр авсан тоног төхөөрөмж, техник технологийг хуучруулж орхидог. Энэ нь гадаад өр ихсэх бас нэг эх үүсвэр. Угаас үндэсний технологи байгаагүйгээс нэлээд орон тусгаар тогтнолоо олж авмагц үрэлсэн эдийн засгийн механизм шилжиж оржээ. Үүнд социалист орнууд ч хариуцлага хүлээх ёстой. Үрэлсэн эдийн засаг бол хөрөнгө мөнгө ихээр шаарддаг, удаж байж үр шим нь гарцал, технологийн шинэчлэл хийх боломж муу. Гэтэл тэр их хөрөнгө мөнгө мөхөн зээлээр л орж ирнэ. Тэр нь эргээд өр болно. Үүний эцэст дэлхийн зах зээлд зарим бараа, бүтээгдэхүүний үнэ, худалдаа-үйлчилгээний тариф тогтворгүй байсан үедийг санаархав. Жишээ нь нефтийн хямралаас хойш дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ, түүний дотор нефтийн үнэ тасралтгүй бууцар 90 ээлд өн хүрсэн. Энэ бол гадаад худалдааны ашиг хамгаарч гэдэг үг. Экспорт нь түүхий эдээр голлосон уу, эсвэл бэлэн бүтээгдэхүүнээр голлосон уу гэдгээс их зүйл шалтгаалдаг. Бас эдийн засгийн хүнсний бүтээгдэхүүн худалдаж авахад зарцуулсан өр нэмэгдэнэ. Энэ бол хөгжиж байгаа гэлтгүй тухайн үеийн социалист орнуудад өр нэмэгдсэн гол шалтгаан юм. Харин энэ бүхний учир шалтгааныг өөрсдөөсөө бус гаднаас (тухайлбал "Үмэгдэл") эрж байсанд хэргийн учир нь оршино. Жишээ нь хөгжиж үй орнууд олон улсын худалдаанд ялгаварлан гадуурхах бэлтгэл явуулж, дэлхийн зах зээлд түүхий эдийн үнийг хэргээр үнэлж байна гэж үздэг байлаа. Учир нь шалтгааныг ийнхүү бүүр тодорхойлсон учраас "Өрийг бүү төл!" гэсэн уриалга түгээж, өр шилжсэн хооронд хиймэл зөрчил үүсгэж байв. Өөрөөр хэлвэл өрийн асуудлыг хоёр системийн хоорондын зөрчил, ангийн тэмцэл шингэх сонирхол бүхий хүч тухайн үед байсан юм.

Өр ширинд баригдсан орнуудыг бүс нутгаар нь ангилах асуудлыг энд орхигдуулж болохгүй. Бид хөгжиж буй орон, "Гурав

дахь ертөнц" гэдгийг Ази, Африк, Латин Америк гэж хэт хавтгайруулж нэрлэдэг нь буруу болох тухай дахин сануулая. Ингэж нэгтгэж авч үзэх нь цаг үеэс хоцорсон. Өрийн тухай ч бас бүгдийг нь нидилтгах аргагүй болжээ. Жишээ нь гаднаас 50 тэрбум долларын өр тависан боловч огцом хөгжиж, олон үзүүдэлтээр дэлхийн тэргүүлэх 20 орны дотор орсон Өмнөд Солонгосыг ертөн хэмээн (БНАСАУ-ын суртал нэвтрүүлэг ингэж үздэг -Зох) Африк, Латин Америкийн орнуудтай нэг зиндаанд үзэж болохгүй. Эсвэл төвхөн хүмүүнлэгийн тусламжаар аргацааж байгаа (энд өр төлөх тухайд орхиё) Африкийн орнуудыг Латин Америкийн ертөн орнуудтай зэрэгцүүлж авч үзэж болохгүй. Ер нь 80-аад оны дунд үе гэхэд өр ширтэй хөгжиж буй орнуудыг 3 ангилалд хуваах болсон юм.

1. Асар их өртэй Латин Америкийн орнууд;
2. Өртэй боловч өр төлөх чадваргүй Африкийн хэсэг орон;
3. Бусад орон гэж авч үзэж байв.

Эхний ангилалд өр төлөх бүү хэл, өрийн хүү төлөхөд олон арван тэрбум доллар төлөх ёстой Латин Америкийн бүлэг орныг нэрлэдэг. Дунд зэргийн хөгжилтэй боловч асар их өртэй 17 орон байсны олонхи нь энэ бүс нутгийнх байв. 1980-1988 онд Латин Америкийн улсуудад нэг хүн ам тутамд ногдох жилийн дундаж орлогын хэмжээ 10 хувиар буурч, эдийн засагт экспортын хэмжээ багасч, өр ихэссэн юм. Гэхдээ энэ бол эдгээр орныг огт чадваргүй гэсэн үг биш. Эдгээр орны аж үйлдвэржсэн, бүс нутагтаа байр сууриа олсон зэрэг нь эрхбиш гэгээтэй тал нь. Тийм учраас эдгээр орны хувьд өр төлөх хугацааг сунгуулах тухай ярихаас бус хөнгөлөх, өрөөс бүрмөсөн чөлөөлөх яриа байхгүй.

Хоёр дахь ангилалд орох орнууд бол хүн амын бодит орлогын хэмжээ маш доогуур, хүн ам нь эдийн засгийн боломжоосоо хэтэртлээ өссөн, өвчлөлт, хүүхдийн эндэгдлээр дээгүүр орох хар Африкийн орнууд ордог. Тэндхийн 500 гаруй сая хүн ардын 100 сая нь байнга өлсгөлөнд нэрвэгдэж, бараг 200 сая хүн ядуугийн доод түвшинд аж төрж байна. Ийм орнуудын хувьд гадаад өрийн зарим хэсгийг хүчингүй болгох, цуцлах зэргээр хөгжингүй орнууд харж үзсээр иржээ. Ингэж хөнгөлөх, цуцлах гол нөхцөл бол мэддүүлэгч орнууд алдагдлаа нөхөх зохих нөөц бий болгох явдал. Энэ бол банкны хийх ажил. 1987 оноос зарим орон өр төлөхөөс шууд татгалзсан тул өрнөдийн банкууд болон засгийн газрууд өрийг хүчингүй болгох арга хэмжээ авсаар тэр практик өнөөг хүрчээ. Үүс өртэй орнууддаа ялгавартай хандаж, олон хүчин зүйл хэмжүүрээр хэмжиж байна. Олон улсын эдийн засгийн институт, НҮБ-ын хүчин зүйл хамтран оролцохыг санал болгож байна.

1988 оноос эхлэн "7-гийн бүлгийн" үлзалтаар өрийг хүчингүй болгох шийшээр хэл өгсөө гаргажээ. Их Британи, Канад, ХБНГУ өр төлөхөд үнэ хэмжээний үзүүнж, Франц нь Африк дахь хуучин колони хэд хэдэн орныхоо 16 тэрбум франкийн өрийг цуцлаж эхний үлгэр

жишээ үзүүлсэн. Бас тэр жил Япон нь Африкийн 20 орны 1978-1988 онд зээлсэн 8 тэрбум долларын (тэр үеийнхээр нэг триллион иен) зээлийг хүчингүй болгожээ. Энэ бол тухайн үедээ чамлахааргүй тоо төдийгүй үнгэр жишээ болох зүйл байсан юм. Хамгийн сүүлийн баримтаар 1994 онд Неапольд болсон "7-гийн бүлгийн" дээд хэмжээний үүлжилтын явцад хөгжиж буй орнуудын засгийн байдлыг хэлэлцэж хүнл хэцүү нөхцөл байдал нүүрлэсэн орнуудын өрийг хөнгөвчлөхийн тулд албан ёсны өрийнх нь гуравны хоёрыг хүчингүй болгохыг Их Британи, Франц хоёр санал болгож байсан. Хэрэв энэ санал хэрэгжсэн дэлхийн эдийн засгийн ачаанаас бага ч болов хөнгөлөх биз эр.

90-ээд он гэхэд өрийн асуудал зарим талаар хөнгөрсөн юм. Латин Америк болон Азийн зарим орон өрөө төлөхийн тулд "Умард" руу ихээхэн хэмжээний валют илгээх болжээ. Тэр үеийн тооцоогоор жил бүр 25-30 тэрбум долларын хөрөнгө шилжүүлж байв. Ийм учраас үмийнхнийн бааз суурьтай, хөгжих найдвартай Латин Америк, түүн болон Өмнөд Азийн орнууд өрийн дарамтнаасаа салж эхлэв. Харин нэн буурхай, идүү орнууд өрөндөө баригдсаар бүр цдиж өлжөж хүрчээ. Ийм учраас өрийн хямрал дэлхийн эдийн засгаас салж олохгүй нэлээд сууралцах төлөлтэй. Одоо өртөйд тооцогдож хөгжиж буй орнуудын гол талчаал юу вэ? гэвэл НҮБ-ын тооцооноор тэрхүү өрийг хариуцах зэвэн байхгүй болсонд байгаа бололтой. Өнөөдөр энэ хариуцлагыг тухайн орны засгийн газар хүлээж байвч хэрэг дээрээ олон арван жилийн тэртээх зээлийг янз янзын шугамаар авчээ. Тийм учраас одоо тэдгээр орны улсын төсөвт ихээхэн дарамт учраад байна. Засгийн газар дотооддоо арвилан хэмнэхийг хичээж, цаасан мөнгийг ихээр үйлдвэрлэж гүйлгээнд оруулан юмныхаа үнийг нэмэвч инфляц дагалдан өсч байна. Үүнийг дагалдан ядуурал газар авч, нийгмийн бухимдал ихэснэ. Энэ нь эргээд аюулгүй байдалдаа нөлөөлөх жишээтэй. Энэ бол тартагтаа тултал доройтсон, хэт ядуу орнуудын хувьд авч ярихаас бус тэгтлээ түгээмэл тархсан үзэгдэл биш.

90-ээд онд өрийн асуудал хөнгөрсөн гол шалтгаан бол "Хүйтэн дайн" дууссантай холбоотой. Өрийн асуудлыг олон улсын харилцааны маргааны гол сэдэв болгож, хоёр системийн зерчилд ашиглах гэсэн хүч байсан тухай дээр дурдсан. Тэгэх нь ч тухайн үедээ улс төрийн тодорхой ач холбогдолтой байсан биз. Харин "Хүйтэн дайн" дууссанаар тэгэх шалтгаан нөхцөл аяндаа алга болж, өр нь цэвэр олон улсын эдийн засгийн харилцааны асуудал болж үлдсэн юм. Одоо өртэй орнууд олон бий. Гэвч тэр нь эдийн засаг-худалдааны механизмаар зохицуулагдах ёстой бөгөөд "7-гийн бүлэг" шиг авлагатай орнуудын өгөөмөр алхамаас шалтгаалах болно.

ДӨРӨВ. НЕФТЬ БА УЛС ТӨРИЙН БОДЛОГО

Олон улсын харилцааны үлэмж хурц, анхаарал татах энэ асуудлыг тусгайлан авч үзэх нь дэлхийн эдийн засаг, "Умард-Өмнөдийн" харилцаа төдийгүй Ойрхи болон Дундад Дорнодын асуудлыг ойлгох нэг дэвсгэр болох биз ээ. Нефть улс төрийн бодлоготой холбогдох асуудал түүхэн ямар уламжлал, учир шалтгаантай, яагаад дэлхийн эдийн засагт нөлөөлсөөр ирсэн, ямар ямар үе шат дамжин уг асуудал хуримтлагдсан, түүнд хэн холбогдох гэх мэт олон асуудалд тоймтой хариу өгсөн ном зохиол Монголд хэвлэгдэн гараагүй байна. Ерөөсөө уг асуудлыг энд заавал тусгайлан авч үзэх хэрэгтэй юмуу гэж эргэлзэх хүн байж болно. Нефть бол зөвхөн шатах тослох материал хийдэг түүхий эд биш. Энэ бол эрчим хүчний шингэн түлш. Тэр утгаараа өндөр хөгжсөн орнуудад амин чухал асуудал (эдийн засгийн хувьд амин сүнс нь) болсоор ирсэн. Ерөөсөө дэлхийн колонийн системийн үүсэл хөгжил, дэлхийг дахин хуваахын төлөө тэмцэл, дэлхийн хоёр дайн, дайнаас хойшхи олон улсын маргаантай асуудал нефтиэс ихээхэн хамааралтай байсныг мартэх ёсгүй.

Энд би түүх сөхөж олон баримт дурдалгүй, ердөө л 70-аад оноос эхлэн ярьж. Өнгөрсөн зуунаас шингэн түлшний эрэлд дэлхий даяараа мордсон юм. ШУТ-ийн болон газар зүйн их нээлтүүд, аж үйлдвэрийн хувьсгалын анхны ололтууд нефтийг дэлхийн улс төрийн бодлогын цөм рүү аажмаар аваачсаныг эргэж саная. Дэлхийн хоёр дайнаас хойш дэлхийн томхон гүрнүүдийн өрсөлдөөний талбар нь манай гаригийн нефтийн гол ордууд болсон билээ. Дэлхийд одоогоор судалж илрүүлээд байгаа нефтийн 60 гаруй хувь нь Арабын хэсэг оронд ногдож байна. Өрнөд Европын орнууд нефтийнхээ хэрэгцээний 70 хувь, Япон 85 хувийг зөвхөн энэ хэдэн орноос хангасаар ирсэн нь 70-80-аад онд нефтийн хоёр удаагийн хямрал дэгдэх нэг нөхцөл болсон юм. АНУ 70-аад он хүртэл эндхийн нефтиэс тэглээ хамааралтай байгаагүй. Гэвч татагдан татагдсаар 70-аад оны дунд үе гэхэд шууд холбогдох болжээ. "Хоёр дахь ертөнцийн" (социалист орнууд) тухайд Ойрхи Дорнодод зөвхөн улс төрийн сонирхолтой байсан болохоор тэрхүү хоёр хямралд шууд холбогдохгүй. Тэгээд ч ЗХУ (өнөөгийн Орос) нь түүхий нефть олборлох үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж үлджээ.

Нефтийн улс төрийн бодлоготой холбож тайлбарлахдаа ОПЕК, ОАПЕК гэсэн хоёр байгууллагыг тойрч гарах аргагүй. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш "Туривдахь ертөнцөд" нөлөөлөх хэмжээнд үүрэг гүйцэтгэж ирсэн бүс нутгийн байгууллага бол ОПЕК. Дэлхийн тухинд нефтийн үнэ цэнэ байнга өсч, ялангуяа 1956 оны Суэцийн хямралын дараа олон улсын анхаарал Ойрхи Дорнод руу төвлөрөх болсон үед яг цагаа олж ОПЕК (1961 он)

байгуулагджээ. Бас дэлхийн колонийн систем сүйрснээр шинэ тулгар хөгжиж буй олон орныг араасаа дагуулна гэсэн тооцоо байсныг үгүйсгэх аргагүй. ОПЕК-т Ойрхи Дорнодын 7, Африкийн хоёр, Латин Америкийн хоёр, Азийн хоёр, нийт 13 улс гишүүнээр бүртгэгддэг бөгөөд эдгээр орныг зөвхөн нефтийн асуудал л холбодоггүй юм бол өөр хоорондоо нийлэх нийтлэг сонирхол байхгүй нь мөдхөн харагдсан. Тэгээд ч байгууллагдасанаас эхлэн 1973 оны Араб-Израилийн дайныг хүртэл энэ байгууллагын үүрэг нөлөө, үр өгөөж төдийлөн мэдрэгдээгүй юм. Тийм учраас 1968 онд Арабын орнууд тусдаа ОАПЕК буюу Нефть экспортолдог Арабын орнуудын байгууллагыг бий болгожээ. Энэ бол ОПЕК-ийг бодоход тухайн цагтаа Ойрхи Дорнодод нөлөө бүхий байгууллага байв.

ОПЕК-ийн жинхэнэ үүрэг 1973-1975 онд илэрсэн байж болох юм. Тэр үед Израильд шахалт үзүүлэх үүднээс өрнөдийн орнууд руу гаргадаг түүхий нефтийнхээ үнийг өсгөж, тэдгээр орны эдийн засагт нэг хэсэгтээ дарамт учруулж дөнгөв. Гэвч түүнээс хойш үүрэг нь хумигдаж, үйл ажиллагаа нь саармагжин зогсонги байдалд оржээ. Үүнд АНУ-аас бүс нутагт явуулсан дипломат бодлого нөлөөлснийг тэмдэглэхийн сацуу ОПЕК-ийн дотор гарсан хагарал (жишээ нь Ираны лалын хувьсгал, Иран-Иракийн дайн, хожим нь Ирак өөрөө ОПЕК болон дэлхийн хамтын нийгэмлэгээс зожигрон салсан гэх мэт) ихээхэн гай түйтгэр тарьсан юм.

Нефтийн хамрал (1973-1975 он) Арабын орнууд өрнөдийн нефть импортлогч орнуудын эсрэг хориг тавих гэж 1967 онд анхны оролдлогоо хийжээ. Тэр үед Израиль-Арабын хооронд ээлжит дайн дэгдэж, АНУ болон Өрнөд Европ Израилийг дэмжив. ОПЕК дотор АНУ-тай ойр дөт харилцаатай байсан Саудын Арав, Иран хоёр нь үүнийг эсэргүүцэж, уг хоригийг цуцлуулав. 1973 онд Синайн дайны үед Израиль нь Арабын томхон хүчийг бут цохисноор үл барам давшиж, Синайн хойгийг бүхэлд нь авчээ. Үүнийг эсэргүүцэж ОПЕК-ийн орнууд АНУ, Нидерландын эсрэг дахин хориг тавьжээ. Энэ үеэс *"Нефть бол зэвсэг"* гэсэн нэр томъёо бий болж, Арабын орнууд улс төрийн зорилгодоо хүрэх цорын ганц хэрэгсэл гэж үздэг болжээ. Энэ бол 1973 оны хэрэг явдал хэр өргөн цар хүрээг хамарсан, ямар үр дагаварт хүргэсний нотолгоо. Дэлхийн эдийн засаг-санхүү-валютын систем хэрхэн хямарсныг түрүүчийн бүлгүүдэд тайлбарласан. Энэ хоригоор нефтийн дайрлага гээч юм олон улсын харилцаанд бий болов. Өрнөдийн эдийн засгийн системийг хямраав. Бас Өрнөдийн улс төрийн эв нэгдэлд анх удаа сэр суулгажээ. Нефтийн нөөцөөр хомсхон буюу огт байхгүй Англи, Итали, Грек, Испани, мөн ХБНГУ Израилийг шууд дэмжихээс булзаж, тэгснээрээ Арабын орнууд болон тэдний ард ивээн тэтгэж байсан ЗХУ-ыг шийдэмгий ажиллахад түлхэв. 1973 оны арванхоёрдугаар сард Женевт Ойрхи Дорнодын асуудлаар энх тайвны бага хурал зарлан хуралдуулсан тухай ярьж байна. Үүнд ЗХУ бага хурлын нэг даргын хувиар (АНУ-

тай хамт) оролцсон бөгөөд бага хурлаар Ойрхи Дорнодод бат бэх шударга энх тайван тогтоох механизмыг бий болгосон гэж үздэг. Гэвч энэ бага хурал 1993 он хүрч байж үр дүнгээ харуулсан болохоор тэр үеийн түр зуурын ололтыг дэлгэрэнгүй авч үзэх хэрэггүй.

Нефтийн анхдугаар хямралын үеэр өрнөдийн болон дэлхийн эдийн засгийг хэрхэн зохицуулсан тухай авч үзье. ОПЕК-ийн орнууд дотроо тууштай эв нэгдэлтэй байсангүй. Хөгжлийн хоцрогдол ба өөр хоорондын ялгаа зөрүү, бас зарим нэг орон нь Ойрхи Дорнодын хэрэг явдлаас хэт алслагдсан (жишээ нь Индонез, Габон, Нигери, Эквадор, Венесуэл), өрнөдийн орнуудаас авсан хариу арга хэмжээ зэргээс үүдэн тавьсан зорилгодоо хүрэлгүй буцаж няцсан хэрэг. Саудын Арав АНУ-тай уламжлалт харилцаатай байсан учраас Арабын орнуудаас хичнээн шахаж шаардаад яаж ч хүчирсэнгүй. Саудын Арав дээр 1974 оноос Египет нэмэгдлээ. Эдийн засгийн хямралд автаж, дээрээс нь газар нутгаа алдсан энэ орны хувьд буулт хийх замаар хүнд байдлаас гарахаас өөр арга байсангүй. Тийм учраас Женевийн энх тайвны бага хурлын дараа АНУ-ын оролцоотойгоор боловсруулсан Синайн хоёр хэлэлцээрийг зөвшөөрөхөөс өөр аргагүй болов. Тэгэх нь ч Египетэд ашигтай байлаа. Энэ хэлэлцээрт нэгдсэнээрээ Египет тухайн үедээ нэг талаар алдаж, нөгөө талаар онов. Арабын орнуудын дотор ганцаардах замд орж, ЗХУ-ын тусламж дэмжлэгээс хасагдсан боловч эзлэгдсэн нутгаа эгүүлэн авч, дээрээс нь АНУ-аас асар их зээл тусламж авчээ. Тэр хөрөнгөөр дайнд сүйдсэн Суэцын сувгаа нөхөн сэргээж, Синайн хойг дахь нефтийн ордуудаа эргэж ашигласан юм.

Нефтийн хямралыг зохицуулсан дараагийн том алхам бол Олон улсын эрчим хүчний агентлаг байгуулсан явдал байлаа. Өрнөдийн эдийн засгийн хувь заяа Арабын нефтээс ихээхэн хамааралтай болохыг 1973 оны аравдугаар сарын хэрэг явдал харуулсны дараа нефтийн талаар нэгдсэн бодлого боловсруулах асуудлаар 1974 онд хоёр том зөвлөлгөөн хийв. Хоёр дахь зөвлөлгөөнөөр (1974 оны арваннэгдүгээр сар, Вашингтон хот) OECD-ийн дэргэд хөгжингүй 18 орныг багтаасан Олон улсын эрчим хүчний агентлаг байгуулжээ. Тус агентлаг дэлхийн нефтийн зах зээлийн асуудлыг судлаад дараахи шийдвэрийг гаргажээ. Үүнд

1. Нефтийн импортын хэрэгцээ ялангуяа Арабын орнуудаас авах нефтийн хэрэглээг багасгахын тулд бололцоотой бүх арга хэмжээг авах;
2. Хэрэв дахин нефтийн шинэ хориг тавибал гишүүн орон бүр дор хаяад 60-90 өдрийн нефтийн нөөцтэй байх;
3. Нефть олборлодог орнуудаас хамааралтай байгааг багасгахын тулд улс орныхоо дотоодод өөр эх сурвалж эрж олох, хөгжүүлэх;

4. Нефть олборлодог гол гол орнуудтай хийх яриа хэлцээнд дэмжлэг үзүүлж, олон улсын нефтийн компаниудтай хэлэлцээ хийх явдлыг чухалчилжээ.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлснээр өрнөдийн орнууд нефтийн гачаалаас гарах төдийгүй Арабын орнууд эргээд хориг цээрээ цуцалж, хэвийн худалдаа хийх ёстой гэж үзсэн байна. Гэтэл Арабын орнууд нефтийн үнээ буулгахгүй байхаар шийдэж, харин олборлолтоо багасгажээ. Ингэснээр нефтийн зохиомол үнэ бий болж, гадаад худалдаанд экспорт-импортын тэнцвэр алдагдаж эхлэв.

Хөгжингүй орнууд эрчим хүчинд нефть орлох нүүрс, атомын эрчим хүчийг түлхүү ашиглаж, атомын эрчим хүчийг хөгжүүлжээ. Мөн мазут нь нефть, байгалийн хийнээс илүү хямд түлш болох нь нотлогдлоо. Нефтийн бүтээгдэхүүний дөрөвний гурав нь авто хөсөгт зориулагддаг тул шатах тослох материалын арвиан хэмнэлт юу юунаас илүү чухал боллоо. Мөн шатахуун их хэрэглэдэг авто машины импортыг дор бүртээ анхааралдан авав. Машины үйлдвэрлэлд ШУТ-ийн шинэхэн ололтыг тусгах, хөдөлгүүр эд ангийг нь боловсронгуй болгох талаар ч их анхаарал. Дхуйн хэрэглээнд нефть, нефтийн бүтээгдэхүүн их хэрэглэж байсныг цэгцлэв.

Дотооддоо нефтийн эрэл хайгуул хийж, шинэ уурхай цооног илрүүлж ашиглах болсноор зарим орон Ардбын орнуудын нефтиэр тэгтлээ гачигдахаа больжээ. Жишээ нь дэлхийн нефтийн олборлолтын 70 хувийг дангаараа гаргаж байсан ОПЕК-ийн орнуудын жин нөлөө багассаар арваад жилийн дорин гэхэд (1973 оноос хойш) 40 гаруй хувьд хүрч, АНУ-ынх 17 хуви байснаа 20 гаруй хувьд, өрнөдийн бусад орных 18 байснаа 33 хувь хүрч өсчээ. Нефть экспортолдог орны тоонд Их Британи, Норвег, Мексик, Малайз болон бусад олон орон нэмэгджээ. Үүнд нь ОПЕК-ийн гишүүн нэг орон гэхэд л 20-40 худалдан авалч үлсгэй харилцаж байсан бол энэ тоо эрс багасчээ. Ийм байдлаар нефть экспортолдог, импортолдог орон дэлхийд нэгэн эрэг шахуу өссөн юм. Хөгжиж буй орнууд нефтиэр далайлгаж "Умардтай" харилцах анхны оролдлого 1975 он гэхэд үр дүнгүй нь харагдаж зогсонги байдалд оржээ. Харин ч хөгжиж буй олон орон эргээд сөрөг үр дагавартай учирчээ.

Нефтийн хямрал (1978-1980 он) Нефтийн анхдугаар хямралын хор уршгийг арай гэж арилгаад байтал хоёр дахь хямрал дэгджээ. Гэхдээ энэ нь Араб-Израилийн харилцаанаас үүссэнгүй. Дундад Дорнод, Персийн булан дахь Иранаас эхлэн дэгджээ. Саудын Арав, Иран, Египеттэй АНУ найрсаг харилцаатай байсны ачаар нефтийн хямралыг хохирол багатай давж, дэлхийн эдийн засгийн тэнцвэрийг хадгалж чадсан тухай дээр өгүүлсэн.

Гэтэл найдвартай түнш Иран нь 1978-1979 оны зааг дээр лалын хувьсгалын дайрлагад гэнэт нэрвэгджээ. АНУ-ыг эсэргүүцэх нэрийдлээр өрнөдийн, христосын соёл иргэншлийг үзэн ядсан шашны хэг даврагчид засгийн эрх авч, бүс нутгаас их гүрнүүдийн нөлөөг шахан гаргахыг оролджээ. Үүний сацуу бүс нутагт АНУ-ын өмөг түшиг гэж үзсэн Саудын Аравыг сулруулахыг зорив. Нефтийн анхдугаар хямралаас хойш ОПЕК-т үнийн хэлбэлзэл тогтворгүй болж, нэг ёсны үнийн дайн хийж байсныг цэгцлэх гэсэн Саудын Аравын чармайлтыг мохоож дөнгөв. Гэвч Иран өөрөө хохирлыг тойрч гарсангүй. Жилд нефтийн экспортоос 20-23 тэрбум долларын орлого олж, валютын орлогынхоо 85 хувийг нефтийн арилжаанаас бүрдүүлдэг байсан баян тансаг орон энэ бүх баялгаа хөрш-Иракт хийсэн дайнд цацаж дууссан юм.

Өдөрт 500 мянган баррель нефть Иранаас импортолдог байсан АНУ-ын хувьд Ираны лалын хувьсгалын дараа гэхэд ганц ч баррельгүй хоцорчээ. Лалын хувьсгалчид АНУ-тай тогтоосон харилцааг чинээнд нь тулгал хурцатгаж, улмаар Тегеран дахь АНУ-ын ЭСЯ-ыг 52 ажилтантай нь барьцаанд авчээ. Үүнд АНУ болон Өрнөд Европын орнууд, мөн Япон дургүйцэж Ираны эсрэг эдийн засгийн хориг тавьсан юм. Энэ бол нефтийн хоёрдугаар хямралын оргил үе байв. ОПЕК-ийн орнууд нефтийн үнээ нэмж дэлхийн эдийн засагт шинэ хүндрэл учрууллаа. Зөвлөлтийн цэрэг Афганистанд цомрон орж, мөн Иран-Ирак хоёр дайн дэгдээгээд байсан нь 70-80-аад онд олон улсын харилцааг хурцатгах бас нэг нөхцөл болов. Хуучин аргаар арабын орнуудтай харилцах аргагүй боллоо. 80-аад он гараад өрнөдийн орнуудын эдийн засагт тууштай өсөлтийг хангаж чадсангүй. Ойрхи Дорнодын нефтиэс эдийн засаг нь 80 хувь хамаардаг орнуудын хувьд Персийн булангийн хэрэг явдал үнэхээр ч дэлхийн хэмжээний асуудал мэт байлаа. Урьд нь Араб-Израилийн дайнаас нефтийн асуудал шалтгаалдаг байсан бол одоо Персийн булан руу шилжив. Энэ шилжилт өнөөг хүртэл үргэлжилсээр байна. 1981 онд Эр-Рияд хотод Саудын Арав, Арабын нэгдсэн Эмират, Кувейт, Бахрейн, Катар, Оманы ГЯА-ны сайд нар цугларч бүс нутгийн шинжтэй хамтын ажиллагааны зөвлөл байгуулснаа зарлажээ. ОПЕК, ОАПЕК-аас гадна бас нэг бүтэц Персийн буланд бий болжээ. Уг нь энд Иран, Ирак хоёр гадна нь үлдэх ёсгүй. Гэвч тэр хоёрын дунд дэгдсэн дайн тэгэх боломж олгоогүй. Иракийн нефтийн нөөцийн 35 хувь, Ираны нефтийн нөөцийн 90 хувь дайны галд өртжээ. Байлдаж буй хоёр талыг даган Арабын орнууд хоёр талцаж, бас худалдааны хөвгөнг онгоц, нефтийн танкерууд өдий төдийгөөр өртөж сүйджээ. Ийм учраас 80-аад онд дэлхийн нефтийн зах зээлийн байдал ониг той сайжралыг ололгүй удав. 80-аад он гараад нефтийн үнэ дэлхийн зах зээлд урьд өмнө үзэгдээгүй өсч, энэ өсөлт 1984 он хүрч байж буурч, эргээд 1989 онд дахин өсөв. Нефтийн хоёрдугаар хямрал дэлхийн олон орны улс төрийн

бодлогод нөлөөлснийхөө хэрээр улс төрийн удирдлагад хүчтэй цохилт үзүүлэв. Өрнөдийн ("7-гийн бүлгийн") орнуудад засгийн эрх арга буюу солигдлоо.

Нефтийн хоёр удаагийн хямралд хөгжиж буй орнууд бусдаас илүү хэлмэгджээ. Нефтийн үнэ нэмсэнээс үүдсэн хамаг алдагдлыг өрнөдийн орнууд өөртөө хүлээсэн бөгөөд энэ нь эргээд хөгжиж буй орнуудад үзүүлдэг тусламжинд нь нөлөөлөв. Нефтийн үнэ нэмэгдсэнээс өрнөдийн хэдэн орон төдийгүй хөгжиж буй орнуудад инфляц гүнзгийрч, үнэ тариф өсчээ. Ийм учраас хөгжиж буй орнуудыг баталгаатай дааж байх боломж хөгжингүй орнуудын хувьд хумигдав. Энэ нь нөгөө талаас хөгжиж буй зарим орон улсын тавцанд тодрон гарах нэг нөхцөл болсон байж болно. Учир нь нефтийн хямралаас үүссэн сул орон зайг бөглөх тухай асуудал тулгарчээ. Үүнд нефтиэ гадаадад гаргадаг баян орнуудаас гадна Латин Америк, Зүүн Азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудад шинэ үүрэг ногдов. Эдгээр орон нэг ёсны хандивлах үүрэг хүлээсэн хэрэг. Жишээ нь нефтийн эхний хямралын дараахан 1976 онд "ОПЕК-ийн сан" гэгч байгуулжээ. Тухайн үедээ дэлхийд эдийн засгийн шинэ дэг журам тогтоох зорилгоор үүнийг байгуулсан гэж үздэг. Уг сан 80 аад оны дунд үнэ гэхэд 4 тэрбум доллар хуримтлуулжээ. Сангийн шүтлэмээр өнөөх бүх хэргийг хөнгөлгөөл олгож, хүү төлөхийг шаардсангүй, бас үнэ төрийн бэлзолт тавьдаггүй гэхчлэн дэвшилт зүйл байсныг үгүйсгэх аргагүй. Хөгжиж буй 80 гаруй оронд зээл олгож, давхардсан тоогоор 100 гаруй оронд буцалтгүй тусламж үзүүлсэн баримт бий. Гэхдээ үүнийг нефтийн үнээ нэмж, түүнээсээ илүү ашиг олох замаар хийсэн бөгөөд голыг нь өрнөдийн банкууд нугалжээ.

"Гурав дахь ертөнцийн" эдийн засгийн байдал ийнхүү огцом хурцадсан тул НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1980 оны найм-есдүгээр сард эдийн засгийн асуудлаарх гурав дахь тусгай чуулганаа зарлан хуралдуулав. Үүнд хөгжиж буй орнуудын эдийн засгийн асуудлыг голлон хэлэлцэж, уг асуудлаар дэлхийн хэмжээний хэлэлцээ хийхийн чухлыг заажээ. Үнэхээр гадна оронд баригдсан орнуудын асуудал энэ үеэс эхлэн дэлхийн хэмжээний асуудал болж өргөжив. Эдийн засгийн бараг бүх үзүүлэлтээр хөгжиж буй ихэнх орон урууджээ. Хүнс тэжээлийн асуудал хурцадсан, хүн амын өсөлт, хүн ам зүйн бодлого хурцаар танигдсан зэрэг олон шалтгаан дэлхийн хэмжээнд ийнхүү хэлэлцээ хийхийг нөхцөлдүүлсэн хэрэг.

Нефтийн хямрал (1990-1991 он) Нефтийн хоёр хямралын үед ихээхэн туршлагажсан өрнөдийн хувьд гурав дахь хямрал дорвитой нөлөө үзүүлээгүй. Гэвч эрх ашгаа хамгаалах үүднээс энэ хямралыг газар авахуулалгүй дарж авсан юм. Хоёрдугаар хямралыг Иран эхлүүлж, Персийн булангаар гадагш тархсан бол энэ удаагийнхыг Ирак сэджээ. Иран-Иракийн дайн энэ шинэ

хямралыг нөхцөлдүүлэв. 250 тэрбум долларын алдагдал, 70 орчим тэрбум долларын гадаад өр гэдэг бол бага тоо биш. Энэ их өрийн талыг Ирак Персийн булангийн хөрш орнууддаа тавьжээ. Гэвч өр төлөх чадвар Иракийн хувьд байсангүй. Олон жил дайн хийж байгалих чадвартай болсон Ирак дайтах замаар л энэ асуудлыг зохицуулна. Үүний сацуу ОПЕК-ийн гишүүн орнуудтай нефтийн үнийн асуудлаар зөрөлдөж, бас ОПЕК-оос Иракт олборлох ёстойгоос нь давуулж хэмжээ тогтоож өгсөн нь энэ зөрөлдөөнийг бүр ч дэвэргэв. Ирак-Кувейтын хилийн маргаантай хэсгээс Кувейт нефть олборлож, тэгснээрээ Иракийн үндэсний баялгийг цөлмөж байгаа мэтээр Багдадаас жижиг хөршөө зэмлэж гоочилж эхлэв. Энэ нь даамжирсаар хилийн маргаантай хэсгээр хилийн шугамыг нарийвчлан тогтоох, хууль бус авч ашигласан нефтийнхээ оронд 2.4 тэрбум долларын нөхөн төлбөр хийх, Иран-Иракийн дайны үед хүүгүй зээлсэн зээлийнхээ 10 тэрбум долларын өрийг хүчингүй болгохыг шаардах болов. Улмаар чинээлэг болон ядуу арабуудын хооронд баялагийг шударгаар хуваах тухай Иракийн ерөнхийлөгч ил цагаан ярих болж, араб дахиныг дахин нэг дайрлага дайрах нь тодорхой болжээ. Энэ бол 1990 оны зун Ирак дэлхийн нефтийн нөөцийн үлэмж хэсэг рүү санаархаж байгаа нь ил боллоо. Хэрэв Ирак, Кувейтыг хамтад нь авч үзвэл энэ хоёр улсад дэлхийн нефтийн нөөцийн тавны нэг нь хуримтлагддаг юм. Ирак-Кувейтын харилцаанд Иракаас тулган дэгдээсэн хямралыг арилгах зорилгоор Египет, Саудын Арав, Йемений тавьсан чармайлт зохих саадыг давж үр дүнд хүрчээ Ирак хэлэлцээний ширээнд суухаар ам өмчиг өгсөн боловч хэд хонолгүй 100 мянган цэргээр Кувейт руу гэнэт халдан түрэмгийлж, араб дахины итгэлийг үхүүллээ. 1990 оны наймдугаар сарын 2-т энэ үйл явдал болж, наймдугаар сарын 8 гэхэд Ирак нь эзэлж авсан улсаа Иракийн 19 дэх муж хэмээн зарлажээ. Баян ах дүүсээ мөлжих замаар Ирантай хийсэн дайныхаа хохирлыг нөхөн авах, улмаар Ойрхи Дорнодод гарсан сул орон зайг бөглөх; Персийн буланд нефтийн гол ордыг мэдэлдээ авснаар АНУ, Япон, Өрнөд Европт бодлогоо тулгахыг Ирак ийнхүү зорьжээ. Үнэндээ ч сая цэрэгтэй Иракт бүс нутагт нь эсэргүүцэл үзүүлэх орон байхгүй. Нөгөө талаас Ирак Кувейтыг эзэлснээрээ Палестины асуудлыг хүчээр зохицуулна гэсэн далд тооцоотой байсан байж болох юм. Палестины асуудал шийдэхийг Кувейтын асуудал зохицуулахтай холбож үзэж байсныг нь хэлж байна.

Ерөнхийд нь иракчуудынхаар болсонгүй. Нефть урьдын адил дэлхийн эдийн засгийг хямраах хүчин зүйл биш болжээ. Ирак буруу тооцооллыг "Хүйтэн дайн" нэгэнт түүх болж байсан тэр мөчид дэлхий нийтээрээ нэгэн зэрэг Кувейтын талд зогслоо. НҮБ-д АНУ, ЗХУ хоёр анх удаа түрэмгийллийн эсрэг санал нэгджээ. Аюулгүйн Зөвлөл ийнхүү шуурхай ажиллаж санал нэгдэн тогтоол баталж байсан нь юусан билээ. Иракийн тал хямралыг эв зүйн

аргаар зохицуулах бүх боломжийг үгүйсгэсэн тул Иракийн эсрэг цэргийн арга хэмжээ авахаас өөр арга байсангүй. 30 орчим орны зэвсэгт хүчнээс бүрдсэн эвсэл бүрдүүлж, НҮБ-ын нэрээр 1991 оны нэг-хоёрдугаар сард Иракт цохилт өгөв.

Ирак Кувейтыг эзэлсэн хэдэн сарын хугацаанд дэлхийн нефтийн зах зээлд нефтийн үнэ өсч, хангалт, нийлүүлэлтэд саад учрав. Учир нь Кувейт бол өрнөдийн зах зээлд найдвартай экспортлогчийн нэг. Нөгөө талаас ОПЕК-ийн гишүүн орнуудын нефть олборлолтыг эрс нэмэгдүүлэх шаардлага тулгарав. Хөгжингүй орнууд стратегийн нөөц рүүгээ орохоос өөр арга байсангүй. Иракийн эсрэг байлдааны ажиллагааг санхүүжүүлэхээс үүдэн хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт удаашрах хандлагатай болжээ. Ялангуяа нефтийн хоёр удаагийн хямралын хор уршгийг мартаагүй байгаа санхүүгийнхэнд Кувейтын хэрэг явдал шинэ түлшүүр мэт байлаа. Өмнөх түүх хуучраагүй (жишээ нь Европын холбоог байгуулах хэлэлцээг 1980 он гэхэд дуусгахаар тэр үеийн 9 гишүүн улс шийдээд байтал нефтийн эхний хямрал тохиолдож түүнийг саатуулсан) дээр нь Дорнод Европын посткоммунист орнуудыг дэмжин түслэх хүнд үүрэг ногдсоны хувьд ЕХН Иракийг буруушаахаас өөр аргагүй байв. Европал валютын бирж дээр АНУ-ын долларцаг Дойч марктай харьцах ханш унаж эхлэв. Энэ бол Европын валютын системийг хэлбэлзэлд оруулна гэсэн үг. Персийн булангаас хэрэгцээт нефтийнхээ 65 орчим хувийг оруулдаг Япон ноцтой бэрхшээл дарамтад ороогүй ч эдийн засгийн өсөлтийн хурд нь саарав. Хоёр жилийн өмнө нь энэ хурд 5.3 хувьтай байсан бол Кувейтыг Ирак эзэлсний дараа 4.4 болж буурчээ. Бас инфляц бага зэрэг өсч, сальдо нь буурчээ.

Персийн булангийн хямралаас хамгийн их хохирол амссан нь хөгжиж буй орнууд байлаа. Ялангуяа нефть импортлодог орнууд хамгаас их хохирчээ. Нефтийн хомсдол, түүний үнийн өсөлт тэдгээр орны хөгжлийн хурдыг сааруулж, улсын санхүүг хоосолж, нийгмийн амьдралыг хурцатгав. "Гурав дахь өртөн цийн" 60 орчим улс төлбөрийн балансын алдагдалд оржээ. Нефтийн гадаадад гаргадаг хэсэг орон цэвэр орлогынхоо 10 хувийг богино хугацаанд алдав. Гадаадын хөрөнгө оруулалт хийх замаар ор ширнээсээ салах зорилготой орнуудын боломжийг Персийн булангийн хямрал бусниулж, өрийн дарамтыг ихэсгэх үүд нээжээ.

Арабын орнууд бараг нэгэн дуугаар Иракийг буруушаасан нь энэ хэрэг явдал тэдгээр орны амин чухал эрх ашигт шууд харшилсантай холбоотой. Иран-Иракийн дайны үед Иракийн талд зогсож байсан араб хөршүүд нь энэ удаа Иракийн эсрэг эргэжээ. Жишээ нь хамгаас илүү хохирол амссан Йордан үндэсний орлогынхоо 30 хувийг алджээ. НҮБ-аас Иракийн эсрэг эдийн засгийн хориг тавснаас болж Ирактай худалдаа хийж байсан хэсэг орон хохиров. Турк гэхэд экспортоо багасгаж, бас иракийн нефтийг нутаг дээгүүрээ транзитаар нэвтрүүлж байснаас олдог цэвэр

орлогоо алджээ. Үүнээс үүдэн тус орон 30 орчим тэрбум долларын алдагдалд оржээ. Иракт гэрээгээр ажилладаг гадаадын бүх ажилчид ажилгүйдсэнээс тэдэнд нөхөн төлбөр олгох хэрэг олон оронд тулгарчээ. Египет үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ 4 хувийг Иракаас болж алдлаа. Энэ мэтээр Арабын улсуудад учирсан хохиролын хэмжээ дор бүртээ чамлахаааргүй болжээ. Тэгэхээр эдний алдагдлыг хөгжингүй орнууд л нөхөн төлөх ёстой. Учир нь тэгэхгүйгээр арабын орнуудыг Иракийн эсрэг нэгтгэх боломжгүй. Жишээ нь Япон Египетэд 300 сая доллар амалж, Европын холбоо 2 тэрбум доллараар тусалж, АНУ зэвсгийн өр болж үлдсэн 7.1 тэрбум долларыг хүчингүй болгожээ.

Ойрхи Дорнодын нефтийн хямралаас огт ажралгүй явж ирсэн Дорнод Европын (хуучин ЭЗХТЗ-ийн) орнууд анх удаа түүний хор уршгийг амсчээ. Хамтын байгууллага ЭЗХТЗ дампуурч, нефть байгалийн хийн хангалтыг хариуцаж ирсэн ЗХУ эдийн засгийн хямралд нэрвэгджээ. Тийм учраас эдгээр орон НҮБ-ын шийдвэрт үг дуугүй захирагдахаас өөр аргагүй. Тэгээд бас Дорнод Европын орнууд 14 орчим тэрбум долларын алдагдалд оржээ. Ойрхи Дорнодын нефтиэр реэкспорт хийдэг орон ЭЗХТЗ-д байсныг нуух аргагүй. Тийм орон хамгаас илүү хохирол амсав. Өрийн сүлжээ (харилцан тавьсан өр) хаа хаанаа өслөө.

Энэ мэт баримт дурдвал Персийн булангийн тэр хямрал дэлхийн эдийн засгийг бүхэлд нь хөндсөн юм. Шингэн түлшний үнэ, алтны үнэ өсч, валютын биржүүд дээр хатуу валютын хэлбэлзэл хэдийн бус болов. Тийм учраас 1990 оны намар гэхэд 1973 оныг санагдуулам уур амьсгал бий болжээ. Ирак ийнхүү дэлхий дахиныг өөрийнхөө эсрэг босгож үхлээ өөрсдөө бэлтгэжээ. Энэ хямралын хор уршгийг 1992 он хүрч байж арилгасан. Учир нь эзлэгдэж, дараа нь дайны хөлд нэрвэгдсэн Кувейтын нефтийн ордуудыг сэргээхэд чөлөөлснөөсөө илүү их хөрөнгө зарцуулсан билээ.

ТАВ. "ЛАЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН" ТУХАЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

60-70 аад оны зааг дээр хөгжиж буй орнуудын хөгжлийн хэтийн төлөвийг лалын шашинтай холбож тайлбарласан нэгэн үзэл баримтлал бий болов. Энэ нь лалын шашныг төрийн хэмжээнд өргөмжилсөн буюу лалын шашинд сүсэглэдэг Ази-Африкийн хэсэг орноос анх үүссэн эдийн засгийн үл гүйцэлдэх сургаалийн нэг байсан гэж үздэг. Лалын шашны "эдийн засгийн философийн үнэт зүйл" гэгчид үндэслэл эдийн засгаа хөгжүүлэх тухай энд авч үзжээ. Лалын шашны шариатын ёс жаяг (жишээ нь өргөл барьц, сүсэгтэн олны хандин, бусад орлого) эрүүл саруул эдийн засгийн

нөхцөл төдийгүй лалын шударга ёс, нэгдэл нягтралын үндэс болох тухай номлодог. Хөгжиж буй орнууд эрх чөлөөгөө олж аваад аж ахуйн элдэв бэрхшээлтэй тулгардаг нь мэдээж. Тийм орнууд өрнөдийн, америкийн, хөрөнгөтний эдийн засгийн хэв загварыг дууриахын оронд лалын үнэт зүйлийг хэрэгжүүлбэл хөгжил цэцэглэлээ хангана гэж лалын онолчид үзжээ. Хувийн өмчийг шүтдэг капитализм, нийтийн гал тогоог шүтдэг социализмын алинаар нь ч явахгүй, гурав дахь замаар хөгжих нь аливаа хямралыг тойрч гарах цорын ганц боломж бөгөөд тэр нь лалын эдийн засаг гэж номлодог.

Ингэж номлохыг шууд үгүйсгэх аргагүй. Колонийн дарлалаас ангижирсан орнууд түүхэн учир шалтгаанаар хөгжлийн хоёр замын аль нэгийг сонгохоос өөр арга тэр үед байгаагүй. Гэтэл тэр хоёр замын аль алин нь үнэмлэхүй зөв гэдгээ тэр үед нотлон харуулж чадаагүй. Ангийн тэмцлээр хөгжлийн хэмжих нэг хэмжүүр болгож байснаас олон орон дотроо иргэний дайн хийж, их гүрнүүдийн өрсөлдөөний талонд болсон байв. Тийм учраас аль алиныг нь сэргүүлэн гурав дахь замын онолыг гаргаж ирсэн хэрэг. Үнэндээ түүхэн уламжлал, үндэсний онцлогоо хадгалан байгалийн баялаг, гажуу гүнзгий мэдэж ашиглая гэвэл хоёр системийн өрсөлдөөнөөс хоншонох ёстой. Ингэж хөндийрч чадсан жишээг Иран харуулсан 80-аад онд "лалын шашны тэсрэлт" (Иранд америкийн тал баримтлсан шахыг түлхэн унагаж, Афганистанд Зөвлөлтийн цэргийн эсрэг лалын дайн дэгдээж, Ойрхи Дорнод лалын терроризм, экстремизм хүчтэй болсон) дэлхий дахиныг доргиов. Тэр үеийн байдлаар лалын дэглэмтэй орнуудыг хэд хэдэн хэсэг болгон ангилж үзэж байв. Үүнд:

1. Уламжлалт лалын шашинтай бөгөөд лалын ертөнцөд хошуучлагчийн байр суурийн өрсөлдөж буй орнууд (Саудын Арав, Иран гэх мэт);
2. Лалын шашныг аажмаар төрийн хэмжээнд өргөмжилж, лалчлагдаж буй орнууд (Пакистан, Судан);
3. Хүн ам нь лалын шашин сүсэгтэн өсөвч төрийн албан ёсны шашин болгоогүй орнууд (Түрк, Индонез, Малайз, Тунис);
4. Парламентын ардчилалтай, өмнө шашинтай боловч шашин-үндэстний мөргөлдөөний хүртэц талар болсон Ливан;
5. Лалын шашин төрийн албан ёсны шашин мөн боловч шашны гол төлөөлөгчид сөрөг хүчин бөгөөд засаг төртэйгээ тэрсэлдэх болсон Египет, Умард Йемен;
6. Лалын шашныг гадаад болногчдоо (империализмын эсрэг, жанжлал, их гүрнүүдийн хөндлөнгийн оролцооны эсрэг) ашиглах сонирхолтой Пери, Афганистан, Алжир, Сири.

Энэ ангилал бодиг байдлыг яг нийцнэ гэж би батлахгүй. Нөгөө талаар энэ хэдэн орон бусдыгаа төлөөлж байгаа гэдгийг анхаарах ёстой. 80-аад оны сүүл гэхэд лалын шашныг хуульчилсан

орны тоо нэмэгдэж, дэлхийн хэмжээнд лалын хүчин зүйлийн үүрэг эрс өсчээ. Тийм учраас Ази, Африкийн лалын орнуудад интеграцийн үйл явц идэвхжив. Олон улсын харилцааны хоёр туйлт систем задарснаар лалын ертөнц бие даасан туйл болохыг эрмэлзсэн юм. "Олон улсын эдийн засагт дэг журам тогтоох" тухай, тийм дэг журамд үндэслэсэн санхүү-эдийн засгийн байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх тухай илт ярих болов. Урьд нь 1976 онд Меккад лалын эдийн засгийн асуудлаар олон улсын анхдугаар бага хурал болж, 1981 онд Лалын санхүү-эдийн засгийн олон улсын институт байгуулжээ. Үүнээс салбарлан Лалын хөгжлийн банк, Лалын санхүүгийн компани, Лалын худалдаа-аж үйлдвэрийн танхим болон бусад институт үүссэн бөгөөд нефтийн хямралуудын уршгаар тэдгээрийн хөрөнгө багасч, үйл ажиллагаа хумигдаад байв. Тийм учраас идэвхжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарчээ. Нөгөө талаас нефтийн хямралын уршгаар санхүүгийн бэрхшээлд учирсан орнуудад лалын банк зохих туслалцаа үзүүлснийг үгүйсгэх аргагүй. Лалын банк, компаниуд шашны нэрээр нөлөө бүхий шашны зүтгэлтэн, сүм хийд, бусад байгууллагаас хандив авахын сацуу "лалын гэсэн онцлогоо ашиглан хөрөнгө оруулалт, зах зээлийн элдэв хөнгөлөлт үздэг. Энэ мэтээр зарим орны эдийн засаг нэлээд бэрхжиж авчээ. Жишээ нь Египетэд лалын шашны хэт даврагчдыг хичнээн хориглолоо ч тэдний цаана 10 тэрбум долларын ашигтай ажилладаг лалын 3 том банк, 50 орчим компани (нийт сая хувьцаа эзэмшигчтэй) ажиллаж байна. Тэд бол Египетийн хар захын гол гол мөнгө хүүлэгч, санхүүгийн эзэд, Тийм учраас засгийн газрын тэмцэл тууштай үр дүнд хүрэхгүй байгаа нь зүйн хэрэг. Ийм байдал өнөөдөр Алжирт тулгараад байна. Тэгэхдээ энд хоёрхон орныг жишээ болгосныг ойлгох хэрэгтэй. Энэ бол арабын ертөнцийг аалзны тор мэт сүлжсэн бүхэл бүтэн санхүү-эдийн засгийн сүлжээний тухай ярьж буй хэрэг. Тэд арабын орнууд дахь зах зээлийг хянахын сацуу дээрэм тонуул, дамын наймаа панзанд хүртэл ихээхэн нөлөө бүхий хүч юм. Ер нь лалын компаниуд оролцоогүй эдийн засгийн тийм салбар тун цөөн бололтой. Хамгийн аюултай нь хар тамхины арилжаанд нэлээд гүнзгий оролцолджээ. Энэ бол олон улсын зүгээс зүй ёсоор буруушаагдах зүйл.

ШУГ-ийн дэвшил үйлдвэрлэлд хамгийн хурдан нэвтэрч, улс орнууд нийгмисрээ харилцан хамааралтай болсон өнөө үед эдийн засгийн санхүүгийн шашны байр сууринаас шийдэх нь хэр оновчтой вэ? гэсэн асуулт зүй ёсоор гарна. Үүнийг хөгжиж буй зарим орон ч анхааруулж байна. Үйлдвэрлэл нь эрчимжиж, нөгөө талаас хүн ам нь хэт өсч байгаа орнууд, эсвэл олон үндэстэн ястан, шашны олон урсгал бүхий орнуудад лалын эдийн засгийн философи тохирохгүй гэж Энэтхэг үздэг.

Хэрвээ ийм шүүмжлэлт байр сууринаас эргэж харвал, лалын эдийн засгийн номлол үйлчлэх газар, үйлчлэхгүй газар гэж тусад нь авч үзэж болно. Жишээ нь өр ширэнд баригдсан, эдийн засгийн байнгын бэрхшээлтэй байдаг Африкийн хэсэг ядуу орон (Габон, Жибути, Камерун, Нигер, Сомали, Чад гэх мэт) лалын шашин нэгт баян ах дүүсээсээ (Саудын Арав, Кувейт, Ливи, Иран, Арабын Нэгдсэн Эмират) эдийн засаг-санхүүгийн тусламж хүртэ-хийг гол болгож энэ сургаалийг үг дуугүй зөвшөөрч байна. Гэтэл Зүүн өмнөд Азийн лалын шашинт зарим улс үүтгийг тинцдаахгүй ч хүлээн аваагүй. Шашны нөлөөг нэг хэвэнд нь байлгах, шашнаар төвийг сахиулах бодлого баримталж, харин эдийн засагтаа Зүүн Азийн орнуудын туршлагыг гол болгож байна.

Лалын эдийн засгийн номлол нь чөлөөт шударга өрсөлдөөн, хувийн өмчийг үгүйсгэдгээрээ төвлөрсөн эдийн засгийг зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл лалын эдийн засгийн социализм төлөвлөгөөт эдийн засгийн олон элемент шүүмжлэлтэй байдаг. Хүмүүсийн хувийн санаачилга, идэвхийг мөхөөж, хөдөөд жижиг танигчдын аж ахуйг гол болгох гэх мэтээр дотроо зөрчилтэй зүйл бий. Гэхдээ л лалын эдийн засгийн радикал талыг баримтлагчид лалын шашныг социализмтой холбохыг оролдож байсан үе бий. "Лалын шашин манай шүтээн, ардчилсан төлөгдлийн бодлого, социализм бол манай эдийн засаг" гэсэн уриа тухайн үедээ Араб дахины дунд тархсан байв. Түүний сонгодог жишээ нь Өмнөд Йемен, Сомали байлаа. Гэвч энэ сургааль биелээгүйгээр үл барам сүйрэн унасан юм.

Энэ мэтээр зөрчилтэй зүйл энэ сургаалд бишгүй бий. Ер нь эдийн засгийн онолын хувьд авч үзвэл энэ нь үл гүйцэлдэх, зарим талаар харгисдуу сургааль юм. Бас гүйцэд төлөвшлийг олж чадаагүй байна. Байгалийн нөөц баялгаар (нефит, байгалийн хий) хомсхон оронд шашны мухар сүсгээр нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах боломжгүй нь олон орны жишээн дээр харагдсан. Эсвэл хүн ам нь боломжоосоо хэтэртэл өссөн, олон үндэстний буюу олон шашинтай оронд энэ сургааль үйлчлэх үндэсгүй. Тийм учраас гадагш тархсан хүрээ нь явцуу, үр өгөөж, нотолгоо муутай, ТУХН-ийн Дундад Азийн зарим орны байдлыг ажихад лалын эдийн засгийн философийн үнэт зүйлсээс хуулбарласан гэмээр юм тааралддаг. Гэвч энэ нь хэрэгжиж байна гэсэн үг биш.

ЗУРГАА. ТУСЛАМЖ

Тусламжийн тухай асуудлыг авч үзэхдээ, эхлээд тусламж гэж чухам юуг хэлэх, ямар орон тусламж хүртэх боломжтой, олон улсын хэмжээнд түүнийг ямар механизмаар зохицуулдгийг тодорхойлох ёстой. Монгол Улс өнгөрсөн 70 гаруй жилд Зөвлөлтийн тусламжийг хангалттай хүртсэн, 60-аад оноос ЭЗХТЗ-ийн шугамаар

Европын тэр үеийн социалист орнуудаас мөн тусламж авч байсан. Бас Вьетнам, Лаос, Афганистанд хэрдээ тохирсон тусламж үзүүлсэн байх. Харин олон улсын шугамаар дэлхийн жишгээр жинхэнэ тусламж авсан нь 90 ээд оноос эхэлнэ. Тийм учраас бид тусламж гэдгийг олон улсын жишгээр (тэгэх тусмаа хөгжиж буй буурай оронд олгодог) ойлгодог болоод тэгтлээ удаагүй байна. Манай социалист эдийн засгийн сургаальд тусламжийг ангийн тэмцэл, хоёр системийн харилцаатай холбон тайлбарладаг байсныг эргэж саная. Бид тусламжийг "чин сэтгэлийн", "сэтгэл харамгүй", "ах дүүгийн", "найрамдлын" гэх мэт зориуд хүч оруулдаг байснаас бус түүний улс төрийн цаад утга, тусламжаар дамжуулан тэр улсаас явуулсан бодлогыг дүгнэж цэгнэж байсангүй. Тусламжийн эцсийн үр дүнг урьдчилан харах чадвар дутсан Жишээ нь ЗХУ болон ЗХИЗ-ийн хавсарга шинжтэй, өөрийгөө тэтгэх чадалгүй тусламжийн үйлдвэр-аж ахуйн газрууд олныг бариулсан хэрнээ түүнийг бид жинхэнэ тусламж гэж ойлгож байлаа. Тэгэхлээр тэр тусламж гэдэг чинь юу юм бэ?

Тусламжийн тухай ерөнхий ойлголт.

Тусламж гэж танинаас үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй чулуудсан бүх юмыг хандяггүй ойлгоног. Орнедийн эдийн засгийн сургаальд тусламж, хөгжил хоёрыг ангид авч үздэггүй. Тусламж гэдгийг Хөгжлийн тусламжийн хороо гэдэг олон улсын институтээс тодорхойлдог. Энэ бол хоёр талын болон олон талын хандивлагч 21 орноос бүрдэх, тусламжийн бодлого хэлэлцэж зохицуулах байгууллага юм (Парисын клуб гэж товчлон нэрлэдэг). Эдгээр 21 орон нь Европын холбоо, Олон улсын санхүүгийн институттэй (ОУВС), Дэлхийн банк) хамтран тусламжийн асуудал шийднэ. Энэ клуб албан ёсны хөгжлийн тусламж гэдгийг тогтоож өгнө. Энэ нь

1. Хоёр талын болон олон талын шугамаар өгөх албан бус тусламж;
2. Хөгжлийг дэмжих зорилгоор үзүүлэх тусламж;
3. Тодорхой нөхцлөөр олгох тусламж (25, түүнээс хувийг буцалтгүй хэлбэрээр)

Энд тодорхой нөхцөл гэдэг нь туслагч байгууллагаас тухайн оронд болзол болгон тавьсан, нэг ёсондоо дараа нь гарцаагүй хөрөнжүүлнэ гэсэн амлалт юм.

Тусламжийн түүхээс.

Колони эзэмшиж байсан зарим орны (жишээ нь Их Британи) бунны үйлсээс хөгжиж буй улсуудад үзүүлэх тусламжийн уламжлал дэлгэрчээ. Харин өнөөгийн хэлбэр дүрсээ олсон тусламжийн хөтөнбөрүүд хоёрдугаар дайны дараахи бэрхшээлт үеэс эхлэн хөгжсөн байна. Дайны дараа олон улсын эдийн засгийн шинэ дэргэжурэм тогтоох тус хэлбэрт гэж тусламжийг ойлгож байв. Тэр үед,

- НҮБ, түүний бүтэц, систем бий болж, шинэ тулгар хөгжиж буй орнуудыг түүний бүрэн эрхт гишүүн болгох лобби үүссэнээр;
 - Бреттон-Вудсын институт үүсч төлөвшсөнөөр;
 - Европт Маршаллын төлөвлөгөө хэрэгжсэнээр;
 - Олон улсын засгийн газрын бус буяны, халамжийн байгууллагууд хөгжсөнөөр
- тусламжийг олон улсын хэмжээний асуудал болгосон юм.

50-иад онд олон улсын хандивлагчдын хүрээнд АНУ дэлхийн нийт зээл тусламжийн гуравны хоёрыг дааж гол хандивлагч болж байв. Гэхдээ энэ их тусламжийн ихэнх нь улс төрийн зорилготой, өөрөөр хэлбэл аюулгүй байдлын үүднээс үзүүлсэн тусламж байв. 50-иад оны хоёрдугаар хагасаас тусламж үзүүлэгч томхон өрсөлдөгч нь ЗСБНХУ болов. Гэвч тус орон АНУ-ынхаас улам чанга болзолтой улс төрийн тодорхой зорилго агуулсан тусламж үзүүлэх болжээ. Ийнхүү тусламжийн улс төрийн ач холбогдол хэт өссөнийг зөөлрүүлэх үүднээс 60-аад онд АНУ тусламжийн хүнд ачааг хамтран үүрэлцэхийг дэлхий дахинд хандан уриалжээ. OECD байгуулагдаж, Парисын клуб ажиллах болсноор тусламжийг улс төржүүлэх хандлага өрнөдөл бэлдсэн. Англи, Франц хоёр колони орнууддаа зориулсан өнхүүжилтийг тусламж гэж өөрчлөн нэрлэж, хэлбэр агуулгыг нь баяжуулснаар хоёр талт хамтын ажиллагааны хэлбэрээр тусламж үзүүлэх явшил түгээмэл боллоо.

70-аад оноос тусламжийн хэлбэр өөрчлөгдлөө. Нефтийн хямрал хоёр талын тусламжийг сорьсон шалгуур болжээ. Ингээд ОУВС, Дэлхийн банкны үүрэг роль нэмэгдэв. 80-аад онд энэ хоёр байгууллага хөгжлийн бодлогод тэргүүлэх үүрэг хүлээж, хандивлагч орнуудтай зэрэгцэх томхон хандивлагч байгууллага болжээ. Ганцхан жишээ дурдахад өнгөрсөн 30 орчим жилд Дэлхийн банк нь хөгжил дэвшлийн зориулалтаар томхон 57 тосол хэрэгжүүлж, түүндээ нэг тэрбум доллар зарцуулжээ.

Тусламжийн хэлбэрүүд.

Тусламжийг дотор нь: 1. Төслийн; 2. Техникийн, 3. Төлбөрийн чадварыг дэмжих гэсэн хэлбэрт хуваана. Томхон хөрөнгө оруулалт, эсвэл яг төслийн хүрээнд бараа тоног төхөөрөмж импортлоход хөрөнгийн тусламж хэлбэрээр өгдөгийг төслийн гэж үздэг. Техникийн гэдэгт сургалт, эсвэл гадаад мэргэжилтэн ажиллуулахыг, төлбөрийн чадварыг дэмжих тусламж гэдэгт хүнс тэжээл, зарим импортод нэмэрлэх валют, цаашлаад өр төлбөрөөс хөнгөлөх, өр цуцлах, өр тавьсан төлбөрийг өмнөөс нь барагдуулахыг хэлнэ.

Тусламжийн хэлбэрийг зориулалтаар нь ийнхүү ангилахын хамт төсөл, бодлого, хангамж гэж 3 ангилал хийж болдог. Төсөл гэдэг нь тодорхой төсөлд хэрэглэх тусламж, бодлого гэдэг нь тодорхой зорилго агуулсан бөгөөд тусламж үзүүлсний цаана ач

холбогдлыг нь илүү тооцсоныг, хангамж гэдэг нь ердөө л үйлчилгээ, өргөн хэрэглээний бараанд зарцуулах хөрөнгө байх жишээтэй

Яглон, АНУ хоёр бол дэлхийн хамгийн гол хандивлагчид. Гэвч тэдний тусламжид зарцуулдаг хөрөнгө мөнгөний хэмжээг ял үнэнээр мэдвэл гайхал төрж мэднэ. Тусламжид зарцуулдаг тэр хэсгийг нь дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулбал маш доогуур хувь эзэлдэг. Хөгжлийн тусламжийн хорооны гишүүн орнуудын (Парисын клуб) баримталдаг 0.7 хувиас ч доогуур гэсэн үг. Энэ нь тэдгээр орны орлого, валютын нөөцтэй холбоотой юм. Баян орнууд тусламжид харьцангуй бага мөнгө зарцуулдаг ч хоёр талын хамтын ажиллагааны хэлбэрээр олгож буй тусламжийн 90-ээс дээш хувийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгож байна. Гэхдээ тусламжийн хуваарилалтад эргэж харах юм бий. Тусламжийн эцсийн зорилго бол ядуурлыг бууруулах явдал. Тийм учраас түүнийг ядуу буурай орнууд руу чиглүүлэх ёстой. Гэтэл нийт тусламжийн дөрөвний нэг нь л дэлхийн ядуу орнуудад очиж байна. Энэ нь ч бас учир шалтгаантай. Тусламжийн үнэ цэнэ гэж байх ёстой. Тусламжийг зөвхөн хоол хүнс, өдөр тутмын зориулалтаар ашиглавал яаж ч тусламж үр дүн гарахгүй. Тиймээс хандивлагчид ямарч өгөөмөр сонголт гаргаад байх боломжгүй. Бас тэдэнд санхүү арилжааны буюу улс төрийн зорилго байх ёстой. Хандивлагч зарим орон төсвийн бодлогодоо хязгаарлалт тогтоож байгаагаас гадна ядуу буурай улсыг гэхээсээ стратегийн ач холбогдолтой түншээ илүүд үзэх болов. Хэрэв тийм зорилгыг гол болговол хөгжлийн тусламж нөгөө тийшээгээ хэлбийнэ. Энэ мэтээр хөгжлийн тусламж тэгтлээ хэлбэр дүрсээ зөв олчихоогүй байна.

Тусламжийг эргэж тооцох, түүнд анализ хийх механизм.

Хөгжингүй орнууд болон ОУВС, Дэлхийн банк зэрэг байгууллага тусламж үзүүлэхдээ туслах гэж байгаа тэр орныхоо талаар маш нарийвчилсан судалгаа хийдэг. Ихэнх хандивлагч ОУВС, Дэлхийн банкнаас хийсэн судалгааг хардаг. Мөн эдгээр байгууллагаас урьд нь хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилт бол хойшилт туслах нэг нөхцөл. Хэрэв төсөл үр дүнд хүрээгүй хэрэгжилт мүү гарсан бол тусламж өгөх эсэхээ эргэж харна. Яагаад гэвэл хандивлагчдын хувьд маш олон түнш тусламж хүлээж байгаа. Тийм учиртай тусламж гэдэг бол хүртэж буй орны хувьд маш том хариуцлага (цалингийн баталгаа) юм.

Хөгжингүй орнууд хөгжиж буй түншүүддээ тусламж үзүүлсэн тэр цагаас хэвлэл өгсөн тусламждаа эдийн засгийн анализ (дүн шинжилгээ) хийдэг механизмыг хэвшүүлсэн юм. Энэ бол маш нарийн үнэлгээний механизмдаг хяналтын хэлбэр гэхэд бараг болно. Алт болох үргүй, зардал гарахгүй байх, тусламжийн нэр хүндийн

хадгалах, эцэст нь байгаль орчны бохирдол, шамшигдал, махингад хийлгэхгүй байхыг урьдчилан тооцно гэсэн үг. Хандивлагч аливаа орон тухайн нэг оронд тусламжийн журмаар ямар нэг төсөл хэрэгжүүлбэ гэж бодъё. Тэгэхийн тулд эхлээд яг тийм төсөл тухайн тэр оронд шаардлагатай эсэхийг тооцно, дараа нь төсөл хэрэгжүүлсний дараа хэр амжилт олох, ямар үр дүнд хүрэхийг урьдчилан тодорхойлно. Тухайн орны засгийн газрын бодлогын алдаа мадагаас хэр алдагдал гарах, хэрэв тэр орон зах зээлийн харилцааг төгөлдөржүүлж чадаагүй бол түүнээс үүдэн гарах зардлын зөрүү байж таарна, түүнийг юугаар нөхөх зэргийг тооцсон байх жишээтэй. Энэ бүхэн нь тухайн төсөл хялбар хэрэгжихгүй, бас нэлээд их зардал шаардана гэсэн үг. Энэ бүхний тооцоог хийхгүйгээр ямар ч орон төсөл хэрэгжүүлдэггүй. Энд бичиж буй зүйл бол *тусламжийн микро эдийн засгийн анализ* гэгчид хамаарах зүйл. Дэлхийн банкны тооцоолсноор тусламжийн микро эдийн засгийн үнэлгээ ерөнхийдөө нааштай үзүүлэлттэй. Дэлхийн банкны шугамаар хэрэгжүүлсэн төслийн 80 хувь нь хангалттай хэрэгжиж байгаа гэж үздэг.

Тусламжийг макро түвшинд шинжлэн дүгнэх нь үүнээс арай өөр. Үр дүн талыг нь энд тоолон авч үзнэ. Бас заавал нэг төсөл гэхгүй, нийт тусламжийг авч үзнэ. Ялангуяа тухайн орны төр засгаас бүтцийн өөрчлөлт хийж байгаа байдал, тусламжийг дэмжих бодлого, хууль тогтоомж, төрийн зохицуулалт бүгд энд орно. Тусламж хүртсэнээр тухайн орны засгийн газар татвар болон зээлээ багасгадаг. Бас хөрөнгийн орлогийг тусламж эрчимжүүлнэ. Валютын ханшийг тогтвортой байлгаж, өсгөх, цаашлаад экспортын нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг тусламж олгоно. Тийм учраас макро түвшинд төрийн үүрэг маш их. Ялангуяа банк санхүү, экспорт импорт, хэрэглээ хангалтад төр засгаас явуулах бодлого тусламжийн үр дүнд шууд нөлөөлнө. Төрөөс бүтцийн өөрчлөлт хэр хийж байгааг энд их гомчиндог байх жишээтэй. Ер нь 80-аад оноос тусламжийн дотор өсөлтийн төлөөд наадамгайлж байна. Тусламжийн нэг хэлбэр - хөрөнгө оруулалтыг төр хэрхэн шийдэж байгааг их хардаг. *"Тусламж - хөрөнгө оруулалт - өсөлт"* гэсэн 3 талт харьцааг тэнцүүхэн хангах нь төрийн засгийн газрын гол үүрэг гэж үздэг. Хар Африкийн ихэнх оронд энэ харьцааг алдагдуулж тусламжийн үнэ цэнийг уламжарсан. Азийн хувьд энэ харьцаа алдагдаагүйгээр үл барам илүүрэн ирилгах, улмаар улс орноо аж үйлдвэржүүлэхэд мучал нөлөө үзүүлсэн юм. Азид өнөөг хүртэл хөрөнгө оруулалтын 3 том урсгал явагдсан гэж үздэг. Эхнийхэд нь Азийн шинээр аж үйлдвэржсэн орнууд хамрагд- жээ. Төрийн зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн сонгодог жишээг Өмнөд Солонгос тэр үед харуулсан. Хоёр дахь урсгал АСЕАН-ны гишүүн орнуудад явагджээ. Түрив дахь нь одоо ид явагдаж байна. Энэ нь Хятад болон Энэтхэг, Вьетнам, Өмнөд Азийг хамарч байна. Энд гол хөрөнгө оруулагч нь Япон юм.

Энд бичсэнээс үзвэл тусламжийн нөхцөл болзол маш хатуу мэт байж болно. Үүнээс ч өөр байх аргагүй. Тэгэхээр 90-ээд онд өмнө бидний бэлэнчлэн авч байсан Зөвлөлт болон ЭЗХТЗ-ийн тусламж энд бичсэн тусламжийн хооронд их зааг байгаа нь тодорхой байна. Бас тусламж гэдгийг ганцхан эдийн засгийн хүрээгээр хязгаарлаж болохгүй. Эсвэл техникийн гэхээр зөвхөн зах зээлийн эдийн засагчдыг бэлтгэх гэдгээр явцууруулж болохгүй юм. Тусламж бол олон чиглэлтэй. Хөгжлийг дэмжих зориулалттай ялгаа эдийн засгийн салбарт огт хамаагүй, жишээ нь сонгуулийн өмнөх улс төр - иргэний боловсролыг дэмжихэд чиглэсэн байж болно. Эсвэл ардчилал, хүний эрхийн асуудлаар семинар зохиох явдлыг төслийн тусламжийн хүрээнд оруулсан байж болно. Сургалтын төсөлд хандивлагч орнууд ихээхэн анхаардаг. Түр хугацаагаар багш илгээх, лекц семинар хийх, ганцаарчилсан зөвлөлгөө өгөх, хууль боловсруулахад оролцох гэх мэт олон хэлбэрээр байж болно. Энэ бүхэн нь тусламж мөн.

ДОЛОО. ДҮГНЭЛТИЙН ОРОНД

1. Хоёр туйлт ертөнцийн үе шувтарснаар улс төр-үзэл сургалтын өрсөлдөөнд зарцуулж байсан асар их хөрөнгө мөнгө хэмнэх боломжтой болов. Хүний хүчин зүйл болон материал техникийн нөөц хэмнэгдэх тухай ярьж байна. Үүнийг дагалдан олон улсын харилцааны улс төрийн асуудал хоёрдугаар байр руу аажмаар шилжиж, олон улсын харилцаанд эдийн засгийн хүчин зүйл өсч байна. Дэлхийн хэмжээний болон бүс нутгийн байгууллага институтын хувьд энэ чиглэлээр нөөц боломжоо илрүүлэн ашиглах үе тулгарав. Ялангуяа хөгжлийн зорилгоор дэлхий нийтээрээ түншлэхийг түүхийн жам хууль шаардаж байна. "Турав дахь ертөнцийн" хувьд хоёр системийн өрсөлдөөн сөргөлдөөнд гарын толгоом болж байсан нь түүх болжээ. Одоо ядуурлыг тууштай арилгах, өр ширнээс салах, хүн ардынхаа аж амьдралыг доршлуулэх боломж бүрдлээ. 90-ээд оны эхэнд яг ийм итгэл үнэмшил хүчтэй түгсэн юм. Гэтэл өнгөрсөн хэдэн жил энэхүү итгэл үнэмшилийг нотолж чадсангүй. Ялангуяа Африкийн эдийн засгийн байдал сайн тусжих хэмжээнд байна. Энэ бол НҮБ болон олон улсын түнш байгууллагын гол хөндүүрцэг нь юм. 50-иад оны сүүлч, 60-иад оны эхэнд африкчууд ямар хэмжээнд аж төрж байсан, түүнээс хэцүү доривсан гэж НҮБ тооцоолжээ. Үлэмж хоцрогдсон 47 улсын 30% нь өөртөө оршдог. Орлогын доод түвшинд байгаа ихэнх өрсөлдөгч Африктай. Ирэх зүүн гартал африкийн ядуурал өсөх төлөвтэй байгаа. Африкын явцаа хэмжээ ба үйлдвэрлэлийн хэмжээ одоо Африк дунд оршиж эхэлж үлэмж өр шир давж гарах дүр зураг тэдний ирээдүйг төдөрхөжүүлж байна. Гэтэл учиралд дэлхийн хамтын нийгэмлэг 90-ээд онд Африкт төлөвлөж ариунтэй жил шүүж байна.

2. "Хүйтэн дайны" төгсгөл хөгжлийн асуудалд цоо шинээр (урьдын хэвшмэл ойлголтоос татгалзах) хандахыг зүй ёсоор шаардав. Дэлхий дахиныг хамарсан ардчилал шинэчлэлийн үйл явц эдийн засгийн хөгжлөөс ангид явагдаж байгаа юм биш. Улс төрийн үйл явц, эдийн засгийн хөгжил хоёр улам бүр салшгүй холбоотой болж байна. Энэ хоёр зэрэгцэн явах ёстой. Улс төрийн тогтвортой байдал эдийн засгийн үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэх гол нөхцөл. Энэ бол хөгжиж байгаа гэлтгүй ТУХН, Дорнод Европын болон нийт посткоммунист орнуудад адилхан хамаарах ёстой. Эдийн засгийн байдал хурцдах юмуу дордвол улс төрийн хурц маргаан хямралыг дагуулна. Хоёр туйлт ертөнцийн үе НҮБ-д энэ асуудлаар шийдмэг ажиллах боломж олгоогүй. Одоо бол нийгэм-эдийн засгийн хөгжилд НҮБ шиг чухал байгууллага алга. НҮБ-ын үзэж байгаагаар хөгжлийн асуудлыг цогцолборор авч үзэх ёстой. Тэр нь

- Энх тайван, ардчилал, хүний эрхийн салбарын зорилтыг хөгжлийн хэрэгцээ гэж үзэх;
- Хөгжил болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах асуудлыг хослуулах;
- Хөгжлийн эдийн засаг-нийгмийн чиглэлийг хослуулах;
- Худалдаа, санхүү, хөрөнгө оруулалт, технологийн хоорондын уялдаа холбоог харгалзах явдал.

Урьд нь хөгжлийн талаар хоёр янзын хандлага давамгайлдаг байсан. Хөгжлийг зөвхөн цэвэр эдийн засаг - мөнгөний талаас нь авч үзэх, эсвэл түүнийг хэт улс төржүүлж, нийгмийн байгуулал, үзэл сурталтай холбож авч үздэг байсан. Одоо цогцолбороор авч үзэх хандлага давамгайлж байна.

3. Ядуурал бол бүх муу муухай юмны эх үүсвэр гэдэг нь тодорхой харагдлаа. Ядуурсан шалтгаанаа зөв тайлбарлаж байгаагүйгээс түүнийг засч залруулах дээр алдаж олдсон ташуун туршлага бэлхнээ бий. Харин ядуурлаас үүдэн гарах цогцолбор туршиг, алс хэтийг урьдчилан харах таамаг дүгнэлтэй байсан. Ядуурал бол ардчиллыг хөгжүүлэхэд хамгийн шалдамжгүй хөрс болж байна. Африкт олон ургальч үеийн хөвсгөлтөх шилардлагатай юу гэвэл мэдэхээс хөрөг шаардлагатай. Энэ өнгөрөх шаардлага хэрэгжих нөхцөл нь тааруухан. Үгээр үгээр, шилсгөлөн хүн ардыг ардчиллаар цагтай хөгжмөж ашиг. Ядуурлыг арилгахгүйгээр өв тэгш хөгжлийн тухай ярих үндэслэлгүй. Африкт ядуурлыг арилгахын тулд НҮБ болон өөрөө үндсэн нийгэмийн хамтлаг нийгэмлэг ажиллах ёстой. Ядуурал бол ардчиллын эсрэг үйл, ядуурал бол хөгжлийг боймлоод зөвсөхгүй байгаль орчныг сүйтгэх, улмаар төр улсыг хямраах, тусгаар тогтнол үндэслэлийг аюулгүй байдлыг бусниулах хор хөнөөлтэй гэдгийг өнгөрсөн хэдэн жил үнэмшилтэй харуулав.

4. Хөгжиж буй орнуудын эдийн засгийн гачаал бол манай зууны төгсгөл үеийн дэлхийн хэмжээний нэг гол асуудал юм. Уг

асуудал дэлхийн цаашдын хөгжил дэвшилд шууд нөлөөлнө. Тийм учраас улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарал өсөхийн хэрээр хөгжиж буй орнуудын эдийн засгийн бэрхшээл дэлхийн хөгжлийг араас нь чангааж чөдөрлөж байна. Хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлийг хамгаалъя гэвэл хөгжиж буй орнуудын бэрхшээлээс хөнгөлөх ёстой. Тийм нийтлэг үнэт зүйлийн талаар тэдгэсэн хэмжүүр хэвшүүлье гэвэл эхлээд ядуурал, өлсгөлөн гуйланчлалыг арилгах хэрэгтэй. Энэ бол олон улсын харилцааны системийг цаашид зөв төлөвшүүлэх угтвар нөхцөл юм.

Холбогдох ном, хэвлэл

1. Ч.Лхагважав. Вилли Брандт: Умард-Өмнөдийн бодлого, В.Брандтын мэндэлсний 80 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. УБ., 1993
2. СССР в мировом сообществе: От старого мышления к новому, М. "Прогресс", 1990
3. И.А.Орнатский. Экономическая дипломатия, (Глава II,III), М. "Международные отношения", 1985
4. А.Кондаков. Грядет ли очередной "нефтяной шок"? "Международная жизнь" Январь, 1991
5. Н.В.Степанова. Ирак: 1968-1988 гг (Учебное пособие) МГИМО, М., 1992
6. В.Наумкин. "Исламский фактор" в развивающемся мире, "Международный ежегодник: Политика и экономика, 1989" М., 1989
7. А.Ионова. Иллюзии "Исламской экономики", "Азия и Африка сегодня" № 12, 1987
8. John Sloman. Economics (23. Economic Problems of the Third World), The University Press, Cambridge., 1991
9. John T.Rourke. International Politics on the World Stage (16. National Economics: The South), DPG., 1993
10. David Howard Davis. Energy Politics. St. Martin 's Press, New York., 1993
11. Howard White. Aid and Development, Institute of Social Studies, The Hague., 1994
12. Jack C.Plano, Roy Olton. The International Relations Dictionary, ABC CLIO., 1988
13. Teaching Programme "Contemporary Issues in Development Studies", Institute of Social Studies, The Hague., June 1994

ГУРАВДУГААР ХЭСЭГ

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

7

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА БА
ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

8

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА

9

БҮС НУТГИЙН АСУУДАЛ

ДОЛДУГААР БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА БА ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Олон улсын харилцаанд голлох байр эзлэх энэ асуудал олон арван жил бидний (хуучин социалист орнууд) анхаарлын гадна явж ирсэн гэхэд хилсдэхгүй. Бид энэ асуудлыг олон улсын харилцааны гадна авч үзэхийг оролддог байсны сацуу ерөөс бидэнд огт падгүй мэт ойлгож, энэ талаар бидэнд нялзаасан аливаа зэмлэлийг няцаасаар 90-ээд онтой золгосон. Гэтэл дэлхийн хамтын нийгэмлэг анх байгуулагдахдаа "Эдийн засаг, нийгэм, соёл ба энэрэнгүй ёсны шинжтэй олон улсын асуудлыг шийдвэрлэх болон арьсны өнгө, эрэгтэй эмэгтэй, хэл, шашин шүтлэгээр үл ялгаварлан хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг сайшаан хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагаа хэрэгжүүлэх явдал" гэж нэг үндсэн зорилгоо тодорхойлсон билээ. НҮБ-д элссэн бүх орон, түүний дотор хуучин социалист орнууд дүрмийн бүх заалтыг хүлээн зөвшөөрснөө батлан илэрхийлж энэ байгууллагад нэгдсэн. НҮБ дээрхи зорилгоо хэрэгжүүлэх үүднээс 1948 онд Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганаараа Хүний эрхийн түгээмэл тунхаглал баталжээ. Хүний эрх, үндсэн эрх чөлөө гэж юу болох тухай нэгдмэл тодорхойлолт өгсөн энэхүү баримт бичиг нь НҮБ-ын гишүүн бүх орны хүний эрхийн салбарт баримтлах үндсэн удирдамж юм. Уг баримт бичигт үндэслэн хүний эрхийн олон улсын хууль зүйн дараагийн тулгуур актуудыг боловсруулсан бөгөөд Монгол Улс 1961 онд НҮБ-д элссэнээс хойш хүний эрхийн асуудлаархи 20 гаруй чухал баримт бичигт нэгдэн орсныг дашрамд дурдъя.

90-ээд онд социалист ертөнцийг доргиосон тайван хувьсгал хүний эрхийн асуудлаар идэвхтэй бодит бодлого баримтлахыг биднээс зүй ёсоор шаардсан. Ялангуяа хүний эрхийн асуудлаархи нэгдэн орсон баримт бичгийн заалтыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, олон улсын тавцанд хүний эрхийн асуудлаар идэвхтэй бодлого явуулах, нэгдэн орсон актуудыг улс орондоо өргөн сурталчлах зэвүүдэл зүй ёсоор тавигдсан юм. Ардчилал гүнзгийрэхийн хэрээр хүний эрхийн асуудал улам боловсронгуй болох ёстой. Гэвч хуучин коммунист дэглэмийн үлдээсэн өв, дэлхий дахинаас тасархай түгжирхий нэгж ирсэн байдал зэргээс үүдэн ардчилал, хүний эрхийн асуудлыг нийгмийн замбраагүй байдал, эрүүгийн хэрэгтэй холбож хуульчлал манай оронд бишгүй тохиолдож байна. Энэ зохилгүй туульчлал эрхбиш засч залруулах, хүний улс төрийн болон сэтгэл зүүний бүтээх эрхийг баталгаатай болгох үүднээс 1993 онд Монголд Хүний эрхийн төв байгуулсан нь үр дүнгээ өгч эхэлж байна.

Грүгөө НҮБ-ын Хүний эрхийн баримт бичгүүдийг үг үсэггүй дагалд мөрдөж, шашин бишүүднээ гэдэг бол харьцангуй ойлголт.

Улс орон бүр өөрийн онцлог, дотоод үйл хэрэгтээ тохируулан эдгээрийг дагаж мөрдөх тухай ярьж буй болохоос нийтэд нь хавтгайруулж авч үзэх аргагүй. Жишээ нь эрүүгийн гэмт хэрэг хэрээс хэтэрсэн, эсвэл нийгэм нь эмх замбараагүй байдал, эх захгүй дайн дажин, аллага хядлагад нэрвэгдсэн газар хүний эрхийг хэлбэрэлтгүй сахиж мөрдөнө гэмэл хэзээ ч биелэхгүй. Гэхдээ ардчилсан эрхээ эдлэх, сөрөг хүний хувьд нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэсэн зүй ёсны үйл ажиллагааг гэмт хэрэгтэй холбож тайлбарлах, ардчиллыг сохроор үзэн ядах, хуучнаа санагалзах, шинэлэг бүх үзэгдлийг үгүйсгэх явдал Монгол гэлтгүй ТУХН-ийн орнуудад түгээмэл ажиглагдаж байгааг анхаарах ёстой. Ийм хандлага данамлал нь олон улсын харилцаа, хүний эрхийн асуудал хоёрыг хооронд нь эрс зааглах, хүний эрхийг зөвхөн дотоод хэрэг мэт ойлгож, улмаар хууль дүрэм, шударга ёс завхруулах нөхцөл бүрдүүлэх аюултай. Үүнийг Чечень, Боснийн хэрэг явдал харуулсан. Энэ бүхнээс урьдчилан сэрэмжлэх, цаашид ийм явдал гаруулахгүй байх баганаа бий болгох нь өнөөдөр олон улсын харилцааны нэг хөндүүр асуудал болж байна. Ямар зорилгоор ийм оршил бишиж буй тухай уншигчдад тодорхой болсон байх [УХН], тасал коммунизмын тухай өмнөх бүлгүүдэд хүний эрх өөрөөн баримт оршил бүрдсэн гэлцээ.

"Хүйтэн дайн" тогтоол би хүний эрх.

50-иад жилийн тэртээ "Хүйтэн дайн" эхэлж байхад хүний эрхийн асуудлаар тул барьж хожим нь бие биенээ зэмлэх тухайд хэн ч төсөөлжгүй байх. Сонгож авсан нийгмийн хоёр өөр байгуулал, тэдгээрийн үнэт зүйлсийг хэрхэн хамгаалах, өрнө-дийнхний хувьд улам бүр эрчээ авч байсан коммунизмын аюулыг хэрхэн хазаарлан барих тухай л бодож байлаа. Аажимдаа НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдаж бусад дагалдах актууд гарсны дараа хүний эрхийн асуудал дорно-өрнийн харилцааны нэг маргаантай сэдэв болсон юм. Социалист орнуудад хүний эрхийг хэрхэн сахин биелүүлэх, тухайлбал, өөрөөр сэтгэгчид, сөрөг үзэл бодлыг зөвшөөрөх ба эс зөвшөөрөх асуудал хоёр системийн үзэл суртлын тэмцлийн торгон үзүүр байлаа. Тухайн цагтаа бүс нутгийн мөргөлдөөнөөс илүү энэ асуудалд анхаарч, хоёр талын болон олон талын харилцааны сайжрал, хурцдал үүгээр тодорхойлогддог байсан үе бий. "Хүйтэн дайн" дуусах дөхөж, Зөвлөлтийн эвслийн орнуудад тоталитари дэглэм ганхаж эхэлмэгц хүний эрхийн асуудлыг тойрон маргах нь багасаж, харин зөвсөглөл, аюулгүй байдлын асуудал хоёр системийн харилцааны хэлэлцэх зүйл болж үлджээ. Ялангуяа Зөвлөлтөд өөрчлөн байгуулалт гүнзгийрэх тусам М.С.Горбачев хүний эрхийн асуудлаар ухаалаг буулт хийж, урьдах удирдагчдын үед гаргасан алдааг засч залруулж энэ хэрээрээ дэлхий дахинд алдаршиж байв. Хүний эрх хосор- дүүлсэн, хууль ёс гажуудуулсан,

олон улсын хууль зүй зөрчсөн түүхэн алдааг засах талаар багагүй зүйл санаачлан хийсэн билээ. Ингээд 1989 он гэхэд хүний эрхийн асуудлаар өрнө-дорнын хооронд зарчмын гэхээр ялгааг арилгаж чадсан юм. Энэ бол түүхэн том ололт байлаа. "Хүйтэн дайны" цайз бэхлэлт-Берлиний хана нурсны дараа дэлхий дахин хөгжлийнхөө шинэ эрин үетэй золгов.

Энэ шинэ үеийг 1990 оны Парисын Хартид "Ардчилал, энх тайван, эв нэгдлийн шинэ эрин" гэж тодорхойлсон бөгөөд уг баримт бичгийн эхний дэд бүлэг "Хүний эрх, ардчилал, хууль ёсыг дээдлэх нь" гэсэн агуулгатай юм. Хельсинкийн Төгсгөлийн баримт бичгийн заалтууд, тухайлбал улс орнуудын хоорондын харилцаанд удирдлага болгох 10 зарчим хэтдээ замыг заагч "Алтан гадас" болно гэж тэр үед тунхаглажээ.

Парисын Хартийн үндсэн хоёр бүлэг хоёул хүний эрхийн асуудлаар эхэлсэн байдаг. Эдийн засгийн эрх чөлөө, гишүүн орнуудын хоорондын найрсаг харилцаа, аюулгүй байдал, эв нэгдэл, энх тайван, хүрээлэн байгаа орчин зэрэг амин чухал асуудлууд ямагт хүний эрхийн дараа тавигдсныг үзвэл уг асуудлын ач холбогдол аяндаа тодорхой болох биз ээ. Тэгээд ч үүнийг онцлон авч үзсэний учир бол Хельсинкт хэлэлцэн тохирсноо түүнд оролцогч зарим орон хөсөрдүүлж байсанд оршино. Тухайлбал, ЗХУ болон Дорнод Европын зарим оронд (80-аад онд Польшид бүр хүрцээр ирсэн) хүний эрх зөрчиж, улс төрийн болон оюуны саглааны оргалал, дарангуйлал тогтоосон баримт зөндөө бий. Ингээд "Хүйтэн дайн" шувтарч бүх юм сайн сайхнаар эргэх шинэ үеийн босгон дээр Парисын Хартийг санал нэгтэй батлан гаргасан юм. Харамсалтай нь 1990 оноос хойш ЗХУ, Дорнод Европын зарим оронд гарсан улс төр-геополитикийн өөрчлөлтүүд энэ баримт бичгийн үг үсэг, үзэл санааг санаатай буюу санамсаргүй зөрчих нөхцөл болсон. Энэ талаар давхардуулан өгүүлэх шаардлагагүй.

Хүний эрх ба орчин үе

Хэдийгээр Парисын Хартид оролцогч зарим орон, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын шинэ гишүүн орнуудад хүний эрх зөрчсөн тохиолдол хангалттай байгаа ч хүний эрхийн асуудал маань өөрөө Өрнө-Дорнын харилцаанаас арилаад байгааг анхаарах ёстой. Өнгөрсөн үед үзэл суртлын тэмцэл энэ харилцааг тодорхойлж байсандаа ч бус, ерөөсөө хүний эрхийг үзэх үзэл, баримтлах хэмжүүр нь ойртсондоо тэгсэн хэрэг. Ингээд хүний эрхийн асуудал яажмаар Умард-Өмнөдийн харилцааны асуудал болчихоол байна. 90-ээд онд олон улсын харилцааг түгшээсэн хямрал бүрхсэнд "Гурав дахь ертөнцөөс" үүдсэний нэг нь хүний эрхийн бодлого, системтэйгээр зөрчсөн явдал юм. Тэгэхээр эхлээд улс төрийн хүний "Гурав дахь ертөнц" гэж ямар хүрээг энд хамруулж авч үзэх талаар нэгдсэн ойлголттой байх ёстой. Африк,

Ази, Ойрхи Дорнод, Латин Америкийн 120 гаруй улсыг энд авч үздэг нийтлэг үнэлгээ байдаг. (Үүнийг түрүүчийн бүлэгт харна уу. Зох) Үүний сацуу хуучин Зөвлөлт, Югославаас салж гарсан зарим орныг энэ бүлэгт оруулсан нь ч бий. Мрьд нь энэ бүлэгт багтдаг байсан боловч одоо шинээр аж үйлдвэржээд, олон үзүүдэлтээр хөгжингүй орнуудад дөхөж очсон хэсэг орон Турив дахь ертөнцөөс хэдийнэ салжээ. Ийм бодит үндэслэлийг харгалзан хүний эрхийн асуудлыг авч үзэх ёстой. Үүний сацуу хүний эрхийн асуудлыг улс төрийн ардчиллаас салгаж үзэж болохгүй. Энэ бол нэг юмны хоёр тал буюу бие биеэ нөхвөрлөж байх учиртай цогц зүйл.

Улс төрийн ардчилал төгс боловсроогүй газар хүний эрх хамгаалах хангах тухай яриа хий агаарт цацагдахаас өөрцгүй. Хүний эрхийг баталгаажуулъя гэвэл улс төрийн ардчилал хэрэгжүүлэхээс өөр аргагүй. Улс төрийн ардчилсан тогтолцоо бүрдүүлж, түүнийг хуульчилж тавиж энэ зорилгыг хангана. Дэлхийн улс орнуудыг эрх чөлөөт бид эрх чөлөөт бус гэж ангилсан ангилал байдаг. Энд тусгаар тогтнолын тухай ярьж буй хэрэг биш л дээ. Улс төрийн ардчилал бүх татвар тогтоож чадсан гэдэг улгаар нь ярьж байна. Ийм ангилал бүхий газрын зураг АНУ болон өрнөдийн орнуудад хамгийн ихэд байдаг гэж харсан зураг авч үзвэл, эрх чөлөөт орнуудыг цайвруулах ямар эрх чөлөөт орныг цайвруулах, угасаа эрх чөлөөт бус, өргөн барилдүүлж засаглалтай орнуудыг хараар дүрсэлсэн бид хам Ази, Манит, Өмнөд Солонгос, Япон, Израиль дөрөв цагаанаар дүр нэгдэжээ. Өрнө, Дорнод Европ цагаанаар, Балканы хойгийн зарим хэсэг, харин ТУХН цайвруулах, Африкт ихэнх нь хараар дүрсэлжрэн бид хамгийн ихэд Тэгэхээр би үүнийг ил үнэмлэхүй зөв гэж үзэжгүй, бус л бодолдох ёстой гашуун үгэн гэж хэлэх гээд байна. Ийм ангилал хүний эрх зөрчиж буй, хүний эрх баталгаатай буй орнуудыг өрнөдийн дүр зураг тодорхой болгох.

Умард Өмнөдийн харилцаанд үндэл маргааны сэдэл болж ирсэн эдийн засгийн хөгжилтэй орнуудад тооцогддог тэдгээг хүнд тавигдахгүй болж, түүнийг өрнө хүний эрхийн асуудал гэж үзэж үү гэлтэй. Олон улсын хүний эрх хамгаалалт Латин Америк арай зөөлөрч, харин Хар Африк, Иүндэл, Персээр, Хятад энэ маргааны талбар болжээ. ИУБ-ын хүний эрхийн комисс 1982 он гараад гол анхаарлаа Персийн булантай Хятад руу шилүүдэл. Иракчууд Кувейтыг эзлэн түрэмгийлжтэй парад Ирак болон энэ комиссын хэсрөнд бөөн маргаан дэлдэж өгөм. Иракчууд Кувейтэд хүний эрх ноцтой зөрчсөн баримт хэргийн гай бий. Хүний эрхийн асуудлаар зөвхөн энэ комисс бус ИУБ-ын Эдийн засаг, нийгмийн Зөвлөл, Ерөнхий Ассамблейн хүрнэл хэлэлцэх үе бишгүй тулгарчээ. Хүний эрхийн комиссын гишүүдийг тоог нэмэгдүүлж, хөгжиж буй орнуудаас илүү татан оруулжтай ярих. Мөн хүний эрхийн асуудлаар бус нутгийн чанартай гэнээр бүлгүүд байгуулж ажиллуулж зарим үе дүнд хүрчээ. Персийн булангийн дайнаас хойш хүний эрхийн асуудлаар

ТУХН, Балканы хэргийг анхаарал татах болж, НҮБ-ын комиссын үйл ажиллагаа олон тийшээ салбарлаж, шинэ шинэ бэрхшээлтэй тулгарсан зэрэг нь ч салбар бүлэг бий болгохыг зүй ёсоор шаардсан юм. Латин Америкийн орнууд НҮБ-ын хүч чармайлтыг дэмжих үүднээс Латин Америк, Сальвадорын талаар Хүний эрхийн бүсийн бүлэг байгуулсан. Бид хүний эрх ноцтой зөрчиж буй орнуудад шахалт үзүүлэх зорилгоор хориг арга хэмжээ авч (жишээ нь Францын талаар 77-гийн бүлэг Мьянмаг үг хөдөлгөөнд оролцуулахаа өгч осон) эхэлжээ.

Энэ мэт нааштай эхлэл буй ч хүний эрхийн асуудал дэлхий дахиныг түгшээх хэмжээнд байсаар байна. Ялангуяа үндэстний болон шашны цөөнхийн эрхийг хөсөрдүүлсэн хэрэг явдал намжихгүй байна. Энэ бүхнийг гэтлэн давах, хүний эрх зөрчихгүй байх олон улсын баталгаа бий болгох, хүний эрхийн талаар цаашид явуулах үйл ажиллагаа, хүний эрхийн асуудлыг хөгжил хамтын ажиллагаатай хослуулах зэрэг асуудал хэлэлцэхээр 1993 оны зургадугаар сард Вена хотод Хүний эрхийн талаар дэлхий дахины бага хурал зарлан хуралдуулсан юм. Ийм хурал хийхийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей шийдэж түүнд бүх талын удирдамж чиглэл өгч, дэмжлэг үзүүлжээ. Бага хурлаас Венийн тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөр баталсан бөгөөд ийм бага хурал хийх болсон шалтгаан зорилго, хүний эрхийн асуудлаар дэлхийн улс орнуудын хүлээх хариуцлага, энэ чиглэлд НҮБ-ын системийг оролцуулан хамтран ажиллах, үйл ажиллагаагаа зохицуулах, түүнд Хүний эрхийн төвийн гүйцэтгэх үүрэг, Хүний эрхийн асуудлаар байнгын ажиллагаатай механизм (Дээд Комиссарын газар гэх мэт) бий болгох, арьсны үзэл ба арьсны өнгөөр, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцэх, эмэгтэйчүүд хүүхдийн эрхийг хамгаалах зэрэг өнөөгийн сэтгэл түгшээж буй олон асуудлыг түүндээ тусгажээ. Энэ бол ач холбогдол, цаг үеэ олсон байдлаараа Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг харилцан нөхөхүйц чухал баримт бичиг гэж үзэхээр байгаа юм.

Хүний эрх зөрчиж байгаа нь

Хүний эрх зөрчиж буй бүс нутгуудийг ерөнхийд нь тав хувааж болно юм. Хамгийн ноцтой нь Африк, цар хүрээгээрээ дараа нь Латин Америк болон Карибын сав газар. Ойрхи Дорнод, эцэст нь коммунист орнууд гэсэн 5 газар хүний эрхийн зөрчил төмдөрлө байна. Олон жил ужиграсан, ноцтой уршиг дагавар дагуулсан, шийдэхэд бэрх байдлаар нь ингэж жагсааж болох авч ТУХН, ЮНЕСКО гэх зэрэг хүний эрхийн асуудлыг шинэхэн юм гээд хялбарчилжээ. Хэвлэл өйлгөж болохгүй. Яг өнөөдөр Африкийн цагтай сэтгэл түгшүүржгүй ч маргааш хаашаа эргэх нь тодорхойгүй, хүний эрхийн төвийн хангах баталгаа алдагдаж байгаа зэрэг нь гэнэж харилцан харгалзгүй байхыг зүй ёсоор шаардаж байна.

Африк бол өмнөх хоёр системийн нийгэм-улс төрийн байгууллын туршилт хийсэн гол газар. Түүний цаана олон жилийн иргэний дайн, улс төрийн аллага сүүдэр мэт дагалдаж байлаа. "Хүйтэн дайн" дуусч Африкт улс төрийн зорилгоор дэгдээсэн дайн мөргөлдөөнүүд шинэлэн зогсчээ. Гэвч түүний орыг өөр төрлийн мөргөлдөөн шийтгэн олон жилийн иргэний дайн нь улс төрийн тогтворгүй байдал, шийн засгийн хоцрогдол, омог-аймгийн зөрчлийн гүн занал үншлэжээ. Африкийн зарим орон, тухайлбал иргэний дайнд нэрвэлдэхгүй, анхнаасаа зөв зам сонгосон буюу сонгосон замдаа эргэж дагуу нэг нь олон намын тогтолцоо, улс төрийн эрх хөдөө, ирэнцлэлг аажмаар төлөвшүүлж байна. Гэтэл тоталитаризм, авторитаризм нэглэмд байсан Этиоп, Сомалид хүний эрхийг байнга сааралтай зөрчиж, Судан, Камерун, Конго, Гана, Чад, Малавид өнөө хүртэл улс төрийн одий төдий хоригдол тарчилсаар байна.

Засгийн эрхийн төлөө зогсолт булгуудийн мөргөлдөөнд энгийн хүн ам ихэнэ мөргөлдөөнд Африкт түгээмэл болжээ. Чад, Судан, Либер, Сомалид үүнийг хангалттай цогцлов Африк дахь иргэний дайны хамгийн том элбэг болж байсан Ангол, Мозамбикт энхийн үйлчилдэх нэгээр тус тусийн тусгаар бүтцийн гурвины нэгийг эзэлсэн өмнөх хэргийг үндэстэнүүд шийтгэж, төлөөрхөй хөгжих боломж төлөвлөх Намбиэ түлгээр тогтнож, ОАБНУ-д шударга сонгууль (цэвэр эрхт цогцхийн 350 жилийн ноёрхлыг эцэс болгосон хүнд хүндрэл юм) явуулснаар энд бас гүнзгий өөрчлөлт гарав. Энэ 4 том хүчин зүйл энэ хавийн уур амьсгалыг бүхэлд нь эрүүлжүүлж Гэтэл эндээс холгүй Руандад хүний эрх хөсөрдүүлсэн эмгэнэл хэргийг явдал 1994 онд гарсан. Омог-аймгийн мөргөлдөөн, аймаглалт устгах бодлогын харгайгаар 300 гаруй мянган хүний амь хөхироосон аймшигт хэрэг ганцхан сарын дотор үйлджээ. Дэлхийн хамтын нийгэмлэгийн шургуу хүч чармайлт, Африкийн удирдагчдын хамтын ажиллагаа, ялангуяа бүс нутгийн асуудлаа өөрсдийн хүчээр шийдэх гэсэн чармайлтын дүнд Руанда, Либерид мөргөлдөөнийг зогсоож чадлаа. Африктай хэзээний уламжлалт харилцаатай Франц энэ талаар бусдад үлгэр болохуйц үүрэг гүйцэтгэж хүний эрхийг хангуулах талаар албадлага ч хийж үзлээ. Гэвч тус орон Африкт өрнөдийн маягийн ардчилал тогтоох тухай урьдын гэнэн төсөөллөө залруулж байна. Одоогоор Заир, Конго, Бурунди, Сомалиас бусад газар хүний эрх ноцтой санаатай зөрчсөн тохиолдол багасч, харьцангуй тогтвортой байдлыг хангажээ. Хүний эрх болон ард түмний эрхийн талаар Африкийн Харти баталж, Хүний эрхийн Африкийн комисс байгуусан зэрэг нааштай эхлэлүүд байгааг батжуулан дэлгэрүүлэх явдал африкчуудын хувьд чухал байна.

Ази тивд хүний эрхийн асуудлыг авч үзэхэд анхаарах зүйл бий. Өрнөдийн тал Хятадыг энд ихээхэн зэмлэдэг. Хэрэв ардчиллын хөмжүүрээр авч үзвэл Тяньаньмэнийн талбайн хэрэг

явдал яах аргагүй хүний эрхийг хөсөрдүүлсэн гашуун сургамж мөн. Хятад, Умард Солонгос, Вьетнамд улс төрийн эрх чөлөөг хязгаарлаж, улс төрийн үй олон хоригдол байлгасаар байгаа жишээ зөндөө бий. Энэ бол улс төрийн шалтгаанаас үүдсэн асуудал. Гэтэл Энэтхэг, Шри-Ланкад шашин-үндэс угсаа, салан тусгаарлах явдал хүний эрх зөрчих гол нөхцөл болж ирсэн. Хиндус ба лалын шашинтны хооронд Энэтхэгт үргэлжилж буй мөргөлдөөнд алагдсан хүний тоо тоймоо алдлаа. Шри-ланка нь тамил-сингал омгийнхны хоорондын дайнд ихээхэн хохирол амссан. Хятадын Түвд, Мьянма, Бангладешт хүний эрх зөрчсөөр байна. Индонезийн засгийн газар Дорнод Тиморт бараг 20 жил хүний эрх зөрчсөн байлдаан хийж байна. Индонезид зарим улс төрийн хэрэгтэнг 24 жил хорьж цагдсаны эцэст цаазалсан баримт илрэв. Мьянма, Филиппин, Афганистан, Камбожид аюулаас хамгаалах болон армийн хүчний хооронд дайсагналцаар ирэв. Үүнээс гадна Мьянмад үндэстний цөөнхийн эсрэг олон арван жил сунжирсан дайн хийж байна. Афганистаны мужахедууд болон камбожид улаан кхмерүүд ард түмнийхээ эсрэг аллага хядлага үйлдсээр байна. Ийм алаг цоог байдал Азид хүний эрхийн асуудлаар засгийн газар хоорондын байгууллага ажиллуулах нөхцөл бүрдүүлэхгүй байна. Хүний эрхийн асуудлаархи засгийн газрын бус бүлэг, бие даасан байгууллагуудын нөлөө сул, Азид коммунизм хүчтэй хэвээр үлдсэн, улс төрийн туйлшрал хэт их зэрэг нь энэ тивд хүний эрхийг баталгаатай болгох, энэ талаар өрнөдийн орнуудын оролцоог нэмэгдүүлэх бололцоо өгөхгүй байгаа юм.

Латин Америкт хүний эрхийн асуудал нэг үеэ бодвол нааштайгаар эргэжээ. Колумб, Перу, Сальвадор, Гватемалд хүний эрх зөрчиж байсан тухайд ярьж байна л даа. Гэвч Куба, Никарагуад үүнээс дээрдсэн юм байгаагүй. Эндхийн орнуудыг Африк, Азийнхаас ялгах хэрэгтэй. Ялангуяа Өмнөд Америкт хүний эрхийг сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх гэсэн хоёр өмнөө ойлголт зарим тохиолдолд хутгалдах явдал бишгүй тохиолддог. Эрүүгийн хэргийн үзүүлэлтээр дэлхийн ямар ч орныг урдаа гишгүүлдэггүй улс энд хэд хэд бий. Хар тамхины панз, хэт давсарсан зүүний партизануудын олон жилийн урагшгүй тэмцэл засгийн газраа хүний эрх зөрчихөөс өөр аргагүй байдалд түлхэн оруулсан тохиолдол олныг дурдаж болно. Чили, Никарагуа, Сальвадор хүний эрхийг хамгаалах талаар нааштай зүйл хийж байна. Хүний эрхийн Америк дундын комисс, Хүний эрхийн Америк дундын шүүх зэрэг үүрэгээ гүйцэтгэж буй олон улсын институтыг энд жишээлэн дурдаж болно. АНУ, Канад зэрэг соёлжсон, ардчилсан орнуудын нөлөө ихээхэн үүрэгтэй. Гэвч 90-ээд он гараад өчүүхэн Гаитид хүний эрх зөрчсөн томхон маргаан дэгдэж, нэг хэсэгтээ дэлхий дахины анхирлын төвд байсан баримт бий. Энэ бол Латин Америкт хүний эрхийн асуудлаар найдвартай баталгаа болох хөрс суурь тавьж чадсан үйлдэл гэрч болсон юм.

Ойрхи Дорнод бол хүний эрхийн асуудлаархи нэг "халуун цэг" мөн. Гянданд улс төрийн хэргээр хоригдож буй хүний тоогоор Ойрхи Дорнод, далайн орнууд дэлхийд толгой цохих биз ээ. Энд улс төрийн хэрэгтэн ба шашин-үндэстний цөөнхийн ялтны хооронд зарчмын алгаа байдаггүй юм. Цаазаар шийтгэгдсэн хүний тоогоор ч эндхийн улсуудыг (жишээ нь Иран) түгшрэх улс ховор. Бас гянданд улс төрийн хэрэгтэнд тулгаж буй ил шийтгэл, эрүү шүүлт, түүний төрөл зүйл анги, эрүүгийн хэрэгтэнд үзүүлдэг хэтэрхий харгис цээрлэлээр нь эднийг гайхан шагнахаас өөр аргагүй. Зарим оронд, жишээ нь Египетэд зарчмын тэнцэр улс төрийн хэд хэдэн хүчний эсрэг (улс төрийн зүүний хүчин, Үндэстний фундаменталистууд) зэрэг тэмцэх хэрэг гарч байна. Сири, Алжирын шоронгууд ялтнаа багтааж ядан, Иран, Иракт шүүмжлэлээр цаазалсаар байна. Үндэстний хувьд олон арван жил эрхэлдэг ч чадахгүй аллага хядлагын золиос болж буй курдуудын энэ зурвас бестой. Алжир, Иордон, Кувейтэд хүний эрхийн талаар яриа цааштай гомоор зүйл ажиглагдсан бол Иран, Ирак, Пакистан ноогоо түүн тал гомоор байна. Олон улсын Эмнэсти интернашнл байгууллагын хамгийн их анхаарал тавьсаар ирсэн бус нутаг бол Ойрхи Дорнод, Араб-Израилгийн олон жилийн мөргөлдөөн, энэгоо талаар улс бүр эрчээ авч буй далайн фундаментализм, чөлөөтэй шүүмжлэлтэй энэ хүний эрхийг баталгаатай хангах хэрэгдэл бүрдүүлдэггүй байна. Хүний эрх ба далайн шашны харилцааныг асуултыг олон жил үр дүнгүй хэлэлцсээр байна. Араб дахины Хүний эрхийн конвенц батлах гэж бүтэлгүй оролдсоор өдий хүрчээ. Хүний эрх болон ард түмний эрхийн талаар Арабын Харти гэгчийн төсөл 1986 онд нийтлэгдээд өдий хүртэл батлагдахгүй байна. Энэ үгээр Ойрхи болон Дундад Дорнод, Умард Африк бол хүний эрхийн зорчдог ноцтой голомт гэж үзэх бүрэн үндэстэй.

Посткоммунист орнуудад хүний эрхийн ноцтой зорчил хуримтлагджээ. Энэ талаар тус голман эхийн хэрэгт олон баримт дурдан өгүүлсэн байгаа. Тэрхүү энэ дугаар санах хоёр өөр асуудал бий. Сталины үргэлжлэл энэ орнуудад ирээд "Хүйтэн дайны" үед социалист орнууд дахь хүний эрхийн асуудал. Өрнө-Дорнын маргааны үед энэ нь бэлх байсан ч олон улсын харилцаанд тэгтлээ хүндээр тусалгүй байсан юм. Тэн нь социалист орнууд дотоод хэрэгтэн аруунахгүй балаж чадаж байсан. Тэгээд ч өөрөөр сэтгэгчид гэсэн үгээр цоохиж хүрхэг хамарч хүний эрхийн тухай ярих болдог байсан. Тэн онго өөрөөр сэтгэгчдийн тухай яриа алга болж, халин шашин омог-аймгийн болон газар нутгийн дайн мөргөлдөөнд хонмолдож буй үндэстэн ястны тухай, эмэгтэйчүүд хүүхдүүд, энгийн тайван иргэдийн тухай ярих боллоо. Оросын холбооны цэрэг Чеченийг хууль бус зөвсөгт эгтгээдүүдээс цээрлэх байлдааны ажиглагаа явуулахдаа энгийн тайван иргэдийг олноор нь хэлмэгдүүлсэн хэрэг дэгдээв. ТУХН-д олон сая хүн омог-аймаг, шашны хэт даварсан явууллагын өмнө хүчгүйтэж, олон улсын

хамтын нийгэмлэгийн тусламж хүртэж чадахгүйд тулаад байна. Яг ийм дүр зураг Боснид харж болно. Хүний эрхийн үүднээс авч үзвэл ТУХН, Югослав дахь дүрвэгсэд хүний наад захын эрхээ эдэлж чадахгүй болжээ. Тэдэнд нийгмийн баталгаа алга. Мөргөлдөөнд байлдаж буй бүх тал буруутай ч дайн дажнаас дайжин амьд үлдсэн эдний хувьд ямар ч буруу хүлээлгэх аргагүй. Хүний эрх зөрчиж буй тав дахь голомтын тухайд ирээдүйг харзнаж байж дүгнэх ёстой болов уу. Тэгээд ч бүх юм эхлэлийн байдалтай, цаашид яаж ч эргэж мэдэхээр байгаа учраас олон тайлбар бичихээ лэная. Нөгөө талаар өмнөх бүлгүүдэд ямар нэг хэмжээгээр тусгасан.

Хүний эрх ба олон улсын механизм

Парисын Харти хүний эрхийг баталгаатай хангах арга зам зааж өгсөн тухай дээр өгүүлсэн. Энэ бол Европын хил хязгаар дотор хязгаарлагдах баримт бичиг боловч дэлхий нийтэд их нөлөөтэй. Европ тив бүхэлдээ хүний эрхийн асуудлаар үлгэрлэж байгаа гэдэг утгаар, бас НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүний дөрөв нь Парисын Хартид нэгдсэн гэдгээр нь ингэж хэлж байна. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хүрлын хүрээнд хүний эрхийн асуудлаар 3 үе шаттай бага хурал (1989 онд Парист, 1990 онд Копенгагенд, 1991 онд Москвад) хийж, холбогдох механизм бий болгожээ. Гэвч энэ механизм үүргээ бүрэн гүйцэтгэж байгаа эсэх нь ондоо асуудал. Энэ механизмыг ажиллуулахад оролцогч орнуудын хүлээсэн үүрэг, түүний биелэлтийн хооронд зай гарч байгаагаас саад бэрхшээл учраад байна. Энд Оросыг нэрлэе. Нөгөө талаас Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлаас гаргасан баримт бичгүүд улс төрийн шинжтэй болохоос шууд олон улсын хууль зүйн эх сурвалж болж чадахгүй байна. Үүнээс үүдэн хүний эрхийн асуудлаар батлан гаргасан баримт бичгүүдийг нэг талын хүлээсэн үүрэг амлалт мэт үзэж, хэрэгсэхгүй байх явдал гарч байна. Энэ нь явсаар хүний эрхийн асуудлаар Европ дотроо бүсийн шинжтэй хэмжүүр тогтоож хандахад хүргэж мэдэх уршигтай.

НҮБ-ын хүний эрхийн талаар тавьж хүч чармайлтыг үр өгнөжтэй болгох, хүний эрхийн талаархи баримт бичгүүдийг түгээмэлжүүлэх, энэ талаар хамтын ажиллагаа хөгжүүлэхэд НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын гишүүд ихээхэн үүрэгтэйг дахин сануулна. Гэтэл тэд хүний эрхийн асуудлаар хамтран ажиллах нь бүү хэл тэд өмнөө байр суурь баримталцгааж, харилцан шөргөөцөлдөж, харим нь түүнд бараг оролцохгүй байна. Хятад хүний эрхийн асуудлаар олон улсын гол гол баримт бичигт нэгдэн ороогүй бөгөөд АНУ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай гэрээнд нэгдэнгүй байх жишээтэй. Хүний эрхийн асуудлаар ноцтой маргалдлын үр дүнд болж буй БНХАУ-ыг энд дурдалгүй өнгөрч болохгүй. Оффит нь хүний эрхийн зөрчилтэй улс хэмээн

буруушаасан тогтоол НҮБ гаргах болгонд БНХАУ уг тогтоолыг дэмжихгүй байхыг бусад улсад шаргуу ятгадаг уламжлалтай. Ийм тогтоолын төслийг НҮБ-ын Хүний эрхийн комисс 1991 оноос жил болгон хэлэлцүүлж байгаа боловч БНХАУ тухай бүрт нь няцааж, хойшлуулсаар ирсэн билээ. Хятадад хүний эрх зөрчигдөж байгаа тухай тодорхой өгүүлсэн илтгэлийг АНУ-ын Төрийн Департамент 1995 оны хоёрдугаар сард гаргасныг мөн л бодит байдлыг гуйвуулсан хэрэг гээд няцаасан. Улс төрийн төрс үзэлтнүүдийг хавчин хяхах, хүмүүсийг үзэл бодол итгэл үнэмшлийнх нь төлөө яллах, цаазлагдсан ялтнуудын эд эрхтэнийг зөвшөөрөлгүй бусдад шилжүүлэн суулгах, Түвдэд лам нарыг хавчиж, сүсэг бишрэлийг доромжлох явдал гарч буйг үнэн байдлын эсрэг зүйл гэж БНХАУ-ын засгийн газар мэдэгдэж байгаа. НҮБ-ын Хүний эрхийн комиссын тогтоолууд Хятадад хүний эрх ноцтой зөрчихийг таслан зогсооход нөлөөлж чадахгүй ч адалгаад Хятадын гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтад базаахгүй нөлөөлж магадгүй гэж үздэг юм. Хэдийгээр ингэж олон талаас нь шахаад ч Хятадыг хэн ч сөгдүүлж хүчирсэнгүй. 1995 оны байдлаар л БНХАУ хүний эрхийн асуудлаархи дээрхи тогтоолыг тав дахь удаагаа батлуулахгүй байж чаджээ. 1995 оны гуравдугаар сард Жоинчэн үл комисст санал хураалт явуулах үед 193 илүүний 171 нь эсэргүүцэж, 20 нь дэмжиж, 12 нь түгэлтэсэн дүнг гарав.

Ерөөсөө хүний эрх гэж юуг тодорхойлох, хэрхэн ангилалх талаар ч Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн хооронд нэгдмэл ойлголт бүрэлдээгүй юм. Хүний эрхийн талаархи олон улсын баримт бичгүүдэд хүний эрхийг дотор нь иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн ба соёлын гэж ангилдаг. Үүнээс өөр ангилсан нь ч бий. Хүний эрх гэдэг нэр томъёо үүссэн цагаас (XV-III зууны Америкийн эрх чөлөөцийн дайн, Францын их хувьсгалын үеэс) ингэж ангилахыг оролдсоор ирсэн. Эхний үед иргэний болон улс төрийн эрхийг л хүний эрх гэж нийлэгдэг байж. Энэ ойлголт Францын их хувьсгалаас эхлэн дэлхийн хоёрдугаар дайн дуустал түгээмэл явж иржээ. Дайны дараа колониал систем задралд орсноор нийгэм-эдийн засаг, төрийн эрхээр энэ ойлголт баяжив. Хүний эрхийн түгээмэл тунхаглал энэ шинэ ойлголтыг баталгаажуулж өгчээ. Эцэст нь энэ ойлголт гурав дахь удаагаа баяжиж, энх тайван аж төрөх эрх, сонгох хурцах эрх, хөгжиж дэвжих, хүрээлэн байгаа орчноо хамгаалах эрхээр гэлсэн байна. Эдгээр эрх 80-аад онд Африкийн Хэргийн болон бусад хэд хэдэн баримт бичигт тусгалаа олсон бөгөөд засгийн газрын бус байгууллагуудын хэмжээнд цааш өргөжсөөр байгаа аж. Тухайлбал, бие даах эрх, байгалийн баялгаа дүр мэдэн ншиглах эрх гэх мэт. Гэхдээ хүний эрх гэдэг ойлголтыг эдгээр эрхтэй холбох, холбосол хэрхэн авч үзэх, хүний эрхийг ард түмнүүдийн эрхээс салгахгүй байх асуудал янз бүрийн шатанд яригдсаар байна. Ард түмний эрх гэдэг бол

хамтын эрх гэсэн үг. Гэтэл ҮЭ-ийн эрх мөн хамтынх. Энэ мэт авч үзвэл хүний эрх маань хаашаа ч салбарлаж болох мэт.

Түүх сөхвөл хүний эрхийг хамгаалах асуудлыг тусгасан баримт бичиг НҮБ-ын дүрэм батлагдахаас өмнө бишгүй гарч байсан. Дэлхийн нэгдүгээр дайны дараа түүнийг боловсронгуй болгох зорилгоор олон гэрээ, конвенц баталжээ. Гэхдээ НҮБ-ын дүрэм гарснаар хүний эрхийн салбарт улсууд хоорондоо өргөн хамтран ажиллах үндэс тавигдсан юм. Үүгээр энэ салбарын хамтын ажиллагааны *нэгдүгээр үе* эхэлж, 80-ад он хүртэл үргэлжилсэн гэж олон улсын хуульчид үздэг. Энэ үед хүний эрхийн салбарт олон улсын хэмжүүр тогтоох тал дээр их анхаарчээ. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн хүрээнд ямар эрхийг гол болгон авч үзэх, тэдгээрийг хэрхэн түгээмэлжүүлэх нь гол байв. Тэгээд ч энэ үед хүний эрхийн гол гол баримт бичиг (хамгийн сүүлд 1984 онд) батлагдан гарчээ. 80-аад оны дунд үеэс хүний эрх хангуулах үр өгөөжтэй арга зам эрэлхийлэхэд анхаарав. Энд Зөвлөлтөд өрнөсөн өөрчлөн байгуулалт хүний эрхийн талаархи олон зөрчлийг намжааж өгснийг дурдах ёстой. Энэ бол хүний эрхийн талаархи хамтын ажиллагааны *дараагийн үе*. Ингээд дэлхийн хамтын нийгэмэг хүний эрхийн хяналтын олон улсын механизм бий болгоход шилжин орсон юм. Хүний эрхийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх механизмын тухай ярьж буй хэрэг. Одоо бүрдчихээд байгаа тиймэрхүү механизм нь хоёр хэлбэртэй гэх үү, хоёр янзаар үйл ажиллагаагаа явуулдаг юм байна. Энэ нь 1. Нийтийн тохиролцооны (консensusаар) хэлбэр: оролцогч ор-нуудын тохиролцсон үндсэн дээр хэрэгждэг, 2. Нөгөөх нь тохи-ролцооны бус (консensusын бус) хэлбэр: олон улсын байгууллагын тогтоолын үндсэн дээр хэрэгждэг ийм хоёр хэлбэр ажээ. Жишээ нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны хүрээнд консensusын үндсэн дээр механизм бий болгожээ. Гэхдээ тэр механизм улс төрийн шинжтэй гэрээний үндсэн дээр бий болсныг дээр дурдсан. Тэгвэл консensusын бус үндсэн дээр, жишээ нь НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн Зөвлөлийн тогтоолоор үүссэн хүний эрхийн механизм үүргээ гүйцэтгэж байна. Гэхдээ ийм механизм болон олон улсын хүний эрхийн асуудлаархи үйл ажиллагааны хэлбэрийг хооронд нь адилтгаж авч үзэж болохгүй. Хүний эрхийн асуудлаархи хяналтын механизм нь тодорхой зохион байгуулалтын бүтэцтэй байдаг бол нөгөөх нь холбогдох асуудлыг судлах дүрэм журам арга барил л гэсэн үг. Тодорхой нэг хяналтын байгууллагын хүрээнд олон төрлийн хэлбэрийг ашиглаж болно. Бас хяналтын нмэр нэг механизмд үүрэг гүйцэтгэж буй хүн тухайн бич хүн өөрийнөө н төлөөлөхөөс бус өөрийн засгийн газраасаа заавар зөвлөгөө авах, эргээд тайлангаа тавих явдал байдаггүй. Хүний эрхийн асуудлаархи үйл ажиллагааны хэлбэрт юу багтах вэ гэвэл, энэ салбарт хүлээн зөвшөөрч үүргээ хэрхэн биелүүлж буй талаар улс орны илтгэлийг авч үзэх, хүний эрх зөрчсөн шалтгаар улс орнуудын

гомдлыг авч хэлэлцэх, тодорхой бие хүн, эсвэл засгийн газрын бус аль нэг байгууллагаас хүний эрхийг төр улсын зүгээс зөрчсөн тухай гомдлыг авч хэлэлцэх, хүний эрх зөрчсөн нь тогтоогдсон бол нөхцөл байдлыг судлах шалгах явдал байж болох жишээтэй.

Орчин үед хүний эрхийн асуудлаар ажилладаг олон улсын байгууллагуудын бүхэл бүтэн систем бүрджээ. Энэ системийг дотор нь бүх дэлхийн ба бүс нутгийн гэж ангилдаг. Дэлхийн хэмжээнд НҮБ, ЮНЕСКО, Дэлхийн хөдөлмөрийн байгууллага, цаашлаад асуудлаас ангид байж болохгүй гэсэн утгаараа ФАО, Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллага байж болох юм. Бүс нутгийн гэдэгт Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал, Европын Зөвлөл, Африкийн төлшний байгууллага, Америкийн улсуудын байгууллага гэх мэт хүний эрхийг бүс нутагтаа авч үзэж, нөлөөлдөг байгууллагууд орно. НҮБ, түүний Ерөнхий Ассамблей мэдээж хэрэг хүний эрхийн асуудлаар голлох үүрэгтэй. Харин энэ асуудлыг өдөр тутам эрхлэн байгууллага нь Эдийн засаг, нийгмийн Зөвлөл Асуудлыг энд хэлэлцэн товлөмж боловсруулж Гуравдугаар хороонд (нийгэм, хүмүүнлэг, соёлын асуудлаархи) шилжүүлж, тэндээс төлөөллийн төсөл болгон Ерөнхий Ассамблейн ээлжит чуулгаанд оруулдаг. Чуулганаас туслах нэгдүгээр байгууллага (жишээгээр Канад, мөргөжлөө асуудлаархи тусгай хороо, Апартеидын эсрэг тэмцэх тусгай хороо, Палестины ард түмний салшгүй эрхийг харагжүүлэх хороо гэх мэт) байгуулж ажиллуулдаг ажээ. Эдийн засаг, нийгмийн зөвлөл гишүүн орнуудаас (53 улс) бүрдэх Хүний эрхийн комисс байгуулсан. Ингээд тодорхой асуудлыг тодорхой оронд (Афганистан, Иран гэх мэт) судлан илтгэл бэлтгэж зөвлөлийн тогтоолын төсөлд оруулж байна. Сүүлийн үед бөөнөөр нь цаазлах, шашны асуудлаас үүдсэн маргаан энд нэлээн хэлэлцжээ. Энэ комиссын хүрээнд цөөнхи үндэстнийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэх тэднийг хамгаалах салбар комисс байгуулж ажиллуулав. Энэ бол 26 улсын бие даасан мэрэгжилтнээс бүрдсэн байгууллага юм. Эд төлөөлж буй улсынхаа өмнөөс бус гагцхүү бие хүн гэдэг нийтлэгээрээ нэгдэцгээсэн гэж дахин дурдъя.

Хүний эрхийн асуудлыг НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газарт НҮБ-ын ерөнхий нарийн даргын орлогчоор ахлуулсан Хүний эрхийн төв данхар хариуцдаг юм. Энэ төв Ерөнхий Ассамблей, Эдийн засаг, нийгмийн Зөвлөл, Хүний эрхийн Комисст хүний эрхийн асуудлаар туслах үүрэгтэй. Эдгээрээс гадна хууль зүйн хувьд НҮБ-д шүүд харъяалагд- даггүй олон улсын бусад байгууллага хүний эрхийн асуудлаар ажиллаж байна. Жишээлэхэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын гэрээнд заасны дагуу 11 мэрэгжилтнээс бүрдсэн Хүний эрхийн хороо гэж бий. Энэчлэн хүний эрхийн асуудлаар баталсан олон улсын чухал чухал баримт бичгүүдийг хэрэгжүүлэх үүднээс Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг устгах Хороо, Эрүүдэн шүүхийг эсэргүүцэх

Хороо, Хүүхдийн эрхийн Хороо, бусад олон байгууллага ажиллаж байна.

Энэ бүхнийг тоочин бичсэний учир уншигчдад аяндаа ойлгогдох байх. Энэ бүлэгт олон улсын харилцаанд хүний эрхийн асуулган ямар байр эзлэх тухайд өгүүлэхийг оролдлоо. Эхлээд бодит байдлыг тодорхой баримт жишээн дээр өгүүлж, дараа нь олон улсын хяналтын механизмын асуудлыг хөндлөө. Тэгэхдээ хүний эрхийн асуудлын ач холбогдлыг түлхүү гаргах гээд олон улсын хууль зүйн асуудал руу нэлээд хазайчих шиг боллоо. Үүнийг болгооно биз ээ. Манай орны бодит жишээн дээр авч үзвэл, хүний эрхийн асуудлыг дотоод хэрэг мэт үзэх, түүнийг гэмт хэрэгтэй хутгах, хүний эрхээр ардчиллыг орлуулж ойлгох дутагдал ажиглагдаж байдгийг бид мэдэх билээ. Тийм учраас хүний эрхийн асуудлаар нийтийг хамарсан сургалт явуулах, шинэ хуучин, эрх баригч, ардчилсан хүчин гэлтгүй бүгд нэгдсэн ойлголттой байхын чухлыг тэмдэглэх гэсэндээ ингэсэн юм.

Холбогдох ном, хэвлэл

1. Монгол Улсын Үндсэн Хууль. Улаанбаатар., 1992
2. Хүний эрх: Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл, НҮБ, УБ., 1992
3. Заключительный акт совещания по безопасности и сотрудничеству в Европе, Хельсинки, 30 июля-1 августа 1975г Москва., 1985
4. Общеввропейская встреча в верхах, Париж, 19-21 ноября 1990г. М., 1991
5. Международное право, М., "Международные отношения", 1994
6. М.Богуславский. Международное частное право, М., "Международные отношения", 1994
7. Vienna Declaration and Programme of Action (World Conference on Human Rights) Vienna, 14-25, June 1993.
8. Wolfgang S.Heinz. North-South conflict and Human Rights in the Third World, "Contours of A New World", Manila, 1992
9. The Coming Anarchy by Robert D.Kaplan, "The Atlantic Monthly", February, 1994
10. Amnesty International: Report 1994, Amnesty International Publications. 1 Easton Street, London WC1x 8DJ UK

НАЙМДУГААР БҮЛЭГ. НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА

Өрнө-Дорнын сэргэлдөөн арилсаар олон улсын харилцааны хоёр туйлт систем төгсгөл боллоо. Олон улсын харилцаа олон туйлт систем рүүгээ шилжилт хийж байна. Дэлхийн шинэ дэг журам тогтоох эхлэл тавигдлаа. Гэвч энэ бол санааснаар бүтчих ажил биш. Ийм дэг журмыг ихээхэн хүч чармайлт тавьж, санал нэгдэж байж тогтооно. Үүнд НҮБ гол үүрэгтэй. Олон улсын харилцааны системийг үндсээр нь өөрчилж байж тэр зорилгыг биелүүлнэ. 50 орчим жил олон улсын харилцааны хоёр туйлын хооронд улс төрийн зэвсэг болж ирсэн НҮБ одоо л жинхэнэ үүргээ гүйцэтгэх ёстой. 1945 онд Сан-Францискод баталсан НҮБ-ын дүрэмд заасан тэр үүргээ биелүүлэх цаг тулгарлаа гэсэн үг. НҮБ одоо дэлхийн хэмжээний бүх асуудлаар дагнан ажиллах боломжтой боллоо. Тийм учраас олон улсын хамтын нийгэмлэгийг шинэ нөхцөлд тохируулан өөрчлөн шинэчлэх хүнд бэрх, нарийн түвэгтэй үүрэг тулгарлаа. "Хүйтэн дайг" дууссанаар дэлхий дахин шинэ орчинд дасч дадаж байгаагийн нэгэн шил НҮБ л мөн замын бэлчирт шилжилтийн үүрэг үндэс байна. Энэ оронд хэдхэн жил НҮБ-ын хувьд 50 жилийнх нь түүхэн гүнзгий, уламжлалд тохиолдоогүй сорилт шалгалтын үе байгаа. НҮБ урьд нь бүс нутгийн чанартай мөргөлдөөний гол юмгод ажиллаж байсан туршлагатай. Тэдгээр нь ихэвчлэн "Гурав дахь ертөнцийн" бүс нутагт өрнөдөг байсан юм. Гэтэл олон улсын харилцааны нэг туйл болж байсан хуучин Зөвлөлтийн нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэх үүнд бэрх сорилт тулгарлаа. Их гүрнүүдийн сэргэлдөөн арилснаар Балканы хойгт сул орон зай үүсч, түүнийг бөглөхийн төлөө Серби НҮБ-тай шууд тулгаралтад орж байна. Хуучин Югослав дахь үндэстэн хоорондын мөргөлдөөнд олон улсын хамтын нийгэмлэг хүчгүйтэж байгаа нь тодорхой харагдлаа. ТУХН-ийн нутаг дэвсгэрт НҮБ ямар ч үүрэг нөлөөгүй байна. Тийм учраас НҮБ-д эргэлзэх явдал бас ч үндэсгүй биш болох нээ. 1990 оноос хойш НҮБ-ын үйл ажиллагааг дүгнэхдээ эерэг, сөрөг хоёр янзаар авч үзье.

1. Эерэг нь:

- Кувейтыг түрэмгийлсэн Иракийг цээрлүүлэхэд НҮБ үүрэг гүйцэтгэсэн;
- Гаитид ардчилал, шударга ёс тогтоов;
- Ойрхи Дорнодод бат бэх энх тайван тогтоох зам нээлттэй боллоо;
- ӨАБНУ-д апартеидыг халж, олонхийн санал бодолд нийцсэн ардчилсан дэглэм тогтоож чадлаа;
- Умард Ирландад энх амгалан байдал сэргээн тогтоох эхлэл тавигдан
- Эритрей тогтнолоо тунхаглав;

- Камбожид ардчилсан дэглэм тогтоож чадсан;

2. Сөрөг тал

- Босни Герцеговина, Хорватад энх тайвныг дэмжин сахиулах ажиллагаа удаа дараа бүтэлгүйтэж, мухардаад байна;
- Сомалид энх тайвныг дэмжиж сахиулах үүрэг нь дампуурсан;
- Гурунди, Руандад олон зуун мянган хүний амь бусниулсан үндэстэн хоорондын мөргөлдөөн дэгдсэн;
- Заирт эмх замбраагүй байдлыг сэрэмжлэн зайлуулж чадаагүй;
- Тажикистанд ах дүүсээ алж хядсан мөргөлдөөн үргэлжилсээр байна;
- Афганистанд явуулсан олон жилийн хүч чармайлт талаар болж, байлдааны ажиллагаа өргөн хүрээнд сэргэсэн зэргийг дурдан болно.

Энэ бол НҮБ-ын үйл ажиллагаа хэр их бэрхшээл туулж, үр дүнд хүрч байгааг илтгэх баримт. Тэгэхдээ Босни, Сомалид мянга мянган хүний амь аварч, Македонийг хямралаас сэрэмжилж, дайн мөргөлдөөний хөлд нэрвэгдсэн олон газар хүмүүнлэгийн тусламж үзүүлснийг тэмдэглэх ёстой. Энд зөвхөн зөвсэгт мөргөлдөөнийг зохицуулах, сэрэмжлэн зайлуулах асуудал яригдах ёсгүй.

Одоо энх тайван, хөгжил, ардчилал гурав урьд өмнө байгаагүйгээр улам бүр харилцан хамааралтай болов. Энэ бол:

- Энх тайвангүйгээр хөгжил дэвшил, ардчилал байж таарахгүй;
- Хөгжилгүйгээр ардчиллын хөрсийг бий болгож үр суулгаж чадахгүй, хөгжилгүй бол нийгэмд хямрал мөргөлдөөн гарцаагүй;
- Ардчилалгүйгээр хөгжлийг хангахгүй гэсэн зүй тогтол хэрэгжинэ гэсэн үг.

НЭГ. НҮБ-ЫН ЗОРИЛГО ЗАРЧИМ ШИНЭ НӨХЦӨЛД

"Хүйтэн дайн" дууссанаар НҮБ-ын олон улсын, олон талт, цорын ганц төлөө бүхий хүчирхэг байгууллагын тэр үүрэг жинхэнэ утгаартай хэрэгжих зам нээгдсэн. Өөрөөр хэлбэл дэлхий дахинд дэг журмыг хэл сахиулах вэ гэдэг асуудал юм. Энэ нь НҮБ-д бүтцийн өөрчлөлт хийх, түүний агуулга, ажлын хэлбэрийг эргэж харгах, зарчим хэм хэмжээг шинэчлэх явдлыг зайлшгүй шаардана. Аймалдан үстлэл, хүний эрх зөрчиж байгаа тодорхой улсад дэлхийн хамтын нийгэмлэгийн оролцох эрхийг бүрэн эрхт байдал, тэгш эрх, дотоод хэрэгт үл оролцох гэх мэт орчин үеийн олон

улсын харилцааны зарчмуудтай хэрхэн харилцан уялдуулах тухай асуудал шинэ зорилт боллоо. Өөрийн уугуул ард түмнийхээ эсрэг тэр улс нь түрэмгий ажиллагаа үйлдэж, эсвэл хүний эрх хөсөрдөж, хүний амьд явах эрх алдагдаж, дайн мөргөлдөөний явцад энгийн номхон иргэд олноороо хэлмэгдэж байгаа нь зөвхөн тэр орны дотоод хэрэг байх уу гэсэн асуудал юм. Тэгэхээр энд хоёр л асуудал яригдаж байна. Тэр нь:

1. НҮБ олон улсын харилцааны зарчим, хэм хэмжээг зөрчиж аль нэг орны дотоод хэрэгт хөндлөгөөс (магадгүй хүч хэрэглэн) оролцох;
2. Эсвэл тухайн тодорхой нэг орон (жишээ нь Боснийн сербиуд) өөрийн дотоод хэрэг гэж үзсэн хүчирхийллээ олон улсын ямар ч хяналтад байлгахгүй байх;

Энэ бол "Хүйтэн дайнаас" хойш 90-ээд онд олон улсын практикт бий болсон шинэ үзэгдэл, өнөөдөр бол хамгийн эмзэг асуудал болчихоод байна. Энэ бол дэлхийн дайны аюул, тэгэх тусмаа цөмийн дайны аюул арилсан, эсвэл бүлгийн үзэл суртлын тэмцэл, антагонизм алга болсноор бий болсон шинэ үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл коммунист дөрвөд, ордоминаст оргодын хоорондын тэмцэл арилснаар дэлхийн хэмжээний мөргөлдөөний шинж чанарт зарчмын өөрчлөлт гарчад байна. Улс хоорондын бус, улс орны дотоодын мөргөлдөөний эрч нэмэгдэв. Одоо дэлхийд өрнөж буй дотоодын шинжтэй ихэнх мөргөлдөөн нутаг дэвсгэрийн маргаантай асуудал шийдэхэд чиглэгдэж байна.

Үүнээс үүдэн аюулгүй байдлын асуудал ч өөрөөр эргэлээ. Аюулгүй байдлын салбарт учрах аюул заналын өнгө аяс өөрчлөгдлөө гэсэн үг. Урьд нь аюулгүй байдал гэдэг ойлголтыг өрнөдорнын хооронд цэргийн тэнцвэртэй байдал хангаж байхад хэрэглэгдэг байлаа. Тийм учраас зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих явдал энд гол байр эзэлж ирсэн. Олон улсын аюулгүй байдлын энэхүү тэргүүлэх чиглэл 90-ээд оноос өөрчлөгдлөө. Яагаад гэвэл:

1. Аюулгүй байдал маань өөрөө зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавихтай холбогдохоо болив.
2. Аюулгүй байдлын салбарын тэргүүлэх чиглэл, зорилго бол улс орны дотоодын мөргөлдөөнийг сэрэмжлэн зайлуулах, зогсоох явдал болов.
3. ЗСБНХУ задарч, хоёр туйлт харилцаа үйлчлэхээ больсноор зэвсэглэл, цөмийн зэвсэгийн асуудлыг авч үзэх шинэ хэмжүүр шалгуурыг бий болгов.
4. Дэлхий дахин геополитикийн өөрчлөлтийн үе рүү шилжиж байна. Энэ нь хүчний харьцаа, бүс нутаг улс орнуудын жин нөлөө байр сууринд нөлөөлж буй учраас олон улсын аюулгүй байдлын шинэ системийг илт үгүйлж байна.

Энэ бүхнийг шийдэх нэлээд боломжийн түгээмэл хэлбэр бол *хоршсон аюулгүй байдлын (cooperative security)* үзэл баримтлал гэж үздэг. Урьд нь аюулгүй байдлын ямарваа систем нь аль нэг дайн мөргөлдөөний (Сонгодог жишээ нь олон улсын харилцааны Ялтын систем) логик төгсгөл, өөрөөр хэлбэл ялагч нь ялагдсан талдаа тулгаж хүлээлгэдэг дэг журам байсан бол энэхүү шинэ үзэл баримтлал нь нийтлэг зорилго, хэм хэмжээ, зарчим дээрээ тунгуурлан хэлэлцээ хийж тохиролцоонд хүрэхийг чухалчлана. Тэгэхдээ энэ бол практикаар шалгагдчихсан, үнэмлэхүй зөв гэдгээ нотолчихсон зүйл биш. Ажиглаад байхад НҮБ-д шийдвэр гаргах ихээхэн прагматик практик хэвшиж байна. Олон улсын зарим институт (тухайлбал НҮБ, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал, НАТО, Баруун Европын холбоо, Европын холбоо гэх мэт) харилцан зөвшилцсөн үндсэн дээр прагматик либерал бодлого руу шилжиж байна.

НАТО-гийн "Энхийн төлөө түншлэл", Төв болон Дорнод Европын орнуудтай Баруун Европын холбооноос тогтоосон түншлэлийн программ зэргийг энд жишээлэн дурдаж болно. Хамтын аюулгүй байдлын систем тогтоох эдгээр алхам нь дэлхийн хамтын нийгэмлэгээс тэгтлээ их хүч чармайлт үрлэг зарлага шаардахгүй, тэгэхдээ шууд хэрэгжчихнэ гэсэн үг бас биш. Улс түмэн туйлшрах, талцахыг халж хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлээр нэгдэж, *улс үндэстэн бие дааж эзэн мэдэх, ардчилах хоёр эрх салшгүй холбогдсон цагт энэ зорилгыг биелүүлж чадна.*

ХОЁР. "ЭНХ ТАЙВАН ХӨГЖЛИЙН ПРОГРАММ" (Agenda for Peace)

1992 оноос ийм шинэ нэр томъёо олон улсын харилцаанд нэвтрээд байна. Энэ нь НҮБ-ын зургаа дахь ерөнхий нарийн бичгийн дарга Бутрос Бутрос-Галийн дэвшүүлсэн үйл ажиллагааны нэг мөрийн хөтөлбөр. Түүнийг энэ тушаалд сонгогдож байх үе ийм мөрийн хөтөлбөр дэвшүүлэхийг зүй ёсоор шаардсан. "Хүйтэн дайны" үед ажиглаж сурсан аргаар НҮБ 90-ээд онтой золгож, Перес де Куэльярын багч түүхэн хоёр үеийн зааг дээр халаагаа өгсөн юм. Тийм учраас НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга хэн ч бай олон улсын харилцааны шинэ нөхцөлд зохицсон мөрийн хөтөлбөр дэвшүүлэх ёстой. "Хүйтэн дайнаас" хойш олон улсын харилцаанд шигээр илгэрэн маргаантай өдий төдий асуудал шийдлээ хүлээж байсан үед НҮБ-ын хоёр ерөнхий нарийн бичгийн дарга ажлаа хүлээцлэн Анги, үзэл суртлын тэмцлээс гадуур үүссэн мөргөлдөөн, хямралыг талцан давах, зохицуулах хүчтэй механизм НҮБ-д илт үгүйсгэгдэж байна. Нийнгуяа улс орны доторхи мөргөлдөөнийг шийдвэрлэх, түүнчлэн тавих явдал чухал болоод байлаа. Тийм

учраас "Энх тайван хөгжлийн программ" цаг үеэ олсон алхам боллоо. Аливаа мөргөлдөөн хямралаас урьдчилан сэргэмжлэхийн тулд идэвхтэй үр нөлөөтэй бодлого явуулахыг ганц НҮБ ч биш. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал, Африкийн нэгдлийн байгууллага, НАТО-д сонирхож байв. Урьд нь түгээмэл хэрэглэж ирсэн "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа" гэсэн ерөнхий нэр томъёогоор бүх асуудалд хандаж болохгүй боллоо. Мөргөлдөөний шинж чанар, цар хүрээ, хохирлыг ялгаж салгах, заримд нь албадлага хэрэглэх замаар хүчээр энх тайван тогтоох, зарим тохиолдолд аль нэг орны бүрэн эрхийг хязгаарлах хүртэл арга хэмжээ авах тухай ярьж байна.

Будрос-Галийн энэ программ анхнаасаа нийтийн таашаал хүлээгээгүй нь мэдээж. Тийм учраас өнөөг хүртэл төгс боловсронгуй болж чадаагүй байна. НҮБ дахь "Гурав дахь ертөнцийн" орнуудын дотор нөлөө бүхий Бразил, Энэтхэг, Пакистан, Малайз, Мексик нь улс орнуудын бүрэн эрхт байдлын асуудлыг гаргаж тавьсан. Өөрөөр хэлбэл иргэний дайны нөхцөлд албадан энх тайван тогтоох тухай асуудлыг эргэж сайтар нягтлахыг шаардсан. Мексик ийм ажиллагаанд цэрэг оролцуулахгүй гэдгээ шууд мэдэгдсэн. НҮБ ийм ажиллагаанд гол анхаарлаа хандуулбал нийгэм эдийн засгийн салбарын ажил зогсох юм биш биз гэж хөгжиж буй зарим орон анхааруулж байна. Мөн НҮБ Өрнөдийнхний зэвсэг болох юм биш биз гэж их болгоомжилж байна.

Үүнд НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга хариулахдаа: Эдийн засгийн эмх замбараагүй байдал, нийгмийн шударга бус явдал, улс төрийн дарангуйлал гурав нийлж байж мөргөлдөөн үүсгэх нөхцөл бүрддэг ба тийм мөргөлдөөн үүсгэдэг шалтгааныг устгахын тулд "Энх тайван хөгжлийн программ" дэвшүүлсэн гэж тайлбарладаг. Үүний сацуу тусад нь "Хөгжлийн программ" боловсруулахыг тэр үед үүрэг болгосон. Хөгжиж буй орнуудын доторхи иймэрхүү үзэл бодлыг зөөлрүүлэхэд Египет, Индонез хоёр гол үүрэг гүйцэтгэсэн.

Өрнөдийн орнууд ч Будрос-Галийн программыг нэгэн зэрэг дэмжин хүлээн аваагүй. Ихэнх нь энхийг сахиулж ирсэн хуучин аргаараа шинэ нөхцөлд хандахыг хүссэн. Ганцхан Франц л уг санааг дэмжиж 48 цэргийн дотор 1000 хүнтэй цэргийн хүч гаргаж чадахаа илэрхийлэв. НҮБ-ыг олон улсын нэр хүндийн асуудалд өрнөдийн орнууд ихэнхэн болгоомжтой хандаж байна. Хуучин Югославт НҮБ-ын үйл ажиллагааны үр өгөөж харагдахгүй байгаа нь өрнөдийн орнуудын ийм байр суурьтай холбоотой байж болох юм. Урьдчилан сэргийлэх дипломат бодлого, энхийг тохируулах, энхийг сахиулах, энх тайван тогтоох гэсэн 4 янзын ойлголтыг нарийвчлан тодорхойлох явдал шинэ нөхцөлд чухлаар тавигдаж байна.

1. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга *урьдчилан сэргийлэх дипломат бодлогыг (Preventive Diplomacy)* талуудын хоорондын маргаан, мөргөлдөөнийг урьдчилан зохицуулах явдал гэж үзэж байна. Энд маргаан, мөргөлдөөн гэдгийг эрс зааглан авч үздэггүй. Нэгэнт маргаан даамжирвал мөргөлдөөнд хүргэнэ. Тэгэхээр аль алиныг нь урьдчилан намжаах ёстой. Тэгэхийн тулд НҮБ мэдэлдээ байгаа бүх арга хэрэгслийг ашиглана. Мэдээлэл цуглуулах, ажиглалт хийх, зуучлах, хэлэлцээ хийх, олон улсын шүүх арбитрын механизмыг ашиглах, мөргөлдөөнөөс сэргийлж цэрэг оруулах практик бий. Хэрэв эдгээр арга хэмжээ үр дүнд хүрэхгүй бол дараагийн алхам руу шилжинэ.
2. Тэр нь *энх тайван тогтоох (Peace making)* ажиллагаа юм. НҮБ-ын дүрэмд *нэгдүгээрт* хориг арга хэмжээ авах; *хоёрдугаарт* цэргийн хүч хэрэглэх (эсвэл хүч хэрэглэхээр сүрдүүлэх) замаар энх тайван тогтооно гэж хуульчилж өгсөн байгаа. Энд тогтоох гэсэн үг нь албадлага гэсэн санааг илэрхийлж байна. НҮБ-ын дүрэм, олон улсын хуулийг хөсөрдүүлсэн аль нэг улс буюу тухайн улсын эрх барих бүлгийн эсрэг явуулах хоёр өөр арга хэмжээний тухай асуудал юм. Байлдаж буй талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол эдгээр арга хэмжээг зайлшгүй хэрэглэнэ. Цэргийн хүчээр албадаж энх тайван тогтоосон томхон жишээ бол Кувейтыг Иракаас чөлөөлсөн явдал юм. Үүнд дэлхийн улс түмний эв нэгдэл, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орнуудын нэгдсэн хүч чармайлт юу юунаас чухал. Одоогоор НҮБ-аас хориг арга хэмжээ авагдаад байгаа улс хэд хэд бий. Югославын Серб, Черногор (нийлээд ХБНГУ) Македони, Хорват, Босни, Ирак, Ливи, Сомалийг нэрлэж болно. 1994 онд БНАСАУ энэ жагсаалтад нэмэгдэх шахсан. Ирак, Ливи, Югославаас бусдад нь зэвсэг, эсвэл нефть нийлүүлэхийг хориглосон бөгөөд Гаити, Өмнөд Африкийн эсрэг авсан хориг арга хэмжээг цуцалжээ. Бас байлдаж буй талуудын аль нэгний эсрэг (жишээ нь Анголын УНИТА бүлгийнхэнд зэвсэг нефть нийлүүлэхийг хориглосон) хориг арга хэмжээ авсан тохиолдол бий. Цэргийн хүч хэрэглэсэн анхны тохиолдол 1960 онд Конгод гарсан юм. "Цөлийн шуурга" байлдааны ажиллагааг эс тооцвол НҮБ түүхэндээ тийм ширүүн тулалдаанд татагдан орж байгаагүй. Боснид агаарын байлдаан хийхийг хориглож чадсан, сербийн зэвсгийн агуулах, их бууны цэгүүдийг агаараас устгасан, ингэснээрээ НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн цувааг хамгааллаа.
3. *Энхийг сахуулах (Peace Keeping)* ажиллагаа энх тайван тогтоохоос арай өөр. Хямрал мөргөлдөөн эхлэхээс өмнө, эсвэл явцад нь байлдааны ажиллагаанд хүргэхгүй байх зорилгоор олон үндэстний цэргийн болон цагдаагийн хүчнийг илгээдэг. Ингэснээр болгошгүй мөргөлдөөнийг бага дээр нь олон улсын

хяналтад авдаг. Сомали, Югославт явуулсан ийм ажиллагаа бүтэлгүйтэлд орсон. Камбожид томхон амжилт олсон. Эритрейд санал хураалт явуулахад НҮБ-ын ажиглагчид үүргээ гүйцэтгэсэн. Мозамбикт энх тайван ардчиллыг сэргээн тогтооход НҮБ нарийн түвэгтэй зорилт шийдвэрлэв. 1993 оноос энхийг сахиулах НҮБ-ын үүрэг тэлэв. НҮБ түүхэндээ ийм их хүч зарж байсныг мэдэхгүй. Энхийг сахиулах 20 орчим ажиллагаанд нийт 100 орчим мянган хүн (бараг 4 тэрбум долларын төсөвтэй) дайчлагдаж байна. НҮБ санхүүгийн хямралд орж, гишүүн орнуудаас нь НҮБ-д тавьсан ор нэмэгдэж байгааг үүгээр тайлбарладаг. Жишээ нь Персийн буланд Иракийн эсрэг байлдахад 40 тэрбум доллар, Сомалид эхний нэг жилд л 1.2 тэрбум доллар, Камбожид засгийн эрх шилжүүлэхэд 1.5 тэрбум доллар зарцуулсныг үүнтэй холбож болно. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг үүрэг зохицуулалтаар нь дотор нь хэд хэд ангилж үздэг. Энэ нь:

- Сонгууль зохион байгуулах болон цааш нь ажиглах (Эритрей, Либер, мөн Камбож)
- Хүмүүнлэгийн тусламж хүргэх, түүний аюулгүй байдлыг хангах, (Босни, Сомали, Ирак дахь курдууд)
- Байлдаж байгаа талуудыг зааглаж, хяналт тавих (Хорват, Ливан, Кипр, Энэтхэг Пакистан, Кувейт-Ирак, Изриаль-Сири гэх мэт)
- Зэвсэглэсэн хүчний зэвсгийг хураах (Камбож, Сальвадор, Сомали)
- Хүний эрхийг хамгаалах (Камбож, Сальвадор)
- Минижүүлсэн талбайг цэвэрлэх(Афганистан, Камбож)
- Цэргийн болон цагдаагийн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд туслах (Камбож, Гаити)
- Улсын хил сэргээн тогтоох (Кувейт-Иракийн хоорондын хил)
- Иргэний засаг захиргааны үүрэг гүйцэтгэх (Камбож)
- Дүрвэгсэд болон эх нутагтаа эргэж ирсэн хүмүүст тусламж үзүүлэх (Югослав, Камбож, Сомали)
- Эцэст нь тайван цагийн бүтээн байгуулалтад туслах явдал.

4. *Энхийг тохинуулах (Peace buiding)* Энэ бол энхийг сахиулах ажиллагааны шууд үргэлжлэл юм. Тийм учраас дээр жагсаасан ангиллын олон элемент энд давхцаж болно. Жишээ нь хойшид хэрхэн мөргөлдөөн гаргуулахгүй байх вэ? гэдэг асуудал тайван цагийн бүтээн байгуулалтыг хэр хийв гэдгээс шалтгаална. Өөрөөр хэлбэл дайны дараахи хөгжлийн найдвартай фундаментыг тавина гэсэн үг. Ардчилал, энх тайван, хөгжил гурвыг энд салшгүй хамтад нь авч үзэх ёстой. Энхийг хэр тохинуулж чадав гэдгээс НҮБ-ын хүч чармайлтын эцсийн үр дүн хамаарна. Одоо Камбож, Сальвадор, Намиби, Өмнөд Африкт ингэж тохинуулж чадсан жишээ харагдаж байна.

Тэгэхдээ энд бичсэн НҮБ-ын 4 төрлийн ажиллагааг хооронд нь эрс заалгаж ойлгохгүй байвал таарна. Энэ бол нэг нь нөгөөгөө нөхсөн, бие биенээсээ урган гарсан, аль нэгэнгүйгээр нөгөөг нь төсөөлөх аргагүй зүйл. Бас энд бичсэнээр яг махчилж ойлгож болохгүй. Энэ өдөр Босни болон Хорватад НҮБ-ын явуулж буй үйл ажиллагааг нэг тэр нь гэж оноож хэлэхэд хэцүү юм. Эсвэл ТУХН-ийн зарим нутагт зэвсэгт мөргөлдөөнд шууд татагдан ордог Оросын энхийг сахиулагчдыг НҮБ-ын тодорхойлолтоор оноож нэрлэхэд гүнзэгтэй.

ГУРАВ. НҮБ ДАХЬ РЕФОРМ

Дэлхий дахинд энх тайвныг дэмжин сахиулахад НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нарын газар, Аюулгүйн Зөвлөл бүгд чухал үүрэгтэй нь мэдээж. НҮБ-ын шинэ ерөнхий нарийн бичгийн дарга энэ хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох үүднээс зохион байгуулалтын реформ хийхээс ажлаа эхэлсэн юм. Учир нь НҮБ-ын үйл ажиллагааны хуучин арга хэлбэрийг өөрчлөх, хуучин туршлага уламжлалаа бататгах үндсэн дээр олон улсын шинэ нөхцөлд тохирсон ажлын арга хэлбэр төлөвшүүлэхэд гол анхаарлаа хандуулсан. Үүний сацуу НҮБ-ын санхүүгийн хямралыг арилгахгүйгээр эдгээр зорилтыг шийдвэрлэж чадахгүй. Санхүүгийн хувьд бэхжиж байж олон улсын энх тайван, аюулгүй байдлыг дэмжиж сахиулах үүргээ гүйцэтгэнэ. Бутрос-Гали НҮБ-д тавьсан гишүүн орнуудын нэг тэрбум долларын өрийг нөхөн төлүүлэх үүрэг хүлээн авсан.

Дэлхий дахин хоёр туйлт системээс ангижирсан учраас дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх гишүүдийн хүсэл тэмүүллийг тусгасан, түгээмэл бодлого явуулах бололцоотой болов. Үүний сацуу олон улсын энх тайван, аюулгүй байдлыг дэмжин сахиулах үүднээс тухайн цагийн өнгө аяст зохицсон шуурхай уян хатан бодлого явуулж, хэрэгцээтэй үед НҮБ-ын мандат эрхийг тухайн үед нэг орны бүрэн эрхээс илүүтэйд авч үзэх ёстой. Үүнд энх тайван, аюулгүй байдлын төлөө гол хариуцлага хүлээдэг Аюулгүйн Зөвлөл их үүрэгтэй. "Хүйтэн дайн" дууссанаар Аюулгүйн Зөвлөлийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэв. Вето тавьдаг тохиолдол ч эрс цөөрөв. Гол нь Аюулгүйн Зөвлөлийн гишүүд өөр нэг татагдан ордог мөргөлдөөний тоо цөөрч, тэдгээр орны нэгүүр эрх шигийг хөндөх явдал багассан юм. Тийм учраас Аюулгүйн Зөвлөл мөргөлдөөнийг зохицуулах, сэрэмжлэх талаар янз бүрийн шийдвэр гаргах болж, НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргагай үйл ажиллагаагаа уялдуулдаг өвөрмөц практик бүрджээ.

Гэхдээ Аюулгүйн Зөвлөлийн хувьд эргэж харах юм бий. Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн тоог шинэчлэн, Бразил, Энэтхэг, Индонез, Нигери зэрэг хөгжиж буй томхон орноор тэлэхийг НҮБ-ын гишүүд нь шаардах болов. Бас вето тавих эрх байсаар байгааг буруушааж байна. Хэрэв хүчийг тэнцүүлье гэвэл Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүнд Герман, Японыг нэмж элсүүлэх ёстой гэсэн үзэл бодол бий. Энэ мэтээс үүдэн Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийг хууль ёсных гэх, эсвэл үгүйсгэх хоёр хандлага ажиглагддаг. Их гүрнүүд нь улс төр, цэрэг, санхүүгийн талаар бусад улсдаа даралт шахалт үзүүлэх хэрэгсэл мэтээр ветог ойлгох явдал бий.

Тийм учраас бусад орны дотоод хэрэгт НҮБ-аас орох хэмжүүр тогтоохыг цаг үе шаардаж байна. Их гүрнүүд Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр гаргахдаа ямар үндэслэл тавих вэ? гэдэг асуудал энд тусах ёстой. НҮБ Сомали, Босни руу цэрэг илгээхдээ тухайн нэхцөлд ямар нэг хэмжүүр тавиагүй. Яагаад тийш нь НҮБ-ын цэрэг илгээснийг хөдлөшгүй нотолж чадахгүй байна гэсэн үг. Тийм учраас элдэв эсэргүүцэлтэй тулж, зарим тохиолдолд НҮБ-ын цэргийн албан хаагчид гэнэтийн довтолгоонд өртөж, амь насаа хүртэл алдаж байна. Ингээд Аюулгүйн Зөвлөл 1993 оны тавдугаар сард маргаанд хөндлөнгөөс оролцох тохиролдлуудыг авч үзсэн юм. Түүнийг бид хэмжүүр гэж нэрлэж байна. Тэр нь:

- НҮБ-ын өөрийн нь бүрэн эрх мэдлийн асуудал байвал дотоод хэрэгт хөдлөнгөөс орж болно;
- Тухайн орны засгийн газрын зөвшөөрөл, эсвэл сөргөлдөгч талуудын зайлшгүй сонирхол байвал;
- Улс төрийн яриа хэлцээг хөхүүлэх, маргааныг эв зүйгээр шийдвэрлэхэд зайлшгүй туслах ёстой бол;
- Аюулгүй Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зогсоох ёсгүй бол;
- Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийг зөрчсөн таны эсрэг холбогдох арга хэмжээ авах ёстой бол;
- НҮБ-ын хүчний явуулж буй үйл ажиллагааны үндсэн дээр Аюулгүйн Зөвлөл нэмж арга хэмжээ авах хэрэгтэй бол;
- НҮБ-ын үүрэг гүйцэтгэж буй хүч өөрийгөө хамгаалах зорилгоор хүч хэрэг нэсэн тохиолдолд;
- НҮБ-ын энхийг сахилуулах ажиллагаанд богино хугацаанд амжуулах зайлшгүй шаардлагатай бол Аюулгүй Зөвлөлөөс бусад орны эсрэг авах ямар нэг арга хэмжээ хууль зүйн үндэстэйд тооцогдоно.

Гэхдээ энэ нь НҮБ-ын энхийг сахилуулах тэр үйл ажиллагаа цаг хугацаагүй, эцэс төгсгөлгүй үргэлжилнэ гэсэн үг биш. Бас тухайн орны дотоодын бүх ажил үйлсэд оролцоно гэсэн үг биш. Үүнээс

гадна цагийн байдлыг дагаж өөр бусад хэмжүүр бий болохыг үгүйсгэх аргагүй.

Энхийг сахиулах үүднээс 1992 оны хавар НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын хүрээнд тусгай хэлтэс байгуулсан нь чухал шинэчлэл болсон юм. Анх газар зүйн зарчмаар (Африк, Ази, Ойрхи Дорнод, Европ) байгуулагдсан энэ хэлтэс хэд хэдэн нэгж торүүлжээ. Энд гол нь энхийг сахиулахад улс орнуудын зөвсөгт хүчнийг татан оруулах, тэдгээрийг бэлтгэх, НҮБ-ын цэргийн эрх зүйн асуудал, ялангуяа НҮБ-ын албан хаагчдад халдвал ямар хариуцлага хүлээлгэх зэрэг олон асуудлаар ажиллаж байна.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг боловсронгуй болгохын тулд үүргээ гүйцэтгэхээ нэгэнт больсон зарим нэг цэргийн төлөөлөгчид, ажиллагчдыг татан буулгасан нь чухал реформ болсон билээ. Тухайн цагтаа гүйцэтгэх ёстой үүргээ биелүүлсэн бөгөөд урт удаан хугацааны турш тийш нь хөрөнгө хүч зарж буй цэгүүд дэлхийд байсан. Кипр, Ойрхи Дорнод, Кашмир дэх энхийг сахиулах ажиллагаа үүний тодорхой жишээ байв. 1974 онд Кипр рүү илгээсэн энхийг сахиулагчид 20 жил үр бүтээлгүй тэндхийн грек, туркуудын хооронд хөндөлджээ. Тийм учраас тэднийг нэг зэрэг буюу хэсэгчлэн гаргах асуудлыг тавьсан юм. Ингээд 1993 онд Канадын дипломат Жо Кларкийг Кипр дэх НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгчөөр томилж энхийг сахиулагчдыг татжээ. Израиль-ПЧБ, Израиль-Иорданы хооронд эвийн хэлэлцээр байгуулж, Израиль-Сири хоёр хэлэлцээний ширээнд суугаад байна. Хэрэв Сири Израильтай тохиролцож чадвал Голаны өндөрлөг дэх НҮБ-ын ажиглагчид цаашид буферын үүрэг гүйцэтгэж байх шаардлагагүй. Энэтхэг-Пакистаны хооронд 1949 оноос маргасаар байгаа хилийн нутгийг НҮБ-ын ажиглагчид хянаж байх нь үр нөлөөгүй гэж НҮБ үзжээ. Тэгээд ч жил бүр тийш нь 7 сая доллар зарцуулж байна.

Хүний эрх хамгаалах тал дээр НҮБ-ын үйл ажиллагааг ихээхэн шинэчлэх ёстой гэж үзэж байна. 90-ээд он гараад хамгийн их шүүмжлэлд өртөж буй салбар бол энэ юм. Энхийг сахиулахдаа хүний эрх хамгаалж чадахгүй буюу үйл ажиллагаандаа үүнийг түсгэх тал дээр дутагдалтай байгааг "Эмнэсти интернэшнл" анхичруулсан. Африкийн 6 оронд (Ангол, Либери, Мозамбик, Руанда, Сомали, Баруун Сахар) энхийг сахиулах ажиллагаа явуулахдаа хүний эрх зөрчсөн тохиолдол гарав. Сомалид байлдааны ажиллагаа явуулахдаа энгийн хүмүүсийг хэлмэгдүүлжээ. Бас гэмгүйн хүмүүсийг баривчилж, байцаасан, хорьсон хэрэг гарчээ.

НҮБ-ын энхийг сахиулахад шинэ тутам оролцож буй орнуудал туршигчид нутагшиж байгааг засч залруулахад НҮБ-ын реформын нэг чиглэл болох ёстой. 1993 он гэхэд энхийг сахиулахад оролцох орны тоо цөөсөрт юм. Түүхэнд ийм олон орон оролцож байсангүй. Тэдний тоонд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн орноос гадна Габон, Гамби, Гүмьн, Саудын Арав, Турк, Уганд, Арабын

нэгдсэн Эмират анх удаагаа энэ хариуцлагатай ажилд оролцжээ. Бас ТУХН-ийн зарим орны цэрэг Югославт, Болгарын цэрэг Камбожид очиж ажиллав. НҮБ-ын энхийг сахиулагчид хүрээгээ тэлснийг мэдээж хэрэг талархах ёстой. Гэвч зарим нэг зөрчил гарчээ. Жишээ нь Югослав дахь олон үндэстний хүчний дотор маргаан гарч, орос, украины цэргээс хулгай, дамын наймаа, янханчлах явдал илэрчээ. Болгар, тунисууд Камбожид, италиуд Мозамбикт биеэ зөв авч явж чадсангүй. Тийм учраас НҮБ-д ажиллах цэргүүдийг сургаж бэлтгэх ажил чухал юм. Сүүлийн хоёр жилд НҮБ-ын шугамаар ажиллах цэргүүдийг 20 гаруй оронд бэлтгэжээ. Умард Европ, Австралид сургалтын төвүүд байгуулагдаж, АНУ-ын цэргийн академи, коллежууд сургалтын программдаа энэ асуудлыг тусгах болон Энэ салбарт АНУ-ОХУ хоёр тусгай хэлэлцээр байгуулжээ. Цаашлаад АСЕАН-ны орнууд энэ талаар арга хэмжээ боловсруулж байна.

Бас нэг эмзэг асуудал бол НҮБ-ын хүчнийг зэвсэглэн төрөлжүүлэх явдал. Гар нүцгэн энхийг сахиулагчид зэвсэглэсэн дээрэмчдийн өмнө яаж ч хүчирдэггүй нь 1992 оны Бурундийн их хядлагын үед харагдсан. Хичнээн сайн зэвсэглэсэн ч америкийн энхийг сахиулагчид Сомалийн дээрэмчдийг нөмхрүүлж чадаагүй. Одоо Босни, Хорватид Францын цэргийн албан хаагчид хохирол амссаар байна. Ийм учраас НҮБ-д цэрэг илгээж байгаа орнуудын дотоодод НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд эргэлзэх явдал өсч байна. Ялангуяа Сомалиас НҮБ-ын хүчнийг яаравчлан гаргасны дараа ингэж эргэлзэх явдал бүр ч ихсэв. Бас өндөр хөгжилтэй орнуудыг илүү их цэрэг зэвсэг гаргахыг шаардах болжээ. Гэтэл "Хүйтэн дайны" дууссанаар хөгжингүй орнууд цэргийн зардлаа хасч (жишээ нь Их Британи, Канад) танаж байгаа учраас энэ бол санаснаар бүтэх ажил биш. Бас зарим орон НҮБ-д тавьсан асар их өр төлбөрөөсөө ангижрахын тулд л энхийг сахиулахад цэрэг илгээнэ гэсэн болзол тавьж байна. Зарим нь гаднаас цэргийн шинэхэн техник, технологи авах, цэргээ сурган бэлтгэхэд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа нэг суваг болно гэж үздэг бололтой.

НҮБ-ын энхийг сахиулагчдын хувьд хамгийн их түгшиж буй зүйл бол хохирч байгаа хүний амь нас юм. НҮБ-д цэрэг илгээгээд хичнээн хүнээ алдах бол гэдэгт улс бүр өөр өөрийнхөөр хандаж байна. Жишээ нь Пакистан дотоодынхоо бэрхшээлд түүртээд, Сомалид хамгаас их хохирол амссан хэрнээ сэтгэл зовинохгүй өнгөрөв. АНУ, Итали хоёр хохирлынхоо хэмжээгээр Пакистан дараа орно. Югославт Испанийн цэрэг олноороо алагдсан явдалд Испани маш их эгдүүцэж байна. Гэтэл ганцхан япон цэрэг Камбожид алагдмагц тэндээс бүх цэргээ татах шахсан. Ингэхэд Японы цэргийг өөр хааш нь ч илгээхгүй байхаар шийджээ. Македонид японы цэргүүдээр үүрэг гүйцэтгүүлэх гэсэн НҮБ-ын чармайлт талаар өнгөрчээ. Боснийн сербийн согтуу хэсэг цэрэг

Канадын 11 цэргийн албан хаагчийг үзэшгүйгээр хядсан байтал Канад шантралгүй өнөөг хүртэл НҮБ-ын энхийг сахиулах бүх ажиллагаанд оролцсоор байна. Одоо НҮБ-ын хүчинд хамгийн тууштай ажиллаж байгаа нь Канад, Скандинавын цэргүүд ажээ. Германы цэрэг дэлхийн хоёрдугаар дайнаас хойш анх удаа л НҮБ-ын цэргийн бүрэлдэхүүнд орж Сомалид очжээ. Хөнгөн зэвсэглэсэн аж ахуйн зориулалттай явсан хэрнээ тэднээс хэн нэг нь нэгэн олзлогдсоон сомалийг буудаж алжээ. Үүнээс үүдэн Германы цэргийг дахин НҮБ-ын хүчинд оруулахыг зогсоожээ. Энэ бол германчуудын өөрсдийнх нь шаардлага байсан юм.

ДӨРӨВ. НҮБ БА АНУ

АНУ НҮБ-д ямар үүрэг нөлөөтэй вэ? Санхүүгийн талаас ч, улс төрийн талаас ч авч үзсэн АНУ НҮБ-д шийдвэрлэх үүрэгтэй. НҮБ-ын санхүүгийн хямралыг зохицуулахад АНУ гол үүрэг гүйцэтгэнэ. Учир нь НҮБ-ын төсвийн дөрөвний нэгийг АНУ бүрдүүлдэг юм. НҮБ-ын ажлын хэрэгцээ шаардлага өгч, цаашлаад явуулж буй үйл ажиллагаа асар их үнээр хэрэгжих болсноор хиймэл өр бий болов. Нөгөө талаас улс бүр дор дорынхоо бэрхшээлд түүртээд татвараа цаг хугацаанд нь төлж чадахгүйгээс санхүүгийн хямрал даамжрав. НҮБ-д тавьсан өрийн нэлээдийг АНУ өөртөө хүлээх ёстой боловч НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг санхүүжүүлэх талаар бусдаасаа илүү их зардал гаргадаг. Гэхдээ АНУ-ын оролцоогүйгээр энхийг сахиулж чадсан олон жишээ бий. Камбожид НҮБ амжилттай ажиллахад АНУ дорвитой туслаагүй, байлдааны ажаиллагаанд оролцоогүй. Сомалид америкийн цэрэг очсон хэрнээ НҮБ-ын ажиллагаа дампуурсан. Ер нь энхийг сахиулахад хамгийн олон цэрэг гаргасан нь АНУ юм. Македони руу 300 цэрэг илгээж, 4000 цэрэг Сомалид очиж, цаашлаад НҮБ-ын хүчнийг тээвэрлэх байрлуулах, хооллох, хувцаслах, зэвсэглэхэд АНУ асар их тусламж үзүүлж ирэв. Энэ үзүүлэлтээр АНУ-ын урд гарах орон байхгүй. Энэ утгаараа АНУ энхийг сахиулахад жинтэй хувь нэмэр оруулсаар байна.

"Хүйтэн дайн" төгсгөл болсноор АНУ-ын үүрэг нөлөө эрс өсөв. Хүссэн хүсээгүй дэлхийн шинэ дэг журам америкийн үзэмжээр тогтож байна. НҮБ-ын нэрээр АНУ-ын бодлого хэрэгжиж байгаа мэтээр үүсдэг. Олон улсын маргаан дэгдээсэн зарим орон (Иран, Ирак, Ливи, БНАСАУ) ийм зэмлэлийг бусдаас чанга тавьж байна. Энэ бол үндэсгүй зэмлэл биш. АНУ-ын гадаад бодлогыг олон улсын харилцааны реалист онол тодорхойлж ирсэн бөгөөд түүний мөн чанар нь хүч чадлаа хадгалах, хүчээ чадлаа өсгөх эцэст нь түүнийгээ харуулах явдал, энэ 3 зорилго нийлж байж гадаад бодлогын ноён нуруу болдог. "Хүйтэн дайны" үеийн хоёр туйл системд АНУ, ЗСБНХУ хоёул ийм зорилгыг өмнөө тавьж

өрсөлдсөөр эцэст нь ЗХУ тамирдан унав. Тэгэхээр үлдсэн цорын ганц хэт их гүрэн -АНУ хүч чадлаа илтгэх боломжоор бүрэн хангагдлаа. Реалист сургуулийн онолчид цэрэг, улс төр, эдийн засгийн хүч потенциалгаа олон улсын харилцааг шийдэх гол зэвсэг гэж үзэх ба үнэт зүйлээ зөвхөн үндэсний эрх ашгаараа тодорхойлдог. Энэ онолоор өнөөгийн НҮБ-ыг АНУ-ын бодлогыг идэвхтэй хэрэгжүүлэгч гэж үзэхэд болох мэт. Гэхдээ яг ингэж махчлан ойлгохгүй байвал зохино.

Ямар ч атугай АНУ-ын явуулж байгаа бодлого НҮБ-ыг хүчтэй, үр нөлөөтэй байгууллага байлгахын төлөө байгаа бөгөөд Клинтонь засаг захиргаа АНУ-ын цэргийг НҮБ-ын командлалд шилжүүлнэ гэсэн мэдэгдэж байсныг эргэн саная. НҮБ-ын энхийг сахиулах албадлагын механизмд америкийн цэргээр гол үүрэг гүйцэтгүүлэхийг АНУ хүсч байна. Түргэн тусгаж шуурхай хөдлөх НҮБ-ын цомхон хүчнийг бүрдүүлэхийг АНУ санал болгосон. Гэвч 1993 онд Сомалид америкийн цэргүүд алагдсаны дараа АНУ дээрх байр сууринаасаа ухрахад хүрчээ. Ингээд энх тайвныг дэмжин сахиулах олон талт арга хэмжээнд АНУ-ыг оролцуулах нэлээд хатуу нөхцөл боловсруулжээ. АНУ өөрөө биечлэн тийм ажиллагаанд оролцох, эсвэл тийм ажиллагааг санхүүжүүлэх нөхцлийг доорхи байдлаар томъёолжээ.

- Олон улсын аюулгүй байдалд яг бодитой аюул учирсан бол;
- Өргөн хэмжээний гамшиг сүйрэл тохиолдсон үед хүмүүнлэгийн салбарт яаралтай тусламж үзүүлэх бол;
- "Хөлөө олж ядаж байгаа" ардчилалд гэнэт аюул занал чирвал;
- Хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн баримт илэрвэл гэх мэт;

Тэгэхдээ ийм тохиолдолд НҮБ үүрэг гүйцэтгэх эсэхийг дэлхийн хамтын нийгэмлэг санал нэгтэй сонирхох эсэх, НҮБ үүрэг гүйцэтгэсний дараа байлдагч талууд болон сөргөлдөгчид харилцан гал зогсоож чадах эсэх, НҮБ төлөвлөсөн ажлаа хугацаанд нь хийж чадах зэргийг урьдчилан харах ёстой.

НҮБ-ын энхийг сахиулах байлдааны болон цэргийн ажиллагаанд АНУ оролцох нь үндэсний эрх ашигтай нь хэр хослох, мөн очсон тэр газрын ард түмэн үүнийг хэр хүлээн авах асуудал эцсийн үр дүнд шууд хамаарна. Өнгөрсөн хэдэн жилд НҮБ-ын далбаан дор явуулсан энхийг сахиулах ажиллагаанд АНУ дүгнэлт хийгээд доорхи 3 хүчин зүйлийг харгалзах ёстой болж байна. Үүнд:

1. АНУ-ын үндэсний эрх ашиг;
2. АНУ-ын холбоотнуудын эрх ашиг;
3. Ялалт олно гэсэн хөдлөшгүй итгэл үнэмшил.

Өнөөдөр НҮБ-ын хүчний бүрэлдэхүүнд АНУ-ын цэргээс олон бий. Тэд өнгөн дээрээ аль нэг өөр орны генералын удирдлагад ажиллаж байгаа боловч цаанаа дээрх 3 гол хүчин зүйлийг үндэслэн АНУ-ын эрх баригчдад захирагддаг.

ТАВ. ЭНХИЙГ САХИУЛАХАД БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУД

"Хүйтэн дайны" үед бүс нутгийн шинжтэй мөргөлдөөнийг зохицуулахад бүс нутгийн байгууллагууд НҮБ-ын дайтай үүрэг гүйцэтгэж байгаагүй, гүйцэтгэсэн нэг нь хязгаартай байсан юм. Хоёр туйлт систем задарснаар бүс нутгийн байгууллагууд өөрийн харъяалж буй бүс нутаг дахь мөргөлдөөний голомтыг шийдвэрлэх асуудлаар судалгаа хийж, НҮБ-д хандаж санал бодлоо илэрхийлэх болов. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын дэвшүүлсэн "Энх тайван хөгжлийн программд" хоёр шалтгаанаар:

1. Бүс нутгийнхаа асуудлыг сайн мэддэг гэдэг үүднээс;

2. НҮБ-ын бүрэн эрхийг бүс нутгийн байгууллага ашигтайгаар хуваалцах ёстой гэдэг үүднээс бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулахад тэндхийн байгууллагуудыг татан оруулах тухай заасан байгаа. Сомалид НҮБ энхийн зохицуулалт хийхдээ Африкийн нэгдлийн байгууллага, Арабын орнуудын холбоо, Лалын бага хурлыг татан оруулсан. Гаитид цэргийн дарангуйлагч дэглэмийг зайлуулахдаа НҮБ, Америкийн улсуудын байгууллага хамтарсан шийдвэр гаргасан. Босни дахь энхийн зохицуулалтын асуудлаархи хэлэлцээний дарга нар Сайрус Вэнс, түүний халааг авсан Торвальд Штольтенберг, лорд Оуэн, Карл Билдт нар НҮБ болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагыг төлөөлж байна.

НҮБ-ын гадна олон улсын маргаан мөргөлдөөнийг зохицуулдаг нэгэн хүчтэй механизм бүрдсэн нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал юм. Вена (мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх төв), Ла-Валетта (маргааныг эв зүйгээр зохицуулах механизм), Варшав (Хүний эрхийн товчоо), Женевт (Арбитрын шүүх) холбогдох институт, мөн хямралын үед Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын онц чуулганы зарлан хуралдуулах механизм, Үндэстний цөөнхийн эрхийн асуудлаархи Дээд комиссар гэх мэт бүтэц бий болоод байна. Үүнээс гадна ТУХН-ийн зарим бүс нутагт зориулан туслах чанарын хэл хэлэлцээн байнгын бүс институт байгуулжээ. Үүнд удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэж байгаа нь Эстон, Гүрж, Латви, Молдов, Тажикистан дахь ажиглагчдын хэсэг юм. Югославын Косово, Санжак, Чернобинд ажиглагчдын хэсэг байгуулсан боловч Сербийн эрх баригчид тэдний мандатын хугацааг сунгах хэлэлцээрийг цуцалсан учраас эргэж татжээ.

Бага хурлын ажиглагчдын хэсэг Македонид байгаа явдан чухал мөн хөндөгдөлтэй. Энэ бол мөргөлдөөнийг урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэж буй НҮБ-тай хамтарсан хэсэг. Албани, Болгар, Унгар, Македон, Румын, Украин болон Хорватад уг асуудлаар богино хугацааны төлөөлөгчдийг илгээж ажиллуулав. Энэ бол энх тайвныг нийлэн тогтоох талаар Серби, Черногори

явуулсан энхийг сахиулах ажиллагааны ажлын нэг хэлбэр болсон юм. Серби-Хорват-Словенийн хооронд гал зогсоох талаар байгуулсан хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих зорилгоор Европын холбооноос 300 ажиглагч илгээж байсныг санаж байна. Гэхдээ энэ бүхэн НҮБ-ын хүч чармайлтад туслахад чиглэсэн Европын орнуудын нэгдсэн хүч чармайлтын эхний илрэл болохоос бус бүрэн төгөлдөр хэрэгжсэн зүйл биш. Тэгээд ч ажлын эхлэл төдий байгаа, нөгөө талаас Сербийн зүгээс ширүүн эсэргүүцэлтэй тулгарч байгаа зэргийг бодолцон тэднээс ажлын үр дүн нэхэх хэрэггүй. Зарим талаар энэ шинэ механизм үр өгөөж муутай байж болно. Тийм учраас НАТО, Умард Атлантын хамтын ажиллагааны зөвлөл, Баруун Европын холбоотой ажлаа уялдуулан, хамтран ажиллах замаар үр нөлөөтэй ажиллана. Боснид агаарын дайн хийх гэсэн санаархлыг НАТО-гийн нисэх хүчний тусламжтайгаар таслан зогсоож, Сербийн их бууны байрлал зэвсгийн агуулахыг агаараас устгасан баримт үүнийг илтгэж байна.

1992 онд НАТО-гийн командлал тодорхой нөхцөл тулгарвал цэргээ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын мэдэлд шилжүүлнэ гэсэн амлалт өгсөн НАТО-гийн гишүүн биш атлаа бага хурлын гишүүн олон орон бий. Ихэнхлэн ТУХИ, Дорнод Европын тодотгор орон үг асуудалд их амьсал хандсан. Тийм учраас НАТО-гийн гишүүн орнууд уг эвслийн гишүүн бус Европын орнуудтай энхийг сахиулах талаар бэлтгэл сургууль хийхийг өрнөдийн зүгээс санал болгосон. Энэ зорилгоор Умард Атлантын хамтын ажиллагааны зөвлөлийн тэргүүлэх чиглэлийн дотор энэ асуудлыг тусгаж, бас "Энхийн төлөө түншлэлийн" программын нэг гол зүйл анги болгосон юм. НАТО-гийн цэргийн бүтцэд ордоггүй Франц энэ талаар өвөрмөц байр суурьтай. Баруун Европын холбооны төв байр Парист байдгаас үүдэн энэ эвслийн хүрээнд энхийг сахиулах үйл ажиллагаанд Франц улс давуу эрх эдлэх гэсэн санаа цухалзсан. Энэ бол энхийг сахиулах асуудлаар Европын улсууд санал нэгдэж чадаагүйн нэг нотолгоо. Францын энэ байр суурийг АНУ эсэргүүцсэн. Гэвч энэ бол ноцтой хэмжээнд хүрсэн асуудал биш. Аажимдаа намжиж одоо НАТО-гийн орнуудын хувьд Югославын мөргөлдөөний асуудлаар санал нэгдээд байна. Тэндхийн мөргөлдөөнийг шатлан өргөжүүлэхгүй байх зорилгоор АНУ, Их Британи, Франц, Нидерландын нисэх хүчнийг Итали болон Адриатын тэнгис дэх баазуудад ойртуулан байрлуулж, болзошгүй ажиллагаанд бэлтгэжээ.

Энэ мэтээр бүс нутгийн институт бүтцүүд мөргөлдөөний голомтод ажиллах дадлага туршлагатай болж байна. Ямар ч атугай НҮБ шууд болон бүс нутгийн байгууллагаар дамжуулан дэлхийн халуун цэгүүдийг хяналтдаа авлаа. Үйл явцыг ажиглаж, цаашдын хандлагыг нь харах бололцоотой боллоо. Энэ бол гол ололт. Дэлхийн хамтын нийгэмлэг одоогоор дэлхийн 28 бүсэд (1994 оны эхний тоо) 34 томхон зэвсэгт мөргөлдөөнийг ажиглаж

бүртгээд байна. Эдгээр мөргөлдөөн бүгд улс орны дотоодын шинжтэй гэдгийг тогтоожээ. Нэр томъёоны талаар санал нэгдлээ. Үүнд

- "Томхон зэвсэгт мөргөлдөөн" гэдэг нь хоёр болон түүнээс дээш тооны засгийн газрын хооронд, эсвэл засгийн газар болон дор хаяад зэвсэглэсэн зохион байгуулалттай нэг том бүлгийн хооронд удаан хугацаагаар үргэлжилж буй, хохирол нь 1000-аас доошгүй хүний аминд хүрсэн мөргөлдөөнийг тосцох болно.
- "Мөргөлдөөний бүс" гэдэгт зэвсэгт мөргөлдөөнд хамрагдсан тэр улсын тухайн нутаг дэвсгэрийг хэлж байна. Зарим үед хэд хэдэн орон нэг бүст сөргөлдөх явдал байдаг. Тэгвэл нэг орон гадагшаа хэдэн тийшээ зэвсэгт мөргөлдөөнд татагдах явдал байдаг. Тийм учраас зэвсэгт мөргөлдөөний тоо, бүсийн тоог тогтооход амаргүй.

Одоогоор хамгийн ноцтойд нь Тажикистан, Чечень, Босни, Хорват орж, тивээр авч яривал Европ зэвсэгт мөргөлдөөний гол төвлөрөл болох хандлагатай. Энд ТУХН-ийн бүх нутаг дэвсгэрийг Европт багтаан авч үзэж байгаа юм. Хэрэв тоон өсөлтөөр нь авч үзвэл 1989 онд энэ тивд мөргөлдөөний хоёр бүс байсан бол 1993 он гэхэд 5 болж, 1995 онд Чечень нэмэгдлээ. Азид энэ үзүүлэлт унасан. Урьд бүртгэгдсэн Энэтхэг-Пакистаны хоорондын ба Ласо дахь зэвсэгт мөргөлдөөний эрч суларч, бараг зогссон. Колумб, Гватемал, Перу дахь сунжирсан мөргөлдөөн Латин Америкт үргэлжилж, Африкт мөргөлдөөний тоо хэмжээ, шинж чанар байнга хувьсан өөрчлөгдөж байна. (Эдгээрийг хавсралтаас тодорхой үзнэ үү) Эдгээр мөргөлдөөнийг ерөнхийд нь олон улсын хяналтад авч зохицуулж хүчрэх, олон улсын хяналтад авч зохицуулж хүчрэхгүй олон улсын хамтын нийгэмлэгийн хүч аргагүй дутагдаж байгаа гэж хоёр ангилж болох юм. Тийм учраас товчхоноор нэмэх, хасах хоёр тэмдэг тавина гэсэн үг. НҮБ-ын өмнө өнөөдөр ийм хасах тэмдгийг цөөлөн, нэмэх тэмдгийг олшруулсаар, эцэст нь "О" (тэглэнэ гэсэн үг) болгох зорилт хэвээр байна.

ЗУРГАА. НҮБ БА МОНГОЛ УЛС

Манай улсын гадаад бодлогын дөрөв дэх чиглэл нь НҮБ болон түүний гаралжсэн байгууллага, олон улсын банк, санхүү-эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал гэдгийг Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан. Бас хөгжиж байгаа орнуудтай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагааг НҮБ, "77 гишүү бүлэг", Эцэсэд үл нэгдэх хөдөлгөөний хүрээнд хамтран ажиллах замаар хэрэгжүүлэх бөгөөд энэ нь хоёр талын харилцаанаас дутахгүй ач холбогдолтой гэдгийг уг үзэл баримтлалд хүрээнд илэрхийлсэн. Тэгэхээр НҮБ нь Монгол Улсын хувьд

олон улсын тавцанд ажиллах нэг боломж гэдэг нь тодорхой. Энэ боломжийг хэр ашиглаж ирэв гэдэг бол үүнээс өөр асуудал. Бид тэр боломжийг олон жил орхигдуулж ирсэн байж магадгүй. Ер нь НҮБ-д хандах манай хандлага зөрчилтэй замаар төлөвшсөн юм. Анх бид НҮБ-д элсэх асуудал тавихдаа дэлхийн хоёрдугаар дайнтай холбож авч үздэг байлаа. Өөрөөр хэлбэл энэ дайнд фашизм, нацизмыг ялахад ямар хувь нэмэр оруулав гэсэн хэмжүүрээр НҮБ-д байр эзлэх ёстой гэж ойлгож байв. Дайны дараахи арваад жилд ЗХУ-аас НҮБ-ын талаар баримталж байсан алдаатай бодлого Монголыг НҮБ-д хууль ёсны суудлаа эзлэхэд нөлөөлсөн байх. 60-аад онд дэлхийн колонийн систем сүйрснээр олон улсын харилцаа улам өргөн, олон талтай болж, Монгол Улс ч олон улсын тавцанд ажиллах өргөн боломжоор хангагджээ. Тэр боломжийн нэг хэсэг нь НҮБ-д элссэнээр биелэх ёстой байв. Гэвч бид тэр боломжийг бараг 30-аад жил тэр бүр өнөөчтэй ашиглаагүй. Ашиглаж чадах эрх нь тухайн орны жин нөлөө, аль нэг эвсэл бүлгийг аялдан дигшидаж байсан эрх, тухайн үед олон улсын харилцаанд ноёрхсон "Хүйтэн дайнтай" холбоотой байсан нь мэдээж. Бие биеэ сөрөн зогссон хоёр системийн үзэл суртлын тэмцэлд Монгол Улс талцдаг эрж, өөрийн жил боддоо, бодит хүч бололцоо, нэгүүр эрж нэгийг сайтар харгалзахгүй, дэлхий дахины чанартай том асуудлаар хэт хөөцөлдөж, империализмд няцаалт өгөхийг гол болгож ирсэн юм. Энэ утгаараа бид НҮБ-ыг үзэл суртлын тэмцлийн талбар, суртал нэвтрүүлгийн индэр болгохыг эрмэлзжээ. Эдийн засаг-нийгмийн чанартай асуудлаар хөгжлийн саад бэрхшээлээ бүрхэгдүүлж, энэ талаар олон улсын байгууллагуудад өгдөг мэдээг нуун дарагдуулах буюу худал мэдээлэх, ололт амжилтаа хэт дөвийлгөн сурталчилахын зэрэгцээ тунхаглах, үзэл сурталдах шинжтэй тогтоол шийдвэр батлуулахын төлөө хий чармайлт тавьж байлаа. Мөн бусад орноос дэвшүүлсэн санал санаачилгад ямагт ангийн байр сууринаас өрөөсгөлөөр харж, улс төржүүлж, ажил хэрэгч биш хандаж байсан дутагдал байсан. Энэ бол 90-ээд он хүртэл НҮБ-д манай явуулсан бодлогын сул тал нь юм. Ололттой тал байсныг энд бичсэнээрээ үгүйсгэж байгаа биш гэдгийг хэлэх нь илүүц биз ээ.

80, 90-ээд оны зааг дээр олон улсын харилцааны хоёр туйлт ертөнцийн бүтэц задарч, шинэ тогтолцоо бүрэлдэх явц эхэлсэн, нөгөө талаас Монголд ардчилсан хувьсгалын дүнд нийгэм-улс төр, эдийн засгийн тогтолцоо солигдож, олон улсын харилцааг үнэлэх хэмжүүр, гадаад бодлогын зарчим, чиглэл зорилго өөрчлөгдсөнтэй холбогдон НҮБ-ын талаар баримтлах манай бодлогод зарчмын өөрчлөлт оров. НҮБ шинэ тогтолцоо руугаа шилжилт хийж байгаагийн нэгэн адил Монгол Улс НҮБ-д хандах үзэл баримтлалаа өөрчлөх шилжилтийн үедээ байна. Ийм завсрын үед анхаарах хэд хэдэн асуудал бий. Үүнд:

1. Монголчууд бид хэн бэ? гэдгээ эхлээд нарийн тодорхойлох ёстой. Гол нь НҮБ мэтийн дэлхийн хэмжээний том байгууллагад ямар үүрэг гүйцэтгэх бололцоотой, ямар үүрэг гүйцэтгэх боломжгүй вэ? гэдгээ яг таг тогтоох ёстой юм. Эдийн засгийн нөөц боломж, геополитикийн онцлог ба орчин гадаад хүрээлэлтэйгээ болон НҮБ-тай хэрхэн харилцаж ирсэн уламжлал, туршлагаа эргэж нэг хармаар байна.
2. НҮБ, түүний системийн байгууллагын талаар мэдлэгээ дахин нэг цэгцлэх ёстой юм шиг санагддаг. "Хүйтэн дайны" дараахи НҮБ-ын талаар нэлээд ултай судалгаа хиймээр байна. Энэ цаг үед НҮБ юуг хүсч, ямар зорилго тавьж, юунд хүрэхийн төлөө чармайж байгааг нь сайтар мэднэ гэсэн үг.
3. Монгол Улс ба НҮБ-ын хүсэл эрмэлзэл, сонирхол, бодлого ямар асуудлаар нийцэж, юугаараа зөрж байгааг олж тогтоох нь дараагийн зорилт. Энэ нь дэлхийн бодлого явуулдаг том орон шиг НҮБ-тай эн тэндүү харилц гэсэн үг биш, гол нь Монгол Улс НҮБ-д ямар чиглэлээр, ямар салбарт тус болж чадах вэ? гэдгээ тодорхойл гэсэн үг юм.
4. Хамгийн сүүлд Монгол Улс, НҮБ-ын харилцан сонирхол дүйцэх тэр чиглэлд тохируулан бодлогоор боловсруулж хэрэгжүүлэх ёстой.

НҮБ-ын үйл ажиллагааны үр өгөөж, нэр хүнд өсч байгаа өнөөгийн нөхцөлд түүний практик дахь шилдэг хандлагыг батжуулан бэхжүүлэхэд бололцооны хэрээр тус дөхөм үзүүлж, НҮБ-д баримтлах байр сууриа уян хатан, аятай хэлбэрээр илэрхийлэхийн хамт манай эрх ашгийг хөндсөн цөөхөн хэдэн асуудалд хүч анхаарлаа төвлөрүүлж гүнзгий орж ажиллах явдал эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал юм. Манай эрх ашгийг хөндөнө гэдгийг зөвхөн зээл тусламж эдийн засгийн асуудлаар төлөөлүүлэн ойлговол гэнэн хэрэг болно. Энд НҮБ-тай Монгол Улс саас холбогдох бүх асуудлыг цогцолбороор авч үзэх ёстой. Жишээ нь хөгжлөө хэт дөвийлгөж байсан үеэ мартчихаад хөгжлөө хэт дарагдуулж таарахгүй. Энэ хоёр туйлын хооронд завсрын хэмжүүр байх ёстой. Тийм учраас эдийн засгийн хөгжлийн гол гол үзүүлэлтээ НҮБ-ын болон олон улсын хэмжээнд мөрддөг бусад прагматикаар тооцон гаргаж мэдээлэх, энэ үндсэн дээр НҮБ-ын хөгжлийн программ болон олон улсын бусад байгууллагаас өшөөдөг тусламжийг тооцож тогтоох ёстой. Үүнээс гадна НҮБ-д Монгол Улсын төлөх гишүүний татвар гэж бий. Түүнийг олон жил ЗХУ төлж ирлээ. Хэрэв тэр татварыг цаг тухайд нь төлөхгүй бол тэр нь эргэлт өр болж хуримтлагдана. Манайх шиг бууурай хөгжилтэй оронд хүүнд НҮБ-д тавьсан өр гадаад өрийн дарамтыг улам хүндрүүлнэ. Иарим жижиг орон НҮБ-ын энхийг сахиулах ажил хандлагад багасган оролцох хэлбэрээр төлөх татварын хэмжээгээ багасгаж чөлөөтэй бярлэж байна. Үүнийг судалж үзэхэд илүүдэхгүй.

юм. "Монгол улсын цэргийн номлолын үндэс" гэсэн баримт бичигт (1994 он): "Ажиглагч, сайн санааны туслалцаа үзүүлэх, зуучлах, эвлэрүүлэх зэрэг НҮБ-ын дүрмийн дагуу НҮБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлнэ", бас "НҮБ-ын зэвсэгт хүчин, олон улсын цэргийн байгууллага болон нөлөө бүхий улс орнуудтай цэргийн харилцаа тогтоож хөгжүүлнэ" гэсэн чиглэл бий. Үүний сацуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал" гэсэн хэсэгт: "Монгол Улс бусад улс орон, олон улсын байгууллагатай цэргийн салбарт хамтран ажиллаж, өөрийгөө болзошгүй түрэмгийллээс урьдчилан сэргийлэх; хамтын хүчээр батлан хамгаалах бодлогодоо хөрш зэргэлдээ, гурав дахь улс гүрэн, НҮБ-ын болон олон улсын бусад нэгдсэн зэвсэгт хүчнийг ашиглах чиг баримтлах" гэсэн заалт оруулсан.

Эндээс үзвэл Монгол Улсын оршин тогтнох нэг үндэс нь НҮБ-тай тогтоосон харилцаанд байгаа нь тодорхой. "Хүйтэн дайн" дууссанаар цэрэг-улс төрийн эвслүүдийн шинж чанар өөрчлөгдөж, ихэнх нь үүргээ гүйцэтгэхээ больсон. 90-ээд оноос өмнө ЗХУ-тай тогтоосон цэрэг-улс төрийн холбоотны харилцаа, цаашлаад социалист хамтын нөхөрлөл, түүний цэргийн нэгдэл Варшавын гэрээний байгууллага Монгол Улсын хувьд оршин тогтнохын баталгаа болж байсан. Түүний орыг одоогоор бүрэн эзэлсэн өөр улс орон, байгууллага байхгүй. НҮБ бүрэн батлан даах боломжгүй, тийм үүрэг хүлээхгүй. Гэхдээ НҮБ-тай хамтран ажиллах явдал энд чухал байр суурь эзлэх ёстой. Хэрэв Монгол Улс гаднын түрэмгийлэлд өртөх буюу дотооддоо дайн мөргөлдөөнд татагдан орвол дэлхийн хамтын нийгэмлэгт л хандана. /

Нөгөө талаас НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд төвийг сахисан орнууд тууштай оролцож ирснийг харгалзан төвийг сахисан шинэхэн орны хувьд энэ ажиллагаанд оролцох ёстой. Чухам тийм цаг үе нь бүрдээд байна. 90-ээд оноос өмнө нэг эвсэл бүлгийн хүрээнд дагуул улс гэгдэж байх үед тийм боломж байгаагүй, байх ч нөхцөл үгүй байв. 90-ээд оноос хойш Монгол Улс нь ЭҮНХ-ний гишүүнээр элсэж, хоёр хөрштэйгээ эн тэнцүү харилцах болж, дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө нээлттэй боллоо. Одоо бидэнд бусад улс үндэстнээс нууж хаах зүйл байхгүй. Монголын гадаад бодлого ил тод болсон. Энэ утгаараа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцоход болохгүй гэх газаргүй. Нөгөө талаас Монголын дотоодын эдийн засгийн боломжоос шалтгаалж тэгж ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Өнөөдөр Монголын ардын цэргийг санхүүжүүлэх асуудал хүнд байгаа. Төсвийн бэрхшээлээс болоод цэргийн анги нэгтгэлүүд хөл дээрээ бүрэн зогсож хүчрэхгүй байна. Цэргийн бэлтгэл сургууль, офицеруудыг мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх, давтан бэлтгэх, цэргийг шинэхэн зэвсэг техникээр хангах зэрэгт бэрхшээл учирч байна. Үүнийг шийдэх нэг зам бол НҮБ-ын цэрэгт багтах

явдал байж болох талтай. Мөн нэгэнт мэргэжил мэдлэг эзэмшсэн хэрнээ сурсан мэдсэнээ практикт харуулж чадахгүй, наснаасаа эрт тэтгэвэрт гарч, гандаж яваа офицеруудын хувьд олон улсын хэмжээнд үр бүтээлтэй ажиллах нөхцөл нь НҮБ байж болох юм. Монгол Улс цэргийн доорхи 3 төрөл мэргэжлээр НҮБ-ын энхийг сахиулахад оролцох боломжтой. Энэ нь:

1. Ар тал-тээвэр;
2. Инженер-салёр (барилгын цэрэг);
3. Хими хамгаалалт

Жишээ нь НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн бараа зөөвөрлөх, хүргэх, түгээхэд ар тал-тээврийн мэргэжлийн анги салбарыг бэлтгэж болно. Афганистанд минийн талбай цэвэрлэхэд оролцож болох байсан. Үй олноор хөнөөх зэвсэг, химийн зэвсэг шалгах устгахад манай химийн цэргийн мэргэжилтнүүд ажиллах бүрэн боломжтой. Үүнийг НҮБ-ын шугамаар давтан сургалт хийсний дараа хэрэгжүүлж болно. НҮБ-ын цэргийн боловсон хүчин, албан хаагч бэлтгэх анхны сургалтын төв 1969 онд Финландад байгуулагдаж, өнөө хүртэл ажиллаж байна. Энд цэргийн ажиглагчид, бусад мэргэжилтнийг бэлтгэдэг. Скандинавын орнууд хямралтай бүс нутагт хамтарсан батальон илгээх талаар туршлага хуримтлуулсан. Тэндхийн "Нордбат" (Умардын батальон) НҮБ-ын шугамаар дэлхийн халуун цэгүүдэд ажилласаар байна.

Монголын энхийг сахиулагчид НҮБ-ын томхон операцид (жишээ нь Босни шиг) оролцдоггүй юмаа гэхэд Ази, Африкийн аль нэг буурай оронд ар тал-хангалтын ажилд зүтгэж болох юм. Өнөөдөр Ази, Номхон далайн бүс нутгийн ямар нэг байгууллага институт НҮБ-ын энхийг сахиулахад хамтран ажиллаж байгаа баримт алга. Энэ нь Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулахад оролцох боломж алга гэсэн үг биш. Бүс нутагт АНУ, Япон, Өмнөд Солонгос гэх мэт энэ талаар дадлага туршлагатай, эсвэл туршлагажиж яваа орон бий. Тэдний тусламж дэмжлэгт түшиглэхэд болохгүй гэх зүйлгүй. Тэгэхээр энэ бүхнийг манай Батлан хамгаалах Яам, Гадаад харилцааны Яам хамтран судалж, асуудал болонсруулж засгийн газарт оруулж болох болов уу.

Холбоо дох ном, хэвлэл

1. Boutros Boutros-Ghali: An Agenda for Peace: One Year Later-Orbis (Summer 1993)
2. A Roberts: The United Nations and International Security-Survival (Vol. 39, No. 2, 1993)
3. M Goulding: The evolution of United Nations' peacekeeping-International Affairs (Vol. 69, No.3, 1993)
4. T.G Worm: New Challenges for UN Military Operations: Implementing an Agenda for Peace: The Washington Quarterly (Winter 1993)

Камбожид анх удаа явагдсан чөлөөт ардчилсан сонгуулиар улс төрийн хоёр гол хүчин олонхийн санал авч эвслийн засгийн газар бүрдүүлэв. Тус орон түүхэндээ нэгэн зэрэг хоёр ерөнхий сайдтай нэг засгийн газрыг ажиллуулж байна. Гэвч Ардчилсан Кампучийн нам гэгч нь сөргөлдөх бийр сууриа орхихгүй тус орны эвийн үйл явцыг саатуулсаар байна.

ТАВ. ГАИТИ

Гаити бол Карибын тэнгист орших арлын жижиг орон, 7 сая хүрэхгүй хүн амтай. Гэтэл олон жил дэлхий дахины анхаарлыг татаж, НҮБ, АНУ, Америкийн улсуудад байгууллагыг хэрдээ түгшээж, эцэст нь багагүй хүч зарж байж 1994 онд дайтахын даваан дээр ардчиллыг сэргээн төгтгөсөн билээ. Уг нь үүх түүхийг нь сөхвөл 1804 онд Францын колониос чөлөөлөгдсөн Латин Америкийн тусгаар тогтносон анхны орны нэг. Бас тусгаар тогтносон дэлхийн анхны хар арьст улс. Гэвч энэ нь тус оронд ардчилал хөгжих нөхцөл болсонгүй. 1957-1986 онд эцэг хүү хоёр Дювалье үе залгамжлан тус оронд дарангуйлан суужээ. 1986 онд тус оронд дарангуйлыг түлхэн унагасан боловч 1991 он хүртэл тайван байсан үе байхгүй юм. Энэ богинохон зурвас үед 4-5 засгийн газар солигдож, 3 удаа цэргийн эргэлт хийжээ.

1990 оны эцсээр тус оронд бүх нийтийн сонгууль хийж анх удаа ардчилсан төр засагтай болох эхлэлээ тавьжээ. Анхны ардчилсан ерөнхийлөгч болох Жан-Бертран Аристид 1991 оны хоёрдугаар сард үүрэгт ажилдаа орж, тус орон олон жилийн аллага хядлага хямралыг зохицуулах боломжтой боллоо. Гэтэл энэ боломж 7 сарын дараа замхрав. 1990 оны сонгуулийг аюулгүй тайван явуулж чадсан хэмээгдэн шинэ ерөнхийлөгчөөс Гаитын цэргийн ерөнхий командлагчаар томилогдсон генерал Рауль Седрас Аристидыг түлхэн унагаж засгийн эрхийг авчээ. Хямрал дахин сэдэрлээ. Энэ генерал эрх барих хугацаандаа 4000 гаруй гар мухар гаитимуудын амь насыг бүрэлгэж, олон мянган хүнийг эрүүдэв. Олон мянган хүн тэнгис далайг татлан хөрш орнууд руугаа (ялангуяа АНУ) дүрвэв. Энэ хямрал яг 3 жил үргэлжилжээ. Энэ хооронд тус орон дэлхийн хамгийн зожиг тасархай битүү улс орон болж хувирав. Хүний эрх, ардчиллыг улан дороо гишгэж, эдийн засагтаа ямар ч шинэ зүйл хийсэнгүй. Тус орны түүхэн хоцрогдол (100 хүн тутмын 95 нь нэрээ битиж чадахгүй) хямралыг бүр ч архагшуулав. Түлхэгдэн унасан ерөнхийлөгч Аристид АНУ-д дүрвэсэн бөгөөд НҮБ болон Латин Америкийн орнуудаар эцэж цуцалгүй аялж, генерал Седрасын дарангуйлах дэглэмийн эсрэг тэмцэлдээ хүчтэй дэмжлэг хүлээх нөхцлөө бүлтгэжээ. 1993 оноос ерөнхийлөгч Клинтон засгийн эрхэнд гарснаар АНУ түүний бат бэх ар тал болжээ. АНУ-ын шахалт, дэлхийн олон нийтийн шаардлага,

НҮБ-ын хориг арга хэмжээ Седрасыг Аристидтэй хэлэлцээний ширээнд арга буюу албадан суулгав. Гэвч ардчиллыг сэргээн тогтоох тухай амлалтаа Седрас хөсөрдүүлэв. 1994 оны есдүгээр сард Гаити мөхөл сөнөлийн ирмэг дээр тулж иржээ. АНУ-ын засаг захиргааны хувьд тэр онд ээдрээ түвэгтэй олон асуудал тулгарсны нэг нь Гаити болсон юм. АНУ тэргүүтэй олон үндэсний хүч Гаитид халдаж ардчиллыг цэргийн хүчээр тогтооход бэлэн болжээ. НҮБ-ын Аюулгүй Зөвлөл холбогдох бүх зөвшөөрлийг өгчээ. Үүний өмнө АНУ-ын засаг захиргаа, тус орны хууль ёсны ерөнхийлөгч Аристидтэй хэлэлцээр байгуулжээ. Тэр хэлэлцээрийн болзол заалт Аристидийн хувьд ч тийм таатай байсангүй. Тэрээр 1991 онд ерөнхийлөгч болоод 1994 оны намар яг 3 жилийн дараа эх орондоо эргэж очих бөгөөд 1996 онд бүрэн эрхийн хугацаандаа дуусмагц шинэ сонгуульд нэрээ дэвшүүлэхгүй байх, парламент засгийн газрын гишүүд нь 1995 онд хугацаа нь дуусмагц мөн улиран үлдэж ажиллахгүй байх тухай заажээ. АНУ-ын цэрэг орж хууль журмыг сахиулж, ардчилсан засаглалыг сэргээх бөгөөд тодорхой хугацаа өнгөрсний дараа АНУ-ын цэргийн халааг НҮБ-ын хүчинд шилжүүлэхээр товложээ.

АНУ ийм төлөвлөгөө сэдэхдээ юуны өмнө Гаитын хямралын уг сурвалж болсоор ирсэн цэргийн генералитетийг эвдэх нөдлийг чухалчилсан юм. Тэгэхийн тулд Гаитид байнгын зэвсэгт хүчин байлгахгүй байх, армийг нь ердөө 1500 цэрэгтэй, цагдаагийн хүч нь түүнээс хоёр дахин байхаар тооцоолсон юм. Тийм учраас Гаитын цэргийнхийг армиас халах, тэдэнд тэтгэвэр тэтгэмж олгох, тэднийг хөдөө аж ахуй, барилгын мэргэжлээр сургах зэрэгт наад зах нь 12.5 сая доллар зарцуулахаар болжээ. Цаашлаад цэргийнхний гарт төвлөрч байсан аж ахуй газруудыг хувьчлах, шүүх засаглалыг нь бэхжүүлэх, цагдаагийн аппаратыг бэхжүүлэх, улмаар шинэ сонгууль явуулах, түүний бэлтгэл ажил зэрэгт бараг 100 гаруй сая доллар төсөвлөхөөр шийдэв. Ер нь л АНУ тэндээс дахин хямрал дэгдэхгүй байх бүх урьдчилсан нөхцлийн бодож боловсруулсан юм. Хэрэв энэ бүх болзолыг хүлээн авбал дарангуйлагч дэглэмийн толгойлогчдыг шүүхэд татахгүйгээр эх нутгаа орхин явахыг зөвшөөрөх, тэдний гэр бүлийн аюулгүй амьдралыг хангах, эс хүлээн авбаас зэвсэгт халдлага хийхээр түлгэлжээ. Энэ болзлыг Седрас эхэндээ хүлээн аваагүй. Үүний хариуд АНУ-ын десантын нисэх онгоцууд агаарт хөөрч, хөлөг онгоцууд Гаити рүү хөдөлжээ. Бас дипломатын сувгийг давхар ашиглан АНУ-ын ерөнхийлөгч асан энхийн энхийн элч Ж.Картер дарангуйлагч Седрастай уулзахаар Гаитын нийслэлд очжээ. Түүний үүчинхэн хүчинд байлдажгүйгээр асуудлыг шийдэв. Гаитид ийнхүү ардчиллыг сэргээж, бүс нутгийн шинжтэй бас нэг тономтыг зохицуулсан юм.

Бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар богино хугацаанд хохирол болгоны үр дүнд хүрсний тодорхой жишээ ийнхүү Гаити

боллоо. НҮБ болон олон улсын хамтын нийгэмлэгт ингэж амжилт олсон жишээ цөөхөн. Тэгээд ч уг үйл явдал 1994 оны дэлхийн 10 том үйл явдлын нэгд зүй ёсоор тооцогдсон. АНУ хүчээр далайлган Гаитын хууль ёсны ерөнхийлөгчийг эргүүлж аваачсанаараа "Гурав дахь ертөнцийн" оронд ардчиллыг тулгаж болдог гэдгийг нотлон харуулах гэсэн байж магадгүй. Энэ нь тусгаар тогтносноосоо хойш өнөө хүртэл хөлөө олохгүй будилж яваа зарим орны хувьд сонгож болох улс төрийн шинэ загвар юм. Нөгөө талаас НҮБ-д том туршлага сургамж боллоо. Хоёр туйлт ертөнцийн тогтолцоо төгсгөл болсноор ардчиллыг хэмжих хэмжүүр дэлхийн хэмжээнд ойртсон. Ингэж ойртсоны хүчинд Гаити мэтийн оронд ардчиллыг албадан тогтооход хялбар гэдгийг үнэмшилтэй харуулав. Энх тайван, ардчилал, хүний эрх өөр хорондоо салшгүй холбоотой бөгөөд энэ гурав нийлж байж хөгжлийг хангана. Хөгжлийн хэрэгцээ бол ердөө л энэ 3 хүчин зүйл. Түүнийг хэн нэгэн дарангуйлагч буюу дарангуйлах засаглалд сул орхиж болохгүй. Түүнийг нийтээрээ хамгаалж бэхжүүлэх ёстой гэдгийг Гаити харуулав. Бас НҮБ-ын шуурхай ажиглах мэдварыг харуулсны хувьд бусдад нөлөөлөх үлгэр жишээ болох ёстой. Содрас шиг дарангуйлал дахин өөр хэлтэй гэрээ гэрээгүй гэх тааргүй. Одоо ч хэлбэр дүрсээ өөрчлөөд нийт гэр оронд аюул учруулж байна. Олон улсын байгууллага, олон улсын хууль зүйг үл тоомсорлогчид бүс нутгийн аюулгүй байдалд заналхийлсээр байна. Тийм этгээдэд Гаити том сургамж болох учиртай.

ЗУРГАА. ДҮГНЭЛТИЙН ОРОНД

1. Найм, есдүгээр бүлэгт хөндсөн асуудлыг эргэж нэг харъя Дэлхий дахинд хагас зуун жил ноёрхсон "Хүйтэн дайн" өндөрлөж, бие биеэ сөрөн зогссон хоёр туйлт ертөнцийн бүтэц задарсан нь нэг талаас ололт амжилт, нөгөө талаас шинэ шинэ асуудал авчрав. Өөрөөр хэлбэл, дэлхий ертөнц хуучин харилцааны системээс шинэ рүү шилжих шилжилтийн зурвас үед, хэлж мэдэхгүй тодорхойгүй үедээ байна. Дэлхийг хамарсан дайн дажин дэгдэх аюул энэ шинэ нөхцөл байдалтай уялдан арилсан ч бүс нутги, салбар бүс нутаг, хөгжиж буй гэгдэгч ертөнцөд орон нутгийн дайн мөргөлдөөн, хямрал дэгдэх магадлал өсөв. Яагаав гэнэн хоёр туйлын нэг тал ЗХУ тэргүүтэй социалист систем задарснаар онгойсон сул орон зайг бөглөх гэж санаархагчид олшрон. Бүс нутгийн шинжтэй гүрнүүд, эсвэл тийм статусыг олж авах гэж илэрхий оролдож буй зарим орон цэрэг-стратегийн хүч нөөцөө бэхжүүлж байгаа учраас хэт их гүрний статусаа хэвээр авч үлдсэн цорын ганц улс-АНУ нөлөө байр сууриа хэвээр хадгалж байхад бэрхшээлтэй боллоо. Урьд нь хэний ч санаанд оромгүй нуугдмал оршиж ирсэн орнууд одоо дэлхий дахиныг түгшүүлэх хэмжээнд ялгаран гарч иржээ.

Тухайлбал, Серби, Ирак, БНАСАУ, Гаити үүний тодорхой жишээ юм.

2. "Хүйтэн дайны" үед аюул, түүний уг сурвалжийн тухай дууриал хэнд ч ойлгомжтой байсан. Гэтэл энэ ойлголт одоо олон улсаар хэлбэр дүрс нь байнга өөрчлөгдөж, хувьсаж, зарим үед хэлбэрээс гарах дөхөж байна. Хэрэв ийм хувьсал орон зай, цаг хугацааны хязгаарлагдмал орчинд явагдах ахул дэлхийн хамтын нийгэмлэг хяналт тавих, адаглаад тэр орчинд нь бариад байх боломжтой. Хэрэв хязгааргүй орон зайд тархах аваас нэж ч хүчрэхгүй болно. ЗХУ болон Югослав задарснаар аюулгүй байдлын асуудал шал өөрөөр тавигдлаа. Цөмийн зэвсэгтэй, цэрэг-стратегийн хүчтэй нөлөөтэй гүрэн олон улсын тавцнаас алга болсноор Өрнөд Европ, АНУ-д учирж байсан цөмийн зэвсгийн аюул арилсан, гэвч хуучин Зөвлөлт, Югославын суурин дээр үүссэн орон зайд бий болсон тогтворгүй байдал, мөргөлдөөний боломжууд дахин өөр нэг аюул заналыг бий болголоо.

3. Цэргийн эвслүүд бутарсан (жишээ нь Варшавын гэрээний байгууллага) буюу үүрэг нөлөө нь өөрчлөгдсөнтэй холбогдон олон улсын байгууллагуудын үүрэг роль цаашид нэмэгдэх хандлага ажиглагдав. Үүнд НҮБ сонгодог үлгэр дууриал үзүүлэх ёстой. 1991 онд Иракийг цээрлүүлэхэд НҮБ оролцсон, цаашлаад Сербийн эсрэг хориг арга хэмжээ авсан. Боснид НҮБ-ын мандатаар цэргийн ажиллагаа явуулсан зэрэг нь үүний анхны жишээ. НҮБ хийж хүчрэх юман дээрээ бие дааж шийдвэр гаргах ёстой, эс хүчрэх юман дээрээ нөлөө бүхий бусад гүрэн юуны өмнө Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүддээ, цаашлаад Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал, НАТО болон бусад байгууллагад хандах болж байна. Энэ бол 90-ээд оноос олон улсын практикт нэвтэрч хэвшиж буй шинэ үзэгдэл юм. Гэхдээ энэ нь төгс төгөлдөр болчихсон, нийтээрээ хүлээн зөвшөөрч буй зүйл биш. Энэ талаар нэлээд маргаан зөрчил бий. НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын гишүүн орнуудын дотор ч уг асуудлаар санал нэг биш байна. Тэгэхээр олон улсын харилцаанаас хямралыг зайлуулах шинэ практик хэвшүүлэх гэж дэлхийн хамтын нийгэмлэг оролдож буй энэ үед түүнд тууштай дэмжлэг үзүүлэх ёстой. Тэгэхгүйгээр бат бэх энх тайван, аюулгүй байдлыг хангах боломжгүй.

4. Бүс нутагт бат бэх энх амгалан байдлыг албадан тогтоож болно гэдгийг энэ хэдхэн жил дэлхий дахинд үнэмшилтэй харуулсан явдал анхаарал татаж байна. Ийм албадлагыг НҮБ хагас дүүн жилийнхээ түүхэнд хийж хүчрээгүй, хийх ч бодит боломж байгаагүй. Үүнийг Камбож, Гаитид харуулав. Гэхдээ энэ бол ердийн нэг цэргийн ажиллагаа биш юм. Түүний цаана асар их үнэ тавих ёстой. АНУ-аас Гаитид ардчилал, энх тайвныг тогтооходоо тавьсан болзолууд үүнийг харуулав. Бас нэгэнт л ингэж явагдах механизм хэрэглэж байгаа бол арыг нь найдвартай дааж гар татахгүй туулах өөртэй гэдгийг АНУ итгэл үнэмшилтэй харуулав.

Хэрэв НҮБ ийм албадлагыг хийхээр шийдвэрлэсэн бол НҮБ-ын гишүүн бүх улс түүнийг үг дуугүй дагадаг байх ёстой. НҮБ-ын Дүрмийн өмнө гишүүн орнууд адил эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ. Хэрэв НҮБ-ын Дүрмээр хүлээсэн үүргээ зөрчвөл олон улсын хуулийн дагуу хариуцлага (цээрлэл) хүлээх ёстой. Үүнийг Гаити, Серб, Иракийн жишээнээс харж болно.

5. Гэхдээ тухайн аль нэг улс үндэстэн аюулгүй байдлаа бүгдийг нь дан ганц НҮБ юмуу, олон улсын хуульд даатгаж болохгүй. Аюулгүй байдлаа ардчилал, хүний эрх, хөгжлийн асуудалтай нэгт үйлдүүлэхгүйгээр хямралыг тойрч гарах аргагүй. Энэ бүгдийн ганцүү хослол аюулгүй байдлын найдвартай баталгаа болно, хэрэв энэ бүгдийн аль нэг нь доголдох, эсвэл санаатай орхигдуулах нэмж хямрал нүүрлэнэ. Тэгэхдээ НҮБ юмуу, АНУ, өрнөдийн ардчилсан гүрнүүд энэ бүхнийг ямагт зааж сургаад байх албагүй.

6. "Хүйтэн дайны" төгсгөлийн шүүд нөлөө, НҮБ-ын чармайлт, их гүрнүүдийн нэгдмэл үйл ажиллагаа бүс нутгийн шинжтэй зарим мөргөлдөөнийг бүрэн зохицуулах боломж олгов. Энд би Ойрхи Дорнод, Камбож, Африкийн өмнөд хэсгийг жишээлье. Гэтэл ийм зохицуулалт хийх боломж үлэм бүр хомсдож байгаа Босни, Сомали, Түмэнгийн өрнөд бүс нутгийн Афганистан, Руандад ямар үр нөлөөтэй механизм харагдах вэ? Гэдэг асуудал нэг хэсэгтээ дэлхийн хамтын нийгэмлэгийн анхаарлын төвд байх бололтой. Бас үүн дээр Алжир, Турк-Курдын асуудал, БНАСАУ, Пакистан нэмэгдэхгүй гэх аргагүй. Олон улсын хууль зүйг лалын шашны мухар сүсгээр хэмжих гэсэн лалын хэт даврагчид, фундаментализм энд тогтворгүй байдлын нэг хүчин зүйл болж эхлэв.

Энэ бүхнээс үүдэн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа хойшид олон салбарлаж, олон талтай болох магадлал бий боллоо. Зөвхөн сэргэлдэгч талуудтай бус шашны олон урсгал, бүлгүүд, олон үндэстэн ястан, омог-аймгийнхны хооронд зуучлах хэрэг гарах нээ. Үүнд НҮБ болон бүс нутгийн бусад байгууллагыг бэлтгэх ёстой болж байна.

Холбогдох ном, хэвлэл

1. Sipri Yearbook 1994, World Armaments and Disarmament, Oxford University Press, 1994.
2. Sipri Yearbook 1993, World Armaments and Disarmament, Oxford University Press, 1993.
3. Robert W. July. A History of the African People, Wareland Press, 1992
4. Arthur Goldschmidt, A Concise History of the Middle East, Westview Press, 1988
5. Chaim Herzog The Arab-Israeli Wars (War and Peace in the Middle East) Vintage Books, 1984

6. Martin Gilbert. The Arab-Israeli Conflict (Its history in Maps) Steimulzky LTD, 1992
7. Susan Huttis Rolef, Editor. Political Dictionary of the State of Israel. The Jerusalem Publishing House, 1993
8. Howard M Sarhar. The Course of Modern Jewish History. The Classic History of the Jewish People, From the Eighteenth Century to the Present Day. New Revised Edition.

ТӨГСГӨЛИЙН ҮГ

"ДЭЛХИЙН БОДЛОГО БА ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА: 90-ЭЭД ОНЫ ҮНДСЭН ХАНДЛАГА" номын үндсэн хэсэг, бүлэг, дэд бүлгүүдтэй Та бүхэн танилцлаа. Энэ номд бичсэнээ төгсгөлд нь базаж дүгнэхийг оролдъё.

1990-ээд оны өмнөх олон улсын харилцааны тогтолцоог "Хүйтэн дайн" тодорхойлж байсан билээ. "Хүйтэн дайн" өөрөө эрс тэс хоёр үзэгдлийг дагуулж ирсэн. Тэр нь *1. Түгшүүртэй байдал; 2. Намжмал байдал*, энэ хоёр бие биенгүй байх аргагүй, харилцан бие биеэ нөхсөн үзэгдэл, үйл явц байсан билээ. "Хүйтэн дайнаар" бий болсон олон улсын харилцааны хямрал дэлхийн коммунист систем сүйрснээр аяндаа алга болсон. "Хүйтэн дайныг" төрүүлж байсан тэр нийгэм-улс төрийн байгуулал, түүний цаадахы хүч үгүй болмогц уг дайн утгаа алдсан. Үүнийг 1990 оны намар Парист хуульчлан тунхагласан "Харти" баталснаар албан ёсоор эцэслүүлэв. Ингээд олон улсын харилцааны нэг үе шувтарч, "Хүйтэн дайны" дараахи шинэ үе эхлэв. Энэ шинэ үе ердөө дөрөвхөн жилийг арван үлдээл байна. Энэ утгаарда түүнийг түүх болгон дүгнэж цэгнэхэд эртдэнэ гэсэн үг. Тэгээд ч маргаантай олон асуудал шийдлээ хүлээж байна. Энэ үеийн зарим онцлогийг эргэж дүгнэхдээ өнгөрсөн 4 жилд бид ямар ямар үзэгдэлтэй тулгарч, хэрхэн хариу өгөв гэдгийг авч үзэх ёстой.

1. Дэлхийн улс төрийн зүтгэлтэн, дипломатууд, судлаачдын хувьд олон улсын харилцааны шинэ үе огцом, гэнэтийн, цаг хугацаа - орон зайны хувьд тааварлашгүй шинэ байдлыг гаргаж ирлээ. Ер нь дэлхийн улс төрийн уур амьсгал ингэж өөрчлөгдөнө гэдгийг урьдчилан харж, тааж бэлтгэж байсан улс үндэстэн, олон улсын байгууллага нэгээхэн ч байхгүй. Тэгэхдээ бидний хүссэнээс, мө- рөөдөж байснаас өөрөөр эргэж, айдас түгшүүрийн шинэхэн харанга дэлдэв үү гэлтэй дүр зураг бий болжээ.

2. Дэлхий дахин зэвсэглэлээр хөөцөлдөх, батлан хамгаалахад асар их зардал урсгах тэр үеэ үдсэн бус, дахин зэвсэглэх, тэгэхдээ бүр ч адгуу, тааварлаж хэлэх аргагүй байдалд зохицож зэвсэглэх үе рүү орох шиг боллоо. Бүс нутгийн мөргөлдөөний голомт урьд нь Ойрхи болон Дундад Дорнод, Африк, Төв Америк хавьд төвлөрч их гүрнүүдийг шууд түгшүүлэх хэмжээнд очдоггүй байсан бол одоо энэ хямрал соёлжсон Европын хаяанд тулан ирж, цааш халдварлах аюул бий болгов. Үүнийг ноцтой баримт гэж үзэж байна.

3. Урьдын хоёр системийн зөрчил, хоёр туйлын сөргөлдөөн түүх болсон нь гарцаагүй боловч сөргөлдөн зөрчилдөх шинэ үе эхэлжээ. Энэ бол үзэл суртлын - ангийн гэхээсээ их гүрнүүдийн нөлөөний хүрээний төлөө тэмцэл шинжтэй болж ирлээ. Урьдын Зөвлөлт, өнөөгийн ТУХН-д ангийн эрх ашиг үгүй болсон ч эзэнт

гүрний урьдын эрх дархаа хадгалж байх эрх ашиг зүй ёсоор тавигдлаа.

4. Дэлхийд өөр хаана ч байгаагүй нэгэн том эзэнт гүрний мөхөн гадж хэлэх аргагүй олон үзэгдлийг дагуулж ирлээ. Өөр хоорондоо ижилсэх юмгүй, Европ-христ, Ази-лалын ертөнцийн олон үндэстэн ястанг хүчээр нэгтгэж байсан энэ гүрэн задралын хил эхний үеийг ардаа хийжээ. ЗСБНХУ-аас ТУХН үүссэнийг хэлж байна. Дараагийн үе нь ТУХН-ийн орнууд дотроо хагарч бутрах аюултай нүүрлэнэ. Улс төр судлаачдын таамагласнаар энэ үйл явц 30-40 жил үргэлжлэх ба үүнд хамгийн их хэлмэгдэх нь Орос болох болов уу. Энэ бол таамаглал боловч үнэнээс нэг их хол зөрөхгүй байх. ТУХН байгуулагдаагүй байхад ингэж задрах хөрс нь бий болсон юм. Жишээ нь, Орос, Молдов, Гүрж, Азербайжан, Украин нь салж бутрах үзэгдэлтэй аль ЗСБНХУ-ын үед тулгарсан шүү дээ.

5. Энэ задралын нөгөө талд Европын интеграц эрчээ авлаа. Ази-Номхон далайн орнууд АПЕК-ийг тойрон нэгдэх үйл явц эхэллээ. Учир нь задран салж, дайн дажинд нэрвэгдэж, эдийн засаг нь хямарч, цөмийн зэвсэг нь найдвартай бус байгаа ТУХН-өөс үүдэх шинэ аюул тэднийг нэгтгэх зайлшгүй нөхцөлийг тулгаж байна. Ялангуяа, жижиг давчуу нутаг дэвсгэртэй, хүн ам шигүү, үйлдвэрлэл өндөр хөгжсөн, хүн амын баялаг амьдралыг бүтээсэн, улс төрийн ардчилал нь боловсронгуй, хүний эрхийг дээдэлдэг Өрнөд Европынхны хувьд түгших аюул нэн их байна. Учир нь учирч болох шинэ аюул тэднийг хайрлахгүй, тэдэнд алдах юм их байна. Гэтэл ТУХН, Хуучин Югослав дахь мөргөлдөөнөөс хожоо гарахгүй ч, уг мөргөлдөөнд оролцож буй хүчнүүдийн хувьд алдах юм үгүй. ТУХН-тэй хил залгаа Дорнод Европын шинэ ардчилсан улсууд, Балтийн 3 улс, Алс Дорнодод Япон, Өмнөд Солонгос, магадгүй Монгол ийм бодит аюулыг өнөөдөр хамгийн их мэдэрч байна.

6. Цөмийн зэвсэглэлийн асуудал өөрөөр эргэв. Зөвлөлт-Америк, дараа нь Орос-Америкийн байгуулсан СТАРТ-1, СТАРТ-2 гэрээгээр дэлхийд хуримтлагдсан цөмийн зэвсгийн сан үлэмж багасах төлөвтэй байгаа. Гэтэл нэгдмэл ЗСБНХУ задарснаар шинэ бийдал бий боллоо. Оросоос гадна Украин, Белорусс, Казахстан цөмийн зэвсэг эзэмшигч болжээ. Энэ бол асуудлын өнгөн тал. Шийдэж болох тал. Гэтэл нөгөө талд нь эдгээр зэвсгийг задалж бүүснэх бүгдийг нь Орос руу зөөж, тэнд төвлөрүүлж устгах, зөөгч хэрэгсэлүүдийг задлах, пуужингийн бааз цооногуудыг цэвэрлэх, цэвэрлэж буй офицеруудыг ажлаар хангах, энэ явцад цөмийн зэвсэг, түүхий эд материал алдагдах, тархах аюулаас сэргийлэх гэх мэт шийдмээр өдий төдий асуудал бий. Цөмийн зэвсгийн хадгалахын сул, үйлдвэрлэл нь хоцрогдолд орсны гайгаар гэмт хэрэгсэлүүд түүнийг эзэмших, хил давуулж наймаалах, энэ орон зай дээр цөмийн зэвсэг эзэмшигч шинэ улс бий болох (БНАСАУ, Ирак, Иран, Ливи гэх мэт) аюул бодитой оршиж байна.

7. Дэлхий дахины анхаарал хуучин социалист гэгдэх улсууд руу ийнхүү төвлөрснөөс бүс нутгийн чанартай асуудал аяндаа шийдэгдэх болов. Урьд нь хоёр системийн зөрчлийн хурц илрэл хөгжиж буй орнууд руу ихээхэн төвлөрч байсан. Одоо байдал өөрөөр эргэж буйг Африкаар авч үзье. Ангол, Мозамбикийн иргэний дайн (хэрэг дээрээ социалист чиг баримжаа - өрнөдийн үнэт зүйлийн хоорондын зөрчил) аяндаа зогсов. ӨАБНУ-д улс төрийн хямралыг зохицуулж чадлаа. Ойрхи Дорнодод арабчууд Израилтай хэл амаа ололцож байна.

8. Дэлхийн тавцнаас нэгэн эзэнт гүрэн алга болж, түүний суурин дээр өв залгамжлагчид нь үр дүнгүй сөргөлдөж байгаагаас түүний эргэн тойронд хүчний харьцааны шинэ хуваарилалт явагдаж байна. Жишээ нь, Ази тивд хэзээ ч тэгтлээ нөлөөтэй байгаагүй, Европт нөлөөлөх хэмжээнд очиж байгаагүй лалын бүхэл ертөнц (систем) бий боллоо. Урьд нь Иран, Афганистанаар хязгаарлагдаж байсан энэ шинэ хүрээ ТУХН-ийн талыг эзэлж, улам цаашилж байна. Босни дахь мөргөлдөөн тэдэнд Европ руу ойртох боломж бүрдүүлэв. Ази дахь Зөвлөлтийн суларсан орон зайг бөглөх үйл явц ихээхэн адармаатай явагдаж байна. Эдийн засгийн хувьд Хятад, Энэтхэг, Азийн барууд, Япон гэх мэт олон "пирамид" гарч ирэн Цэргийн стратегийн хувьд АНУ, Хятад хоёр өрсөлдөж мэдэх байдал бий болов. Тэгээд ч Хятадын ацалсан, туйлбаргүй гэмээр байр суурь байдлыг ихээхэн ойлгомжгүй болгож байгаа.

9. ЗСБНХУ-ын задралаар коммунизмын аюул ариллаа гэж дүгнэх нь учир дутагдалтай. Энэ аюул өнөөгийн Хятад, БНАСАУ-аас гарах нь юу л бол. Энэ аюул эргээд Зөвлөлтийн буурин дээр амилж мэдэх юм. Гэхдээ үндсэрхэг, их гүрний, хонзогногч, фашист, монархист үзэл сурталтай холилдон гарч ирэх аюул илүү бодитой. Нөгөө талаас, хуучин коммунист суртлыг үндсэрхэг үзэл ёс мэт өвлөн авч орлож байна. ТУХН, хуучин Югославын жишээн дээр үүнийг ажиглаж болно. Тэгэхээр Өрнөдийн ардчиллыг хамгаалахын тулд "Хүйтэн дайны" өөр нэг хувилбарыг бий болгож ч мэдэх юм.

10. Олон улсын харилцаанд үйлчлэх ёстой ямар хүчин зүйл байна вэ? гэдэг маргаан ч намжихгүй байна. Хоёр системийн үед хоёр их гүрэн олон улсын харилцааны тогтолцоог тодорхойлж байлаа. Тэр хоёрын цэрэг - стратеги, эдийн засгийн хүч чадал, нийгмийн үнэт зүйл эргээд хүч болж дэлхий дахинд нөлөөлж байсан хэрэг. Хүчний эсрэг талд олон улсын хууль зүйг шүтсэн олон улсын байгууллага үүрэг гүйцэтгэдэг. Ингээд хүч үү, эсвэл олон улсын байгууллага уу? гэсэн хоёр сонголт гарч ирнэ. Хоёр системийн эсрэгцэл алга болж, "Хүйтэн дайн" шувтарсан учраас хүч байх шаардлагагүй, дэлхийн засгийн газар маягтай систем бий болгох ёстой гэж үздэг хандлага бий. Гэтэл 1990 оноос хойш хүч гол үүрэгтэй гэдгээ илүү тод харуулсан төдийгүй хүчгүйгээр

дэлхий дахинд энх тайвныг хамгаалж болохгүй нь харагдаж байна. АНУ-ын гадаад бодлого дэлхий дахинд энхийг сахиулах чиглэлээр (НҮБ-аар дамжуулан) идэвхжиж байгаа жишээ бэлхнээ байна

Өнгөрсөн 4 жилд олон улсын харилцаанд тохиолдсон үйл явдлуудыг ингэж томъёолж, дүгнэж болох юм. Гэвч энэ бол зохиогч миний хувийн үзэл бодлын илэрхийлэл болохоос бүх хүн түүнтэй санал нэгдэх албагүй. Гол санаа нь номд бичсэнээ нотлоход чиглэсэн бөгөөд аюул түгшүүрийн бүс улам наашилж байна гэдэгт энэ маань оршиж байна. Үүнээс үүдэн Монголын үндэсний аюулгүй байдлын асуудлыг хөндсөн шинэ орчин бий болж мэдэх юм. Энэ аюул умар зүгээс наашилж яваа. Гэвч Монголтой хил залгаа Оросын нутагт мөргөлдөөний ноцтой голомт алга. Гэхдээ төвдөө улс төрийн хямралтай, эдийн засаг нь замбраагүй, гэмт хэрэг байнга өсч, салан тусгаарлах явдал хэрээс хэтэрч цус урсгах хэмжээнд (Чечень) хүрснийг бодолцвол Монголд ямар нэг хэмжээгээр нөлөөлөх магадлал бий. Бас баруун талд лалын ертөнцөөс ямар асуудал гарч ирэхийг урьдчилан таашгүй. Тажикистан дахь иргэний дайн лалын ертөнцийг түгшүүлэх хэмжээнд өрнөв. Нөгөө талаас, лалын хэт даврах үзэл хаяагаа тэлж байна. Ингээд бодоход Монголын аюулгүй байдалд умардаас, баруун талаас хоёр хүчин зүйл нөлөөлж болзошгүй гэж таамаглаж болох байна.

*1995 оны зургадугаар сар.
Улаанбаатар хот.
МУҮИС-ийн ОУХДС*

A SUMMARY OF THE BOOK "GLOBAL POLITICS AND INTERNATIONAL RELATIONS: KEY TRENDS OF THE 1990'S "

In 1994 the author D. Bayarkhuu published a book "International Relations in the Twentieth Century", in which he attempted to throw new light on major international events after 1990. This book was unique in the sense that the author sought to alter the notion that the history of the twentieth century was a history of class struggle, and in particular, he made an attempt to interpret phenomena and events in inter - state relations from a non - class position . What is even greater significant is that this was the first book ever to be published in Mongolia which comprehensively dealt with international relations

In his new book, the author takes up the issue of the new trend in international relations after 1990. This second book by this author is in itself a continuation of his previous work which ends with international events up to 1990. It is not an easy task to define "post - Cold War" international relations, this is because, the events in the last few years cannot be considered, firstly, as a history and as history - making events; secondly, the entire world is making a transition from a bipolar system to a multi - polar one. In this sense, this could very well be called a transition period. Thirdly, this period of transition is rather ambiguous and unpredictable. Hence, it would be premature to draw any conclusion. Since ambiguity is to be dealt with, it is almost impossible to predict the future, and if any prediction is made, it cannot but be an extremely general prediction.

The author has divided the book into three main chapters, the chapters into sections, sections into sub - sections, sub sections into concrete topics, in other words, the approach could very well called unique.

Chapter one has the general heading: "Post - communism and international relations". Under this heading, the author, one, deals at length with the evolution and growth of the former USSR, the

present Commonwealth of Independent States, the present - day pressing issues, political and economic crisis and the future prospects of these countries. The author gives a year - by -year chronology of events starting with the August 1991 coup attempt of the so - called "State Emergency Committee" and then deals with separate regions and issue by issue. The author agrees and provides ample evidence that the disintegration of the Soviet Union was predetermined by the natural course of history. At the same time, he does not think that the appearance of the Commonwealth of Independent States was inevitable, because its emergence bore a conspiratorial nature and was illegal since it was formed without the consensus of all the 15 republics that initially formed the Soviet Union. It is an open secret that the meeting of the Presidents of Russia, the Ukraine and Belorussia in Belovesch gave rise to many a conflicting and insoluble problems. At that time nobody suspected what formidable difficulties would be encountered because of the inconsiderate handling of the matter. The consequence of this ignorance is being suffered even today. In this sense, the author finds it hard to give any definition of the relations between the CIS member countries from the stand - point of international relations. For instance, the CIS cannot be likened either to the British Commonwealth, the European Union or APEC. If we consider the CIS an international federation or union, we find that its 12 member countries are not federated to each other. What' s more, the war between Armenia and Azerbaijan is persisting. What common interests, if any, do Tajikistan and Moldova, Armenia and Belorussia have? That is why, the issue of the international status of the CIS was controversial from the very beginning and will remain so in the future. Since the CIS was not formed in keeping to international law and existing global practice, the commonwealth is extremely fragile and short - lived.

The disintegration of the Soviet Union had both positive and negative consequences world - wide. The positive thing about it was that the downfall of the USSR put an end, once and for all, to the "Cold War", the armaments race and regional conflicts. The USSR

itself was on the other end of the bipolar world, and with its destruction the world was no longer divided, artificially, into two conflicting military, political and ideological camps. Mankind was eventually rid of the dark cloud of totalitarianism and Stalinism. The negative thing was the establishment of shaky nation on the foundation of the once - almighty empire. Because of the hostility amongst them, the world has come face - to - face with a new stage in international tension. If the hostility between the two systems created international tension in the past, then today the CIS itself has become the breeding place of such tensions. This is evidenced by regional wars and conflicts, political crisis, ideological confusion, and the reemergence of national revanchism, neo - Bolshevik conservatism, separatism and fascism in the CIS. Today, the CIS has come face - to - face with the influence and dangers of Islam, which is one of the factors that could destabilize this vast country. In the long run, the CIS could likely become an arena of concentration of contradiction between Christianity and Islam, East and West.

Two. The next section takes up the issue of the influence of the formation of CIS on international relations and global policy. The author first looks at the attitude of the USA, Western European countries, NATO, Conference on Security and Cooperation in Europe (CSCE) towards the CIS. Neither the United States nor the Western European countries suspected that they would have to deal with an unstable and unreliable partner in the face of the CIS. This is precisely why truly equitable partnership relations are not being developed between the United States and the Russian Federation, the United States and the CIS. Similarly, Western Europe is unable to choose the right strategic and tactical approach in its relationship with Russia and its close partners. Owing to instability and unpredictability in the CIS, the Western partners are somewhat reluctant to support its reform policy. Democracy is slow in coming and human rights violations are rampant in the CIS, which cannot be encouraged. However, the CIS needs help and this help must be extended.

As the legitimate successor of the Soviet Union, equitable partnership with the Russian Federation is essential. However, the real state of affairs are not conducive to such a partnership. For the West, domestic political life in Russia is not as important as is the insurance of long - term stability, which is one of its single most important objective. A country which does not have strategic stability, where the life of the people is going downhill and where crime is rampant, does not shoulder any responsibility whatsoever for global peace. This unstable country possesses enormous stockpile of nuclear and conventional weapons, and has millions of soldiers. This basically causes the concern of the United States, Western Europe and Japan. International institutes in Europe are unable to cope with the persisting regional wars and conflicts, human rights violations, and the persecution and raping of minorities in the CIS. The taking in of all the CIS members to the Conference on Security and Cooperation in Europe could have negative consequences in the long - run. This is commonly acknowledged and consequently, it is imperative to renew the duties and tasks of this organization.

The second part of this section deals with Asia. The foundation of the CIS did not have much of an impact on Asia. Since the Soviet Union was conducting an erroneous and ruinous policy in Asia, Soviet policy did not leave behind deep impression on any other part of this region other than Mongolia. This is why, the Asians are not concerned with the internal crisis in the CIS. It is quite natural that the neighboring Islamic countries made attempt to fill up the vacuum in Central Asia after the collapse of the Soviet Union. Linked to it are the expansion of Islam fundamentalism and the attempts of Iran, Turkey, Iraq and Afghanistan to distinguish themselves on the international arena. The nuclear scandal of the Democratic People' s Republic of Korea in the Far East and international focus on that country is yet another similar desire to fill up the vacuum.

Three Section three of chapter one deals with the post - communist and communist countries of the 1990' s. With the

collapse of the world socialist system, all countries under this system, big and small, entered into motion, which had different impact on all individual countries. To some it brought social progress, while social regress to some others. Eastern European countries and Mongolia gained genuine political independence. The developed nations of Eastern Europe once again obtained the possibility to join in the great European culture and civilization. During "Cold War" these countries were deliberately isolated from the great European culture and civilization with the

"Iron Curtain". In the 1990' s, thanks to democracy some countries, such as Slovak, Macedonia, Croatia, Slovenia, and Bosnia were able to break away from the shelter and influence of the great nation and the great empire. Thanks to democracy, some of these countries returned to free - market relations, which they had prior to 1945, thus regaining the possibility to develop their economy. Communist countries like China and Vietnam have recorded impressive success by blending free - market relations with nationalism. But neither the DPRK, some of the CIS countries nor Cuba have accomplished anything significant.

The entire post - communist and communist countries, according to the scale and scope of reform, renewal and transition process, have been divided into the following four categories. 1. A group of countries where both political and economic reforms could be successful; 2. A group of countries where political reform is successful, however, economic transformations are slow and crisis - ridden (Mongolia is included in this group); 3 Countries where economic reform is crisis - free and successful but in politics, democracy is trampled underfoot and human rights are violated, and, 4. A group of countries which neither has political nor economic reform as such.

The author looks at the post - communist countries according to regions - European and Asian post - communist countries. The last part contains a sub section entitled "Post - communism and the international communist - worker' s movement." This sub - section looks into the causes leading to the collapse of the world communist

movement, and referring to concrete facts the author indicates that this movement has met its doomsday and there is practically no hope for its revival. This sub - section was specially included in the book because there are still quite many people in Mongolia who once believed in the existence of this movement and continue to do so and has been done to help them understand that this movement is no longer existent.

In 1994 the author visited the European Parliament which coincided with the elections to this parliament. Basing on the election returns and the ratio of socialist and communist members in the European Parliament, the author writes that the communist movement in Europe has become history, the Europeans never considered this movement a reality and never would believe in it in the future.

Chapter two of the book is entitled "Global economy and international relations". It has three sections, each under separate heading: "The Group of Seven and Global Economy", "European Union," and "The Third World and Global Economy". This chapter has been written in a rather interesting manner. The author is not a trained economist, but while attending a refresher' s course in the Netherlands in 1994, he attended classes dealing with global economic system. In writing this chapter, the author has used the knowledge he obtained at the " Erasmus " University in Rotterdam, and the "European Center" of International Economy and Commerce in the Netherlands, as well as related books, materials and publications. The author was able to substantiate his theoretical knowledge with practicals when he did his practicals at the European Union and the Organization for Economic Co - operation and Development in Paris.

The teaching of free market economy became quite common in Mongolia starting 1990, however, it is not very common to consider it in link with global economy and its trend. It is quite unique for an international relations expert to consider such issues as the Bretton Wood institute, the question of creating a new global economic order, the evolution, growth and influence of the G - 7, the

key mechanism of international economy of Europe, the European Union etc. The section dealing with the numerous oil crisis, oil and politics and their impact on global economy is of particular interest. A comparative study of the international economic policies of the major G - 7 countries like the United States, Federal Republic of Germany and Japan is totally new approach. The author shows how the United States, which although founded Bretton Woods - the key post - war international economic system - gradually losing its economic influence, and how Japan and Germany have attained the present level of progress. In the meanwhile, Great Britain has been constantly losing its influence and position.

2. The evolution and growth of the European Union has been presented in the form of a historical chronology. When it was first emerging in the 1950' s nobody then imagined that it would grow to become such a powerful union. This union passed several stages of its development in keeping the then global policy. General Charles de Gaulle' s accession to power in France weakened Great Britain' s influence in Europe, and in Western Europe, when France and Federal Germany consolidated their position. Britain was almost isolated. The numerous British governments even now are in a state of confusion for they have always failed to understand reality. The heated debate in Britain around the Maastricht Treaty almost ended in a tragedy for the UK, and a similar thing also happened in Denmark. The author further continues to shed light on the economic cooperation and development organization, its inception and growth, objectives and orientation. It grew from an European regional organization into a major global donor institute. The author produces sufficient evidence as to how the European Union and the aforementioned organization are assisting the former socialist countries.

3. The status of the "Third World" in the global economy is considered in great detail in this chapter. The author, first, makes attempt to classify countries according to the level of their development. Having compared a set of methods, the author writes that the developing countries can be divided into four categories.

however, he did not rush to provide a standard definition of all the countries of Asia, Africa and Latin America. Up until the mid - 60' s, it was common to give such a standard definition or consider these countries under one and the same category. Today, the differences among the developing countries are many and numerous. For instance, is it relevant to consider the new industrialized countries of Asia and industrialized Latin American countries as developing nations? There are many countries in Africa that are barely managing to survive thanks to international humanitarian assistance. Under which category will such countries like Mongolia come, which are facing many development problems although they possess enormous untapped natural resources? Hence, the term "Third World" could have become an obsolete notion. So, which term would be appropriate to replace it and while doing so the real state of the development level of the different countries must be taken into full consideration.

The author further maintains that after the "Cold War" the "North - South" relations have become richer in substance. It is commonly believed that this relationship developed after World War Two, however, it was Monroe - the fifth US President who in the last century first suggested this new doctrine. Later, Presidents Woodrow Wilson and Franklin Roosevelt, while waging a struggle to abolish colonialism, paid particular attention to the issue of North - South and suggested new ideas and concepts. The North - South relationship entered a new stage in 1960 after the collapse of colonialism in Africa, which demanded many answers to questions both theoretical and practical. At that time this issue became a major part of the foreign policy of the then two systems and also a part of the ideological struggle between these systems. In the 1970' s during the height of international detente, the then German Chancellor, Nobel Prize Winner Willy Brandt suggested a new concept which added a powerful impetus to North - South relations. He considered this issue not only from the stand - point of economy and development, but also in close conjunction with global peace and

security. He indicated that hunger and abject poverty must be eliminated if we wish to establish lasting peace worldwide.

The next section of the chapter deals with the issue of debt and the ways this matter has been resolved, and also the role of oil in politics and how the developing countries have been using oil as an instrument in their dealing with the West. The Arabian countries used oil as their key policy, which eventually led to the new doctrine - the so - called Islamic economy. There had been numerous attempts by the Islamic world to introduce a third option of development by way of placing West' s free capitalism at logger - head with socialism' s centrally planned economy, and there have been reasons for such attempts.

The last section of this chapter deals with the issue of aid. The author first criticizes the stereotype mentality of the Mongolians, who had a top - sided understanding of aid. The Mongolians, only starting in the 1990' s began to understand the enormous difference between the aid provided by the former Soviet Union and the Council for Mutual Economic Assistance (Comecon) countries to Mongolia in the past and the assistance rendered to the developing countries by the industrialized West. The classification of aid, its objective and the aid budget and money constitute an important issue in international economic relations and in the 1960' s a powerful mechanism of coordinating aid was created which was called the "Paris Club", which would analyze the aid - recipient country at its macro - and micro - levels and the impact of aid. Hence it is important to make countries like Mongolia to understand clearly first what aid actually means, which only is just too ready to absorb aid as it comes along. In order to receive aid, the necessary preparations must be first made, and a proper mechanism of evaluating the outcome of such aid should be created, thinks the author.

The third chapter of the book deals with pressing issues of international relations such as human rights, UNO, regional conflicts. Section seven of the book is devoted to human rights issue and this is the first time this issue has been considered in great detail from the stand - point of international relations. The author first

includes documents which looks into the legal interpretation of human rights, how the United Nations and other international institutions uphold human rights and combat infringers of human rights. It is clear why human rights has always been a subject of international debate, how international relations strain because of this conflict, and how much money and effort are expended to resolve such conflicts. The author provides answers to such questions as to how a country can be called ideal in terms of full ensurance of human rights, and what is the yardstick to measure such a judgement. He has divided all the countries into three categories - free, semi - free and not free, and draws up a list of all of them. In Asia there are only four countries totally free and they are Mongolia, Japan, South Korea and Israel.

Section eight of the book deals with the United Nations. The United Nations, according to the author, is going through the post -Cold War transition period, and this transition demands enormous reform. UN Secretary General Boutros Boutros - Ghali has assumed the tough job of carrying through this reform. The reform in the United Nations has coincided with the new wave of regional wars and conflicts, which is creating additional pressure on the UN. In the past, the United Nations did not have to deal so comprehensively with the peace - keeping efforts, which today are carrying out in four stages and four comprehensive forms - preventive diplomacy, peacemaking, peace - keeping and peace - building. The author clearly explains the common features and the differences in them, and underlines the vital importance of involving Mongolia in these peace - efforts. Mongolia is not a country which is capable of paying its membership dues in time to the UN. In the past, the Soviet Union paid the dues on behalf of Mongolia. Member countries owe huge debt to the United Nations and Mongolia could be one of them too. Mongolia can be relieved of her debt to the United Nations by involving Mongolian soldiers in the UN peace - keeping efforts, and this could be one way of testing the knowledge and skill of the Mongolian military personnel. The United Nations could also be used for building up the defence potential of Mongolia.

Regional conflicts necessitated the peace - keeping efforts of the United Nations. In this connection, the author first looks at length into the Middle East and makes an attempt to rectify the stereotype notion of the Mongolians, who for many years have been criticizing and condemning Israel - a country whose territory is 75 times smaller than Mongolia but with the population of five million, and which has been able to withstand some 20 Arab countries with a total population of almost 200 million and which has withstood five wars, which were all instigated by the Arabs, while the Jews have been only taking retaliatory actions. It is regrettable that the Mongolians have been condemning them without any reason and have been meddling in Mideast affairs where Mongolia does not have any national interest. Israel will return the occupied Arab territories, which have been overtaken temporarily in order to establish peace in the region. This is evidenced by the peace treaties and agreements Israel has concluded with the PLO and Jordan.

Afghanistan is one country which desperately needs the peace - keeping efforts of the United Nations. The end of the "Cold War" did not bring victory to any of the conflicting parties in Afghanistan. With the collapse of the Soviet Union, the Marxist - regime in Kabul lost its chief guardian and shortly after was destroyed by the Mojahedeens, who, however, owing to serious inter - tribal differences, have been now fighting for the last three years since they took control over Kabul. This fighting, within a comparatively short period of time, has brought no less casualties and sufferings than the decade long war against the Soviet intervention. The United Nations is losing hopes and is helpless. Afghan crisis has spread into neighbouring Tajikistan, which is fraught with the danger of creating a volatile hotbed of tension.

Africa is one of the major hotbeds of regional conflicts and the author in the next section of this chapter looks at this issue from various angles. The conflicts in Angola and Mozambique have been resolved gradually since the end of the "Cold War." The Republic of South Africa has been able to resolve its conflict. The enormous efforts of the United Nations to ensure human rights and resolve

conflicts in Cambodia and Haiti are beginning to produce tangible results. The author has considered these classical examples of regional settlement.

As a conclusion of the book, the author has written the following. The newly developed situation in international relations following the end of the "Cold War" have been considered in ten - points.

International relations prior to the 1990' s were determined by the "Cold War", which also brought along with itself two diametrically opposite developments - tension and detente - which could not exist without each other and which also supplemented each other. The international crisis created with the "Cold War" gradually precipitated with the collapse of the world communist system. The disintegration of the socio - political structure and the force that gave birth to "Cold War" made this war meaningless. The "Cold War" was officially proclaimed dead with the promulgation of the Paris Charter in the fall of 1990.

In this way , one epoch in international relations came to an end a new "post-Cold War" period began, which is only four years old, and hence it is a bit too early to draw any conclusion by considering its history. No wonder, many conflicting issues are pending solution. However, some of the special features of this period must be taken stock of.

1. The new period in international relations brought before world politicians, diplomats and researchers a sudden, spontaneous and unpredictable - in terms of time and space - a totally new situation. There was not a single nation and a single international organization which predicted such a sudden and dramatic change in international politics, and was prepared for such an alternation which, however, turned out to be more tension - ridden than anybody anticipated or expected.

2. The world has not bid farewell to armaments race and enormous defence spending, on the contrary, it seemingly has entered into a stage of re - armament - gradual and unpredictable. In the past the hotbeds of regional conflicts revolved in and around Asia, Africa

and Latin America, which thus did not evoke serious concern of the major powers. However, today these conflicts have come to the doorsteps of civilized Europe and there is imminent danger of them spreading further out. This is an extremely serious development.

3. It is unquestionable that the contradiction and conflict between the two old systems have become history, however, a new period of conflicts and contradictions has begun. The great powers are struggling to expand their sphere of influence which overrides any other ideological and class contradiction. Although the class interests of the former USSR and the present CIS are no longer existent, their interest to preserve the former rights of the empire has naturally come to the fore.

4. The destruction of the unprecedentedly large empire brought along with itself many new and totally unpredictable developments. This empire, which had been forcibly uniting totally different Asian, Euro-Christian and Muslim nationalities and tribes, has overcome the first stage of its break - up. This implies the formation of the CIS on the foundations of the USSR. The next stage of this break - up would be the fragmentation within the CIS countries. Politologists reckon that this process will continue for 30 - 40 years and Russia would suffer the most in the process. This is a mere prediction but it could be as close to reality. The foundation for such a fragmentation was already laid even before the emergence of the CIS. For instance, it was during the USSR that Russia, Moldova, Georgia, Azerbaijan and the Ukraine seceded from this union.

5. On the background of this break - up, the process of European integration is gaining momentum. The Asia - Pacific region is beginning to rally around APEC. The danger emanating from the CIS, which is in the process of fragmentation, which is riddled with wars and conflicts, where the economy is in crisis and which cannot provide nuclear weapons guarantee, have all made it imperative for the Asian - Pacific countries to unite. This causes serious concern of Western European countries with small territories, dense population, advanced industrial development and well - to - do living standards, and where democracy and human

rights are upheld strongly. There will be no winners in the conflicts flaring up in the CIS and former Yugoslavia, and those forces involved in them have nothing to lose either. It is quite likely that the new - democratic countries of Eastern Europe bordering with the CIS, the three Baltic states, and Japan and Korea in the far East and perhaps Mongolia including sense this danger more than anybody else.

6. The issue of nuclear armaments has taken a different turn. The START - 1 and START -2 treaties first concluded between the Soviet Union and the United States, and later between the Russia and the United States could help scale down the nuclear armaments stockpile around the world. However, a new situation arose with the disintegration of the USSR. Apart from Russia, the Ukraine, Belorussia and Kazakhstan now possess nuclear weapons. This is just the superficial aspect of the issue, which can be resolved. On the other hand, there are many pending problems, that need immediate solution, such as the relocation of these weapons back to Russia for their centralized destruction, dismantling of the weapons carriers, clearing of the missiles bases and wells, provision of job to the many displaced officers, and taking of precautionary measures against theft and proliferation of nuclear weapons and their components. Owing to slack storage of nuclear weapons, and their backward production methods, they are coming into the hands of criminal elements who are smuggling them overseas and this creates a potential danger of the appearance of new countries (DPRK, Iraq, Libya etc.) possessing nuclear weapons.

7. Regional problems are being solved because international attention is focused on the so - called former socialist countries. In the past, such attention was focused on countries where the contradictions of the two systems were felt more strongly. Things are changing, now can be illustrated on the example of Africa. The wars which flared up in Angola and Mozambique in 1974 (which in fact was a conflict between the socialist orientation and Western values) have subsided eventually. The Republic of South Africa has been able to resolve its political crisis. In the Middle East, the people there

are beginning to reach understanding with their once - loathed adversary - Israel.

8. While one nation is disappearing from the international arena, new nations are being formed on their soil, which are entering into endless and meaningless quarrel and confrontation among them, and this fact leads to the new division of the balance of power. For instance, an entire Islamic system has been created which did not have much influence in Asia and which could not have much impact on Europe either. In the past, this new system, the sphere of influence of which was restricted to Iran and Afghanistan, has spread its tentacles covering one half of the CIS, and is spreading its sphere of influence further. The war in Bosnia has laid the grounds for its spread to Europe. Efforts, though complicated, are being made to fill up the vacuum left behind in Asia by the Soviet Union. Economically, there is now an array of "pyramids" consisting of China, India, Asian tigers, Japan etc. Militarily and strategically, the United States and China could come into confrontation with each other. Furthermore, the situation is complicated because of the absolutely uncertain and incomprehensible policy of China.

9. It would be naive to conclude that the threat of communism has dissipated with the collapse of the USSR. It is unlikely that this threat will come from either present - day People' s Republic of China or the DPRK. This threat could revive on the soils of the former Soviet Union. It is quite likely that the threat of communism could be infused with national, great power, revanchist, fascist ideology. On the other hand, the former communist ideology is being understood and interpreted as nationalism. This is evidenced by the developments in the CIS and former Yugoslavia. It is probable that a new version of "Cold War" might as well have to be created in order to uphold Western democracy.

10. The debate around the question "What kind of force should there be which can act as an instrument in international relations?" continues unabated. Under the previous two systems, the two super powers determined international relations. Their military, strategic and economic potentials, and social values in turn became a new

force which affected the entire world. Contrary to such force, international agencies keeping to international laws were playing an important role. This places before mankind a new choice: force or international agencies ? The confrontation of the two systems is no longer existent, and neither is the "Cold War" alive, and hence, there is a prevailing attitude that there is no need for force but a need to create a world - government - type of system. However, since 1990, force has shown itself to be more powerful and effective, and it is impossible to uphold global peace without resort to force. The very example of intensifying foreign policy of the United States designed at upholding global peace (through the United Nations) bears evidence to this fact.

International developments in the last four years could be defined and appraised in this manner. This is, however, the viewpoint of this author and everybody has the right to agree or disagree. Such a conclusion has been drawn simply because of the concern that the zones of threat and tension are gaining ground. This could create a new environment directly affecting the national security of Mongolia. And this threat is moving in from the north. But, there are no serious hotbeds of conflicts on the territory of Russia bordering with Mongolia. However, there is also almost no guarantee that Mongolia's security will not be affected given the fact that in the Russia's center there is political crisis, the crime is on the beat, and secessionist movement has gone beyond control to the point of bloodshed (Chechnya) . It is also impossible to say what problems will confront Mongolia from the west from the Islamic world. The civic war in Tajikistan almost shook the Islamic world to its foundation. On the other hand, Islamic fundamentalism is growing stronger. There are Muslims in Mongolia. Proceeding from this, the threat to Mongolia's security could come from the north and the west.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

Дэлхий дахиныг бүсчилж ангилах нь
(ХБНГУ-ын эрдэмтэн Г.Вагнерын хувилбар)

Бүс нутгууд	Нийт хүн ам	Нутаг дэвсгэрийн хэмжээ
Зүүн хойд Ази (Амар мөрнөөс урагш Гималайн уулсыг хүртэл Хятад, Монголыг багтаасан нутаг)	1 тэрбум 200 гаруй сая	12.3 сая хавтгай дөрвөлжин км
Зүүн буюу эрэг дагуухи Ази (Япон, Солонгос, Индонези, Малайз, Филиппин, Энэтхэг- Хятадын хойг)	500 орчим сая	3.6 сая хавтгай дөрвөлжин км
Өмнөд ази (Энэтхэгийн Кашмираас Шри-Ланк хүртэл)	1 тэрбум орчим	4.8 сая хавтгай дөрвөлжин км
Лалын ертөнц (Мароккоос Пакистан хүртэл бүх Арабын орнууд, Дундад Ази)	350 орчим сая	13.5 сая хавтгай дөрвөлжин км
Австрали ба далайн орнууд (Шинэ Зеландыг оролцуулан)	24 сая	8.4 сая хавтгай дөрвөлжин км
Европ (Шпицберген арлаас Гибралтар, Атлантаас Камчаткийн хойг хүртэл бүх нутаг)	660 сая	28.8 сая хавтгай дөрвөлжин км
Хар Африк (Сахарын цөлөөс Кейптаун хүртэл ӨАБНУ-ыг эс тооцон Африкийн бүх улс үннэтэн)	458 сая	17.8 сая хавтгай дөрвөлжин км
Умард Америк (АИУ, Канад, Мехсик)	355 сая	21.3 сая хавтгай дөрвөлжин км
Дунд Америк (Кариб далаас Аргентин, Чилийн өмнөд хэсэг хүртэл)	341 сая	18.5 сая хавтгай дөрвөлжин км

Хувилбар Энэ хувилбар зөвхөн газар зүйн ойлголт дээр үндэслээгүй, геополитик, шинэ улсын харилцааг үндэс болгосноороо бидэнд илүү ойлгомжтой бийгдэнэ. Дөрвөгийн хуудсанд геополитикийн бүс нутгуудыг тус тусад нь илэрж харуулсан болно.

Ардчилал ба дарангуйллыг дэлхийн
хэмжээнд авч үзэх нь
(Английн "The Economist" сэтгүүлийн
1994.VIII.27-ны дугараас авав)

Тив, Бүс нутаг	Эрх чөлөөтэй	Хагас эрх чөлөөтэй	Эрх чөлөөгүй
<i>Нэг. Америк тив</i> 35 улс	Аргентин Багам Барбадос Белиз Болив Канад Чили Коста-Рик Доминик Эквадор Гренада Гвайнана Гаити Сент-Китс Сент-Люиза Тринидад ба Тобаго АНУ Уругвай (Нийт 19 орон)	Антигуа ба Барбуда Бразил Колумб Доминикан Сальвадор Гватемал Гондурас Мексик Никарагуа Панам Парагвай Перу Суринам Венесуэл (Нийт 14 орон)	Куба Гаити (одоо бол өөрчлөгдсөн - Зох.) (Нийт 2 орон)
<i>Хоёр. Европ тив</i> 47 улс	Андорра Австри Бельги Их Британи Болгар Кипр Чех Дани Эстон Финланд Франц Герман Грек Нидерланд Унгар Исланд Ирланд Итали Лихтенштейн Литва Люксембург	Албани Армен Беларусс Хорват Гүрж Латви Македони Молдов Румын Орос Словак Турк Украин	Азербайжан Босни- Герцеговин Серб ба Черногор (ХБНЮУ)

	<p>Мальт Монако Норвег Польш Португал Сан-Марино Словен Испани Швед Швейцар (Нийт 31 орон)</p>	(Нийт 13 орон)	(Нийт 3 орон)
<p><i>Гурав. Африк 53 улс</i></p>	<p>Бенин Ботсван Кабо-Верде Гамби Мали Мавритан Намиби Сан Томе ба Присинпи Өмнөд Африк (Нийт 9 орон)</p>	<p>Буркино-Фасо Төв Африк Комор Конго Габон Гана Гвиней-Бисау Лесото Мадагаскар Марокко Нигер Сенегал Сейшел Замби Зимбабве (Нийт 15 орон)</p>	<p>Алжир Ангол Бурунди Камерун Чад Кот д'Ивуар Жибути Египт Экваторын Гвиней Эритрей Этиоп Гвиней Кени Либер Ливи Малави Мавритан Мозамбик Нигери Руанди Сьерра Леон Сомали Судан Свазиланд Танзани Того Тунис Уганд Заир (Нийт 29 орон)</p>
<p><i>Дөрөв. Ойрхи ба Дундад Нормон 20 улс</i></p>	<p>Израиль</p>	<p>Иордан Казахстан Кыргызстан Кувейт Ливан Йемен</p>	<p>Афганистан Бахрейн Бутан Иран Ирак Оман Катар Саудын Арав</p>

	(Ганцхан орон)	(Нийт 6 орон)	Сири Тажикистан Туркменистан Арабын Эмират Узбекистан (Нийт 13 орон)
<i>Тав. Ази, Номхон Далай 35 улс</i>	Австрали Япон Кирибати Маршаллын арлууд Микронез Монгол Улс Науру Шинэ Зеланд Соломоны арлууд Өмнөд Солонгос Тонга Вануату Баруун Самоа (Нийт 13 улс)	Бангладеш Камбожи Фижи Энэтхэг Малайз Балба Пакистан Папуа-Шинэ Гвиней Филиппин Сингапур Шри-Ланк Тайвань Таиланд Тувалу (Нийт 14 орон)	Бруней Хятад Индонез Лаос Мальдив Мьянма Умард Солонгос Вьетнам (Нийт 8 орон)


Төрийн зөвшөөрлийн мэдээлэл 1994 оны байдлаар

№	Эзэмшүүлэгч	Мэдээллийн зөрчил	Сөөгөлдөгч талууд	Байлдаж буй бие бүрэлдэхүүн	Эзлэнгээс хойш нийт хохирагч	Хавьдлыг төлөө
1	Салар тусгаарлах (нутаг дэвсгэр)		ОХУ-ын Засгийн газрын эсрэг Чеченийн ерөнхийлөгч тэргүүтэй зэвсэг салан тусгаарлагчид	Тодорхойлох боломжгүй	Тодорхойлох боломжгүй	Базваагүй
2	Мутаг дэвсгэр		Азербайжаны Засгийн газрын эсрэг Нагорно-Карабах Армений тал	42 000 10 000 20 000	4 000 10 000	Базваагүй
3	Мутаг дэвсгэр		Боснийн Засгийн газрын эсрэг Боснийн Серби БНУ, Югославын сербийн дайчио	50 000 90 000 136 500	Нийт 20 000 -50 000	Базваагүй
4	Мутаг дэвсгэр	1991-1993	Боснийн БНУ-ын эсрэг Хорват	50 000 103 500		
5	Мутаг дэвсгэр	Хорват 1990	Боснийн Засгийн газрын эсрэг Сербийн хялгаар, мөн Югослав	103 500 16 000 136 500	Нийт 6 000 10 000	Базваагүй
6	Мутаг дэвсгэр	Гүрж 1992	Гүржийн Засгийн газрын эсрэг Абухаз	20 000 5 000	Нийт 2 500	Зогсонги
7	Мутаг дэвсгэр	Их Британи 1969	Их Британийн Засгийн газрын эсрэг Ирландын БНУ-ын арми	274 800 200-400	Нийт 3 000	Тамжсанч
8	Засгийн эрхийн төлөө нутаг дэвсгэрийн	ХОЁР ОЙГХИ ДОРНОД Иран 1970/1990 1972/1979	Ираны Засгийн газрын эсрэг "Халк" гэгддэг партизань хүчин мөн Курдын ажиглалчид	473 000 тодорхойгүй мөн адал	Тодорхойгүй	Хэлж мэдэхгүй
9	Засгийн эрхийн төлөө	Ирак 1980/1991	Иракийн Засгийн газрын эсрэг Иракийн лалын хувьсгалын дээд хурал	450 000	бүгд тодорхойгүй	Хэлж мэдэхгүй
10	Нутаг дэвсгэр	1977/1980	Иракийн Засгийн газрын эсрэг Рудистивы эх оронч холбоо	10 000 36 000		
11	Нутаг дэвсгэр	1961/1980	Иракийн Засгийн газрын эсрэг Курдистаны эрдчилсэн тэм	тодорхойгүй		
12	Нутаг дэвсгэр	Израиль 1964	Израильн Засгийн газрын эсрэг Палестины зарим отряд, ялан хядах байгууллага (жишээ нь ХАМАС)	176 000 бусад нь тодорхойгүй	1948 оноос хойш нийт 12 300	Зохилуулах эхлэл тавьсан

№	Төрөл 1992-1994	Нутаг дэвсгэр	Тусхийн Засгийн газрын төлөө курсын ажиллагааны нэмэгдэл	400 000 10 000 000	Нийт 4 200 10 500	Мөд шийдвэрлэлт дэвтэр
11	Түрээс 1992-1994 Авганистан 1978	Засгийн захирлын төлөө	Авганистаны Засгийн газрын эсрэг хэрэг и. Д. Сами Хүсэг и. Вавзаг Дуусуурын эсрэг	800 Тодорхойгүй	Нийт 1 сая 1992-1994 онд 11 000 000	нэгдвэртэй
12	Бангладеш	Нутаг дэвсгэр	Бангладешийн эсрэг - 1 сая эсрэг Чугтангийн - 1 сая зохицуулах хэлбэр	107 000 3 000 - 5 000	Нийт 3 500	Бэлтгэлтэй
13	Энэтхэг 1981 1992 1990 1980/1984 1978 1991	Засгийн захирлын төлөө	Энэтхэгийн Засгийн газрын эсрэг Кадмирын боловсрол Сикхийн боловсрол Төмүр омгийн эсрэг Бодолийн хэл Ас-Аман Франс Наладенден Социалист эсрэг Ардын иргэдийн эсрэг	1 265 000 Бусад нь Тодорхойгүй	Нийт 33 000	Бэлтгэлтэй
14	Индонез 1975	Нутаг дэвсгэр	Индонезийн Засгийн газрын эсрэг Дорнод Тиморын эсрэг Тяньшэнь төлөө Хуарэйгийн эсрэг	279 900	Нийт 16 000 Цооног	Тодорхойгүй
15	Камбож 1979	Засгийн захирлын төлөө	Камбожийн Засгийн газрын Ард иргэдийн Камбожийн нутаг Баван кумерүүд	150 - 200 195 000	Нийт 25 500	Бэлтгэлтэй
16	Мьянма 1945	Нутаг дэвсгэр	Мьянмалгийн Засгийн газрын эсрэг Карачын үндэсний тусламж	35 300 286 000	Хайрлах Тодорхойгүй Боломжгүй	Хэлж мэдэгдгүй
17	Филиппин	Засгийн захирлын төлөө	Филиппиний Засгийн газрын эсрэг Ардын шинэ армь	4 000 105 500	Нийт 25 000 Архив	Бэлтгэлтэй
18	Шри Ланка 1978-1982	Нутаг дэвсгэр	Шри Ланкийн Засгийн газрын эсрэг Тамил Исламат төлөө Бас	140 800 7 000	Нийт 25 600	Хэлж мэдэгдгүй
19	Тажикстан 1991-1992	Засгийн захирлын төлөө	Тажикстан Орхс Узбаны - ган Засгийн газрын эсрэг Ардын ардчилсан армь	Тус тус Тодорхойгүй	Нийт 50 000	Бэлтгэлтэй
20	ДӨНӨН АФРИК Анжир 1982 1978	Засгийн захирлын төлөө	Анжирын Засгийн газрын эсрэг Далын өрөөх фронт Паллан зөвлөлөгч	199 000 Нийт 15 000 Архив	Нийт 3000	Цөөшид дэмжжирнэ
21	1972-1978	Засгийн захирлын төлөө	Анголлын Засгийн газрын эсрэг НУТА	50 000 45 100	Нийт Цэргийн 39 000 Энгийн 86 000	Бэлтгэлтэй
22	1982-1985	Засгийн захирлын төлөө	Либериын Засгийн газрын эсрэг Босон Африкийн эсрэг Амгалангийн эсрэг Гмберсон үндэсний эсрэг	200 - 400 15 000 - 17 000 11 000	Нийт 20 000	Хэлж мэдэгдгүй

	Засгийн эрхийн төлөө	Руандын Засгийн газрын эсрэг Руандын эх оронч	40 000	Нийт хохирол бэрэг хагас сая	Базаахгүй
	Засгийн эрхийн төлөө	Сомалийн нэгдсэн конгресс Сомалийн үндэсний холбооны эсрэг сэргэлдэгч талууд	Тодорхойгүй	Тодорхойгүй	Найдваргүй
25	Засгийн эрхийн төлөө (1994 оны сонгуулийн амнэх үеэр)	ӨАБНУ-ын Засгийн эсрэг. 1. Африк үндэсний конгресс 2. Африк дундын конгресс 3. Азанийн ардын байгууллага 4. Эрх чөлөөний холбоо	70 000 тодорхойгүй	Зөвхөн сүүлийн 10 жилд 18 900	1994 оноос зогсонги
26	Нутаг дэвсгэр	Суданы Засгийн газрын эсрэг Суданы ардын чөлөөлөх арми	72 800 тодорхойгүй	Нийт 40 000	хэлж мэдэхгүй
27	ТАВ, ТӨВ БОЛОН ӨМНӨД АМЕРИК Колумб 1947/1978 1965/1978	Колумбийн Засгийн газрын эсрэг Хувьсгалт зэвсэгт хүч Үндэсний чөлөөлөх арми	139 000 тодорхойгүй 8 000	Тодорхойгүй	зогсонги
28	Гватемал 1967/1968	Гватемалын Засгийн газрын эсрэг Үндэсний хувьсгалт эр нэгдлийнхэн	43 900 800 + 1 100	Нийт 2 900 цэрэг 43 500 иргэд	зогсонги
29	Перу 1980/1986	Перугийн Засгийн газрын эсрэг зүүний хувьсгалт партизанд	115 000 9 000	Нийт 28 000	хэлж мэдэхгүй

Европын аюулгүй, байдал, хамтын
ажиллагааны бага хурлын гишүүн
орнууд



"7-гийн бүлэг"



Олон улсын валютын сангийн хамтран ажиллаж буй хуучин социалист орнууд




Members

Note: 81% members are at various stages of preparing for membership; the Baltic states' applications for membership are pending.

Баруун Европын Холбооны
гишүүн орнууд



Тусгаар улсуудын хамтын
нөхөрлөл




Note: Georgia is a CIS member

Европын Холбоо
(харлуулсан нь элсэхээр өргөдлөө өгсөн улс)



Европын чөлөөт худалдааны холбоо



Note: EC and EFTA form EEA

НАТО-гийн гишүүн орнууд



НАТО-гийн "Энхийн төлөө" түншлэлд оролцож буй орнууд



Note: NACC includes NATO;
Georgia's formal membership is still pending

Европын зөвлөл



Балканы бүс нутаг



КАВКАЗ

(Барагдлаар Өвөр Кавказыг, цагаанаар Ар Кавказыг дүрсэлжээ)



Босни-Герцеговина ба Серби
(Цагаанаар Сербизэс гална, Босни, Хорват дахь
сербүүдийн нутгийг тэмдэглэжээ)



ГАРЧИГ

<i>Зохиогчийн өмнөх үг</i>	5
<i>Оршил</i>	7
Нэгдүгээр хэсэг. Посткоммунизм ба олон улсын харилцаа	16
<i>Нэгдүгээр бүлэг. ЗСБНХУ-ын задрал ба тусгаар улсуудын хамтын нөхөрлөл</i>	
Нэг. ЗСБНХУ: Нэгдмэл улсын шинэ загварын эрэлд (1991 он)	17
Хоёр. ЗСБНХУ-ыг аврах эрэл мухардсаны дараа замын бэлчирт (1991-1992 он)	31
Гурав. Орос: Улс төрийн хямралын замд (1991-1994 он)	39
Дөрөв. Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл дэх зөрчил бэрхшээл.	46
Тав. Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн хэтийн төлөв.	60
<i>Хоёрдугаар бүлэг. Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл ба олон улсын шинэ харилцаа</i>	
Нэг. ТУХН - АНУ - НАТО - Европ	70
Хоёр. ЗСБНХУ-ын задрал ба Ази	92
<i>Гуравдугаар бүлэг. Посткоммунизм ба их шилжилт</i>	111
Нэг. Посткоммунизм Европт	115
Хоёр. Посткоммунизм Азид	125
Гурав. Посткоммунизм ба коммунист хөдөлгөөн	137
Дөрөв. Цүүнэлтийн оронд	144
Хоёрдугаар хэсэг. Дэлхийн эдийн засаг ба олон улсын харилцаа	
<i>Дөрөвдүгээр бүлэг "7-гийн бүлэг" ("G-7") ба дэлхийн эдийн засаг</i>	149
Нэг. "7-гийн бүлгийн" үүрэг, төлөвшилт	150


Хоёр. Эдийн засгийн шинэ дэг журам	158
Гурав. Америкийн Нэгдсэн Улс	162
Дөрөв. Япон	167
Тав. ХБНГУ	172
Зургаа. Их Британи	175
 <i>Тавдугаар бүлэг. Европын холбоо</i>	
Нэг. Европын интеграцын түүхээс	181
Хоёр. Маастрихтын гэрээ ба шинэ Европ	186
Гурав. Ирээдүйн тухай төсөөлөл	190
Дөрөв. ЕХН-ийн институтууд	192
Тав. Европын холбоо ба посткоммунист орнууд	196
Зургаа. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)	200
Долоо. Посткоммунист ертөнцийн эдийн засгийн төлөв	204
 <i>Зургадугаар бүлэг. Дэлхийн эдийн засагт "Гурав дахь ертөнц"</i>	
Нэг. Ангилал ба хэмжүүр	209
Хоёр. "Умард-Өмнөдийн" харилцаа	213
Гурав. Өрийн дарамт	218
Дөрөв. Нефть ба улс төрийн бодлого	222
Тав "Лалын эдийн засгийн" тухай үзэл баримтлал	230
Зургаа. Тусламж	233
Долоо. Дүгнэлтийн оронд	238
 Гуравдугаар хэсэг. Олон улсын харилцаа	241
 <i>Долдугаар бүлэг. Олон улсын харилцаа ба хүний эрхийн асуудал</i>	242
 <i>Наймдугаар бүлэг. Нэгдсэн Үндэстний Байгууллага</i>	255
Нэг. НҮБ-ын зорилго зарчим шинэ нөхцөлд	256
Хоёр. "Энх тайван хөгжлийн программ" (Agenda for Peace)	258
Гурав. НҮБ дахь реформ	262
Дөрөв. НҮБ ба АНУ	266
Тав. Энхийг сахиулахад бүс нутгийн байгууллагууд	268
Зургаа. НҮБ ба Монгол Улс	270

<i>Есдүгээр бүлэг. Бүс нутгийн асуудал</i>	
Нэг. Ойрхи Дорнод	276
Хоёр. Афганистан	284
Гурав. Африк	286
Дөрөв. Камбож	291
Тав. Гаити	293
Зургаа. Дүгнэлтийн оронд	295
<i>Төгсгөлийн үг</i>	299
<i>A Summary of the book</i>	
<i>Global Politics and International</i>	
<i>Relations: Key Trends of the 1990' s</i>	303
<i>Хавсралт</i>	319
<i>Хүснэгт ба газрын зургууд</i>	320

УЛСЫН ГЭРЭЛ ЗУРГИЙН ГАЗАР



Үзэмжтэй чанартай хэвлэсэн сайн ном, уншигч түмний хүсэл, шаардлага болсон өнөө үед Улсын Гэрэл Зургийн Газар захиалагч таны хүссэн загвараар төрөл бүрийн хэвлэлийн бүтээгдэхүүнийг олон улсын чанарын түвшинд хийж өгөхөд бэлэн байна.



Улаанбаатар-46
Сүхбаатарын гудамж 5
Утас: 322591
320587
323512
Факс: 976-1-322591

Dashdorj BAYARKHUU

**GLOBAL POLITICS AND
INTERNATIONAL RELATIONS:
KEY TRENDS OF THE 1990'S**